

ТАВДУГААР БҮЛЭГ

1.Янинаас бидэнд бичиж байна.

Нуартъегийн өрөөнөөс, Франц гарахдаа, Валентина хүртэл өрөвдмөөр сэтгэл нь догдолсондоо элий балай болсон амьтан гарчээ.

Энэ хэцүүхэн явдлын үеэр учир нь олдохгүй хэдэн үг аман дотроо буйтнаж байснаа, дараа нь өрөө уруугаа яаран явсан Вильфор хоёр цагийн дараа дараах захидлыг хүлээн авлаа.

“Өнөөдөр, энэ зүйл илэрснээс хойш эрхэм Нуартъе де Вильфор өөрийн гэр бүл ба Франц-д Эпинегийн гэр бүлийн хооронд ураг төрлийн холбоо тогтооно гэдэг боломжгүйг мэдэж байгаа биз ээ. Эрхэм де Вильфор өнөөдрийн зарлан тунхагласан зүйлийг мэдсээр байгаад энэ тухай урьдчилан сануулаагүйг бодохоос Франц-д Эпинед аймшигтай санагдаж байна” гэжээ.

Хүнд цохилтод дарагдсан вангийн прокурорыг энэ үед харсан хүн түүнийг ийм юм болно гэж огтхон ч бодоогүйг нь тааварлан мэдэхээр байв. Үнэн хэрэг дээрэ Вильфор эцгийгээ ийм илэн далангүй, чухамдаа ийм хайр найргүй байдалд хүргэнэ гэж огтхон ч зүүдэлсэнгүй явжээ. Үнэндээ ч хүүгийнхээ саналыг хайхардаггүй эрхэм Нуартъе энэ явдлын тухай түүнд хэлэх хэрэггүй Жэж үзсэн байжээ. Тийм ч учраас Вильфор генерал де Кенель буюу д Эпине түшээ гүн үнэнч тулалдаанаар алагдсан биш, харин алуурдчын гарт амь үрэгдсэн гэж бодож явжээ.

Хүндтэй залуу хүнээс ирсэн энэ ширүүн захидал биеэ тоосон Вильфорт том цохилт болжээ.

Түүнийг тасалгаандаа дөнгөж ортол хойноос нь эхнэр нь орж ирлээ.

Эрхэм Нуартъегийн өрөөндөө дуудаж аваачсан Франц яваад өгсөнд бүгдээр гайхаж, хатагтай Вильфор, гэрчийн этгээдүүд ба нотариусын дунд байхад эвгүй болжээ. Эцэст нь шийдэмгийхэн босоод чухам юу болсныг мэдээд ирье хэмээн тасалгаанаас гарчээ.

Нуартъе, д Эпине хоёрын хооронд болсон явдлын дараа Валентина Франц хоёрын гэр бүл болох явдал бүтэхгүй боллоо гэдгийг л эхнэртээ хэлэв.

Хүлээж байсан хүмүүст үүнийг хэлж болохгүй болохоор хатагтай Вильфор зочдын өрөөнд буцаж ирээд эрхэм нуартъег дайрлага дайрсан учир гарын үсэг, зурах явдлыг хэд хоног хойшлуулалгүй болохгүй болжээ гэж хэлэв.

Энэ мэдээ шал худлаа хэдий ч энэ байшинд тохиолдсон хоёр тохиолдол дээр нэмэлт болж, цугларсан хүмүүс гайхан бие бие өөдөө хараад, чимээгүй гарч одов.

Тэр завсар, тасаршгүй холбоотой болчихлоо гэж Валентинагийн бодож байсан гинжийг ганцхан цохилтоор тасалсан арчаагүй өвгөнийг охин эелдгээр үнсээд, айх баярлах зэрэгцэсэн бүсгүй өрөөндөө очиж амрах зөвшөөрөл гуйв. Нуартъе түүний явахыг зөвшөөрөн харав.

Валентина тасалгаанаас гараад, өөдөө өгсөж өрөөндөө орохын оронд гудмаар явж жижиг хаалгаар гарч цэцэрлэгт очив. Энэ ээлжлэн болигдох хэрэг явдлын дунд бүсгүйн зүрх нэгэн битүүлэг түгшүүрлээс болж шимшрэн байв. залуу бүсгүй Моррелийг “ламмермурийн болзоот хүүхэн” дээр гардаг Ревенсвуд шиг цонхийж цайгаад аймшигтайгаар хүрээд ирэх байх гэж хүлээж байжээ.

Бүсгүй яг цагийг нь олж очжээ. Хүүр оршуулах газраас Францыг Вильфортой хамт яваад өгөхөөр Максимилиан учрыг тааварлан мэдэж хойноос нь даган явжээ.

Франц гэртээ ороод, дараа нь эргэн гарч, хэдэн минутын дараа Альбер, Шато-Рено хоёртой хамт ирэхийг Моррель харжээ. Ингээд түүнд эргэлзэх юмгүй болжээ. Тэгээд Валентинаг бололцоо гармагц гүйж ирнэ гэж бодоод бэлэн зэлэн болж ногооны газар хүрч иржээ.

Тэр андуурсангүй. Хашааны завсраар хартал Валентина урьдын болгоомжилсон байдалгүй шууд хаалга өөд гүйн ирж яваа харагджээ.

Валентинаг харангуутаа тайвширч, дуугармагц нь баярлан дэвхцэв.

- Аврагдсан! Гэж валентина дуу алдахад Моррель аз жаргалдаа итгэж чадалгүй
- Аврагдсан гэнэ ээ! Хэн биднийг аврав? Гэж асуув.
- Өвгөн аав, Моррель минь түүнд үүрд хайртай байгаарай

Өвгөнд үнэн сэтгэлээсээ хайртай байна гэж Моррель тангараг тавив. Тэр энэхэн минутанд өвгөнийг найз нөхөр, эцгээ гэж хайр нь хүчр байснаар бархагүй аврагч бурхнаа хэмээн үзэж байсан учир ийм тангараг тавихад хэцүүгүй байв.

- Яаж ийм юм болов? Тэр юу хийв? Гэж Моррель асуув.

Валентина бүхнийг тоочин ярих д бэлнэ байсан боловч энэ бүхний цаана зөвхөн өвгөн аавд нь холбогдоод зогсохгүй аймшигтай нууц хадгалагдан байсныг гэнэт санав.

- Би дараа нь бүгдийг нь яримц гэж охин хэлэхэд, Моррель,
- Хэзээ? Гэж асуув.
- Эхнэр чинь болсон хойноо.

Чухам ийм үг л Моррелийг юунд ч зөвшөөрүүлж болох байв. Тийм болоод ч сонссон зүйлээрээ хангагдаж тэр ч байтугай маргааш орой нь Валентинаг уулзана гэж болзоо хийвэл явахыг ч зөвшөөрөв.

Валентина амлав. Бүх зүйл бүсгүйд ашигтайгаар өөрчдөгөж нэг цагийн өмнө Францын эхнэр болохгүй гэж итгэхэд хэцүү байсан бол одоо Максимилианы эхнэр болно гэж итгэхэд хялбархан болсон байв.

Тэр завсар хатагтай Вильфор, Нуартье дээр очихоор өгсөв.

Нуартье түүнийг бахь байдгаараа баргар ширүүн царайлан угтав.

- Валентинагийн хурим хийх явдал, чухам энд бүтэхгүй болсон болохоор тэр тухай яриад ч яахав гэж хатагтай хэлэв.

Нуартье хэнэг ч үгүй байв.

- Харин би ямагт тэгж гэр бүл болохын эсрэг байсан бөгөөд миний саналаас зөрж энэ явдал болж байсан юм гэдгийг та мэдэхгүй л дээ гэж хатагтай Вильфорын хэлэхэд өвгөн бэр өөдөө учрыг нь тайлбарлан ярь гэсэн янзтай харав.

- Тэгэхээр, таны нэгэнт сайшаагаагүй энэ хэрэг хүчингүй болсон болохоор, миний нөхөр ч тэр Валентина ч тэр надаас гуйж чадахгүй нэг зүйлийг би танаас хүсэх гэж ирлээ.

Нуартье түүн өөд асуусан янзтай харав.

- Надад өөрт минь ямар ч ашиг гарахгүй юм болохоор ганц би хүсэх эрхтэй учир танаас гуйхаар ирлээ. Тэгэхээр танаас би ач охиноо хайрлаач гэж гуйх гээгүй, харин хөрөнгө хогшлоо түүнд эргүүлэн өгөөч гэж гуйх гэсэн юм гэж хатагтай Вильфор үргэлжлэн яриу.

Тэгэхэд Нуартъегийн царайд эргэлзэх шинж илрэв. Бодвол ингэж гуйх болсны шалтгааныг эрээд олсонгүй бололтой.

- Таны бодол миний хүсэлтэй тохирч байгаа гэж найдаж болох уу? гэж хатагтай асуухад Нуартъе,
- Тийм гэж дохив.
- Тэгвэл би таны эндээс ихэд баяр талархалтай явах болж байна гэж хатагтай Вильфор хэлээд өвгөнд мэхийн ёсолж тасалгаанаас гарч явав.

Маргааш нь Нуартъе нотариус дуудуулж авчрав. Анхныхаа гэрээслэлийг устгаж, шинээр гэрээслэж, хэрэв Валентинаг түүнээс салахгүй л байвал бүх хөрөнгөө өвлүүлж өгөхөөр болов.

Зарим хүмүүс, Сен-Меран бээлийн үе залгамжлагч бүсгүй өвгөн аавынхаа хайр хишгийг хүртсэн болохоор, нэгэн өдөр л жилд бараг гурван зуун мянган ливрийн орлоготой хүн болно гэж бодож гаргажээ.

Энэ завсар Монте-Кристо гүн Морсер гүнийд очиж, цаадах нь Дангларт бэлэн зэхээний байгаагаа үзүүлэх гэж ёслолынхоо дэслэгч генералын хувцсыг өмсөж гоёод, бүх одон тэмгүүдээ зүүж, хамгийн сайхан сүйх тэргээ өгөхийг тушаав.

Тэгээд Шосе-д Антен гудамжинд очиж Дангларт ирснээ мэдэгдэхийг тушаав. Ян энэ үед Данглар сарынхаа тайланг гаргаж байв.

Сүүлийн үед Дангларыг сайхан зантай байнаа үед нь уузल्या гэвэл өөр үед л ирэх хэрэгтэй байжээ.

Данглар хуучин найзаа хараад ихэмсэг дүр үзүүлэн сандал дээрээ гэдийв.

Угийн ширүүн дориун зантай Морсер энэ удаа их л хөгжилтэй байхыг хичээж байв. Өөрийн нь саналыг баяртай хүлээн авна гэж бараг итгэсэн байсан учир ямар ч ёсорхолгүйгээр шууд ярих юмандаа оров.

- Би түшээ гүн тан дээр манай хуучин төлөвлөгөөнийхөө тухай ярилцах гэж... хэмээн Морсер ярьж эхлэв.

Морсер түшээ гүний баргар царайтай байгаа, өөрийн хариу өгөгүйгээс болсон хэрэг гэж бодож байсан учир энэ үгийг дуулаад Дангларын царай гэрэлтэн, гэгээ орно гэж харж байв.

Гэтэл энэ царай цлам гүнзгий хэнэггүй хүйтэн боллоо.

Ийм учраас Морсер үгээ хэлж гүйцэлгүй дутуу орхисон нь энэ байжээ.

- Гүн та ямар төлөвлөгөөний тухай ярьж байна гэж банкны эзэн чухам юу ярьж байгааг нь ойлгохгүй байдлаар асуув.
- Эрхэм түшээ гүн та их ёсорхуу хүн юм. Би ёс журмыг бүх горимоор нь гүйцэтгэх хэрэгтэй байх гэж бодоогүй юм. Зах яах вэ. Уучлахыг хүсье. Би ганц хүүтэй, тэгээд түүнийгээ анх гэрлүүлэх гэж байгаа болохоор ийм ажилд баахан шинэлдээд байна шүү. Уучлаарай би буруугаа хүлээе гэж Морсер хэлэв.

Тэгээд Морсер зориуд инээмсэглэн босоод Дангларт бөхийн ёсолж хэлсэн нь:

- Би өөрийн хүү бээс Альбер де Морсертоо эхнэр болгохоор мадмуазель Эжени Дангларыг гуйж явна гэв.

Гэтэл Морсерийн найдсанчлан энэ үгэнд нь баярлахын оронд Данглар хөмсгөө зангидаад гүнг дахин суу ч гэж урилгүй

- Гүн танд хариу хэлхийн өмнө би бодох хэрэгтэй байна гэв.

- Бодох ий! Танд бодох цаг байгаагүй гэж үү? Та бид хоёр энэ гэрлэлтийн тухай анх ярьснаас хойш найман жил өнгөрсөн билээ гэж Морсер гайхан өгүүлэв.
- Өдөр бүр шинэ шинэ хэрэг явдал үүсэн гарч, гаргасан шийдвэрээ өөрчлөхөд ч хүргэх юм гэж Данглар хариу хэлэхэд
- Энэ юу гэсэн үг вэ? Түшээ гүн таны хэлж байгааг ойлгохгүй байна ! гэж Морсер хэлэв.
- Бас нэг шинэ нөхцөл байдал бий болоод хоёр долоо хоног болж байна гэж хэлэх гэсэн юм... хэмээн Дангларыг хэлтэл Морсер,
- Уучлаарай бидэнд ийм жүжиг тоглох ямар хэрэг байна вэ гэж хэлэв.
- Ямар жүжиг,
- Илэн далангүй ярилцъя.
- Зөвшөөрнө өө. Та Монте-Кристо гүнтэй уулзав уу?
- Бид хоёр найз нөхөд болохоор байн байн уулздаг юм гэж Данглар ихэмсэг байдлаар хэлэв.
- Та түүнтэй саяхан нэг уулзахдаа, энэ гэрлэлтийн тухай намайг их мартагтай, шийдвэргүй хүн вч гэж хэлсэн байх шиг билээ.
- Яг үнэн.
- Гэвч миний талаас ямар ч мартсан ч юм уу шантарсан явдал гараагүй, харин таныг амласнаа биелүүлээч хээмн ирлээ шүү дээ.

Данглар юу ч хариулсангүй.

- Та шийдвэрээ өөрчлөчихөж амжсан байж болноо, эсвэл намайг доромжилж бахаа хангах гэж намайг ийм алхам хийхэд хүргэв үү? Гэж Морсер нэмж хэлэв.

Яриаг цааш нь ийм байдлаар үргэлжлүүлбэл өөрөө эвгүй байдалд орохыг ойлгосон Данглар

- Гүнтэн та миний даруу занг гайхах бүрэн эрхтэй билээ. Би таныг сай ойлгож байна. Би өөрөө ч энүүндээ маш их зовж байгаа боловч, нэгэн чухал явдал түүн уруу шахаад байна гэв.
- Таны энэ бодол шалтаг зааж байгаа хэрэг. Надаас өөр хүн байсан бол түүгээр чинь хангагдаж болох байсан биз. Гэвч Морсер гүн бол хэн хамаагүй хүн биш шүү. Тэр я-тар нэгэн хүн дээр ирж хэлсэн үгийнх нь тухай сануулахад цаад хүн нь хэлсэн үгэндээ хүрэхийг хүсэхгүй байвал үгүйдээ л тайлбарлаж өгөхийг шаардах эрхтэй гэж гүн хэлэв.

Данглар аймхай хүн байсан боловч түүнийгээ харуулахыг хүссэнгүй. Морсерийн хэлсэн үг шарыг нь гозойлгожээ.

- Тайлбарлах юм надад байлгүй яах вэ.
- Та юу гэж хэлэх гээд байна?
- Надад тайлбарлах юм байлаа ч гэсэн гаргаад хэлчихэд амаргүй байна.
- Таны энэ дутуу зэмдэг үгэнд сэтгэл хангагдахгүй байна. Ямар ч байсан худ ураг бололцохоосоо няцаж байх шив дээ гэж Морсер хэлэхэд Данглар хариуд нь,
- Үгүй эрхэм минь, би зөвхөн өөрийн шийдвэрийг хойшлуулж байгаа юм гэж хэлэв.

- Би таныг хэзээ хайр хишгээ хүртээх юм бол гээд л тааллыг тань хүлээж сууна гэж арай бодоогүй биз дээ?
- Гүн та хүлээх дургүй байгаа бол бидний төлөвлөгөө биелэгдсэнгүй гэж тооцъё л доо.

Гүн түргэн зангаа барих гэж хөмхийгөө өвдтөл зуув. Одоогийн энэ байдалд ганцаараа инээдэмтэй байдалд орчихсоноо ойлгож байв. Тэгээд үүд рүү явах гэснээ больж буцаж ирэв.

Нүүр нь барзайж ирснээ доромжлогдсон байдал нь, үл мэдэг сэтгэл түгшсэн янзаар солигдов.

- Эрхэм Данглар та бид хоёр танилцаад ганц жил болж бхйгаа биш, бие биеэ бага зэрэг бодох ёстой. Би танаас учрыг тайлбарлаж өгөхийг хүсье. Үгүй ядахдаа, ямар муу ёрын юм миний хүүд хандах таны харьцааг өөрчлөхөд хүргэснийг мэдэх ёстой байна гэж гүн хэлэхэд Морсерыг бага зэрэг зөөлсөрн байхыг харсан Данглар зальхай байдалдаа эргэн орж,

- Энэ бол бээсээс шалтгаалсан хэрэг огт биш гэдгийг л би танд хэлж чадах байна гэж хариулав.

- Тэгээд хэнд хамаатай юм бэ? гэж царай нь хувхай цайсан Морсер хахирсан дуугаар асуухад нь сэтгэл зовсон байдлыг нь ажсан Данглар Морсер өөд урьдынхаасаа илүү итгэлтэй харцаар харж,

- Харин илүү тодорхой ярьчихаагүйд минь баярлау яв гэж хэлэв.

Морсерын хор нь хөдөлснөөс бие нь чичрэв. Тэгээд хүч гарган,

- Би тайлыбарлаж өгөхийг танаас шаардах эрхтэй. Танд хатагтай Морсерын эсрэг ямар нэг юм байна уу? Эсвэл та намайг хүрэлцэхүйц баян биш гэж үзэж байна уу? Эсвэл миний үзэл таныхтай адилгүй байна гэж үү? Гэж асуув.

- Нэг дэх нь ч хоёр дахь нь ч, гурав дахь нь ч биш. хэрэв би ингэсэн бол уучлагдахгүй байх ёстой. Анх зөвшөөрөхдөө л энэ бүхнийг мэдэж байсан. Одоо бүү шалгаагаад байгаарай. Таныг ингэж түгшүүлсэндээ би харамсаж байна. Үүнийг орхиё. Зүгээр л холбоогоо тасална ч гэхгүй, таслахгүй ч гэхгүй дундыг баримталсан шийдвэр гаргая. Яарах юу байх вэ? Миний охин арван долоотой, танай хүү хорин нэгтэй. Жаахан хүлээе. Яах вэ, цаг хугацаа өнгөрч л байг. Өнөөдөр биэнд тодорхойгүй байгаа зүйл маргааш дэндүү тодорхой ч болж болох юм. Хамгийн аюульай гүтгэлэг нэгэн өдрийн дотор буруушаагддаг ёс ч байдаг гэж Данглар өгүүлэв.

- Гүтгэлэг ий? гэж Морсер царай нь үхтлээ зэвхийрэг асуугаад, - тэгвэл намайг гүтгээ юу? гэв.

- Дахин хэлье. Гүн та тайлбар битгий шаа^одаад байгаарай.

- Тэгвэл эрхэм минь, ийнхүү татгалзахыг чинь үг дуугүй хүлээж өнгөрүүлэх хэрэг үү?

- Надад илүү их зовлонтой байна. Би тантай ураг төрлийн холбоотой байх гэж их итгэж горьдож байсан учраас надад илүү хүнд байна. Ер нь тэгээд гэрлэлт бүтэхгүй болоход нөхөр болох хүнээсээ эхнэр болох хүнд нв илүү хар сүүдэр үлдээдэг юм шүү дээ.

- За тийм байж, энэ яриагаа больё гэж Морсер хэлээд бээлийгээ ууртай хумхиж бариад тасалгаанаас гарав.

Морсер, өөрөөсөө болоод данглар хэлсэн үгээ буцав уу гэж нэг ч удаа асууж зүрхэлсэнгүй гэж банкны эзэн дотроо бодож хоцорлоо.

Орой нь Данглар хэдэн найз нөхөдтэй удаанаар зөвлөлдөн ярилцав. Хатагтай нартай хамт зочдын өрөөнд байсан Кавальканти тэднийхээс хамгийн сүүлд явав.

Маргааш өглөө нь Данглар дөнгөж сэрмэгцээ сонин ирэв үү гэж нэхэв. Сонинуудыг авчирч өгмөгц бусдыг нь орхиод “Үнэн мөний дуу хоолой” гэдэг сонин шүүрэн авав.

Энэ сонины эрхлэгч нь Бошан байв.

Данглар сонины боолтыг задлаад яаран дэлгэж, тэргүүн өгүүллийг нь хайрхалгүй өнгөрч, сонсгол мэдээнүүдэд хүрээд: “Янинаас бидэнд бичиж байна” гэдэг үгээр эхэлсэн мэдээг уншиж хорсолтойгоор инээмсэглэв. Тэгээд уншиж дуусаад,

- За ман сайн хэрэг. Ямар ч л гэсэн Морсер гүнд тайлбар тавиад байх явдлаас намайг зайлуулж өгөх хурандаа Фернаны тухай жаахан өгүүлэл байна гэв.

Энэ үе буюу тухайлбал өглөөний есөн цагт Альбер де Морсер тас хар хувцас өмсөж, бүх товчийг нь товчилчихоод царай нь цонхийж, сэтгэл нь түгшсэн амьтан Елисейн Тал дахь байшинд ирэв.

- Гүн хагас цагийн өмнө яваад өгсөн гэж хаалгач хэлэхэд,
- Батестеныг дагуулаад явсан уу? гэж Морсер асуув.
- Үгүй, эрхэм бээс ээ!
- Тэгвэл Батистаныг дуудаач, би түүнтэй ярих юм байна.

Хаалгач даамлыг олж ирэхээр яваад минутын дараа түүнтэй хамт хүрч ирлээ.

- Найз минь, миний ингэж шалгааж байгааг уучлаарай. Гүн гэртээ үнэхээр байхгүй эсэхийг танаас өөрөөс чинь асуух гэсэн юм гэж асуухад Батистен,
- Байхгүй эрхэм минь гэв.
- Намайг гэртээ орно гэхэд ч байхгүй юу?
- Гүн тантай уулзахдаа баяртай байдгийг би мэдэх учир таныг яаж гэж бусад хүмүүстэй адил үзэх билээ.
- Читний хэлдэг зөв. Би түүнтэй маш чухал хэргээр уулзах гэсэн юм. Мөд ирэх болов уу?
- Удахгүй ирнэ байх гэж бодож байна. Тэр арван цагт өглөөнийхөө хоолыг иднэ гэж захисан.
- За маш сайн. Би Елисейн Талаар явж байгаад арван цагт хүрээд ирье. Хэрэв гүн надаас түрүүлээд ирчихвэл, намайг хүлээж байхыг гуйгаарай.
- Гүйцэтгэе эрхэм минь.

Альбер, гүнгийн үүдэнд хөлсөлж ирсэн хөнгөн сүйх тэргээ орхиод өөрөө явган явав.

Бэлжэвсэн хүүхнүүдийн гудамжийг өнгөрч явтал Госсейн буудлагын газрын үүдэнд гүнгийн сүйх тэрэг зогсож байгаа харагдав. Альбер дөхөж очоод хөтчийг нь танЁв.

- Гүн буудлагын газар бахйна уу? гэж Морсер асуухад хөтөч,
- Тийм ээ, эрхэм минь гэж хариулав.

Үнэндээ ч Альбер буудлагын газар дөхөж яваад бууны дуу дуугарч байхыг сонсов.

Тийшээ яваад ортол үйлчлэгчтэй нь дайралдав.

- Уучлаарай эрхэм бээс, та жаахан хүлээж байхгүй юу гэж хэлэхэд,
- Яагаад тэр билээ, Филипп? Гэж Альбер асуув.

Альбер энэ буудлагын газар тогтмол ирдэг хүмүүсийн нэг байсан учир ингэж саад тохиолдсон явдалд гайхжээ.

- Яагаад гэвэл одоо сургууль хийж байгаа хүн буудлагын газрыг бүхлээр нь хөлслөн авдаг бөгөөд хүний дэргэд хэзээ ч бууддаггүй юм.
- Филипп таны дэргэд ч тэр үү?
- Эрхэм та намайг энд зогсож байгааг харж байгаа биз дээ?
- Буугий нь хэн цэнэглэж өгдөг юм бэ?
- Зарц нь
- Нэг нуби хүн байна уу?
- Хар арьстан
- Тийм байх ёстой.
- Та энэ эрхэм хүнийг таньдаг юм уу?
- Би хойноос нь ирсэн юм. Миний найз байгаа юм.
- Тэгвэл өөр хэрэг. Би түүнд хэлье.

Тэгээд үгэнд дурласан Филипп буудлагын газар руу оров. Секундийн дараа Монте-Кристо босгон дээр гарч ирэв.

- Эрхэм гүн та ингэж хүрч ирсэн явдлыг минь уучлаарай. Харин танай зарц чинь буруутай биш шүү гэдгийг юуны өмнө хэлчихье. Би өөрөө ингэж шаргуу хөөцөлдсөн юм. Би танайд очсон л доо. таныг зугаалахаар явсан, арван цагт өглөөнийхөө хоолыг захисан гэж хэлсэн. Би бас арван цаг хүртэл зугаалхаар шийдээд явж байтал санаандгүй таны сүйх тэргийг харчихлаа.
- Энэ бүгдээс чинь таныг надтай хамт өглөөний хоол идэхээр иржээ гэж дүгнэж байна.
- Баярлалаа. Надад одоо өглөөний хоолтой манатай байна. Бид сүүлд арай эвгүй улстай хамт ч гэхнээ өглөөний хоол идэж болох байх!
- Юу гэнэ ээ, би ойлгохгүй байна.
- Эрхэм гүн минь би өнөөдөр нэг хүнтэй халз тулалдах болоод байна.
- Та юу? Яах гэж?
- Тулалдах гэж тэр байхгүй юу.
- Би тулалдааныг нь мэдэж байна. харин юуны төлөө тэр вэ? Олон шалтгаанаар тулалдаж болдог шүү дээ.
- Миний нэр төрийг хөндсөн хэргээр.
- Тэгвэл ч ноцтой хэрэг байх нь ээ.
- Би танаас юм гуйхаар хүрч ирэхүйцээр ноцтой хэрэг.
- Юу гуйх гээ вэ?
- Таныг миний гэрч болж өгөхгүй юу гэж гуйх гэсэн юм.
- Энэ ч тоглоом биш дээ. Энэ тухай энд ярихаа больё. Али надад ус өгөөч.

Гүн ханцуйгаа шамлаад буудлагын өрөөнд орогчид гараа угаадаг жижиг өрөөнд оров.

- Бээс орооч. Танд харахад сонин юм байна гэж Филипп шивгэнэв.

Морсер орлоо. Байны самбар дээр байны оронд тоглодог хөзрүүд наасан байв. Тэнд тамганаас эхлээд дандаа тоо хөзрүүд байна.

- Тө хөзөр тоглож байгаа юм уу? гэж Альбер асуухад гүн,
- Үгүй зүгээр тоо хөзөр хийж байсан юм гэв.
- Тоо хөзөр ий?
- Тийм ээ. Энэ тамга туг хоёроор миний сум дадар, тав, долоо, найм, ес арвыг хийсэн юм.

Альбер ойрхон очив.

Нээрээ ч сумнууд адил хэмжээ зайтайгаар хөзрийн цаасан дээр дутуу тэмдгүүдийг нь байх газар нь тавьж цоо цохисон байв.

Альбер бас байны дэргэд очоод гүнгийн гар бууны сум тусах газар болгоомжгүй нисэж явж гүнгийн суманд өртсөн гурван хараацай шувуу оллоо.

- Чөтгөр ав! гэж дуу лдлаа.

Монте-Кристо Алийн өгсөн алчуурт гараа арчих зуур,

- Одоо яая гэх вэ дээ. Завтай цагаа ямар нэг юмаар өнгөрүүлэх хэрэгтэй ёүү дээ. За явъя. Би таныг хүлээж байна гэв.

Тэр хоёр Монте-Кристо гүнгийн сүйхэд сууж хэдэн минутын дараа гучдугаар байшингийн үүдэнд хүрч ирэв.

Монте-Кристо Морсерыг өрөөндөө оруулаад суух сандал зааж өгөв.

Тэр хоёр хоёулаа суулаа.

- За одоо тайван ярилцъя гэж гүн хэлэв.
- Би ер тайван байгааг та харж байгаа биз.
- Та хэнтэй тулалдах гээд байна?

-Бошантай!

- Найзтайгаа юу?
- Ер нь дандаа найзтайгаа л тулалддаг шүү дээ.
- Үүнд шалтгаан хэрэгтэй.
- Шалтгаан байна.
- Тэр хүн яагаа вэ?
- Өчигдөр орой түүний сонинд ... Та үүнийг унш л даа гэж хэлээд Альбер Монте-Кристорд сонингоо өгсөнд гүн ингэж уншив.
- “Янинаас бидэнд бичиж байна.

Хотыг хамгаалж байсан цайзыг Али-Тебелиний бүрэн итгэмжилж байсан Фернан гэдэг нэртэй франц офицер түргүүдэд тавьж өгсөн гэдэг урьд өмнө хэний ч мэдээгүй, юу ч л гэсэн хэнд ч зар дуулдаагүй мэдээ баримт бидний сонорт хүрэлцэн ирэв”

- Тэгээд яагаа вэ. Танд гомдоод байх юу байгаа юм бэ? гэж Монте-Кристо асуув.
- Юу, юу байгаа юм бэ гэж?
- Яниний цайзыг Фернан гэдэг хүн тавьж өгсөн байгаа нь танд ямар хамаатай юм бэ?
- Миний эцэг Морсер гүн, Фернан гэдэг нэртэй юм.
- Танай эцэг Али-пашийн албанд байсан юм уу?
- Өөрөөр хэлбэл тэр Грегийн тусгаар тогтнолын төлөө тулалдаж явсан хүн. Гүтгэсний учир нь энэ байна.

- Эрхэм бээс, сонсож бай. Ўмыг саруул ухаанаар тунгаан үзье.
- Болно, болно.
- Одоо Феронан гэдэг офицер Морсе° гүн хоёр нэг хүн гэдгийг Францад хэн мэдэж байгаа юм бэ, мөн би андуураагүй бол мянган найман зуун хорин хоёр эсвэл мянга найман зуун хорин гурван онд эзлэгдсэн Янинийг хэн сонирхох юм бэ?
- Энэ чинь л бузар хэрэг. Өчнөөн жил дуугүй байснаа өндөр тушаалтай хүний нэрийг гутааж шймээн шуугиан дэгдээх гэж аль эрт өнгөрсөн баларсна юмыг сэргээж байна. Би эцгийнхээ нэрийг залгамжлан авах хүн. Тэгхээр өчүүхэн сэжиглэхийн сүүдэрт чө тэр хүн өртөхийг хүсэхгүй байна. Би энэ мэдээ нийтлэгдсэн сониын газар руу нэг гэрчээ явуулж Бошаныг энэхүү мэдээг хүчингүй болгож залруулж аль гэж шаардана гэв.
- Бошан юу ч залруулж өгөхгүй дээ.
- Тэгвэл бид хоёр үзэлцэнэ дээ.
- Та хоёр үзэлцэж чадахгүй. Яагаад гэвэл Грегийн армид Фернан нэртэй офицер хагас зуу шахам байж болохгүй гэхийн арга байхгүй.
- Хамаагүй бид хоёр үзэлцэнэ. Би үүнийг зүгээр өнгөрүүлэхгүй. Миний эцэг бол сайхан сэтгэлтэй дайчин эр... Алдар нэртэй хүн байгаа юм...
- Хэрвэ: “Морсер гүн хэдийгээр Фернан гэж нэртэй боловч энэ Фернан нь түүнтэй ямар ч хамаарах зүйлгүй гэж үзэх үндэс бидэнд байгаа юм” гэж бичвэл яах вэ?
- Би ийм юмаар хангагдахгүй. Надад ёстой бүрэн залрууга хэрэгтэй.
- Та тэгээд гэрчээ түүн руу явуулах уу?
- Тэгнэ. Дэмий л юм даа.
- Өөрөөр хэлбэл миний гуйсан зүйлийг та татгалзаж байгаа юм шив дээ?
- Та ирүүл тулааны тухай миний үзлийг мэднэ шүү дээ. Би Ромд байхдаа танд хэлж байсныг санаж байна уу?
- Гэсэн ч би өнөөдөрхөн таныг тэр үзэлтэйгээ тун бага авцалдам дасгал хийж суусныг харсан шүү дээ.
- Үгүйсгэх юм гэж хэзээ ч байдаггүй. Хэрэв галзуу хүмүүсийн дунд байбал бас л галзуу хүн шиг байж сурах хэрэгтэй. Ер нь таны энэ Бошантай маргалдах гэж байгаа шиг тийм шалтаг гаргасан нэг галзуу юм гарч ирээд надад гэрчээ ирүүлэх юм уу намайг олны өмнө доромжилбол тэр амьтныг аргагүй л алах хэрэгтэй болно шүү дээ.
- Тэгвэл та өөрөө тулалдаж болно гэж үзэж байх шив.
- Үзэхээр барах уу даа!
- Тэгээд намайг үзэлцэхэд яагаад дургүйцээд ыайгаа юм бэ?
- Би таныг ерөөсөө тулалдах хэрэггүй гэж хэлээгүй. Би зөвхөн л халз, тулалдах гэдэг бол тун ноцтой хэрэг, няхуур бодох хэрэгтэй л гэж хэлж байна.
- Аа, Бошан, эцгийг минь доромжлохдоо бодоо болов уу?
- Бодоогүй байгаад түүнийгээ хүлээвэл, та түүнд уурлах хэрэггүй юм биш үү.
- Эрхэм гүн та их нинжин сэтгэлтэй хүн юм!

- Харин та дэндүү ширүүн хүн юм. Бодоод үзье л...дээ... Та дуулж байна уу, бодоод үзье...харин та миний хэлэх юманд бүү уурлаарай.
- Биттаны хэлэхийг дуулдъя.
- Тэр дурдсан баримт үнэн байж гэж бодоод үзье...
- Эцгийн нь нэр төрийг хөндөж байхад хүү нь зүгээр бодоод сууж болохгүй.
- Манай үед чинь олон юм болдог үе шүү.
- Бидний үе үүгээрээ л муу байгаа юм.
- Та түүнийг нв засах гэж бодож байна уу?
- Тиймээ, надад хамаатайгий нь засна.
- Би ланыг ийм өчүүхэн юманд хэтэрхий хатуу хүн гэж мэдсэнгүй!
- Би ийм л төрсөн хүн дээ.
- Тэгвэл та санй санааны зөвлөгөөг хэзээ ч дуулдаггүй хүн үү?
- Үгүй, хэрэв найз хүн минь хэлбэл дуулдаг
- Та намайг найз нөхрөө гэж үздэг үү?
- Тийм.
- Тэгвэл Бошанд гэрч хүнээ явуулхаас өмнө сайн лавлаж үз.
- Хэнээс?
- Гайдегээс асуусан чяах вэ.
- Энэ хэрэгт эмэгтэй хүн оролцуулах гэж үү? Тэр надад юу гэж хэлж чадах юм бэ?
- Танай эцгийг түүний эцгийн ялагдал үхэлд буруугүй гэж батлах ч юм уу эсвэл хэрэгтэй тайлбар өгөх, эсвэл танай эцэг золгүйгээр тэр явдалд оролцсон ч юм бил үү...
- Тийм байх ёсгүй гэж би танд түрүүн хэлсэн билээ.
- Тэгвэл та энэ аргыг хэрэглэхээс татгалзж байгаа юм уу?
- Татгалзаж байна.
- Шийдвэртэй татгалзаж байна уу?
- Шийдвэртэй татгалзаж байна!
- Тийм бол танд өгөх миний сүүлчийн зөвлөгөөг сонс.
- За сайн, харин сүүлчийнх нь шүү._
- Эсвэл та сонсохыг хүсэхгүй байна уу?
- Харин ч бүр хүсэж байна.
- Бошанд гэрчийн хүнээ бүү явуул.
- Яагаад тэр вэ?
- Өөрөө түүн дээр оч.
- Энэ чинь ёс журмаас гажууд болж байна шүү дээ.
- Таны хэрэг бусдынх шиг зүйл биш.
- Та яагаад намайг түүн дээр биеэрээ оч гэж байна?
- Ягаад гэвэл бүх зүйл та хоёрын дунд үлдэж хоцорно.
- Би таны хэлж байгааг ойлгохгүй байна.
- Энэ маш тодорхой зүйл. Хэрэв Бошан хэлсэн үгээ буцааж авахаар та түүнд үүнийг сайн дураараа хийх боломж олгож үр дүнд нь залруулга гаргуулж авна. Хэрвэ та татгалзвал та өөрийн нууцыг гаднын хоёр хүнд хэлж мэдэгдэж хэзээд амжина шүү дээ.

- Гаднын хүн биш найз нөхөд.
- Өнөөдрийн найз нөхөд маргаашийн дайсууд байдаг юм.
- Боль доо!
- Аа, Бошан яах вэ?
- Үгүй нээрээ ,тэгээд?...
- Тэгэхээр болгоомжтой байж үзээрэй.
- Та намайг өөрөө Бошан дээр очих ёстой гэж үзэж байх шив дээ?
- Тиймээ.
- Ганцаараа юу?
- Ганцаараа. Хэрэв хүн нэрээ хичээвэл, түүнийгээ надын дайралтаас хааж өгөх хэрэгтэй байдаг юм.
- Таны зөв ч юмуу даа.
- Би их баяртай байна.
- Би ганцаараа очно.
- Яв яв, гэхдээ ер нь огт очихгүй байсан нь дээр дээ.
- Энэ ч амжихгүй хэрэг ээ.
- Өрөө л мэд, гэхдээ л таны хийх гэж байсан юмнаас дээр л юмсан.
- Хэчнээн болгоомжтой байгаад, яаж ч аргалаад байхад аргагүй тулалдах хэрэг болбол та миний гэрч болох уу?
- Эрхэм бээс, миний танд туслахад бэлэн байдгийг итгэх учрал танд тохиолдсон. Харин та одоо бололцоогүй юм хүсэж байна гэж гүн ноцтой нь аргагүй хэлэв.
- Яагаад?
- Хожим мэдэж магадгүй.
- Тэр болтол яах вэ?
- Тэр хүртэл үүнийг задруулахгүй байгаач, танаас гуйя.
- За яах вэ, Феранц, Шато Рено хоёрыг гуйч.
- Маш сайн. Франц, Шато Рено хоёрыгоо гуй.
- Хэрэв би тулалдах болбол сэлэм, буудлагын хичээл зааж өгөх үү?
- Үгүй, энэ бас бололцоогүй хэрэг. Та ямар хачин хүн бэ! Та ер нь юунд ч оролцохгүй гэж байнаа даа?
- Юунд ч оролцохгүй.
- Тэгвэл энэ тухай яриаа больё. Баяртай гүнтэн!
- Баяртай бээстэн!

Альбер малгайгаа аваад гарч одлоо.

Үүдэнд хөнгөн тэрэг хүлээж байв. Альбер уур хилэнгээ барьж тогтоохыг хичээн Бошан дээр очихоор явав. Бошан сониныхоо газар байж байв.

Альбер сонины газар уруу явлаа.

Сонины газрын бүдэг, тоостой өрөөнд Бошан сууж байв. Ер нь сонины газар ямагт ийм байдаг ер нь ч ийм байх биз.

Альбер де Морсерыг ирлээ гэж түүнд мэдэгдэв.Тэгэхэд нь энэ нэрийг хоёр дахин хэлүүлэв. Дараа нь бас л үнэмшээгүй байсан боловч,

- Ор, ор гэж хашгирав.

Альбер орж ирлээ.

Өошан найзаа хараад гайхан дуу алдав.

Альбер бөөн цаасан дээгүүр алхаж, шалан дээгүүр тавилсан янз бүрийн хэмжээний сонины дундуур эв дүй муутхйаан алхан орж ирэв.

- Наашаа, наашаа гээд гараа Алоьбер өөд сарвайж, - Газрын хаанаас гараад ирэв? Хруун чинээ хүү шиг төөрөд ирэв үү? Эсвэл надтай хамт өглөөний хоол зоглох гэж ирэв үү? Алив сандал олоод суугаач. Тэнд шимтэглэй цэцгийн дэргэд нэг сандал байна. Тэр л ганцхан хавтгай юм бүхэн сонины цаас байдаггүй юм. гэдгийг надад сануулж байдаг юм гэв.
 - Би чухамдаа тэр сониноос чинь болоод л хүчр ирлээ гэж Альбер хэлэв.
 - Та юу? Юу болоо вэ?
 - Би няцаасан залруулга гаргахыг шаардаж явна.
 - Няцаасан залруулга гэнэ ээ? Ямар шалтгаанаар тэр билээ? Алив суугаач!
 - Баярлалаа гэж Альбер шүд зууж хэлээл мэхийн ёслов.
 - Учрыг нь тайлбарлаач!
 - Манай гэр бүлийн нэгэн гишүүний нэр хүндийг хөндсөн мэдээг няцааж хүчингүй болгуулахыг хүсэж байна.
 - За боль доо! гэж гайхаж хоцорсон Бошан хэлээд
 - Ямар мэдээ? Тийм юм байх ёсгүй гэв.
 - Янинээс та нарын авсан мэдээ.
 - Янинээс ий?
 - Тиймээ, миний ярьж байгаа юм»г та ойлгохгүй байна гэж үү?
 - Үнэхээ хэлэхэд мэдэхгүй байна... Алив Батистаа өчигдрийн сонин өгөөч! гэж Бошан хариулав.
 - Хэрэггүй, адад байна.
- Бошан сониныг авч,
- “Янинээс бидэнд бичиж байна” гээд цааш нь уншлаа!
- Бошаныг мэдээг уншиж дуусах үед Морсер,
- Ноцтой хэрэг гэдгийг та ойлгож байгаа биз? гэж хэлэв.
 - Тэр офицер танай хаамтан юм уу гэж сэтгүүлч асуухад Альберийн царай улайж:
 - Тийм гэж хариулав.
 - Та надаар юу хийлгэхийг хүсэж байна вэ? гэж Бошан товчхон асуув.
 - Би няцаавар нийтлүүлэхийг хүсэж байна.
- Бошан Альбер өөд анхааралтай боловч найрсгаар харав. Тэгээд,
- Алив суугаач, ярилцъя. Няцаавар гаргана гэдэг их ноцтой хэрэг. Суу л даа, би энэ мэдээг дахиад нэг уншчихъя гэв.
- Альберийн суухад Бошан найзын нь уур хилэнг бадруусан мэдээг түрүүчийнхээсээ илүү их анхааралтай уншив.
- Танай сонин манай гэр бүлийн нэг хүнийг доромжилсно байгааг та өөрөө харж байгаа биз. Би няцаалт гаргуулахыг шаардаж байна гэж Альбер ширүүн дориун хэлэв.
 - Та... шаардаж байна ий?...
 - Тийм ээ, шаардаж байна.
 - Эрхэм хүндэт бээс, таныг муу дипломат гэж хэлэхийг зөвшөөрнө үү!

- Би дипломат бхйхыг ч хүсэхгүй гэж хэлээд Альбер босож – Би энэ мэдээг няцааж хүчингүй болгож өгөхийг шаардаж бөайна. Би үүндээ ч хүрнэ гэж хэлэхэд нь Бошан ихэмсгээр толгойгоо өндийлгөхийг хараад Альбер шүдээ зууж
- Та миний ямаршуухан шулуухныг ойлгохоор л болсон доо гэж би итгэж байна гэв.
- Морсер, би таны найз нөхөр шүү дээ. Хэрэв та цааш нь ийм байдлаар ярих юм бол би түүнийгээ мартаж ч бас чадн ... гэхдээ боломжтой байхад марга«даад яах вэ... Та сэтгэл хөдөлж, уур чинь хүрсэн байна... тэр Фернанан гэдэг чинь танай юу юм бэ?
- Тэр бол миний эцэг байгаа юм. Фернан Мондего, гүн де Морсер бол хорин удаа тулалдаанд оролцсон, хууичн дайчин хүн. гэтэл түүний сайн сайхан нэрийг бусармаглах гэж байна гэж Альбер хэлэв.
- Танай эцэг ий? Эрхэм Албьер энэ бол өөр хэрэг, би таны уурлаж байгааг ойлголоо... Дахиад нэг уншчихъя... гэж Бошан хэлэв.
Тэгээд уг мэдээг үг бүрийн нь цэгнэн дахин уншив.
- Үгүй, энэ Фернаныг таны эцэг гэж хэлсэн газар хаана байна вэ? гэж Бошан асуув.
- Хаана ч байхгүй, гэсэн ч би мэдэж байна. Бусад хүмүүс үүнийг олж харна. Тийм учраас л би няцаавар гаргуулах гэж шаардаад байгаа юм.
Шаардаад гэдэг үгийг хэлэхэд Бошан Альбер өөд харснаа дахин доошоо харж, минутын хэр юм бодов.
- Та няцаалт нийтэлж өгөх үү? Гэж Альбер улам ууртай боловч биеэ барьсан хэлэв.
- Өгье! Гэж Бошан хэлэхэд Альбер
- За, ашгүй дээ! гэв.
- Гэвч энэ мэдээг худал гэдгийг лавтай мэдсэний дараа шүү.
- Яалаа гэнэ ээ!
- Тийм ээ, энэ бол шалгаж үзвэл зохих ёстой юм байна. Би шалгаж үзнэ.
- Эрхэм минь, энүүнд чинь шалгаад байх юу байгаа юмбэ? Хэрэв та миний эцгийн тухай гэдэг итгэхшүй байгаа юм бол шууд хэлчих. Түүний тухай мөн гэж бодож байгаа бол би тантай тулалдах шаардлага тавих байн гэж Альбер тэсэж ядан хэлэв.
Бошан өөрийн ямар ч байдлаа илрүүлэн гарагж чадд г тэр инээмсэглэлээрээ инээмсэглэв.
- Эрхэм та ингэж ярих таалалтай байгаа юм бол, тулалдахыг шаардах гэж ирсэн юм бол, хагас цагийн туршид сонсож байгаа найз майзын тухай дэмий ярих хэрэггүй шууд л түүнийгээ хэлэх байсан юм. Та бид хоёр ийм байдалд хүрэхийг хүсээд байна уу?
- Та энэ бузар гүтгэлгээ буцааж авахгүй бол тийм!
- Байзаарай! Эрхэм Фернан де Мондего бээс де Морсер, +элдвийн сүрдүүлэлхгүй яриарай. Би ийм сүрдүүлгийг чинь найз нөхдөөсөө байтугай дайснаасаа сонсонхыг ч тэсвэрлэж чаддаггүй юм. Тэгэхээр надад огтхон ч хамаагүй мэдээ болох тэр хурандаа Фернаны тухай мэдээг залруулж хүчингүй болгохыг та шаардаж байгаа юм шив дээ?

- Тийм ээ, би үүнийг шаардаж байна гэж Альбер бүр биеэ барьж чадахаа больж хэлэхэд, Бошан мөн л тайван байдлаараа
- Тэгэхгүй бол тулалдана гэх үү? Гэж хэлэхэд
- Тийм ээ! гэж Альбер дуугаа өндөр болгож хэлэв.
- За тэгвэл өршөөлт эрхэм минь зөвлөгөө имй байна. харин та миний анхаарлыг ийш нь татуулж би энэ мэдээг сонирхох болно. Тийм учраас энэ мэдээ ташаа юм уу, үнэнтэй болохыг нь зохих хүмүүс нотолтол энэ хэвээрээ байх болно гэв.
- Тэгвэл хүндэт эрхэм минь гээд Альбер босож
- Би гэрчийн хүнээ тан дээр ирүүлэх болж байх шив. Та түүнтэй тулалдах газар, зэвсгийн тухай болзож тохирно биз гэв.
- Эрхэм минь, их сайн байна.
- Хэрэв танд таалалтай бол өнөө орой эсвэл хамгийн цаанадаа л маргааш хоёулаа уулзамц.
- Үгүй үгүй Би цагийг нь болохоор л ирүүл тулалдаанд гарч ирнэ. Миний бодвол \та н майг тулалдахаар дуудсан болохоор би саналаа хэлэх эрхтэй биз дээ?\ энэ цаг арай болоогүй байна. Би таныг сэлмэнд сайн гэдгийг мэднэ. Би ч бас чадамгай хэрэглэдэг. Би таныг зургаан сумнаас гуравт нь онодог гэдгийг мэднэ. Би ч бас барагцаалбал тэр зэрэгтэй байх. Та зоригтой хүн. Би ч бас танаас дутахгүй. Тэгэхээр та бид хоёрын хооронд болох тулалдаанд тун ноцтой хэрэг болно. Тийм учраас хангалттай үндэслэлгүйгээр таныг аах ч юм уу өөрөө алагдахыг хүсэхгүй байна. Би одоо харин танаас асууя. Түрүүнд танд хэлсэнчлэн тэр мэдээний тухай би юу ч мэдээгүй, танаас өөр ямар ч амьтны толгойд тэр Фернан гэдэг чинь Морсер гүн байгаа юм гэж орж ирэхгүй гэдгийг танд хэлсэн, одоо ч дахин хэлж байхад намайг няцаавар нийтлэхгүй л бол заавал алахаар тэгтлээ шийдэмгийгээр шаардаж байна уу?
- Тэгж шаардаж байна.
- За яах вэ, эрхэм минь, бие биенийхэ хоолойг огтлохыг зөвшөөрье. Харин тэгэхдээ гурван долоо хоногийн хугацаа шаардаж байна. гурван долоо хоногийн дараа би танд эсвэл: “Тэр худалд мэдээ байж” гэж хэлээд хэлснэ буцааж авна. Эсвэл тэр үнэн байна гэж хэлээд таны шилж сонгосон, сэлмээ хуйнаас нь сугалах ч юм уу буугаа хайрцагнаас нь гаргана.
- Гурван долоо хоног ий? Энэ чинь надад бол нэр төрөө алдсан гурван бүхэл бүтэн үе болно! гэж Альбер дуу алдлаа.
- Хэрэв та бид хоёр найз нөхөд хэвээрээ байсан бол, найз минь тэсвэрлэж үз гэж хэлэх байлаа. Та миний чайсан болсон болохоор эрхэм минь, надад ямар хамаа байх вэ гэж хэлж байна.
- За яах вэ, гурван долоо хоногийн дараа больё. Харин гурван долоо хоногийн дараа ямар ч хойшлуулах шалтаг байхгүй шүү гэж Альбер хэлэв. Тэгэхэд Бошан босож,
- Эрхэм Албьер де Морсер, би таныг гурван долоо хоногоос наана цонхоор гаргаж хаях эрхгүй, та намайг энэ хугацаа дуусахаас өмнө нэвт гаргах эрхгүй. Өнөөдөр наймдугаар сарын хорин есөн. Тэгэхээр есдүгээр

сарын хорин нэгэнд уулзъя. Харин одоо уяаны хоёр нохой шиг бие бие рүүгээ дайраад байх хрэрэггүй гэдгийг эр хүний ёсоор зөвлөө гэв.

Тэгээд Бошан Альеерт мэхийн ёслоод, эргэж хэвлэлийнхээ үйлдвэр лүү оров.

Альбер бөөн цаасанд уураа гаргаж, таягаараа ийш тийш нь тараагаад, хэдэн удаа хэвлэлийн газрын зүг эргэж харсаар гарч одов.

Альбер гэм хоргүй хэвлэлийн цаасандуураа гаргасны дараа таягаараа сүйх тэрэгнийхээ урд уруу ууртайгаар нүдэн цэцэрлэг өнгөртөл Моррель, явж байхыг харав. Моррель, хятадын халуун усны хажуугаар толгойгоо гэдийлгэж нүдээ гялалзуулан Мадлен хэмээх сүмийг чиглэн их л цовоо алхалж явна.

- Аз жаргалтай хүн явж байна! гэж Альбер санаа алдан хэлэв.

Альбер энэ удаа андуурсангүй.

2.НИМБЭГИЙН УНДАА

Моррель үнэхээр аз жаргалтай явж байжээ.

Өвгөн Нуартье түүнийг хүн явуулж дуудуулжээ. Моррель юун ас болон дуудуулсан учрыг мэдэх гэж яаран хөлсний тэрэгнээс өөрийнхөө хөлд илүү найдан алхалж яўсан нь тэр байжээ. Тэр бараг хар гүйхээрээ явж Сан-Оноре хүрэв.

Моррель тамирчин хүний алхаагаар алхлах бөгөөд хөөрхийн Барруа арай ядан гүйцэж явна. Моррель гучин нэгтэй, Барруа жараннастай. Моррель дурлалын сэтгэлээр дүүрч явахад Барруа халууцаж цанган зүдэрнэ. Нас, сонирхлоороо хол зөрөөтэй энэ хоёр хүн гурважингийн хоёр тал шиг үндсээрээ тусгаарлагдаж үзүүртээ нийлжээ.

Үзүүр гэдэг нь Моррелийг бушуу ир гэж хүн явуулсан нуартье бөгөөд Моррель түүнийг нь яг таг биелүүлж Барруад багагүй зовлон болжээ.

Моррель зорьсон газраа хүрээд амьсгаадсан ч үгүй, Түүнийг дурлал давлавчуулж, дурлалын тухай аль хэлийнэ мартсан Барруа хөлс нь гоожчихсон байв.

Хөгшин зарц Моррелийг бидний дээр мэдэх тусгай хаалгаар оруулаад хаалгыг нь түгжсэн бөгөөд удалгүй даашигзны хормой сэвлээх дуулдаж Валентина хүрч ирлээ.

Валентина гашуудлын хувцастай байхдаа ер бишийн сайхан харагдана.

Зүүд нойрондоо байгаа юм шиг санагдан, сэтгэл нь хөөрөн Нуартьетэй ярилцахаар ирснээ ч мартаход бэлхэн байв. Тэгтэл удалгүй зүймэл шалан дээгүүр түрэх тэрэгний дугуйн дуу сонстож өвөгөн хүрэлцэн ирэв.

Валентиан болон өөрийгөө цөхөрлөөс гайхамшигтай сайхнаар аварсанд нь баярлаж байгаагаа Моррелийг хэлэхэд Нуартье тааламжтайгаар чагнана. Дараа нь Моррель, өөрийнхөө ярих цагийг хүлээгээд холхон шиг сууж байсан Валентина өөд асуусан янзтай харав.

Нуартье ч бас түүн өөд харав.

- Би таны да лгасан тэр зүйлийг хэлэх үү? Гэж охин асуусад Нуартье,
- Тэг гэж хариулав.

Валентина өөрийгөө залгих мэт ширтэж байгаа Максимилианд,

- Эрхэм Моррель_ энэ гурван хоногт өвгөн аав танд эхлэх гэсэн зүйлээсээ их олон юм надад хэлсэн Өнөөдөр энэ зүйлээ танд хэлж өгье гэж хүн

явуулсан юм. Өвгөн аав намайг хэлмэрчээр сонгож авсан бөгөө би түүний хэлсэн үгийг гээхгүй бүрэн дамжуулан өгье гэв.

- Би тэсгэлгүй хүлээж байна. Яриахыг хүсье гэж Моррель хариу өгүүлэв.

Валентина зовхио доош буулгалаа. Энэ бол сайны ёр хэмээн Моррельд санагджээ. Валентина аз жаргалтай үедээ л сул дорой байдал үзүүлдэг ажээ.

- Өвгөн аав энэ байшингаас явах гэж хүсэж байна. Барруа түүнд байшин эрж байгаа гэж охиныг хэлэхэд,

- Аа, та яах вэ? Эрхэм Нуартье танд тийм их хайртай шиг, та ч түүнд хэрэгтэй биш үү? Гэж Моррель асццв.

- Би өвгөн ааваас салахгүй. Ингэж шийдсэн. Би түүний дэргэд амьдрах болно. Хэрэв эрхэм де Вильфор зөвшөөрвөл би эндээс даруй явна. Хэрэв түүнийг татгалзвал насанд хүртлээ хүлээх хэрэг болно. Аравхан сар үлдээд байна. Тэгэхэд би хэнд ч хамаагүй чөлөөтэй болно, тэгээд....

- Тэгээд?... гэж Моррель асуув.

- Тэгээд өвгөн аавын зөвшөөрөлтэйгээр, танд хэлсэн үгэндээ хүрнэ.

Валентина сүүлийнхээ энэ үгийг, Моррель маш анхааралтайгаар шимтэн чагнаж байгаагүйсэн бол дуулдахгүйгээр аяархан хэлэв.

- Өвгөн аав аа Үи таны санааг зөв гаргав уу? гэж Валентина Нуартье өөд харж хэлэхэд,

- Тэглээ гэж хариу дохив.

- Намайг өвгөн аавынчаа суухаар эрхэм Моррель миний сай сэтгэлт хүндэт асрамжлагчийн минь дэргэд надтай уулзаж болно. Хэрэв бидний туршлагагүй, гуйвамтгай байж болох сэтгэлийн холбоо өвгөн аавд таалагдвал, энэ нь дараа эрхэм Моррельд намайг гуйх зөвшөөрөл олгож, би түүнийг хүлээж суух болно \Саад бэрхшээл дунд оволзож дүрэлзсэн, зүрх, сайн сайхны үед хөрдөгтгэж ярьдаг\.

- Би имй аз жаргалыг хүртэх ямар юм хийсэн хүн юмбэ? Гэж бурхан лугаа адилаар өвгөний өмнө сөхөрч, чигээ тэнгэр лугаа адилаар Валентинагийн өмнө сөхрөхөд бэлхэн байсан Моррель дуун алдлаа.

Хэрэв биднийг салгаж хагацаах гэж оролдохгүй бол, тэр болтол бид манай эцэг эхийн зоригийг хүндэтгэж явъя. Үүгээр бүх зүйл хэлэгдэж байгаа болохоор бид хүлээж байх болно гэж Валентина тод товир дуугаараа хэлэв.

- Надад ногдож байгаа энэ бүхнийг би дуулгавартайгаар зогсохгүй баяртайгаар биелүүлнжэ гэдгээ андгайлъя хэмээн Моррель өвгөнд хандан хэлэв.

- Ийм болохоор найз минь өнөөдрөөс эхлэн таны нэрийг цэвэр ариунаар авч явахаар заяагдсан тэр хүний нэр төрийг хамгаалан, бодлогогүй юм бүү хийгээрэй хэмээн Валентина Максимилианы зүрхний угт хүртэл харав уу гэлтэй эелдэг зөөлнөөр харан байж хэлэв.

Моррель зүрхэн дээрээ гараа тавилаа.

Нуартье тэр хоёрыг их л эелдгээр харна. Бүх нууцыг мэдэх болсон Барруа духан дээрээ бурзайсан том хөлсийг арчаад инээмсэглэн зогсож байв.

- Хөөрхий Барруа минь бүр ударч орхиж гэж Валентина хэлэхэд,

- Тийм шүү. Би гүйсэн юм чинь. Үнэнийг хэлэхэд эрхэм Моррель надаас хурдан гүйсэн шүү гэж Барруа хэлэв.

Нуартье тавиур дээр байгаа галуун хүзүүтэй нимбэгийн ундаа, шил аяга хоёр өөд харав. Галуун хүзүүт дундуурхан байв. Нуартье өөрөө талыг нь хагас цагийн өмнө уучирсан юм байжээ.

- Барруа минь уу, уу, нүдийг чөинь хараад нимбэгийн ундаа уухыг хүсэж байгааг чинь мэдэж байна гэж Валентина хэлэхэд, Барруа,
- Үнэнээ хэлэхэд би цангаж үхэх нь. Таны эрүүл мэндийн төлөө нэг аяга уучихъя гэв.
- Тэгвэл аваад яв, харин бушуухан эргэж ирээрэй гэж Валентина хэлэв.

Барруа тавиурыг аваад гудамд гарангаа Валентинагийн хийж өгсөн аяга ундааг нэг амьсгаагаар хөнтөрч байр нь дутуу хаасан хаалгаар харагдж байлаа.

Валентина Моррель хоёр Нуартьегийн дэргэд салах ёс гүйцэтгэтэл Вильфорын талын шатан дээр хонх дуугарах сонстов.

Валентина ханы цагаа харав.

- Өдөр дунд болжээ. Өнөөдөр чинь бямба гариг. Өвгөн ааваа эмч ирж байх шиг байна гэж бүсгүй хэлэхэд өвгөн хариуд нь,
- Тийм байх гэв.
- Барруа, Барруа нааш ир гэж валентина дуудахад,
- Очлоо мадмуазель гэж хөгншин зарц хэлэх сонстов.
- Барруа таныг хаалга хүргэж өгөг. За. Одоо эрхэм дарга_, бидний аз жаргалд саад учруулах ямар ч юм бүү хийгээрэй гэж Валентина хэлэв.
- Би хүлээнэ гэж амласан. Хүлээх болно гэж Моррель хэлэв.

Энэ минутанд Барруа орж ирэв.

- Хэн хонх дуугаргав? Гэж валентиа асуухад Барруа хөл дээрээ арай ядан тогтож,
- Эмч -д Авринь гэж хэлэв.
- Барруа Ia яаж байна? гэж Валентина асуув.

Өвгөн юу ч хариулсангүй. Тэр айсан харцаар эзэн өөдөө харж, унахгүйн тулд ямар нэг юмнаас чинэртэл атгасан гараараа түших гэж оролдож байв.

- Энэ хүн одоо ойчих нь! Гэж Моррель дуу алдав.

Үнэндээ ч Барруагийн бие чичрэх нь улам нэмэгдэж байв. Царай нь татавганах нь мэдрэлийн хүчтэй дайрлага дайрсныг харуулна.

Барруагийн зовж шаналж байгааг харсан нуартье ийш тийшээ тэвдэн харах нь сэтгэл түгшүүртэй байгааг илт харуулна.

Барруа эзэн өөдөө алхлав.

- Бурхан минь, бурхан минь, ямар гээч юм болж байна даа? Хамаг бие өвдөж, нүд бүртэлзэж байна. Толгой шатаж байгаа юм шиг л байна. надад бүү гар хүрээрэй, надад бүү гар хүрээрэй! Гэж хэлэв.

Нүд нь бүлтийж, толйго нь гэдийгээд бүх бие нь татавганан чангарна.

Валентина айж хашгирав. Моррель, охиныг нь үл үзэгдэх аюулаас хамгаалах адил тэврэн авав.

- Эрхэм д Авринь, эрхэм д Авринь, наашаа, наашаа туслаач гэж Валентина хашгирав.

Барруа доороо эргээд алхам ухарч гуйван байснаа нуартьегийн өвдөгнөөс барьж хөлийн нь дэргэд унав.

- Эзэн минь! Миний сайн санаат эзэн минь гэж хашхирч байв.

Энэ үед дуу шуугиан болохыг сонссон Вильфор орж ирэв.

Моррель хагас ухаантай байсан валентинаг орхиод тасалгааны мухар уруу гүйж, том хөшигний цаана орж нуугдав.

Вильфорын царай зэвхийрч урдаа байгаа могойг гэнэт харсан юм шиг үхэж байгаа хүн өөд айн ширтэнэ.

Нуартье арга нь барагдан байв. Түүний сэтгэл санаа нь зарц гэхээсээ илүү найз нөхөр нь байсан золгүй өвгөнд туслах гэж тэмүүлж байв. Саагийн гэмд дайрагдсан нүүрэн дээр нь өмнө нь болж байгаа амьдхал үхэл хоёрын аймшигт тэмцэр илрэн духны нь судас бүдүүрч, амьд үлдсэн сүүлчийн нь булчингууд болох нүдийг нь тойрсон булчин хөвчлөн чангарч байв.

Барруа нүүр нь таталдаж, нүд нь цусаар дүүрч, толгой нь гэдийн гараараа шөл самардан хэвтэж байв. Хөшсөн хөл нь нугарсан гэхээсээ хугарсан юм шиг байв.

Уруул дээгүүр нь хөөс сахарч, багтран байв.

Вильфор дөнгөж босго алхангуутаа л харсан энэ үзэгдлэс нүд салгаж чадсангүй, гайхан сандарч зогсов.

Тэр Моррелийг ажигласангүй. Царай нь мэдэгдэм зэвхийрэн минут хэртэй зогсов.

- Эмч! Эмч! Гээд үүд рүү ухасхийж, - Нааш ир, бушуулаарай! Гэж хашхирав.

Валентина шатны бариулаас зууран хойд эхээ дуудан,

- Хатагтай минь, наашаа ир! Бушуулаарай! Үнэртдэг давсаа авчирч өгөөч гэв.

- Юу болоо вэ? гэж хатагтай Вильфор төмөр мэт хатуу дуугаараа асуув.

- Нааш ир, нааш ир!

- Эмч хааччихав аа? гэж Вильфор хашхирав.

Хатагтай Вильфор шатаар аяархан буухад гишгүүрийн нь банз хяхнан дуугарч байв. Нэг гартаа барьсан алчуураар нүүрээ арчиж нөгөө гартаа үнэртэх давстай шил барьжээ.

Хатагтай хаалган дээр хүрч ирээд нуратье өөд харав. Ийм явдлын үед сэтгэл нь хөдөлсөн байлыг эс тооцвол огтын эрүүл саруул байлаа. Дараа нь хатагтай үхэж байгаа хүн өөд харав.

Хатагтайн царай зэвхийрч харц нь зарцаас эзэн өөд шилжив.

- Бурхан минь, эмч хаана байна? гэж Вильфор давтан асуугаад, - Тэр тан дээр орсон. Саа дайрч байгааг харж байгаа биз дээ? Цусыг нь жаахан ханачихвал амийг нь аварч болно гэж хэлэв.

- Ямар нэг юм идчихсэн юм биш биз дээ? гэж хатагтай Вильфор хариут хэлэхээс зайлсхийж хэлэв.

- Өглөөнийхөө хоолыг идээгүй байхад нь өвгөн аав яаралтай юманд явуулсан юм. Тэгээд их ядарсан ирээд, нагц л аяга нимбэгийн шүүс уусан юм гэж Валентина хэлэв.

Тэгэхэд хатагтай Вильфор,

- Яагаад дарс уугаагүй юм бэ? Нимбэгийн ундаа маш хортой шүү дээ гэж хариулав.

- Нимбэгийн ундаан энд өвгөн аавын галуун хүзүүтэд байсан юм. Хөөрхий Барруа юм уух гээд аль гартаа ойр байсныг уучихсан юм.

Хатагтай Вильфор цочив. Нуартье түүнийг учиртай хурц харцаар харав.

- Хүзүү нь ямар богинохон юм бэ? гэж хатагтай дуугарав.
- Хатагтай минь, би танаас д Авринь хаана байна ? гэж асууж байна шүү. Хариулаач бурхан минь! гэж Вильфор хэлэв.
- Тэр Эдуард дээр байгаа. Хүүхдийн бие муу гэж хатагтай Вильфор цааш нь зайлсхийх аргагүй болж хариулав.

Вильфор эмчийг авчрахаар шат өөд гүйв. Хатагтай Вильфор савтай үнэртэх юмаа Валентинад өгч,

-Май, түүнийг ханаж л таарна байх. Би өрөө рүүгээ явлаа, цус харж чаддаггүй юм гэж хэлэв.

Тэгээд хатагтай нөхрийнхөө хойноос гарлаа.

Моррель нуугдаж байсан харанхуй булангаасаа гарч ирлээ. Хөл үймээн дунд түүнийг хэн ч ажигласангүй.

- Максимилиан яв яв. Намайг хэл өгтөл бүү ирээрэй. Яв, яв гэж Валентина хэлэв.

Моррель Нуартьтэй дохиогоор харицлан зөвлөхөд, угийн хатан зоригоо хадгалан байсан Нуартье мөн яв гэж дохив.

Моррель Валентинагийн гарыг зүрхэндээ дараад хажуугийн гудмаар гарч явав.

Энэ үед нөгөө талын хаалгаар Вильфор, эмч хоёр орж ирлээ.

Барруа бага зэрэг ухаан оров. Дайрлага нь өнгөрч, гингэнэж гиншсэн амьтан өрөөсөн өвдөг дээрээ өндийлөө.

Д Авринь, Вильфор хоёр Барруаг жижиг орон дээр хэвтүүлэв.

- Эмч ээ, юу хэрэгтэй байна гэж Вильфор асуув.
- Ус, эфир хоёр авч ир. Танайд эфир бий юу?
- Бий.
- Давирхайн шүүсний тос, бөөлжүүлэх эм хоёрт хүн явуул.
- Бушуухан яваарай гэж Вильфор тушаав.
- Би бас гарах уу? гэж Валентина хулчгардуухан асуухад эмч,
- Тийм ээ, юны өмнө та гарна гэж ширүүн хэлэв.

Валентина түүн өөд гайхан хараад өвгөн аавынхаа духан дээр үнсээл гарав.

Эмч түүнийг гарангуут царай муутай нь аргагүй хаалга хаав.

Эмч ээ, хараач, хараач, ухаан орж байна. Зүгээр зүгээр л ухаан алдсан юм байжээ.

Д Авринь зэвүүнээр инээмсэглээд,

- Бие чинь ямар байна Барруа? Гэж асуув.
- Эрхэм минь, арай дээр байна.
- Та эфиртэй аяга ус уучхаж чадах уу?
- Оролдоод үзье. Харин надад бүү гар хүрээрэй:
- Яагаад тэр вэ?
- Хэрэв та надад хуруугаа ч гэсэн хүргэчихвэл дахиад ухаан алдчихмаар байна.
- Уучих, уучих.

Барруа аягатай усыг аваал хөхөрсө уруулдаа хүргэж хагасыг нь шахам уув.

- Таны хаана чинь өвдөж байна гэж эмч асуув.

- Энд тэднгүй. Хамаг бие л татаад байна.
- Толгой чинь эргэж байна уу?
- Тэгж байна.
- Чих чинь шуугьж байна уу?
- аймшигтай шуугьж байна.
- Хэзээ эхэлсэн юм бэ?
- Дөнгөж саяхан.
- Шууд л эхэлсэн үү?
- Тэнгэр ниргэсэнэ юм шиг л...
- Өчигдөр бие чинь зүгээр байсан уу, Уржигдар бас зүгээр байсан уу?
- Юу ч мэдэгдээгүй.
- Нойр чинь хүрч байсан уу? Ходоод чинь эвгүй оргиж байсан уу?
- Үгүй. Тө өнөөдөр юу идсэн бэ?
- Би юм идэж амжаагүй байна. Дөнгөж сай эрхэм Нуартъегийн галуун хүзүүтээс нимбэгийн ундаан хийэ уусан гэж хэлээд Барруа сандал дээрээ хөдлөлгүй сууж, энэ бүхнээс нэг ч хөдөлгөөн, нэг ч үг гээлгүй чагнаж байсан өвгөний зүг харав.
- Тэр нимбэгийн ундаан чинь хаана байна? гэж эмч сэргэн асуув.
- Доор, галуун хүзүүтэд,
- Доор хаана?
- Гал тогооны өрөөнд
- Би аваад ирэх үү эмчээ гэж Вильфор хэлэв.
- Үгүй, эндээ байж, өвчтөнд үлдсэн усыг нь уулгахыг оролдож бай.
- аа, нимбэгийн шүүс?
- Би өөрөө явна.

Д Авриньи үүд рүү гүйж хаалга онгойлгоод нууц шатаар мөн гал тогоо руу бууж явсан хатагтай Вильфорыг арай л дайрчихсанши буув.

Хатагтай дуу тавилаа.

Д Авриньи үүнийг анхаарсан ч үгүй. нэгэн зүйлд санаа нь автагдсан эмч сүүлийн гишгүүрийг гишгэлгүй үрсэн буугаад гал тогооны өрөөнд орж, дөрөвний гурав ньхоосон болчихсон галуун хүзүүт тавиур дээр байхыJ харав.

Тэгээд олз уруугаа дайрах бүргэд мэт түүн өөд ухасхийв.

Хүндээр амьсгаадан нэгдүгээр давхарт гарч, Нуартъегийн өрөөнд буцаж оров.

Хатагтай Вильфор энэ үед өөрийнөө өрөө өөд алгуурхан өгсөж явав.

- Энэ өнөөх галуун хүзүүт мөн үү? Гэж эмч асуулаа.
- Мөн, эрхэм эмч гуай.
- Мөн байх аа.
- Ямар амттай байсан бэ?
- Гашуун амттай байсан.

Эмч хэдэн дуслыг алган дээрээ хийгээд уруулаараай сорж дарс амтлан үзэж байга юмшиг амандаа хэсэг байлгаж байгаад задгай зуух уруу нулимчихлаа.

- Энэ мөн байна. Эрхэм нуартъе та үүнээс бас уусан уу? гэж асуухад өвгөн,
- Тэгсэн гэж дохив.
- Таныг уухад бас л гашуун амттай байсан уу?

- Тийм.
- Эрхэм эмч минь, дахиад бие муудлаа! Өршөөлт бурхан минь намайг өрөвдөөч! Гэж Барруа хашхирав.

Эмч өвчтөн өөд ухасхийв.

- Вильфор өнөө бөөлжүүлдэг эм чинь хаана байна?

Вильфор тасалгаанаас гүйж гараад,

- Бөөлжүүлэх эм хаана байна? Авчрав уу? гэж хашхирав.

Хэн ч хариу дуугарсангүй. Хүн бүр энэ аймшигт явдалд автагджээ.

- Хэрэв Би уушгинд нь агаар оруулж чадвал хоолойг нь боочихоос аварч болмоор байна. Юу ч байхгүй гэж үү? Юу ч байхгүй гэнэ ээ? гэж эмч ийш тийш сандчин харж асуув.

- Эмч минь, намайг бүү үхүүлээч! Би үхэх нь, бурхан минь, үхэх нь гэж Барруа хашхирав.

- Үзэг! Үзэг байхгүй юу? гэж эмч асууснаа ширээн дээр үзэг байхыг харав.

Тэгээд татавгана. Эвхэрсэн өвчтөний аманд үзгээ шугуулахыг оролдов. Гэвч эрүү нь чанга зуурчихаа үзэг орж өгсөнгүй.

Барруа түрүүчийнхээс нь илүү хүчтэй дайрлага дайрав. Орон нээрээс гулсан унаж, шалан дээр хөдөлгөөнгүй хэвтэв.

Эмч яагаад ч туслахаасаа өнгөрсөн болохоор дайрлагын нь эрхэнд үлдээгээд Нуартъед дөхөж очлоо.

- Таны бие ямар байна? Зүгээр үү? Гэж шивгэнэн асуув.

- Тийм,

- Ходоод чинь хүндгүй байна уу?

- Үгүй. Ням гариг бүр ууж байгаарай гэж өгсөн эмийг уусны дараах шиг л байна уу?

- Тийм.

- Тэр нимбэгийн ундааг танд хэн бэлтгэж өгсөн бэ? Барруа юу?

- Тийм.

- Та түүнийг ундаа уу гэсэн үү?

- Үгүй.

- Эрхэм Вильфор уу?

- Үгүй.

- Хатагтай Вильфор уу?

- Үгүй.

- Тэгвэл Валентина юу?

- Тийм.

Барругийн хүндээр санаа алдах, эрүү нүд нь тачигнах нь Д Авриньи-ийн анхаарлыг татаж тэрээр өвчтөн уруу яаран гуйв.

- Барруа, та юм ярьж чадмаар байна уу? гэж хэлэхэд цаадах нь үл ойлгогдох хэдэн үг бувтнав.

- Найз минь биеэ хүчилж үз.

Барруа цус хурсан нүдээ нээв.

- Энэ нимбэгийн ундаа хэн бэлтгэсэн бэ?

- Би өөрөө

- Та бэлтгэчихсэн доороо эзэндээ аваачиж өгсөн үү,

- Үгүй.
- Тэгвэл хаана үлдсэн бэ?
- Шүүгээнд үлдсэн. Намайг дуудсан.
- Хэн түүнийг нааш нь авчирсан бэ?
- Мадмуазель Валентина

Д Авринь гараараа духаа илбэж,

- Бурхан минь гэж шивгэнэв.
- Эмч ээ, эмч ээ! хэмээн дахиад дайрлага дайрахыг мэдсэн Барруа хашхирав.
- Бөөлжүүлэх эм яагаад авчирч өгөхгүй байна вэ? гэж эмч асуухад тасалгаанд орж ирсэн Вильфор
- Энэ байна гэлээ.
- Хэн бэлтгэсэн юм бэ?
- Эмийн санч бэлтгэсэн, надтай хамт Снд ирээд байна.
- Уугаарай.
- Чадашгүй нь ээ эмч минь, хожимджээ! Хоолой боогдож бүтэж үхэх нь!... Зүрх... толгой... ямар зовиуртай юм бэ?... Би ингэж удаан зовох юм болов уу?
- Үгүй найз минь, таны хажууд удахгүй төгсгөл болно.
- Би мэдэж байна аа! Бурхан минь намайг өрөвдөж хайрлаач! Гэж золгүй амьтан дуу алдав.

Тэгснээ дахин дуу тавиад цахилгаанд цохиулсан мэт нам унав.

Д Авринь зүрхэн дээр нь гараа тавиад уруул дээр нь толь барьж үзэв.

- За яав? Гэж Вильфор асуув.
 - Надад нэг жаахан нил цэцгийн ханд одоохон аваад ир.
- Вильфор тэр дороо гал тогооны өрөө рүү буулаа.
- Эрхэм Нуартье, бүү айгаарай. Би өвчтөнийг хажуугийн өрөөнд оруулаад цусыг ханаж үзье. Ийм дайрлага гэдэг чинь аймшигтай зүйл байгаа юм шүү гэж Д Авринь хэлэв.

Тэгээд Барруаг өргөж хажуугийн өрөөнд оруулав. Гэвч тэр дороо эргэн орж ирээд нимбэгийн ундааны үлдэгдлийг аваад явав.

Нуартье баруун нүдээ аньчихсан байв.

- Валентинаг дуудах юм уу? Та Валентинаг ирүүлэх гэж хүсэж байна уу?
- Вильфор шатаар буцаж явахад д Авринь түүнтэй гудамд уулзлаа.
- За яах вэ? гэж Вильфор асуухад, д Авринь,
 - Тийшээ явъя гэж хэлэв.

Тэгээд түүнийг Барруагийн байгаа тасалгаанд дагуулж авчрав.

- Ухаангүй, хэвээрээ байна уу? гэж вангийн прокурор асув.
- Үгүй дээ, үхчихсэн.

Вильфор толгойгоо атгаж, гуйван ганхаад үхсэн хүн өөд харж, үнэхээр санаа зовсон байдалтайгаар,

- Ийм гэнэтхэн үхчих гэж дээ! гэж дуу алдав.
- Дэндүү гэнэт байна, тийм ээ? Гэвч энэ явдлыг та гайхах хэрэггүй. Сен-Меранууд бас л ингэж гэнэт үхсэн. Ер нь, танай гэрт түргэн үхээр байна шүү гэж д Авринь хэлэв.

- Яалаа гэнэ ээ! гэж вангийн прокурор айж цочсон дуу алдаад, - Та нөгөө аймшигт санааг дахин хэлж байна уу? гэлээ.
- Тийм ээ, эрхэм минь гэж д Авринь дийлсэн хүний янзтай хэлээд – Тэр санаа надаас нэг ч минут салдаггүй байсан юм. Таныг өөрийнхөө үгэнд итгүүлэхийн тулд анхааралтай чагнаж байгаарай гэж хүсэх байна гэв.

Вильфорын бүх бие дагжин чичирлээ.

- Бараг ямар ч ул мөр үлдээлгүй алж чаддаг хор байдаг юм. Би тийм хорыг сайн мэднэ. Би түүний бүх илрэл, хор нөлөөг сайн судалсан юм. Энэ хорын үйлчилгээг хатагтай Сен-Мераныг амьсгаа хураах үед харсны адил бас сая харлаа. Энэ хор байгааг үнэмшин мэдэх арга байдаг юм. Ямар нэг хүчлээр улаан өнгөтэй болгочихсон лакмусын цаасыг буцааж хөх өнгөтэй болгох ба нил цэцгийн хандыг ногоон өнгөтэй болгон хувиргадаг юм. Бидэнд одоо лакмусын цаас алга гэхдээ, нилийн ханд аваад ирэх шив.

Гудамд хөлийн чимээ дуулдахад эмч хаалга онгойлгоод зарцын авчирч өгсөн хоёр, гурван халбага хандтай савыг аваад дахин хаалгаа хаав.

- За хараарай гэж эмч зүрх нь галзуу мэт цохилж байгаа вангийн прокурор өөд харж хэлээд, - Энэ галуун хүзүүтэд Нуартье Барруа хоёрын уусан нимбэгийн ундаатай үлдэгдэл, энэ аяганд нил цэцгийн ханд байна. Хэрэв энэ нимбэгийн ундаа ямар ч хольцоо байхгүй, хоргүй бол хандны хөх өнгө өөрчлөгдөхгүй, хэрэв нимбэгийн ундаа хордогдсон бол хандны өнгө ногоон болно. За харж байгаарай гэв.

Эмч алгуурхнаар галуун хүзүүтэд байсан нимбэгийн ундааг аяганд хийгээд орхитол аяганы ёроолд байсан ханд бүдгэрч булингартав. Эхлээд индранил шиг хөх болчихов. Тэгээд өнгө нь хувирсаар, хувирсаар оюу шиг ногоон болоод тэр чигээрээ хоцров.

Сайхь туршлагад эргэлзэх юм байсангүй.

- Хөөрхийн Барруа хуурамч ангостур ч юм уу, гэгээн игнатнийн самраар хийсэн хороор хордож талийгаач болжээ. Би одоо бурхан, хүмүүсийн өмнө тангараглахад ч бэлэн байна гэж д Авринь хэлэв.

Вильфор юу ч дуугарсангүй. Тэр гараа тэнгэр өөд өргөж айж нүдээ бүлтийлгээд сандал дээрээ цохигдсон мэт уналаа.

3.Ял

Энэ нүгэлт тасалгаанд хоёр дахь хүүр нь болчих дөхсөн вангийн прокурорыг д Авринь зэгсэн түргэн сэхээ оруулав.

- Миний гэр үхлийн гэр болжээ! Гэж Вильфор гингэнэхэд эмч,
- Бас гэмт хэргийнх гэж хэлэв.
- Одоо миний дотор юу болж байгааг танд гаргаж хэлэх үг алга. Айх, тарчлах, ухаан солирох үэрэгцээд байна гэж Вильфорыг дахин гингэнэхэд,
- Тийм ээ, бид одоо хөдөлж эхлэх болсон. Үхлийн энэ урсгалыг зогсоох цаг болсон шиг санагдаж байна. Энэ үрэгдсэн гэмгүй хүмүүсийн өшөө авагдана гэж итгэх найдваргүй болохоор би л хувьдаа ийм нууцыг хадгалж явж чадахгүй гэж эмч тайвнаар хэлэв.

Вильфор баргар хүйтэн харцаар тасалгааг эргэн тойрон хараад,

- Миний гэрт үү дээ! Миний гэрт шүү! гэж шивгэнэв.

- Вильфор та миний хэлэхийг сонс. Эр хүн шиг байх хэрэгтэй. Хууль сахиулагч таны нэр төр таныг хорихол хүлээхийг шаардаж байна гэж д Аврины хэлэв.
 - Өөрийгөө хохиролд учруулна гэдэг чинь муухай үг байна даа!
 - Тийм ээ, ингэх л хэрэгтэй болж байна.
 - Тэгэхээр та хэн нэгийг сэжиглэж байгаа юм уу?
 - Би хэнийг ч сэжиглээгүй, танай гэрийн хаалгаар эрлэг орж ирээд өрөөнөөс өрөө дамжин сохроор биш ухаан бодлоготойгоор явж байна. Харин би түүний мөрийг мөшгин дагаж, явсан замыг нь харж байна. Би хуучны мэргэн үгэнд итгэдэг. Би тэмтэрч явна. Танай гэр бүлтэй эв найрамдалтай явдаг маань, таныг хүндэтгэн үздэг маань миний нүдийг халхалж байгаа хочр боолт байж, гэтэл ингээд л...
 - Эмч ээ, ярь ярь, би таны хэлэхийг дуулахад бжэлхэн байна.
 - Танай байшинд, магадгүй танай гэр бүлд юм уу, зуун жилд нэг удаа төрдөг тийм аймшигтай амьтан нуугдаж байна. Локуста, Агриппина хочр нэг үед амьдарч байсан. Энэ бол онцгой тохиолдол. Энэ бол өчнөөн төчнөөн хорт үйлээр бузарлагдсан Ромын эзэнт улсыг устгах гэж дээд тэнгэр хичнээн хүсэж байсныг нотолж байна. Брунгильда Фрегонда хоёр бол үүсэн хөгжиж байсан соёлт ёс дотоод сэтгэхүй, муу юмтай нөхөрлөсөн хэдий ч танин мэдэх гэж эрмэлзэж байсан нөр их зовлонгийн илрэл юм. Тэд цөм залуу сайхан хүүхнүүд байсан. Танай гэрт байгаа тэр ялт хэрэг үйлдэгч хүүхнийг нүүрэн дээрх гэмгүй, ариун тунгалаг байдал бас тэдний царайд ч цагтаа байж байсан юм шүү.
- Вильфор «уу алдаад хоёр гараа атган эмч өөд гуйсан байдалтай харав.
- Гэвч цадаах нь хайр найргүй үргэлжлүүлэн,
- Гэмт явдал хэнд ашигтай б йсан гэдгийг эрхэ хэрэгтэй гэж хуулийн зүйл ангид байдаг шүү дээ.
 - Эмч ээ! Хүн төрөлхтний шударга үнэний шүүх хэчнээн удаа энэ үгэнд хууртсан гэж санана! Би сайн мэдэхгүй байна. Гэвч энэ гэм хэрэг... гэж Вильфорын хэлэхэд эмч
 - Та үүнийг гэмт хэрэг гэж үзэж байх шив дээ? гэлээ.
 - Тийм ээ тэгж үзэж байна. Өөрөөр би яах ч юм билээ? Гэвч намайг гүйцэд хэлүүлээд орхи. Би энэ гэмт хэргийн гол хохирогч нь гэж надад санагдаж байна. Энэ бүх нууц үхлийн ард миний сүйрэл нуугдаж байгаа юм.
 - Хүн бол амьд амьтдын дотроос хамгийн хувиа хичээсэн, биеэ тоосон амьтан бхйгаа юм! Зөвхөн өөрт нь зориулж наран гийгүүлж, дэлхий ертөнц эргэлдэж, үхэл зовлон дайрч байдагн юм шиг санадаг. Өвсний толгой дээр гарчхаад бурхныг хараан зүхэгч шоргоолжны үлгэр бий! Гэтэл амь алдсан хөөрхий авгай, нөхөр Сен-Мераныг, бас эрхэм Нуартыег... гэтэл дуу алдаж,
 - Яалаа гэнэ ээ? Эрхэм Нуартые юу? гэв.
 - Тийм ээ! Та тэр золгүй үарцын амь насыг хөнөөх гэлээ гэж санасан юм биш биз дээ? Үгүй, Шекспирийн нөгөө Полоний шиш л өөр хүний орноос үхчихсэн юм. Тэр нимбэгийн ундаа Нуартые уух ёстой байсан юм. Нуартые

түүнийг нь уул нь уусан. Харин зарц бол санаандгүй уусан байна. Уг нь Баррау биш Нуартье үхэх ёстой байсан юм.

- Тэгээд миний эцэг яагаад үхсэнгүй вэ?
- Хатагтай Сен-Мераныг талийгаач болсон тэр үдэш цэцэрлэгт учрыг танд хэлсэн билээ. Түүний бие энэ хорыг хэрэглэж дассан байсан учраас тийм байгаа юм. Түүнийг алж дийлэхгүй байгаа тун өөр хэнийг ч алчихаж чадна. Энэ дэлхий дээр хэн ч, тэр ч байтугай алуурчин ч эрхэм Нуартыег бруцин буюу гожилоор эмнэж байсныг мэдэхгүй. Харин алуурч бол гожилийг хүчтэй хор гэдгийг туршлага дээр мэдсэн.

- Бурхан минь! гэж Вильфор гараа атгалан хэлэв.
- Алуурчийн ажиллагааг мөрдөн дагаад ирье. Эхлээд бээлийг алсан...
- Эмч ээ!
- Би үүнийг батлахад бэлэн байна. Түүний үхлийн тухай надад ярьсан зүйл миний нүдээрээ үзсэнтэй минь яг ницэж байна.

Вильфор түүнээс зөрж маргалдахаа больж, зүгээр гиншиж байв.

- Тэр бээлийг алсан, дараа нь хатны нь алсан. Энэ бол түүнд хоёр давхар өв хөрөнгө үлдэж байгаа хэрэг гэж эмч давтан хэлэв.

Вильфор духан дээрээ урссан хөлсийг арчив.

- Та анхааралтай чагнаж байгаарай.
- Таны хэлсэн үг бүхнийг дуулж ббайна.
- Эрхэс Нуартье таныг ба танай гэр бүлд хөрөнгөнөөсөө юу чүлдээлгүй ядуучуудад шилжүүлэхээр гэрээсэлсэн байсан. Тэгэхэд эрхэм Нуартыегаас горьдох юм байгаагүй учир зүгээр хорисон. Харин анхныхаа гэрээслэлийг хүчингүй болгож хоёр дахь гэрээслэлийг хиймэгу гэм хэргийн эзэн гурав дахийгаа хийчих бий гэж болгоомжлон хорлосон байна. Уруигдар гэрээсэлэл хийсэн байх аа. Цаг алдахгүй байгааг нь харж байгаа биз.

- Д Авринь мин хайрлаж үзээч!
- Ямар ч хайрлах юм байхгүй эрхэм минь. Эмч хүнд ариун гэгээн үүрэг байдаг. Үүний төлөө амьдралын эх булаг өөд өгсөж үхлийн харанхуй уруу бууж ирдэг юм. Гэмт хэрэг үйлдэгдэж, бурхан тэрхүү гэмт хэргээс нүүр буруулаад эмч хүн тэр байна гэж зааж өгөх үүрэгтэй!

- Охиыг минь хайрлаач! Гэж Вильфор шивгэнэхэд эмч,
- Та түүнийг өөрөө нэрлэх шив гэлээ.
- Валентинаг минь хайрлаач! Үгүй тийм байх ёсгүй. Би түүнд ял тулгахаас өмнө өөртөө ял тулгана! Валентина бол сүүн цагаан сэтгэлтэй, гэм халгүйн ариун дагина биеэрээ мөн билээ!

- Эрхэм вангийн прокурор минь, хайр найр гэж байж болохгүй. Эд мөрийн баримт нүүрэн дээр ил байна. Бээл де Сен-Меранд явуулсан эмийг Валентина өөрөө боосон, тэгээд бээл өөд болчихсон.

Мадмуазель де Вильфор Мен-Меран хатагтайд уух усыг нь бэлтгэж өгсөн. Хатагтай бас л талийгаач болсон. Мадмуазель де Вильфор өглөө бүр Нуартыегийн уудаг нимбэгийн ундааг Барруагийн гараас авч авчирч өгдөг. Харин эрхэм Нуартье ид шидээр аврагдсан.

Мадмуазель де Вильфор бол гэмт этгээд, хор уулгагч мөн! Эрхэм вангийн прокурор аа, би мадмуазель де Вильфорт ял тулгаж байна. харин та өөрийн үүргийг гүйцэтгээрэй.

- Эмч минь, би тантай маргалдахгүй. Танд итгэж байна. Харин намайг бүү алаач, нэр төрийг минь бүү хөөдөөч!
- Эрхэм Вильфор гээд эмч улам ширүүнээр – Тэр тэнэг явдалтай эвлэрч болох цаг үе байсан. Хэрэв таны охин ганцхан хэрэг хийчихсэн бол би хлёр дахийгаа хийх нь гэж мэдээд танд түүнэSc болгоомжилж бай, амьдралынраа үлдсэн хагасыг нулимсаараа урьдынхаа нүглийг на танчилж өнгөрүүлэг хэмээн сүмд суулга гэж хэлэх байсан. Хэрэв хоёрхон удаа хорлоод зогссон бол би танд, май хор нь энэ байна. Үүнийг эсэргүүцэх хор гэж байхгүй. Энэ бол ухаан бдол шиг түргэн, цахилгаан шиг эгшин зуурын, тэнгэрийн дуу шиг ниргэдэг хор байгаа юм. Энэ хорыг өөрт нь өгөөд бурхан тэнгрэрт сүнсийг нь даатгаж нэр төр, амьдралаа авран хамгаалж үз. Тэгэхгүй бол танд өөрт чинь халдана шүү гэж хэлэх байсан. Тэр охин хуурмаг инээдмээр инээмсэглэж, хуурмаг зөөлөн үг хэлсээр таны орны толгойд дөхөж явна! Та түрүүлэхгүй бол танд гай болно шүү! Хэрэв хоёрхон хүн алсан бол танд хэлэх байна. Гэтэл тэр охин тарчлан үхэж байгаа гурван хүн үзэж, гурван хүний хүүрийн дэргэд өвдөг сөхрөн байсан_ Хордуулагчийг алуурчийн гарт өг! Та өөрийн нэр төрийн тухай ярьж байна. Тэгэхлээр миний хэлж байгаа бүхнийг хийж нэр алдраа мөхнжүүлж ав! гэж хэлэв.

Вильфор мөхрөн унаж,

- Надад тан шиг зориг алга. Гэвч миний охины тухай биш, таны охины тухай хэрэг байсан бол танд ч гэсэн ийм зориг байхгүй байсан биз гэв.

Д Авриньи царай цонхийв.

- Эмч ээ, эмэгтэй хүнээс төрсөн хүн бүр үхэл зовлон эдлэх үйлтэй бахйдаг. Би зовж зүдрэн, үхэх цагаа хүлээе.
- Болгоомжтой байгаарай. Тийм ч түргэн болохгүй байх шүү. Тэр цаг таны нүдэн дээр эцэг чинь, эхнэр хүүхэд чинь үхсэний дараа ч ирж магадгүй юм шүү гэж д Авриньи хэлэв.

Вильфор амьсгаадан эмчийн гараас барьж,

- Намайг өрөвдөөч... надад туслаач... Үгүй, миний охин буруутай хүн биш... Бидний шүүхийн өмнө аваачсан ч би миний охин гэм буруугүй гэж хэлнэ... Миний гэрэт гэмт хэрэг болоогүй... Миний гэрт гэмт хэрэг гарахыг би хүсэхгүй... Яагаад гэвэл айл гэрт гэмт хэрэг болоход бас л үхлийн адил ганцаар зогсдоггүй юм. Би аллагын золиос болох нь танд ямар пад байна аа?... Та миний найз гэж үү? Та хүн гэж үү? Танд зүрх байна гэж үү? ... Үгүй ээ, та бол эмч!... Үгүй, би охиноо алуурчдын гарт өгөхгүй!... Энэ бодол зүрхийг минь бачимдуулж, би солиотой амьтан шиг хумсаараа цээжээ урагнаа ч бэлхэн байна!... Хэрв та ташаарч байвал яана? Хэрэв охин минь биш, өөр хүн байвал яах вэ? хэрэв би нэгэн сайхан өдөр хий үзэгдэл шиг зэвхий царайлан тан дээр ирж: алуурчин чи, Миний охиныг алсан гэж хэлбэл яана! Хэрэв тийм явдал тохиолдвал... би христос шашинтан хүн... гэхдээ би өөрийгөө алчихна даа гэж Вильфор хэлэв.

- За сайн гээд эмч бага зэрэг бодолхийлж байснаа – Би хүлээж байя гэж хэлэв.

Вильфор түүн өөд итгэлгүй харав.

- Харин танайд хүн өвдөх ч юм уу танд өөрт чинь саа дайрч байх шиг санагдвал над уруу хүн бүү явуулаарай. Би рэхгүй шүү. Би тантай энэ нууцыг хуваалцахад бэлэн байгаа боловч танайд хорт аллага уй гашуу олширч байгаагийн адил миний сэтгэлд ичгүүр зовиур оршин байхыг хүсэхгүй гэж д Авринь хэлэв.
- Эмч та, намайг хаяж байна уу?
- Тийм ээ та бид хоёр цаазын давцан хүртэл хамт явлаа. Одоо цааш зам нийлэхгүй нь байна. Одоо дахин нэг удаа илчлэх хэрэг болбол энэ аймшигт эмгэнэлт явдлын төгсгөл болно. Баяртай.
- Эмч минь гуйя танаас!
- Энд болж байгаа юм бүхэнд миний дургүй хүрч байна. Би таны гэрийг үзэн ядаж байна. Баяртай эрхэм минь.
- Эмч ээ, ганцхан үг хэлчихье! Таны хэлснээс хойш улам аймшигтай болж байгаа энэ байдлалд намайг ганцааранг минь орхиж байгаа юм уу. Хөөрхий Барруагийн үхлийн тухай юу гэж хэлэх вэ?
- Таны хэлдэг зөв. Намайг гаргаж аль гэж д Авринь хэлэв.

Эмч түрүүлж, Вильфор түүнийг дагаж гарав. Сандарч тэвдсэн зарц нар гудам, эмчийн явж өнгөрөх ёстой шатан лээр бөөгнөрч байв. Тэгэхэд л Авринь бүхэнд дуулдахаар Вильфорт,

- Эрхэм минь, хөөрхий Барруа сүүлийн жилүүдэд дэндүү суумгай амьдралаар амьдарч иржээ. Эзэнтэйгээ хамт бүх Европоор морьтой, тэрэгтэй явж дасчихсан хүн чинь сандлаас босож чадахгүй өвчтөн хүнийг сувилж байсан нь түүнийг алчихлаа. Цус нь царцаж, бүдүүн хзүүтэй махлаг хүн байсан учир дайрлага дайрч, та нар намайг дэндүү өнгөрсөн хойно дуудсан байна гэж хэлснээ нил цэцгийн хандыг пийшинд асгахаа бүү мартаарай гэж шивгэнэв.

Тэгээд эмч Вильфорт гараа ч өгсөнгүй, хэлсэн үгээ эргэж давтсангүй, зарц нарын уйлаан майлаанаар үдүүлэн гарав.

Тэр оройдоо Вильфорын бүх зарц гал тогооны өрөөнд цугларч, өөр хоорондоо ярилцаад хатагтай Вильфор дээр очиж чөлөөлөн явуулж өгөхийг гуйв. Тэднийг ятгаж ухуулж, хөлсийг нь нэмнэ гэж хэлээд ч болсонгүй. Тэд зөвхөн л:

“Энэ байшинд үхэл шүглэсэн болохоор бид явахыг хүсэж байн” гэж шаардав.

Хэчнээн гуйж гувшсан боловч хайхралгүй, харин ийм сайн сэтгэлт эзэд ялангуяа эелдэг зөөлөн Валнетинагаас салж хагацаж явахдаа харамсалтай л байна гэж хэлээд явцгаажээ.

Вильфор энэ үгийг дуулаад Валентина өөд харлаа.

Бүсгүй уйлж байв.

Вильфор хэдийгээр энэ нулимсыг хараад сэтгэл түшсэн боловч хатагтай Вильфор өөд харлаа. Тэгэхэд түүний уруул дээр дуутай борооны хар үллний дундуур зүсэн өнгөрөх аймшигт солир адил эгшин зуурын хүйтэн инээмсэглэл тодрох шиг санагджээ.

4.БИЕ АМАР СУУГАА ТАЛХЧНЫ СУУЦ

Морсер гүн, өөрийгөө хүйтнээр хүлээж авсан явдлаас болж мэдээж ичиж зовон, уур нь хүрч, уушги нь сагсайсан амьтан Дангларынхаас гарч явсан тэр өдрийн үдэш Андреа Кавальканти үсээ засуулж, сахлаа мушгин янзлаад, бариухан цагаан бээлий хийж ганц хүний тэргэн дээрээ бараг зогсоогоороо явж Шоссе-д Антен дахв банкны эзний гэрт давхиж очив.

Тэгээд зочдын өрөөнд бага үэрэг эргэлдэж байснаа тохиромжтой мөчийг ашиглан Дангларыг хажуу тийш нь дуудаж аваачин их л чадмагаар тал засаж хэдэн үг хэлснийхээ дараа сайн сэтгэлт аавыгаа явснаас хойш сэтгэл хий зовон байгаагаа ярив. Тэгээд эцгийгээ явснаас хойш төрсөн хүү шигээ үзэх болсон банкны эзний гэрт, хүн бүхэн шунал тачаалаас дээрд тавих тэрхүү жаргалын эр ундраа болох бүх зүйл байгаа хийгээд түүнийг мадмуазель Дангла^оын сайхан нүднээс олж авах хувь зохиол өөрт нь ногдож байгаа тухайгаа ярив.

Даглар түүний үгийг ихэд анхааралтай сонсов. Энэ үгийг хэлэх байх гэж хэдэн өдөр хүлээж байсан бөгөөд ингээд цаг нь болоход Морсерын үгийг сонсоод хачин хүйтэн царайлсныхаа хэрээр баясан баярлаж, царай нь гэрэлтэв.

Гэвч залуу хүүгийн хэлснийг хүлээн авахаасаа өмнө зарим нэг эргэлзсэн байдал үзүүлэх нь зүйтэй гэж үзэж,

- Бээс та гэрлэх тухай бодоход дэндүү залуу байгаа юм биш үү? Гэв.
- Өчүүхэн ч үгүй, эрхэм минь гэж Кавальканти зөрж хэлээд, - Италийн дээдсийн гэр бүлд багаасаа гэрлэх явдал заншил болсон зүйл. Их ухаалаг заншил юм шүү. Амьдрал гэдэг хувирамтгай болохоор аз жаргалыг гарт дайралдсан цагт нь л барьж авах хэрэгтэй гэв.
- Надад их л таалагдаж байгаа таны энэ хүслийг эхнэр охин хоёр маань сайн хүлээн авлаа гэж бодъё. Тэгээд бид ажил хэргийн талыг нь хэнтэй хэлэлцэх вэ? Энэ чухал асуудлыг эцгүүд л хүүхдийнхээ сайн сайхны төлөө зүй ёсоор шийдвэрлэж чадах байх гэж Данглар хэлэв.
- Миний аав ухаантай, бодлоготой хүн байгаа юм. Тэр намайг Францад эхнэр авах магадгүй гэдгийг урьдаас бодсон байна билээ. Тийм учраас явахдаа миний хувийн баримт бичгүүдийн хамт, хэрэв гэрлэлтийг сайшаавал хурим хийсэн өдрөөс эхлэн жил бүр зуун тавин мянган ливр өгч байна гэж үүрэг авсан захидал үлдээсэн байна билээ. Энэ бол минийхээр эцгийн орлогын дөрөвний нэг хувь нь болж байгаа юм.
- Өө, би бол охиныхоо инжинд таван зуун мянган франк өгнө гэж боддог юм. Түүнээс гадна миний охин бол ганц өв залгамжлах хүн маань шүү дээ.
- Хэрвээ мадмуазель Эжени, хатагтай Данглар хоёр миний хүслийг татгалзахгүй бол бүх зүйл сайн сайхан болох нь байна даа. Бидэнд жилд зуун далан таван мянган франкийн орлого олох нь байна. Би бээлсийг надад түрээс төлөлгүй, харин үндсэн хөрөнгөө шууд өгөхийг гуйна даа \Энэ амаргүй хэрэг, гэвч бүтэж магадгүй\.
- Тэр үед та бидний хоёр гурван саяыг эргэлтэд оруулж болно. Тийм хэмжээний мөнгө туршлагатай хашир хүний гарт орохоороо ямагт арван хувийн орлого оруулж байх болно.
- Би дөрвөн хувь өөрөөр хэлбэл гурван хувь хагасаас илүү төлдөггүй. Харин хүргэндээ бол таван хувиар төлж, орлогоо хувааж авна гэж банкны эзэн хэлэв.

- Ай даа, аав минь сайхан хэрэг дээ гэж Кавальканти хэдийгээр язгууртны байдалтай байхыг хичээх боловч хааяа сурсан юмыг сураар боож болдоггүй болохоор бага зэрэг бүдүүлэг байдлаа гарган хэлэв.

Гэвч тэрхэн доороо санаа аван түгдрээд

- Уучлаарай түшээ гүнтэн зөвхөн энэ горьдлого маань л ухаан алдуулчих гээд байгааг хар! байгаа биз дээ . Хэрэв хүсэл минь биелбэл яах бол? гэв.

Тэгэхэд Данглар анхандаа харамгүй эхэлсэн энэ яриа яаж ажил хэргийн чанартай болсныг ажигласангүй.

- Гэхдээ таны эцэг танаас татгалзаж чадахгүй хөрөнгө байдгийг бодох хэрэгтэй гэв.
- Тухайлбал ямар? Гэж Андреа асуув.
- Таны эхэд байсан хөрөнгийг хэлж байна.
- Өө тийм л дээ. Миний ээж Оливе Корсарынх уу?
- Таны энэ хөрөнгөний хэмжээ хэр зэрэг вэ?
- Үнэнээ хэлэхэд тэр тухай нарийн бодож байгаагүй, гэвч хамгийн багадаа лл хоёр сая байх гэж бодох юм.

Данглар баярлан ухаан алдах шахав. Тэр алдсан олзоо олж байгаа худалдаачин, живж үхэх гнэж байснаа хөл доороо хатуу газар байгааг мэдэрсэн хүн шиг болов.

- Тэгэхлээр түшээ гүнтэн би найдаж болох уу гэж Андреа ихэд хүндэтгэлтэйгээр ёслол хэлэхэд Данглар хариуд нь.
 - Бээс та найдаж болно. Хэрэв таны талаас саад тотгор бхйхшүй бол үүнийг шийдвэрлэгдсэн асуудал гэж үзэж болно гэж өгүүлэв.
 - Ай гүнтэн би ямар их баяртай байна вэ? гэж Андреа хэлэхэд Данглар бодлогоширсон бхйдалтайгаар
 - Гэхдээ энэ чинь, Парисын дээдсийн хүрээлэнд таныг ивээгч Монте-Кристо гүн таныг дэмжихээр яагаад тантай хамт ирсэнгүй вэ? гэж асуулаа.
- Андреагийн царай үл мэдэг улайв.

- Би шууд гүнгийнхээс ирээд байна. Үнэхээр гайхам хүн боловч их өвөрмөц зантай хүн. Гүн миний сонгосныг бүрэн сайшааж байна билээ_ Тэр ч байтугай, аавыг зөвхөн орлогоосоо өгөх биш үндсэн хөрөнгөө ч өгөх байх гэж найдаж байгаагаа хэлж байна билээ. Аавыг итгүүлэхэд өөрийн нөлөөтэй байдлыг хэрэглэнэ гэсэн. Харин тэр өөрөө хэзээ ч хэний ч төлөө бэр гуйж яваагүй бөгөөд тэгж гуйхгүй гэж байна билээ. Би түүнийг зөв гэж бодож байна. Өөртөө ийм ёс тогтоогоод түүндээ харамсаж байсан бол, энэ удаа хамгийн их харамсаж байна гэж байна билээ. Ямар ч юманд шууд оролцохгүй гэж байгаа боловч таныг өөртэйгөө ярихыг хүсвэл өөрийн бодлыг хэлнэ гэж байна билээ гэж Андреа хэлэв.

- Маш сайн.

- Аа, одоо хадамтайгаа ярих яриа дуусаж, банкны эзэнтэй ярих юм байна гэж Андреа эелдэг сайхнаар инээмсэглэн өгүүлэв.

- За танд түүнээс юу хэрэгтэй байна? гэж Данглер асуугаад инээмсэглэв.

- Би нөгөөдөр танаас дөрвөн мянгаад франк авах ёстой. Гэвч гүн энэ сард үлэмжхэн зардал хэрэгтэйг минь ойлгож, эхнэргүй эрийн өчүүхэн орлого юу ч болохгүй гэдгийг мэджээ. Тийм учраас тэр надад хорин мянган

франкийн чек өгсөн юм, энэ байна. Энүүн дээр гүнгийн гарын үсэг байгаа. Болно биз дээ?

- Ийм сая франкийн чек ч авчирсан би авна гэж хэлээд Данглар чекийг хармаандаа хийж – Маргааш тохиромжтой цагаа тогтоож өгвөл мөнгөний нярав тан дээр очиж хорин дөрвөн мянган франз хүлээн авсан гарын үсгийг тань болно гэв.
- Хэрэв боломжтой бол өглөө арван цагт. Хэдий эрт л бол төдийчинээ сайн. Би маргааш хотын захад гарна.
- За сайн. Арван цагт. “Жононууд” хэмээх зочид буудалдаа биз?
- Тийм ээ.

Маргааш өглөө нь банкны эзний нэр төрийг үзүүлэн, яг болзсон цагтаа хорин дөрвөн мянган франкийг Кавалькантид гардуулан өгсөн бөгөөд тэрээр Кадрусст хоёр зуун франк үлдээгээд гарч явав.

Андреа гол нь өөрийн аюулт найз нөхрөөсөө зайлсхийх гэж тэгж явсан байжээ. Тэр шалтгаанаараа ч аль болох орой иржээ. Гэвч дөнгөж хашаанд орж иртэл кочид буудлын хаалгач малгайгаа гартаа баоьж өөрийг нь хүлээж байв.

- Эрхэм минь тэр хүн ирсэн шүү гэж дуулгав.
- Ямар хүн? гэж Андреа сайн мэдэж байсан боловч огт мартчихсан юм шиг дүр үзүүлэн асуув.
- Гэгээн, дээдэс таны жаахан тэтгэвэр хайрладаг хүн.
- Өө, эцгийн минь хөгшин зарц уу? Түүнд миний орхисон хочр зуун франкийг өгсөн үү?
- Өгсөн, гэгээн дээдэс минь.

Андреагийн хүслээр зарц нар түүнийг “гэгээн дээдэс” гэж дуудаг байжээ.

- Гэвч аваагүй шүү гэж хаалгач цааш хэлэв.

Андреагийн царай цонхийн цайрав. Гэхдээ маш харанхуй байсан тул үүнийг хэн ч ажигласангүй.

- Яалаа гэнэ ээ, авсангүй юу? гэж чичирхийлсэн дуугаар асуув.
- Үгүй, тэр өөрөө гэгээн эзэн тантай уулзах гэнэ. Би түүнд таныг гэртээ байхгүй гэж хэлсэн боловч зүтгээд байв. Сүүлд нь надад үнэмшиж, дугтуйлан бэлтгэж ирсэн энэ захидлыг танд орхиод явсан.
- Алив нааш нь өгөөтөх гэж Андреа хэлэв.

Тэгээд тэрэгнийхээ дэнгийн гэрэлд уншсан нь:

“Чи миний хаана байгааг мэднэ. Тэгэхлээр чамайг маргааш өглөө есөн цагт хүлээж байя” гэжээ.

Андреа лацыг нь харж, хүн захидлыг задалж, даруу биш нүдээр доторх утгатай нь танилцчихаагүй байгаа гэж үзэж ёалгав. Захидлыг маш нарийн ухаан зарж эвхсэн бөгөөд хэрэв унших гэвэл лацыг эвдэхээс өөр аргагүй ажээ. Гэтэл лац нь бүрэн бүтэн байв.

- За сайн, хөөрхий амьтан! Их санй хүн байгаа юм шүү гэж Андреа хэлэв.

Хаалгач энэ үгэнд бүрэн хангагдсан боловч, эрхэмсэг залуу түүний хөгшин зарц хоёрын хэнийг нь бахархахыг мэдэхгүй байв. Андреа хөтөчдөө,

- Бушуухан морь тэргээ тавиад над дээр хүрч ирээрэй гэв.

Тэгээд хоёрхон харайгаад өрөөндөө орж, Кадруссын захидлыг шатаагаад үнсийг нь ч устгалаа. Үүнийг дөнгөж хийж амжтал хөтөч нь орж ирлээ.

- Пьер чи надтай нуруугаар адилхан шүү дээ гэж Андреа хэлэхэд,
- Тийм азтай төржээ гэв.
- Чамд өчигдөр шинэ хувцас авч өгөх ёстой байсан.
- Тийм, эрхэм эзэн минь.
- Би хэргэм цол, эрх ямбаа хэлэхгүй байж байгаад нэг залуу бүсгүйтэй уулзах гэсэн юм. Чи надад хувцсаа өмсүүл, бас буудалд хоновол хэрэг болж магадгүй бичиг цаасаа өгөөрэй.

Пьер түүний хэлснийг гүйцэтгэв.

Андреа таван минутын дараа огт танигдахгүй болж зочид буудлаас гарч хөлсний хөнгөн тэрэг хөлслөн авч Пикпюс дахь “Улаан морь” гэдэг буудалд хүргэж өгөхийг тушаав.

Маргааш өглөө нь Андреа жононгууд буудлаас гарсан шиг хэнд ч мэдэгдэлгүй гарч Сент-Антуаныг өнгөрч Мениьмонтан гудамж хүрч зүүн гар татын гурав дахь байшингийн хаалганы дэргэд зогсоод хаалгач байхгүй байсан учир юм асуучхаар хүн харж байтал,

- Ганган хархүү гуай хэнийг эрээ вэ? гэж жимсний мухлагЁйн худалдагч хүүхэн мухлагийнхаа босгон дээрээс асуув.
- Эрхэм Пайтеныг эрж байна, бүдүүн хүүхэн гуай гэж Андреа хариулав.
- Талхчин байсан уу? гэж худалдаачин хүүмэн асуув.
- Тийм ээ, түүнийг хайж явна.
- Хашааны үзүүрт, зүүн тийшээ эргээд дөрөвдүгээр давхарт.

Андреа зааж өгсөн зүг рүү явж дөрөвдүгээр давхарт гараад үүдэн дээрх туулайн савраас ууртайгаар татав. Хонх жингэнэн дуугарав.

Хормын дараа хаалганд гаргасан сараалжны нүхээр Кадруссын царай харагдав.

- Чи яг иржээ! Гэж хэлээд хаалганыхаа түгжээг тайлав.
- Үгүй ер өө! Гэж Андреа орох зуураа хэлэв.

Тэгээд малгайгаа шидчихсэн чинь, малнай нь сандал дээр оносонгүй, газар унажшалан дээгүүр гулгав.

- За, за, хүү минь бүү уурла! Би чиний төлөө санаа тавьж, ямар хоол бэлдэж тавьсныг харж байна уу? гэж Кадрусс хэлэв.

Андреад үнэхээр хоолны үнэр үнэртсэн нь бор бааздуу боловч, өлссөн ходоодонд сайхан л байжээ. Энэ бол Провансаль нутгийн шинэ өөх, саримсаг хольж хийдэг жирийн хоолны аятайхан нь аргагүй үнэр ажээ. Бас шарсан загасны үнэр ханхалж байсан бөгөөд энэ бүх үнэр бол үирээн дээр тавьсан хочр гүнзгий таваг, ширмэн пийшингийн уурын тогооны тагнаас ханхалж байв.

Түүнээс гадна хажуугийн өрөөнд нямбайлан зассан ширээн дээр хоолны хоёр хэрэгсэл, нэг нь ногоон нөгөө нь шар лацтай хоёр лонх дарс, галуун хүзүүтэд хийсэн архи, байцааны навчин дээр гоёмсгоор өрж, шаазан таваг дээр тавьсан хэрчмэл жимс байв.

- За хүү минь юу гэх вэ? Гэмгүй үнэртэ© байгаа биз? Чи намайг сайн тогооч байсныг мэднэ шүү дээ. Та нар цөмөөрөө хуруугаа долооцгоодог байснаа санаж байна уу? Миний бэлтгэсэн сүмсийг чи л хамгийн түрүүнд, бусдаасаа хамгийн их амталсан шиг санагдаж байна гэж Кадрусс хэлээд, сонгино хэрчиж эхлэв.

- За болно, болно гэж Андреа төвөгшөөн хэлээд
- Чи зөвхөн өглөөний хоолны төлөө надад яршиг болсон бол чөтгөр аваг чамайг! гэв.
- Хүү минь хоол идэж суугаад ярилцахад аятайхан байдаг. Тэгээд ч чи хөгшин найзтайгаа уулзахдаа баярлахгүй байна уу? Би бол уулзсандаа баярлаж нулимс минь гарч байна гэж Кадрусс хэлэв.

Кадрусс үнэхээр уйлж байв. Гэвч хуучин буудлын эзний нулимсны булчирхайд баяр хөөр, сонгино хоёрын аль нт илүү нөлөө үзүүлснийг ялган мэдэхэд хэцүү байв.

- За, за хуурмаг аашт минь зүгээр дуугүй байвал дээр биш үү? - Чи л болоод надад сайн байдаг байх даа? гэхэд Кадрусс,
- Тийм ээ, сайн байдаг, миний муу тал л энэ байгаа юм. Одоо яая гэх вэ гэж хэлэв.
- Гэхдээ намайг дуудаж ирүүлээд булай юм сэдэхэд чинь саад болохгүй шүү дээ.
- Боль л доо! гэж Кадрусс хормойвчиндоо гал тогооныхоо том хутгийг арчаад – Хэрэв би чамд хайргүй байсан бол чиний намайг оруулсан энэ золгүй амьдралаар амьдрахыг зөвшөөрөх байсан гэж үү? Чи хар л даа. Чи зарцын хувцас өмссөн байна. Тэгэхлээр чамд зарц байх нь байна. Тэгэхэд надад байхгүй, би л өөрөө ногоо цэвэрлэх болж байна. Чи жононгууд зочид буудал эсвэл Кафе-де-Парид тусгай ширээнд хоол иддэг болохоор миний хийсэн хоолыг голж байна. Би ч бас зарц, сүйх тэрэг хөлсөлж аваад, дуртай газраа хоол идэж явж болох шүү дээ. Яагаад энэ бүгдээс татгалзаж байна вэ? Гагцхүү бяцхан Бенедетогоо л гомдоохгүй гэж тэр шүү дээ. Ядахдаа миний зөв гэдгийг зөвшөөрч үзээрэй гэж хэлэв.

Энэ үгийг Кадруссын харцны байр тун тодорхой батлав.

- За яах вэ, чи надад сайн юм болог. Харин би ирж хоол идэх ямар хэрэг болов? гэж Андреа хэлэв.
- Чамтай уулзах гэсэн юм, хүү минь.
- Надтай уулзах ий? Яах гэж? Чи бид хоёр бүх зүйлийн тухай ярилцаж тохирсон шүү дээ.
- Ай, хонгор найз минь нэмэгдэл тодорхойлолтгүй гэрээслэл байдаг гэж үү? За яах вэ хоолоо идчихье. Уурт хар минь, чамайг ирнэ гэж усан үзмийн навчин дээр зориуд тавьж бэлтгэсэн шинэхэн тос, сардин загаснаас эхэлье. Чи миний өрөөний сүрэл сандал, хана чимсэн сохор зоосны үнэтэй зургуудыг харж байх шиг байна. Яая гэх вэ, энэ чинь жононгууд буудал биш шүү дээ! гэж Кадрусс хэлэв.
- Тээр, чи хэдийнэ гомдоллож, сэтгэл ханамжгүй болжээ. Чи өөрөө л биеийн амар харсан талхчингийн ёсоор амьдрах гэж хүсээ биз дээ.

Кадрусс санаа алдлаа.

- За юу гэмээр байна? Хүчэл чинь биелэгдсэн юм биш үү?
- Энэ бол зөвхөн хүсэл, хонгор Бенедетто минь, биеийн амар харж суугаа талхчин бол орлого олдог, баян хүн байдаг.
- Чамд ч орлого бий шүү дээ.
- Надад уу?
- Тийм ээ, би чамд хоёр зуун франкийг чинь авчирсан.

Кадрусс мөрөө хавчив.

- Ямар цагт хагацаж мэдэх, дургүй өгч байгаа мөнгийг авна гэдэг доромж явдал шүү дээ. Чиний элбэг дэлбэг байдал төгсгөл болбол надад ч бас хойш нь хийх юм хэрэгтэй гэдгийг чи мэдэж байгаа. Аа, найз минь! Манай цэргийн хорооны ламын хэлснээр аз жаргал гэдэг чинь байнгын юм биш. Гэхдээ чи Дангларын охинтой суух гэж байгаа болохоор чиний элбэг дэлбэгт чинь эцэс төгслө байхгүй л дээ гэж хэлэв.
- Юу? Данглар ий?
- Тийм ээ, Данглар! Эсвэл түшээ гүн Данглар гэж хэлэх хэрэгтэй юм уу? Энэ бол чамайг Бенедетто гүн гэж хэлсэнтэй адил юм. Данглар бид хоёр танил найз улс байхгүй юу. Хэрвээ тэр мартагтай л хүн бишсэн бол чний хуриман дээр намайг урих л ёстой... Тэр чинь минийх дээр ирсэн юм. Тийм ээ, минийх дээр ирсэн. Тэр үед ийм бардам сэхүүн амьтан байгаагүй юм байхгүй юу. Моррель гуайн өчүүхэн албан хаагч байсан юм. Морсер гүн тэр бид гурав нэг биш дуаа хамт хоол идэж явсан улс. Надад ямар их нэр төртэй танилууд байгааг харж байгаа биз. Хэрэв би тэднийг жаахан түшихийг хүссэн сэн бол чи бид хоёр нэг л зочид буудалд хоол идэж байх байсан юм даа.
- Кадрусс чи атаа жөтөөнөөс болоод бүр худалч болчихжээ.
- За яах вэ, миний Бенедетто би юу ярьж байгаагаа мэднэ. Бид ч гэсэн нэг сайхан өдөр гоёлынхоо нувцсыг эгэлдэргэлж орхиод нэг баян айлын хаалганы дэргэд очиж “Онгойлгоорой” гэж хэлж байж магадгүй. Харин одоохондоо хоолоо идчихье.
- Кадрусс жишээ үзүүлж, зочилж байгаа хоолоо магтан байгаад идэж гарав. Цаадах нь яаж ч чадахгүй болон лонхтой дарсыг шалмаг онгойлгож, саримсагтай тосонд шарсан сагамхай загаснаас авав.
- Аа, найз минь чи хуучин муу тогоочтойгоо эвлэрэх тийшээ хандаж байх шиг байх чинь вэ? гэж Кадрусс хэлэхэд, залуу эрийн хоол идэх хүсэл нь бүхнийг дийлж,
- Тэгж байна гэж Андреа хэлэв.
- За, солиг минь амттай байна уу?
- Их амттай байна! Ийм сайхан хоол хийж амтархан иддэг хүн яагаад амьдралдаа хангалуун биш байдаг юм бэ гэдгийг л ойлгохгүй байх.
- Миний бүх аз жаргал нэг л санаа бодлоор хорлогдсон юм гэж Кадрусс хэлэв.
- Ямар?
- Хэзээд үнэнчээр хоол олж идэж явсан болохоор, одоо найзаасаа идэж байгаадаа зовох юм.
- Зовох юмаа олж дээ. Чи бид хоёрт хүрэлцэх юм бий, битгий нэрэлх гэж Андреа хэлэв.
- Үгүй, үнэмших, үнэмшихгүйгээ өөрөө мэд, ямар ч гэсэн сарын эцэст сэтгэл минь зовж эхэлдэг юм.
- Боль доо Кадрусс!
- Тэр ч байтугай өчигдөр зовоод энэ хоёр зуун франкийг аваагүй ирсэн шүү дээ.
- Чи надтай уулзах гэж хүссэн. Зөвхөн хүн ч сэтгэлээсээ л тэр үү?
- Чухам тийм. Түүнээс гадна надад бас нэг санаа төрлөө.

- Андреа цочин давхийв. Кадруссын санаа түүнийг ямагт айлгадаг байжээ.
- Сарын эхэн болохыг хүлээж амьдарна гэдэг ямар шившигтэй болохыг харж байгаа биз гэж Кадруссын хэлэхэд, Андреа түүний санаа юу болохыг мэдэх гэж гүн ухаантны ёсоор,
- Ай, хөөрхий амьдрал гэдэг чинь үргэлж хүлээлтийн дунд өнгөрдөг юм шүү! Би яаж амьдарч байна вэ? Би тэсвэртэйгээр л хүлээж байна гэв.
- Чи ямар нэгэн роёрхон зуун франк хүлээх биш, харин тав, зургаан мянга, түүнээс ч дээш, арав, арван хочр мянган франк хүлээх юм чинь. Чи чинь бидэн дундаа зальтай нь. Чамд хөөрхий Кадруссаас нуудаг түрийвч, хуримтлал байдаг байсан шүү дээ. Харин аз болоход Кадрусс нь сайн үнэрч байжээ.
- Чи дахиад л дэмий донгосоод гарлаа. Дандаа л өнгөрснөө ярьж байх юм. Энэ чинь юунд хэрэгтэй юм бэ? гэж Андреа хэлэв.
- Чи дөнгөж хорин нэгтэй. Чамд өнгөрснөө мартаход амархан. Харин би тавь хүрсэн хүн, дуртай ч, дургүй ч өнгөрсөн уруугаа эргэж ороод байх юм. За ажил хэргээ ярилцъя.
- Ашгүй дээ.
- Би чнийн оронд байсан бол...
- За тэгээд?
- Хөрөнгөө гүйлгээнд оруулах байсан даа.
- Гүйлгээнд оруулах ий?
- Тийм ээ, би л бол үл хөдлөх хөрөнгө эсвэл сонгуулын эрх худалдаж авах гэж байна гэдэг нэрийн доор мөнгөө хагас жилийн өмнө авчихна. Тэгээд л оргоод явчихна даа.
- Тийм, тийм, энэ ч муугүй л санаа юм гэж Андреа хэлэхэд, Кадрусс,
- Хонгор найз минь, миний хийсэн хоолыг идсэн бол миний зөвлөгөөг сонс. Чи үүнээс сэтгэл оюун, бие цогцсоороо хожих болно.
- Чи өөрөө, зөвлөгөөгөө яагаад ашигладаггүй юм бэ? Чи яагаад мөнгөө хагас жил, тэр ч байтугай жилийн өмнө аваад Брюссель уруу явчихгүй байгаа юм бэ? тэгвэл чи талхчин байсан хүний дүр үзүүлж байсанд орохноо жинхэнэ дампуурсан хүний дүртэй болох байсан юм. Одоо ийм маяг их дэлгэрчээ. Жэж Андреа хэлэв.
- Би хармаандаа мянга хоёр зуухан франктай юу хичээх вэ?
- Кадрусс чи ямар их шаардамтгай болчихоов. Хоёр сарын өмнө өлсөж үхэх байсан шүү дээ гэж Андреа хэлэв.
- Амсан байж амтархдаг юм. Тийм учраас би өөртөө нэг төлөвлөгөө зохиогоод байна гэж Кадрусс инээж байгаа сармагчин ч юм уу, архирч байгаа барынх шиг арзгар шүд гарган хэлээд, талхаа залуу хүн шиг тас татан үмхэв.
- Кадруссын төлөвлөгөө Андреаг санаанаас нь илүүгээр айлгажээ. Санаа бол зөвхөн эх үүсвэр, гэтэл төлөвлөгөө гэдэг биелэгдэх аюултай.
- Тэр чинь юу гээчийн төлөвлөгөө юм бэ? гэж асуув.
- Юу гэж? Хэний бодсон төлөвлөгөөгөөр бид нэгэн газрыг хаяж явлаа? Минийх шиг л санах юм. Түүнээс болоод муудаагүй, тэгээгүй бол бид хоёр энд сууж байхгүй байсан даа.

- За би маргаагүй байна шүү дээ. Чи ажил хэрэг ярьъя гэсэн биз дээ. Чамд ямар төлөвлөгөө байна вэ? гэж Андреаг асуухад Кадрусс
- Чи өөрөөсөө нэг ч мөнгөний гарзгүйгээр надад арван таван мянган франк олж өгч чадах уу?... Үгүй, үгүй арван таван мянга ч багадаа нь. Гучин мянган франкаас бага мөнгөтэй байж тохитой хүн шиг амьдрахыг би зөвшөөрөхгүй гэхэд,
- Үгүй, би чадахгүй гэж Андреа хүйтнээр хариулав.
- Тэгэхэд Кадрусс тайван боловч хүйтэн царайгаар,
- Чи миний хэлснийг ойлгохгүй байна. Би чамд өөрөөсөө нэг ч мөнгөний гарзгүй гэж хэлж байна шүү дээ гэв.
- Тэгээд чи юу гээ вэ? Би хулгай хийж хамаг ажлаа нураагаад, хоёулаа нөгөө газраа хүргэгдэх гээ юу?
- Надад ямар хамаатай юм бэ? аваад явбал аваад л яваг. Би хачин хүн шүү. Би чам шиг өгөрсөн амьтан биш, заримд а нөхдөө санах юм! Чи бол ч тэдСнтэйгээ уулзахгүй л байвал баярлана даа!
- Энэ удаа Андреа зөвхөн цочин давхийгээд зогссонгүй, царай нь зэвхийрэв.
- Кадрусс чи тэнэглэхээ болиорой! гэж хэлэв.
- За, Бенедетто чи битгий ай, надад өөрийн оролцоогүйгээр тэр гучин мянган франкийг олох аргыг л заагаад өгчих.
- За яах вэ, бид бодъя гэж Андреа хэлэв.
- Аа, одоохондоо миний тэтгэврийг таван зуу болгож нэмэгдүүлээрэй за юу? Би зарц авгай хөлсөлж авахаар шийдсэн гэв.
- За яах вэ чи таван зуун франк авч байх болно, гэхдээ энэ хялбаргүй байна. Чи дэндүүлж байна шүүл гэж Андреагийн хэлэхэд Кадрусс,
- Юу байсан юм бэ! Чи чинь ёроолгүй авдраас авч байгаа шүү дээ! гэв.
- Андреа ийм л үг хэлийг нь хүлээж байсан юм шиг нүд нь гялалзсанаа дороо унтарчихлаа.
- Тэр үнэн, намайг тэтгэгч тэр хүн надад их сайн байдаг юм гэж Андреа хэлэхэд Кадрусс,
- Ямар хонгор сайхан сэтгэлтэй тэтгэгч вэ! Чамд сар бүр өгдөг үү? Гэж асуув.
- Таван мянган франк гэж Андреа хэлэв.
- Чи таван зууг өгч байна гэж амласны адил тэр чамд таван мянгыг өгдөг юмаа даа! Хууль биш төрсөн хүүхэд азтай байдаг гэж ярьдаг нь үнэн юм байна шүү. Сард таван мянган франз... ийм их мөнгийг хааш нь үрэх билээ дээ, чөтгөр ав! гэж Кадрусс хэллээ.
- Бурхан минь! Үрчихэд амархан. Би бас л чам шиг хөрөнгөтэй болох юмсан гэж хүсдэг юм.
- Хөрөнгө... ойлг@мжтой хэрэг... хэн бүхэн хөрөнгөтэй болох юмсан гэж хүсдэг.
- Надад хөрөнгө бий болно.
- Хэн чамд өгөх юм бэ? Чиний ноён уу?
- Тийм ээ, миний ноён, харин би жаахан хүлээх ёстой нь харамсалтай.
- Юу хүлээх гэж? хэмээн кадрусс асуув.
- Үхэхийг нь хүлээнэ.
- Ноёныхоо үхэхийг үү?

- Тийм ээ.
- Яагаад тэр вэ?
- Яагаад гэвэл гэрээслэлдээ миний нэрийг дурдаж байгаа.
- Үнэн үү?
- Үнэн.
- Хэчнээнийг вэ?
- Таван зуун мянга!
- Хүрэлцээтэй мөнгө байна даа!
- Тэгээд л би чамд хэлж бхйхгүй юу.
- Үгүй байх аа.
- Кадрусс чи миний найз мөн үү?
- Амьдрал үхэл аль алинд нь найз.
- Би чамд нууцаа хэлье.
- Хэл, хэл
- Харин ганцхан...
- Загас шиг л дуугүй явна.
- Тэгэхлээр надад ингэж санагдаж байна... гэж хэлээд Андреа дуугүй болж ийш тийшээ харав.
- Юу санагдаж байна?... за, чи битгий ай! Бид хоёулхнаа байна.
- Би өөрийнхөө эцгийг олж байх шиг байна.
- Жинхэнэ эцгээ юу?
- Тийм.
- Кавальканти биш үү?
- Үгүй, тэр явчихсан. Чиний хэлдгээр жинхэнэ эцэг...
- Тэр эцэг чинь...
- Кадрусс, Монте-Кристо гүн л бололтой.
- Яалаа гэж дээ!
- Тийм шүү, тэгвэл бүх юм ойлгомжтой болно. Тэр ил хэдж чадахгүй байна. гэсэн ч өвгөн Каюальканти миний эцэг гэж зөвшөөрөөд, үүнийхээ төлөө тавин мянган франк авсан.
- Тавин мянган франкаар чиний эцэг болох гэнэ ээ! Би бол хагасаар нь хорин мянга, арван таван мянган франкаар ч болсон зөвшөөрнө дөө. Өөдгүй амьтан чи миний тухай санасангүй юу?
- Би тэр тухай мэдээгүй байсан шүү дээ. Биднийг танд байхад л учрыг нь олчихсон байсан юм билээ...
- Өө, тийм л дээ. Тэгээд гэрээслэлдээ...
- Тэр надад таван зуун мянган фрак үлдээж байгаа юм.
- Чи итгэлтэй байна уу?
- Тэр өөрөө надад үзүүлсэн. Бас түүгээр ч дуусаагүй.
- Миний хэлснээр нэмэлт тайлбар бий юу?
- Тийм бололтой.
- Тэгээд түүнд нь юу гэж байна?
- Намайг хүүгээ гэж хүлээн зөвшөөрч байна.
- Ямар сайн эцэг вэ! гэж хэлээд Кадрусс тавгаа дээш хаяад хоёр гараараа барьж авав.

- Харж байгаа биз? Одоо надад чамасс нуух юм байна гэж хэлээдхээч!
- Чиний хэлдэг зөв. Надад итгэж байгаад чинь баяртай байна. Тэр эцэг ноён чинь баян хүн үү?
- Тэгэлгүй яах вэ! Тэр өөрөө хичнээн мөнгөтэйгээ мэддэггүй юм.
- За үгүй байлгүй!
- Би мэдэхгүй бол хэн мэдэх юм бэ. Би түүн дээр дуртай цагтаа л ордог юм. Саяхан банкны хүн түүнд тавин мянган цранкийг дэвсгэртээр нь авчирч өгсөн, чиний энэ ширээний бүтээлэг шиг л юм байна билээ. Өчигдөр банкны эзэн өөрөө алтаар зуун мянгыг авчирч өгсөн.

Кадрусс гайхан бахаджээ. Андреагийн ярьж байгаа үгэнд зоосны хангинах дуу сонстож байх шиг түүнд санагджээ.

- Чи тэр байшинд дуртай цагтаа ордог гэнэ ээ? гэж Кадрусс цагаахнаар асуув.
- Ямар ч цагт орно.

Кадрусс дуугүй байлаа. Ямар нэг юманд бодлого ширсон нь илт байлаа. Тэгснээ гэнэт:

- Би тэр бүхнийг харах юмсан. Ямар сайхан байх бол! гэж дуу алдлаа.
- Тийм ээ, мөн ч сайхан амьдарч байгаа хүн дээ гэж Андреа хэлэв.
- Тэр чинь Елисейн Талд суудаг байх аа?
- Гучдугаар байшин.
- Гучдугаар байшин ий? гэж Кадрусс давтан асуув.
- Тийм ээ, хашаа, цэцэрлэгтэй маш сайхан шилтгээн Үайдгийг чи мэдэх ёстой!
- Мэдэх байх аа. Гэвч би гадаад байдлыг нь сонирхоогүй, дотор талыг нь сонирхож байна. Дотроо ямар сайхан төхөөрөмжтэй бол!
- Чи хэзээ нэгэн цагт Тюильрид орж үзсэн үү?
- Үгүй шүү.
- Тэрнээс хавьгүй илүү.
- Андреа, тэр сайн сэтгэлт Монте-Кристок түрүүвчээ унагахад нь авч өгөх аятайхан биз?
- Тэрнийг нь хүлээх юү байна? Энэ байшинд мөнгө гэдэг нь цэцэрлэг доторх алим шиг л энд тэндгүй хэвтэж байдаг юм.
- Чи намайг нэг дагуулаад ороосой.
- Тэгж яаж болох юм бэ? хэн гэж дагуулж орох вэ?
- Чиний хэлдэг зөв. Гэвч чиний хэлснийг дуулаад шүлс гоожчихлоо байна. Би энэ бүхнийг өөрийн нүдээр харах ёстой. Арга олно оо.
- Кадрусс аа, бүү тэнэглээрэй!
- Би шал цэвэрлэгч гэж хэлье.
- Тэнд чинь цул хивс байдаг юм.
- Өө, чөтгөр гэж! тэгвэл би тэр бүхнийг сэтгэлдээ л харахаас өөргүй болох нь ээ.
- Энэ чинь л бүхнээс дээр дээ.
- За яах вэ, ядахдаа тэнд юу юу байдгийг нь ярьж өг л дөө.
- Би чамд яаж ярих билээ?
- Тэрнээс амархан юм гэж байхгүй. Байшин нь том уу?

- Том ч биш, бага ч биш.
- Тасалгаанууд нь ямар зохион байгуулалттай вэ?
- За алив, чамд зураг нь хэрэгтэй бол цаас бэх хоёр өгөөтөх.
- Одоо өгье гэж кадрусс яаран хэлээд хуучин бичгийн ширээн дээрээс худаас цаас, бэх, үзэг авчраад,
- За аль вэ хүү минь энэ бүгдээ цаасан дээр зураадах гэж хэлэв.
- Андреа үл мэдэг инээмсэглээд, үзэг авч ажилдаа оров.
- Байшингийн нь дэргэд хашаа цэцэрлэг бий гэж би чамд хэлсэн шүү дээ. за харж бай гэж Андреа хэлээд цэцэрлэг, хаша байшин зурав.
- Хашаа нь өндөр үү?
- Үгүй дээ, найм есөн фут л байх. Тэрнээс илүүгүй.
- Энэ чинь их болгоомжгүй хэрэг дээ гэж Кадрусс хэлэв.
- Хашаан дотор нь алтан жүржийн мод, зүлэг, цэцгийн хүрээлэн бий.
- Аа хавх бхйхгүй биз?
- Байхгүй.
- Морины нь хашаа хаана вэ?
- Хаалганы хоёр талд, энд энд гэж Андреа хэлээд зурав.
- Надад доод давхрыг нь зурж өгөөч гэж Кадрусс хэлэв.
- Доод давхарт нь хоолны өрөө, зочдын хоёр өрөө, бильярдын өрөө, үүдний өрөө, гол шат, дотоод шат байдаг юм.
- Цонхнууд нь ямар вэ?
- Цонхнууд нь өргөн сайхан даа. Аль ч шилээр нь чам шиг биетэй хүн орчхож багтана.
- Ийм цонхтой байж ямар чөтгөртөө хийж шат хийнэ вэ?
- Одоо яая гэх вэ? Гоёл!
- Цонхонд нь хаалт бий юу?
- Хаалт бий. Гэхдээ хэзээ ч хаадаггүй юм. Тэр Монте-Кристо гүн гэдэг чинь их өвөрмөц хүн, шөнө ч гэсэн тэнгэр харж байх дуртай.
- Зарц нар нь хаана унтдаг юм бэ?
- Тэд тугай байшинтай. Хаалганы баруун талд саравчин дотор галын шат нь байдаг юм. Энэ саравчны дээд талд зарц нар нь тусгай, тусгай суудаг юм. Тийш нь гол байшингаасаа хонх залгасан байдаг.
- Хонх ий, чөтгөр ав!
- Чи яав?...
- Үгүй зүгээр. Хонх гэдэг үнэтэй эд дээ гэж ярьж байна. тэр юунд хэрэг байна?
- Тэнд урьд нь нохой байсан юм. Шөнөжингөө хашаан дотор сул тавьдаг байсан юм. Харин тэр нохойг Отейльд аваачсан. Чиний очсон байшин. Санаж байгаа биз?
- Тийм ээ.
- Би өчигдөрхөн түүнд “Гүн та бүх зарц нараа аваад Отейль уруу явчихаар гэрл чинь хэн ч үлдэхгүй аймшигтай юм биш үү” гэж хэлсэн.
- “Тэгээд яагаа вэ” гэж тэр өөдөөс асуусан.
- “Нэг сайхан өдөр хуурайлаад явчихвал яана” гэж би хэлсэн.
- Тэгэхэд тэр юу гэж байна?

- Юу гэж ий?
- Тийм.
- “Үгүй, яах вэ, хулгай орвол орохоос биш” гэж хариулсан.
- Андреа, тэнд чинь бариад авах ямар нэг нууц юм байдаг биш биз.
- Ямар бариад авдаг юм?
- Яах вэ? хулгайчийг гараас нь барьж авмагц хөгжим дуугардаг юм. Би сүүлчийн үзэсгэлэн дээр тийм юм гарсан байна билээ гэж дуулсан.
- Тэнд зөвхөн улаан модон шүүгээ л бий. Дандаа түлхүүр нь ёрдойж байдаг юм.
- Чиний гүнгийн чинь хулгай ордоггүй юм уу?
- Үгүй, зарц нар нь түүнд маш үнэнч шударга байдан.
- Тэр түүгээн дотор хичнээн хэмжээний мөнгө байдаг бол?
- Магадгүй.... аа хэн мэдэх вэ золиг!
- Тэр шүүгээ чинь хаана байдаг эд вэ?
- Хоёрдугаар давхарт.
- Алив хүү минь хоёрдугаар давхрын үлгэрчилсэн зургийг дахиад зураад өгнө үү.
- Болнооо.

Тэгээд Андреа дахин үзгээ авч,

- Аоёрдугаар давхарт үүдний өрөө, зрчдын өрөө байдан. Зочдын өрөөний баруун талд, номын сан, ажлын тасалгаа, зүүн талд нь унтлагын өрөө, амралтын жижиг өрөө бий. Энэ өрөөн дотор тэр шүүгээ байдаг юм.
- Тэнд цонх бий юу?
- Хоёр бий. Энд энд гээд Андреа гүнгийн унтлагын том өрөөний залгаа байгаа булангийн багахан өрөөний хоёр цонхыг зурав.

Кадрусс бодлого болон суув.

- Тэр чинь Отейль өөдөө байн б йн явдаг уу?
- Долоо хоногт хоёр гурваны удаа очдог. Маргааш тийшээ явж бүтэн өдөр өнжөөд тэндээ хонох гэнэ билээ.
- Чи үүндээ үнэмшиж байна уу?
- Намайг тэндээ ирж үдийн хоол идээрэй гэж урьсан.
- Хотод байшинтай, хотын захад байшинтай, ёстой амьдрал гээч байна даа! гэж Кадрусс хэлэв.
- Тэгэх л гэж баян байгаа юм шүү дээ.
- Чи тэнд хоол идэхээр очих уу?
- Тэгэх байх.
- Чи тэнд хоол идэхээрээ хонодог уу?
- Байдлаасаа л болдог. Би гүнгийн гэртээ байгаа юм шиг л байдаг.

Кадрусс залуу хүү өөд зүрхний нь үнэн бодлыг мэдэх гэсэн юм шиг харав.

Харин Андреа хармаанаасаа тамхиныхаа хайрцгийг гаргаж дотроос нь ороомол навчин тамхи авч тайвнаар сорон утаагий нь цагираглуулан гаргаж байв. Тэгээд,

-Чи таван зуун франкаа хэзээ авах вэ? гэж Кадруссаас асуув.

- Чамд одоо бэлэн байвал одоо ч яахав.

Андреа хармаанаасаа хорин таван луйдор гаргаж ирэхэд,

- Жингэнүүрүүд үү, үгүй их баярлалаа! Гэж Кадрусс хэлэв.

- Энүүнд дургүй чинь хүрдэг хэрэг үү!
- Үгүй, би их хүндэтгэдэг. Гэвч ийм мөнгөнд дургүй.
- Тэнэг минь, солиход хожил гарна шүү дээ, чалчаа минь. Алтан зоос солиход таван су илүү өгдөг юм.
- Мэднэ ээ. дараа нь мөнгө сольдог хүн хөөрхий муу Кадруссыг чинь мөрдөөд, тэгээд барьж авна. Тэгэхэд хөөрхий Кадрусст хэн ингэж алтан зоосоо төлдгийг хэлэх хэрэг болно шүү дээ. Хүү минь бүү тэнэглээд бай. Зүгээр л ямар нэг вангийн зурагтай мөнгөн зоос аль. Таван франкийн зоос хэнд олдоно шүү дээ.
- Би таван зуун франкийн мөнгөн зоос өвөртөө яаж авч явдаг юм бэ! Хүн дагуулж үүрүүлэх болно шүү дээ.
- Тэгвэл зочид буудлын хаалгачид орхичхоорой. Тэр шударга сайн хүн байгаа юм. Би очоод авчихна.
- Өнөөдөр үү?
- Үгүй маргааш, би өнөөдөр завгүй. За яах вэ, маргааш Отейль уруу явахдаа түүнд орхичхамц.
- Би найдаж болно биз.
- Бүрэн болно.
- Би зарц хүүхэнтэй урьдаас ярьж тохирох гээд л тэгж байгаа юм.
- Тохир, тохир. Гэхдээ үүгээр дууслаа шүү. Одоо дахиад намайг шалгаагаад байхгүй биз?
- Хэзээ ч үгүй.

Кадруссын царай хачин баргар болоход Андреа энэ өөрчлөлтийг нь анхааран үзэх хэрэгтэй юм биш байгаа гэж айв. Тиймээс ч улам хөгжилтэй, хайнга царайтай байхыг хичээв.

- Чи яагаад ингэж улам их хөгжилтэй болчхов. Үе залгамжлах хөрөнгөө авчихсан гэж бодмоор байх чинь! Гэж Кадрусс хэлэв.
- Одоохондоо ч даанч үгүй л байна. Харин би түүнийг хүлээн авсан өдрөө...
- Тэгвэл яах гэж?
- Тэгвэл би өөрийн найд нөхдийг мартахгүй.
- Чиний толгой ч дээ!
- Би чамайг надаас мөнгө чангаагаад байх боловч уу гэж бодож байгаа юм.
- Би юу даа! Хэл вээ бас! Харин би чамд сайн санааны зөвлөгөө өгчихье.
- Ямар?
- Энэ очир алмас шигтгээтэй бөгжөө энд орхичих. Чи өөрсдийгөө баригдаг Гэж бодож байна уу? Хоёулаа балрах гээ юү?
- Яана гэж?
- Юу яана гэж? Чи зарцын хувцас өмсчихөөд таван мянган франкийн бөгж зүүж явна шүү дээ.
- Чөтгөр ав! Чи аатчихлаа! Чи яагаад эд үнэлэгчээр ороогүй юм бэ?
- Би очир эрдэнэ мэднэ ээ. Надад өөрт минь бас байсан юм.
- Чи үүгэрээ илүү их бардамнан бахархаж баймаар юм даа! гэж хэлээд огтхон ч уурласангүй бөгжөө өглөө.

Кадрусс түүнийг нүдэндээ ойрхон барьж үзэж байгааг нь хараад Андреа талуудыг нь үзэж байгааг мэдэв.

- Энэ чинь хуурамч очир эрдэнэ байна шүү дээ гэж Кадрусс хэлэв.
- Чи тоглоом хийж байна уу? яаж байна? гэж Андреа хэлэхэд Кадрусс,
- Битгий уурлаарай. Одоохон шалгаад орхиё гэв.

Кадрусс цонх өөд очиж, чулуугаар шилэн дээгүүр зурав. Тэгэхэд чихран дуугарав.

- Буруугаа хүлээе гэж хэлээд Кадрусс бөгжийг хураандаа зүүгээд, - Би андуурчээ. тэр өөдгүй эрдэнэсийн дэлгүүрийнхэн чулууг айхтар дуураймлаар хийж чаддаг юм. Бас л нэг сөнөж байгаа гар урлал даа гэв.
- За тэгээд, одоо дуусав уу? Чамд өөр юу хэрэгтэй байна? Малгай, цамцаа өгөх үү? Битгий ёсорхоод байгаарай гэж Андреа хэлэв.
- Үгүй, чи ерөнхийдөө сайн хүү. Би одоо чамайг цааш нь барихгүй, биеэ барихыг бодож үзье.
- Очир эрдэнэ зарахдаа болгоомжлоорой! Тэгэхгүй бол алтан зоосноос айсангтай чинь адил юм болж мэднэ шүү.
- Бүү зов. Би үүнийг зарах гээгүй байна.

“Ямар ч л гэсэн нөгөөдөр болтол” гэж Андреа дотроо бдлоо.

- Чи мөн их азтай золиг юм. Чи одоо зарц нар, морьд, сүйх тэрэг, болзоот хүүхэндээ очно! Гэж Кадрусс хэлэхэд,
- Тэгэлгүй яах вэ гэж Андреа хариулав.
- Чи миний найз Дангларын охинтой хурим хийсэн өдрөө наддаа хуримын сайхан бэлэг ирүүлэх биз дээ?
- Энэ зүгээр чиний санаагаараа зохиосон яриа гэж би чамд хэлсэн шүү дээ .
- Охиныхоо инжинд хэчнээнийг өгч байгаа юм бэ? г
- Би чамд хэлсэн шүү дээ...
- Сая уу?

Андреа мөрөө хавчив.

- Сая гэ бодъё. Чамд хичнээн ч байла гэсэн улам ч их байгаасай гэж хүсэж байна гэж Кадруссын хэлэхэд Андреа
- Баярлалаа гэв.

Тэгэхэд Кадрусс инээд алдаж ,

- Үнэн зүрхнээсээ шүү. Б чамайш гаргаж өгье гэж хэлэв.
- Тэгж ажил удахын хэрэггүй .
- Маш их хэрэгтэй.
- Яагаад тэр вэ?
- Миний цоож багахан нууцтай юм . энэ бол Юре, Фише хоёрын системийн Гаспар Кадруссын хянэан үзэж засамжилсан тий цоож байгаа юм . Чамайг хөрөнгтөн болохоор чинь бас гиймийг хийж өгөмц .
- Баярлалаа . Чамд долоо хоногийн өмнө мдэгдмэгц гэж Андреа хэлэв. Тэр хоёр салав. Кадрусс Андреаг доошоо бууснаао барахгүй хаашаа өнгөрснийгш нүлээрээ хартал шатан дээр зогслоо . Тэгээд гэртээ яаран орж ирж хаалгаа түгээж Андреагийн үлдээсэн зургийг туршлагатай уран барилгачин шиг судалж гарав.

- Энэ Бенедатто хүү үе залгамжлахаасаа буцахгүй байна. Тэгэхээр таван зуун мянган франк гарт нь орж ирэх өдрийг хурдатгасан хүн бол түүний муугүй л нөрийн нэг болно доо гэж Кадрусс өөр зуураа хэллээ .

5.ЭВДЭЖ ОРСОН НЬ

Дээр бидний өгүүлсэн ярианы маргааш нь Монте Кристо гүн , Али бас хэдэн зарц , үсэргэж үзэх хэдэн морио аваад Отейльдоо очлоо .

Урьд өдөр нь Монте- Кристо бас л Андреа шиг явах эсэхээ мэдэхгүй байв. Ингэж явсан нь Нормандад байшин ба хөнгөн хөлөг онгоцны тухай ажлаар явсан Бертуччо эргэж ирсэн явлдаас гол нт шалтгаалжээ .

Байшин нь бэлэн зэлэн болж, хөлөг онгоц нь үйлчлэх зургаан хүнийхээ хамт хамаг гүйцэтгэвэл зохих баримт бичгүүдээ бэлэн болгочоод , тэнгисийн бяцхан буланд ирж зогсоод долоо хонож байгаа ажээ . Монте-Кристо Бертуччог үүргээ трүгэн биелүүлээд ирсэнд магтаад сарын дараа Францыг олрхиж явах бодлоготой учир явахад бэлхэн байхыг захив.

- Одоохондоо , би парисаас Тренор уруу нэг шөнө яваад ирэх санаатай, энэ тавин бээр газрыг арван цагт явж чадахаар найман өртөө байгуулбал зүйтэй гэж гүн түүнд хэлэхэд хариуд нь Бертуччо ,

- Гэгээн эзэн та энэ бодлоо надад цухуйлгаж байсан сан билээ . Морьд бэлэн байгаа . Би морьдыг худалдаж аваад, хамгийн тохимжтой газрууд , өөрөөр хэдлбэд хэн ч энгүүдээ бууж зогсдоггүй тосгонуудад хувиарлан таавсан гэ хэлэв.

- Маш сайн . Би энд нэг хоёр хононо. Эн тухай бас бодоорой гэж Монте-Кристо хэлэв.

Бертуччог зохих тушаал өгөхөөр гармагц , Батистен зөрөн орж ирэв. Алталсантавиур дээр тавьсан захидал авчирчээ . гүн түүний тоосонд дарагдчихсан байхыг хараад,

- Та юу гэж ирэв? Би таныг дуудаагүй байх аа гэж хэлэв.

Батистен хариу үг дуугаралгүй гүнгийн дэргэд очоод түүндп захидлаа өгч, Маш чухал бөгөөд яаралтай юм гэнэ гэж хэллээ .

Гүн захидлыг задлан уншсан нь:

“Елисейн тал дээрх Монте-Кристо гүнгийн гэрт өнөө шөнө хүн орж , амралтын жижиг өрөөн дэх шүүгээнд лавтай байгаа хэмээн бодсон баримт бичгүүдийг хулгайлах нь гэдгийг Монте-Кристо гүн зоригтой хүн учираас энэ хэрэгт цагдаагийн ыайгууллагыг оролцуулахгүй байх. Тэгж оролцуулбал энэ мдэг мэдэгдэж байгаа хүнд хортой юм . Гүн өөрөө унтлагын өрөө жижиг өрөөн дотроо нуугдаж байгаад тэрхүүз эвдлэн оровчтой учраа олж болно. хэрэв олон хүн байлгах буюу урьдчилан арга хэмжээг авбал хорно санаатан өөрийн ажиллагааг зогсоож , үүнийг мэдээлж байгаа хүний санамсаргүй олж мэдсэн дайсныгш авах бололцоогоо монте-Кристо гүн алдана . тэгвэл оролдлогын тухай мэдэж чадахгүй байж магадгүй юм” гэжээ .

Гүн эхлээд энэ бол хулгайё нарын занга , илүү их аюултай зүйлээс анхаарал холдуулахын тулд үлт ялих юмны утхай мэдэгдэж байгаа зальт арга гэж боджээ . тэгээд сануулж хэлснийг хайхралгүйгээр цагдаагийн даргад захидал бичих гсэн боловч, үгүй, ер нь энэ үл мэдэгдэх сайн санаат хүний урьдчилан

мэдгдсний ачаар, ганцхан түүний өөрий нь таних буюу эсвэл хэрэг тохиолдвол , Фиеско ба өөрийн нь алах гэсэн мавр хүн хоёрт тохиолдсолн явдал юм шиг ямар нэг юманд ашиглаж болох хүнийн дайсан гараад ирэх юм биш байгаа гэдэг санаа түүд гэнэт төрлөө .

Бид гүнг мэднэ. Тийм учраас зоригтой , сэтгэл санааны талаар их хүчтэй гэдгийг нь дээд зэргийн зарчимч хүний ёсоор болохгүй юмыг хүч гарган хийхээр барьж авдаг тухай нь ярихын ч хэрэггүй юм . Түүний бүх амьдрал , юуны ч өмнө зогсохгүй хэмээн зориглон шийдэж байсан бүхэн нь бурхан хэмээх байгаль ба шулам гэж нэрлэж болох ертөнцийн эсрэг тэмцэн бие сэтгэлийн жаргалыг олход сургажээ .

- Тэд надаас баримт бичиг хулгай хийх гээгүй байх. намайг лх санаатай байгаа байх. Эд бол хулгайч биш , алуурчид байна. ер нь фагдаагийн даргын хувийн хэрэгтээ оролцуулахыг хүсэхгүй . Би цагдаагийн гарын төсөвт тээр болохгүй баян хүн гэж өөртөө хэлэв.

Гүн захидал өгчөөд гарсан Батистеныг дуудаж,

- Бушуухан Парист буцаж очоод үлдсэн бүх зарцыг нааш нь аваад ир. Энд надад хэрэгтэй байа гэж хэлэв.
- Эрхэм гүн минь , байшинд хэн ч үлдэхгүй гэж үү? Гэж Батистен асуув.
- Хаалгачийг л үлдээ .
- Эрхэм гүн та, хаалгачийн тэндээс байшин хүртэл нэлээд зайтайг бодохсон болов уу?
- Тэгээд яагааа ву?
- Байшинг хоослоод аваад явчихлаа гэхэд нь тэр юу ч дуулахгүй шүү дээ .
- Хэн хулгай хийх билээ?
- Хулгайч нар.
- Эрхэм та илжиг шиг хүн юм . ЫБи §арц нараар дутагдаж байснаас бүх байшинг хоослоод явахыг дээр гэж үзнэ.

Батистен мэхийн ёслов.

- Та цөмийг нь ава д ирээрэй. Харин байшин ердийнхөө байдлаар үлдэх ёстой шүү. Зөвхөн доод давхрын цонхны хаалтуудыг хаагаарай . тэгээд л болно .

Хёрдугаар давхрынхныш яах вэ?

Түүнийг хэзээ ч хаадаггүй та мэднэ шүү дээ . За яв. ганцаараа хоолоо иднэ , Али үйлчилнэ гэж хлээрэй гэдгийг хэлэв.

Гүн ердийнхөө заншлаар багахан хоол идэд , Алийг дагуулж явган хаалгаар гараад зугааг яваа юм шиг Булоныг ой хүрээд гараад зугаалан яваа юм шиг Булоны ой хүрээд санаандгүй мэт Парисын зүг эргэж бүрэнхий болоход Елесейн Тал дахь байшингийнхаа өмнө иалд очив.

Байшин хав харанхуй байв. харин Батистенын ярьсанчлан байшингаас дөчөөд алхмын зайтай байдаг хаалгачийн байранд сүүмэлзэн гэрэл асаж б айв.

Хүн гэтэж байгаа эсэхийш ажиглан харахын тулд молд налж , хурц нүдээр модот гудамж бай хажуугийн гудамжийг харав. Арваад минутын дараа хэн ч хойноос нь ажиглаагүй байгааг магдлан мэдэв.

Тгээд Алитай хамт явган хаалга өөд гүйж очоод түргэн орж, авч явсан нууц шатныхаа түлхүүрээ хаалгыг онгойлгож , унтлагынхаа өрөөнд оров. Тэгэхдэ хаалгач нь ч хоосон байшинд эзэн ирснийг сэжиглэхээргүй ганц ч хөшиг хөдөлсөнгүй .

Унтлагынхаа өрөөнд ороод Алийг дохиж зогсоов.

Дараа нь нөгөө жижиг өрөөнд орж харав. Бүх зүйл хуучин хэвээрээ байлаа . Шүүгээ хуучин байрандаа, түлхүүр нь дүүжлээстэй хэвээр байлаа . Тэгээд түлхүүрээр хоёр эргүүлж цоожлоод сугалан авч унтлагынхаа өрөөний үүдэнд очиж түгжээг нь тайлаад , жижиг өрөөнөөс гарав.

- тэр завсар Али гүнгийн зааж өгсөн , богион карибан , буудлагын газар будлагаас дутуугүй мэргэн тусгалтай хоёр амтай хоёр гар буу авчирч ширээн дээр тавив. Гүн ингэж зэвсэглэснээр таван хүний амийг гартаа барьж байх чадалтай болов.
- Есөн цаг хагас болж байв. Гүн , Али хоёр яаруухан шиг зүсэм талх идэж, аяга испани дарс уулаа . Дараа нь гүн оньс хөдөлгөн нэг өрөөнөөс нөгөө өрөөнд болж байгаа юмыг харах болгодог хаалт банзыг нээв. Дэргэдээ гар буу, карабинаа тавьж Али хажууд нь загалмайтны аян дайны үеэс одоо хүртэл нь өөрчлөгдөөгүй араб ламын сүх барьж зогсов.
- Елисейн Тал руу харсан жижиг өрөөний цонхны адил, унтлагын өрөөнийх нь цонхоор гудамж харагдаж байв.
- Ингэж хоёр цаг өнгөрлөө . Гадаа хав харанхуй байсан боловч Али зэрлэг араатан нүд шиг хурц хараагаараа , гүн харанхуйд харж сурснаароа хашаан доторх моны мөчрийн өчүүхэн хөдлөхийг боловч харж байв.

Хаалгачийн байран дахв гэрэл аль хэдийн унтарчээ . хэрэв үнэхээр мудгай орох нь үнэн бол цонхоор орохгүй доод давхрын шатаар гарч ирнэ Жэж бодож болох балаа . Монте-Кристо хорон санаатнууд хулгай хийх биш, түүнийг алах гэж байгаа юм байна гэж бодлоо . Тэгэхээр зорилго нь унтлагын өрөө бөгөөд энэ өрөөнд нууц шат эсвэл жижиг өрөөний цонхоор орж таарна.

Алийг шатны үүдэнд зогсоод өөрөө жижиг өрөөг ажиглан харав.

Тахир дутуучуцудын байшингийн цаг арван хоёрт арван тав дутуу байгааг зааж цохив. Баруун зүгийн чигтэй салхинд гурван удаагийн муухай дуу дуугарлаа .

Сүүлчийн цохилтын дуу намдаагүй байтал жижиг өрөөний тэнд үл мэдэг чихрах дуу гарав. Дахиад дуугарлаа . Дөрөв дэх удаад нь гүн эрэлзэх юмгүй олов. Сурмаг гараар алмаасаар цонхны шил зүсэж байв.

Гүнгийн зүрх цохиллов. Хүмүүс аймшиг түгшүүрт хичнээн хатуужсан ч заналхийлж байгаа ямар ч аюулыг угтан золгоход бэлхэн байлаа ч гэсэн бодол ба үнэн байдал , санаа ба түүний биелэн хрёрын хооронд ямар их ялгаатай бадгийг зүрхнийхээ түрэгдсэн цохилтоор ямагт мэдэрдэг ажээ .

Монте-Кристо , Али өөд дохиж болгоомжлохыг мэдэгдэв. Цаадах нь жижиг өрөөний талаас аюул ирж байгааг мэдээд эзэн өөдөө дөхөж очив.

Монте-Кристо дайсан нь хэн болох хичнээн хүн байгааг мэдэх сэн гэж тэсэж ядаж байлаа .

Алмаасын зүсэлтэнд хяхнаж байсан цонх яг гүнгийн харж байсан цоорхойн эсрэг зүгт байв. Гүн цонхыг хараад байв. Харанхуйн дунд нэгэн их бараан сүүдэр байхыг олж үзэв. Дараа нь цохны шил дээр нь цаас наачихсан юм шиг харагдахгүй хар болоод цонхны шил дуугарсан боловч газар унасангүй. Гаргасан нүхээр нэг гар орж ирээд цонхны түгжээг эрэв. Секундийн дараа цонх онгойж хүн орж ирэв. Тэр хүн ганцаараа байв.

- Зоригтой луйварчин юм даа! гэж гүн шивгэнэв.

Тэр үед Али мөрөнд нь аяархан хүрэхэд гүн эргэж харав. Али унтлагын өрөөний гудамж уруу харсан цонх өөд заав.

Монте-Кристо цонхны зүг гурав алхав. Өөрийн үнэнч зарцын гайхам сонор сэргэлэнг мэднэ. Үнэхээр хаалганы баруун талд нэг хүн юман дээр гараад зогсчихсон байшин дотор юу болж байгааг харах гэж оролдож байв.

- Тэгэхээр эд хоёул юм байна. Нэг нь ажиллаж, нөгөөх нь харуул хийж байх нь байна гэж хэлэв.

Тэгээд гудамжинд зогшо байгаа хүнээс нүд бүү салгаарай гэж Алид дохиод өөрө жижиг өрөөн дотор орсон хүн өөд явав.

Хулгайч тасалгаанд орчихсон хоёр гараа урагш нь сарвайлгаад болгоомжтой хөдөлж байв.

Эцэст байдалтай танилцсан бололтой, жижиг өрөөн дотор хоёр хаалга байсныг хоёуланг нь түгжив.

Тэгээд унтлагын өрөө уруу ордог хаалганд дөхөж очихоох гүн орох нь гэж бодод нэг гар буугаа авав. Гэвч зэс гогцоонд тээглэх дэгээний дууг сонслоо . Энэ бол зөвхөн болгоомжлон арга хэмжээ байв. Шөнийн гийчин тээлэх дэгээний дууг сонслоо . Энэ бол зөвхөгн болгоомжилсон арга хэмжээ байв. Шөнийн гийчин гүнг түгжээг тайлсныг мэдэхгүй учир гэртээ байгаа юм шиг тайван хийх юмаа хайж эхлэв.

Хулгайч өргөн хармаанаасаа юм гаргаж аваад жижиг ширээн дээр тавьж , шүүгэ өөд очоод цоожийг нь тэмтрэн үзээд түлхүүр нь алга байгааг мэдлээ .

Гэвч эвдэгч болгоомжтой хүн байсан учир бүгдийг урьдаас бэлтгэжээ . Гүн нэгн л сонин хяхнх дуу гаргахыг дуулав. Энэ бол эвдэрсэн цоож онгойлгох гэж засварчингийн авчирдаг багжийн дуу мөн байв. Хулгайч нар түүнийг “Алтан гургалдай” гэж нэрлэдэг ажээ. Шөнө дүлийн цагаар цоожин дотор эргэж чахран сэтгэлийг нь ыаясгадаг учраас тэгж нэрлэсэн нь мэдээж.,

- Энэ зүгээр л нэг хулгайч байна гэж Монте-Кристо цөхөрсөн байдалтайгаар бувтнав.

Харин нөгөө хүн харанхуйн дундаас тохирох багажаа олж чадахгүй байв. Тэгэхээр ширээн дэр юавьсан юмныхаа тусламжиг авахад хүрэв. Хулгайч оньс дарахад сулхан боловч гэрэл асааж түүний гар, нүүрийг гийгүүлэв.

- Аа, энэ байдаг байж! Гэж дуугараад Монте-Кристо гайхан алхам ухарч - Энэ чинь ... гэв.

Али сүхээ өргөв.

- Байрандаа зогсож бай. Сүхээ таьв . Одоо бидэнд зэвсэг хэрэггүй гэж Монте-Кристо шивэгнэн хэлэв.

Тэгээд хэдэн үг хэлбэл, намдуу дуугарсан боловч хулгайчид дудуулж эртний гуранздагчийн байдалтай болж хөшин зогсов.

Али гүнгийн хэлснийг сонсоод хана уруу очиж өлгүүр дэSp байсан хар хувцас , гурвалжин малгай авчрав. Тэр завсар Монте-Кристо цамц, хантааз, дотуур хувцсаа тайлав. Ханын завсрын нүхээр туссан гэрэлд XIV Людовикаас хойш хэн ч хуьганаас айхаа больж, хутгалуулахын оронд толгойгоо авахуулахад болсон учир Францад хэрэглэхээ больсон нимгэн төмөр цээжинд нь өмсөөтэй байгаа харагдав.

Энэ гархин хуг гүнгийн өмссөн хиймл хар үс шиг ламын хар хувцасны цаанаа халхлагдаж , гурвалжин малгай өмсөн нт гүнг лам болгон хувиргав. Тэр завсар эвдэгч дахиад яимээ сонстохгүй болохоор дахин цээжээ өргөж, Монте-Кристо хувцса өмсөү байхад шүүгээ уруу очиж, цоож нь “алтан гургалдайн” дууны доор тачигнав.

- За , за, яах вэ. Чи бас хэдэн минут нухаж бай! гэж эвдэрч хэдий туршлагатай боловч онгойлгож чадахгүй нууцгай цоожиндоо итгэлтэй гүн хэлэв.

Тэгээд цонх руу очив.

Юман дээр гараад харж байсан хүн одоо буучхаад гудамжаар нааш цаашаа алхаж байв. Гвч тэр хүн Елисейн Тал буюу Сен- Онорегийн зүгээс хүн хүрээд ирж магадгүй гэж харх ёстой атал зөвхөн гүнгийн гэрт юу болж байгаа, жижиг өрөөнд юу олж байгааг илүү сонирхоод байх нь хачин хэрэг байв.

Монте-Кристо гэнэт духаа алгадахад уруул дээр нь инээмсэглэл тодрон гарав.

Тэгээд Алид дөхөж очив.

- Чи энд харанхуйд зоJсож бай, тэгээд юу дуулсан , юу ч болсон нэрээ дуудахаас нааш эндээс бүү гараарай гв.

Али толгой дохин зөвшөөрөв.

Тэгэхэд Монте-Кристо шүүгээнээс асаасан лаа гаргаж аваад хулгайчийг цоожоор оролдож байгаа минутыг ашиглан, нүүрэн дээр гэрэл тусахаар аярахан онгойлгов.

Хаалга даанч чимээгүй онгойсон учир хулгайч юу ч сонссонгүй . Гэвч тасалгаа гэнэт гийгүүлэгдсэнийг мэдээд ххэп гайхав.

Тэгээд эргэж харав.

- Сайн байна уу, эрхэм хүндэт Кадрусс !ийм орой та энд юу хийж байгаа юм бэ? гэж Мнте-Кристо хэлэв.

- Брузони ламтан! Гэж Кадрусс дуу алдлаа .

Тэгээд, хоёр хаалга түгжээтэй байсан байтал энэ гайхалтай хүн ямар замаар ороод ирснийг мэдэхгүй гайхан, цоож гаргачаа газар унагаж гөлрөн зогслоо .

Гүн айсан хулгайчийн гарах ганц замыг хааж Кадрусс ба цонх хоёрын хооронд огслоо .

Лам Бузони юу? гэж Кадрусс гүн өөд гөлийн харав.

- Тийм ээ , би лам Бузони мөн байна! эрхэм Кадрусс намайг таньсан явдалд би их баяртй байна.

- Та ер нь юм мартадгүй хүн юм . Та бид хоёр чинь арваад жил уулзаагүй юм байна гж Монте-Кристо хэлэв.
- Эн иайван байдал, ёжтой яриа, захирангүй дуу нь Кадруссыг үхтэл нь айлгаж толгой нь эргэв. Гараа мушиглан, шүдээ хавиран.
- Ламтан! Гэж дуугарав.
- Тэгэхлээр бид чинь Монте-Кристо гүнгийнхнийг ухахаар шийдээ шив дээ? гэж хуурамч лам мэлэхэд Кадрусс гүнгийн хажгуугаар цонх руу өнгөрчих гэж дэмий оролдон,
- Эрхэм лам , эрхэм ламтан би өөрөө ч мэдэхгүй байна... Үнэмшээд нада... танд тангаргальа гэж шивэгнэнэ.
- Зүссэн шил , нууц гэрэл, цоож онгойлгогч , хагас дутуу эвдсэн шигээ энэ бүгд чинь өөрөө хэлээд өгч байна шүү дээ гэж гүн хэлэв.
- Кадрусс ийш тийшээ арчаагүй байдлаар харж, нуугдах булан, зугтаагаад гарчихаж болох нүх сүв харна.
- Та чинь өнөө алуурчин эрхэм хэвээрээ шив дэ гэж гүн хэлэв.
- Эрхэм лам та бүгийг мэдсэн болохоор тэр бол би биш, Карконта байсан гэдгийг мэдэх ёстой шүү дээ, үүнийг шүүх ч зөвшөөрсөн . Тийм ч учраас намайг зөвхөн албанд хөдөлмөр хийлгэхээр ял ногдуулсан шүү дээ .
- Та дахиад тийшээ лчихыг хичнээн оролдож байгааг бодоход хугацаагаа дуусгаад гарчихжээ .
- Үгүй, лам гуай, намайг нэг хүн суллан тавиулсан юм .
- Тэр хүн чинь нийгэмд их тус хүргэж дээ .
- Үгүй би ам өгч... гэж Кадрусс хэлтэл,
- Тэгээд та чинь ялт хөдөлмөрөөс оргожээ? Гэж гүн яриагий нь таслан хэлэв.
- Ээ чааваас гж айсан Кадрусс хариулав.
- Дахин хэрэг өдүүлбэл хүндэтгэх шалтгаан байдаг шүү дээ !... Хэрвээ би андуураагүй бол түүний төлөө толгой авдаг байхаа . манай нутгийн ёжтой улсын ярьдагаар тэр тусмаа л муу даа, чөтгөр алгад гэв.
- Эрхэм лам минь хүнд уруу татагдчихлаа .
- Хэрэгтэн бүхэн тэгж хСлдэг юм .
- Дутагдаж гачигдаад л.
- Боль доо . Дитагдаж гачигдсан хүн гуйлга гуйж, лангуун дээрээс талх хулгайлдаг болохоос биш , хоомон байшинд орж шүүгээ эвддэг юм биш. Танд миний өгсөн очир эрдэнийг аваад дөчин таван мянган франк тоолж өгсөн эрдэнэсийн худалдаачин Жоаннесыг мөнгө, алмас эрдэнэ хоёрыг зэрэг авахаар алахдаа та бас л дутагтаж гачигдаад тэгсэн үү?
- Эрхэм лам та уучилна уу? Та намайг нэг удаа аварсан, одоо хоёр дахь удаагаа авраач гэж Кадрусс хэлэв.
- Энэ туршлагыг давтан хийх хүсэл төдийлөн алга даа.
- Эрхэм лам та энд ганцаараа байна уу? Эсвэл намайг барь авах цагдаа нар нуугдаж байна уу? гэж Кадрусс асуухад,

- Би огт ганцаараа байна. Миний зөөлөн сэтгэл шинэ гай зовлонд хүргэж болох боловч би таныг нигүүлсэн хайрлахад бэлэн байна. Та надад бүх үнэнээ хэлбэл би таныг суллан тавина гэж лам хэлэв.
- Эрхэм лам минь, та бол үнэхээр намайг аврагч хүн юм гэж хэлээд, Кадрусс Монте-Кристо өөд нэг алхав.
- Таны ялт хөдөлмөрийн газраас оргоход чинь хүн тусалсан гэж ярив уу?
- Эрхэм лам минь, энэ бол үнэн юм шүү, итгэж үзээрэй.
- Хэн бэ?
- Нэг англи хүн.
- Түүнийг хэн гэдэг вэ?
- Лорд Уилмор.
- Би түүнийг танина. Та худлаа хэлж байгаа эсэхийг шалгана.
- Эрхэм лам минь, би чин үнэнийг хэлж байна.
- Тэгвэл тэр англи хүн таныг дэмжин тэтгээ юу?
- Намайг биш, надтай хамт нэг гав гинжинд байсан нэгэн корсик залууг сулласан юм.
- Тэр корсик залууг чинь хэн гэдэг вэ?
- Бенедетто.
- Энэ чинь зөвхөн нэр нь л шүү дээ.
- Хэрээс олдсон, эцэггүй хүүхэд байгаа юм.
- Тэр залуу тантай хамт оргосон уу?
- Тэгсэн.
- Яаж оргосон юм бэ?
- Бид Тулоны ойролцоо Сен-Мандриед ажил хийж байсан. Та Мен-Тандриег мэдэх үү?
- Мэднэ.
- Хүмүүс цөм өдөр дундаас нэг цаг хүртэл унтдаг байсан....
- Ялт хөдөлмөрийн хүмүүст өдөр дундын амралт өгдөг гэнэ! Мөн ч их эрхлүүлдэг юм байна даа! гэж лам хэлэв.
- Бид чинь нохой биш хүн болохоор ноход гомдох сон гэж гүн хэлэв.
- Бусдыгаа унтсан хойно бид хоёр жаахан холдоод англи хүний өгсөн хуурайгаар гинжээ тас хуурайдаад оргочихсон юм.
- Тэр Бенедетто чинь яасан юм бэ?
- Мэдэхгүй.
- Та заавал мэдэх ёстой.
- Үгүй үнэндээ мэдэхгүй. Би түүнээс Гиерт салсан.
- Тэгээд өөрийн үгийг улам итгүүлэх дүр үзүүлэн ламд алхам дөхөв. Лам нагаа газраа л тайван хэвээрээ зогсоно.
- Та худлаа хэлж байна гэж лам захирангуй дуугаар хэлэв.
- Эрхэм лам аа!...
- Та худлаа хэлж байна. Тэр хүн мөн хуучин хэвээрээ таны найз нөхөр хэвээр байгаа, магадгүй хамжаа чинь ч байж мэднэ.
- Эрхэм ламтан!
- Тулоноос оргосноос хойш та ямар хөрөнгөөр амьдарч байсан бэ? хариулаарай.

- Аль тохиолдсоноороо л амь зууж явлаа.
- Та худлаа хэлж байна! гэж лам гурав дахь удаагаа улам ширүүнээр хэлэв.

Кадрусс айж гүн өөд харав.

- Та түүний өгсөн мөнгөөр амьдарч байсан шүү дээ гэж лам хэлэхэд Кадрусс,
- Тийм ээ, тэр үнэн, тэр баян ноёны хүү болсон гэж хэллээ.
- Тэр яаж баян ноёны хүү болдог билээ?
- Нууцгай хүү нь юу байна.
- Тэр хүнийг чинь хэн гэдэг юм бэ?
- Энэ байшингийн эзэн, Монте-Кристо гүн.
- Бенедетто гүнгийн хүү байх гэнэ ээ? гэж одоо өөрөө гайхсан Монте-Кристо асуув.
- Тийм ээ, тийм л болж таарч байна. Гүн түүнд хуурамч эцэг олж өгөөд, сард дөрвөн мянган франк өгдөг, бас гэрээслэлээр таван зуун мянган франк үлдээж өгч байгаа.
- Өө, тийм байдаг байж! Хэмээн учрыг тааварлан мэдсэн лам хэлээд, - Одоо тэр залуу чинь хэн гэдэг нэртэй байна? гэв.
- Андреа Кавальканти.
- Тэгэхээр миний найз Монте-Кристо гүн гэртээ хүлээн авдаг, мадмуазель Данглартай суух гэж байгаа залуу мөн байх нь ээ?
- Яг мөн.
- Тэр золгүй амьтан үүнийг тэсвэрлэж байна уу. Та түүний амьдрал, биен дээр нь дарсан тэмдгийг мэднэ биз дээ?
- Би юу боллоо гэж нөхөртөө садаа болох ёстой юм бэ? гэж Кадрусс хэлэв.
- Тийм ээ, үүнийг эрхэм Дангларт би л мэдэгдэх ёстой юм байна.
- Эрхэм лам, бүү тэгээрэй!
- Яагаад?
- Яагаад гэвэл та үүгээрээ биднийг хэрчим талхнаас минь салгачихна.
- Би бузар булай амьтдын хэрчим талхыг үлдээх гэж та хоёрын эвсэгч, гэмт хэргийн хамжаа чинь болох гэж үү?
- Эрхэм лам! Гэж Кадрусс улам оройтон гуйж байв.
- Би бүгдийг хэлнэ.
- Хэнд?
- Эрхэм Дангларт?
- Чөтгөр авчамайг гэж хэлээд Кадрусс хутгаа сугалан гүнгийн цээж уруу шааж – Ламтан чи юу ч хэлэхгүй болно гэв.

Тэгтэл хутга нь маханд шааж орсонгүй, халтиран өнгөрөхөд Кадрусс ихэд гайхлаа.

Тэр хооронд гүн бугуйнаас нь зүүн гараараа барьж ава д, гар нь хөшиж хутгаа алдтал чанга атгав. Хоро санаат өвдсөндөө бархирав.

Гэвч гүн бархирахыг нь хайхралгүй эхлээд өвдөг дээрээ сөхөртөл, дараа нь шал дэр үхэтхийн унатал бугуйг нь мушгисаар байв.

Гүн түүний толгой дээр хөлөө тавиад,

- Бузар чиний гавлыг чинь хага цохивол таарах байсна юм гэв.
- Намайг өршөөж хайрлаач гэж Кадрусс хашгирав.

Гүн хөлөө авч,

- Бос гэж хэлэв.

Кадрусс бослоо.

- Эрхэм, лам та бас айхтар атгах юмаа! мөн ч их хүч байна шүү! гэж Кадрусс бадайрсан гараа үрэн хэлэв.
- Дуугаа тат! Чам шиг ийм цусанд дуртай араатанг номхтгож бай гэж бурхан надад хүч чадал хайрласан юм. Би түүний нэрийн төлөө үйлчилж байдаг хүн, мэдэв үү, бузар золиг! Чамайг энэ минутад өршөөж хайрласан нь, гагцхүү л бурхны санаа бодолд нийцүүлэх гэж байгаа хэрэг.
- Ёох! Гэж арайхийн сэргэсэн Кадрусс хэлэв.
- Май, энэ үзэг цаас ав. Хэлж өгснийг бичээрэй!
- Эрхэм ламаа, бич бичиж чаддаггүй.
- Худлаа үзэг аваад бич.

Кадрусс дуулгавартай захирагдан бичсэн нь:

“Өршөөлт эзэн минь, таны гэртээ хүлээн авч, охинтойгоо суулгах гэж байгаа хүн бол надтай хамт Тулоны ялт хөдөлмөрийн газраас оргосон ялтан хүн. Тэр 59 дугаартай, би 58 дугаартай байсан юм. Түүнийг Бенетто гэж дууддаг байсан. Тэр жинхэнэ эцэг эхээ мэдэхгүй учир өөрийн ямар нэртэй болохыг мэддэггүй юм”

- За тэгээд гарынхаа үсгийг зур! Гэж гүн хэлэв.
- Та намайг игэж хөнөөх нь үү?
- Тэнэг минь, би чамайг хөнөөе гэсэн бол цагдаагийн газар хүргүүлчих байхгүй юу. Тэгээд ч энэ бичиг зохих эзэндСэ хүрэхийн цагт чамд ч болгоомжилж айгаад байх юмгүй болох байх. Тэгэхээр гарынхаа үсгийг зур.

Кадрусс гарынхаа үсгийг зурав.

- Шосе-д Антен гудамжинд суудаг банкны эзэн, эрхэм Данглар танаа гэж бич гэв.

Кадрусс хаягийг бичингүүт лам зурвасыг авч,

- За одоо зайл гэв.
- Хаагуур гарах вэ?
- Ирснээрээ л гар!
- Та намайг энэ цонхоор гар гэж байгаа юм уу?
- Чи энүүгээр орж исрэн биз дээ.
- Эрхэм лам та надад нэг муу хийх нь ээ дээ.
- Тэнэг минь, би юу хийдэг юм бэ?
- Та намайг яагаад хаалгаар гаргаж болдоггүй юм.
- Хаалгачийг сэрээж яах юм бэ?
- Эрхэм лам та намайг үхээсэй гэж бодохгүй биз дээ.
- Бурхны л хүсэж байгаа юмыг би хүсэж байдаг.
- Намайг доошоо буутал адахгүй гэж ам өгөөч.
- Ямар аймхай тэнэг амьтан бэ?
- Та намайг яах нь вэ?
- Энэ тухай яамаас өөрөөс чинь асуух хэрэгтэй. Би чамайг аз жаргалтай хүн болгох гэж хүссэн. Гэтэл чи алуурчин болсон!

- Эрхэм лам минь та одоо сүүлчийн удаа оролдоод үз л дээ гэж Кадрусс хэлэхэд,
- За яах вэ. Би хэлсэн үгэндээ дандаа хүрдгийг чи мэдэн шүү дээ? гэж гүн хэлэв.
- Тийм ээ гэж Кадрусс хэлэв.
- Хэрэв чи гэртээ бүрэн бүтэн харивал...
- Би танаас өөр хэнээс айх билээ?
- Хэрэв чи гэртээ бүрэн бүтэн харьдаг юм бол Парис, ер нь Францыг орхиж яв. Би чамд үнэнч гударгаар амьдрах хугацаанд чинь багахан хөрөнгө өгч байх болно. Хэрэв чЭ гэртээ бүрэн харьдаг юм бол...
- Тэгвэл? ... гэж Кадрусс хоолой нь чичрэн асуув.
- Тэгвэл чамайг бурхан өршөөсөн юм байна гэж мэдээд бЭ ч бас уучлах болно.
- Та намайг үхтэл минь айлгаж байна! гэж Кадрусс ухрах зуур бувтнахад гүн түүнд цонх өөд зааж,
- Одоо зайл! Гэв.

Амлалтад бүрэн тайвшараагүй байсан Кадрусс цонх давж, гадна талаас нь тавьсан шат дээр хөлөө тавив. Тэнд хамаг бие нь чичрэн зогсов.

- Одоо буу гээд лам гараа зөрүүлэн цээжиндээ аваад хэлэв.

Кадрусс энэ талаас ямар ч аюул байхгүйг мэдэж ухаан ороод доошоо бууж эхлэв.

Тэгэхэд гүн лаа барьж цонхон дээр очоод цонхоор бууж яваа хүнд нөгөөдөх нь гэрэл гаргаж өгч байгаа юм шиг гудамжнаас харагдахаар гэрэлтүүлэв.

- Лам та яаж байна? хэрэв эргүүл.... гэж Кадрусс хэлэхэд лаагаа даруй үлээж унтраав.

Кадрусс цаашаа бууж бүр газарт хөл нь хүрсэн хойноо сая л санаа нь бүрэн амрав.

Монте-Кристо унтлагын өрөөндөө орж цэцэрлэг гудамж өөд иүргэн харж, Кадрусс эхлээд цэцэрлэгт бугаад түүнийг тойрон явж орж ирснээсээ өөр газраар гарах гэж хашааны өнцөгт шат аавчин тавьж байхыг харав.

Дараа нь гүн бас дахин гудамж өөд харж, Кадруссын хүлээж байсан хүн мөн түүний давах гэж байгаа хашааны өнцөг өөд гүйж явах нь харагдав.

Кадрусс шатаар аяархан өгсөж хаигийн дээд гишгүүр дээр хүрч очоод гудамжинд хүнгүй байгаа эсэхийг ажиглан харав.

Нэг ч амьд хүн, өчүүхэн ч чимээгүй нам гүм байв.

Тахир Дутуучуудын байшнигийн цаг шөнийн нэг цаг болсныг мэдэгдэж цохив.

Тэгэхэд Кадрусс хашааны орой дээр суугаад шатаа татаж нөгөө талд нь тавив. Дараа нь бууж эхлэв. Үнэндээ буусан биш шатныхаа арал модыг даган гулгав. Ингэж чадмаг гулгах нь анх ингэж бууж байгаа бишийг харуулна.

Харин доошоо гулгачихсан болохоор зогсох аргагүй байв. Шатны дунд хүрч яваад харанхуй булангаас хүн үсрэн гарч ирэхийг харжээ. Тэгээд түүнийг дөнгөж газарт хүрмэгц гараа далайх нь харагдаж хамгаалж амжаагүй байтал нь нуруу уруу нь хүчтэй шаахад, бархираад шатаа алдлаа.

- Туслаарай гэж хашхиртал хажуу уруу нь дахин шаав.
- Аллаа! Гэж Кадрусс хашхираад ойчив.

Тэгэхэд нөгөө хүн үснээс нь зуурч гурав дахь удаагаа цээж уруу нь хутгалав.

Энэ удаа Кадрусс хашхирах гэснэ боловч зөвхөн гинших дуу гараад, гурван шархнаас нь цус олгойдон гоожно.

Алуурчин золиосоо дахин дуугарахгүй гэдгийг мэдээд үснээс нь барьж толгойг нь өргөв. Кадруссын нүд аниастай, ам нь мурийчихсан байв. Алуурчин үхсэн гэж үзэж хаячихаад алга болчхов.

Тэгэхэд нь Кадрусс явсныг нь мэдээд байдаг чадлаа шавхан сөөнгө хоолойгоор

- Аллаа! Би үхлээ! Эрхэм лам минь туслаач! Гэж хашхирав.

Энэ муухай дуу шөнийн харанхуйд цуурайтав. Нууц шатны хаалга, дараа нь цэцэрлэгийн явган хаалга нээгдэж Али, эзэн хоёр дэнлүү барин гүйж байгаа харагдав.

6. БУРХНЫ ЦЭЭРЛЭЛ

Кадрусс гоморхсон дуугаар бас л,

- Лам минь туслаач, туслаач гэж дуудсаар байв.
- Юу болоо вэ? гэж Монте-Кристо асуув.
- Туслаач, намайг алж байна гэж Кадрусс хэлэв.
- Тэсэж байж үз, бид очиж л явна.
- Өнгөрсөө! хожимджээ! Та нар миний үхлийг л харах гэж иржээ. Яаж хутгалсан гэж санана. Хэчнээн цус гарав аа! гэж хэлээд ухаан алдлаа.

Али, эзэнтэйгээ шархадсан хүнийг өргөж гэртээ оруулав. Тэнд оруулаад Монте-Кристо хувцсыг нь тайлахыг Алид тушааж тайлуулахад аймшигтай гурван шарх гарч ирэв.

- Бурхан минь, чи заримдаа өшөө авахдаа удах юм. гэвч тэр өшөө тэнгэрээс улам ч хүчтэй болж бууж ирэх юм даа.

Али, эзэн өөдөө цааш юу хийвэл зохихыг асуусан мэт харав.

- Одоохон Сен-Оноред очоод вангийн прокурор эрхэм де Вильфориг нааш нь аваад ир. Замдаа хаалгачийг сэрээгээд эмч дуудуул.

Али хуурамч ламыг одоо хүртэл ухаагүй байгаа Кадрустай үлдээгээд өөрөө тушаалыг биелүүлэхээр явлаа.

Гамшигт учирсан хүн дахин нүдээ нээхэд гүн түүнээс хэдэн алхмын зайтай газар суугаад их л өрөвдөн зовсон байдалтай, маань уншиж байх шиг байв.

- Эмч, эмч гэж Кадрусс гиншинэ.
- Эмчид хүн явуулсан гэж лам хариулав.
- Эмч надад тус болохгүйг мэдэж байна. гэвч жаахан тэнхээ орж нэг юм хэлмээр байна.
- Юун тухай!
- Намайг алсан хүний тухай.
- Та түүнийг таньсан уу?
- Танилгүй яах вэ! Энэ бол Бенедетто байсан.
- Нөгөө корсик залуу юу?
- Тэр биеэрээ мөн.
- Таны нөхөр үү?

- Тийм ээ. Тэр надад гүнгийн байшингийн байдлыг зурж өгсөн юм. Тэгэхдээ, би гүнг алж орхивол өвий нь залгамжлан авах эсвэл гүн намайг алчихвал надаас салж амрах гэж горьдсон юм байж. Тэгээд дараа нь намайг гудамжинд отож байгаад аллаа.
- Би эмч, вагийн прокурор хоёрт зэрэг хүн явуулчихсан.
- Тэр хожимдоно. Цус минь гоожиж дуусаж байх шиг байна гэж Кадрусс хэлэв.
- Байзнаарай гэж Монте-Кристо гүн хэлээд гарч жижиг лонхтой юм барьж орж ирэв.

Түүнийг байхгүй хооронд үхэж байгаа хүний хөдөлгөөнгүй нүд хаалга өөд ширтэн харж, түүгээр л тусламж орж ирнэ гэж горьдож байв.

- Бушуулаарай, лам минь, бушуулаарай! Би одоохон ухаан алдах нь байна гэж хашхирав.

Монте-Кристо шархадсан хнү дээр ирж хөхөрсөн уруул дээр нь өнөө барьж орж ирсэн шилтэй шингэнээсээ гурав дусаав.

Кадрусс гүнзгий амьсгаа авав.

- Дахиад, дахиад... та надад амь оруулж байна гэж хэлэхэд ширээт лам,
- Дахиад хоёр дуслыг дусаавал та үхчихнэ гэж хариулав.
- Яагаад хэн ч ирэхгүй байна вэ? Би алуурчийн нэрийг хэлэх гэсэн юм.
- Би таны орноос мэдэгдэл бичиж өгөх үү? Та гарын үсгээ л зурчихна биз.
- Тэг, тэг... гэж Кадрусс хэлэхэд үхэхдээ өшөөгөө авах нь гэж нүд нь гялалзан байв.

Монте-Кристо бичсэн нь:

“Тулонд ялт хөдөлмөрийн газар хамт байсан 59 дугаартай миний найз Бенедетто гэдэг корс хүний гарт би амь үрэгдэв” гэжээ.

- Бушуулаарай, бушуулаарай! Тэгэхгүй бол би гарын үсэг зурж амжихгүй шүү гэж Кадрусс хэлэв.

Монте-Кристо түүнд үзэг бариулахад Кадрусс бүр чадлаа шавхан байж гарынхаа үсгийг зураад гэдрэг унаж,

- Эрхэм лам та бусдыг нь яриарай. Тэр өөрийгөө Андреа Кавальканти гэдэг, жононгууд зочид буудалд суудаг, бас... бурха минь би үхлээ! Гэв.

Тэгээд Кадрусс дахин ухаан алдлаа. Лам түүний нүүрэнд шилтэй шингэнээ оройтуулбал шархтан нүдээ харав.

Өшөө авах хорон санаа ухаангүй байхад ч гэсэн орхисонгүй.

- Лам та, бүгдийг нь ярина, тийм ээ?
- Энэ бүгдийг, бас өөр олон юм ярина.
- Өөр юу ярих юм бэ?
- Таныг гүнгээр алуулах гэхдээ энэ байшингийн зургийг танд өгсөн байх гэж хэлнэ. Бас гүнд захидал бичиж тэр тухай урьдчилан мэдэгдсэн тухай хэлнэ. Тэр үед нь гүн байгаагүй учир, би түүний захидлыг хүлээн авч таныг энд хүлээснээ хэлнэ.
- Түүнийг лав цаазаар авна, тийм ээ? Түүнийг цаазлуулж өгөхийг надад амлаач дээ? Би ингэж найдаад л үхье. Ингэж бодож үхэхэд надал хөнгө байна гэж Кадрусс хэлэв.

- Тэр таныг дагаж ирээд үргэлж хүлээж басйныг хэлнэ. Таныг цонхоор гарахыг хараад тосон гүйж, нуугдсаныг хэлнэ гэж гүн үргэлжлүүлэн ярив.
- Та энэ бүгдийг харсан юмуу?
- “Хэрэв чи гэртээ бүрэн бүтэн харьдаг юм бол бурхан чамайг өршөөж гэж мэдээд би ч бас чамайг уучилна” гэж миний хэлснийг сана л даа.
- Тэгээд та надад сануулахгүй яагаа вэ? гэж Кадрусс дуу алдаад тохой дээрээ өндийх гэж оролдон, - Та намайг эндээс гармагцаа алагдана гэдгийг мэдсээр байгаад хэлдэггүй юм байжээ? Гэв.
- Үгүй, би Бенедеттогийн гарыг бурхны цээрлэл гэж үзсэн юм. Тэгээд бурхны тааллаас зөрж болохгүй гэж бодсон юм.
- бурхны үнэн шүүх! эрхэм ла мнь надад түүн тухай бүү ярь ! хэрэв тийм шүүх бадаг бол зарим нэг хүн цээрлүүлэгдэх ёстой гэдгийг та бусдаас илүү мэднэ.
- Тэсвэрлээрэй! Тэсвэрлээрэй! гэж лам хэлэх үхэ байгаа хүн түүний дуунаас тэвдэн сандран.

Кадрусс гайхан гүн өөд харав.

- Тэгээд ч бурхан бол бүхэнд энэрэнгүй байдаг. Танд ч гэсэн энэрэнгүйгэр хандсан . Бурхан юуны игөө эцэг шиг, дараа нь эс болбол шүүгч болдог юм шүү гэж лам хэлэхэд Кадрусс,
- Та бурханд итгэдэг үү? Гэж асуулаа .
- Гай болж одоо хүртэл итгээгүй явсанг юмаа гэхэд одоо чамайг хараад итгэх байсан гэж Монте-Кристо хэлэв.

Кадрусс гара зангидан тэнгэр өөд өргөлөө . Лам шархдсан хүний дээр түүнийг итгэ гэж тушааж байгаа юм шиг гара сунгаад

Чи сонсоу бай. амьсгаа хураахдаа ч гэсэн үйгүйсгэж багаа бурхан чиний төлөө юу хийсэн гэж санана. Бурхан чамд эрүүл би? хүч чадал хангалттай хөдөлмөр, тэрч байтугай нйз нөхөд нь ер ердийн чигч шулуун хүсэл эрмэлзэлтэй хүн бол тайван хангалттай байхаар аж амьдралаа өгсөн билээ . Бурхан ингэж элбэг арвинаар хайрласан энэ бэлгийг эдэлж ашиглахын оронд чи юу хийв? Чи залхуу хойрго , архи дарсны шавар намагт унасан, тэгээд согтуу байж байхдаа сайн нөхдийнхөө нэгийг урваж хөнөөсөн.

- Туслаач надад лам хэрэггүй , эмч хэрэгтй . шарх үхлийнх биш байж , би үхэхгүй амь аврагдаж магадгүй гэж Кадрусс хашхирав.
- Чи үхлийн үарх олсон . хэрэв танд энэ шингэнээс өгөхгүй бол аль хэдийн үхчихсэн байса. Дуулж бай чи!
- Та бас хачин лам юмаа! Үхэж байгаа хүнийг тайвшрулахын орон сүүлчийн нь горьдлогоос хагацааж байна гэж Кадрусс шивэгнэлээ .
- Чамайг найз нөхрөөсөө урван холдыож байхад чинь бурхан чамайг залхаалгүй зүгээр сануулаад орхисон . Чи гуйлагчин болж өлсөх гэгчийн үзсэн. Чи ертөнцийн сайн сайхныг олж авч болох амьдралынхаа хагасыг атаа жөтөөгөөр өнгөрөөсөн . Бүр тэгэхэ чи гэмт хэргийн тухай бодож гаичгдал дутагдлаар түүнийгээ зөвтгөх гэж оролдсон . Тэгэхд бурхан чамд гайхамшгийг үзүүлж надааро дамжуулан , чам шиг ийм явуу хүнд хэмжээ хязгааргүй их баялагийг бэлэглэн өгсөн. Гэтэл гэнэтийн энэ баяялаг гарт чинь ороол ирэхтэй

зэрэг чамд чамлалттай санагдаж , түүнийгээ хоёр дахин өсгөх гэж хүссэн. Ямар аргаар гээч? Аллагаар. Чи түүнийгээ хёр даин нэмэгдүүлд авчихсан боловч бурхан чамаас түүнийг чинь булаан авч өөрийг чинь шүүхийн өмнө уулгасан гэж лам үргэлжлэн ярихад:

- Тэр бол би биш. Би тэр жүүдийг алах гээгүй . Карконтаас л болсон юм гэж Кадрусс хэлэв.
- Тийм ээ бурхан энгүй их энэрэнгүй сэтгэлээр чамайг эдэлбэл зохих үхлээр чинь шийтгэсэнгүй . Харин хэлсэн үгийг чинь шүүгч нарын сэтгэлийг хөдөлгөхөөр болгшож, чиний амийг үлдээж өгсөн гэж Монте-Кристо гүн хэлэв.
- Яалаа гэж тэр вэ! Намйг бүх насаар ялт хөдөлмөрт зүтгүүлэхээр явуулсан шүү дээ! Энэ чинь энэрэнгүй сэтгэл үү?
- Гэвч золгүй амьтан , чи энэ бүгдийг энэрэнгүй сэтгэл гэж хүртэж байсан үү дээ . Үхлээ хүлээж байсан чиний бузар зүрх , чиний мөнхийн гутамшигийг дуулаад баярлан цохилж байсан шүү дээ . Яагаад гэвч чи бумад бүх ялт хөдөлмөрийнхөө адил ялт хөдөлмөрөөс зайлж олно , харин үхлээс зайлж болохгүй гэж үздэг байсан учраас тэр юм . Тэгээд ч чиний зөв болжээ . Шоронгийн хаалга санамсаргүй байтал нээгджээ . Хоёр хүнийг гутамшигаас ангижруулж буян хийх гэсэн нэг англи хүн Тулонд хүүрч ирсэн... Тэр чамайг , чиний нөхрийг сонгож авсан. Тэгээд ялт хөдөлмөрт насаа барах байсан чамд аз жаргал тэнгэрээс унаж чамд мөнгө , тайван чөлөөтэй байдалд бий болж дахин хүний ёсоор амьдарч болох байсан. Тэгэхэд чи гурван дахь удаагийн бурхны таалаас зөрчлөө . Чамд урьд өмнө байсанаас чинь илүү их хөрнгө мөнгө би болоход чи түүнийг чамлаж ямар ч шаардлаггүй юугар ч зөвтгөх аргагүй гурав дахв гэмт хэргээ хийж байна. Ингэхээр чинь бурхан тэнгэрэ тэсвэрлэхэ болив. Бурхан чамайг цээрлүүлэн залхаав.

Кадрусс хэлэхд Монте-Кристо аягатай ус өглөө .

- Бузар Бенедетто гэж Кадрусс аягаа өгөнгөө хэлээд, лав зайлж алга болно доо гэв.
- Хэнч зайлж гарахгүй . Бенедетто цээрлэгдэх болно доо. Та санваартан хүнийхээ үүргийг биГлүүлж Бенедеттог намайг алах гэхэд нь саад болох ёсгүй байсан билээ гэж Кадрусс хэлэв.
- Би юу? гэж гүн инээмсэглэн хэлэхэд амьсгаа хурааж байгаа хүний судасны цус зогсох шиг болжээ .
- Чиний хутга миний цээжний хамгаалалтанд мөргөж хугарсны дараа , Бенедетто чамайг алахад би саад хийх ёстой гэнэ ээ!... Хэрэв чи нүгэл хилэнцээ хүлээж уучлахыг гуйсан бол Бенедетто чамайг алахаас би саад хийх байсан байж магадгүй , гэтэл чи тийм биш дэндүү танхай балмад байсан учир би бурхны тааллаар болог гэж бодсон юм гэв.
- Бурханд би итгэдэггүй! Чи ч бас өөрөө итгэдэггүй... чи худлаа хэлж байна... чи худлаа ярьж байна! гэж Кадрусс хашхирав.
- Дуугаа тат. Чи биендээ үлдсэн цусныхаа эцсийн дуслбг алдаж байгаа шүү... Чи бурханд итгэдэггүй ч гэсэн түүний гараар үхэж багаа шүү дээ! Чи бурхандп итгэхгүй байна, гэтэл бурхан чиний ганц

залбирал , ганц үг, ганц дусал нулимсаар чинь нүглийг чинь уучлахад бэлэн байна. Чамаг доор чинь үхүүлэх алурчны хутгыг чиний зүг чиглүүлж чадаж байсан бурхан одоо бас чмайг нүгдээ наманчлаг гэж энэ хэдэн минутыг өгч байна. Одоохон ухааран бодож нүглээ наманчлан гэв.

- Үгүй би юунд ч нүглээ наманчлахгүй . Бурхан буг аль нь ч байхгүй харин гай тохиолдол гэж байдаг вюм гэж Кадрусс хэлэхэд Монте-Кристо

- Буг, бурхан аль нь ч байдаг юм . Чи бурохныг үгүйсгэсээр баг ад ингэж аргаа барж байхад би чиний өмнө баян яинээлэг , аз жргалтай зогсож чиний тэр гаднаа итгэхгүй гэж байгаа боловч дотроо итгэж байгаа бурханд залбирч хүч тамир нь цэцэглэж байгаа насан дээрээ явна гэж хэлэв.

- Та чинь ер нь хэн байна даа? гэж Кадрусс асуугаад, гал нь унтарч байгаа нүдээрэ гүнг харав.

Тэгэхэд нь Монте-Кристо лаа авч нүүрэндээ ойрхон бариад.

- Сайн хар гэв.

- Та чинь лам ... лам Бузони...

Монте-Кристо нүүрийг нь маш сайхан зохимжтой хүрээлэн байсан хиймэл урт хамар сахлаа хуу татан ав хаяв.

Бурхан минь хэрэв хар ус байгагүйсэн бол өнөөх англи хүн лорд Уилмор ч биш гэж Монте-Кристо хариулаад- Өнгөрсөн үзье сайн хар, бур эртний явдлуудыг дурсан сана.

Гүнгийн энэ үгэнд тийм их сорнозон адил татах хүч байсан бололтой золгүй амьтны уларч байгаа сэрэхүй сүүлчийн удаа сэхэж сэргэв.

- Нээрэ би таныг үзсэн хүн юм шиг, хэзээ нэгэн цагт таньдаг ч байсан хүн юм шиг байна гэж хэлэв.

- Тийм ээ , Кадрусс чи намайг үзсэн, чи намайг таньдаг байсан .

- Үгүй, та чинь хэн гэгч байна даа? Тгээд та намайг мэддэг байсан юм бол яагаад ингэж үхэхэд хүргэв.

- Яагаад гэвэл Кадрусс чиний шарх үхлийнх учраас ямар ч юм чамайг аварч чадахгүй . Хэрэв чамайг аварч болох байсан бол би үүнийг бурхны сүүлчийн энэрэл өршөөлийн нэг гэж үзэж чамайг амьдруулахыг оролдох байсан гэж эцгийнхээ булшийг мартаж тангаргалая.

- Эцгийхээ булшийг ий! гэж хэлээд Кадрусс амьдралын эцсийн оч гялсхийж энэ хамгийн ариун гэгээн тангараг тавьсан энэ хүчийг ойрхноос харахаар өндийж - Чи чинь хэн бэ? гэж асув.

- Гүн түүний тамир тасрахыг тасралтгүй ажиглаж байв. тиймээс ч энэ бол сүүлийн сэргэлт гэдгийг мэджээ . Тэгээд үхэж байгаа хүн уруу тонгойж , тайван боловч гунигтайгаар хэрэв. Тэгээд:

- Би бол... би бол гэж түүний чихэнд хэлэв.

Тэгэхэд түний амнаас, өөрөөч дуулахаас айсан мэт тийм аяархан хэлсэн нэр дуулдав.

Кадрусс өвдөг дээрэ өндийж , гараа дээш өргөө хамаг биеэрээ ганхаж байж хоёр алгаа хавсарч залбираад .

- Бурхан минь бурхан минь! би чамайг үггүйсгж бодож байсныг минь уучлаарай. Чи амьд байгаа юм байж. Үнэн хэрэг дээрээ чи бол тэнгэрийн эцэг, газрын шүүгч мөн! Бурхан минь, би чамд удаан итгэхгүй явсан! Бурхан минь сүнсийг минь хүлээн ав! гэв. Тэгээд Кадрусс сүүлчийнхээ удаа бархирч, сүүлчийн удаа гүнзгий амьсгаа аваад нүдээ аньж унав.
- Тэр дороо шархнаас нь цус гоожихоо болив.
- Тэр үхжээ.
- Нэг нь! гэж гүн нууц утгатай үг хэлээд аймшигт үхлээр дүрс нь хувирсан хүүр өөд харав.
- Алийн авчирсан вангийн прокурор хоёр ирэхэд лам Бузони үхдэлийн дэргэд хойтохыг нь уншаад сууж байв.

7.БОШАН!

Гүнгийнхнийг тонох гэж зоригтойгоор оролдсон тухай Парист бүтэн хоёр доло хоногийн турь яриа болжээ. Үхсэн хүн, өөрийгөө Бенедетто гэдэг хүн алсан гэж мэдгдэл бичсэн ажээ.

Цагдаагийн газар алуурчийн мөрөөр бүх төлөөлөгчөө тавив.

Кадруссын хутга, дэн хэлхээтэй дэгээ, түлхүүр болон хантаазнаас нь бусад бүх хувцсыг нь хаанаас ч олдохгүй байв. Харин хантааз нь бусад бүх хувцсыг нь хэрэгт нь хавсаргажээ. Харин хантааз нь хаанас ч олдохгүй байв. Кадруссын хүүрийг задлан шинжлэх газар явуулжээ.

Гүн хүн бүхэнд л намайг Отейльд байхад болсон хэрэг болхоор миний номын сангийн ховор номноос юм үзэж тэмдэглэл хийж авах гэж тэр шөнө манайд хонох зөвшөөрөл авсан байсан лам Бузониос л энэ тухай дуулсан гэж хариулж байв.

Бертуччо л түүний дэргэд Бенедетто нэрийг хэдэхд царай нь цонхийн зэвхийрч байв. Гэвч Бертуччогийн царайны өнгийг хэн ч сонирхсонгүй.

Гэмт хэрэг болсон газар ирсэн Вильфор энэ хэргийн учрыг өөрөө олохоор шийдэж, биеэрээ хариуцаж бүх эрүүгийн хэргийг явуулдаг шигээ шаргуу байдлаар мөрдөж эвлэв.

Түүнээс хойш гурван долоо хоног өнгөрсөн боловч, хэчнээн утгагүй эрж, хайж мөрдөж мөшгөвч юу ч гарсангүй. Дээдсийн хүрээлэн сайхь хлугай хийх гэсэн оролдлого, нэг хамжаа нь өнгөөгөө алсан тухайг мөртаж эхлэв. Мадмуазель Данглар, Андреа Кавальканти гүн хоёрын гэрлэлтийн тухай ярилцах боллоо.

Энэ гэрлэлт бараг албан ёсоор зарлагдсан бөгөөд Андреа банкны эзний гэрт хүргэний ёсоор байх болов.

Эцэг Кавалькантид бичив. Тэрээр хуримыг сайшааж, албан ажил нь Парма хотоос гарч явах бололцоо өгөхгүй байгаад харамсаад, жилд зуун тавин мянган ливрийн орлого оруулах хөрөнгө тасдаж өгөхөө бичжээ.

Бас гурван саяыг Дангларын дансанд хийж эргэлтэд оруулахаар тохирчээ. Залуу хүүд ирээдүйн хадам эцэг нь сүүлийн үед удаа дараалан мөнгөний худалдаанд алдагдалд орж ажил хэрэг нь төдий л бат суурьтай биш байгааг сануулан хэлэх хүн ч гарлаа. Гэвч харамгүй сэтгэл, итгэл найдвараар оргилсон Андреа энэ бүх хоосон цуу яриаг няцааж, тэр ч байтугай энэ тухай түшээ гүнд дурсалгүй ёсыг бодож өнгөрчээ.

Түшээ гүн ч бас Андреа Кавалькантийг бахархан байсан нь дэмий биш байлаа.

Мадмуазель Эжени Дангларын тухайд гэвэл, нөхөрт гарах үнэхээр дургүй байсан учир Андреаг үзэгдэх болсон явдлыг Морсероос хөндийрөх арга гэж үзэж байснаа харин Андреаг дэндүү ойртоод ирэхээр түүнд илэрхий дургүйцэх болов.

Түшээ гүн энэ байдлыг ажиглах мэдсэн ч байж болох юм. Гэвч зөвхөн зөрүүд загийн илрэл гэж үзсэн учир түүнийг мэдээгүй юм шиг царай гаргаж байв.

Түүнээс гадна Бошаны тогтоосон хугацаа дуусаж байлаа. Ташрамд хэлэхэд, уг хэргийг чимээ аниргүй намдаачих гэж зөвлөсөн Монте-Кристогийн рзөвлөгөөнийг зүй ёсоор үнэлэн үзэх бололцоо Морсерт ч гарчээ. Генералд хамаатай сонины мэдээг хэн ч анхаарсангүй бөгөөд тайж нарын Танхимд хуралдаж суудаг сайн төрөлт гүнг Яниний цайзыг урван худалдсан дарга гэж хэний ч толгойд орсонгүй.

Хэдий тийм боловч сонинд бичигдсэн хэдэн мөр зүйлийг санаатайгаар нийтэлсэн гэж эргэлзээгүй үзэж байсан Альбер өөрийгөө доромжлогдсон хэмээн тооцож байв. Түүнээс гадна тэр хоёрын ярианы төгсгөлд Бошаны байсан байдал түүний сэтгэлд гашуун мөр үлдээжээ. Тийм учраас тулалдах тухайгаа л бодож, харин үнэн шалтгаанааныг нь хэрэв Бошан зөвшөөрвөл гэрч нараасаа ч тас нуухаар байв.

Альберыг очсоноос хойш хэн ч Бошантай дайралдсангүй. Түүнийг сурагласан хүн бүрд хэд хоног юманд явсан гэж хэлдэг байв.

Тэр хаана байсан бэ? Хэн ч үүнийг мэдэхгүй.

Нэг өглөө Альберыг хиа нь сэрээж Бошан ирсэн тухай мэдэгджээ. Альбер нүдээ нухаад, Бошаныг доор тамхины өрөөнд хүлээж байна уу гэж хэлүүлээд өөрөө яаран хувцаслаж доошоо буулаа.

Түүнийг охоход Бошан булангаас булан руу алхаж байв. Бошан түүнийг хараад зогслоо.

- Өнөөдөр намайг очихыг хүлээлгүй өөрөө орж ирж байгаа явдлыг чинь би сайны ёр гэж үзэж байна. За, та бушуухан хэлээрэй. Би таны гарыг атгаж, Бошан та буруу байснаа хүлээж, миний найз хэвээр үлдлээ гэж хэлж болох уу. эсвэл би зүгээр л та ямар зэвсэг шилж авах вэ гэж асуух уу? гэж Альбер хэлэв.
- Альбер, юуны өмнө сууж ярилцъя гэж Бошан хэлэхэд Альбер түүний гунигтай дууг дуулаад гайхав.
- Үгүй эрхэм минь суухын өмнө та надад хариулт өгөх ёстой мэт санагдаж байна.
- Альбер...Хариулт өгөх л хамгийн хэцүү болчихдог үе бас байдаг шүү дээ гэж сэтгүүлч дуугарав.
- Би танаас мэдээгээ буцааж авах уу, үгүй юу гэж асуугаад хариулт хэлэхэд чинь хялбар дөхөмтэй болгож өгье.
- Морсер хэрэг явдал, нэр төр, нийгмийн байдал, фрнцын дэслэгч генерал, гүн Морсер шиг хүнтэй хамаатай болохоор зүгээр л нэг тийм эсвэл үгүй гэж хариулчихдаггүй юм.
- Тэгвэл яах ёстой юм бэ?
- Миний хийсний л адил юмыг хийдэг юм, Альбер минь. Бүхэл бүтэн гэр бүлийн ашиг сонирхол, нэр төрийн тухай хэрэг болоход, мөнгө, цаг хугаца,

хүчин зүтгэл ямар ч үүрэг гүйцэтгэгдэггүй юм. Найзтайгаа халз тулалдахын тулд зөвхөн нэг сэжиг хангалтгүй, лавтай итгэлтэй байх хэрэгтэй. Гурван жилийн турш найз нөхрийн ёсоор гар барьж явсан хүнтэйгээ сэлэм зөрүүлэх эсвэл буудалцах хэрэг болбол, хүн амьдралаа хамгаалахад чухал хэрэгтэй хүн ч ариун цагаан сэтгэлтэй очихын тул би яагаад ингэх болов гэдгээ дор хаяж лавтай мэдэх хэрэгтэй юм.

- За сайн байна гэж Альбер яаран хэлээд- Тэгээд энэ бүгд чинь юу гэсэн үг болж байна ? гэв.
- Энэ бол би дөнгөж саяхан Янинээс буцаж ирлээ гэсэн үг.
- Янинаас ий? Та юу?
- Тийм ээ, би
- Үгүй байлгүй!
- Эрхэм Альбер минь миний паспорт энэ байна. Нэвтрүүлэх тэмдгүүдийг нь хар л даа. Женев, Милан, Венец, Триест, Дельвино, Янина гэж байгаа биз. Бодвол та нэг Бүгд Найрамдах Улс, нэг хаант улс, нэг вант улсын цагдаагийн газарт итгэх юм байгаа биз дээ, даанч.

Альбер паспортыг үзээд Бошан өөд гайхан харж,

- Та Янина ороод ирлээ гэнэ ээ? гэж асуув.
- Альбер хэрвээ та надад хол хөндий хүн байсан бол, нөгөө хэдэн сарын өмнө хүрч ирж санасандаа хүрэх гэж шаардаж байгаад надад алагдсан англи хүн шиг байсан бол би өөртөө ийм хүнд үүрэг хүлээхгүй байсан юм. Гэвч таныг хүндэтгэдгээ үзүүлж үүнийг хийх ёстой гэж үзсэн юм. Надад тийшээ очиход долоо хоног, ирэхэд долоо хоног шаардагдлаа. Дөрөв хоног хөл цээрэнд, хоёр хоног уг гараа байж, бүгд нийлээд яг гурван долоо хоног боллоо. Урьд шөнө буцаж ирсэн, тэгээд танайд ирж байгаа нь энэ.
- Бурхан минь, ямар их удиртгалтай юм бэ! Та яагаад миний хүсэж байгаа юмыг хэлэхгүй удаагаад байна аа!
- Үнэнийг нь хэлэхэд Альбер минь...
- Таныг хэлж зүрхлэхгүй байна гэж бодож болох нь ээ.
- Тийм ээ, айж байна.
- Та сурвалжлагчаа худлаа хэлсэ байна гэж хүлээхээсээ айж байна уу? Бошан чи нэр алдраа бодохоо боль, шууд хэлчих. Таныг зоригтойд хэн ч эргэлзэхгүй.
- Огт тийм биш гэж сэтгүүлч шивгэнээд – Харин шал өөр юм байж гэв.

Альбер үхдэл мэт зөвхийрэв. Юм хэлэх гэснээ үг нү хоолой дээр нь ирээд тээглэх шиг болов.

- Найз минь гэж Бошан хамгийн эелдэг дуугаар хэлээд- Би танд уучлалт гуйж ирсэн бол илүү их баяртай, сэтгэл хангалуун ирэх байсан юм. Гэтэл харин... гэв.
- За юу вэ?
- Тэр мэдээ үнэн байдалд нийцэж байна, найз минь
- Яалаа гэнэ ээ! Тэр франц офицер...
- Тифийм ээ.
- Тэр Фернан уу?
- Тийм ээ.

- Пашийн цэргийн албан хааж байгаад урваж цайзыг нь өгсөн тэр...
- Найз минь миний хэлэх ёстой болсон зүйлийг уучларай! Тэр хүн танай эцэг мөн байна билээ!

Альбер, Бошан өөд ухасхийн дайрахаар зэхтэл түүнийг Бошаны гар нь биш, харин эелдэг зөөлөн харц нь барьж зогсоолоо.

- Энэ байна, найз минь. Баримт нотолгоо нь энэ байна гээд хармаанаасаа бичиг гаргаж ирэв.

Альбер уг цаасыг задла үзлээ. Энэ бол Янины дөрвөн нэртэй хүнээс Али-Тобелений цэрэгт албан хааж байсан, сургагч-хурандаа, Фернан Мондего, урваж Янины цайзыг хоёр мянган түрийвчээр худалдан буулгаж өгснийг баталсан бичиг байв.

Гарын үсгүүд нь консулаар батлагдсан байв.

Альбер гуйвалзсанаа, буйдан дээр ойчлоо.

Одоо эргэлзэх юм байхгүй, овог нэр нь бүрэн бичигдсэн байв.

Тэрээр минут хэртэй бачимдан тарчилж байснаа тэссэнгүй хүзүүний нь судас томорч, нулимс нь цувлаа.

Бошан уй гашуунд дарагдсан нөхрийгөө гүнээ эмгэнэн харж байснаа түүн дээр очив.

- Альбер, та одоо намайг ойлгож байгаа биз дээ? Би өөрийн биеэр бүгдийг үзэж, бүгдэд итгэж, бүх зүйл эцэгт чинь сайн сайхнаар өнгөрч, түүний сайн нэрийг хамгаална гэж найдаж явсан юм. гэтэл миний цуглуулсан мэдээнүүд бол тэр Али-Пашийн генерал губернатораар цол дэвшүүлсэн офицер, сургагч Фернан Мондего бол одоогийн Фернан де Морсероос өөр хэн ч биш болчихлоо. Тэгээд би таныг найз нөхөр гэж бодож явдгийг бодоод хүрч ирлээ.

Альбер өдрийн гэрлээс нуугдах гэсэн юм шиг хоёр гараараа нүүрээ дараад буйдан дээр хэвтэж байв.

- тэгээд л би танд, манай энэ тайван биш үед эцгийн явдал хүүхдүүдэд сүүдэр тусгадаггүй юм гэж хэлэх гэж яаран хүрч ирлээ. Альбер бид бүх хувьсгалын үед, цэргийн ёслолын хувцас ч шүүгчийн нөмрөг нь ч шавар шалбааг цус нөжинд хутгалдаагүй туулж өнгөрсөн цөөн хүмүүсийн дунд төрсөн билээ. Одоо миний гарт таны бүх нууц, бүх баталгаа байж байхад таны хүнч сэтгэл чинь гэмт хэрэг гэж үзэх болж байгаа тэр халз тулааныг хүлээн ав гэж хэн ч надад тулгаж чадахгүй. Харин таны надаас шаардах эрхгүй болсон тэр зүйлийг чинь би танд сайн дураараа шилжүүлж өгье. Надад ганцааранд минь байгаа энэ гэрчилгээ, нотолгоо үүрд алга болохыг та хүсэх үү? Энэ аймшигт нууц зөвхөн та бид хоёрын дунд хадгалагдан үлдэхийг та хүсэх үү? Хэзээ ч олонд мэдэгдэхгүй гэдгийг нэр төрөө барьж андгайлъя. Альбер та үүнийг хүсэх үү? Найз минь та үүнийг хүсэх үү?

Альбер ухасхийн Бошаны хүзүүгээр тэвэрч,

- Сайн санаат найз минь! гэж дуун алдлаа.
- Үүнийг ав гэж Бошан Альберт бичиг цаасыг өглөө.

Альбер түүнийг нь ухасхийн шүүрч аваад, атгаж хумин базаад ураад хаячих гэлээ. Тэгснээ хэзээ нэгэн цагт тасархай нь салхинд босож духыг нь шүргэн хийсэж

мэдэх юм гэж бодоод янжуур асаахад зориулж үргэлж асаалттай байдаг лаанд дөхүүлэн цөмийг нь шатаачихлаа.

- Зүйргүй сайн найз минь! гэж Альбер бичиг цаас шатааж байхдаа шивгэнэн байв.
- Энэ бүгд муухай зүүд мэт мартагдах болтугай. Энэ харлаж байгаа цаасан дэгүүр өрвөлзөж байгаа гал адил алга болдог. Энэ нуран унаж байгаа үнсэн дээр манарч байгаа утаа шиг замрхан арилаг гэж Бошан хэлэв.
- Тийм, тийм харин энэ бүхнээс бидний мөнхийн найрамдал үлдэг, аврагч минь. Энэ нөхөрлөлийг үр хүүхэд минь дурсан хүндэтгэж яваг. Энэ нөхөрлөл таны, миний нэр төрийг аварсан ачийг хариулах ёстой гэж ямагт бодогдуулж яваг. Бошан, хэрэв хэн нэг хүн энэ тухай мэдвэл би өөрийгөө буудаж ална. Эсвэл ээжийгээ бодоод амьд үлдлээ ч гэсэн Францыг орхиж явна.
- Хонгор Альбер минь! гэж Бошан дуугарав.

Гэвч Альберийн энэ гэнэтийн% нэлээд зохиомол баярт сэтгэл нь түргэн алга болж, улам ч уйтгар гунигт уналаа.

- Юу болов? та яав? Гэж Бошан асуухад,
- Сэтгэл нэг л сэвтэй болчихдоо. Толбо суугаагүй гэж бодож явсан эцгийгээ хүндэтгэх, итгэх бахархах сэтгэлээс сална гэдэг тийм амаргүй хэрэг. Ай Бошан минь! Би одоо эцгийнхээ нүүрийг яаж харна? Үнэсэх гээд ирэхэд нь духаа өгөхгүй сэгсрэн зайлуулж, гар барих гэхээр нь угзран авах уу?... Бошан минь би хамгийн золгүй хүмүүси©н нэг юм байна. Хөөрхий золгүй ээж минь! гэж хатагтайн зураг өөд нулимс бүрхэж бүрэлзсэн нүдээр харж хэлээд, - Хэрэв ээж минь энэ тухай мэдвэл яасан их зовж шаналах бол! гэв.
- Найз минь, сэтгэлээ барь! Гэж Бошан хэлээд түүний гарыг барив.
- Үгүй ингэхэд тэр мэдээ танай сонинд яаж яваад гарчихав дээ? Энэ бүхний цаана хэн нэгний өшөө хорсол, нууц дайсан байна гэж Альбер дуу алдлаа.

Тэр тусмаа л зоригтой байх хэрэгтэй дээ. Таны царай дээр сэтгэл түгшсэний нэг ч тэмдэг байж болохгүй. Тэгэхээр үер борооны хар үүл тэнгэр ниргэтэл үхэл сүйтгэлийг өөртөө нуун авч явдаг шиг чи энэ гаслан зовлонгоо дотроо авч явах хэрэгтэй. Найд минь тэнгэр ниргэх хүртэл хүчээ хайрлаж бай гэж Бошан хэлэв.

- Та үүнийг төгслөө гэж бодохгүй байна уу гэж Альбер айж асуув.
- Би юу ч бодохгүй байна, гэсэн ч юм бүхэн бололцоотой байдаг шүү дээ. Ингэхэд...
- Юу вэ? гэж Альбер Бошаны тээнэгэлзэхийг хараад асуув.
- Та одоо мадмаузель Дангларын болзоот нөхөр нь гэж тооцогдсоор байна уу?
- Та яагаад чухамхүү одоо үнийг асууж байна аа?
- Яагаад гэвэл тэр гэр бүл болох явдал та бид хоёрын одоогийн энэ ярьж байгаа юмтай холбоотой учраас асууж байгаа юм._
- Яалаа гэж! Та Дангларыг...

- Би зүгээр л таны хурим юу болж байна гэж асууж байгаа юм. Миний асууж байгаа үгэнд, асууж байгаагаас өөр ямар ч илүү дутуу юм бүү бодоорой.
- Үгүй хурим болохоо больсон гэж Альбер хариулахад Бошан,
- За сайн болж гэж хэлэв.

Дараа нь залуу хүү бас л гунигтай байхыг хараад,

- Альбер, гадагшаа гаарт гаръя. Булоны ойгоор морьтой эсвэл тэргээр зугаалъя. Энэ таныг сэргээнэ. Дараа нь хаана нэгэн газар орж хоол идээд, тус тусынхаа ажил хэргээр оролджё.
- Дуртайяа зөвшөөрнө. Харин явган явъя. Жаахан ядарвал надад ашигтай байна гэж Альберо хэлэхэд Бошан,
- Тэгье л дээ гэв.

Тэгээд хоёр найз явган гарч цэцэрлэгээр явж Мадлен сүм хүрэхийн үес Бошан,

- Та бид хоёр нэгэнт энд ирчихсэн хойно Монте-Кристо гүнгийнхээр орьё. Тэр лав таныг зугацуулах бахйх. Тэр хүнээс хэзээ ч юу ч асуудаггүй болохоороо хүнийг бодож яваа бодлоос нь ангижруулж сайхан чаддаг хүн байгаа юм. Ер нь хэзээ ч юу ч асуудаггүй хүн л хамгийн сайн тайвшруулагч шиг надад санагддаг юм гэхэд Альбер,
- Тэгье л дээ. Орьё, би түүнд сайн байдаг юм гэж хэллээ.

8.ЖУУЛЧЛАЛ

Хоёр залууг хамт ирсэнд Монте-Кристо маш их баярлаалаа.

- Тэгэхээр бүх зүйл дуусгавар болж, учир нь олдож, эв зүйгээ олсон байх гэж найдаж байна гэж хэлэхэд,
- Тийм ээ, тэр тэнэг яриа шуугиан аяндаа өөрөө замхарсан. Хэрэв тэр яриа дахин сэргээд ирвэл би л лав түрүүлж хамгаалан босно. Ээн тухай ярихаа больё гэж Бошан хариу өгүүлэв.
- Би бас тэгж зөвлөснийг Альбер танд баталж өгөх байх аа. Та хоёр намайг маш эвгүй юм хийж суухад орж ирж дээ гэж гүн хэлэхэд,
- Та юу хийж байна вэ? гэж өөрийн бичиг цаасыг эмхэлж цэгцэлж байна уу? гэж Альбер асуув.
- Бурхан минь! Өөрийнхийгөө биш. Надад тийм бичиг цаас байдаггүй, минийх бол ямаг эмх журамтай байдаг юм. Би эрхэм Кавалькантийн бичиг цаасыг эмхэлж байна.
- Кавалькантий ий? гэж Бошан өөдөөс нь асуув.
- Гүн түүнийг тэтгэж дэмждэгийг та мэддэггүй юм уу? хэмээн Альбер хэлэхэд Монте-Кристо гүн,
- Та огт буруу ярьж байна. Би хэнийг ч тэтгэж тусалж дэмждэггүй, тэгээд Кавалькантийг бол бүр ч үгүй гэв.
- Тэр миний орноос мадмаузель Данглартай суух гэж байгаа. Намайг зовлонд учруулж байгаа шүү дэ эрхэм Бошан минь гэж Альбер инээмсэглэхийг оролдон хэлэв.
- Яалаа гэнэ ээ! Кавальъанти мадмаузель Данглартай суух гэнэ ээ? гэж Бошан асуув.

- Та чинь тэнгэрээс унаад ирээгүй биз дээ? Одоо Парис даяар л энэ тухай ярьж байгаа шүү дээ гэж Монте-Кристо хэлэв.
 - Та энэ гэрлэлтийг бүтээж өгөө юу? гэж Бошан гүнгээс асуув.
 - Би юу? Эрхэм шинэ сонин мэдээ бүтээгч минь, та имй шуугиан тараачих гэж бүүү бодоорой! Бурхан минь! Би хүний гэрлэлтийг бүтээж өгөх гэнэ ээ? Үгүй, та намайг мэдэхгүй байна. Харин би янз бэрээр эсэргүүцсэн. Тэр ч байтугай жуучлахаасаа ч татгалзсан.
 - Ойлгож байна, манай найз Альберээс болоод тэр биз? гэж Бошан хэлэв.
 - Надаас болоод тэгж байгаа юм биш юм. Би аль хэдийн үүнийг хүсэж байсан гэдгийг гүн батлаж өгөхөөсөө татгалзахгүй байх. Би үүний төлөө гүнд баяр талархлаа хүргэх хэрэггүй гэж өөрөө хэлээд байгаа юм. Тэгэхлээр би эртний хүмүүс гиг л үл мэдэгдэх бурханд зул өргөөд л сууж байх хэрэгтэй болох нь байна гэж Альбер хэлэв.
 - Энэ бол надаас их хол хөндий хэрэг бөгөөл би хадам эцэг хүргэн хоёрын аль алинаас нь хөндийдүүхэн харьцаатай байдаг. Харин мадмаузель Данглар л эрх чөлөөтэй байдлаас нь холдуулах гэж хичээж хүнтэй суулгах гэж шаардахгүй болохоор надад баярлаж сайн санаж явдаг хэвээр байх гэж гүн хэлэв.
 - Тэр хурим нь удахгүй болох уу?
 - Тийм ээ, намайг сэрэмжилж хэлсээр байтал хийх гэнэ билээ. Би тэр залуу хүнийг мэдэхгүй л дээ. Баян чинээлэг, нэртэй айлын хүүхэд л гэж ярьцгаах юм. Надад бол зөвхөн “ярьцгаах юм” гэж хэлэхээс өөр юм алга. Би энэ тухай Дангларт улиг домог болтол нь хэлсэн, гэвч итали хүүдээ ухаангүй л байна билээ. Тэр ч байтугай би түүнд тэр хүүг бага байхад нь хүн сольчихсон ч юм уу, цыганууд хулгайлаад явчихсан, эсвэл хүмүүжүүлэгч нь алдчихсан юм гэж сураг дуулддаг юм гэдэг нэгэн чухал зүйлийн тухай мэдэгдэх нь зүйтэй гэж бодоод хэлж ч үзсэн. Түүний эцэг нь арван жилийн турш түүний тухай сураг сонсоогүй байсан гэдгийг би сайн мэдэж байна. Энэ тэнүүчилж явсан арван жилийн дотор түүний юу хийж явсныг бурхан л мэдэх байх даа. Гэтэл ингэж болгоомжлон хэлсэн маань ч тус болсонгүй. Хошуучид захидал бичиж баримт бичгүүдийг авчрахыг надад даалгасан юм. Тэр нь энэ байна. Би тэднийг Дангларынд явуулна. Гэвч Пилат шиг гараа угаана даа.
 - Та сурагчийг нь салган авчихаар мадмаузель д Армильи танд гомдохгүй юм бЭз? гэж Өошан асуулаа.
 - Танд үнэндээ хэлж мэдэхгүй байна. Гэхдээ Итали явах болов уу даа, хатагтай Данглар надтай ярихдаа итлаийн урлагийн газруудын эздэд танилцуулах захидал бичиж өгөхийг гуйж байна билээ. Би тэгэхээр нь Валле театрын захиралд захидал бичиж хатагтайд өгсөн. Тэр захирал надад тус болох учиртай хүн байгаа юм. Харин Альбер та яаж байна? Та их уйтгартай байх чинь. Та өөрөө мэдэлгүй мадмаузель Дангларт дурлачихсан юм биш биз дээ?
 - Үгүй л юм шиг байна шүү дээ гэж Альбер хэлээд, гунигтайгаар инээмсэглэлээ.
- Бошан зураг үзэж эхлэв.

- Ямар ч л гэсэн та хуучин шигээ биш байна. Юу болоо вэ, хэлээч? Гэж Монте-Кристо үргэлжлэн асуухад, Альбер
- Толгой өвдөөд байна гэж хэлэв.
- Хэрэв тийм бол эрхэм бээс минь, бид танд биеэ муу байхад хэрэглэдэг өөр юугаар ч сольшгүй тийм эм танд хэлэх үү гэж Монте-Кристо хэлэхэд,
- Ямар? Гэж Альбер асуулаа.
- Газар солих.
- Уухай!
- Би ч бас төдий л тавгүй байгаа болохоор явах гэж байна. Надтай хамт явахгүй юу?
- Та төдий л тавгүй байна гэнэ ээ, яагаад тэр вэ? гэж Бошан асуув.
- Танд хэлэхэд амархан. Танай байшинд мөрдлөг явуулбал таны царай ямар байхыг харах сан!
- Мөрдлөг ий? Ямар мөрдлөг тэр вэ?
- Эрхэм де Вильфор өөрөө миний хүндэт алуурчийн талаар мөрдөн мөшгөж байгаа. Ямар нэг ялт хөдөлмөрөөс оргосон дээрэмчин юм байх аа.
- Өө, тийм, би энэ тухай сонин дээрээс уншсан. Тэр Кадрусс гэдэг чинь ямар хүн бэ? гэж Бошан суулаа.
- Прованс нутгийн хүн юм гэнэ. Вильфор түүний тухай Марсельд байхдаа дуулсан. Данглар бас үзсэн ч хүн шиг санагдаж байна гэж байна билээ. Тийм учраас авнгийн прокурор өөрөө энэ хэрэгт хамгийн идэвхтэй оролцож байгаа бөгөөд цагдаагийн газрын дарга ч маш их сонирхож байгаа бололтой. Тэдний энэ их анхаарал санаачлагын ачаар сүүлийн хоёр долоо хонот Парис түүний орчин тойрноос олж барьсан бүх дээрэмчинг Кадруссыг алсан хүн гэдэг нэрийдлийн дор манай гэрт дагуулж ирж байна. Хэрвээ ингээд үргэлжлээд байвал гуравхан сарын дараа алдарт цранцын вант улсын дэвсгэр нутагт миний гэрийн доторх байдлыг мэдэхгүй нэг ч луйварчин, нэг ч алуурчин үлдэхгүй бололтой. Тэгэхээр би байшингаа тэдний дуранд тавьж өгчихөөд харсан зүг уруугаа явахаас өөр юмгүй болох нь, бээсээ надтай явъя!
- Дуртайяа зөвшөөрнө.
- Тэгвэл шийдэх шив дээ?
- Тэглээ, харин хаашаа явах вэ?
- Агаар нь цэвэр, шуугиан чимээ нь бүүвэйлж байгаа юм шиг хүн хэчнээн ч бардам сэхүүн байлаа гэсэн өөрийнхөө өчүүхэн дорой болохыг мэдэрдэг тийм газар уруу явна.
- Тэр чинь хаана байдаг газар вэ?
- Тэнгис дээр бээс минь. Би чинь далайчин хүн шүү. Би бүр хүүхэд байхдаа хөгшин Далайн гар дээр, гоо сайхан Амфитритийн элгэн дээр унтаж байсан юм. Би түүний ногоон цув, хөх цэнхэр хувцсаар нь тоглож, байсан юм. Би далайд сэтгэлтэй хүүхэн шигээ хайртай, үзэхгүй удвал санаж уйтгарладаг юм
- Явъя, гүн минь!
- Тэнгис уруу юу?
- Тийм ээ.

- Та зөвшөөрч байна уу?
 - Зөвшөөрч байна.
 - Тэгвэ« бээс минь дотор нь явахад орон дотроо байгаа юм шиг тийм тохиромжтой сүйх тэрэг өндөөрө шатны дэргэд ирж хүлээх болно. Тэр тэргэнд дөрвөн морь хөллөнө. Бошан, миний сүйх тэргэнд дөрвүүлээ маш тохитой багтана шүү. Бидэнтэй явахгүй юу? Би таныг урьж ыайна.
 - Баярлалаа, би тун саяхан далайгаар яваад ирлээ.
 - Далайгаар яваад ирлээ гэнэ ээ?
 - Тийм ээ, бараг л тийм. Би дөнгөж саяхан Борромейн арлаар аялаад исрэн.
 - Тэгсэн ч яах вэ, явъя л даа! гэж Альбер хэлэв.
 - Үгүй эрхэм Морсер, хэрэв би ийм азтай завшаанаас татгалзаж байгаа бол тийм бололцоогүй бйгаа гэсэн хэрэг юм. Түүнээс гадна гээд Бошан дуугаа намхан болгож – Одоо би үгүй дээ л мэдээнүүдийг ажиглан харж байхын тулд Парист байх хэрэгтэй байна гэхэд Альбер,
 - Та бол үнэнч найз нөхөр маань мөн. Таны хэлдэг зөв. Бошан минь ажиглан харж тэр мэдээ нийтэлсэн дайсныг олж илрүүлэхийг хичээгээрэй гээлд Альбер Бошан хоёр салах ёс гүйцэтгэв.
- Тэр хоёр энэ гар барилтаар хүний дэргэд хэлж болохгүй юмаа ойлгуулалцав. Сэтгүүлчийг гараад явахаар,
- Энэ Бошан чинь сайн хүн шүү! Тийм ээ, Альбер аа? гэж Монте-Кристо хэлэв.
 - Сүү шиг цагаан санаатай хүн дээ. Би түүнд их хайртай байдаг юм. Одоо надад хаашаа явах нь хамаагүй ч гэсэн бид хаашаа явахыг хэлж өгөх үү?
 - Хэрэв таныг дургүйцэхгүй бол Норманди орно.
 - Маш сайхан хэрэг. Бид тэнд байгалийн сайханд байх болно, тийм ээ? Дээдсийн хүрээлэн, айл хөршЁйн аль нь ч байхгүй байх уу?
 - Бидэнд зөвхөн унах морь, ан хийх ноход, загас барих завьтай л байх болно.
 - Энэ чинь ь надал хэрэгтэй ганц юм маань тэр дээ. Би ээждээ хэлчхээд дараа нь тани мэдэлд хүрч ирье.
 - Танд зөвшөөрөх юм болов уу? гэж Монте-Кристо асуулаа.
 - Юу тэр вэ?
 - Нормандад явахыг.
 - Надад уу? Би дуртай юмаа хийж болохгүй гэж үү?
 - Тийм ээ, нээрээ та чинь дуртай газраа ганцаараа жуулчилдаг л даа. Бид хоёр Италид дайралдсан сан билээ.
 - Тэгээд юу гэж?
 - Харин таныг Монте-Кристо гэдэг нэртэй хүнтэй хамт явахыг чинь зөвшөөрөх болов уу?
 - Гүн та мартагтай хүн юмаа.
 - Яагаад тэр билээ?
 - Ээж танд ямар талархалтай ханддаг тухай танд би хэлээгүй гэж үү?
 - Бүсгүйчүүлийн сэтгэл хувирамтгай гэж нэгдүгээр Франциск хэлсэн. Шекспир, хүүхнүүд долгион адил улс гэж хэлсэн билээ. Энэ хоёрын нэг нь

их ван, нөгөөдөх нь агуу ир яруу найрагч байсан. Тэр хоёр хоёулаа бүсгүйчүүлийн төрөлх байдлыг лав сайн мэдэж байсан байж таарна.

- Тийм ээ, гэвч миний ээж бол зүгээр нэг бүсгүй биш жинхэнэ сайн бүсгүй юм.
- Уучлаарай, би таны хэлснийг бүрэн ойлгосонгүй.
- Миний ээж сэтгэл санааны талаар харам боловч, хэрэв хэн нэгэн хүнийг хайрлавал бүх насаараа хайрлаж дурлана гэж хэлэх гэсэн юм.
- Уухай гэж хэлээд Монте-Кристо санаа алдсанаа – Тэгвэл надад огт хайхрамжгүйгээс арай өөрөөр хандаж байна гэж та бодож байна уу? гэв.
- Би танд хэлсэн, одоо ч дахиад хэлчихье, та е° нь их хачин өвөрмөц, ер бишийн хүн юмаа гэж Альбер зөрж хэлэв.
- Боль доо!
- Таны, хүн болгоны сониуч занг хөдөлгөдөг гэхээ байя гэхэд сонирхлыг татдаг чанарт мөн автсан байна билээ. Бид хоёр хоёулхнаа байхаараа гагцхүү таны тухай л ярьдаг юм.
- Тэгэхээр ээж чинь Манфретэд бүү итгээрэй гэж зөвлөж байна уу?
- Үгүй, харин ч бүр надад: “Альбер минь энэ гүн их сайн хүн гэж би итгэж байна. Түүний хайрыг нь хүлээхийг хичээгээрэй” гэж хэлдэг юм.

Монте-Кристо эргэж хараад санаа алдсанаа,

- Нээрээ тэгж байна уу? гэж асуув.
- Тэгэхээр ээж миний явахад дургүйцэхгүйгээр барахгүй харин өөрийн хь санаа бодолтой нийцэж байгаа учраас сайшаах болно гэж Альбер хэлэхэд,
- За тэгвэл орой болтол баяртай. Таван цагт энд байж байгаарай. Бид хүрэх газраа шөнө дунд буюу шөнийн нэг цагт хүрнэ гэж Монте-Кристо хэлэв.
- Яалаа гэнэ ээ? Трепорт уу?
- Трепор буюу түүний орчны газарт.
- Та наймхан цагийн дотор дөчин найман бээр газар явна гэж санаж байна уу?
- Энэ арай ч удаан байгаа юм гэж Монте-Кристо хэлэв.
- Та ер нь гайхамшигт хүн юм! Та удахгүй төмөр замыг гүйцэх нь байна. Энэ ч ялангуяа Францад амархан ажил л даа. Харин цахилгааны мэдээг гүйцэх нь байна шүү дээ.
- Тэнд хүрэхэд бидэнд ямар ч гэсэн найман цаг шаардагдах болохоор бүү хожимдоорой.
- Бүү санаа зов. Би бүр чөлөөтэй хүн. гагцхүү замынхаа юмыг л төхөөрөх хэрэгтэй.
- За тэгвэл таван цагт уул᠑ъя.

Альбер гарч одлоо. Монте-Кристо толгой дохиж инээмсэглээд, гүн бодолд авта дуугүй зогслоо. Тэгээд эцэст нь ухаан санаа дарь бодлоо хөөх гэсэн мэт гараараа духаа илбээд, хонх руугаа очиж, хоёр дахин дарж дуугаргав.

Бертуччо орж ирэв.

- Би бодож байснаараа маргааш нөгөөдрөөс биш өнөөдөр таван цагт Норманди орохоор гарна. Таван цаг хүртэл танд хийх ажил байна. Анхны

өртөөний адуучингуудад хэлсэн үү? Өнөөдөр надтай хамт де Морсер бээс явна. За яв гэж Монте-Кристо хэлэв.

Бертуччо гаран одож, сүйх тэрэг зургаан цагт өнгөрөн гарна гэж хэл хүргэхээр Понтуазе руу морьтой хүн давхиулав. Понтуазийн өртөөнд байсан хүн дараагийн буудалд хүн явуулж, тэр нь цааш нь хүн явуулах зэргээр хэл хүргэв. Ингэж зургаан цагийн дараа бүх өртөөлсөн буудлуудад хэл хүрч чадлаа.

Гүн явахынхаа өмнө Гайде дээр орж хэзээ, хаашаа явах гэж байгаагаа хэлээд бүх байшинг түүний мэдэлд үлдээв.

Альбер яг цагтаа ирлээ. Тэр сүйх тэргэнд суухдаа уруу царайтай байсан боловч хурдан давхилтаас болж тэр байдал нь даруй замрхан арилав. Ийм хурдан явж болдог гэж Альбер огтхон ч бодоогүй байжээ.

- Францад замаар явах ямар ч бололцоо алга. Шуудангийн сүйх тэрэгнүүд цагт хоёрхон бээр явахын дээр нэг жуулчин нөгөөгөө зөвшөөрөл авахгүйгээр гүйцэж түрүүлж гарахыг хориглосон тэнэг хууль энэ бүгд аймшигтай хэрэг юм. Ямар нэг өвчтэй буюу золигийн амьтан бусад бүх эрүүл саруул хүмүүсийн замыг хааж саатуулаад байж болох юм. Би өөрийнхөө хөтөч, өөрийнхөө морьдоор жуулчлан явадг болохоор энэ бүх тохиромжгүй байдлаас зайлсхийж чаддаг юм. Тийм ээ, Али? Гэж Монте-Кристо хэлэв.

Тэгээд гүн сүйх тэрэгнийхээ цонхоор толгойгоо цухуйлгаж морьдоо чүү гэхэд, тэдгээр нь давхих биш бүр нисэх шиг хурдлав. Сүйх тэрэг вангийн мазаар цахилгаан адил гялалзан давхиахд энэ гялалзан өнгөрөх солирыг хүн бүхэн эргэн харж үлдэнэ. Али хашгхирах дууг сносоод цагаан шүдээ гялалзуулан инээмсэглэж булиа гараараа жолоогоо атган, сахлаг дэл нь салхинд хийссэн морьдоо хөөргөнө. Цөл говийн хүү Али өөрийн хэвийн байдалд байгаа нь энэ бөгөөд цасан цагаан хувцсан дээр хар нүүр нь тодорч, нүд нь гялалзан манарсан тоосон дунд давхих нь салхины бурхан мэт харагдаж байв.

- Энэ ч ёстой миний хэзээ ч үзээгүй цэнгэл байна гэж Альбер хэлэв.

Түүний царайд үлдсэн уйтгарт байдлын сүүлчийн сүүдэр сөрөх салхинд үлээгдэн арилах мэт замхрав.

- Та энэ морьдыг хаанаас авдаг юм бэ? Эсвэл эднийг танд захиалгаар хийж өгдөг юм уу? гэж Альбер асуув.
- Чухам тийм. Би зургаан жилийн өмнө Мажараас маш сайхан азарга олсон юм. Тэгээд түүнийг худалдаж авсан. Чухам чаж авлаа даа мэдэхгүй байна. Бертуччо л мөнгийг нь өгсөн юм сан. Тэр жилдээ азарга маань гучин хоёр унага өгсөн юм. Та бид хоёр энэ азарганы бүх удам угсааг үзнэ. Тэд цөмөөрөө духан дээрх сарнаасаа өөр ямар ч толбо байхгүй. Тэр морин заводын эрхлэгч хаан татвар эмч шилж авч байгаа юм шиг гүүнүүдийг шилж сонгож авсан байсан юм.
- Гайхалтайяа!... Үгүй, гүн та ийм олон мориор яах гэсэн юм бэ?
- Би унаж хэрэглэж байгааг харж байгаа биз.
- Та дандаа л унаж хэрэглээд байдаггүй юм байна шүү дээ?
- Энэ морьдуудыг надад хэрэггүй болохоор Бертуччо аваачиж худалдах болно. Тэр үүнээс дөчин мянгаг хожиж болно гэж байна билээ.
- Европод ван ч үүнийг худалдаж авахаар тийм баян биш шүү дээ.

- Тэгвэл дорнодын нэг эзэнд худалдчихгүй юу. Тэр худалдаж авах гэж бүх сангаа шавхаж хоослоод түүнийгээ нөхөж олох гэж өөрийн албат иргэдийг саваадах болно.
- Гүн та намайг юу бодлоо гэж санана?
- Хэлээч.
- Европод таны дараа орох баян хүн бол энэ эрхэм Бертуччо байх гэж бодож байна.
- Та ташаарч байна, бээс. Түүнийг хармааг уудалж үзвэл сохор зоос ч гарахгүй.
- Нээрээ гэж үү? Тэгвэл танай Бертуччо бас ид шидийн гэж үү? Та намайг ид шидийг ертөнц уруу битгий тийм гүн оруулаад байгаарай, гүн минь, би танд итгэхээ больчихно шүү гэж Альбер хэлэв.
- Альбер, надад ямар ч ид шид байхгүй. Тоо, саруул ухаан хоёр л байгаа юм. Даамал, дэмч хулгайлж байна, яагаад тэгж хулгай хийж байна вэ? гэж танаас асууя.
- Төрөлхийн тийм улс болоод тэр. Хулгай хийхгүй байж чадахгүй болоод л хулгай хийж байгаа юм гэж Альбер хэлэв.
- Та ташаарч байна. Тэр эхнэр хүүхэдтэй, бас өөрийн гэр бүлийн байдлыг бэхжүүлэх, ялангуяа эзнээсээ салахгүй гэдэгт бүрэн итгэлтэй байдаг биш учраас ирээдүйгээ хангаж авах гэж хулгай хийдэг юм. Харин Бертуччо бол энэ дэлхий дээр ганцаараа хүн, тэр миний түрийвчийг огт тооцоогүй зарцуулж байдаг юм. Тэр надаас хэзээ ч салхагүй гэдэгтээ итгэлтэй байдаг.
- Яагаад тэр вэ?
- Надад түүнээс илүү хүн олдохгүй учраас тэр.
- Та ид шид, магадгүйн дунд эргэлдэж байх юм аа.
- Үгүй дээ, энэ бол итгэл байгаа юм. Надад бол амьдрал үхэл нь миний гарт байгаа тэр хүн л сайн зарц болдог.
- Тэгвэл Бертуччогийн үхэл, амьдрал таны гарт байгаа юм уу? гэж Альбер асуув.
- Тийм ээ гэж Монте-Кристо хүйтнээр хариулав.

Төмөр хаалга мэт яриаг төгсгөл болгодог тийм үг байдаг. Гүнгийн “тийм” гэсэн үг яг ингэж дуулдав.

Цаашдын зам мөн л ийм хурдтай явж өнгөрөв. Найм өртөөлж тавьсан гучин хоёр морьд дөчин найман бээр газрыг наймхан цагт туулан өнгөрөв.

Шөнө дунд гоо үзэсгэлэнт цэцэрлэгт хүрэлцэн ирэв. Хаалгач хаалгаа онгойлгон зогсож байв. Түүнд сүүлчийн өртөөний хүн ирж хэлсэн ажээ.

Шөнийн нэг цаг өнгөрч байв. Альберыг өрөөнд нь оруулахад түүнийг халуун ус, хоол хүлээж байв. Сүйх тэрэгний ард зогсож ирсэн зарц түүнд үйлчлэв. Дэлбэгчийн суудал дээр явсан Батистен гүнд үйлчлэв.

Альбер усанд орчхоод хоолоо идээд, унтахаар хэвтэв. Бүхэл шөнийн турш түүнийг тэнгисийн түрлэг бүүвэйллээ. Альбер орноосоо босож, шилэн хаалга онгойлгож бяцхан тавцан дээр гарлаа. Өмнө талд нь зах хязгааргүй далай харагдаж, ар талд нь төгөлтэй нийлсэн сайхан цэцэрлэг байлаа.

Бяцхан тэнгисийн буланд шовх хошигтай жижигхэн онгоц давлагаанд дайвалзан байв. Дээр нь Монте-Кристо гүнгийн сүлдтэй далбаа намирна. Энэ сүлд

нь хөх цэнхэр тэнгис дээр байгаа хүрэн улаан хэрээс тэмдэгтэй алтан уул байсан нь Монте-Кристогийн нэрийг ёгт утгаар гаргасан байж болох байв. Бурхны наждаар цул алтнаас илүү үнэтэй уул болж хувирсан Голгоф толгой болоод түүний ариын цусаар будагдсан бузар хэрээсийг дээр нь дүрсэлсэн нь энэ үл ухагдах хүний өнгөрсөн үл мэдгэдэх амьдралд тохиолдсон гай зовлонг илтгэсэн ч байж болохоор ажээ.

Хөнгөн онгоцны дэргэдүүр нутгийн загасчдын хэдэн завь хөвж, эзэн ноёныхоо зарлигийг хүлээн зогсож байгаа номхон албат иргэд нь шиг харагдана.

Энд Монте-Кристо дөнгөж хоёрхон хонох боловч бусад бүх газрын адил юм бүхнийг нь тохьтой засжээ. Тийм учраас ирмэгц л амьдрал хөнгөн сайхан боллоо.

Үүдний нь өрөөнд хоёр буу, ангийн бусад чухал хэрэглэлүүдийг тавьсан байхыг Альбер олж харав. Нэгдүгээр давхрын нэг өрөөнд агуу загасчин англичууд, францын үхширмэл барилтай загасчдад хэрэглэдэг болгож чадахгүй байгаа тийм ухаалаг нарийн хийцтэй загасны хэрэглэл тавьсан байв.

Тэд бүхэл өдрийг энэ олон янзын зугаа цэнгэлээр өнгөрүүлж, энэ бүхэнд Монте-Кристо гүнтэй тэнцэх хүн огт байсан үгүй. Цэцэрлэг дотор арваад алтан гургуул буудан алж, голоос мөн төдийчинээ хулд загас барьж тэнгис уруу харсан сэрүүвчинд хоол идэж, номын санд цай уулаа.

Гурав дахь өдрийн үдэш энэ бүх цэнгэлд яда^oсан Альбер цонхны дэргэд байгаа зөөлөн сандал дээр унтаж, энэ бүхнийг хүүхдийн зугаа мэт үздэг Монте-Кристо байшиндаа, бариулах цэцэг тарих дулаан байрны зургийг уран барилгачтай хамтран үзэж байв. Гэтэл чулуурхаг замаар давхиж морин туурайн чимээ дуулдаж, Альбер толгойгоо өндийлгөн цонхоор харвал өөрийн нь хиа давхин ирж явав. Альбер Монте-Кристорд төвөд удаад яах вэ гэж бодоод дагуулж гараагүй ажээ. Тэр сандлаасаа ухасхийн босож:

- Энэ чинь Флорантен байна! Ээж өвдчихөө юм болов уу гэж дуу алдав.

Тэгээд үүд уруу ухасхийн гүйв.

Монте-Кристо түүний хойноос харж, хиа дээрээ яаж гүйж очиж, цаадах нь амьсгаагаа дарж ядан байж хармаанаасаа багхан битүүмжилсэн дугтуй гаргаж өгөхийг харав.

- Хэнээс захидал ирээ вэ? гэж Альбер асуухад

- Эрхэм Бошанаас... гэж Флорантен хариулав.

- Бошан таныг нааш нь явуулав уу?

- Тийм ээ, эрхэмтэн минь. Тэр намайг дуудан аваачаад замын зардлын мөнгө өгч, шуудангийн морь олж өгөөд, энэ захидлыг саадгүй даруй хүргэж өг гэж надаас ам хэлийг минв авсан. Би арван таван цаг яваад хүрч ирлээ.

Альбер салганан байж захидлыг задлаад эхний мөрийг уншмагцаа хашхиран дуу алдаад сонингий нь барьж авав.

Гэнэт нүд нь харанхуйлж хэрэв Флорантен барьж аваагүй бол ойчих байлаа.

- Хөөрхий залуу! Гэж Монте-Кристо өөртөө ч дуулдахааргүй аяархан хэлээд- Эцгүүдийн нүгэл гурав дөрөв дэх үеийн мүүхдүүдэд нь хүртэл тусдаг гэдэг үнэн юм гэв.

Тэр завсар Альбер бүх хүчээ гаргаж цааш уншлаа. Дараа нь хөлөрсөн духан дээрээсээ үсээ ар тийш нь болгоод захидал сонин хочрыг базав.

- Флорантен морь чинь буцаад Парис орж чадах уу? гэж асуув.

- Энэ чинь шуудангийн ядарсан морьдын нэг шүү дээ.

- Бурхан минь! Таныг гарахад гэрт ямар байсан бэ?
- Бүх зүйл нэлээд тайван байсан, харин Бошан дээрээс ирэхэд хатагтай уйлчихсан байна билээ. Хатагтай таны хэзээ ирэхийг асуулгах гэж над уруу хүн явуулсан байна билээ. Тэгэхэд нь би түүнд эрхэм Бошаны даалгавраар тан уруу явах гэж байна гэдгээ хэлсэн. Тэгэхэд хатагтай хориглох гэсэн юм шиг гараа сунгаснаа дараа нь хэсэг зуур бодож байгаад “Яв, яв. Флорантен, тэр буцаж ирэг” гэж надад хэлсэн.
- Ээж минь тайван бай гэж Альбер хэлээд – Би буцаж очоноо. Бузах амьтан гашуудах болно доо! Харин юуны өмнө явах хэрэгтэй гэв.

Тэгээд Монте-Кристогийн байсан өрөөнд буцаж орж ирэв.

Альбер таван минутын дотор танигдашгүй өөрчлөгдөж, хоолой нь сөөн, царайд нь улаан улаан толбо гарч хавдсан зовхин доорх нүд нь улайж, алхаа нь согтуу хнү шиг болчихжээ.

- Гүнтэн, таныг ингэж сайхан зочилсонд баярлалаа. Би цааш нь зочлуулахдаа баяртай байх байсан боловч Парис өөд буцалгүй горьгүй болохгүй боллоо гэж Альбер хэлэв.
- Юу болоо вэ?
- Их золгүй явдал болжээ. Намайг явахыг зөвшөөрнө үү. Надад амьдралаас минь илүү үнэтэй чухал хэрэг болоод байна. Та юуны ч тухай бүү асуугаарай би гуйя танаас. Харин надад морь өгөөч!
- Миний морь таны бүрэн мэдэлд байга. Та дан мориор Парис хүртэл явбал ядарч орхино, тэгэхээр дуртай сүйх тэргээ аваад яв гэж Монте-Кристо хэлэв.
- Үгүй, дэндүү удна. Би ядрахаас айхгүй байна. Харин ч надад тус болно.

Альбер суманд оногдсон хүн шиг гуйвлан хэд алхсанаа хаалганы дэргэдэх сандал дээр ойчив.

Монте-Кристо хоёр дахь удаа ухаан балартахыг нь харсангүй. Цонхны дэргэд очиж,

- Али, бээсэд морь өг! Бушуулаарай, яарч байгаа хүн шүү! гэж хашхирч байлаа. Энэ үг Альберыг ухаан оруулав. Альбер тасалгаанаас гүйн гарахад гүн бас араас нь гарав.
- Баярлалаа танд! Гэж Альбер морин дээр үсрэн гарч хэлээд – Флорантен чи аль болох бушуухан буцаж ирээрэй. Морь авахын тулд ямар нэг нууц дохио хэрэгтэй юу? гэв.
- Та зүгээр л наад унаж яваа морио өгөхөөр чинь орны нь морийг солиод өгнө.

Альбер морио давиран давхих гэснээ зогсож,

- Та миний энэ явж байгаа явдлыг хаичн гайхалтай, тэнэг хэрэг гэж үзэж байж болох юм. Сонины хэдэн мөр үг хүнийг ямар байдалд хүргэж болдгийг та мэднэ шүү дээ гэж хэлээд гүн өөд сонин шидэж – Харин та миний царай улайхыг харахааргүй, намайг явсан хойно уншаарай гэж нэмж хэлэв.

Тэгээд тэрээр гуталд нь бэхэлж өгсөн давируулаар морио ёвроход, морь дээрх хүнээ надад юунд ингэж ширүүн арга хэрэглэв гэж ихэд гайхан харвасан сум мэт дүүлэн одлоо.

Гүн түүний хойноос ихэд өрөвдсөн байдалтай хараад бүр далд орсон хойно нь сонин авч уншдаа.

“Гурван долоо хоногийн өмнө “Үнэн мөний хоолой” сонин дээр нийтлэгдсэн Яниний паш Алийн цэрэгт албан хааж байсан францын офицер зөвхөн Яниний цайзыг тавьж өгөөд зогсоогүй харин өөртөө ач тус бологчийг түргүүдэд худалджээ. Энэ хүн тэр үед дээрх сонины нийтэлсэн ёсоор Фернан гэдэг нэртний байсан авч тэр цагаас хойш язгууртны хэргэм зүүж, эдлэн газартай ч болжээ.

Одоо тэр хүн Морсер нэртэй бөгөөд тайж нарын Танхимд суудаотай хүн юм” гэжээ.

Ингэж Бошаны сайн сэтгэлээсээ нуух гэсэн нууц нь дахин хий үзэгдэл мэт босож ирж, Альберыг Норманди уруу явсны нөгөөдөр нь өөр нэгэн сонинд хэвлэгдэж, залуу хүүг арай л галзууруулчхаагүй нь энэ ажээ.

9.ШҮҮХ

Альбер өглөөний найман цагт Бошаны өрөөнд эрчээрээ гүйж оров. Хиа түүнийг ирнэ гэж мэдэж байсан учир дөнгөж саяхан усанд орчхоод гарсан эзэн дээрэ оруулав.

- Тэгэхээр? Гэж Альбер асуулаа.
- Тийм боллоо, хөөрхий найз минь, би таныг хүлээж байлаа гэж Бошан хариулав.
- Би хүрээд ирлээ. Бошан, таны сайн санаатайд итгэх урчаас таныг тэр тухай хүнд ярьчихсан гэж санахгүй байна. Түүнээс гадна та намайг нааш нь дуудсан байгаа нь нөхөрлөлийн бас нэг баталгаа юм. Тэгэхээр илүү дутуу юм ярьж цагаа барахыг больё. Энэ цохилт хэнээс гарч байгааг тааварлан мэдэж бахйгаа юм байна уу?
- Би одоо танд юухан хээхэн хэлье.
- Тэг, харин эхлээд та энд юү болсон тухай тодорхой дэс дарааллаар нь яриарай.

Тэгээд ичиж зовсон Бошан дараах зүйлийг Альберт ярив.

Энэ мэдээ Альберыг үвсны нөгөөдөр нь “Үнэн мөний дуу хоолойд” би, харин өөр сонинд, тэгэхдээ бүр засгийн газрын сонинд нийтлэгджээ. Бошаныг өглөөнийхөө хоолыг идэж суутал нүдэнд нь мэдээ өртжээ. Тэгэхээр нь даруй хөнгөн тэрэг авчруулж өглөөнийхөө хоолыг ч идэж дуусалгүй сонины газар өөд яаран явжээ.

Бошан ба тэр сонины эрхлэгч хоёрын улс төрийн үзэл өөр боловч эвтэй, найз нөхөд байлаа.

Бошаныг орж ирэхэд тэрээр сонингоо барьж өөрийн бичсэн бололтой чихрийн манжингийн тухай тэргүүнийг их л тааламжтайхан уншиж байв.

- Эрхэм минь, та сонингоо барьж байгаа болохоор би яагаад ирснээ танд тайлбарлан хэлэх хэрэггүй биз гэв.
- Та чинь чихрийн нишингийг дээрд үздэг хүн гэж үү? Гэж засгийн гаүрын сонины эрхлэгч асуухад, Бошан
- Үгүй, би энэ асуудлыг бага сонирхож байна. Би бэр өөр шалтгаанаар ирлээ гэв.
- Ямар шалтгаанаар?
- Морсерын тухай мэдээний талаар.

- Өө тийм хэрэг үү. Энэ нээрээ сонин юм шүү тийм ээ?
- Энэ бол ялын төлөвлөгөө шиг болж байгаа бөгөөд юугаар төгсөхийг нь бүү мэд.
- Үгүй, мэдээтэй зэрэг бид тэр бүхнийг баталсан баримт бичгүүдийг хүлээж авсан. Тэгэхээр Морсерийг дуугүй байна гэдэгт итгэж байна. Тэгээд ч бид эх орны нэр төрийг хүлээж чадахгүй тийм бузар амьтныг илрүүлж улс орондоо тус хүргэж байгаа юм.

Бошан зовж,

- Хэн танд тингэж тодорхой сайн мэдээлчихээ вэ? Миний сонин анх удаа дуугарсан боловч баримт нотолгоо байхгүй учр ас дуугүй болох ёстой болсон юм. Түүнээс гадна Морсер Францын тайж% бид бол сөрөг талынхан болохоор түүнийг илчлэх илүү сонирхолтой байдаг юм гэв.
- Зүгээр л ийм болчихсон юм. Бид шуугиан тарих сонин мэдээний хойноос хөөцөөлдөөгүй, харин энэ мэдээ өөр гарт ороод ирсэн юм. Өчигдөр манайд илчлэх баримт бичиг барьсан хүн Янинаас хүрч ирсэн. Бид нийтлэхийг шууд зүрхэлж ядан бхйтал тэр хүн хэрэв та нарыг татгалзвал энэ мэдээ өөр сонинд гарах болно гэж хэлсэн. Бошан чи сонирхолтой мэдээ гэж юу болохыг өөрөө мэднэ шүү дээ. Бид тийм завшааныг гараасаа яаж алдах билээ. Одоо цохилт болсон. Энэ цохилт Европ даяар дуурсагдана л даа.

Бошан толгойгоо бөхийлгөж ёслоод гарч явахаас өөр аргагүй болсныг мэдэж Альберт хүн явуулахаар шийдвэрлээд гунигтайяа гарч одлоо.

Гэвч хүн явуулсны дараа болсон хэрэг явдлыг Альберт яахин бичиж чадах билээ. Тэр өдөр тайжуудын танхимд, энгүүндээ тайван байдаг чуулганыхны дунд их л хөл үймээнтэй байв. Хүмүүс цөм тогтоосон цагаас бараг түрүүлж ирээд Дээд танхимын нэгэн нэр хүндтэй гишүүний зү олны анхаарлыг татах болсон муухай явдлын тухай хоорондоо шүүмжлэн ярилцаж байв.

Зарим нь мэдээг уншиж, нөгөө зарим нь тэрхүү мэдээг нотолсон урьдын явдлуудыг санан дурсаж ярилцлаа. Морсер гүн өөрийн хөдийн хайрыг хүлээгээгүй хүн байв. Тэрээр гэнэт өөдөө гарчихсан бүх хүний адил хэтэрхий их зан гарган өөрийгөө хүндлүүлэх гэж хичээдэг хүн байв. Тэгэхэд нь жинхэнэ язгууртнууд түүнийг шоолон инээлдэж_ ухаантан хүмүүс үл тоомсорлон, цэвэр ариун нэртнэй алдар цуутай дайчид бол түүнийг жигшин үзнэ. Нүглээ наминчлан хохирох тийм гашуун хувь зохиол гүнд тулгарав. Гүн бурханд буруу үзэгдэж, олон түмэнд цээрлэл залхаалт хүлээлгэхийг шаардаж мэдэх болоод байв.

Зөвхөн Морсер гүн л өөрөө юу ч мэдээгэй байв. Тэр өөрийг нь гутамшиг болгосон сониныг хүлээн аваагүй байсан бөгөөд өглөөнөөс хойш хэдэн захидал ичээд, дараа нь шинэ морио шалгаж үзэв.

Ингээд тогтсон цагтаа ирж, сүйх тэрэгнээс буугаад толгой дээш өргөж, бардам ихэмсэг царай гарган гудмаар алхаж, өөрийн нөхдийн тоомсоргүй мэндэлж байхыг ажигласангүй явж хурлын тасалгаанд орж ирэв.

Морсерыг орж ирэхэд хурал эхэлчихсэн байв.

Гүн болсон явдлыг мэдээгүй боловч ердийнхөөрөө ихэсэг байдалтай орж ирсэнд нүүр царай хөдөлж аяглах нь улам ч хиймэл харагдаж нэр төрөө эрхэмлэн үздэг чуулганыханд хэтэрхий ихэмсэг, цадиггүй явдал мэт харагдаж зарим нь өдөж байна, зарим нь доромжилж байна гэж үзжээ.

Бүх л танхимаараа шүүн хэлэлцэх юмсан гэж тэсэж ядаж байгаа нь илхэн харагдаж байв.

Илчилсэн мэдээ нийтлэгдсэн сонин хүн бүхний гарт байх боловч хэн ч иүрүүнд босож үг хэлэх хариуцлага хүлээхийг зүрхэлсэнгүй. Гэвч эцсийн эцэст хамгийн хүндтэй тайжийн нэг, Морсер гүнгийн ил дайсан удаан хүлээсэн цаг минь одоо л эг боллоо гэсэн бхйдалтай индэр дээр гарч ирлээ.

Танхимд чимээ аниргүй. Ганцхан Морсер л энэхүү төдий уран цэцэн биш, олны анх арлыг тэгтэл татаж чаддаггүй илтгэгчийн үг хэлэх гэхэд өчнөөн их анхааралтай сууцгааж байгаагийн учрыг мэдсэнгүй.

Илтгэгч Танхимын мьдралд чухал, маш ноцтой асуудлыг авч ярих тул хэлэх үгийг минь ихэд анхааралтай сонсохыг хүсэж байна гэсэн эхний хэсгий нь Морсер гүн чихнийхээ хажуугаар тайван өнгөрүүлчихжээ.

Харин Янины тухай, хурандаа Фернан, Морсер гүнгийн тухай үг цухуйлгамагц царай нь жигтэйхэн зөвхийрээд явчихсанд улс амьтан шивэр авир болоод хүн бүхэн гүн өөд ширтэв.

Сэтгэл санааны шарх гэдэг үл харагдавч эдгэрч битүүрнэ гэж ер үгүй, хүний сэтгэлийн гүнд үргэлж зовиуртай цаг ямагт цус шүүрч, үүрд эмзэглэн байдаг ажээ.

Үхсэн мэт чимээ аниргүйн дунд илтгэгч уг мэдээг уншлаа. Хүмүүсийн бүдэг хүнгэнэх дуу гарсан боловч илтгэгч дахин ярьж эхлэхэд цөм нам гүм боллоо. Тэрээр Морсер гүнгийн нэр төр, бүх Танхимын нэр төрийн тухай хэрэг болохоор миний авсан үүрэг хүнд бэрх бөгөөд нэр төрийг хамгаалах сэтгэлийн үүднээс шүүн хэлэлцэх гэж байна гэж тайлбарлаад, хүний хувийн ажил явдал, хэзээд эгзэгтэй нарийн байдаг асуудлыг ярилцахад хүрэх нь гэлээ. Энэ хэргийг угт бузар гүтгэлэг байгаа болохоор даруй түргэн судлан үзэж, олноо ийм өндрөөр үнэлэгддэг Морсер гүнгийн сайн нэрийг хамгаалж, ингэж доромжилсон этгээчийг олж илрүүлэн өшөө авах нь чухал гэж дүгнэлээ.

Морсер энэ гэнэтийн явдалд йхавтар ихээр балмагдан нөхдийнрөө өөдөөс бүрэлзсэн нүдээрээ харж арай ядан хэдэн үг бувтнаж чадлаа. Гэмгүй хүний гайхсан дүр, эсвэл гэм буруутны ичгүүрийн аль алиныг илчилж чадах энэхүү зовсон байдал нь зарим хүмүүст өрөвдөх сэтгэл төрүүллээ. Дайсны нь золгүй явдал өөрсдийн нь үзэн ядах үзлээс аваад ирэхэд үнэнхүү сайн сэтгэлт хүмүүс өрөвдөхдөө бэлхэн байдаг юм.

Хурлын дарга асуудлыг санал хурааж, шалгаж үзэхээр тогтлоо.

Өөрийгөө зөвтгөхөөр бэлтгэхэл хэчнээн хугацаа шаардагдахыг гүнгээс асуулаа.

Морсер анх балмагдсаныхаа дараагаар бага зэрэг тайвширч, биеэ барьж чадан ийн өгүүллээ:

- Ноёд тайж нараа, бузар гүтгэлгийн сүүдэрт нуугдсан үл мэдэгдэх дайсны довтолгоог цохиж няцаахал цаг гээд байх юу байх вэ. Намайг эгшин зуур дайрсан энэ цахилгааныг би аянгын ниргэлтээр хариулах ёстой. Ах дүү нартаа тэдний эгнээнд байх гавьяатайгаа харуулахын тулд ам хэлээр батлахын оронд цусаа урсгах боломж надад яагаад олдсонгүй вэ!

Энэ үг аятайтан сэтгэгдэл төрүүллээ. Морсер цааш үргэлжлүүлэн,

- Тийм учраас шалгаж үзэж ажлыг аль болохуйц түргэн хийж өгөхийг хүсэж, бүх шаардагдах баримт бичгүүдээ Танхимын тэдэлд шилжүүлэн өгье гэв.
- Танд ямар өдрийг тогтоовол дээр байна? гэж дарга асуувал
- Өнөөдрөөс эхлэн би өөрийн биеийг Танхимын мэдэлд өглөө гэж гүн хариулав.

Дарга хонхоо дуугаргав.

- Шалгаж үзэх хурлыг өнөөдрийн дотор хийвэл танхим юу гэж үзэж байна?
- Болно оо гэж ху°алдагсад нэгэн дуугаар хариулав.

Морсерын гаргаж өгөх баримт бичгүүдийг шалган үзэх арван хоёр хүнтэй комисс сонголоо. Энэ комиссын анхдугаар хуралдааныг оройн найман цагт Танхимын байшинд хийхээр тогтлоо. Хэрэв хэд хэдэн хурал хийх шаардлага гарвал тэндээ л тэр цагтаа хийж байхаар шийджээ.

Шийдвэр батлагдмагц Морсер явах зөвшөөрөл гуйлаа. Морсер ингэж балрах цаг ирж мэднэ гэж хэзээний заль муухай санаа гарган баримт бичгүүдийг бэлтгэчихсэн байжээ.

Бошан энэ бүгдийг Альберт хэллээ.

Альбер заримдаа ичиж зовон, заримдаа хорсон хамаг бие нь чичрэн энэ яриаг сонслоо. Тэр Бошаныг Янин ороод ирснээс хойш эцгийнхээ гэм буруутайг мэдсэн бөгөөд яаж гэм буруугүй хэмээн нотлохыг нь мэдэхгүй байв. Тэгээд Бошаныг дуугүй болоход,

- Тэгээд цааш нь? Гэж асуулаа.
- Цааш нь уу? гэж Бошан давтан хэлэв.
- Тийм ээ.
- Найз минь энэ үг надад их аймшигтай үүргийг ногдуулж байна. та цаашаа юу болсныг заавал мэдэх юм сан гээд байна уу?
- Би мэдэх ёстой, би танаас өөр хэнээс ч мэдэхийг хүсэхгүй байна.
- За тэгвэл хамаг зоригоо хуримтлуулж зоригоо чангалж бай даа, энэ зориг зүрх танд өнөөдөр шиг хэзээ ч хэрэг болж байгаагүй байлгүй гэж Бошан хэллээ.

Альбер амиа хамгаалах гэж бэлтгэж хуягныхаа бат бэх, сэлэмнийхээ уян хатанг шалгаж үзэх адил духаа илэх нь хүч чадлаа сорин үзэх мэт.

Тэр догдлон хөдлөсөн сэтгэлийг хүч чадал гэж үзсэн учир зориг чадалтай байна гэж санажээ.

- Яриарай гэж хэл.в
- Үзэш болл@о. Бүх Парис амьсгаа даран хүлээж байв. Зраим хүмүүс танай аавыг хүрээд ирэхээр л ял зэмлэл нуран унаж үгүй болно гэцгээж байв. Зарим нь бүр ирэхгүй гэж ярилцаж байв. Бас танай эцгийг Брюселль уруу яваад өгөхийг харсан хүн байгаа мэт ярилцав. Зарим нь цагдаагийн газар очиж, паспортаа солиулсан эсэхийг асуусан байна билээ гэв.

Би хурлын тасалгаанд орох гэж комиссын нэг гишүүнийг ятгаж чадах л бүхнээ хийснийг танд хэлэх ёстой гэж үзэж байна. Тэр манайд долоон цагт хүрч ирж намайг аваад нэг бичгийн түшмэлд өгч, тэр хүн намайг нэг тагтанд оруулаад цоожилсон юм. Би баганын цаана бүрэг харанхуйд нуугдаж суулаа. Болох гэж байгаа аймшигт үзэгдлийг харж, дуулж чадна гэж итгэж байв.

Яг найман цагт бүх хүн цугларав.

Эрхэм де Морсер цагийн зүү сүүлчийн удаа цохиж байхад орж ирэв. Тэр гартаа бичиг барьж их л тайван байдалтай байгаа харагдав. Ердийн байдлаасаа их л энгийн байдалтай цэвэр сайхан хувцаслаж, хуучин цэргийн хүний ёсоор бүх товч бүчээ бүрэн товчилсон байлаа.

Түүий хүрч ирсэн явдал их сайхан сэтгэгдэл төрүүлжээ. Комиссын гишүүд түүний эсрэг биш, харин зарим нэг нь түүн дээр очиж гар ч барьж байлаа.

Энэ минутад зарлага орж ирэд хурлын даргад захидал өглөө. Дарга захидлыг задлах зуураа,

“Эрхэм де Морсер та одоо үгээ хэл” гэж хэлэв.

- Гүн өөрийгөө хамгаалах үнээ хэлж эхэллээ. Альбер минь, энэ үг нь тун сайхан дэс дараатай сайн бэлдсэн үг байсан шүү гэж Бошан хэлээд цааш үргэлжлүүлэн: - Тэрээр Янины эзэн ноён сүүлчийнхээ минутыг хүртэл түүнд итгэж, амьдрал үхэл хоёрын аль нэгийг шийдвэрлэх хэлэлцээ султан хаантай хийхийг даалгасан юм гэв. Тэгээд Али-Тебелин төрийн тэмдэг болгож, бичиг захидлаа битүүмжилдэг бөгжөө буцаж ирэхдээ шөнө өдөр ямар ч цагт түүн дээр орж ирж болох тэмдэг болгон өгсөнийг харуулав. Аз нь хаяхад хэлэлцээ амжилтгүй болж энэрэлт эзнээ хамгаалахаар зориг шулуудан буцаж ирэхэд үхчихсэн байсан юм гэж гүн яриулав. Харин Али Паша надад ихэд итгэж байсан учир өөрийн хайрт эхнэр, охин хоёроо надад даатган өгсөн юм гэв.

Бошаны ярихын хэрээр гоо сайхан грег хүүхэн тэр даалгаврын тухай, бөгжний тухай, бас яахин худалдагдаж боол болсноо Гайдегийн ярьсан нь Альберт санагдаж энэ үгийг дуулаад татвасхийв.

- Тэгээд гүнгийн хэлсэн үг ямар сэтгэгдэл төрүүлэв гэж Альбер сэтгэл түгшин асуухад,
- Хэлсэн үг нь миний сэтгэлийг бүх комиссын сэтгэлийг хөдөлгөсөн юм гэж Бошан хариулав.
- Тэр завсар хурлын дарга өгсөн захидлыг хайхрамжгүйхэн харлаа. Гэтэл эхний нь мөрнөөс эхлээд анхаарлыг нь татах шиг болов. Дарга захидлыг уншаад, дараа нь дахин уншаад Морсер гүн өөд харлаа.

“Гүн та дөнгөж саяхан Янины эзэн өөрийн эхнэр охин хоёрыг даатгаж өгсөн гэж ярьсан байх аа” гэж асуухад Морсер,

“Тийм эрхэм минь, энэ хэрэгт ч гэсэн бас надад золгүй явдал тохиолдсон юм. Намайг буцаж ирэхэд Василики түүний охин Гайце хоёр алга болчихсон байсан юм” гэж хариуллаа.

“Та тэднийг таньдаг байсан уу?”

“Пашид ойр дотно, түүний бүрэн итгэлийг хүлээж байсны ачар би тэднийг нэг биш удаа харж байсан”

“Тэд яасныг мэдэх юм байна уу?”

“Байна аа, эрхэм минь, тэд уй гашуу буюу эсвэл ядуу зүдүү байдлаа тэсвэрлэж чадаагүй гэж дуулсан юм. Би баян биш, амьдрал минь үргэлж аюул дунд байснаас тэднийг эрж олох бололцоогүй байсандаа их харамсдаг юм”

Дарга хөмсгөө зангидав.

“Ноёдууд аа та нар Морсер гүнгийн хэлсэн үгийг сонслоо. Гүн та өөрийнхөө хэлснийг ямар нэг гэрчээр нотолж чадах уу?” гэж асуухад гүн,

“Эзнийг хүрээлж байсан буюу надтай түүний ордонд дайралдаж байсан хүмүүсээс үхэж үрэгдэх нь үхэж үрэгдээд, үлдсэн зарим нь хорвоогоор нэг тарж одсон нь даанч харамсалтай байна. Миний мэдэж байгаагаар, тэр аймшигт дайныг туулан гарсан хүн миний нутгийнхан дотроос надаас өөр байхгүй. Надад зөвхөн Али-Тебелиний захидал байсныг та нарт өгсөн. Надад зөвхөн түүний хүсэл зоригийн тэмдэг болсон бөгж бий. Бас хамгийн итгэгдэхээр нэг баримт нотолгоо бол нэргүй дайралтаас хойш үнэнч хүн миний үгийг няцаах хүн миний хир суугаагүй нэр төр байна шүү дээ” гэж хэлэв.

Хурлынхны дунд магтан шивгэнэлдэх чимээ гарав. Энэ минутад гэнэтийн нэгэн явдал болоогүй бол танай эцгийн нэр төр аврагдах байсан юм.

Зөвхөн санал хураах л үлдээд байлаа. Тэгтэл дарга үг хэлэв.

“Ноёд оо, мөн түүнчлэн гүн та ч Жэсэн мэдүүлэг өгөх гэж ирээд бацагаа, өөрийнх нь үгээр бол чухал хэрэгтэй гэрчийн үгийг сонсвол надад зүйтэй санагдаж байна. Гүнгийн хэлснийг дуулсны дараа сайхь гэрчийн этгээд манай нөхрийн огт гэм буруугүйг баталж өгнө гэдэгт бид эргэлзэхгүй байна. Би дөнгөж саяхан энэ захидлыг хүлээн авлаа. Энэ захидлыг та нарт уншиж өгөх үү эсвэл түүнийг уншиж танилцуулан саатахгүйг хүсэж байна уу” гэж дарга хэлэв.

Морсер гүнгийн царай дэвхийрч атгасан цаас нь шаржигнан дуугарлаа.

Комисс захидлыг уншихаар тогтов.

Гүн Морсер гүнээ бодлогоширч, өөрийнхөө саналыг илэрхийлсэнгүй.

Тэгэхэд дарга дараах захидлыг уншлаа.

“Эрхэм хурлын дарга аа!

Дэслэгч генерал Морсер гүнгийн Эпир ба Македонд байсан байдлыг хянан үзэх комисст хамгийн үнэн нарийн мэдүүлгийг би өгч чадна”

Дарга секундийн хэртэй дуугүй боллоо.

Морсер гүнгийн царай зэвийж, хурлын дарга сонсогчдоос асуусан байртай эргэн тойрон харлаа.

“Цааш нь!” гэж тал бүхнээс хашхирахад дарга үргэлжлүүлэн уншсан нь:

“Али Паша миний дэргэд үхэж, тоүний амьдралын сүүлчийн мөч миний нүдэн дээр өнгөрсөн билээ. Василики ба Гайде хоёрын хувь заяа ямар болсныг би мэднэ. Би комиссын ажилд тус болоход бэлэн байгаа тул миний хэлэх үгийг сонсохыг хүсье. Энэ захидлыг танд гардуулан өгөх үед би Танхимын гадаа өрөөнд хүлээж байх болно” гэжээ.

“Тэр гэрчийн этгээд буюу үнэндээ тэр дайсан чинь хэн бэ?” гэж гүнгийн дуу өөр болж асуулаа.

“Хэн болохыг бид одоохон мэднэ. Комиссын гишүүд ээ, энэ гэрчийн этгээдийн үгийг сонсох уу? гэж хурлан дарга хэлэхэд,

“Тэгье, тэгье!” гэж нэгэн зэрэг хариулав.

Зарлагыг дуулдаа.

“Үүдний өрөөнд ямар нэг хүн хүлээж байна уу?” гэж дарга асуулаа.

“Байна аа, эрхэм дарга аа”

“Ямар хүн байна”

“Зарц дагуулсан хүүхэн байна”

Хүмүүс цөм бие бие өөдөө харлаа.

“Тэр хүүхнээ нааш нь урьж оруулаад ир” гэж дарга хэллээ.

- Таван минутын дараа зарлага буцаж ирлээ. Хүмүүс цөм хаалга өөд ширтэн харахад би ч бас олны адилаар тэсэж ядан хүлээж байв гэж Бошан нэмж хэлэв.

Зарлагын хойноос толгойноосоо хөлөө хүртэл нөмрөг нөмөрсөн хүүхэн орж ирлээ. Биеийн нь сайн мэдэгдэхгүй байгаа дүрс, анхилуун сайхан үнэр сэлтээр нь үзэхэд залуу сайхан бүсгүй гэдэг нь харагдаж байв.

Дарга бүсгүйг нөмрөгөө тайлахыг хүсэхэд грег хувцас өмссөн залуу сайхан бүсгүй олны нүдний өмнө гарч ирлээ. Тэр бүсгүй ер бишийн гоо сайхан хүүхэн байлаа.

- Өө, тэр байх нь! Гэж Альбер хэлэв.
- Хэн бэ?
- Гайде.
- Хэн танд хэлээ вэ?
- Би зүгээр л тааж байна. За Бошан цааш нь яриач. Хэрэг явдлын шувтарга уруу орйтож байгаа боловч би зоригтой байгааг харж байгаа биз.
- Эрхэм Морсер тэр охиныг айх гайхах зэрэгцэн харлаа. Тэр сайхан уруулаас урсан гарах үг түүний үхэх сэхэхийг шийдэхээс бус, бусад хүмүүсийн хувьд эрхэм Морсер үхэж ч байна уу, сэхэж ч байна уу хамаагүй болж, цөм залуу бүсгүйг сонирхон ширтэнэ.

Дарга залуу бүсгүйг сууна уу гэсэн боловч толгойгоо сэгсэрлээ. Гүн зөөлөн сандал дээр уначихлаа. Хөл нь нугараад болж өгсөнгүй бололтой.

“Хатагтай та Янинад болсон явдлын тухай мэдэгдэж чадах бөгөөд тэр хэрэг явдлыг гэрчлэх хүн гэж бичсэн байсан биз” гэж дарга хэлэв.

“Тэр үнэн” гэж үл таних бүсгүй Дорнодын хүмүүсийн яриаг бусдаас ялгадаг уянгат сайхан дуугаар өрөвдөм гунигтай байдлаар хариу өгүүллээ.

“Гэвч та тэр үед дэндүү бага балчир байсан гэдгийг хэлэхийг зөвшөөрнө үү” гэж дарга хэлэв.

“Тэгэхэд би дөрвөн настай байсан. Гэхдээ хэрэг явдал надад ер бишийн чухал байсан учраас би нэг ч зүйлийг нь мартаагүй юм”

“Энэ хэрэг явдал танд юугаараа чухал байсан бэ? Та ер нь хэн гэгч вэ? Яагаад тэр явдал танд ийм гүн сэтгэгдэл төрүүлсэн юм бэ”

“Миний эцгийн үхэх сэхэхийн тухай явдал болж байсан юм. Би бол Янины Паша Али-Тебелин түүний хайрт эхнэр Василики хочрын охин Гайде байна” хэмээн охин дуугарлаа.

Хацар нь даруу мөртөө бардам янзаар улайж, гал дөл бадарсан харц, хэлсэн үгийн агуу сайхан нь хурлынханд өгүүлшгүй сайхан сэтгэгдэл төрүүллээ.

Морсер гүн өмнө нь газар хагарч гав гарсан юм шиг охин өөд сүрдэн харлаа. Дарга охинд мэхийн ёслоод,

“Хатагтай танаас би нэг зүйлийг асууя. Би таны үгэнд эргэлзэж байгаа юм биш шүү. Та өөрийнхөө хэлсэн зүйлийг баталж чадах уу” гэж асуулаа.

Тэгэхэд Гайде нөмрөгийнхөө нугалаанаас торгон уут гаргаж ирээд,

Чадна аа. Миний эцэг бичиж, түүний уэргийн дарга нар гарын үсэг зурсан төрсний минь гэрчилгээ энэ байна. Энэ гэрчилгээн дээр Македони ба Эпирийн агуу

хамба лам нарын тамга дарсан байгаа. Эцэст нь Францын офицер өөрийн энэрэлт эзний эхнэр хоин хоёрыг олзны хувь гэж мянган түрийвч буюу дөрвөн зуун мянган франкаар армяны худалдаачин Эль-Коббирт худалдсан тухай баримт гэрчилгээ энэ байна. Энэ л хамгийн чухал баримт болох биз” гэж хэлэв.

Энэ аймшигт ялыг хурлынхан зэвүүн чимээ аниргүйн дунд чагнан суухад, гүнгийн царай цайвар ногоондуу болж, нүдэнд нь цус хуран улайж байв.

Гайде өнөө тайван хэвээрээ боловч энэ тайван байдал ньөөр ямар ч хүн уурлан омгорхож байснаас илүү аймшигтайгаар худалдааны тухай араб хэл дээр бичсэн гэрчилгээг дарга өөд сарвайв.

Эдгээр баримтуудын зарим нь араб, шинэ грег эсвэр түрэг хэл дээр бичигдсэн байж болох тул Танхимын дэргэд байдаг орчуулагчийг хүн явуулж дуудууллаа.

Египетийн их аян дайны үед араб хэл сурсан нэгэн сайн язгуурт тайж орчуулагчийн ингэж цаасан дээр бичсэн зүйлийг унштихыг ажиглан хянаж байв. Орчуулагч чанга дуугаар дуудсан нь:

“Эрхэм дэд султан хааны ордонд татвар эмс олж нийлүүлэгч, боолын худалдаачин Эль-Коббир миний бие, Али-Тебелинийд цэргийн албан хааж байсан Францын хурандаа Фернан Мондего гэдэг хүнээс долоон жилийн өмнө Константинопольд ирэнгүүтээ нас барсан эхтэй нь хамт худалдан авсан Янины паш талийгаач Али-Тебелин түүний гэргий Василики хоёрын олноо зөвшөөрөгдсөн арван нэгэн настай христос шашинтан Гайдег худалдсаныхаа үнэд хоёр мянган түрийвчийн үнэтэй маргад эрдэнийн чулуу падишахад гардуулан өгөхөөр Францын ноён Монте-Кристогоос хүлээн авсан тул энэхүү баталгааг гаргалаа.

Дээр дурдсан наймааг би эрхэм дээд эзэн султан хааны даалгавраар мянган түрийвчээр худалдан авсан билээ.

Энэ баталгаа бичгийг эрхэм дээд эзний зөвшөөрөлтэйгээр Константинопольд тогтоон бичлээ. Гижирийн 1247 он.

Гарын үсэг: Эль-Коббир

Энэ баталгаа бичгийн үнэн зөв болохыг эрхэм дээд эзний тамга даруулж батлуулах бөгөөд энэ тамга даруулах ажлыг худалдсан хүн би хариуцан гүйцэтгэх болно” гэжээ.

Үнэхээр ч худалдаачны гарын сүгийн хажууд падишахын тамга дарсан байлаа.

Үүнийг уншсаны дараа аймаар чимээ аниргүй боллоо. Гүнгийн амь голтой байсан юм бүхэ нь нүдэнд нь хуран цугларч, түүний зориг хүслээс гадуур Гайде өөд ширтэн, гал цусаар маналзан байв.

“Эрхэмсэг хатагтай тантай хамт Парист байгаа Монте-Кристо гүнгээр тодорхойлолт гаргуулж болохгүй юм болов уу?” гэж дарга асуулаа.

“Миний хоёр дахь эцэг Монте-Кристо гүн Норманди орохоор яваад гурав хонож байна”.

“Тэгвэл хатагтай таныг энд ирж, манай Танхимынхны баяр хүргэж байгаа мэдүүлэг хийхийг хэн танд зөвлөсөн юм бэ? Ер нь ч таны төрсөн ба амсаж эдэлсэн зовлонг анхааран үзэхэд таны энэ хийж байгаа зүйл бол зүй ёсны хэрэг” гэж дарга хэлэхэд Гайде ийн хариу өгүүллээ:

“Эрхэм минь үхэгсдийгээ хүндэтгэн уй гашуугаасаа болж ингэхэд хүрлээ. Бурхан өршөөг, би хэдийгээр христос шашинтан бүсгүй боловч нэр цуутай эцгийнхээ

өршөөг авахыг үргэлж хүсэн мөрөөдөж явсан юм. Тэгээд би Францын газар дээр гишгэснээс хойш үргэлжийн хараа тавин, сонордсоор байв. Би өөрийн энэрэн тэтгэгчийн гэрт ганцаардмал янзаар амьдардаг юм. Яагаад гэвэл сүүдэр, чимээ аниргүйн дунд байхад л зөвхөн санаа бодолтойгоо хамт байдаг юм. Гэвч Монте-Кристо гүн намайг эцгийн ёсоор халамжлан хайрлаж, хорвоогийн юм бүхнээс тасархай биш байлгадаг. Үнэндээ би хорвоогийн холын сураг чимээг л сонирхдог. Бүх сонин сэтгүүлүүдийг авч шинэ хөгжим сурч байдаг. Би хэдийгээр наднаас нь боловч бусад хүмүүсийн амьдралыг ажиглан харж байдаг учраас өнөөдөр өглөө тайж нарын танхимд юу болж, өнөө орой чухам юу болох гэж байгааг мэдсэн юм. Тэгээд би захидал бичсэн нь энэ билээ”

“Монте-Кристо гүн таны энэ захидал бичсэн явдлыг мэдээгэй юу?” гэж дарга асуув.

“Тэр юу ч мэдээгүй, харин би түүнийг энэ тухай дуулахаараа сайшаахгүй болов уу л гэж болгоомжилж байна гэж охин хэлснээ гал дөл бадарсан нүдээ дээш өргөн тэнгэр өөд харж: - Гэвч энэ өдөр бол надад агуу их өдөр боллоо. Энэ өдөр би эцгийнхээ өшөөг авч чадлаа!” гэв.

Гүн энэ завсар нэг ч үг дуугарсангүй. Эмэгтэй хүний зөөлөн дулаан амьсгалаас амьдрал нь нуран унаж байгаа энэ хүнийг нөхөд нь өрөвдөн харж байв. Нүүр царай нь нэгэнт гай зовлонд дарагдсан шинжтэй болжээ.

“Эрхэм Морсер та энэ бүсгүйг Янины паш Али-Тебелиний охин гэж хүлээж байна уу?” гэж дарга асуухад гүн арай гэж босож,

“Үгүй, энэ бүгд бол миний дайснуудын арга явуулга” гэж хэллээ.

Хүн хүлээж байна уу гэлтэй хаалгаа өөд нүд салгалгүй харж байсан Гайде түргэн эргэж гүнг хараад аймшигтайгаар хашхирав.

“Чи намайг танихгүй байна гэнэ ээ, гэсэн ч би чамайг таньж байна! Чи бол миний энэрэнгүй сэтгэлт эцгийн минь цэргүүдийг сургаж байсан франц офицер Фернан Мондего мөн. Яниний цайзыг чи урван тавьж өгсөн! Чи энэрэн хайрлагчийнхаа амь нас аврагдах эсэхийн тухай хэлэлцэж тохирохоор Константинополь ороод ирэхдээ түүнийг бүрэн уучилсан тухай хуурамч зарлиг авч ирсэн! Чи тэр зарлигийнхаа хүчээр гал хадгалж байсан Селимийг хутгалж алсан! Чи ээж бид хоёрыг худалдаачин Эль-Коббирт худалдсан! Алуурчин! Яргачин! Яргачин! Чиний дух дээр эзний чинь цус одоо хүртэл хатаагүй байна! Цөмөөрөө харцгаа!” гэж хэллээ.

Энэ үгийг хачин үнэмшигдэхээр хэлсэн тул цөм гүнгийн духыг харсан бөгөөд Морсер ч өөрөө Алийн цус нойт оргисон мэт гараараа духаа илбэв.

“Та Фернан Мондего гэдэг чинь Морсер гүн мөн болохыг таньснаа баталж байгаа юм уу?”

“Би түүнийг танилгүй яах вэ! Ээж минь надад: “Чи эрх чөлөөтэй байсан. Чамайг хайрлаж энхрийлдэг эцэг байсан. Чи хатан хаан болж болох байсан юм! Энэ хүнийг сайн харж аваарай. Энэ хүн чамайг болл болгож, эцгийн чинь толгойг жаданд өлгөж, биднээс урваж худалдсан хүн шүү! Баруун гарыг нь хараарай, том сорви байгаа. Хэрэв чи түүний царайг мартчихвал худалдаачин Эль-Коббирос зоосы нь толж авч байгаа энэ гараар нь таниарай!” гэж хэлсэн юм. Би үүнийг танилгүй яах вэ! Одоо тэр намайг танихгүй гэж хэлж зүрхлээд хэлэг л дээ!” гэв.

Үг бүр нь хутгаар шаах мэт гүнгийн хүч тамирыг сулруулан байв. Гайдегийн сүүлийн үгийг дуулаад гүн өөрийн эрхгүй зэрэмдэглэгдсэн гараа цээжиндээ нууж, арга нь барагдан сандал дээрээ унаад өглөө.

Тэнд байсан хүмүүсийн санаа бодол үзсэн дуулсан юмнаасаа болж умартын салхины хүчирхэг амьсгалд автан эргэлдэх навч шиг хуйлрав.

“Морсер гүн та багтарсан сэтгэлдээ бүү захирагд, хариулаарай. Танхимын дээд шүүхийн өмнө хүн бүхэн бурхны шүүхийн өмнө шиг тэгш эрхтэй. шударга үнэний энэ шүүх таныг дайсантайгаа тулалдар бололцоо олгохгүйгээр дайснаар чинь даруулчихгүй. Та шинэ судалгаа шалгалт хийлгэхийг хүсэж өайна уу? Би танхимын хоёр гишүүнийг Янина өөд явуулж өгөх үү? Яриач!” гэж дарга хэлэв.

Гүн юу ч хариулсангүй.

Тэгэхэд комиссын гишүүд айж сандран ббие бие өөдөө харлаа. Хүмүүс цөм генералын захирангуй шантаршгүй занг мэддэг байв. Энэ хүн өөрийгөө хамгаалыг болино гэхэд хүч чадал нь маш их барагдсан байж таарна. Энэ унтаж буй мэт чимээ аниргүйн дараа тэнгэр ниргэх ачил юм болох байх гэж хүн бүхэн Үодож байв.

“За яав? Та юу гэж шийдээв?” гэж дарга асуухад гүн суудлаасаа босож,

“Юу ч шийдээгүй” гэж бүдэгхэн хариулав.

“Тэгвэл Али-Тебелиний охин үнэхээр үнэн зүйлийг хэлээ юу? Тэгвэл яллагагч хүн “үгүй” гэж хэлж чаддаггүй тэр аймшигт гэрч бол энэ хүүхэн байх нь уу? Та тэр бүх гэмт хэргийг үнэхээр хийсэн юм уу?”- гэж дарга асуулаа.

Гүн эргэн тойрон сууж байгаа хүмүүсээ ичиж зовж арга нь барагдсан янзаар харах нь барсын уур хилэнг боловч намтгаж ч чадахаар байсан бол харин шүүгчдийг зөөлрүүлж чадсангүй. Дараа нь дээшээ харсан боловч таазын хүнхрээс түүнийг харуж, илүү дээд хүчирхэг шүүх ниргэх байх гэж айсан мэт даруй доошоо харлаа.

Тэгснээ гэнэт хоолойгий нь бариад байгаа цамцныхаа захыг огцом хөдөлгөөнөөр тас татаад тасалгаанаас ухасхийн гарлаа. Эхлээд алхалж буй хахир дуу цуурайтаж байснаа дараа нь сүйх тэрэг байшингийн багана доргиулан давхиж одлоо. Дараа нь тасалгаан дотор нам гүм болоход,

“Ноёдууд аа, Морсер гүн урвагч, бузар булай, нэр төргүй явдалдаа гэм буруутан нь үнэн үү?” гэж дарга асуухад шалган байцаах комиссын гишүүд нэгэн дуугаар

“Үнэн” гэж хариуллаа.

Гайде хурал тартал тэнд байсан. Тэр хүүхэн гүнгийн ялыг дуулсан. Тэгэхэд түүний царайд баярлаж, гомдсоны ямар ч шинж тэмдэг илэрхгүй байсан.

Дараа нь нөмрөгөө нүүрэн дээгүүрээ буулгаад хурлын гишүүдэд ихэмсгээр мэхийн ёсолж, Виргиллийн харж асан охин тэнгэрийн сайхан алхаагаар алхлан гарч одсон билээ гэж яриу.

10.ХАЛЗ ТУЛАЛДААНД ДУУДСАН НЬ

- Би хүмүүсийн чимээ аниргүй, харанхуй байсныг ашиглаж гарсан гээд Бошан үргэлжлүүлэн, - Тэгэхэд надад хаалга онгойлгож өгсөн зарлага үүдэнд хүлээж байсан. Тэр намайг гудмаар дагуулан явж Вожирар гудамж руу харсан хаалганд хүргэж өгсөн. Би зовж зүдрэхийгн хажуугаар гайхаж бахархан гарсан билээ. Уучлаарай. Альбер минь, зовж шаналсан нь тани төлөө, гайхаж бахархсан нь эцгийнхэ өшөөг авсан сайн санаат охины нь

төлөө юм шүү. Альбер, энэ муухай илчлэлт хаанаас ч гарлаа гэсэн дайсны явуулга гэж би ганц үг хэлэх байна. Харин энэ дайсан бол дээд тэнгэрийн л зэвсэг байж таарна.

Альбер толгойгоо гараараа тулан сууж байлаа. Тэр ичиж улайн нулимсандаа норсон нүүрээ өргөж Бошаны гараас барьж аваад,

- Найз минь миний амьдрал төгслөө. Таны хэлснээр дээд тэнгэр намайг ингэж балласан гэж хэлж чадахгүй, харин намайг үзэн ядаж мөшгөж яваа тэр хүнийг олох хэрэгтэй байна. Би тэр хүнийг олбол ална, эсвэл тэр намайг алаг. Харин жигших сэтгэл чинь найз нөхрийн ёсыг таны зүрхнээс айлган зайлуулчхаагүй бол би танаас нөхөрсөг тусламж авна хэмээн найдна гэж хэллээ.
- Найз минь жигших йи? Энэ золгүй явдалд та вугаараа буруутай юм бэ? Хүүхдүүд нь эцгийнхээ явдлын төлөө хариуцл га хүлээдэг хоцрогдсон үе өнгөрсөн. Альбер минь амьдралаа дурсан санаач. Амьдрал чинь хэдийгээр бага залуу боловч цэвэр ариун шүү дээ! Альбер, Ia бол залуу, баян хүн Францаас аваад өг! Та надад үнэмшээрэй. Энэ амьдрал буцалж сонирхол хувирамтгай байдаг аварга Вавилонд хамаг юм амархан мартагдана. Тэгээд гурван жилийн дараа оросын ямар нэг вангийн охинтой суучхаад хүрээд ирэхэд чинь, хэн ч тэр арван зургаан жилийн өмнөх байтугай, өчигдрийн болсон явдлыг дурсан санахгүй мартаж болно.
- Хайрт Бошан минь таны энэ сайхан зөвлөгөөнд, сэтгэлд чинь баярлалаа. Гэвч энэ бололцоогүй хэрэг. Би танд өөрийхөө хүслийн тухай хэлсэн. Харин одоо бол “хүсэл” гэдэг үгээ “санаа зориг” гэдэг үгээр сольж болох юм. Энэ бол надад дэндүү ойрхон хамаарагдах болохоор тан шиг юмыг тэгж бодож чадахгүй гэдгийг та ойлгох ёстой. Энэ болж байгаа бүхэн таныхаар бол тээд тэнгэрийн хүслээс болж байгаа бол минийхээр нэлээд цэвэр биш эх булгаас гарч байгаа бололтой. Энд тэнгэр бурхан огтхон ч хамаагүй юм шиг надад санагдаж байна. Харин үл үзэгдэж харагдах тэнгэрийн хайр хишиг, залхаал цээрлүүлэлтийн оронд би үзэгдэж харагдах амьтныг хайж олоод энэ бүхэн сарын турш зовж зүдэрснийхээ өшөөг авна. Бошан, найз минь би хүмүүсийн хорвоо, материаллаг ертөнцөд эргэж ормоор байнаа. Харин найз минь чи надад хуучин хэвээрээ байгаа чинь үнэн юм бол тэр цохилт өгсөн гарыг эрж олоход минь туслаарай.
- За яах вэ! Та намайг газар бугаасай гэж хүсэж байга юм бол би бууя л даа. Таныг дайснаа эрж эхэлбэл, би бас танта© хамт түүнийг чинь эрэлцье. Би Iүүнийг олно. Миний нэр төр ч таныхын адилаар үүнийг шаардаж байгаа болохоор бид түүнийг олно.
- Тэгвэл Бошан, бид хоёр эрэл хайгуулаа одоохон эхлэх хэрэгтэй. Минут хойшлуулна гэдэг чинь надад бүтэн зуун жил шиг санагдаж байна. Хов жив хүргэгч шийтгэгдээгүй байна. Тэгээд ч хариуцлага шийтгэл хүлээхгүй гэж бодож явж магадгүй. Гэвч тэр маш их ташаарч байна даа гэдгийг тангараглаж хэлье.
- Морсер чи сонсооч...
- Бошан та ямар нэг юм мэдэж байх шиг надад харагдах юм. Та намайг амьдралд буцаан оруулах нь ээ!

- Альбер, би тодорхой юу ч мэлэхгүй. Гэвч энэ бол төөрсөн хүнд гэрэл болно. Бид энэ гэрлийг дагаад явбал зорьсондоо хүрч мэднэ.
- Алив хэлээч дээ! Би тэсэж чадахгүй нь
- Би танд Янинаас ирээд ярихыг хүсээгүй тэр зүйлээ ярья
- Би сонсож байна.
- Альбер, ийм явдал болсон юм. Би тодорхойлолт олох гэж хотын тэргүүн банкны эзнийд очсон юм. Намайг энэ хэгийн тухай асууж, таны эцгийн нэрийг хэлж гүйцэхээс өмнө тэр хүн
“Таны яах гэж ирснийг таалаа” гэж хэлэв.
- “Яаж тэр вэ?”
“Энэ тухай надаас нэг хүн асуугаад хоёр долоо хоног ч болоогүй байна”
“Хэн бэ?”
“Миний нэг харилцагч, дарисын банкны эзэн”
“Нэр нь хэн гэдэг юм бэ?”
“Данглар”
- Данглар ий! гэж Альбер дуу алдаад, - Тэр муу атаа жөтөөч миний хөөрхий эцгийг аль хэдийнээс мөрдөн хяхаад байгаа юм. Өөрийгөө ардчилсан үзэлтэн гэж тооцдог болохоор Морсер гүнг тайж болсон явдлыг уучилж чадахгүй байгаа юм. Яагаад гэр бүл болж болоогүй нь мэдэгдэхгүй байсна юм... Ийм учиртай байж шү! гэлээ.
- Альбер, учрыг нь сайн ол. Бүү уурлаж тэвдээрэй. Хэрэв ийм бол...
- Хэрвээ ийм бол тэр миний зовж зүдэрснийг төлж өгөх болно.
- Бүү шохоорх. Тэр чинь нас нь явчихсан хүн.
- Тэр манайхтай тооцоо хийсэн шиг, би түүний нас сүүдэртэй нь тооцоо хийнэ дээ. Хэрэв эцгийн минь дайсан юм бол яагаад илэрхий довтлоогүй юм бол? Тэр бодвол эр хүнтэй нүүр тулгаран уулзахаас айсан байлгүй!
- Альбер би чамайг зэмлээгүй шүү. Зөвхөн болгоомжлуулж байна, болгоомжтой байгаарай.
- Битгий зов. Та намайг дагаж явах уу? Ийм асуудлыг гэрчийн дэргэд ярьдаг юм. Хэрэв Данглар буруутан бол өнөөдөр л Данглар бид хоёрын нэг үхнэ. Чөтгөр ва, би өөрийгөө их сүртэй сайхан оршуулна!
- За сайн. Альб?р. Имй шийдвэр гаргасан ыбол даруй биелүүлэх хэрэгтэй байдаг. Та Дангларынд очих уу? за тэгвэл явъя.

Тэр хоёр хөлсний тэрэг авчруулахаар хүн явуулав. Тэр хоёрыг банкны эзний байшинд очвол хаалганы нь хажууд Андреа Кавлькантийн хөнгөн тэрэг, зарц нь байхыг харлаа.

- Энэ чинь л амжилттай хэрэг боллоо доо! гэж Альбер уруу царайтгаар хэлээд – хэрэв Даглар өдөлтийг хүллээн авахгүй бол би түүний хүргэнийг ална. Ноён Кавальканти яагаад тулалдахгүй байх билээ? гэв.

Тэдний эзний тухай банкны эзэнд айлтгахад тэрээр Альберийн нэрийг сонсоод, өмнө нь юу болсныг цөмийг дуулсан ч гэлээ хүлээж авахгүй гэж хэлэхийг тушаажээ. Гэвч тэр хожимджээ. Альбер зарцын нь хойноос дагаж оржээ. Сайхь хариултыг сонсоод хаалгыг нь дэлгэн банкны эзний албан тасалгаанд Бошаны хамт орлоо.

- Үгүй энэ чинь, уучлаарай, эрхэм минь, би чинь гэрийн эзэн байхаа больж, хэнийг хүлээж авах, хэнийг хүлээж авахгүйгээ мэдэх эрхгүй болж байна уу? Та арай дэндэж байх шиг байна гэж Данглар хэллээ.
- Үгүй дээ. Хэрэв аймхай хулчгараа гайхуулах гээгүй бол зарим ирсэн хүнийг хүлээн авахгүй байж болдоггүй үе байдаг юм гэж Альбер хүйтнээр өгүүллээ.
- Эрхэм та надаам юу хүсээ вэ?
- Би танд, бид хоёрыг арван минутын туршид хэн ч саад хийхгүй тийм газар уулзъя гэдэг саналаа хэлэх гэсэн юм. Би танаас үүнээс илүү юм хүсэхгүй. Тэнд уулзсан хоёр хүний нэг нь тэндээ хоцорно гэж Альбер Дангларт ойртон, задгай зуухны дэргэд зогсож байгаа Кавалькантийг хараагүй юм шигээр хэллээ.

Дангларын царай зэвхийрээд Кавальканти хөдөллөө. Өльбер түүн өөд эргэж өгүүлрүүн:

- Болно, болно, гүн та ч гэсэн бараг энэ гэр бүлийн гишүүн болохоор хүсвэл бас очих эрхтэй. Би хэн дуртай хүнтэй ийм уулзалт хийхээр тохирно шүү.

Кавальканти, данглар өөд гайхан харахад цаадах нь хүч гарган босож ирж хоёр залуугийн дунд зогслоо. Альбер Андреа өөд дайрч байгаа нь энэ ирсэн учир нь Дангларын бодож байсан шалтгаанаас болсон биш гэдэг найдварыг банкны эзэнд төрүүлжээ. Тэгээд Альберт,

- Хэрэв та намайг өөрөөс чинь илүүгээр гүнг тоолоо хэмээн түүнтэй маргалдахыг хүсэж байгаа бол би энэ хэргийг вангийн прокурорт шилжүүлнэ шүү гэдгээ хэлчихье гэв. Тэгэхэд Алвбер баргараар инээмсэглээд:
- Та ташаарч байна. Мөн хурим бодохтой манатай, эрхэм Кавалькантид, бидний ярианд оролцох санаа төрөх шиг надад санагдсан юм. Таны хэлдэг зөв. Би өнөөдөр хэнтэй ч маргалдахад бэлхэн байна. Гэвч бүү зов, эрхэм Данглар танд гол нь зорьж ирсэн юм шүү гэв.

Тэгэхэд айх хорсохоос болж царай нь зэвхийрсэн Данглар,

- Эрхэм минь, би замдаа дайралдсан галзуу нохойг алчихдаг. Ингэж алахаа буруутай гэж үздэггүй бөгөөд, харин ч нийгмийн өмөн гавьяа байгууллаа гэж үзнэ. Тэгэхээр хэрэв та галзуурч намайг ураг гэвэл би таныг огтхон ч өрөвдөхгүй алах болно шүү. Таны эцгийн нэр гутаагдсанд би яагаад буруутай байх ёстой билээ гэв.
- Тийм ээ, бузар амьтан! Энэ бол чиний л буруу байгаа юм гэж Альбер дуу алдлаа.

Данглар алхам ухарлаа.

- Миний буруу гэнэ ээ? Минийх ий? Та галзуурч байна! Би грегийн түүхийг мэдэх юм гэж үү? Би тэр орноор очиж байгаа юу? Би тэр бүх орноор жуулчлан явсан юм гэж үү? Би таны эцэгт Янины цайзыг урван худалд... гэж зөвлөө юү? Гэж Данглар хэлэхэд, Альбер шүдээ зууж,
- Дуугүй бай! Та өөрөө биеэрээ энS явдлыг үүсгээгүй ч гэсэн та зохион байгуулсан гэж хэллээ.
- Би юу?

- Тийм ээ, та! Тэр яриа хаанаас гарсан бэ?
- Сонин дээр л гарсан байсан биз дээ. Янинаас байлгүй өөр хаанаас байх вэ!
- Янинд хэн бичсэн бэ!
- Янинд уу?
- Тийм ээ. Хэн миний эцгийн тухай асуусан бэ?
- Янинд бичиж болохгүй гэж хэнийг ч хориглоогүй шиг надад санагдаж байна.
- Юу ч л гэсэн ганцхан хүн бичсэн байна билээ.
- Зөвхөн ганцхан уу?
- Тийм ээ, тэр хүн нь та байсан.
- Мэдээж хэрэг би бичсэн. Хэрэв залуу хүнтэй охиноо суулгах гэж байгаа бол тэр залуугийнхаа гэр орны тухай мэдээ цуглуулах эрхтэйгээр барахгүй, үүрэг маань гэж бодож бана.
- Эрхэм та ямар хариуль авахаа сайн мэдэж байж бичсэн байна билээ. Альберт хэлэхэд Данглар айж сандарсанаасаа биш, золгүй залууг өрөвдсөн сэтгэлээсээ.
- Янинад захидал бичих хэрэгтэй юм гэж миний толгойд хэзээ ч ороогүй юм гэдгээ тангараг тавьж баталъя. Би Али-Пашид тохиолдсон золгүй явдлын тухай төсөөлж байсан вч гэж үү? Гэж хэллээ.
- Тэгвэл хэн эг хүн тэгж бичихийг зөвлөждээ!
- Мэдээж хрэг
- Танд зөвлөсөн үү?
- Тийм ээ
- Хэн тэр вэ? ... Хэлээч, Хэлээч дээ..
- Уучлаарай, би таны эцгийн өнгөрсөн үеийн тухай, түүний баялаг хаанас эхтэй болохыг хэн ч мэдэхгүй гэж ярьсан юм. миний ярилцсан тэр хүн таны эцгийг хаана с ийм хөрөнгөтэй болсон хүн бэ? гэж асуусан юм л даа. Тэгэхэд нт би: Грегээс юм гэнэ билээ гэж түүнд хариулсан. тгэхэд тэр хү: Тэгвэл Янинд захидал явуулахгүй гэж хэлсэн:
- Хэн танд ийм зөвлөгөө өгсөн юс бэ?
- Таны найз Монте-Кристо гүн
- Монте-Кристо гүн танд Янина өөд бичихийг зөвлөсөн гэнэ ээ?
- Тийм ээ, тэгээд л би бичсэн юм. Хуулбарыг үзмээр байна уу? Би тад үзүүлье л дээ.
- Альбер Бошан хоёр өөд өөдөөсөө харлаа. Тэгээд одоо хүртэлд дуугүй зогсож байсан Бошан
- Эрхэм та гүнг Парист байхгүй байгааг нь мэдээд биеэ өмгөөлж чадахгүй гэ тэгж байгаа юс биш биз дээ? гэлээ.
- Эрхэм минь би хэнийг ч буруушаагаагүй зүгээр л хэрэг явдал яаж болсныг л ярьж байгаа юм.
- Монте-Кристо гүнг байхад ч гэсэн үүнийгээ давтан хэлэхэд бэлхэн байна гэж Данглар хариулав.
- Тэгээд ямар хариу авсныг гүн мэдэх үү?
- Би түүнд хариугаа үзүүлсэн.

- Тэр миний аавын нэрийг фернан , овгийг Модего гэдгийг мэдэж байна уу?

- Мэднэ ээ. Би энэ тухай аль хэдийн хэлсэн юм . нэг үгээр хэлэхэлд ер нь миний оронд хэнч байлаа гэсэнм хийх тэр зүйлийг л хийсэн , харин нь ч маш багаар хийсэн юм шүү дээ . Энэ захидал хүлэн авсны маргааш танай эцэг Монте-Кристо гүнгийн өвлөснөөр манай охиныг танд гуйж ирсэн. Би түүнд эрс татгалзсн хариу өгсөн , тэгэхдээ ямар нэг тайлбар, хэрүүл маргангүйгээр үүнээ хэлсэн . надад тэгж шуугиан дэгдээх хэрэг юу байх вэ._ Эрхэм де Морсери©н нэр хүнд , унана уу байна уу ямар хамаа бйна? энэ бол мөнгөний ханш дээшилж доошлоход яаж ч нөлөөлөхгүй шүү дээ гэв.

Альбер царай нь улайх шиг санаджээ . Данглар бүгдийг үнэнээр биш ч гэсэн үнэний хувьтай зүйлийг чин сэтглэсэ биш, айснаасаа болж амиа хамгаалахын үүднээс ярьж буй нь эргэлзээгүй байлаа. Гэвч Альберт юу хэрэгтэй байв. Данглар , Монте-Кристо хоёрын хэн нь их , бага буруутай нь хамагүй , харин доромжлолын хариуг авах хүн , өдөлтийг нь хүлээн авах хүнийг олох нь хэрэгтэй байв. Данглар өдөлтийг хүлээн авахгүй нь харваас илт болов.

Тэгтэл түүний мартсн ажиглахгүй өнгөрсөн зүйлүүдп ухаан санаанд нь урган буулаа. Монте-Кристо хоёрын хэн нь их бага буруутай нь хамаагүй , харин доромжлолын хариуг авах хүн , өдөлтийг нь хүлээн авахгүй нь харваас илт боллоо .

Тгтэл түүний мартсан ажиглахгүй өнгөрсөн зүйлүүд ухаан санаанд нь урган буулаа . Монте-Кристо х Али-Пашийн охиныг худалдаж авсан болохоор, цөмийг нь мэдэж байгаа мөртлөө Янинд захидал бич гэж Дангларт зөвөжээ . Хариуг нь мэдээд Альберыг Гайдетай танилцахыг зөвшөөрсөн . Тэр хоёр Гайде дээр ормогц яриаг Алийн үхсэгн тухай уруу чиглүүлж , Гайдегийн ярихад саад болоогүй (Бас грегээр хэлсэн хэдэн үгэндээ , эцгийн нь тухай яриа болж байгаа бол®хоор нэрий нь бүү дурсаарай гэж хэлсэн баж болох юм)” Түүнэс гадна Гайдегийн дэргэд аавынхаа нэрийг бүү хэлээрэй гэж гуйж байсан. Эфэст нь гол үйл явдал дэгдэх, үед Альберыг Норманди уруу дагуулан явсан, энэ бүгдээс үзэхэд үүнийг санаатайгаар хийжээ . Монте-Коисто түүний эцгийн дайснуудтай хуйвалдсан нь эргэлзээгүй боллоо .

Альбер Бошаныг хажуу тийш нь дуудаж аваачаад энэ бүх таавраа ярихад:

- Таны хэлдэг зөв. Данглар энэ явалд зөвхөн бүдүүлгээр материалбн талаар л холбогдоно. Монте Кристо гүгээс л тайлбар шаардах ёстой юм байна гэж цаадах нь хэлэв.

Альбер Данглар өөд эргэж

- Эрхэм и тантай миний хэцэх яриа ингээд төгсөөгүй гэдгийг та ойлгох ёстой шүү . Би таны үг хэр зэрэг үнэн болохыг мэдх хэрэгтэй байна. Үүнийг лавлахын тулд одоо Монте-Кристо гүнгийнд очлоо гэж хэлэв. Тэгээд Кавальканти өөд харах ч үгүйгээр , банкны эзэнд мэхийн ёслоод , Бошаны хамт гарч явлаа .

Данглар тэднийг үүдээ хүртэд гаргаж өгөөд, босгон дээрээ Морсер гүнг үзэн ядах ямар ч хувийн шалтгаан байхгүй гэдгээ Альберт дахин хэллээ .

11.ДОРМЖЛОЛ

Банкны эзнийхээс гараад Бошан зогслоо.

- Альбер би танд Монте-Кристо гүнгээс тайлбар шаардах хэрэгтэй гэж хэлсэн шүү дээ гэв.
- Тийм ээ, бид тэдний уруу очно.
- Ганцхан минут хүлээгээрэй. Гүнгийнд очихоосоо өмнө сайн бодох хэрэгтэй.
- Би бас өөр юу бодох юм бэ?
- Энэ алхам маш ноцтойн тухай бод.
- Дангларынд очдогос илүү ноцтой гэж үү?
- Тийм ээ, Данглар бол ажил хэргийн хүн. Иймэрхүү ажил хэргийн хүмүүс хөрөнгөнийхөө үнийг санй мэддэг болохоор тулалдахдаа дургүй байдаг юм. Монте-Кристо гүн бол, лав л гадаад байдлаараа жинхэнэ эр хүн. Боловсон хүн шиг дүрийн нь цаана алуурчин байж мэднэ гэж айхгүй байна уу? гэхэд
- Би ганцхан түүнийг тулалдахаасаа татгалзах бий гэж л айж байна.
- Тэр тухай бүү зов. Тэр чинь тулалдана. Тэр ч байтугай дэндүү сайн тулалдаж магадгүй гэж айж байна. Та болгоомжлоорой! Гэж Бошан хэлэхэд Альбер цагаахнаар инээмсэглэн,
- Найз минь тэр л надад хэрэгтэй. Надад хамгийн их затай хэрэг бол эцгийнхээ төлөө тулалдаанд алагдах явдал мөн. Энэ л бид бүхнийг аварна гэж хэллээ.
- Энэ явдал танай ээжийг чинь ална шүү дээ!
- Хөөрхий ээж минь гээд Альбер гараараа нүдээ арчаад, - Тийм ээ, би Мэднэ. Гэвч ичгүүр сонжуураас болж үхсэнээс уйтгар гунигаас болж үхсэн нь дээр гэж хэллээ.
- Тэгвэл та хатуу шийдэв үү?
- Тийм ээ.
- Тэгвэл явъя! Түүнийг гэртээ байхад нь олж очно гэж та итгэж байна уу?
- Тэр миний хойноос Парси руу гарах ёстой байсан, одоо лав Парист ирсэн байгаа.

Тэгээд хөлсний тэргэнд сууж Елисейн Тал уруу явлаа.

Бошан ганцаараа орох гэсэн боловч энэ халз тулалдаан нэлээд ер бишийн болох учир ёс журмыг зарим талаар зөрчихөд болох юм гэж Альбер хэлэв.

Альберыг зоригжуулж байгаа сэтгэл нь тун ч ариун учир Бошан хүсэлд нь захирагдахаас өөр арга байсангүй. Тийм у-раас үгэнд нь орж найзынхаа хойноос нь дагах үүрэг гүйцэтгэлээ.

Альбер хаалганаас шат хүрхтэл бараг гүйж очлоо. Тэнд Батистентай дайралдлаа_

Гүн үнэхээр буцаж ирсэн байв. Тэр хэнийг ч ирсэн хүлээн авахгүй гэж хэлээрэй хэмээн Батистенд хэлжээ.

- Гэгээн эзэнтэн усанд орж байгаа гэж Батистен Альберт хэлэв.

- Усныхаа дараа яах бол?
- Хоолоо иднэ.
- Хоолныхоо дараа?
- Амрах болно.
- Дараа нь
- Дараа нь Операд очно.
- Та үүнийг бүр мэдэж бөайна уу? гэж Альбер асуулаа.
- Бат мэдэж байна. Гүн яг найман цагт морь өгөхийг тушаасан.
- За маш сайн, надад өөр юу ч хэрэггүй гэж Альбер хариу хэлэв.

Тэгээд Бошан өөд эргэж,

- Хэрэв та ийш тийшээ явах хэрэгтэй бол одоо яв. Хэрэв өнөө орой хүнтэй уулзах болзоо тавьсан бол маргааш болгож хойшлуулаарай. Би таныг өөртэйгөө хамт Операд очно гэж найдаж байгааг та ойлгож байгаа биз. Амжвал Шато-Реног дагуулаад ирээрэй гэв.

Бошан найман цагт арван таван минут дутуу байхад дайраад ирнэ гэж хэлээд Альбертэй салах ёс гүйцэтгэв.

Гэртээ хүрч ирээд Альбер хүн явуулж Франц, Дебрэ, Моррель гурвыг өнөө орой Операд уулзахыг маш их хүсэж байгаагаа хүнээр хэлүүлжээ.

Дараа нь дээрх ядллын дараа өөр дээрээ хэнийг ч бүү оруулахыг тушаагаад өрөөндөө ороод түгжчихсэн ээж дээрээ орлоо. Түүнийг ороход нь ээж нь болсон явдалд үймрэн гунихарч, орондоо хэвтэж байлаа.

Альбер орж очсонд болох ёстой байсан юм болж хатагтай хүүгийнхээ гарыг атган цохирон уйллаа. Гэхдээ энэ нулимс дотрыг нь онгойлгожээ.

Альбер ээж дээрээ тонгойн дуугүй зогсоно. Түүний хөмсгөө зангидан, царай нь зэвхийрэн байхыг харваас өшөөгөө авах хүсэл нь зүрхийг нь улам хүчтэй эзэмдэн байгаа бололтой.

- Ээжээ, та Морсер гуайд дайсан бий эсэхийг мэдэх үү? Гэж тэр асуулаа. Альбер, миний эцэгт гэж хэлсэнгүйг Мерседес ажиглаад цочжээ.
- Хүү минь, гүн шиг ийм тушаалтай хүнд нууц дайсан олон байдаг юм. харин илэрхий дайснууд хамгийн аюултай биш гэдгийг чи мэднэ гэж ээж нь хариуллаа.
- Тийм ээ, би мэднэ. Тийм учраас таны хурц хараатайд найддаг юм. Таны хараанаас юу ч зайлж чадахгүйг би мэднэ!
- Чи надад үүнийг яагаад ярьж байна!
- Монте-Кристо гүн манай бүжигт наадам дээр юу ч амсахыг хүсэхгүй байсныг та ажигласан шүү дээ.

Мерседесийн бүх бие дагжин орон дээрээ өндийгөөд,

- Монте-Кристо ий! гэж дуугараад - Чиний асууж байгаа юманд энэ хүн ямар хамаатай юм бэ? гэж асуулаа.
- Ээж, та Монте-Кристо гүнг Дорнодын олон заншилд үнэнч болохыг мэднэ шүү дээ. Дорнодод бол хүн өшөө авах эрхээ хадгалахын тулд дайсныхаа гэрт юу ч ууж иддэггүй юм.
- Монте-Кристо гүн манай дайсан гэж үү? Үүнийг хэн чамд хэлэв? Яагаад тэр вэ? Альбер чи дэмийрч байна. Монте-Кристо гүн бидэнд сайн л байдаг байсан шүү дээ. Монте-Кристо гүн чиний амийг аварсан, чи өөрөө түүнийг

бидэнтэй танилцуулсан шүү дээ. Альбер минь гуйя чамаас, энэ бодлоо орхи. Би чамд түүнтэй найрамдалтай байхыг зөвлөө, тэгээд ч зогсохгүй гуйя гэхдээ Мерседесийн царай хувхай цайжээ.

Тэгэхэд Альбер ээжээ царай нь барайн харж

- Ээж ээ танд тэр хүнтэй өршөөнгүйгээр харьцах нэг учир шалтгаан байна гэлээ.
- Надад уу! гэж Мерседес хэлээд царай нь эгшин зуурын дотор улалзсанаа дараа нь түрүүчийнхээсээ улам илүү зэвхийрэв.
- Тийм ээ. Тэр хүн бидэнд бөөн хар гай учруулж болох болохоор л ээж та тэр хүнийг өршөөн үзэхийг гуйж байна, тийм ээ? гээд хүү эхийнхээ өөдөөс аягүй харахад ээж нь цочин чичирч хүүгээ шинжих мэт харлаа.
- И ямар хачин юм ярина вэ! Хаанаас чамд ийм бодол төрөв! Гүнгийн эсрэг чи юу мэдэж байна? Чи гурван өдрийн өмнө Нормандад тэднийд зочилсон. Гурван өдрийн өмнө чи ч, би ч гэсэн түүнийг чиний шилдэг сайн нөхөр гэж үзэж өөрсөн биш билүү гэж хатагтай хэллээ.

Альберын уруул дээр ёжтой инээмсэглэл тодров. Мерседес энэ инээмсэглэлийг харж эх хүн эмэгтэй хүний төрөлхийн зангаар бүхнийг тааварлан мэдлээ. Гэвч болгоомжтой, зориг хатуужилтай хүн болохоор зовж түгшсэн байдлаа ил гаргахгүй байж чадлаа.

Альбер дуугүй байлаа. Бага зэрэг байзнасны дараа Мерседес яриагаа үргэлжлүүлэн

- Чи миний биеийг ямар байгааг асуух гэж ирсэн гэж хэлсэн. Хүү минь миний бие муу байна. Альбер минь налтай хамт бай. Ганцаараа байхад надад хэцүү байна гэхэд залуу хүү
- Ээж минь яаруу, хойшлуулашгүй хэрэг болоогүй бол таныг орхиж явахгүй байх сан даа гэж хэллээ.
- За яая гэх вэ? Хүү минь чамайг үр хүний сэтгэлдээ хэт баригдан зовог гэж би үл хүснэ гэж Мерседес санаа алдан хэллээ.

Альбер энэ үгийг сонсоогүй юм шиг дүр үзүүлж, ээжтэйгээ салах ёс гүйцэтгээд гарч одлоо.

Альберыг хаалгаа хааж амжаагүй байхад Мерседес итгэмжилсэн зарцаа дуудаж Альберыг хаашаа явсан ч дагаж, ву хийж байгааг тухай бүр нь өөртөө мэдэгдэхийг даалгав.

Дараа нь үйлчлэгч хүүхнээ дуудаж ямар ч хэрэг болсон бэлхэн байхаар хувцсаа өмсөж бослоо.

Зарцад өгсөн даалгавар биелэгдэхэд төвөггүй байжээ. Альбер гэртээ буцаж очоод маш нямбай хувцаслав. Наймаг цагт арван минут дутуу байхад Бошан ирлээ. Тэрээр Шато-Ренотой уулзсан бөгөөд хөшиг нээгдэхийн өмнө эхний эгнээнүүдийн нэгэнд байлдаг өөрийн сандалд сууж байна гэж хэлжээ.

Залуу хүмүүс Альберын сүйх тэргэнд суугаад, хаашаа явахыг нуух хэрэгцээгүй байсан тул чангаар:

- Опера театрт очно гэж тушаалаа.

Тэсэж ядсан залуу жүжиг эхлэхээс өмнө театрт орлоо.

Шато-Рено суудал дээрээ хэзээний сууж байлаа. Бошан түүнд бүх зүйлийг хэлсэн учир Альбер ямар ч юм тайлбарлан нуршихын хэрэг байсангүй. Эцгийнхээ

өшөөг авах гэсэн хүүгийн аяг ааш зүй ёсны байсан учир Шато-Рено түүнийг ятгаж барих ч гэсэнгүй зөвхөн түүнд үйлчлэхэд бэлхэн өайгаагаа хэлэв.

Дебрэ алга байсан боловч, Операд ирэхгүй байх нь цөөн байдгийг Ёльбер мэднэ. Хөшиг нээгдэхээс өмнө Альбер театр дотуур холхин явж байв. Тэрээр Монте-Кристо гүнтэй гудам буюу шатан дээр дайралдана байх гэж горьджээ. Хонх дуугарч түүнийг буцаж орох болгосно тул Альбер орж, Шато-Рено Бошан хоёрын дунд байдаг суудалдаа очиж суулаа.

Гэвч түүний нүд нэгдүгээр үзэгдлийн туршид багануудын хоорондох хаалттай байсан лоож өөд салалгүй ширтэнэ.

Тэгтэл арай гэж хоёрдугаар үзэгдэл эхлэх үед буюу Альберыг цагаа зуу дахь удаагаа харах үед лоожны хаалга нээгдэж тас хар хувцас өмссөн Монте-Кристо орж ирээд хашлага тулан зогсож үзэгчдийн танхимыг харлаа. Түүний араас Моррель орж ирээд дүү, хүргэн хоёроо харлаа. Тэднийг дээд давхарт суужж байхыг хараад мэхийв.

Гүн үзэгчдийн танхим уруу харж, өөрийг нь эрж, шунахайгаар гялалзаж байгаа нүд, зэвхийрсэн царайг олж үзлээ. Альберыг таньсан боловч эдгүйцсэн царайг нь хараад хараагүй юм шиг өнгөрлөө. Өөрийн санаа бодлыг юугаар ч илрүүлсэнгүй суугаад дурангаа гэрнээс нь гарган нөгөө тал өөд дурандлаа.

Гэвч Альберыг хараагүй юм шиг дүр үзүүлэн байсан мөртлөө түүнээс хараагаа салгахгүй байлаа. Хоёрдугаар үзэгдэл төгсөж хөшиг хаагдахад Альбер хоёр нөхрөө дагуулж танхимаас гарч ирэхий нь хүртэл андалгүй харав.

Дараа нь түүний нүүр зэргэлдээ лоожинд харагдлаа. Нүн аянга ниргэх ойртож байгааг мэдэрч, лоожны хаалганы түгжээ дуугарахад Моррельтой хамгийн хөгжилтэй янзаар ярьж байсан боловч юу болох гэж байгааг мэдэж бэлхэн хүлээж байв.

Хаалга нээгдлээ.

Тэгэхэд гүн эргэн харж, чичрэн зэвхийрсэн Альберыг харлаа. Түүний ар талд Боша, Шато-Рено хоёр зогсож байв.

- Өө, та чинь давхиад ирээ юу гэж найрсаг бөгөөд дээдсийн хүрээлэнгийн ёс болсон мэндчиллээс өөр энгийн дотноор мэндлээд, - Эрхэм Морсерт оройн мэндийг хүргэе гэв.

Биеэ барьж чаддаг энэ хүний царай үнэхээр найрсаг шинжтэй байв.

Моррель дотор нь юу ч дурдаагүй, зөвхөн орой Опера театрт очихыг хүссэн захидал бээсээс авснаа саналаа. Тэгээд одоо юу болохыг ойлгов.

- Бид хуурмаг царай гарган, худлаагаар бие биедээ нөхөрсөг дүр үзүүлье гэж ирээгүй билээ. Би танаас тайлбарлахыг шаардахаар ирсэн юм гэж Альбер хэлэв.

Альбер шүдээ зууж, хоолой нь чичрэх ажээ.

- Оперийн театрт ирж тайлбар шаардах гэнэ ээ? гэж гүн өөртөө бүрэн итгэлтэй хүний тайван дуугаар нэвт шувт харцаар харж хэлээд – Би Парисын заншлыг бага мэдэх боловч, ямар ч гэсэн энд тайлбар шаардах газар биш байх гэлээ.

- Хэрэв хүн нуугдаж, усанд орж байна, хоолоо идэж байна, цнтаж байна гээд байвал уулзаж дайралдаж болдог газар нь ярилцхааса биш яах вэ гэж Альбер хэллээ.

- Намайг олоход амархан. Би эндүүрээгүй л бол та өчигдөрхөн манайд зочилж байсан шүү дээ гэж Монте-Кристо хэллээ.

- Би өчигдөр таны хэн болохыг мэдэхгүй байсан учир таны зочин болж байсан юм гэж Альбер уурандаа багтран хэлэв.

Альбер энэ үгийг хэлэхдээ зэргэлдээ лоож гудамд дуулдахаар чанга хэлжээ. Үнэхээр ч маргалдах дууг дуулаад лоожинд сууж байсан хүмүүс эрэгж, гудмаар явж байсан хүмүүс Бошан, Шато-Рено хоёрын ард зогсов.

Монте-Кристо ямар ч догдолсон дүр үзүүлэлгүйгээр,

- Эрхэм та хаанаас гараад ирэв? Та чинь өөрийн ухаангүй байх шиг байх юм гэв.

- Би таны бузар ядлыг ойлгож, танаас түүний чинь төлөө өшөө авах хүсэлтэй байгаагаа мэдэгдэх гэсэн юм гэж Альбер байж ядан хэллээ.

- Өршөөлт эрхэм минь, би таны хэлж байгааг ойлгохгүй байна. Ямар ч байсан таны дэндүү чанга чрьж байгааг л лав мэдэж байна. Би энд өөрийнхөө байранд байгаа болохоор би л энд өндөр дуугаар ярих эрхтай байх. Одоо зайл! Гэж Монте-Кристо хэлэв.

Тэгээд Монте-Кристо захирч сурсан хүний зангаар хаалга өөд заав.

- Би таныг өөрийг чинь эндээс гаргах болно доо! гэж Альбер хэлээд гүнгийн нүд салгалгүй харж байсан гар дахв бээлийгээ татваганан базлаа.

- За сайн, эрхэм та маргаан үүсгэхийг рхүсэж байх шиг байна. Танд нэгэн зүйлийг зөвлөхийг зөвшөөрнө үүү. Халз тулалдаанд дуудагдаа шуугиан их тарьдаг чинь өөдгүй зан гэдгийг санаж яваарай. Шуугиан дэгдээх гэдэг чинь бүх хүнд ч ашигтай байдаг юм биш шүү, эрхэм Морсер гуай гэж Монте-Кристо тайван хэлэв.

Энэ нэрийг хэлэхэд цугларсан хүмүүсийн дунд шивгэнэлдэх дуу сонтлоо. Өчигдрөөс хойш Морсерын нэр хүн бүхний амнаас салахгүй байжээ.

Альбер, гүнгийн үгний егөөг бүхнээс илүү, бүхнээс түргэн ойлгож, бээлийгээ гүнгийн нүүд өөд шидэх гэтэл Моррель түүний гараас барьж авлаа. Энэ явдал зохих хэр хэмжээнээс хэтрэх нь гэж айсан Бошан, Шато-Рено хоёр ч түүний мөрнөөс татав.

Харин Монте-Кристо суудлаасаа ч босолгүй гараа сунгаж, Альберын атгасан гараас үрчийж чийг даасан бээлийг нь суга татан аваад аймшигтай дуугаар,

- Эрхэм ттаныг энэ бээлийгээ над уруу шидсэн гэж би үзэж байна. Тэгэхлээр маргааш сумтай хамт буцааж өгнө дөө. Одоо эндээс зайлж хайрла, тэгэхгүй бол би зарцаа дуудаж хаалганы цаана хаяулна шүү гэж хэллээ.

Альбер нүд нь луайж, согтуу хүн шиг гуйван дайвалзаж алхам ухарлаа.

Моррель үүнийг нь ашиглан хаалга хаав.

Монте-Кристо дурангаа авч юу ч болоогүй юм шиг дурандаж эхлэв.

Энэ хүний зүрх нь хүрлээр, нүүр нь гантигаар сийлэгджээ.

Моррель гүн рүү тонгойж,

- Та түүнд ямар гэм хийсэн юм бэ? гэж шивгэнэн асуухад,

- Би юу, биеэрээ л лав ву ч хийгээгүй гэж Монте-Кристо хариуллаа.

- Гэвч энэ хачин явдалд заавла нэг шалтгаан байх ёстой.

- Морсер гүнд тохиолдсон будлианаас хойш золгүй хүү өөрөө ч өөрийгөө мэдэхээ больчихсон байна.

- Та тэр явдалд хамаатай гэж үү?
 - Гайде түүний эцгийн урвасан тухай Танхимд мэдэгдэл хийсэн юм.
 - Тантай энэ лоожинд сужж байхыг чинь харсан, таны шивэгчин грег хүүхэн Али-Тебелиний охин юм гэнэ гэж дуулдсан юм. гэвч би үнэмшээгүй байсан шүү хэмээн Моррель хэллээ.
 - Яагаад та тэгж бодож байна?
 - Өнөөдөр Операд очоорой гэсэн зурвасыг би Альбераас хүлээн авсан юм, ланыг доромжлох энэ хэргийнхээ гэрч болгох гэсэн юм байж л дээ.
 - Тун ч болох юм гэж Монте-Кристо огтхон ч тоосон шинжгүй хэлэв.
 - Та түүнийг яах вэ?
 - Хэнийг?
 - Альберыг?
 - Альберыг би яах вэ гэнэ ээ, Максимилиан? Гэж Монте-Кристо мөн л өнөө янзаараа хэлээд, - Өнөөдөр би таныг харж гарыг чинь барьж байгаа минь үнэн шиг, маргаал бөглөө би түүнийг ална. Би түүнийг ингэнэ дээ гэв. Моррель өөрийн ээлжинд Монте-Кристоргийн гарыг атгаж түүний гар хүйтэн тэгээд огт тайван байхыг мэдэрч цочих шиг болжээ.
 - Үгүй гүнтэн, эцэг нь түүндээ хайртай юм шүү дээ! гэж хэлэхэд Монте-Кристо,
 - гагцхүү үүнийг надад бүү яриарай! Гэж анх удаа хорсоо чаддагаа үзүүлэн хэлээд, - Би түүнийг шууд алчихгүй байж мэднэ гэлээ.
- Моррель гайхан Монте-Кристоргийн гарыг тавилаа.
- Гүн, гүн! гэж түүнийг хэлэхэд гүн үгийг нь таслан,
 - Эрхэм Максимилиан, Дюпрэгийн
- Өө, Матильда, өр зүрхний минь уяа... гэж ирээд л гайхалтай дуулахыг нь чагнаач, би Неаполиос анх Дюпрээг нээж олсон, хамгийн түрүүн түүнд алга ташсан юм даа. Зүйтэй зүйтэй! Гэв.
- Үүнийг Моррель өөр вун ч тухай бүү ярь гэсэн үг гэж мэдээд дуугүй боллоо. Хэдэн минутын дараа үзэгдэл төгсөж, хөшиг хаагдахад, хаалга цохилоо.
- Ор, ор гэж Монте-Кристо хэлэхдээ хоолойд нь сэтгэл догдолсон шинж огтхон ч үгүй байв.
- Бошан орж ирлээ.
- Эрхэм Бошан танд оройн мэнд хүргэе гэж Монте-Кристо энэ орой сэтгүүлчтэй анх уулзаж байгаа юм шиг мэндлээд, - Наашаа суу гэлээ.
- Бошан бөхийн ёслоод орж суулаа. Тэгээд Монте-Кристо уруу тонгойн,
- Би дөнгөж сая эрхэм де Морсерыг дагаж ирснийг та ажигласан байх гэж хэлэхэд,
 - Үүнээс дүгнэлт хийхэд та хоёр хамт хоол идсэн байж таарах нь. Таныг цаадахаасаа илүү биеэ барьж байсныг хараад баярласан шүү гэж Монте-Кристо инээгээд хэлэв.
 - Гүнтэн, Альбер хэтэртлээ уурласан нь буруу байсныг хүлээгээд өөрийн зүгээс уучлалт гуйя. Би одоо буруугаа хүлээсэн болохоор таныг Яниныхантай ямар харьцаатай байдаг тухайдаа хариу хэлэх байх гэж найдаж байна. Дараа нь би тэр залуу грег бүсгүйн тухай хэдэн үг хэлье гэв. Монте-Кристо түүний үгийг харцаараа зогсоолоо.

- Ингээд л хамаг найдвар минь нурчихлаа гэж гүн инээмсэглэн хэлэхэд Бошан,
- Яагаад тэр вэ? гэж асуулаа.
- Маш амархан. Та нар намайг маш өвөрмөц сонин хүн гэдэг алдартай болгохыг яарсан. Та нарыхаар бол би Лара ч биш. Манфред ч биш, лорд Рутвен ч биш. Дараа нь миний хачин өвөрмөц байдал та нарт залхуутай санагдахаар, одоо байчхаад намайг хамгийн бор бараг хүн болгох гэж байна уу? Та нар намайг олхиогүй, задгай зайдан амьсан болохыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл та нар надаас тайлбао шаардаж байна. Больж үз дээ Бошан гуай, та надаар доог хийж байна шүү дээ гэв...
- Гэвч нэр төр шаарддаг үе байдаг юм...гэж Бошан ихэмсэгээр хэлэхэд үгийг нь таслан,
- Эрхэм минь Монте-Кристо гүнээс зөвхөн Монте-Кристо гүн л ямар нэгэн юм шаардаж болно. Тийм учраас дахиад нэг ч үг бүү хэлээрэй. Эрхэм Бошан гуай, би хүссэн л юмаа хийнэ. Тэгэхдээ тун сайн хийнэ гэдэгт итгэж яваараа гэж хэллээ.
- Эрхэм ээ, шгударга хүмүүсийг ийм үгээр аргацааж болдоггүй юм. Нэр төр бол баталгаа шаарддаг гэж Бошан хариулав.
- Эрхэм минь, би өөрөө амьд баталгаа байна гэж гүн тайван хэлсэн боловч харц нь аягүй дүрсхийгээд – Бид хоёрын хоёулангийн судсанд урсгахаас буцахгүй цус гүйж байгаа. Энэ л харилцан баталгаа болно. Энэ хариуг бээсэд дамжуулаад маргааш өглөө арван цаг цохихоос өмнө цусны чинь өнгийг харамц гэж байна хэмээн дамжуулчихаарай.!
- Тэгвэл одоо тулалдааны болзлыг ярилцахаас өөр ювмгүй болж байх шив гэж Бошан хэллээ.
- Эрхэм минь тэр чинь надад ямар ч ялгаагүй, та ийм үалихгүй юмны төлөө жүжиг үзэж байхад минь яршиг удаад байх юм. Францад сэлэм буув гар буугаар тулалддаг, колони орнуудад бол зарбин бууг илүүд үздэг. Арабд хутга хэрэглэдэг. Би хэдийгээ доромжлогдсон боловч өвөрмөц сонин хүн гэдэг нэрээ хадгалахын тулд, түүнд ямар ч маргалдах юмгүйгээр дуртай зэвсгээ хэрэглэх боломжийг олгож, бүхнийг зөвшөөрнө гэж байна гэж итгэн явуулсна хүндээ хэлээрэй. Бүгдийг шүү, бүгдийг, тэр ч байтугай сохроор аз туршсан сугалаагаар тулалдахыг ч зөвшөөрнө. Надтай бол өөр хэрэг шүү. Би ялж гарна гэдэгтээ итгэлтэй байна гэж Монте-Кристовийн хэлэхэд, Бошан сандарсан байдалтай гүн өөд харж,
- Та итгэлтэй байна гэнэ ээ? гэв.
- Тэгэхэд Монте-Кристо мө°өө хавчиж,
- Тийм ээ, мэдээж хэрэг. Тэгэхгүй бол би хаанаас эрхэм Морсерын өдөлтийг хүлээж авах билээ. Би түүнийг ална. Тэгж алах ёстой, тэгэх ч болно, харин өнөөдөр ханаа, ямар зэвсгээр тулалдахыгаа надад хэлж өгвөл сайн байна. Би ер нь өөрийгөө хүлээлгэхэд дургүй хүн шүү гэв.
- Өглөө найман цагт, Венесний ойд гар буугаар гэж хүн хүнээс шал өөр амьтантай юу эсвэл хоосон хөөргөн амьтантай ярьж байгаа алиныгаа ч мэдэхгүй байгаа Бошан хэлэв.

- За маш сайн, эрхэм минь. Одоо бүх зүйлийн тухай ярилцан тохирсон болохоор намайг жүжиг үзэхийг зөвшөөрнө үү. Харин та найз Альбертаа дахин наашаа бүү ирээрэй гэж хэлээрэй. Зохимжгүй байдал өөрт нь л муу болно доо. Гэртээ харьж унтаж амарвал түүнд дээр байх гэж Моонте-Кристо хэлэв.
- Бошан гайхаж хоцрон гарч одлоо.
- Аа одоо би танд найдаж болох уу? гэж Монте-Кристо, Моррель өөд эргэн асуув.
- Мэдээж хэрэг гүн та намайг өөрийн хэрэгт бүрэн хэрэглэж болно. Харин...
- Юу вэ?
- Үнэн учрыг мэдэх явдал надад чухал байна...
- Өөрөөр хэлбэл та татгалзаж байна уу?
- Үгүй дээ.
- Үнэн шалтгаан гэнэ ээ? гэж гүн давтан асуугаад, - Энэ хүү өөрөө ч мэдэхгүй сохроор ингэж байгаа юм. Үнэн шалтгааныг нь бурхан, бид хоёр л мэднэ. Харин бүхнийг мэдэж байгаа бурхан бидний төлөө гэдгийг Моррель танд амлан хэлье гэв.
- Энэ хангалттай боллоо. Харин таны хоёр дахь гэрч хэн болох вэ? гэж Моррель асуулаа.
- Би Парист хэнийг ч танихгүй болохоор Морреь та, таны хүргэ Эмманюель хоёррос өөр хэнийг гуйх юэ. Эмманюель надад ийм тусламж үзүүлнэ гэдэлт та итгэж байна уу,
- Би өөртөө Ётгэж байгаа шиг итгэж байна.
- Маш сайн! Энэ л надад хэрэгтэй бүх зүйл юм. Тэгвэл маргааш долоон цагт манайд уулзах уу?
- Бид яг ирнэ.
- Чимээгүй! Хөшиг нээгдлээ, алив сонсьё. Би энэ шзэгдлийн нэг ч аяыг өнгөрөөлгүй чагнадаг юм. “Вильгельм Тель” гайхалтай сайхан дуурь шүү!

12.ШӨНӨ

Монте-Кристо гүн заншлаараа Дюпрээг “Миний хойноос!” гэдэг алдарт аяа дуулж төгстөл чагнаж байгаад дуусахаар нь босож лоожноосоо гарлаа.

Моррель гадаа хаалган дээр маргааш өглөө долоон цагт ирнэ гэж дахин амлаад салж одлоо.

Дараа нь гүн мөн л нөгөө инээмсэглэсэн тайван байдлаараа сүйх тэргэндээ суулаа.

Таван минутын дараа гэртээ хүрч ирлээ.

Гэртээ орж ирээд Алийг дуудаж,

- Али, чи миний зааны ясан бариултай гар бууг гаргаад ир! гэж хэлэхэд нь уур нь хүрсэн байдал дууны өнгөнд байсныг гүнг мэдэхгүй хүн бол ажиглахааргүй байлаа.

Али хайрцаг авчирч өгөхөд, гүн буугаа үзлээ. Ганцхан бөөрөнхий пойлоосонд амиа даатгаж байгаа хүнд зүй ёсны хэрэг юм.

Энэ бол МонтеКристо гэртээ буудлагын сургууль хийж байх гэж тусгай захиалан хийлгэсэн онцгой хэлбэрийн буу байв. Буудахад нь гагцхүү бялт л хийх хэрэгтэй бөгөөд зэргэлдээ өрөөдн нь байхад гүн буудлага хийж байна гэж мэдэхийн аргагүй билэ.

Буугаа дөнгөж аваад байны оронд хэрэглэдэг төмөр самбар өөд чиглүүлэн шагайтал тасалгааны үүд нээгдэж Батистен орж ирлээ.

Түүнийг үг хэлэх гэж амаа ангайж амжаагүй байхад ар талд нь нүүрэндээ гивлүүр унжуулсан хүүхэн Батистены араас орж ирэхийг харав.

Хүүхэн гүнгийн гарт нэг гар буу, ширээн дээр хоёр сэлэм байхыг хараап тасалгаанд гүйн орлоо.

Батистен асуух мэт эзэн өөдөө харлаа.

Гүн түүн өөд дохиход Батистен хаалга хаалгаад гарч одлоо.

- Хатагтай та хэн гэгч вэ? гэж гүн гивлүүртэй хүүхнээс асуулаа.

Үл таних хүүхэн хоёулхнаа байгаа эсэхийг шалгах тэм тасалгааг эргэцүүлэн хараад, өвдөг дээрээ сөхрөн унах гэж байгаа мэт доор бөхийгөөд цөхөрсөн байдалтай гараа атгалан байв.

- Эдмон, та хүүгий минь бүү алаач гэж хүүхэн хэллээ.

Гүн алхам ухраад, хашхирах мэт аяархан дуугараад гар буугаа алдаж унагаав.

- Хатагтай Морсер та ямар нэг хэлэн вэ? гэж асуухад нь бүсгүй гивлүүрээ дээш нь болгож

- Таны нэрийг хэлж байна. Ганцхан би л иатраагүй байж мэдэх тэр нэрийг хэлж байна. Одоо тан дээр хатагтай де Морсер биш, харин Мерседес ирээд байна гэлээ.

- Хатагтай минь. Мерседес үхсэн, би түүнээс өөр имй нэртэй хүн танихгүй гэж Монте-Кристо гүн хэллээ.

- Мерседес амьд. Мерседес бүгдийг мартаагүй, саж байгаа. Тэр ганцаараа л таныг хармагц, тэр ч байтугай Эдмон таны дуугий чинь дуулаад таньсан. Түүнээс хойш би таныг мөрөөр чинь даган харж явсан. Морсер гүнд хэний гар цохилт өгснийг эрээд байх ч хэрэг байсангүй.

- Хатагтай та. Феран гэж хэлэх гэсэн юм биш биз гэж Монте-Кристо гашуунаар ёжлоод – Та л эхэлж тэр нэрнүүдийг санаж гаргаж ирсэн хойно цөмийг нь л гаргаж ирвэ гэй.

Монте-Кристо тэрхүү “Фернан” гэдэг нэрийг тийм их үзэн ядаж хэлсэн тул Мерседес айн чичирлээ.

- Би андуурсангүйг Эдмон та харж байна уу? Би хүүгий минь хайрлаач гэж гуйсан минь дэмий хэрэг биш байгаа биз! гэж хүүхэн дуу алдлаа.

- Би таны хүүгийн дайсан гэж хэн танд хэлээ вэ?

- Хэн ч хэлээгүй! Эх хүн бүхэн далдыг харагч байдаг юм. Би цөмийг тааварлан мэдээд, түүний хойноос Опера театрт очиж, лоожинд нуугдаж байгаад бүгдийг нь харсан

- Тэгвэл та Фернаны хүү намайг олны өмнө доромжилсныг харсан биз дээ? гэж Монте-Кристо аймаар тайван байдлаараа хэллээ.

- Өрөвдөн хайрлаач!

- Хэрэв миний найз эрхэм Моррщль түүний гараас барьж аваагүй бол миний нүүр өөд бээлийгээ шидэх байсан юм гэж гүн үргэлжлүүлэн ярив.
- Та намайг сонсооч. Миний хүү бас таныг тааварлан мэдэж, эцэгтээ тохиолдсон гай зовлонг танаас болсон гэж бодсон байна.
- Хатагтай та, ташаарч байна, энэ бол гай зовлон биш, өшөө авалт байгаа юм. Би эрхэм де Морсерт цохилт өгсөн биш, харин тэнгэрийн бошго түүнийг ийнхүү залхаан цээрлүүлж байгаа юм гэж хэлэхэд Мерседес,
- Та яагаад өөрийгөө дээд тэнгэрийн оронд тавиад байгаа юм бэ? дээд тэнгэр өөрөө мартчихсан байхад та яагаад санаж гаргаж ирээд байгаа юм бэ? Эдмон танд Янина, түүний эзэн ямар хамаатай юм бэ? Фернан Мондег® Али-Тебелинэс урвахдаа танд ямар гэм хийсэн юм бэ? гэж Мерседес хэллээ.
- Хатагтай таны хэлдэг үнэн. Энэ бүхэн бэл зөвхөн францын офицер ба Василикийн охин хоёрт хамаатай юм. Энэ надад огт хамаагүй. гэхдээ би францын офицерээс биш, Морсер гүнгээс биш, каталан бүсгүй Мерседесийн нөхөр загасчин Фернанаас өшөө хорслоо авна гэж тангарагласан юм гэж Монте-Кристо хариуллаа.
- Хувь заяа минь намайг түлхэн оруулсан тэр алдааны төлөө яасан хатуу ширүүн өшөө хорсол вэ! Гэм буруутан нь би юм шүү дээ Эдмон. Хэрэв та өшөөгөө авах гэж байгаа юм бол таны эзгүй байхад өөрийн ганцаардмал байдлыг тэсвэрлэн өнгөрүүлж чадаагүйи надаас л аваарай гэж хатагтай дуу алдлаа.
- Аа би яагаад байхгүй байсан юм бэ? Та яагаад ганцаараа байх болсон юм бэ гэж Монте-Кристо өгүүллээ.
- Яагаад гэвэл таныг бариад авчихсан, яагаад гэвэл та шоронд бхайсан учраас тэр.
- Би яагаад баригдсан юм бэ? Яагаад би шоронд байсан юм бэ?
- Энүүнийг би мэдэхгүй гэж Мерседес хэллээ.
- Тиймээ, хатагтай та үүнийг мэдэхгүй байх, үгүйдээ л мэдэхгүй байх гэж найдаж байна. Харин би танд хэлж өгье. Би тантай суух ёстой байсан тэр өдрийн урьд өдөр “нөөц” гуанзны сэхээвчинд Данглар гэдэг нэртний хүн нэгэн захидал бичиж, загасчийн Фернан биеэрээ шууданд аваачиж өгсөн учраас би баригдаж, шоронд орсон вч гэж хэлээд Монте-Кристо ширээ уруугаа очиж нүдийг нь татаж зэвхийрсэн бэхээр бичсэн, өнгө нь үхэж шарласан цаас гарагж ирээд. Мерседесийн өмнө тавив.

Энэ бол Млнте-Кристо гүн Томсон ба Френчийн пүүсийн төлөөлөгч гэдэг нэрээр ирж, эрхэм Бовилийн тасалгаанаас Эдмон Дантесийн хэрэг дотроос авсан Данглараас вангийн прокурорт бичсэн мөнөөх захидал байлаа.

Мерседес айн тэвдэж ийнхүү уншсан нь:

“Неаполь, Порто-феррайогоор ороод өнөөдөр Смирнээс ирсэн “Фараон” онгоцны ахмадын туслах Эдмон Дантес нь Мюратаас захидал авч узурпаторт аваачиж өгсөн бөгөөд узурпатороос Парист байгаа бонапартичийн талынхны хооронд захидал авчирсан болохыг эрхэм вангийн прокурор танд ван ширээ, үнэн ёсны талын хүн би айлтган толилуулъя.

Түүнийг баричвлан авбал ялт хэргийн нь нотолгоо баримтыг олж болно. Тэр захидал нь нэг бол өөрт нь, нэг бол эцэгт нь эсвэл “Фараон” онгоц дээрх түүний өрөөнд байгаа!” гэв.

- Бурхан минь! гэж Мерседес гиншээд, хөлс дааварласан духаа гараараа илж – Тэгээд энэ захидал гэлээ.
- Хатагтай минь, би захидлыг хоёр зуун мянган франкаар худалдан авсан юм. Үүний ачаар би өнөөдөр өөрийгөө таны өмнө зөвтгөж чадаж байгаа болохоор тийм ч үнэтэй биш юм гэж Монте-Кристо хэллээ.
- Тэгээд энэ захидлаас болж...
- Үүнээс болж би баривчлагдсан юм. Та үүнийг мэднэ. Харин хатагтай та намайг шоронд хэчнээн жил тарчилсныг мэдэхгүй. Би арван дөрвөн жил танаас бээрийн дөрөвний нэгийн зайд орших Иф цайзад хоригдсон. Би энэ урт удаан арван дөрвөн жилийн туршид өдөр бүр өшөөгөө авна гэж тангараглаж байлаа. Тэгэхэдээ би таныг намайг ховлогч Фернантай суусан, эцэг минь үхсэн, үхэхдээ өлсөж үхсэнийг мэдээгүй байсан билээ.

Мерседес дайвалзаж,

- Өршөөлт бурхан минь! гэж дуу алдлаа.
- Шоронд арван дөрвөн жил суугаад гарч ирсэн хойноо Мерседесийн амьдрал, эцгийнхээ үхлийн төлөө Фернанаас өшөөгөө авна гэж ам тангараг тавьсан юм. Тэгээд ч ... би өшөөгөө авах болно.
- Таныг хөөрхий золгүй амьтан Фернан ховлосон гэдэгт та итгэж байдаг уу?
- Энэ үнэн гэдгийг аврагдсан сүнсээ барьж тангараглая. Гэвч энэ бол Францын иргэж байж англичуудад худалдагдсан, испани гаралтай байж испаничуудын эсэрг тулалдан Алид цэргийн албан хааж байж түүнээс урваж хөнөөхөөс илүү бузар хэрэг биш л дээ. Үүнийг танд үзүүлсэн тэр захидалтай зэрэгцүүлж үзвэл юу вэ? Энэ бол эхлээд хэний ч болзоот бай хамаагүй суусан хүүхэн нь хожим өршөөн уучилдаг сэтгэлтэй хар хүүгийн арга гэдгийг би хүлээж байна. Харин болзоот хүүхнээ гэж бодож байсан тэр хүн нь энэ арга залигч уучлан өнгөрөөдөггүй юм. Францчууд урвагчаас өшөөгөө аваагүй, испаничууд урвагчийг буудан алаагүй, булшинд орсон Али урвагчийг шийтгээгүй. Гэвч булшинд хаягдаж байнаад бурхны авралаар түүнээсээ гарсан тэдэнд үнэнч байгаа би бурхны өмнө тэдний төлөө өшөө авах үүрэгтэй. Тэд нараар өшөөгөө авахуулах гэж явуулсан юм. Тэгээд би энд ирээд байж байна.

Золгүй бүсгүй гараараа нүүрээ дараад хадуураар цавчигдсан юм шиг өвдөг дээрээ сөхрөн уналаа.

- Уучлаач. Эдмон намайг бодож уучла ч, танд сайн байсан миний сэтгэлийг бодож уучлаач гэж бүсгүй хэллээ.

Хань ижилтэй, айлын авгай хүн гэдэг нэр төрөө бодоод л уймарч догдолсон зүрхээ дарав.

Авгай бараг нүүрээ шаланд хүртэл тонгойход нь гүн ухасхийн очиж өргөн босгов.

Тэгээд бүсгүй зөөлөн сандал дээр сууж нулимс бүрхэн бүргэлзсэн нүдээрээ Монте-Кристогийн зовж зүдэрч, хорсож занасан аймшигт шиэж тэмдэг нь хэвээрээ байгаа эрэлхэг царай өөд нь харлаа.

- Энэ бузар удам угсааг устгахгүй байх уу? Түүнийг залхаан цээрлүүл гэсэн бурхны үгийг дагахгүй байх уу? Үгүй, чадахгүй гэж гүн шивгэнэв.
- Эдмон гэж арга нь тасарсан золгүй эх хэлээд – Бурхан минь, би таныг Эдмон гэж дуудаж байхад та яагаад намайг Мерседес гэхгүй байна аа? гэхэд,
- Мерседес! Гэж Монте-Кристо давтан хэлээд – Тийм ээ, таны хэлдэг зөв, энэ нэрийг хэлэхэд надад бас л сайхан хэвээр байна. Олон жил өнгөрсөний хойно энэ нэрийг анх удаа тодоос тод хэлж байна. Мерседес, би таны нэрийг уйдаж гунин санаа алдаж, өвдөж зовон гиншиж, аргаа баран орилж олон удаа хэлж дуудаж байсан. Би нэрийг чинь даарч бээрэн, шоронгийн сүрэл дэвсгэр дээр атиран эвхрэлдэн байж хэлж байсан. Би таны нэрийг халуудн халж тамирдан, шоронгийнхоо чулуун шал дээр мөлхөж байж хэлж байсан. Мерседес би арван дөрвөн жил зовж зүдэрч, арван дөрвөн жил уйлж унжиж, зүхэж занаж байсан учир өшөөгөө авах ёстой. Мерседес, би заавал өшөөгөө авах ёстой! Гэв.

Тэгээд гүн голгүй хайртай байсан хүүхнийхээ гуйлтад зориг алдаж магадгүй гэж айсандаа үзэн ядах сэтгэлээ улам хатуу болгож өгөх хуучин ядллыг эргэн санав.

- За тэгвэл, Эдмон өшөөгөө ав даа. Харин гэм буруутнуудаас өшөөгөө ав. Түүнээс ав, надаас ав, харин хүүгээс минь бүү аваарай! Гэж золгүй явдалд учирсан эх уйллаа. Тэгэхэд Монте-Кристо
- Гэгээн сударт бичихдээ: “Эцгийн гэм буруутай явдал гурав дөрөв дэх үеийн үр хүүхдэд нь хүртэл ногдоно” гэсэн байдаг. Бурхан ингэж айлдсан байхад би яагаад бурхнаас илүү энэрэнгүй сэтгэлтэй байх юм билээ? гэв.
- Яагаад гэвэл бурхан цаг хугацаа энх мөнхийг эзэмдэн байдаг, харин хүн бол тийм биш бурчаас тэр.

Монте-Кристогийн цээжнээс гинших ч шиг, хүрхрэх ч шиг дуу гарч хоёр гараараа чамархайгаа дарлаа.

- Эдмон, би таныг таних бослон тэр цагаасаа хойш таныг бишрэн хүндэлж, таныг ариунаар дурсан явж ирсэн. Эдмон, найз минь үүрд миний зүрхэнд хадагдсан тэр сайн сайхан, цэвэр тод дүрийг бүү бараантуулж сүүдэрлээч! Би таныг амьд мэнд гэж найлаж байхдаа, таныг үхсэн гэдэгт үнэмшсэнээсээ хойш таны төлөө бурханд хичнээн мөргөж залбирсныг минь мэддэг болоосой! Би таны хүүрийг ямар нэг бараан цамхгийн гүн ёроолд хаясан даа гэж бодон уйлдаг байлаа. Би эдмон таны төлөө залбирал, уйлахаас өөр юу хийж чадах билээ? Би арван жилийн турш шөнө бүр нэг л янзын зүүд зүүдэлж байсан. Таныг өөр нэгэн үхсэн хоригдлын оршуулгын хүүдийд орж зугтахыг оролдсон, тэгээд тэр амьд хүүрийг Иф цайзын өндөр эрэг дээрээс хаячихсан тухай цуу яриа байсан юм. тэгэхдээ, таны унах үедээ хашхирсныг дуулаад, таныг алагч яс баригчид хүн солигдчихсоныг мэдсэн мэт ярьцгааж байсан юм. Эдмон, би арван жилийн туршид шөнө бүр хүмүүс нэгэн аймшигтай үл мэдэгдэх юм өндөр хадан дээрээс хаяж байна гэж зүүдэлж байсан гэдгээ одоо танаас амийг нь гуйгаад зогсож

байгаа хүүгийнхээ амь насыг барьж тангараглая. Арван жилийн турш зүүдэндээ аймшигтай хашхирахыг дуулан сэрэхэд бие дагжин, хүйт даасан байдаг байлаа. Эдмон, би хэдий буруутай ч гэсэн бас их зовж зүдэрсэн шүү гэж Мерседес гүн уруу гараа сунган хэлэв.

- Аа, та эцгийгээ өөрөөсөө хол үхэж байсныг мэдэрч байсан уу, таныг ангалын ёроолд амьсгаадан хэвтэж байхад хайрт хүүхэн чинь чиний өрсөлдөгчид гараа өгч байгаа байх гэж сэтгэл чинь шаналан зовж байсан уу? гэж Монте-Кристо дуу алдахад, Мерседес түүнийг үгийг тасалж,
- Үгүй, харин миний дурлаж хайрлаж байсан хүн, хүүг минь алах алуурчин болохдоо бэлхэн байгааг харж байна гэж хэллээ.

Мерседес энэ үгийг өгүүлшгүй их уйтгар гунигтай, тун их цөхөрсөн байдалтай хэлсэн тул гүн цохирон уйлчихлаа.

Арслан номхорлоо, өшөө авах хатан зориг зөөлөрлөө.

- Та яалгах гээл байна вэ? Хүүгий чинь амьд үлдээх гэж үү? За яах вэ, тэр үхэхгүй гэж гүн хэллээ.

Тэгэхэд Мерседес баярлан хашхирлаа. Монте-Кристогийн нүдэн дээр хоёр нулимс гарч ирсэн боловч тэр даруй алга болов. Бурхан тэдгээрийг авахуулахаар чигаа тэнгэрээ илгээсэн бололтой, юу гэвэл тэр хоёр дусал нулимс бурханд бол Гузерат ба Офирын хамаг гоё сайхан сувднаас илүү үнэтэй байсан ажээ.

- Баярлалаа чамд, баярлалаа Эдмон! Гэж хүүхэн хэлээд гүнгийн гарын шүүрэн авяч уруулдаа хүргээд, - Чи надад ийм л байдалтай санагддаг байсан, чамайг иймд чинь л би дурладаг байсан юм. Одоо би үүнийг хэлж болно оо гэлээ.
- Тэгэх тусмаа одоо хөөрхий Эдмоныг удаан хайрлахгүй болсон хойно доо. нөгөө ертөнцөөс ирсэн хүнбулшиндаа, буг хий хоосондоо буцаж орох болжээ гэж Монте-Кристо хариу хэллээ.
- Эдмон та юу гээд байна?
- Мерседес та үүнийг хүсэж байгаагаас би үхэх ёстой гэж ярьж байна.
- Үхэх ий? Хэн тэгж хэлж байгаа юм бэ? Хэн үхлийн тухай ярьж байна вэ? Та яагаад үхлийн тухай дахин ярих болов?
- Танай найз нөхөд, таны хүүгийн найз нөхдийн дэргэд, үзэгчдийн танхимд сууж байсан бүх хүний нүдний өмнө илэрхийгээр доромжлогдож, миний уучилсныг мэдэхгүй намайг ялсан мэт бардамнан ярих хүүхдээс тулалдах дуудлага авчихсан хүн би амьд үлдэж болно гэж та бодож байна уу? Би таны дараагаар өөрийгөө, намайг хүмүүсээс дээр тавьсан тэр нэр төрөө, хүч чадлаа хайрлах болсон юм. Энэ хүчинд миний амьдрал байсан юм. Таны ганц үг түүнийг минь эвдэн нураав. Би үхэх ёстой.
- Эдмон та уучилж байгаа хойно энэ тулалдаан болохгүй шүү дээ.
- Хатагтай минь энэ тулалдаан болно. Харин таны хүүги©н цус урсаж, улаан хүрэн өнгөөр газар будах байсан бол миний цус урсах болно.
- Эдмон, тэнгэр дээр бурхан байгаа, та амьд байж_ бЭ таныг дахин харж бөайгаа болохоор би түүнд бүх зүрхнээсээ итгэнинайдаж байна. Би түүний тусламжинд найдаж, таны үгэнд итгэж байна. Эдмон та миний хүүг үхэхгүй гэсэн би? гэж хатагтай хэллээ.
- Тийм ээ, хатагтай!

Өөрийн нь амь насыг Мерседес ийнхүү хааш яаш золиосонд гаргаж байгаа нь Монте-Кристорд гоморхолтой санагдав.

Мерседес гүнгийн гарыг барьж, түүн өөд дүүрэн нулимстай нүдээрээ хараад,

- Элмон та их энэрэнгүй сэтгэлтэй хүн юм! Та өөр дээрээ гоьдлогогүй шахам ирсэн золгүй бүсгүйд сайн сайхан сэтгэл гаргаж өрвөн хайрлалаа! Он жилээс илүүгээр уйтгар гунигаас болж хөгширсөн болохоор, тэр нэгэн цагт миний Эдмоны дурлан хайрлаж байсан тэр Мерседесийнх нь инээмсэглэлийг ч, харцыг нь ч дүрслэн үзүүлж чадахгүй болжээ. Эдмон би бас их зовсон шүү. Сэтгэлд нэг ч баярт үе, зүрхэнд нэг ч найдвар горьдлогогүй явж амьдралыг өнгөрөөнө гэж бодоход ч хэцүү байна. Газар дээрх амьдралаар бүх зүйл гүйцчихгүй. Үүнийг би зүрх сэтгэлдээ амьд байгаа бүхнээр мэдэрч байна. Эдмон тан шиг ингэж уучилна гэдэг бол сайн сайхан, энэрэнгүй хэрэг гэдгийг дахин хэлье! гэв.

- Мерседес та үүнийг хэлж байхдаа миний хүлээж байгаа хохирлын хүндийг мэдэхгүй байна. Хэрэв бүхний дээд бурхан хорвоог бүтээж, эмх замбараа тогтоогоод бидний хорт явдлууд хонсим бодисатын мөнхийн мэлмийн Сэс нулимс гарахад хүрэхээс хамгаалан, бүрэн төгс бүтээгээгүй бол ямар шүү байх сан бол доо? Бурхан бүхнийг гүйцээн бодож, хорвоог нэгэнт бүтээгээд баярлах гэж байснаа гэнэт нараа унтрааж, ертөнцийг мөнхий харанхуйд түлхчихвэл юу болох байсан бэ? Та үүнийг дүрслэн бодвол бүгдийг ойлгоно, үгүй дээ та тэгээд ч миний амьдралаасаа хагацахдаа юу алдаж байгааг ойлгохгүй гэв.

Мерседес гүн өөд гайхах, баярлах зэрэгцэн харлаа.

Монте-Кристо бодол санааны нь хүндэд тэргүүн нь гудайх мэт чичирсэн гараараа толгойгоо тулав.

- Эдмон надад одоо танд хэлэх ганц үг үлдээд байна гэж Мерседес хэлэхэд гүн гашуунаар инээмсэглэлээ.

- Эдмон, миний царай гундаж, нүдний гал унтран, гоо сайхан минь алга болж урьдын Мерседестэй адил юм огт үгүй болсныг та харж байгаа байх. гэвч зүр минь тэр хэвээрээ шүү! ... Баяртай Эдмон, одоо надад тэнгэрээс хүсэн юм юу ч байхгүй... Би таныг урьдынх чинээ сайн санаатай, энэрэнгүй сэтгэлтэй байгааг харлаа. Баяртай Эдмон... Хагацъя даа, таныг бурхан тэтгэж яваг!... гэж хэллээ.

Гэвч гүн хариу юу ч хэлсэнгүй.

Мерседес тасалгааны хаалгыг онгойлгож, гунигт бодлоосоо сэргэж амжихаас өмнө гарч одлоо.

Хатагтай Морсерыг авч одсон сүйх тэрэг Елисейн Талаар түчигнэн явах чимээг сонсоод, Монте-Кристо гүн толгойгоо өндийлгөхөд Тахир дутуучуудын байшингийн цаг нэг болсныг мэдэгдэн цохиж байв.

- Солиотой амьтан би, өшөө хорслоо авахаар шийдвэрлэсэ тэр өдрөө цээжин дотроосоо зүрхээ авч хаях минь яав! Гэж гүн өөртөө хэлэв.

13.ХАЛЗ ТУЛААН

Мерседесийг явсны дараа Монте-Кристогийн байшинг дахин харанхуй нөмөрлөө. Түүний орчин тойронд ч дотор нь ч цөм чимээ аниргүй боллоо. Ядарсан биеийг нойр дарахын адил, түүний хөдөлгөөнт ухаан хөшин зогслоо.

Тэр завсар дэнлүү, лаа уйтгартайгаар шатан дуусаж, үүдний өрөөнд ядарсан зарц хүлээж ядан сууна.

- Ингэж анхааран санаачилга тавьж ийм удаанаар арай ядан барьж байсан барилга эгшин зуурын дотор ганцхан үгнээс болоод нурчих гэнэ ээ! Өөрийгөө бусад хүмүүсээс илүү дээрд үзэж бардамнаж явсан би, Иф цайзын харанхуй шоронд хэвтэж байсан өрөвдмөөр өчүүхэн амьтан би, агуу их хүч чадлыг олчихоод маргааш үхдэл болоо хувирах гэж үү! Би амьдралдаа харамсахгүй байна. Үхэл гэдэг бол бүхний эрмэлздэг амралт, зовон зүдрэгсдийн хүсэн мөрөөддөг зүйл, Фариаг миний өрөөнд орж ирэх хүртэл зовж зүдрэн, өлсөж ядран, хүсэж мөрөөдөн байсан тэр тайван орон юм. Үхэр гэдэг надад юу вэ? Үл ялих илүү тайван, чимээ аниргүй байдал юм. Би амь насаа хайрлахгүй, харин тэгж алгуур аажмаар боловсруулан тэгж нягт нямбайгаар өөдөлж өндийж ирсэн санаа бодлынхоо нуралтад л харамсаж байна. Тэгтэл тэнгэрийн бошиг үүнийг минь няцаалаа. Би түүнд хэрэгтэй вь гэж бодож явсан билээ! Түүний биелэгдэхийг бурхан зөвшөөрсөнгүй байж дээ!

Миний энэ хорвоо ертөнц шиг хүнд, эцэст нь хүргэх гэж Үодсон айхавтар дарамт миний хүсэлд нийцсэнээс биш, хүч чадалд минь нийцээгүй юм байж. Миний санаа зоригт тохирч байснаас биш миний эрх мэдэлд ороогүй зүйл болохоор замын хагаст хаях болж байх шив. Гунихрал зовлонгийн арван дөрвөн жил, найдлага горьдлогын арван жилийг өнгөрүүлсэн би дахин тавиландаа итгэгч болох хэрэг болж байх шив.

Миний үхсэн гэж бодож байсан зүрх зөвхөн царцсан байсан учраас энэ бүгд ийм боллоо. Эмэгтэй хүний дуу сонсоод, сэргэн цээжинд минь цохилсныг би тэсвэрлэж чадаагүйгээс ийм боллоо!

Ийм сайхан сэтгэлтэй эмэгтэй амьдрал чадал нь бүрэн байгаа намайг хайхрахгүй үхэлд хаячих гэж байх ёсгүй тэгэх ёсгүй! Тэр хүүхэн, эхийн хайр чухамдаа эх хүний ухаангшүй сэтгэлээр тийм хол гарчих гэж үү! Буянт үйл хэтрэхээрээ чивэлт явдал болдог ч байдаг. Үгүй, тэр лав чмар нэг вь хийж, бидний хооронд орж зогсч байх, тэр нь энд агуу сайхан харагдаж байсан бол тулалдааны талбар дээр инээдэмтэй хэрэг болно доо хэмээн маргаашийн явдлыг дүрслэн гүн бодлоо.

Тэгээд царай нь бардам сэтгэлийн өнгийг оллоо. _

- Инээдэмтэй юм. Би инээдэмтэй амьтан болно. Би инээдэмтэй болох гэнэ ээ! Үгүй, үхсэн нь дээр.

Мерседесийн хүүгийн амийг үлдээнэ гэж амлаад, өөртөө ямар гай дуудсанаа хамгийн муу муухайгаар бүгдийг бодоод,

- Тэнэг хэрэг, тэнэг хэрэг, энэрэнгүй сайхан сэтгэлтэй хүн болох гээд тэр хүүхдийн гар бууны хөдөлгөөнгүй бай болох гэж дээ! Тэр хүү хэзээ ч би өөрөө өөрийгөө алс н гэдэгт үнэмшихгүй дээ. Би өөрийн зориг хүслээр, хэнээр ч албадуулалгүйгээр, д лайсан гараа зогсоож, бусдад хичнээн

аймшигтай тэр гараараа өөрийгөө алсан юм гэдгийг хүмүүс мэдэх ёстойг, миний нэр төр шаардаж байна. тэгэх хэрэгтэй, тэгэх ч болно гэв.

Тэгээд үзгээ шүүрэн авч бичгийн ширээнийхээ нууц хайрцагнаас Парист ирснийхээ дараа бичсэн гэрээслэлээ гарган ирж хамгийн сэргэлэн биш хүн ч гэсэн түүний үхлийн үнэн учрыг мэдэхээр нэмэлт зүйлийг бичлээ.

- Бурхан минь би үүнийг гээд тэнгэр өөд харж, - Чиний төлөө л өөрийнхөө төлөө ч хийж байна. Би арван жилийн туршид өөрийгөө чиний өшөө хорслоо авах зэвсэг гэж үзэж явсан юм. Морсер, Данглар, Вильфор болон бусад үл бүтэх этгээдүүд азтай тохиолдлоор дайснаасаа аврагдлаа гэдэг санаа бүү төрөг. харин тэд, тэнгэрийн бошигт өшөө авалт миний санаа зоригийн хүчээр зогсоогдсон гэдгийг мэдэж аваг. Энд авахаар зэхэж байсан цээрлүүлэлт нөгөө ертөнцөд тэднийг хүлээж байх болж, зөвхөн цаг хугацаа нь л өөрчлөгдөнө.

Зовлон зүдгүүр нь унтуулахгүй байгаа энэ хүнийг ингэж шаналан байх завсар үүрийн гэгээ цонхоор тусаж, гүнгийн өмнө байгаа дөнгөж саяхан тэнгэрийн бошигийг зөвтгөж бичсэн цайвар хөх цаасыг гэрэлтүүлээ.

Өглөөний таван цаг болж байлаа.

Гэнэт түүнд аяархан гинших дуу сонсогдлоо. Хүн амьсгалах шиг болж ийш тийшээ харвал хэн ч байсангүй. Харин сайхь санаа алдах нь дахин тодхон дуулсан учир эргэлзээ нь үнэн байдал болон хувирав.

Тэгэхд гүн босож зочдын өрөөний хаалгыг онгойлговол зөөлөн сандал дээр Гайде хэвтэж байхыг харлаа. Гар нь сулдайн унижиж, гоо сайхан нүүр нь гэдийжээ. Бүсгүй гүнг өөрийгөө жаиглахгүйгээр гаргахгүйн тул сандлаа үүдэнд нь тулгасан авч, эцэст нь ядран залуу хүний нойронд дарагдан унтжээ.

Монте-Кристог хаалга онгойлгоход охин сэрсэнгүй.

Гүн түүнийг нэгэн үзүүрт сэтгэлээр өрөвдөн, хайрлаж харлаа.

- Тэр өөрийн хүүгийн утхай санасан байхад би өөрийн охины тухай мартжээ! Гэж гүн хэлээд гунигтайгаар толгойгоо сэгсрэв.
- Хөөрхий Гайде минь, надтай уулзаж, ярих гэж хүсжээ. Юу болох гэж байгааг тааварлан мэдэж, миний төлөө айжээ... Би үүнтэй салах ёс гүйцэтгэхгүй, хэн нэгэн хүнд захиж орхилгүй үхэж болохгүй гэж хэллээ.

Тэгээд суудал дээрээ аяархан хүчр ирээд түрүүчийнхээ бичсэн дээр дараах мөрүүдийг нэмэн бичлээ.

“Марселийн хөлөг онгоцны эзэн, манай хуучин эзэн байсан Пьер Моррелийн хүү, морни цэргийн ахмад Максимилиан Моррцльд хорин саяны хөрөнгийг гэрээслэн өвлүүлж байна. Түүнийхээ хагасыг охин дүү Жюли ба хүргэн Эмманюель хоёрт, хэрэв хэт баяжих явдал тэдний аз жаргалд хор хүргэхгүй гэж үзвэл өгөх ёстой. Энэ хорин саяыг Монте-Кристо арал дээрх миний агуйд нуусан бөгөөд тийшээ яаж орохыг Бертуччо мэднэ.

Хэрэв Максимилиан сэтгэлтэй хүнгүй бол, миний бие эцэг нь болон хүмүүжүүлж, намайг энхрий охины ёсоор хайрладаг Янины паш Алийн охин Гайдетай суухыг хүсвэл, миний сүүлчийн санаа зоригийг төдийгүй, миний сүүлчийн хүслийг биелүүлэх болно.

Энэ гэрээс «элээр Гайде миний бусад эд хогшил, хөрөнгө болох газар, Англи, Австри, Голланди улсуудын мөнгөн тэмдэгт, бас ордон, байшин зарц нартаа гэрээслэн үлдээсэн хөрөнгө бүгд жаран сая орчмын хөрөнгийг өйлөн авах болно».

Түүнийг сүүлчийнхээ мөрийг бичиж дуусахад ар талд нь аяархан чимээ гарч, гүн үзгээ алдаж унагалаа.

- Гайде, чи уншчихаа юу?

Залуу боол бүсгүйг зовхин дээр нь туссан үүрийн туяа сэрээжээ. Тэгээд босож, хөнгөн алхаагаараа зөөлөн хивсэн дээргүүр чимээгүй явж гүн дээр очжээ.

- Эзэн минь гээд гараа зөрүүлэн элгэндээ бариад,

- Та яагаад үүнийг ийм цагт бичиж байна вэ? Яагаад надад бүх баялгаа гэрээслэн өвлүүлж байна вэ? намайг орхин явах гэж байгаа юм гэж үү? Хэмээн хэлэхэд Монте-Кристо хязгааргүй өрөвдөж хайрласан царайгаар,

- Хүү минь, би хол газар явлаа. Хэрэв надад ямар нэг явдал тохиолдвол... гэж хэлснээ гүн бодолд оров.

- Тэгвэл яах вэ?... гэж охин хэзээ ч өөрийн эзэнтэй ярьж байгаагүй захирангуй дуугаар хэлэхэд, Монте-Кристо,

- Надад ямар ч юм тохиолдсон миний охин аз жаргалтай байхыг хүснэ гэлээ.

Гайде уйтгартайгаар инээмсэглэж, аяархнаар толгойгоо сэгсрээд,

- Эзэн минь, та үхэх тухай бодож байна уу? гэж асуулаа.

- Охин минь, энэ бол аврагч санаа гэж мэргэн хүн хэлсэн юм.

- Хэрэв та үхвэл өөрийн баялгийг өөр хшнд гэрээслэн үлдээ. Яагаад гэвэл хэрэв таныг үхвэл... надад ямар чбаялаг хэрэггүй болно гэж хэлээд залуу бүсгүй гэрээслэлийг аван урж шалан дээр хаялаа.

Ийнхүү болл бүсгүйн хувьд хэт догшин авирлаад ухаан алдан ойчив.

Монте-Кристо түүнийг гар дээрээ өргөж, царайсан сайран царай, аньсан урт сормуус, хөдлөхгүй арчаагүй байгаа биеийг нь хараад энэ бүсгүй зөвхөн охины хайраар надад хайртай байдаггүй юм биш байгаа гэж анх удаа боджээ.

- магадгүй юм! Би бас аз жаргал амсаж болох байсан байж мэдэх нь ээ! гэж гүн уйтгартайгаар шивгэнэв.

Ухаангүй байгаа Гайдег өрөөнд нь аваачиж үйлчлэгч хүүхнүүдийн нь асрамжинд өглөө. Тэгээд өрөөндөө орж ирээд хаалгаа бушуухан хааж өөр нэгэн гэрээслэл бичжээ.

Түүнийг бичиж гүйцээгүй байтал хашаанд нь хөнгөн тэрэг орж ирэх дуулдлаа. Монте-Кристо цонх уруу очиж Максимилиан, Эмманюель хоёр байхыг харлаа.

- Маш сайн. Би яг цагт нь гүйцээж гэж хэлээд, гэрээслэлээ гурван лацаар битүүмжлэв.

Минутын дараа зочдын өрөөнд хөлийн чимээ гарахыг сонсож хаалгаа онгойлгож өгөхөөр явлаа.

Моррель орж ирлээ.

Тэр тогтоосон цагаас хориод минутын өмнө хүрч иржээ.

- Гүн минь, жаахан эрт ирчихсэн байж магадгүй. Үнэнээ хэлэхэд гэрийнхнийхээ адил бас л унтаж чадсангүй. Би сэтгэлээ тайтгаруулахын тул таны тайван, итгэлтэй байдлыг харах ёстой байлаа гэж хэлэв.

Монте-Кристо энэхүү үнэн сэтгэлийн дотно байдлад сэтгэл нь хөдлөн Максимилианы гарыг атгахын оронд тэврэн авлаа.

- Моррель, өнөөдөр тан шиг ийм хүн надад хайртай сайн байгааг мэрсэн учир надад их сайхан өдөр б@лж байна. Сайн байна уу? ЭмманюГль гэснээ – Максимилиан та надтай хамт явах уу? гэлээ.
- Тэгэлгүй яах вэ. Та үүнд эргэлзээ гэж үү?
- Аа хэрвээ миний буруу байсан бол...
- Би өчигдрийн бүх явдлыг харсан. Би бүх л шөнийн турш таны биеэ барьж чаддагийг гайхан бодлоо. Тэгээд би хүний царайлд итгэж болдог бол үнэн мөн нь таны талд байна гэж өөртөө хэлсэн.
- Альбер таны найз шүү дээ.
- Зүгээр л танил хүн.
- Та надтай танилцдаг тэр өдөр л түүнтэй танилцсан байх аа?
- Тийм ээ, үнэн. Хэрэв таныг энэ тухай сануулан хэлээгүй бол би санахгүй нь байна шүү.
- Баярлалаа Моррель.

Тэгээд гүн нэг удаа хонхоо цохилоо. Тэр дор нь орж ирсэн Алид

- Үүнийг миний нотариуст хүргэж өг гэж тушаа. Энэ бол миний гэрээс байгаа юм. Моррель, намайг үхсэний дараа та үүнтэй танилцаарай гэв.
- Таны үхсэний дараа гэнэ ээ? Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж Моррель асуув.
- Юм бүхнийг урдаас харах хэрэгтэй. Найз минь. харин өчигдөр орой салаад та юу хийв.
- Би Тортони уруу очсон. Миний бодсоноор Бошан, Шато-Рено хоёрыг олж уулзлаа. Би тэднийг эрсэн гэдэг үнэнээ хэлье.
- Бүх зүйлийг ярилцаж тохирсон хойноо яах гэсэн юм бэ?
- Гүн минь халз тулаан гэдэг зайлшгүй, ноцтой юм л даа.
- Та түүнд эргэлзэж байсан юм гэж үү?
- Үгүй. Олны өмнө доромжилсон, одоо хүн бүр энэ тухай л ярьж байна.
- Тэгээд яагаа вэ?
- Би тэднийг зэвсгээ өөрчилж, гар буугаа сэлмээр сольё гэж ятгах гэсэн юм. Сум гэдэг сохор шүү дээ.
- Тэгээд та амжЕв уу? гэж үл мэдэг найдлагын оч гялсхийсэн Монте-Кристо асуулаа.
- Үгүй, таны илдСнд гарамгайг хүн бүхэн мэдэх учраас болсонгүй.
- Уухай! Хэн намайг хэлчхээ юм бол?
- Таны дийлсэн сэлэмний сургуулийн багш нар.
- Та тэгээд амжилт олсонгүй юу?
- Тэд эрс татгалзаж байна билээ.
- Моррель та намайг гар буугаар буудахыг ер нь харсан уу? гэж гүн асуулаа.
- Хэзээ ч үгүй.
- Тэгвэл хар л даа, бидэнд цаг байна гэж хэлээд Мерседесийг орж ирэхэд гартаа барьж байсан буугаа авч самбар дээр хөзрийн тамга наагаад дөрөв

буудаж гурван сумаар нь гурван салаа навч, дөрөв дэх сумаар нь ишийг хийлээ.

Гүнгийн буудах бүрд Моррелийн царай улам улам царайна.

Монте-Кристо гүнгийн хийсэн энэ гайхамшигийг сонирхвол томхон үрлээс томгүй сумны нүх байлаа.

- Эмманюель, энүүнийг хараач, ямар аймшигтай юэ! Гэж хэллээ. Дараа нь Монте-Кристо өөд эргэж,
- Гүн минь та, ариун гэгээн бүхнийг бодож Альберыг бүү алаач! Золгүй хүүд эх бий шүү дээ! гэж хэллээ.
- Тэр үнэн, харин надад эх байхгүй гэж Монте-Кристо хэллээ.

Гүн үүнийг Моррелийг дагжин чичрэхэд хүрсэн өнгөөр хэллээ.

- Та доромжлогдсон шүү дээ.
- Мэдээж тэгсэн. Та юу гэж хэлэх гэж байгаа юм бэ?
- Энэ бол та түрүүлж буудна гэсэн үг.

-Би түрүүлж буудах уу?

- Тийм ээ, би энэ амжилтыг олсон, үнэндээ шаардсан юм. Бид тэдэнд хангалттай буулт хийж өгсөн болохоор тэд үүнийг аргагүй зөвшөөрөх болсон.

- Аа, зай нь?
- Харин алхам.

Гүнгийн уруул дээр аймшигтай инээмсэглэл т®дорлоо._

- Моррель сая юу үзсэнээ бүү мартаарай гэж гүн хэллээ.
- Би зөвхөн таны сэтгэл догдолбол Альбер аврагдаж магадгүй гэж найдаж байна.
- Миний сэтгэл догдлох ий? гэж Монте-Кристо асуулаа.
- Өөрөөр хэлыэл таны энэрэнгүй сэтгэл, найз минь. Би таны алдалгүй бууддагийг мэдсэн учир өөр хүнд хэлбэл инээдтэй болох нэг юм хэлье.
- Тухайлбал юу вэ?
- Түүний гар ч юм уу өөр нэг газар нь оноорой. Харин бүү алаарай.
- Моррель та, надад Морсерыг хайрлах тухай ятгаад байх хэрэггүй. Морсер нөхөдтэйгээ хамт гэр өөдөө тайван буцахаар тэгж хайрлагдан өршөөгдсөн. харин би...
- Харин яа яах гэж?
- Энэ бол өөр хэрэг. Намайг дамнуургаар авя явах болно.
- Гүн та юу ярина вэ? гэж Максимилиан айсандаа дуу алдлаа.
- Хайрт Моррель минь Морсер намайг ална.

Моррель гүн өөд гайхсан янзтай харав.

- Гүн минь, урд шөнө юу болоо вэ?
- Филиппийн тулалдааны өмнө Брутэд тохиолдсон явдал шиг юм боллоо. Би урд шөнө хий үзэгдэл үзлээ.
- Тэгээд?..
- Тэгээд тэр хий үзэгдэл чи энэ ертөнц дээр амьдарч гүйцэлээ гэж хэлсэн.

Максимилиан Эмманюель хоёр бие бие өөдөө харлаа. Монте-Кристо цагаа гаргаж ирээд,

- Явцгаая. Долоон цагаас таван минут өнгөрч байна. халз тулаан яг найман цагт шүү дээ гэж хэллээ.

Монте-Кристо гудмаар явж байгаад нэгэн өрөөний үүдэнд очиж зогсоход заруу биш байдал гаргахгүйн тулд Максимилиан Эмманюель хоёр урагшаа түрүүлэн холдоход цурхиран уйлах ха^оиуд нь санаа алдах чимээ сонсдох шиг болов.

Сүйх тэрэг үүдэнд хүлээж байв. Монте-Кристо гэрч нарыхаа хамт тэргэнд суулаа.

Тэя яг найман цагт болзсон газраа очсон байв.

- За бид ч хүрээд ирлээ, тэгэхдээ түрүүлж ирсэн байна шүү гэж Моррелийн хэлэхэд эзнээ дагаж ирсэн Батистен,
- Уучлаарай, эрхэм минь, тэнд модны доор сүйх тэрэг зогсож байх шиг байна гэв.

Монте-Кристо сүйх тэрэгнээсээ хөнгөхөн гэгчийн үсэрч буугаад Максимилиан Эмманюель хочр туслан гараа өглөө.

Максимилиан гүнгийн гарыг өөрийнхөө гарт барьсаар байв.

- Өөрийнхөө үнэнийг ухааран мэдэж, амь насаараа бай болж зогсож байгаа хүн л ийм гартай байдаг байх ёстой гэж тиэр хэллээ.
- Нээрээ тэнд, залуу хүмүүс нааш цааш явж, хүн хүлээж байгаа юм шиг байна гэж Эмманюель хэллээ.

Монте-Кристо Моррелийг хажуу тийш нь хэдэн алхам аваачлаа.

- Максимилиан чиний зүрх чөлөөтэй юү гэж асуухад Моррель гайхан Монте-Кристо өөд харлаа.
- Би таныг хамаг байдгаа тоочихыг хүсээгүй, зөвхөн л асууж байгаа юм. Та надад тийм, үгүй гээд л хариулаарай. Зөвхөн үүнийг л танаас асууя.
- Гүн минь би хүнд сэтгэлтэй.
- Их үү?
- Амь наснаасаа ч илүү.
- Итгэл найдвар минь бас нэг зүйлээр багаслаа. Хөөрхий Гайде минь гэж хэлээд Монте-Кристо санаа алдав.
- Хэрэв би таныг муу мэддэг байсан бол халирамхай сэтгэлтэй хүн юм гэж хэлмээр байна шүү гэж Моррцль дуу алдлаа.
- Яагаад тэр вэ? Яагаад гэвэл би хайрбай бүхнээсээ салахдаа санаа алдаж байна гэж үү? Моррель та цэрэг явсан хүн, тэгэхлээр эрэлхэг зориг гэж юу Үайдгийг сайн мэдэх ёстой. Би амиа хайрлаж байна гэж үү? Амьдрал үхэл хоёрны хооронд хориод жилээ өнгөрөөчихсөн надад үхэх амьдрах хоёр огт ялгаагүй юм биш үү. Гэвч Моррель та бүү зов. Хэрэв энэ явдал миний сул дорой тал мэт харагдаж байгаа бол ганцхан та л үүнийг харж байна. Ертөнц гэдэг бол бүхэнтэй ёсорхог сайхнаар салыхн ёс гүйцэтгээд хөзрийнхөө өрийг төлчхөөд явж чаддаг байх ёстой гэдгийг би мэдэж байна.
- Бурхан минь, энэ чинь л мэргэн хэлсэн үг байна. Үгүй ат буугаа авчирсан уу? гэж Моррель асуув.
- Би юу? Яах юм бэ? Тэр эрхмүүд буу авчирсан байх гэж найдаж байна.
- Очиж мэдье.
- За сайн, харин ямар ч хэлэлцээ яриа хэрэггүй шүү.

- Санаа бүү зовоорой.

Моррель, Бошан, шато-Рено хоёр өөд очлоо. Цаадуул нь Моррелийг ирж явааг хараад өөдөөс нь хэд алхлаа.

Залуу хүмүүс бие биедээ найрсаг ч биш гэсэн ёсорхгоор мэхийн ёсолцгоов.

- Уучлаарай эрхмүүд ээ, Морсер үзэгдэхгүй байх чинь вэ гэж Моррелийн хэлэхэд Шато-Рено,
- Өнөө өглөө л, тэр биднийг тулалдах газраа уулзъя гэж хэлүүлсэн байна билээ гэв.
- Аа тийм бий гэж Моррель хэллээ.

Бошан цагаа харлаа. Тэгээд,

- Найман цагаас таван минут өнгөрч байна. Бас ч оройтоогүй байна шүү, эрхэм Моррель гэж хэллээ.
- Би ерөөсөө ч үүнийг асуугаагүй юм гэж Моррель зөрж эхлэв.
- Аа, тэр сүйх тэрэг гараад ирлээ гэж Шато-Рено хэлтэв тэдний зогсож байсан модот гудамжны уулзвар дээр сүйх тэрэг давхин гарч ирлээ. Эрхмүүд ээ, та нар буугаа авчирсан биз? Монте-Кристо гүн өөрийнхийгөө хэрэглэхээс татгалзаж байна гэж надад хэлсэн билээ гэж Моррель хэлэв.
- Бид үүнийг урьдаас бодсон юм. Би хэрэг болж магадгүй гэж бодоод долоо хоногийн өмнө худалдан авсан гар буугаа авч ирсэн. Тэр буунууд маань цоо шинэ, нэг ч удаа хэрэглээгүй байгаа юм. Та тэдгээрийг үзэх үү? Гэж Бошан хариуллаа.
- Тэр буугаар Морсер буудаж дасгал хийгээгүй гэж та хэлж байгаа хойно, таны энэ үг л надад хангалттай боллоо гэж Моррель мэхийн ёсолж хариуллаа.
- Эрхмүүд ээ, энэ чинь Морсер огт биш байна. хараач! гэж шато-Рено хэлэв.

Нээрээ ч Франц, дебрэ хоёр тэдэн өөд ирж явлаа.

Шато-Рено тэдний гарыг барьж,

- Эрхмүүд ээ та хоёр яагаад энд хүрээд ирэв? Гэж хэллээ.
- Өнөө өглөө Альбер биднийг тулалдах газраа ирэхийг хүссэн юм гэж Дебрэ хэллээ.

Бошан, Шато-Рено хоёр гайхан өөд өөдөөсөө харлаа.

- Эрхмүүд ээ, ямар учиртай болохыг нь би ойлгох шиг боллоо гэж Моррель хэлэв.
- Тэгвэл хэлээч дээ.
- Би өчигдөр өдөр Морсерээс орой Операд очихыг хүссэн захидал хүлээн авсан.
- Би бас гэж Дебрэ хэллээ.
- Би бас гэж Франц хэллээ.
- Бид хоёр ч бас гэж Шато-Рено Бошан хоёр хэллээ.
- Тэр өдөлт дээрээ та нарыг байлгахыг хүссэн юм байж л дээ. Одоо бас тулалдахдаа байлгая гэж бодож л дээ гэж Моррель хэллээ.
- Нээрэн тийм, эрхэм Моррель та таачих шиг боллоо гэж залуу хүмүүс хэллээ.

- Гэсэн хэдий боловч Альбер өөрөө ирэхгүй байна. Одоо арван минут хожимдоод байна гэж Шато-Рено амандаа үглэв.
- Өө, тэр гараад ирлээ. Морьтой ирж явна. Хар хурдаараа давхиж явна. Бас зарцаа дагуулчхаж гэж Бошан хэлэхэд Шато-Рено,
- Бууцалдах гэж байхад морьтой давхиж ирдэг чинв ямар болгоомжгүй юм бэ! Би хичнээн захиж хэлсэн гээч! Гэв.
- Түүнээс гадна зангиа зүүж, цагаан хантааз өмсөж, цамцныхаа энгэрийг задгай тавьжээ. Гэдсэн дээрээ байны дугараг тэмдэг зурчихгүй яагаа юм бол, тэгвэл түргэн, амар байхгүй юу! гэж Бошан хэлэв.

Тэгтэл Альбер тэдний дэргэд арваадхан алхмын зайтай хүрч ирээд мориныхоо амыг татан үсрэн буугаад цулбуураа зарц өөд шидчихлээ.

Түүний царай цонхигор бөгөөд зовхи нь улайж, хавджээ. Шөнөжингөө унтаагүй нь илэрхий байв.

Царай нь урьд өмнөхөөсөө шал өөр, уйтгар гунигтай төв харагдана.

- Эрхмүүд ээ, миний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн явдалд баярлалаа. Энэ нөхөрсөг анхаарал тавьсанд чинь их баярлаж байна гэж хэллээ.

Моррель тэднээс хөндий зогсож байлаа. Морсерыг ирмэгц тэр холдсон юм байжээ.

- Эрхэм Моррель танд ч бас, Та наашаа зогсохгүй юу, та энд гадны хүн биш гэж Альбер хэлэв.
- Эрхэм та, намайг Монте-Кристо гүнгийн гэрч гэдгийг мэдэхгүй байж болох юи шүү гэж Максимилиан хэллээ.
- Би рэгж бодсон юм .Тэгэх тусмаа сайн! Сайн сайхан хүмүүс энд олон байх тусмаа надад сайхан байна.
- Эрхэм Моррель та одоо эрхэм Морсерыг ирсэн гэж Монте-Кристо гүнд хэлээд, бид түүний мэдэлд байна гэж мэдэгдэнэ үү гэж Шато-Рено мэллээ.

Моррель энэ даалгаврыг биелүүлэхээр эргэв.

Бошан энэ завсар гар буутай хайрцгийг сүйх тэргэн дотроос гаргав.

- Байзаарай эрхмүүд ээ, надад Монте-Кристо гүнд хэлэх хоёр үг байна гэж Альбер хэлэхэд, Моррель,
- Хоёулхнаа юу? гэж асуув.
- Үгүй, биүгдийн чинь дэргэд гэв.

Альбзын гэрч нар гайхан бие бие өөдөө харцгаалаа. Франц Дебрэ хоёр хоорондоо шивнэлдэв. Харин ингэж саатсан явдалд баярласан Моррель модот гудамжаар Эмманюельтэй хамт алхлан яваа Монте-Кристо гүн дээр очлоо.

- Тэр надаар яах гэсэн юм бэ? гэж Монте-Кристо асуув.
- Үнэндээ мэлдэхгүй, тантай ярих гэсэн юм байх.
- Бас дахин дромж муу үг ярьж бурхан тэнгэрийг хилэгнүүлээгүй нь дээр! Гэж Монте-Кристо хэллээ.
- Түүнд тийм бодол байхгүй байх гэж бодож байна гэж Моррцль зөрж хэллээ.

Гүн Максимилиан, Эмманюель хоёрыг дагуулан Альбер дээр очлоо. Түүний тайван тунгалаг царай нь нөхдүүдээ дагуулан өөдөөс нь тосож ирсэн Альберийн догдолсон царайнаас тэс өөр харагдаж байлаа.

Альбер, гүн хоёр бие биеэсээ гурван алхмын зайтай зогслоо.

- Эрхмүүд ээ, нааша ойртоцгоо. Монте-Кристо гүнд миний хэлэх үгнээс нэг нь ч дуулдалгүй өнгөрөхийг би хүсэхгүй байна. Учир нь миний аз болж гүнд хэлэх гэж байгаа эн үг та нарт хачин санагдавч, хүссэн хнү бүгдэд та бүхэн давтан хэлж өгөх ёстой гэж Альбер хэлэхэд, Монте-Кристо,
- Би таны хэлэх үгийг сонсьё гэв.
- Гүн гэж Альбер эхлэн хэлэхдээ хоолой нь чичирч байснаа сүүл сүүлдээ намдсаар – Эрхэм яе Морсерын Эпирт байхдаа үйлдсэ явдлыг, тэр хэдийгээр буруутай ч байлаа гэсэн таныг рэгж цээрлүүлэх эрхгүй хэмээн үзэж би таныг буруутан болгож байв. Харин би одоо тэгэх эрхтэй болохыг чинь мэдлээ. Фернан Мондего, Али пашийн өмнө хийсэн урвалт таныг миний нүдний өмнө зөвтгөж байгаа биш, харин загасчин Фернан таны өмнө хийж, түүний үр уршгаар урьд өмнө дуулдаагүй гашуун зовлон амссан чинь таныг миний өмнө зөвтгөж байна. Тийм учраас би танд, бүхнээ дуудахаар та бол түүнээс өшөөгөө авах эрхтэй байсан юм гэж илэрхийлэн хэлээд, хүү нь болсон би таныг түүнээсээ илүү юм хийгээгүйд чинь баярлалаа гэв.

Энэ явдлыг харсан хүмүүсийн дунд аянга цахилгаан буусан ч гэсэн Альберын энэ мэдэгдсэн зүйлээс илүү цочин гайхуулахгүй байсан биз.

Монте-Кристо нүдээ өргөн тэнгэр өөд харахад, хязгааргүй талархсан байдал илэрхий байв. Ромын дээрэмчдийн дунд тийм их зоригтой байсан хурц түргэн зантай Альбер яагаад гэнэт ийм доромж байдалд орсныг нь гайхаад барахгүй байлаа. Тэгээд Мерседесийн нөлөөг ойлгон, яагаад өөрийг нь хохироох болж байхад эсэргүүцэлгүй гараад явсны учрыг мэдэв.

- Эрхэм дээдэс , та миний энэ хэлсэн уучлалтыг хангалттай гэж үзвэл гараа барьчихъя гэж Альбер хэлээд, - тан лугаа адил осол бурууг үл үйлдэх ховор сайхан чанарын дараад, гэм буруугаа хүлээж чаддаг байхыг би бас эрхэм дээд ч нар гэж үздэг билээ. Ийнхүү гэмээ хүлээн уучлалт гуйж байгаа явдал бол миний хувийн хэрэгээ. Хүн төрөлхтөний жам ёсны үүднээс бол би зөв ажил хийсэн, харин та бол бурхны санаа зоригоор тэгж байгаа хүн. зөвхөн чигаа тэнгэр л та бил хоёрын гэгийг үхлээс аврах байсан юм. Энэ тэнгэр та бид хоёрыг найз нөхөд биш, энэ бол бололцоогүй хэрэг, харин бие биеэ хүндэтгэдэг хүмүүс болгох гэж газарт бууж иржээ гэв.

Монте-Кристогийн нүдэнд нулимс гүйлгэнэн, хүндээ амьсгаа авч Альберт гараа өгөхөд цаадах нь бараг л бишрэх байртай асар их хүндэтгэн гарыг нь барилаа.

- Эрхмүүд ээ, Монте-Кристо уучлалт гуйсныг минь хүлээн авч байна. Яаруу хөнгөн гэдэг бол муу зөвлөгч юм. Би тэнэг хэрэг хийжээ. Би одоо гэм буруугаа арилгалаа. Хүнч стэгэлээрээ удирдлага болгон ингэсэн явдалд хүмүүс намайг аймхай хулчгар гэж бүү үзэг. Гэвч миний энэ явдлыг буруугаар ойлгохол хүртэл гэснээ өөрийн нөхөд болон бусдыг ч өдөн дуудах мэт бардам омогтойгоор толгойгоо дээш өргөөд – Миний тухай тэдний бодлыг өөрчлөхийг хичээнэ гэлээ.
- Урьд шөнө юу болоо бол? Энд бид тийм атаархмааргүй үүрэгтэй байх шив гэж Бошан Шато-Ренод хэллээ.
- Альбзрийн хийж байгаа нь нэг бол маш муухай хэрэг, нэг бол тун сайн сайхан хэрэг гэж түшээ гүн хариуллаа.

- Энэ бүгд юу гэсэн үг вэ? гэж Дебрэ Францаас асуугаад – Монте-Кристо гүн Морсерын нэр төрийг гутаасан байхад хүү нь зөв гэж үзэж байна аа! хэрэв миний гэр бүлд арван Янина байсан ч гэлээ би зөвхөн арван удаа тулалдана гэдгийг л мэдэх байсан гэж хэлэв.

Монте-Кристо гүн хорин дөрвөн жилийн хүнд дуртгалд дарагдан толгойгоо гудайлган, гараа унжуулан когсохдоо, Альбер, Бошан, Шато-Рено, ер нь тэнд байсан хүмүүсийн хэний ч тухай бодсонгүй. харин хүүгийнхээ амь насыг гуйж ирсэн тэр зоригт хүүхний тухай, түүнд гүн өөрийн амийг оронд нь өгсөн тухай, бас гүнгийн амийг аврах гэж энэ залуу хүүгийн эцгээ гэдэг сэтгэлийг, магадгүй үүрд үгүй хийсэн гэр бүлийг тэр аймшигт нууцыг задалсан тухай бодож байлаа.

- Бас дахин дээрхийн тавилангаар боллоо. Би одоо намайг бурхан явуулжээ гэдэгт бүрэн итгэлээ гэж тэрээр шивгэнэв.

14.ЭХ ХҮҮ ХОЁР

Монте-Кристо гунигтай атлаа аятайхнаар инээмсэглээд залуу хүмүүстэй салах ёс гүйцэтгээд Максимилиан Эмманюель хоёрын хамт сүйх тэргэндээ суулаа.

Альб, Бошан, шато-Рено гурвуулхнаа тулалдааны талбарт үлдлээ.

Альбер гэрч нар өөдөө айж зовсон биш ч гэхнээ болсон явдлын тухай тэдний саналыг асуусан мэт харцаар харлаа.

- Баяр хүргэе, хүндэт найз минь! Эвгүй явдлын санамсаргүй тайлал боллоо гэж бусдаасаа илүү түргэн зантайгаасаа ч юм уу эсвэл зусардах гэдгийг мэддэггүйгээсээ болоод Гошан эхэлж дуугарав.

Альбер юу ч хариулсангүй.

Шато-Рено гулжганасан таягаар гутлаа тогшиж байснаа,

- Явах юм биш үү! Гэж чимээ аниргүй байдлыг эвдэн дуугарав.
- Дураараа л бол. Харин гайхан бахархаж байгаагаа Альберт хэлэхийг зөвшөөрнө үү. Энэ хүн өнөөдөр манай үед маш ховор баатар хүний энэрэнгүй сэтгэл гаргалаа! Гэж Бошан хэлэв.
- Тийм ээ гэж Шато-Рено хэллээ.
- Ийм биеэ барьж чадах чадварыг гайхан бишрэхээс өөр аргагүй гэж Бошан үргэлжлүүлэн хэллээ.
- Эргэлзэх юм алга. Би л бол ямар чбайсан ингэж чадахгүй дээ гэж Шато-Рено шулуухан хүйтэн байдлаар хэллээ.
- Эрхмүүд ээ, та нар Монте-Кристо гүн бид хоёрын хооронд ердийн биш юм болсныг ойлгоогүй өайна... гэж Альбер тэдний үгийг таслан хэлэхэд,
- Үгүй, үгүй харин ойлгож байна. гэхдээ манай чалчаа саарлууд таны Энэ баатарлаг явдлыг үнэлж чадах болов уу даа. Та эрт орой алин боловч тэдэнд тайлбар тавих л болно. гэхдээ таны эрүүл мэндэд хортойгоор ч байж магадгүй шүү. Танд нөхөрсөг зөвлөгөө өгөх үү? Неаполь, Гааг эсвэл Санкт-Петербург уруу яв. Тэнд чинь нэр төрийн хэргийг манай энэ Парисаас илүү ухаалгаар харж үздэг тайван газар байгаа юм. Тэнд сэлэм буудлагын сургуулийг илүү хичээнгүй хий. Хэдэх жилийн дараа таныг бүр мартана, эсвэл атны цэргийн урлагт гарамгай болсон чинь Парист дуулдана. Тэгэхээр нь Францад тайван буцаад ирэхгүй юу? Шато-Рено та надтай санал нийлж байна уу? гэж Бошан хэлэхэд,

- Таны саналыг бүрэн зөвшөөрч байна. Болоогүй ирүүл тулааны дараа илүү ноцтой тулаан болдог шүү дээ Жэж түшээ гүн хариуллаа.
- Эрхмүүд ээ, би та нарт баярлалаа гэж Альбер хүйтнээр хэлээд –Би хаашдаа Францыг орхиж явахаар шийдвэрлэсэн болохоор тан нарын зөвлөгөөг хүлээж авлаа. Та нарыг миний гэрч болохыг зөвшөөрсөн явдалд баярлалаа. Би та нарын үгийг сонсож байгаа хэрнээ энэ үзүүлсэн туслалцааг чинь ч санаж байна гэдгийг өөрсдөө бод л доо гэв.

Шато-Рено, Бошан хоёр өөд өөдөөсөө харлаа. Альбзын хэлсэн үг, тэр хоёрт адилхан сэтгэгдэл төрүүлж, хэрэв энэ яриа үргэлжилсэн бол хэн хэнийг нь эвгүй байдалд оруулахаар тийм шийдмийг дуугаар сайхь талархсан үгээ хэлжээ.

- Баяртай Альбер гэж Бошан яаран хэлээд гараа түүнд хааш яаш сунгахад Альбер гүнээ бодлогоширсон байдалтай байв. Юу ч л гэсэн тэр сунгасан гарыг нь харснаа юугаар ч мэдэгдсэнгүй.
- Баяртай гэж шато-Рено бас хэлээд, таягаа зүүн гартаа барьж, баруун гараараа салах ёс гүйцэтгэн дохилоо.

Хоёр гэрчээ явсны дараа хэсэг зуур хөдлөлгүй зогслоо. Дараа нь огцом хөдөлгөөнөөр соринхоо цулбуурыг уяатай байсан модноос нь тайлж аваад эмээл дээрээ хөнгөхнөөр мордон Парисын зүг давхилаа. Арван таван минутын дараа Эльдер гудамжинд дахь шилтгээндээ орлоо.

Яаран орж явтал нь цонхны нь хөшигний цаана Морсер гүнгийн цонхигор цАрай харагдах шиг санагджээ. Тэгэхэд нь санаа алдан эргээд, өөрийн байшин уриу явав. Босгон дээрээсээ, хар багаасаа эхлэн эдэлж явсан энэхүү баян тансаг бүхнийг эцсийн удаа зэрвэсхэн харав. Эцсийн удаа зурагнуудаа ч харлаа. Зураг дээрх хүний цуарай түүнд инээх шиг ч, байгаль нь амьд юм шиг харагдана.

Дараа нь ээжийнхээ зургийг цаср модон жаазнаас нь салган авч хуйлаад, алтадмал жаазыг хоосон орхилоо.

Үүний дараа өөрийн сайхан түрэг сэлмүүд, англи зэвсгүүд, япон шаазан хэрэглэл, мөнгөлсөн аяга, Фетер Барин хоёрын гарын үсэгтэй уран сайхан хүрэл барималаа эмхэлж цэгцлэв. Ширээнийхээ нүдийг онгойлгож, орхиод хармааныхаа мөнгө, элдэв бусын хэрэгтэй хэрэггүй үнэт эдлэлүүдийг хийж, эд бүгдийн жагсаалтыг тодорхой хийж, саад тээр болсон номнуудыг ширээн дээрээс зайлуулаад нүдэнд харагдах газар тавив.

Энэ ажлын эхэнд хиа нь орохыг хориглосон боловч тасалгаанд орж ирлээ.

- Танд юу хэрэгтэй вэе гэж ууртайгаасаа уйтгартай нь аргагүй асуухад
- Эрхэм та уучлаарай. Хэдийгээр танд яршиг төвөг удахыг хориглосон боловч Морсер гүн, намайг дуудаад байна гэв.
- Тэгээд яагаа вэ? гэж Альбер асуулаа.
- Би таны зөвшөөрөлгүйгээр гүн дээр очиж зүрхэлсэнгүй.
- Яагаад тэр вэ?
- Яагаад гэвэл намайг таныг дагаж халз тулааны газар очсоныг мэдсэн байж таарна.
- Магадгүй гэж Альбер хэлэв.
- Тэр лав тэнд юу болсон тухай мэдэх гэж намайг дуудсан байх. Түүнд юу гэж хариул хэмээн тушаах сан бол?
- Үнэнийг хэл.

- Тулалдаагүй гэж хэлэх хэрэгтэй юм шив дээ?
- Намайг Монте-Кристо гүнгийн өмнө буруугаа хүлээсэн гэж хэлээрэй. За яв.

Хиа нь мэхийн ёслоод гарч одлоо.

Альбер дахин жагсаалтаа бичиж эхлэв.

Ажлаа хийж дуусаад байтал хашаан дотор морьдын туурай тэрэгний дугуйн чимээ дуулдаж цонхны шил доргиуллаа. Цонх уруугаа очиж харвал эцэг нь тэргэнд суугаад яваад өгөв.

Шилтгээний хаалга гүнгийн араас хаагдж амжаагүй байхад Альбер ээжийнхээ өрөө уруу явлаа. Тэнд чоод ирснээ хэлүүлэх хүн байхгүй болохоор шууд ээжийнхээ унтлагын өрөөнд орж босгон дээр нь гайхан зогслоо.

Эх хүү хоёр нэгэн санаатай юм шиг, Мерседес мөн л Альберын хийж байгаад ирсэн тэр зүйлийг хийж байлаа.

Бүх юмаа бэлтгэжээ. Үнэт зүйлүүд, алтан эдлэл, хувцас хунар, мөнгө цаасаа шүүгээнүүдэд тараан хийж түгжиж байв.

Альбер энэ бэлтгэлийг харлаа. Тэр бүх зүйлийг ойлгон “Ээж ээ” гэж дуу алдаад Мерседесийн хүзүүгээр тэврэн авав.

Энэ үед эдний байдлыг зураач хүн дүрслэн зурвал маш сайхан зураг бүтээх биз.

Альбер зоригтой алхамд бэлтгэхдээ өөрийн төлөө айгаагүй боловч, эхийнхээ энэ бэлтгэлийг хараад айжээ.

- Та юу хийж байгаа юм бэ? гэж Альбер асуухад,
- Аа чи юу хийсэн бэ? гэж өөдөөс нь асуув.
- Би бол өөр хэрэг гэж Альбер амьсгаадан хэлээд, - Намайг энэ байшинг орхиод явах гэж байхад та бас ингэж шийдэж бодохгүй ... Би тантай салах ёс гүйцэтгэх гэж ирсэн юм гэлээ.
- Альбер, би ч бас адилхан явлаа. Миний хүү намайг дагана гэж бодож байсан чинь буруу болж, би ташаарлаа гэж үү?
- Ээж ээ, надад тохиолдох тэр хувь зохиолыг тантай хуваалцаж чадахгүй. Одоо надад гэрч байхгүй, мөнгө ч байхгүй болсон. Хэцүү хүнд амьдралтай болж таарна. Би одоохондоо, өөрөө өөртөө зүсэм талд олдог болох хүртлээ найз нарынхаа гэнээс тусламж авах болно. Тийм учраас би одоо Франц дээр очиж надад хэрэг болох цөөн мөнгөөр санхүүжүүлээч гэж гуйхаар явна гэж Альбер эрс хэллээ.
- Хөөрхий хүү минь! Чи өлсөж гуйлгачин болох гэж үү? Чи ингэж бүү ярь. Чи намайг шийдвэрээсээ буцахад хүргэж байна! гэж Мерседес дуу алдан хэллээ.
- Гэхдээ би өөрийнхөөсөө буцахгүй. Би залуу, хүч чадалтай, бас ч зоригтой гэж найдаж байна. Би өчигдөр хатуу зориг гэж юу байдгийг мэдсэн. Хэмжээ хязгааргүй зовж зүдэрсэн мөртлөө үхээгүй, харин тэнгэр илгээж байсан өчүүхэн найдвар горьдлогынхоо балгас дээр өөртөө шинэ амьдрал барьж байгуулсан хүмүүс байна. Би ийм хүмүүсийг мэдлээ, би тийм хүсмүүсийг үзлээ, ээж минь. Дайсан тэднийг ёроолгүй гүнд хаячхад тэд асар их хүч чадал, алдар цуутай болон босож ирж дайснуудыгаа ялаад, ёроолгүй харанхуйд өөрсдийг нь хаяж байгааг би мэдлээ. Одоо би

хууцнаасаа салж, өнгөрсөн үеэсээ юу ч авахгүй тэр ч байтугай нэрээ ч авахгүй. Ээж минь би хүмүүсийн царай улайх тэр нэрийг зүүж явж чадахгүй гэдгийг ойлгооч гэж Альбер хэлэв.

- Альбер хүү минь би үүнээсээ илүү сэтгэлийн зоригтойсон бол өөрөө чамд ийм зөвлөгөө өгөх байсан юм. Миний тамиргүй сулхан дуу дуугарч чадсангүй, харин чиний хүнч сэтгэл эхлэн дуугарлаа. Альбер минь, хүнч сэтгэлийнхСэ дуу хоолойг л сонс. Чамд найз нөхөд байсан, тэднээсээ холбоогоо нэг хэсэгтээ тасал. Харин эхийнхээ нэрийг бодоод бүү гунихар! Чиний насан дээр амьдрал улам ч сайхан, чам шиг ийм ариун сайхан сэтгэлтэй хүнд хар толбо суугаагүй нэр хэрэгтэй. Тэгэхээр чи миний эцгийн нэрийг ав. Түүнийг Эррера гэдэг байсан юм. Альбер минь би чамайг мэднэ. Чи ямар ч мю сонгож авлаа гэсэн удахгүй энэ нэрээр алдарших болно. Тэр цагт хүү минь Паристаа эргэж ир. Энэ зовж зүдэрсэн чинь чамайг улам өөд татаж өргөн явна. Хэрэв энэ бүгд миний хүсэл мөрөөдлөөс зөрвөл үгүй ядахдаа ийм найдвар надад үлдлээ. Би ингэж бодоод л амьд явах болно. Эс тэгвэл энэ байшингийн босгоны цаанаас миний үхэл эхэлнэ гэж Мерседес хэллээ.

- Ээж ээ, би таны хүслийг биелүүлж бас тантай адил найдаж горьдож байна. Бурхны цээрлэл таны ариуныг, миний хоргүй сэтгэлийг өршөөн гэтэлгэнэ. Бид одоо хөдлөх хэрэгтэй. Эрхэм Морсер гэрээсээ гараад хагас цаг хэртэй болж байна. Энэ л элдэв тайлбар, шуугианаас хэлтрүүлсэн тохиромжтой нөхцөл боллоо Гэж Альбер хэлэхэд Мерседес,

- Хүү минь би чамайг хүлээж байя гэлээ.

Альбер гэрээсээ гарч хөлсний тэрэг авч ирлээ. Альбер Гэгээн эцгүүдийн гудамжны нэгэнэ багахан бөайшинг санаж, түүнийг ээждээ хөлслөн авч өгөх гэж бодож байв. хөлсний тэрэг хаалган дээр хүрч ирж Альбер түүн өөд гарч очиход нэгэн хүн ирж захидал өгөлөө.

Альбер Бертуччо танилаа.

- Гүн өгч байна гэж даамал хэллээ.

Альбер захидлыг авч задаллаа.

Тэрээр уншиж дуусаад Берлуччо хартал цаадах нь алга болчихсон байв.

Тэгэхээр нь нүдэндээ нулимстай буцаж ирээд Мерседест дуугүй захидлыг өглөө.

Мерседес уншсан нь:

“Альбер!

Би таны одоо хийх гэж бодож хийж байгаа зүйлийг чинь тааварлан мэдлээ. Би бас сэтгэлийг ойлгодгийг харж байгаа биз дээ. Та чөлөөтэй болж, гүнгийн байшинг орхиж, мөн тан шиг чөлөөтэй болсон эхийгээ дагуулан явах гэж байна. Альбер санй бод. Чи ээждээ өгч чадахаасаа илүү их юм өгөх ёстой, хөөрхий залуу минь! Тэмцэл зовлон зүдүүрийг өөртөө ав, харин та хоёрын эхний алхмуудад тохиолдох гуйланчлалын байдалд эхийгээ бүү оруул. Тэр чинь өөрт нь тохиолдсон золгүй юудлын сүүдрийг ч хүлээх ёсгүй хүн шүү. Гэм буруугүй хүн гэмтэн буруутай хүний төлөө хохирохыг тэнгэр зөвшөөрөхгүй.

Та хоёр хоёулаа Эльдер гудамжин дахь байшингаас юу ч авалгүй орхиж явах гэж байгааг чинь мэдэж байна. Үүнийг яаж мэдэв гэж надаас бүү шалгаагаарай. Би мэдсэн. Энэ л хангалттай болно.

Альбер сонсож бай.

Хорин дөрвөн жилийн өмнө би гэдэг хүн баяр хөөртэй, бардам сэхүүн, эх орондоо буцаж ирж байсан юм. Надад дагина шиг шүтэж явсан ариун гэгээн охин, болзоот бүсгүй байсан юм. Завсар чөлөөгүй хүнд ажил хийсээр, зуун тавин алтан зоос хуримтлуулж түүндээ авчирсан билээ. Энэ мөнгө түүний юм. Би түүнд зориулсан юм. Тэнгис далайн итгэлгүйг мэдэх учир би баялгаа Марсель дахь эцгийнхээ сууж байсан Мельяний мод@т гудамжин дахь байшингийн бяцх н цэцэрлэгт булсан юм.

Альбер, танай ээж чинь энэ хонгор сайхан байшинг сайн мэднэ.

Би тийм я эрт биш, саяхан Праис уруу ирэх замдаа марселийг дайрсан. Би тэр гашуун дуртгалаар дүүрэн байшинг харахаар очсон. Орой нь би гартаа зээтүү барьж хомсхон баялгаа булж хадгалсан цэцэрлэгийн буланд очлоо. Төмөр хайрцаг тэндээ хэвээр бөгөөд хэн ч түүнд гар хүрсэнгүй. Тэр мөнгө намайг төрсөн өдөр эцгийн минь суулгасан сайхан инжийн модны дор бий.

Энэ мөнгө тэр нэгэн цагт миний тахин шүтэж байсан бүсгүйн тайван амьдралыг хангах ёстой байсан бөгөөд харин одоо хувь заяаны эргэлт хувиралтаар мөн тэр хэрэгцэгээ олох нь байна. Альбер, би энэ хүүхэнд хэдэн саяын хөрөнгийг өгч болох боловч, харин би миний дурлаж байсан хүүхнээс минь хагацаан салгасан тэр өдөр ядуу муу ормынхоо дэргэд хадгалж орхисон тэр зүсэм талхыг л өгье.

Альбер та нүүгүлсэнгүй сэтгэлтэй хүн, гэвч бардам зан, гомдол гутрал таныг төөрүүлж мэднэ. Хэрэв та миний хэлснээс татгалзаж, би танд өгөх эрхтэй тэр зүйлийг өөр хүнээс авбал таны эцгийн буруугаар эцэг нь өлсөж тарчилж үхсэн хүнээс танай эхэд өгч байгаа зүсэм талхыг буцааж байгаа хахир муухай хэрэг болно шүү”.

Альбех эхийнхээ шийдвэрийг харж царай нь зэвхийн хөдлөлгүй зогсоно.

Мерседес сэтгэл нь хөдөлсөн байртай тэнгэр өөд харав.

- Би хүлээн авлаа гэж Мерседес хэллээ.

Тэгээд захидлаа энгэртээ хийчхээд, хүүгээ хөтлөн, магадгүй өөрийнхөө санаснаас илүү ч чанга гишгэж шатан дээр гарлаа.

15.АМИА ХОРЛОСОН НЬ

Тэр завсар Монте-Кристо, Эмманюель Максимилиан хоёрын хамт хотод буцаж ирлээ.

Тэд хөгжилтэйгээ буцаж явав. Эмманюель энэ явдал ийм тайван сайхан төгссөнд баярласнаа нуугаагүй бөгөөд ер нь эв найрамдалд дуртай гэдгээ хэлж явлаа. Моррель хүргэнийхээ баяр хөөр болоход нь саад хийхгүйгээр тэрэгний буланд дуугүй суух бөгөөд багагүй их баяр хөөр харцанд нь гэрэлтэн харагдана.

Тэд Тронын харуулын тэнд Бертуччотой дайралдлаа. Тэр манаанд гарсан хүн шиг хөдлөлгүй зогсож тэднийг хүлээж байв.

Монте-Кристо тэрэгнийхээ цонхоор толгой цухуйлгаж хэдэн үг шивнэлдэн ярихад даамал яаран явж одлоо.

Тэднийг Пляс-Роялийн дэргэд хүрч ирэхэд Эмманюель гүнд,

- Эхнэр маань та бид хоёрын төлөө нэг ч минут илүү санаа зовохгүй байхын тулд тэргээ манай гэрийн гадаа зогсоогооч гэлээ.

- Хэрэв ялснаараа бахархах нь инээдтэй хэрэг биш бол гүнг манайд ор гэж урих сан. гэвч гүн бас хэн нэгний догдолж байгаа зүрхийг тайвшруулах хэрэгтэй байх даа. За, Эмманюель бид хүрч ирлээ. Найз нөхөртэйгөө салах ёс гүйцэтгэж, үзамаа цааш үргэлжлүүлэх бололцоог олгоё гэж Моррель хэллээ.
 - Байзаарай, хоёрын хоёр нөхдөөсөө шууд салчихыг хүсэхгүй байна. Та эхнэртээ очиж миний өмнөөс чин сэтгэлийн баяр Хүргээрэй. Харин Моррель та намайг Елисейн Тал хүртэл гаргаж аль гэж Монте-Кристо хэлэхэд Максимилиан,
 - Маш сайн хэрэг. Тэгээд ч бас би танай тийшээ явах хэрэгтэй гэж хэллээ.
 - Чамайг өглөөний хоолонд хүлээх үү? Гэж Эмманюель асуухад,
 - хэрэггүй гэж Максимилиан хариуллаа.
- Хаалга дуугарс сүйх тэрэг цааш давхив.
- Би танд аз жаргалыг авчирлаа. Та энэ тухай бодоогүй биз? гэж Моррель гүнтэй хоёулхнаа үлдээд хэлэв.
 - Бодсон, тийм уч раас танаас хэзээ ч салмааргүй байна гэж Монте-Кристо гүн хэллээ.
 - Ёстой л гайхамшиг юм! гэж Моррель өөрийнхөө санаанд хариулан өгүүллээ.
 - Тэр юу вэ? гэж Монте-кросто асуув.
 - Тэр болсон явдал.
 - Тийм ээ, Моррель та үнэн хэлж байна. Энэ бол ёстой л гайхмашиг юм! гэж гүн инээмсэглэн хэлэхэд Моррель үргэлжлүүлэн
 - Ямар ч гэсэн Альбер зоригтой хүн юм гэлээ.
 - Маш их зоригтой хүн. Хоолой дээр нь хутга тавьчихсан байхад тайван унтаж байсныг нь би өөрөө харсан юм гэж Монте-Кристо хэллээ.
 - Би түүнийг хоёр удаа халз тулалдахыг харсан, тун сайн тулалдсан юм. Харин энэ бүгд нь өнөөдрийнхтэй нь нийцэхгүй байна._
 - Энэ таны нөлөө байлгүй гэж Монте-Кристо инээмсэглэхэд
 - Альбер цэргийн хүн байгаагүй нь л аз болж дээ гэж Моррель хэлэв.
 - Яагаад тэр вэ?
 - Яагаад гэвэл тулалдааны талбар дээр гарч ирсэн хойноо буруугаа хүлээнэ гэдэг болшгүй! гэж хэлээд залуу ахмад толгойгоо сэгсэрлээ.
 - Моррель, та сонсож бай! Та зрдийн хүмүүсийн бодлыг хуваалцаж байна гэж үү? Альбер зоригтой хүн бол түүнийг айгаад иншэлээ гзу болохгүй шүү дээ. Өнөөдөр ингэх бүрэн шалтгаан байж « таарна. Тэгэхэд түүнийг нь баалралаг явдал гэж хэлж болно гэж гүн зөөлнөөр хэллээ.
 - Тийм ээ, гэхдээ испаничуудын ярьдгаар, тэр өнөөдөр өчигдрийнхөөсөө арай зориг багатай байна гэх сэн гэж Моррель хариулахад гүн яриагаа өөрчлөн,
 - Моррель, та надтай хамт өглөөний хоол иднэ биз дээ гэлээ.
 - Үгүй, би арван цагт танаас салж явна.
 - Та хүнтэй хамт өглөөний хоол иднэ гэж ярьсан юм уу?
- Моррель инээмсэглээд толгойгоо сэгсэрлээ.
- Тэгвэл та хаана нэг газар хоол идэх хэрэгтэй биз дээ?

- Үгүй, би өлсөхгүй байна гэж Максимилиан татгалзлаа.
- Хүн хоол идэх дургүй болдог хоёр л үе байдгийг би мэднэ. Энэ нь уйтгар гуниг, хайр дурлал хоёр юм. Та их л хөгжилтэй байгаа болохоор уйтгар гуниг гэж байж болохгүй.... Таны өнөө бөглөө надад хэлснийг бодоход... ингэж бодож болох нь ээ.... гэж гүн хэлтэл,
- За яах вэ, би түүнийг чинь үгүйсгэхгүй байна гэж Моррель хөгжилтэй хариуллаа.
- Максимилиан та энэ тухайгаа надад юу ч яригүй юм даа? гэж гүн Моррелийн нууцыг мэдэх гэж тэсэж ядан байгаагаа нуулгүй асуулаа.
- Гүн та өнөө өглөө надад зүрх байгаа гэдэгт итгэж чадсан биз дээ? Монте-Кристо хариу өгүүлэхийн оронд Моррельд гараа сунгалаа.
- Одоо миний зүрх тантай хамт Венсений ойд байгаа биш болохоор би зүрхнийхээ байгаа газар өөд явъя.
- Яв, яв. найз минь гэж гүн аяархан хэлээд – хэрэв таны зам дээр саад т@тгор тохиолдвол би энэ дэлхий дээр олон юм хийж чадна, өөрийн энэ эрх мэдлийг хайртай хүнийхээ ашиг тусын тулд хэрэглэхдээ баярлах болно. Тэр хайртай хүн нь Моррель та юм шүү гэдгийг санаж яваарай гэлээ.
- За сайн, би үүнийг хувиа бодсон хүүхдүүд эцэг эхийнхээ тусламж авах хэрэг болохоор тэдэндээ ханддаг шиг санаж чвах болно. хэрэв надад хэрэг болбол \хэрэг болох минут ирж тун ч магадгүй\ би гүн тан дээр ирж тусламж гуйна даа гэж Максимилиан хэллээ.
- За за тэгнэ гэж амласан шүү. За баяртай.
- Баяртай.

Тэд Елисейн Тал дахь байшинд хүрч ирэхэд Монте-Кристо сүйх тэрэгнийхээ хаалгыг нээж, Моррель үсрэн буулаа.

Шатан дээр Бертуччо хүлээж байв.

Моррель холдон явахад Монте-Кристо Бертуччогийн өөдөөс түргэн очоод,

- За юу болов? гэж асуулаа.
- Тэр хүүхэн гэрээ орхиж явах гэж байна.
- Хүү нь яасан бэ?
- Түүний хиа Флорантен бас л эзнийгээ эхтэйгээ адил юм хийх гэж байх шиг байна гэж байна.
- Намайг дагаад яв.

Монте-Кристо Бертуччотой хамт өрөөндөө орж, дээр бидний мэдсэн тэрхүү захидлыг бичиж даамалдаа өгөөд,

- За яв, бушуулаарай. Бас намайг ирсэн гэж Гайдед хэлээрэй гэж хэллээ.
- Би энд байна гэж Гайде өөрөө хариуллаа. Бүсгүй сүйх тэрэг ирэхийг дуулаад буун ирж гүн эрүүл саруул эсэн мэнд хүрч ирснийг хараад баярлан царай нь гэрэлтэж байв.

Бертуччо гарч одлоо.

Гайде ингэж тэсэж ядан хүлээж байж уулзахдаа эцгээ дахин үзсэн энхрий охин, дурлалд хүнээ дахин үзсэн дурласан бүсгүй хоёрын сэтгэлийн хөдлөлийг зэрэг мэдэрлээ.

Монте-Кристовийн баяр хөөр ч тийм ч хурц тодоор бус ч гэхнээ бас л багагүй байв. Зовж зүдэрсэн зүрхэнд баяр хөөр гэдэг бол халуун наранд хатсан газар дээр

шүүдэр унахын адил юм. Зүрх газар хоёр амьдралыг өгөгч чийгийг сорон авдаг бөгөөд үүнийг хажуугийн нүд үл харна.

Монте-Кристо сүүлийн өдрүүдэд, аль хэдийн бололцоогүй мэт санагдаж байсан тэр зүйлийг: Энэ дэлхий дээр хоёр Мерседес байхаж болох юм. Тэр бас аз жаргалыг амсаж болох юм гэдгийг ойлгожээ.

Түүний баярлан хөөрсөн харц Гайдегийн сүүмийсэн нүдэнд шуналтайяа тусаж байтал гэнэт хаалга нээгдлээ.

Гүн хөмсгөө зангидлаа.

- Эрхэм Морсер гэж орж ирснээ цагаатгаж байгаа юм шиг Батистен айлгалаа.

Үнэндээ ч гүнгийн царай саруулхан болоод явчлав.

- Аль нь? Бээс нь үү, гүн нь үү? Гэж асуулаа.

- Гүн нь.

- Тэр явдал бас дуусаагүй гэж үү? Хэмээн Гайде дуу алдлаа.

- Дууссан юм уу, үгүй юм уу бүү мэд, хүү минь гэж Монте-Кристо хэлээд охины гараас барьж, - Чамд айх юм байхгүй гэж хэллээ.

- Үгүй, тэр бузар золиг чинь...

- Гайде, тэр хүн миний өөдөөс ямар ч хүч чадалгүй. Харин хүүтэй нь явдвал болж байхад л айх хэргтэй байсан юм.

- Чи намайг хичнээн зовсныг мэдэхгүй шүү дээ, эзэн минь гэж Гайде хэлжээ.

Монте-Кристо инээмсэглэв.

- Хэрэв хүнд золгүй явдал тохиолддог юмаа гэхэд лав л надад тохиолдохгүй гэдгийг эцгийнхээ булшийг барьж тангараглая гэв.

Тэгэхэд залуу бүсгүй гүнд духаа өгч,

- Эзэн минь, би чамд бурхан шигл итгэдэг гэж хэллээ.

Монте-Кристо энэ цэвэр сайхан духан дээр үнэсэхэд хоёр зүрх нь нэг нь түргэн, нөгөө нь бөглүүгээ^o лугшин цохилгов.

- Бурхан минь, чи надад дахин дурлал төрүүлэх нь үү!... гэж гүн шивгэнээд, - Морсер гүнг зочдын өрөөнд ороыг урь гэж Батистенд хэлээд гоо сайхан грег хүүхнийг нууц шатаар гаргаж өглөө.

Монте-Кристо энэ хүнийг ирнэ гэж хүлээж байсан байж болох юмаа гэхэд уншигчид маань тэгж ирнэ гэж бодоогүй болохоор Морсерын ирсэн учрыг тайлбарлах нь чухал байна.

Мерседес гэртээ Альберын бичсэний адил жагсаалт хийж, үнэт эдлэлүүдээ эмхэлж, шүүгээнүүдээ түгжиж өөрөөсөө хойш бүх үддэх юмаа эмх цэгцтэй байлгах гэж түлхүүрүүдээ нэг доор цуглуулж, байхад, гудмын шилэн хаалганы цаана зэвийж барайсан муухай царай харагдахыг ажиглаагүй ажээ. Хаалганы цаанаас харж байсан хүн өөрөө үзэгдэж харагдаж, дуулдахааргүй боловч хатагтай Морсерын өрөөнд юу болж байсныг сүгдийг нь үзжээ.

Энэ зэвхий царайтай хүн хаалганаас холдоод унтлагынаа өрөөнд орж хашаа уруу харсан цонхны хөшгийг чичигнэсэн гараараа хойш нь болгоод харж зогсов.

Ийнхүү зүрхнийхээ цохилтыг чагнан дуу чимээгүй арван минут зогслоо. Түүнд энэ аравхан минут нь бүтэн жил шиг санагджээ.

Чухам тэр үеэр тулалдааны газраас эргэж ирсэн Альбер өөрийг нь отон зогсож байгаа эцгийгээ цонхон дээр хараад, хараагүй юм шиг эргэж явсан байна.

Гүн нүдээ бүлтийлгэлээ. Альбер Ёонте-Кристог доромжилсон ба ийм доромжлол энэ ертөнц дээр заавал үхлийн тулаанд хүргэдэг гэдгийг гүн мэднэ. Альбер бүрэн бүтэн амьд иржээ. Тэгэхээр эцгийн нь өшөө авагдсан байж таарна.

Тэнгэрийн хаяан дахь бараан үүлний цаагуур далд орж байгаа нарын сүүлчийн туяа адил тоочин хэлэхийн аргагүй баяр хөөр түүний баргар царайг гийгүүллээ.

Бидний дээр өгүүлснээр, Альбзрыг орж ирээд, ялалтынхаа тухай ярина гэж дэмий хүлээжээ. Хүү нь эцгийнхээ нэр төрийг хамгаалахаар тулалдах гэж явахдаа эцэгтэйгээ орж ирж уулзахгүй нь ойгомжтой байлаа. Харин эцгийнхээ нэр төрийн төлөө өшөөгөө авчхаад ирэхдээ хүү нь орж ирж, эцэгтээ тэврүүлдэггүйн учир юу билээ.

Тэгээд гүн Альбертэй уулзаж чадахгүй болоод түүний хаиаг дуудуулжээ. Альбер хиадаа гүнгээс юу ч нуух хэрэггүй гэж тушаасныг бид мэднэ.

Арван минутын дараа Морсер гүн цэргэ янзын захтай гадуур хар цамц, хар өмд өмсөж, хар бээлий хийгээд шатан дээр гарч ирлээ. Түүнийг шатнаас бууж амжаагүй байтал сүхий тэрэг ирж зогссоныг бодоход түрүүнд нь тушаал өгчихсөн байсан бололтой.

Хиа хоёр сэлэм ороосон цув сүйх тэргэн дотор тавиад, тэрэгний үүдийг хааж хөтчийн хажууд очиж суулаа.

Хөтөч тушаал хүлээж байв.

- Елисейн Тал өөд, Монтц-Кристо гүнгийн дотор очно. Түргэлээрэй гэж генерал хэллээ.

Морьд ташуурын исгэрэлтэнд ухасхийн таван минутын дараа гүнгийн байшингийн дэргэд ирж зогслоо.

Морсер өөрөө хаалгаа онгойлгоод залуу хүүхэд шиг явдал дунд үсрэн модот гудамж уруу буугаад, хонх дарж нээлтэй байгаа хаалгаар хиатай Жаа хамт орлоо.

Секундийн дараа Батистен гүнгийн ирсэн тухай Монте-Кристорд айлтгаж, Монте-Кристо гүн Гайдег дөхүүлж өгөөд Морсерыг зрчдын өрөөнд оруул гэж тушаажээ.

Генерал зочдын өрөөний уртын хэмжээг гурван удаа нааш цааш алхаж хэмжчихээд байтал Монте-Кристо орж ирэв.

- Өө эрхэм Морсер ирсэн юм уу? Би буруу дуулсан юм байх даа гэж бодож байсан юм гэж Монте-Кристо тайвнаар хэлэв.

- Тийм ээ би байна гэж гүн хэлэхэд уруу нь чичрэн, арай гэж үгээ хэлж байв.

- Ямар хэрэгтэй болоод Морсер гүн ийм эртлэн явж байгааг мэдэх л үлдээд байна гэж Монте-Кристо гүн хэлэхэд,

- Миний хүү эрхэм та хоёрын хооронд өнөө өглөө халз тулаан болох ёстой байсан биз? гэж генерал асуулаа.

- Та мэдсэн юм уу? гэж гүн асуув.

- Тийм ээ, бас миний хүү ноцтой шалтгаанаар тангйа тулалдаж таныг алахыг хичээх байсан юм.

- Тийм ээ, эрхэм минь. Үнэхээр ноцтой шалтгаан байсан юм. Гэсэн ч тэр намайг алсангүй, тур ч байтугай тулалдаан ч үгүй гэдгийг харж байгаа биз дээ .
- Гэвч та бол хүүгийн нүдэнд эцэгт нь тохиолдсон бузар явдлын буруутан, манай гэрийг нөмрөн авсан аймшигт золгүй явдлын буруутан шүү дээ.
- Эрхэм минь, тэр үнэн гэж Монте-Кристо гүн өнөө л аймаар тайван байдлаараа хэлээд, - Буруутан мөн, гэхдээ ч гол буруутан нь биш, харин хоёрдугаар зэргийнх байх гэлээ.
- Та түүний өмнө буруугаа хүлээсэн ч юм уу эсвэл тайлбар өгсөн байх нь ээ?
- Би түүнд ямар ч тайлбар өгөөгүй, би буруугаа хүлээсэн биш, харин тани хүү буруугаа хүлээсэн юу.
- Түүнийг ингэж буруугаа хүлээсэн ядлыг та юу гэж үзэж байна!
- Надаас өөр хүн илүү буруутай юм байна гэдгийг л итгэж мэдсэн юм билээ.
- Хэн байх нь вэ?
- Түүний эцэг.
- Гэмтэй хүний гэмийг хэлж өгөхөд гэмтэн хүн дургүй байдгийг та мэдэх ёстой гэж Морсер царай нь зөвхийрэн хэллээ.
- Би үүнийг мэднэ... Тийм учраас тэр явдлыг болно гэж хүлээж байсан юм.
- Миний хүү аймхай амьтан болж хувирахыг хүлээж байлаа гэнэ ээ? гэж гүн дуу алдлаа.
- Альбер де Морсер бол огтын аймхай хүн биү гэж Монте-Кристо хэлэв.
- Хэрэв хүн гартаа сэлэм барьж байгаад дайсан нь урьд нь зогсож байхад тулалдахгүй бол аймхай хулчгар хүн болно. хэрэв би түүнийг энд байсан бол нүүрэн дээр нь хэлэх байсан юм!
- Эрхэм минь, би таныг гэр бүлийнхээ хэргийг шүүмжлэн хэлэлцэх гэж ирээгүй байх гэж бодож байна. үүнийгээ хүүдээ очиж хэл. Тэр танд хариулах үг олж магадгүй гэж Монте-Кристо хүтнээр хариуллаа.
- Үгүй, үгүй, таны хэлдэг маш зөв. Би ингэж ярих гэж ирээгүй! Би таныг бас өөрийнхөө дайсан гэж хэлэх гэж ирсэн юм! Би таныг зөнгөөрөө л үзэн ядаад байна! Таныг таньдаг, үргэжл үзэн ядаж явсан юм шиг сэтгэл надад төрөөд байдаг юм! Одлогийн залуу хүмүүс тулалдахаасаа татгалзаад байвал бид тулалдах болж байх шив... Эрхэм та зөвшөөрч байна уу?
- Дүүрэн зөвшөөрч байна. Тийм ч учраас би болох ёстой юмыг хүлэсж байсан гэж хэлэхдээ таныг л ирэх байх гэснээ хэлсэн юм шүү дээ.
- Тэгвэл бүр ч сайн... Тэгэхээр та бэлхэн үү?
- Би хэзээ ч бэлхэн Үайдаг.
- Та бид хоёр, аль нэгийгээ үхтэл тулалдах болно. ойлгож байгаа биз гэж генерал шүдээ зууж, уур омог нь бадран хэллээ.
- Тийм ээ, нэг нь л үхтэл гэж Монте-Кристо гүн давтан хэлээд, толгой дохив.
- Тэгвэл явах уу, бидэнд гэрч нар хэрэггүй.
- Мэдээж хэрэг хэрэггүй. Бид бие биеэ дэндүү сайн мэднэ! Гэж Монте-Кристо хэллээ.

- Үгүй, бид хоёр бие биеэ огт мэдэхгүй гэж гүн хэллээ.
- Та юу гэнэ ээ? Та чинв Ватерлогийн тулалдааны өмнө цэргээс оргосон цэрэг Фернан биш гэж үү? Испанид францын армийг байхад тагнуул хийж холбоо барьж байсан тэр бага дарга Ферана биш үү? Өөрийн ачит эзэн Алийгаас урваж, худалдаж түүнийг алсан хурандаа Фернан биш гэж үү? Энэ олон Фернанууд нийлээд Францын тайж дэслэгч генерал Морсер гүн болсон юм биш гэж үү? Хэмээн Монте-Кристо өнөөх хэнгүй байдлаараа хэлэхэд энэ үг генералыг халуун төмрөөр хайрах шиг болж,
- Бузар золиг, чи магадгүй намайг алахынхаа өмнө ингэж миний булай бүхнээр дайрч болох шүү! Үгүй, би чамайг өөрийгөө мэдэхгүй гэж хэлэхгүй. Чи муухай чөтгөр, миний өнгөрсөн үеийн харанхуй явдалд нэвтрэн оржээ. Чухам ямар бамбарын гэрэлд миний амьдралын хуудсуудыг уншихсаныг бүү мэд. Гэхдээ миний шившигт явдал чиний энэ гялалзсан сайхнаас илүү нэртэй төртэй ч юм байж болох юм шүү. Чи намайг мэдэж байгаа гэдэгт чинь би эргэлзэхгүй байна. Харин алт, үнэт эрдэнийн чулуун дотор умбаж явдаг зальхай амьтан чиний хэн болохыг би мэдэхгүй байна! Парист ирэхээрээ чи өөрийгөө Монте-Кристо гүн гэж нэрлэдэг, Италид болохоор Синдбад-Далайчин, Мальтид өөр хэн ч билээ мартчихаж элдвээр нэрлэдэг. Харин би чиний зүрхэнд ёсэлмээ шаахдаа нэрийг чинь хашхирахын тулд чиний энэ олон нэр дотроос жинхэнэ нэрийг чинь мэдэх хэрэгтэй байна. Үүнийг би шаардаж байна! гэв.

Монте-Кристовийн царай үхтлээ цонхийж нүдэнд нь аюуцмшигт гал улалзлаа. Тэр зэргэлдээ өрөө рүү ухасхийн орж зангиа цамц, хантаазаа тайлж хаячихаад далайчны хүрэм, далайчин хүний малгай өмсөхөд урт хар үс нь цухуйж байв.

Тэгээд ер бусын аймаар байдаотай орж ирээд гараа зөрүүлдэн генерал өөд алхав. Түүний гэнэт гараад явчихсанд гайхсан генерал хүлээж байлаа. Зүсээ хувиргаад орж ирсэн Монте-Кристо гүнг хараад хөл нь гуйвж, шүд нь тачигналаа. Тэгээд ухарч эхэлсэн боловч нэгэн ширээнд тулаад зогслоо.

- Фернан, миний өчнөөн олон нэрэн дундаас нэг л нэрийг хэлэхэд чи муужирна. Тэр нэрийг чи таах шив дээ, тийм үү? Чи тэр нэрийг санав уу? Би хэчнээн зовж зүдэрсэн гэлээч өшөө хорслоо авна гэж баярласандаа өндөөр чиний өмнө залуужин зогсож байгааг харж байгаа биз. Чи намайг, миний болзоот хүүхэн Мерседестэй сууснаасаа хойш.... Ганц бус удаа зүүдлээ биз дээ? гэж хашхирах шахам хэлэв.

Генерал толгойгоо гэдийлгэж, гараа урагш сунган энэ аймшигт үзэгдлийг харж дуу шуугүй зогслоо. Тэгээд уначихгүйн тулд х на түшин араараа ухарч хаалга хүрээд,

- Эдмон Дантес! Гэж дотор арзаганамаар муухай хашхираад гуйвлан гарч одов.

Дараа нь хүний хэрээс хэтэрсэн хүч гаргаж шат хүрээд цааш нь согтуу хүн шиг гуйвлан хашаан дотуур өнгөрөөд хиагийнхаа гар дээр унаж,

- Харъя, харъя! Гэж бувтналаа.

Замын цэвэр агаар зарц нараасаа ичих сэтгэл нь түүнийг ухаан оруулжээ. Гэвч явах зам нь урт биш учир гүн гэртээ ойртох тусам улам цөхөрлөө.

Гүн гэрээсээ хэдхэн алхмын зайтай газар зогсохыг тушаагаад тэрэгнээсээ буулаа.

Хаалга цэлийтэл нээлтэй байв. Ийм баян гэрт хөлсний тэрэг ямар хэрэгтэй юм бол гэж гайхсан хөтөч хашаан дотор нь хүлээж байв. Гүн түүн өөд айн харсан боловч, юу ч асууж зүрхэлсэнгүй шууд өрөөндөө орлоо.

Шатаар хоёр хүн бууж явлаа. Тэр тэдэнтэй мөргөлдөхгүйн тулд хажуугийн тасалгаанд арайхийн амжиж нуугдлаа.

Энэ бол хүүгийнхээ гараас түшсэн Мерседес байв. Тэр хоёр гэрээ орхин гарч байгаа нь энэ ажээ.

Тэр хоёр хөшигний цаана нуугдсан золгүй амьтны хажуугаар өнгөрөн гарахад Мерседесийн даашинзны хормой түүнийг бараг шүргэн алдаж,

- Ээж минь зоригтой бай! Явъя, явъя, бушуухан явъя. Энэ байшин та бид хоёрын гэр биш болсон гэж хэлж яваа хүүгийн нь бүлээн амьсгал нүүр дээр нь хүрэх шиг санагджээ.

Ярилцах үг нь дуулдахаа больж алхаа нь холдлоо.

Гүн биеэ эгцэлж хөшигнөөс зууран зогслоо. Эхнэр хүүхэд хоёр нь хаяад явчихсан эцгийн цээжнээс л гарч болох мэлмэрэх нулимсаа тогтоохыг байдгаараа хичээн байв.

Удалгүй хөлсний тэрэгний хаалга хаагдан, хөтөч нь хашхиран, хүнд тэрэгний дугуйн доргионд цонхны шил донслон дуугарахыг сонслоо. Тэгэхээр нь энэ ертөнцөд дурлан хайрлаж байсан зүйлүүдээ дахин нэг харах гэж унтлагынхаа өрөөнд гүйж орлоо. Гэвч хөлстний тэрэг холдон явж, Мерседес, Альбер аоёрын аль нь ч нөхрөө, эцгээ хоосорсон байшингаа баяртай хэмээн тэрэгний цонхоор харсангүй.

Сүйх тэрэгний дугуй чулуун зам дээгүүр тачигнах яг тэр үед буун дуу гарч, доргилтоос хагарсан унтлагын өрөөний цонхоор бараан утаа суунаглалаа.

16.ВАЛЕНТИНА

Моррель, хаашаа яарч, хэнтэй уулзах ёстой байсныг уншигч авгай нар тааварлан мэдэж бхйгаа биз ээ.

Монте-Кристоогоос салаад Вильфорын байшингийн зүг аажуухан алхлаа.

Бид түүнийг аажуухан алхлаа гэж хэлсэн. Моррельд хагас цагийн зай байсан, гэлээ ч очих газар нь тавхан зуун алхмын цаана байсан учраас тэгж яеаралгүйхэн алхжээ. Гэвч хэдийгээр уаг байсан боловч, бодол санаатайгаа хоёулхнаа байх гэж Монте-Кристоос салахыг яарчээ.

Валентина Нуартъед өглөөний нь хоолыг идүүлдэг учраас, түүнийг эн ариун үүргээ биелүүлэхэд нь хэн ч саатуулж чадахгүй тэр цагийг Моррель сайн тогтоож авчээ. Нуартъе, валентина хоёр түүнийг долоо хоногт хоёр удаа ирж байхыг зөвшөөрсөн болохоор энэхүү эрхээ эдлэх гэж яваа нь энэ ажээ.

Моррелийг орж ирэхэд түүнийг хүлээж байсан Валентина гараас нь барьж өвгөн аав дээрээ аваачлаа. Валентина царай нь цонхийж сэтгэл нь хүчтэй догдолсон байв.

Бүсгүй Операд болсон будлианыг дуулаад сэтгэл нь зовжээ. Монте-Кристо Альбер хоёрын маргааныг бүгд үдээдсийн хүрээлэн дандаа юм бүгдийг мэднэ\ мэдсэн бхйв. Энэ явдлын дараа зайлшгүй ирүүл тулалдаан болно гэдэгт Вильфорынхон хэн нь ч эргэлзэхгүй байв. Валентина эмэгтэй хүний зөнгөөр Моррелийг Монте-Кристогийн талын гэрч болно гэдгийг мэдэж, зоригтой тэгээд гүнд

ихэд дотно байдгийн учир зөвхөн идэвхгүй гэрчийн үүргийг гүйцэтгээд зогсохгүй байх бий гэж айж байжээ.

Тийм учраас бүсгүй болсон явдлын тухай тодорхой асуу, Моррелийн хариултыг сонсоод, Моррель сэтгэлтэй бүсгүйн нүдэнд тулалдаан тэгж сайн сайхнаар дууссан явдалд хязгааргүй баярласан шинж байхгы олж харлаа.

- Аа одоо гэж Валентина хэлээд Моррелийг өвгөнтэй хамт суу гэж дохиж суулгаад өөрөө өвгөний хөлд тавиастай байдаг урт сандлын үзүүр дээр сууж – Бид өөрсдийн хувийн яриаг ярьж болно. Өвгөн аав нэг үе эрхэм Вильфорын гэрээс нүүж тусгай суух саналтай байсныг Максимилиан та мэднэ шүү дээ гэхэд,
- Мэдэлгүй яах вэ, би тэр төлөвлөгөөг мэдэж ихэд сайшааж байсан юм гэж Моррель хариуллаа.
- Тэгвэл би таныг баярлуулж чадах нь байна. Яагаад гэвэл өвгөн аав энэ бодолдоо дахин эргэж орсон гэж Валентина хэлэхэд,
- Маш сайн! Гэж Максимилиан хэллээ.
- Өвгөн аау яагаад энэ байшингаас явах гэж хүсэж байгааг мэдэж байна уу? гэж валентинаг ца ш нь ярихад нуартье ач охин өөдөө дуугүй байхыг тушаан их л нухацтай харлаа.

Гэвч Валентинагийн харц, инээмсэглэл нь ганцхан Моррель дээр байсан учир түүн өөд харсангүй.

- Эрхэм Нуартъегийн хүсэл ямар ч байдаг байсан би дэмжинэ гэж Максимилиан хэлэхэд,
- Би бас чин зүрхнээсээ гэж валентина хэлээд – Сент-Онорегийн агаар миний эрүүл мэндэд хортой байна гэж өвгөн аав итгэхээд байна гэлээ.
- Валентина, эрхэм Нуартъегийн хэлдэг түмэн зөв. Миний л мэдэж байгаагаар та хоёр долоо хоногийн өмнөөс эв эрүүл биш байх шиг байгаа юм гэж Моррель хэлэхэд,
- Тийм ээ, миний бие тааруухан байна. тэгэхээр өвгөн аав өөрөө намайг эмчлэхээр шийдсэн. Өвгөн аав юм бүгдийг мэднэ, тийм учраас ч би бүрэн итгэдэг юм гэж Валентина хариуллаа.
- Тэгэхээр та үнэхээр өвчтэй байх нь ээ? гэж Моррель яаран асуулаа.
- Энэ өвчин биш ээ. Зүгээр л бие эвгүйцээд байгаа юм. Би хоол идэх дургүй болж, бие махбод минь ямар нэг юмтай тэмцэлдэж байгаа юм шиг санагдаад байх юм.

Нуартье Валентинагийн нэг ч үгийг сонсолгүй өнгөрсөнгэй.

- Та тэр үл мэдэгдэх өвчнөө юугаар эмнэж байгаа вэ?
- Би зүгээр л , өглөө бүр өвгөн аавын уудаг тэр эмнээс цайны халбагаар уудаг юм. Эхлээд нэг халбага ууж байсан бол одоо нэмсээр байгаад дөрвөн халбага уух болсон. Өвгөө энэ эмийг бүх төрлийн өвчнийг эмнэдэг эм гэж хэлдэг юм.

Валентина инээмсэглэлээ. Гэвч инээмсэглэл нь зовлонтой ч вч шиг уйтгартай гунигтай байлаа.

Хайр сэтгэлдээ сансуурсан Һаксимилиан түүн өөд дуугүй харж сууна. Гоо сайхан харагдах царай нь сиймийгээд тунгалаг ч юм шиг болж, нүд нь урьдынхаасаа

илүү гялтганаж, танын өнгөт цагаан гар нь он жил өнгөрч бага зэрэг шарласан лаваар хийсэн юм шиг болчихжээ.

Максимилиан Валентинаг харж байснаа, орхиж, өвгөн Нуартье өөд харлаа. Тэр ч бас Моррелийн адил өвгөн эцэг ба дурлалт хүн хоёроос нь өөр хэн ч олж ажиглахааргүй энэ нууц тэмдгийг олж харсан ажээ.

- Энэ чинь эрхэм Нуартьед бичиж өгсөн эм биш үү? Гэж Моррель асуухад,
- Тийм ээ их гашуун амттай эм байгаа юм. Уусны дараа юу ч уусан гашуун амтагдаад байдаг эм дээ гэж Валентина хариуллаа.

Нуартье ач охин өөдөө асуусан мэт харлаа.

- Нээрээ шүү, өвгөн ааваа, би сая тан дээр ирэхдээ чихэртэй ус уусан чинь гашуун оргиод аягатайгаа дуустал ууж чадсангүй.

Нуартьегийн царай цайж нэг юм хэлэх гээд байгаа бололтой Валентина толь бичиг авч ирэх гэж бослоо.

Нуартье илтэв сэтгэл зовсон байдалтай түүний хойноос нь харна.

Охины толгойд цус хөөрч хацар нь улайжээ.

- Ямар хачин юм бэ? Миний толгой эргэж байна. Наранд цохиулчихлаа гэж үү? Хэмээн бүсгүй хөгжилтэйгээр хэлэв.

Тэгснээ бүсгүй ширээний өнцгөөс барьж авав.

- Ямар ч нар байхгүй байна шүү дээ гэж Моррель хэллээ.

Валентинагийн бие эвгүйцсэнээс илүүгээр Нуартьегийн царайны байдал түүнийг тэвдүүлжээ.

Тэгээд валентина өөд гүйж очиход, залуу бүсгүй инээмсэглэж,

- Тайвшир, өвгөн ааваа . Тайвшир гэж өвөөдөө хэлээд Максимилиан минь тайвшир, одоо згээр өнгөрлөө. Ямар нэгэн хүн хашаан дотор орж ирэх шиг боллоо гэв.

Бүсгүй хаалга онгойлгож гудамд байгаа цонхон дээр гүйж очоод тэр дороо эргээд ирлээ.

- Хатагтай Данглар охинтойгоо ирлээ. Баяртай, би тийшээ очъё. Тэгэхгүй бол нааш нь хүн явуулна. Максимилиан, өвгөн ааютай бууж бай. Би тэднийг барьж удаахгүй гэж хэлээл гарлаа.

Моррелийн нүд түүний хойноос дагаж хаалга хаагдахыг хараад, хатагтай Вильфор ба бүсгүйн өрөөнд ордог жижигхэн шатаар дээшээ өгсөхийг сонслоо.

Нуарье охиныг гармагц толь бичиг ав гэж Моррельд дохилоо.

Моррель түүний хүслийг биелүүллээ. Тэрээр Валентинагийн удирдлагын дор өвгөний санааг сайн ойлгож чаддаг болжээ.

Удаа бүрд цуагаан толгойн үсэг дараалан эрхэ учир арваад минут явчихна. Тэгсээр байж “Валентинагийн тасалгаанаас аягатай ус, галыын хүзүүт хоёрыг авчруул” гэдэг санааг мэдэж авлаа.

Моррель Барруагийн оронд орсон зарцыг даруй дуудаж энэ тушаалыг Нуартьегийн нэрийн өмнөөс өглөө.

Минутын дараа зарц буцаж ирлээ.

Галуун хүзүүт, аяга хоёр хов хоосон байв.

Нуартье нэг юм хэлэх гэж хүсэж байгаа дохио өглөө.

- Галуун хүзүүт, аяга хоёр яагаад хоосон байгаа юм бэ? валентина аягатайгаа ууж гүйцээгүй гэж хэлсэн шүү дээ гэж тэр асуулаа.

Энэ санааг үг болгох гэж таван минут зарцуулжСэ.

- Мэдэхгүй, харин мадмаузель Валентинагийн тасалгаанд шивэгчин хүүхэн орж явсан тэр аваачаад асгачихсан юм биш байгаа даа гэж зарц хариуллаа.
- Тэр хүүхнээсээ энэ тухай асуугаад ир гэж Моррель Нуартъегийн нүдээр санааг нь ойлгон хэллээ.

Зарц гарч яваад тэр дороо буцаж ирлээ.

- Мадмаузель Валентина сая тасалгаандаа ороод үлдсэнийг нь уучхаад гарсан байна. Харин галуун хүзүүтэд байсныг нь Эдуард нугаснууддаа цөөрөм хийж өгөх гээд асгачихсан гэнэ.

Нуартъе бүх хөрөнгөө хөзөрт тавьчихсан тоглогч шиг дээшээ харлаа._

Дараа нь өвгөн хаалга руу хараад түүнээс хараа салгасангүй.

Хатагтай Данглар охинтойгоо хамт ирлээ гэж Валентина хэлсэн нь ташаа болсонгүй. хатагтай Вильфор өрөөндөө хүлээн авна гэсэн болохоор тэднийг өрөө рүү нь оруулжээ. Валентина тасалгаагаараа дайрч гарсан учир нь энэ байжээ. Валентинагийн тасалгаа хойд эхийнхээ тасалгаатай нэг давхарт байдаг бөгөөд тэдгээрийг зөвхөн Эдуардын өрөө л тусгаарлана.

Зочид нэгэн чухал зүйлийг мэдэгдэх гэсэн мэт их л албан ёсны байдалтай орлоо.

Нэгэн зиндааны хүмүүс бие биеийнхээ янз байдлыг амархан ойлгодог. Хоёр авгайн ёсорхог байдалд хатагтай Вильфор бас ч тийм ёсорхгоор хариуллаа.

Энэ үед Валентина орж ирж дахин мэнд усаа асуулцав.

Хоёр залуу охин гараа барьж мэндлэх үед_ хатагтай Данглар,

- Хайрт найз минь, би охиноо Кавальканти ноёнттой суулгах хурим удахгүй болно гэдгийг та нарт хамгийн түрүүн мэдэгдСх гэж ирлээ гэв.

Ноён хэргэмээр нь дуудна хэмээн Данглар зүтгэжээ. Ардчилсан үзэлтэй банкны эзэн үүнийг гүнгээс илүү сонсголонтой гэж үзжээ.

- Тийм бол та нарт баяр хүргэхийг зөвшөөрнө үү. Кавальканти ноён ховор тохиолдох сайн чанартай залуу хүн гэж би боддог шүү гэж хатагтай Вильфор хэллээ.

- Найзын ёсоор хэлэхэд Кавальканти ночн хүрэх эзлэх сууриндаа хүртэл өдий байгаа хүн юм. Францчууд бид хараад л мэддэг итали германы язгууртнуудад байдаг хачин байдал их байгаа юм. гэсэн ч сайн санаа нарийн ухаан түүнд байх шиг байна. Ажил хэргийн талаар гэвэл Данглар гуай түүнийг асар их хөрөнгөтэй хүн гэж батлаж байна билээ. Тэр бүр асар их гэж хэлсэн юм шүү гэж хатагтай данглар инээмсэглэн хэллээ.

Хатагтай Вильфорын зургийн цомгийг үзэж суусан Эжени,

- Түүнээс гадна тэр залуу хүнд хатагтай та өөрөө онц их дотно байдгаа нэмээд хэлчихгүй юу гэж хэллээ.
- Би танаас асуугаад ч яах вэ дээ, та ч бас тэр дотно байдлыг хуваалцдаг байлгүй гэж хатагтай Вильфор хэлэхэд Эжени ердийнхөө шулуун байдлаар,
- Хатагтай минь огтхон ч үгүй. Тэр эрэгтэй нь хэн ч байлаа гэсэн, би ажахуйн сонирхол эрэгтэйчүүдийн дур зоргыг гүйцэтгэгч байж чадахгүй юм шиг байна билээ. Миний хүсэл зориг бол жүжигчин л байх явдал. Тэгэхээр

сэтгэл зүрх, бие цогцос, санаа бодлоо өөрөө чөлөөтэй мэдэх хэрэгтэй биз дээ гэв.

Эжени энэ үгийг тун шийдэмгий өнгөөр хэлсэн учир Валентина дэрдгээд явчхав. Эмэгтэй хүний ичимтгий зангийн сүүдэр ч байхгүй энэ зоригто© охиныг ичимхий даруу охин яаж ойлгох билээ.

- Ингэхэд нэгэнт л хүнтэй суух учирт йгаас хойш харин Морсер гуайтай суулгаагүй тэнгэрт л баярлах ёстой. Хэрэв тэнгэр оролцоогүй бол өдийд нэр төргүй болсон хүний эхнэр болчихсон байхгүй юу гэж Эжени цааш ярилаа.
- Нээрээ тийм шүү, хэрэв Морсер эргэлзээгүй бол манай охин аль хэдийн нь Альбертай суучих байсан юм. Генерал хүүгээ гэрлүүлэх гэхдээ өөрийн биеэр Данглар гуай дээр зөвшөөрөөүүлэх гэж ирсэн юм. Бид азтай хөндийрсөн шүү гэж хатагтай Данглар язгууртнуудын зан болох илэн далангүй цагаахнаар хэллээ.
- Эцгийн нь шившиг хүүд нь сүүдэр буулгана гэж үү? Бээс, генералын урвасан явдалд огтхон ч буруугүй юм шиг надад санагдаж байна хэмээн Валентина аяархан хэлэв.
- Уучлаарай хонгор минь, бээсэд ялгагдах юм байхгүй. Өчигдөр Операд Монте-Кристо гүнг тулалдаанд өдчихөөд, өнөө өглөө буруугаа хүлээж байна гэх чинь билээ гэж Эжени цахөршгүй байдлаараа хэллээ.
- Үгүй, байлгүй! гэж хатагтай Вильфор хэлэхэд хатагтай данглар бидний дөнгж саяхан хэлээд өнгөрсөн гэнэн байдлаараа,
- Эй, хонгор минь, тийм байх шүү. Тэгж байх үед нь байсан Дебрэгээс дуулсан юм гэж хэллээ.

Валентина бас бүгдийг мэдэж байсан боловч дуугүй өнгөрлөө. Халз тулаан гэдгээс болоод бодол санаа нь Моррелийн хүлээж байсан Нуартъегийн тасалгаа уруу шилжлээ.

Валентина бодлогошрон байсан учир хэдэн минут ярианд оролцсонгүй. залуу бүсгүй юун тухай ярьж байсныг нү хэлж чалахааргүй байв. Гэнэт х тагтай Данглар түүний гарт хүрлээ.

- Хатагтай та суу гээ вэ? гэж валентина ингэж хүрэхэд нь цахилгаан зайд цохиулчихсан юм шиг болж асуулаа.
- Валентина минь таны бие муу байна уу? гэж хатагтай Данглар асуухад, залуу бүсгүй халуун оргисон духан дээгүүрээ илж,
- Бие муу гэнэ ээ? гэж гайхан асуулаа.
- Тийм ээ, та толинд хараач, сүүлийн минутад царай чинь дөрвөн ч удаа өөрчлөгдлөө.
- Нээрээ тийм байна шү. Чи аймшигтай цонхигор байна! гэж Эжени ч дуу алдлаа.
- Эжени, бүү зов хэдэн өдөр ингээд байгаа юм.

Валентина хэдийгээр сайхан санаатай боловч энүүгээр шалтгаалан явж болохыг ойлгов. Гэтэл хатагтай Вильфор өөрөө түүнд тусаллаа.

- Валентина өрөө уруугаа оч доо. Таны бие үнэхээр муу байна. Манай зочид таныг уучлах байлгүй. Аяга хүйтэн ус уучихвал танд зүгээр болох байх гэв.

Валентина Эженийг үнэсээд, хатагтай Дангларт мэхийн ёслоод тасалгаанаас гарав.

Хөөрхий охин, намайг тоглоомгүй их айлгаад байгаа юм шүү. Сүрхий өвдөж магадгүй гэж айж байна гэж хатагтай Вильфор Валентинагийн араас хаалга хаагдахад хэлэв.

Тэр завсар Валентина бие нвэгүй болж Эдуардын тасалгааг өнгөрөөд, түүний дүрсгүйтэхэд хариу дуугаралгүй, өөрийн унтлагын өрөөгөөр дайрч жижигхэн шат уруу буулаа. Буухад гуравхан гишгүүр үлдээд байтал Моррелийн дуу дуулдаж, гэнэт нүд нь бүрхэн хөл нь хөшиж шатны бариул гараас нь мултранхана налж, доошоо алхах биш гишгүүр дээгүүр гулслаа.

Моррель ухасхийн хаалг онгойлгож Валентинаг шатны талбай дээр уначихсан байхыг хараад даруй өргөн аваад зөөлөн сандал дээр суулгалаа.

Валентина нүдээ нээгээд

- Би ямар эв дүйгүй амьтан бэ! Хөр дээрээ тэнцэж зогсохыг мартчихсан юм шиг боллоо. Тавцан хүртэл бас гурван гишгүүр байдгийг яагаад мартчихав аа гэж халуурсан хүний хурц хэлээр хэллээ.

- Валентина та гэмтчихээгүй биз? гэж Моррель дуу алдав.

Валентина тасалгааг эргэн тойрон харахад Нуартъегийн нүдэнд ихэд айсан шинж тодрон байв. Валентина инээмэглэх гэж оролдон,

- Өвгөн аав аа, бүү зов. Энэ зүгээ... Толгой эргээд л тэр... гэв.

- Дахин толгой эргэлээ гэнэ ээ! Валентина биеэ хайрлаж, болгоомжилж байхыг гуйя гэж Моррель тэвдэн хэлэхэд Валентина,

- Одоо зүгээр, өнгөрлөө. Энэ дажгүй гэж хэлээд байна шүү. Харин би одоо сонин юм хэлье. Долоо хоногийн дараа эжени хүнтэй суух гэнэ. Гурав хоногийн дараа гэрлэх баярт зориулж том найр хийх гэнэ. Бид бүгдээрээ, аав, хатагтай Вильфор бас би уригдсан... Миний ойлгосон энэ л байна гэж хэллээ.

- Манай ээлж хэзээ болох юм бэ? Ай, Валентина минь та өвгөн аавдаа их нөлөөтэй болхоор түүгээр удахгүй гэж хэлүүлээч!

Тэгээд тасалгаанаас гүйж гарав.

Моррель ч нөгөө хаалгаар нь гүйн гарав.

Түүний зүрхэнд аймшигт дуртгал урган гарч ирлээ. Хатагтай Сен-Мераныг талийгаач болсон тэр шөнө Вильфор эмч хоёрын ярилцахыг сонссон с наанд нь оржээ. Шинж тэмдэг нь сулхан ч гэсэн Барруагийн үхэл мөн ийм байлаа.

'эгтэл хоёрхон цагийн өмнө Монте-Кристо өөрт нь "танд юу хэрэгтэй болсон Моррель та над дээр ирж байгаарай. Би олон юм хийж чадна шүү" гэж хэлсэн үг чихэнд нь жингэнэх шиг болов.

Тэрээр сум шиг чавхдан Сент Онорегоор өнгөрч Матиньон гудамж руу орж, Матиньон гудамжнаас Елисейн Тал руу очлоо.

Тэр завсар Вильфор хөлсний тэрэг авч д Авринийн гэрт очлоо. Тэр тун огцом хонходсон учир хаалгач нь айсан царайтай үүдээ нээж өглөө. Вильфор үг ч дуугарч чадалгүй шат өөд гүйлээ. Хаалгач нь түүнийг таних учир түүний хойноос зөвхөн,

- Эмч албан өрөөндөө байгаа шүү, вангийн прокурор гуай гэж хашхирч амжлаа.

Вильфор эмчийн өрөөнд орлоо. Орох ч юу байх вэ бүр ухасхийн дайрав.

- Өө та юу! гэж д Авринь хэлэхэд
- Тийм ээ, эмч ээ гэж хэлээд Вильфор хаалгаа хааж – Энэ удаа танаас энд хоёулхнаа байна уу гэж би асууя. Эмчээ миний гэрт бурхан хараал хийжээ гэж хэллээ.
- Юу болоо вэ? гэж эмч гаднаа хүйтэвтэр боловч дотроо сэтгэл нь түгшин асуугаад – Танайд бас нэг чинь өвдчихсөн вч биш биз? гэлээ.

Вильфорын цээжнээс зовлонтойгоор гинших дуу гарч эмчийн гарыг барьж авав.

- Валентина! Энэ удаа Валентинагийн ээлж болжээ! Гэж тэр хэлэв.
- Таны охин уу? гэж эмч айх гайхах зэрэгцэн асуулаа.
- Та одоо ташаарч андуурснаа харж байгаа биз гэж Вильфор шивгэнээд, - Түүнд минь тусажл зовж шаналж байгаа түүнийг бурууга р сэжиглэж байсныхаа бурууг хүлээгээч гэлээ.
- Та нар намайг дуудуулах бүрд хожимдсон байдаг. Гэвч яах вэ би очъё. Гагцхүү бушуулъя. Танай дайсантай цаг алдаж болохгүй гэж д Авринь хэллээ.
- Энэ удаа эмч та намайг сул дорой гэж зэмлэхгүй байа. Энэ удаа би яргачин нь хэн болохыг мэдэж, өрөвдөн хайрлахгүй.
- Юуны өмнө өшөө авахаа бодохоос хохирч байгаа хнүээ аврахын төлөө бүх зүйлийг хийе. Явъя гэж д Авринь хэллээ.

Вильфорыг хүргэж өгсөн мүйх тэрэг түүнийг д Авриньийн хамт буцаан авч давхиж явахад Моррель, Монте-Кристогийн хаалгыг цохиж байлаа.

Гүн тасалгаандаа Бетуччогоос яаралтай ирүүлсэн зурвасыг уншин их л санааширсан байдалтай сууж байв.

Хоёрхон цагийн өмнө салсан Моррелийг хүчр ирсэн тухай айлтгахад гүн гайхаж толгойгоо өндийлгөлөө.

Энэ хоёр цагийн дотор Моррель гүн хоёрт хоёуланд нь олон зүлийн өөрчлөлт тохиолджээ. Залуу хүү гүнгээс салж явахдаа инээмсэглэн явсан бол одоо түүний өмнө уруу царайтай зогсож байв.

Гүн ухасхийн босож түүн өөд очлоо.

- Юу болов: Максимилиан? Царай чинь цонхийж, амьсгаадж байх чинь юу вэ? гэж хэллээ.
- Моррель зөөлөн сандал дээр бараг унах мэт сууж,
- Тийм ээ, тантай ярих хэрэгтэй юм гараад, гүйж ирлээ гэж хэлэв.
 - Гэрийнхэн чинь цөм сайн биз? гэж гүн эргэлзэхийн аргагүй үнэн санаанаасаа асуухад, Моррель яриагаа яаж эхлэхийг мэдэхгүй,
 - Гүн танд баярлалаа. Гэрийнхэн маань сайн, эрүүл энх гэж хариулав.
 - Би их баяхтай байна. Харин та надад ямар нэг юм хэлэх гээд байна аа даа? гэж гүн улам эцгэл нь түгшиж асуухад,
 - Тийм ээ. Би тан дээр үхэл нөгчсөн нэг айлаас гүйж ирлээ гэж Моррель харуи өгүүллээ.
 - Тэгвэл та Морсерынхоос ирэв үү? Гэж Монте-Кристо асуухад,
 - Үгүй дээ. Морсерынхоос хэн нэг нь үхсэн биш биз дээ? гэж Моррцль хэлэв.
 - Генерал духандаа сум зоосон гэнэ гэж Монте-Кристо хэлэхэд,

- Ямар аймаар юм бэ! гэж Максимилиан дуу алдлаа.
- Хатагтай, Альбер хоёрын хувьд аймаар юм биш. Түүний нэр төргүй явдлыг үзсэнд орохноо эцэггүй, нөхөргүй болсон эь дээр, цус чивэлт явдлыг угаадаг гэж Монте-Кристо хэлэхэд Максимилиан,
- Хөөрхий хатагтай! Тэр сайхан санаатай эмэгтэйг л би илүү их өрөвдөж байна гэж хэллээ.
- Альберыг ч бас өрөвдөх хэрэгтэй шүү. Альбер бол хатагтайд тэнцэх хүү байгаа юм. За тэр ч яах вэ. Та надтай уулзах гэж ирсэн гэсэн. Хэрэв би танд хэрэг болбол их баярлана даа.
- Бурхан л тусажл чадахаас өөр юу ч тус болж чадахгүй тийм хэрэг гараад би танд ухаангүй итгэж найдан хүрч ирлээ.
- Хэлээч дээ!
- Ийм нууц мюыг энэ ертөнц дээр ганц ч болов хүнд илчлэн хэлж болох эрхтэй эсэхийг би мэдэхгүй байна. Гэвч хувь заяа минь ингэхийг шаардаж байна. Бти өөрөөр яаж ч чадахгүй гэж Моррель хэлээд шийдэж ядан тээнэгэлзэн дуугүй боллоо.

Тэгэхэд Монте-Кристо Моррелийн гарыг барьж,

- Би танд хайртайг та мэднэ шүү дээ гэлээ.
- Таны үг надад зориг оруулж, танаас нуух юм надад байхгүй гэж зүрх минь хэлж байна.
- Тийм ээ, үүнийг бурхан өөрөө танд итгүүлжээ. Та зүрхнийхээ таалалд тохируулан надад бүгдийг нь хэлээч.
- Гүн минь, таны таних нэгэн эмэгтэйн эрүүл мэндийг таны нэрийн өмнөөс Батистеныг явуулж асуулгах зөвшөөрөл өгнө үү?
- Би өөрөө таны мэдэлд байхад зарц нарын турай ярих юу байх вэ?
- Түүний бие ямар байгааг мэлэхгүй бол би ухаан алдах нь байна шү.
- Батистеныг дуудах уу?
- Үгүй, би өөрөө түүню хэлчихье.

Моррель гарч, Батистеныг дуудаад хэдэн үг аяархан хэллээ. Даамал яаран гарч одлоо.

- За яав? Явуулав уу? гэж Монте-Кристо Моррелийг буцан орж ирэхэд асуув.
- Тэглээ, одоо бага зэрэг тайвширлаа.
- Би таны ярихыг хүлээж байна гэжү Монте-Кристо инээмсэглэн хэллээ.
- Тийм ээ, би танд бүгдийг нь хэлнэ. Сонсож байгаарай. Би нэг орой нэгэн цэцэрлэгт байж байлаа. Намайг бут бургас халхалж миний байгааг хэнч мэдсэнгүй. Миний хажуугаар хоёр хүн өнгөрлөө. Нэрийг нь одоогоор хэлэхгүй байхыг зөвшөөрнө үү. Тэд аяархан ярилцаж байсан боловч, би тэдний юу ярьж байгааг мэдэх нь чухал байсан учир чих тавин, чагнаж, нэг ч үг гээлгүй сонслоо,
- Таны царай зэвийж байгааг бодоход эхлэлт нь нэлээд муухай явдал юм аа.
- Тийм ээ, найз минь энэ бүгд их аймшигтай! Тэр байшинд тэр үеэр нэг хүн дөнгөж нас барчхаад байв. Ярилцаж байгаа хүний нэг нь гэрийн эзэн нөгөөдөх нь эмч байв. Тэнгэр уур хилэнгээ гаргаж өшгөө хорслын элчээ

явуулсан мэт энэ сарын дотор хоёр удаа гэнэтийн хурдан үхэлд дайрагдсан байшингийн эзэн өөрийн болгоомжулол, гунигт байдлаа нөгөөдөхдөө ярилаа.

- Уухай! Гэж Монте-Кристо Моррель өөрсө ширтэн харж үл ажиглагдах хөдөлгөөнөөр сандлаа эргүүлж өөрийнхөө царайг сүүдэрт, зочныхоо нүүр дээр гэрэл тусахаар болгож суулаа.
- Тийм ээ! нэг сарын дотор энэ байшинд хоёр удаа үхэл зочлон ирсэн юм.
- Эмч түүнд юу гэж хариулав? Гэж Монте-Кристо асуув.
- Тэр ингэж хариулсан... Энэ үхэл бол ердийн биш, үүнийг ганц л юмаар тайлбарлаж болно...
- Юугаар тэр вэ?
- Хор!
- Үнэхээр үү? Гээд Монте-Кристо сэтгэл хүчтэй догдолсноо дарах ч юм уу эсвэл царайнхаа улайх, цайхыг эс бөгөөс их анхааралтай сонсож байгаагаа нуухын тул хоолойгоо засаад
- Үнэхээр үү, Максимилиан? Та энэ бүгдийг сонсоо юу? гэлээ.
- Тийм ээ, хүндэт гүн минь, би энэ бүхнийг сонссон юм. Тэр ч байтугай эмч, ийм явдал давтагдав шударга үнэний шүүхэд өөрийгөө хандах хэрэгтэй гэж хэлсэн юм.

Монте-Кристо хиймэл ч байж мэдэх асар их тайван байдлаар сонсож суулаа.

17. Үнэнээ хүлээв

Дараа нь үхэл гурав дахь удаагаа ниргэв. Гэрийн эзэн ч, эмчийн аль алин нь хэнд ч юу ч хэлсэнгүй. Одоо үхэл дөрөв дэх удаагаа ниргэж магадгүй байна. Гүн минь энэ нууцыг мэддэг минь надад ямар үүрэг ногдуулж байна вэ? гэж Максимилиан хэллээ.

- Хайрт найз минь, та бараг бүх хүний мэдэх явдлын тухай ярьж өйна. Таны энэ бүгдийг дуулсан байшинг би мэднэ. Үгүй ядахдаа л яг тийм байшинг мэднэ. Тэнд цэцэрлэг, бас гэрийн эзэн, эмч бий бөгөөд гурван удаа гэнэтийн хачин үхэл болсон. Наашаа хар л даа. Би хэнээс ч юу ч сонсоогүй мөртлөө танаас дооргүй мэдэж байна. Гэвч намайг хүч сэтгэл минь зовоож байна гэж үү? Үгүй шүү, энэ надад огтхон ч хамаагүй. Өшөө хорслын элч энэ байшинд бууж ирсэн юм шиг гэжэ та ярьж байна. ээн тийм биш гэж хэн танд хэлэв? Харах ёстой хүн нь харахыг хүсэхгүй байгаа энэ гэмт хэгийг бүү анхаар. Хэрэв энэ байшинд бурхан өөрийн шүүхийг явуулж байгаа бол максимилиан минь буруу хараад л бурхны шударга үнэний шүүхэд бүү саад бол гэж Монте-Кристо хэллээ.

Моррель цочин чичирлээ. Гүнгийн дуу сүртэй, хахир атлаа хангалуун шинжтэй байв. Гүн ярианыхаа өнгийг эрс өөрчилж өөр хүн ярьж байгаа юм шигээр,

- Ингээд та энэ бүгдийг дахин давтагдах ёстой гэж яаж мэдэж байгаа юм бэ? гэлээ.
- Энэ явдал давтагдлаа гүн минь! Тэгээд л би энд хүрч ирсэн юм гэж Моррель дуу алдав.
- Моррель би юу хийж чадах билээ? Эсвэл намайг вангийн прокурорт мэдэгд гээ юу?

Монте-Кристо сүүлийнхээ эн үгийг Моррелийг ухасхийн босохоор тийм ойлгомжтой ёжтойгоор хэллээ.

- Гүн та намайг хэний тухай ярьж байгаа мэдэж өбайна уу? гэж Моррщль асуув.
- Тийм ээ, найз минь, мэдээжийн хэрэг. Би тэнд дурдагдаж байгаа бүх хүмүүсийг нэрлэж үүнийг мэддэгээ үзүүе. Та Вильфорын цэцэрлэгт зугаалж явсан. Таны яринаас бодоход хатагтай Сен-Сераны талийгаач болсон үдэш юм байна. Вильфор, д Авриньи хоёр Сен-Мерануудын үхсэн тухай ярь! байхыг та сонсжээ. Хорлож алсан, тэр дундаа хоёр ч удаа хорлосон тухай д Авриньи ярьсан байна. Тэгээд л та ховор тохиолдох томоотой хүн болохоороо эн нууцыг илчлэх үү байх уу гээд сэтгэл зүрхээ шаналгаад яваа юм байна л даа. Найз минь, та бид дундад зууны үед амьдарч байгаа биш, одоо чинь тэр харгис хатуу шашин шүүх, чөлөөт шүүгч нар байхгүй болсон цаг. Та тэднийг яах гэсэн юм бэ? “Хүнч сэтгэл минь чи надаас юу хүсэж байна?” гэж Стерн хэлсэн байдаг. Яах вэ найз минь. Тэд унтах дуртай бол, унтаж л байг, эсвэл нойргүй хонож эцэж доройтвол доройтож л байг, харин та өөрөө бурхнаа бодоод л тайван унтаж бай. Таны хүнч сэтгэл цэвэр ариун сан билээ.

Моррелийн царай зовж тарчилсан байдалтай хачин болж, Монте-Кристо гүнг гараас нь шүүрэн барилаа.

- Үгүй, тэр явдал дахин давтагдлаа шүү дээ! Та дуулж байна уу? гэхэд гүн түүний ийм шаргуу байгааг гайхаж, түүн өөд галгах мэт харж,
- Тэгээд яагаа вэ? Тэгж л байг. Энэ чинь Атридын гэр бүл байгаа юм. Бурхан тэднийг цээрлүүлж тэд шийтгэлээ хүлээж байгаа нь тэр. Тэд хоёр зуун хүн ч байгаа гэсэн хүүхдийн хайчилж хийсэн цаасан хүнүүд шиг цвуан үрэгдэх болно. Гурван сарын өмнө Сен-Меран бээл үхсэн, дараа нь хэдхэн хоноод хатан нь, саяхан Барруа, өнөөдөр өвгөн Нуартье, залуу Валентина хоёрын нэг үхнэ биз гэлээ.
- Та энэ тухай мэдэж байсан гэж үү? Хэмээн Моррщль тэнгэр нурсан ч хөдлөхөөргүй тайван байдаг Монте-Кристок хүртэ» айхаар муухай хашхираад – Та энэ тухай мэдсээр байж дуугүй байсан юм уу? гэлээ.
- Энэ надад ямар хамаа байсан юм бэ? гэж Монте-Кристо мөрөө хавчаад,
- Энэ улс надад юу юм бэ? нэгийг нь аврах гэж нөгөөг нь хөнөөх ямар хэрэг байна. Би үнэндээ алж байгаа, алагдаж байгаа хүмүүсийн алийг нь ч гэхгүй байна гэж хэллээ.
- Үгүй, би, би! гэж Моррель арга нь барагдан дуу алдаад – 2-Би тэр бүсгүйд сэтгэлтэй юм гэв.
- Аль бүсгүйд сэтгэлтэй гэж? хэмээн Монте-Крихсто хэлээд ухасхийн босож, Моррелийн гараас барьж авлаа.
- Би ухаангүй сайн, хайр сэтгэлтэй юм. Би түүний ганц дусал нулимсыг хатаахун тулд бүх цусаа өгөхөд бэлхэн. Та дуулж байна уу. Би Валентина де Вилфьорт хайртай юм, гэтэл түүнийг минь алж байна! Би түүнд хайртай. Би урхан тэнгэрт залбирч, түүнийг аврах аргыг надад зааж өгөөч гэж гуйж байна!

Монте-Кристо хашхираад, тэр ньв шархадсан арслангийн хүрхрэх адил байлаа.

- Золгүй амьтан чи Валентинад хайртай юм гэнэ ээ! Би энэ бузар төрөлтнүүдийн охинд сайн юм гэнэ ээ! гэж дуу алдлаа.

Моррель амьдралдаа ийм аймшигт царай, ийм аймгинт харцыг үзээгүй ажээ. Тулалдааны талбар, Алжирын үхлийн шөнүүдэд дайралдаж явсан аймшиг түүнийг ийнхүү цахилгаан цахих мэт ниргэж байсангүй.

Айсандаа алхам ухарлаа.

Монте-Кристо ингэж дүрэлзэн уурласныхаа дараа дотоод галдаа үялбасан мэт нүдээ анилаа. Тэр биеэ барих гэж хүний хэрээс хэтэрсэн хүч гаргав. Шуурга аянг ны дараа нарын гэрэл тусаж галзууран долгилсон давалгааны намхархын адил түүний цээжин доторх шуурга бага багаар намдлаа.

Ийнхүү өөрөө өөртэйгСэ тэмцэлдсэн тэмцэл, чимээ аниргүй байдал хориодхон хором үргэлжилсэн билээ.

Гүн цайсан царайгаа өөд болгож,

- Найз минь, бусдыг аймшигт гай зовлонд ороод байхыг юман чинээ боддоггүй хүмүүсийг тэнгэр яаж цээрлүүлэн шийтгэж байгааг хараа биз. Энэ муухай эмгэнэлт явдал миний нүдэн дээр болж байхад би зүгээр л сонирхон харж байсан юм. Хүмүүс нууцын бүрхүүлээр халхлан хийж байсан тэрхүү хорт явудлыг хараад би сахиулсан тэнгэр бууж ирсэн юм шиг инээн шоолж байв. \Баян хүчирхэг хүмүүсийн нууцыг хадгалахад амархан\, Мушгиралдан тахиралдсан замаар нь мөшгөж явсан могой намайг бүр зүрхэнд минь хатгалаа! Гэв.

Моррель бүдэгхэн гиншиж байВ.

- Гомдохоо .больж зориг ор. Би тантай хамт байгаа болохоор таныг хамгаална гэж гүн хэллээ.

Моррель уйтгартайгаар толгойгоо сэгсрэв.

- Би танд итгэж найд гэж хэлсэн шүү. Би хэзээ ч худлаа хэлдэггүй, хэзээ ч андуурч ташаардаггүй. Одоо үд дунд болж байна. Харин та өнөө орой ч юм уу, маргааш өглөө ирээгүй, өдөр дунд ирсэндээ бурханд баярлаарай. Максимилиан, одоо үд дунд болж байна. Хэрэв Валентина одоо амьд л байгаа бол үхэхгэй гэж Монте-Кристо дуу алдлаа.

- Бурхан минь! Би түүнийг үхэж байхад нь орхиж ирсэн шүү дээ! гэж Моррель хэлэв.

Монте-Кристо гараараа нүдээ дарлаа.

Аймшигт нууцыг хадгалсан энэ тархинд юу болж байгаа бол? Энэхүү хэлбэршгүй бөгөөд хүнч саруул ухаанд тэнгэрийн эл, хар зүгийн элч хорёын алин нь ирж ухаан заасан бол?

Үүнийг гагцхүү бурхан л мэднэ!

Монте-Кристо дахин толгойгоо өөд өргөлөө. Энэ удаа түүний царай нойрсож байгаад сэрсэн хүүхдийнх шиг тайван байлаа.

- Максимилиан чи одоо тайван харь. Ямар ч арга хэмжээ авч, сэтгэл түгшүүртэй байгаагаа хэнд ч бүү үзүүл гэж би танд тушааж байна. Надаас мэдээ хүлээж байгаарай. За одоо яв.

- Таны шижээргүй тайван байдал намайг айлгаж байна. та үхлийг захирдаг юм уу? Та хүн үү, юу вэ? Эсвэл та бурхан тэнгэр үү? Гэж Моррель хэллээ.

Тэгээд ямар ч аюулын өмнө ухарч үзээгүй залуу дарга өгүүлшгүй их сүр аймшигт автан ухарлаа.

Харин Монте-Кристо түүнийг энэрэн хайрласан нгунигтай харцаар харж, инээмсэглэхэд Максимилианы нүдэнд ус гүйлгэнэлээ.

- Найз минь, олон юм миний мэдэлд бий. Одоо яв, би ганцаараа байх хэрэгтэй байна гэж гүн хэллээ.

Монте-Кристовийн орчин тойрныхоо хүмүүсийг захирч чаддаг тэрхүү их хүчинд автсан Моррель гүнгээс зөрөхийг ч оролдсонгүй. Моррель гүнгийн гарыг бариад гарч одлоо.

Гэвч хаалга хүрээд гудамжны буланд Батистен гарч ирэхийг харж зогслоо.

Тэр завсар Вилфьор, д Авриньи хоёр вангийн прокурорын гэрт хүчр ирлээ. Тэднийг ирэхэд Валентина бас л ухаангүй хэвээр байв. Д Авриньи аймшигт нуцыг мэдсэн эмч хүн яаж үзвэл зохих хэмжээгээр өвчтөн бүсгүйг нарийвчлан сайн үзлээ.

Вильфор д Авриньнийн царайгаас нүд салгалгүй түүний шийдээрийг хүлээж зогсов. Вильфороос илүү хариу хүлээн байсан Нцуртье, Валентинагаас илүү зэвхийж сэтгэл овуны бүх хүч харцанд нь хуралдсан байлаа.

Эцэст нь д Авриньи аяархнаар,

- Бүсгүй одоогоор амьд байна гэж хэллээ.
- Одоогоор ий? Ямар аймшигтай үг вэ? гэж Вильфор дуу алдлаа.
- Тийм ээ, би дахиад хэлчихье. Одоогоор амьд байна. Энэ надад их гайхалтай санагдаж байна.
- Аврагдаж болох уу? гэж эцэг нь асуулаа.
- Амьд байгаа болохоор болно.

Энэ үед д Авриньийн харц Нуартъегийн харцтай тулгарлаа. Энэ харцадн хязгааршгүй их баях хөөр, гүн бодол байгааг эмч харж бишрэн гайхлаа.

Тэгээд эмч хөхөрсөн уруул нь цонхийсон царай дээр нь арай гэж ялгагдаж байгаа охиныг зөөлөн сандал дээр дахин тавиад түүний хөдөлгөөн бүрийг анхааралтай харж байсан Нуартъе өөд харж хөдлөлгүй зогслоо.

- Эрхэм Вильфор та Валентинагийн шивэгчнийг дуудуулаач гэж эмч хэллээ.

Вильфор охиныхоо толгойг түшиж байснаа тавиад шивэгчинг дуудахаар өөрөө явлаа.

- Та надад нэг юм хэлэх гээд байна уу? гэж тэр асуулаа.

Өвгөн нүдээ анилаа. Түүнд ийм ганц л баталсан дохио байдгийг бид мэднэ.

- Надад ганцааранд нь уу?
- Тийм гэж Нуартъе дохиоло.
- За сайн, би тантай хоёулхнаа үлдэхийг хичээе.

Энэ минутад Вильфор шивэгчинг дагуулан орж ирлээ. Шивэгчингийн араас хатагтай Вильфор орж ирлээ.

- Хөөрхий охин минь яагаа вэ. Дөнгөж саяхан над дээр ороод гарсан юм сан. Бие муу байна л гэж байсан юм. Ийм юм болно гэж даанч санасангүй гэж хатагтай хэллээ.

Тэгээд залуу хүүхэн нүдэндээ доглон нулимстай, эх хүний эелдэг байдлаар валентина дээр чоиж гарыг нь барилаа

Д Авринь Нуртэгийн харцыг ажиглан харж байв. Өвгөн нүдээ бүлтийлгэн, хацар нь цайрч, духны нь хөлс чийхран байв.

- Аа тийм байдаг байж! Гэж д Авринь өөртөө хэлээд, Нуртэгийн харц дагуулан өөрөөр хэлбэл, Вильфор хатагтайг харав.
- Хөөрхийн охиныг хэвтүүлье. Алив Фанин хоёулаа хэвтүүлье гэж хатагтай Вильфор хэлэв.

Д Авринь энэ саналыг Нуртэетэй хоёул хоцрох боломж гэж үзэн зөвшөөрч толгой дохиод, харин өвчтөнд түүний зөвшөөрлөггүйгээ юу ч өгч болохгүй гэж хориглолоо.

Валентинаг аваад явлаа. Залуу бүсгүй ухаан орсон боловч дайрлагад хүндээр нэрвэгдсэн учир хөдөлж ч, дуугарч ч чадахгүй байлаа. Гэсэн ч сүнсийг нь биеэс нь суга татан авч байгаа юм шиг тэсэж ядан харж байгаа өвгөн аавтайгаа нүдээрээ салах ёс гүйцэтгэлээ.

Эмч өвчтөннийг явуулаад эмийн жор бичиж өгч, Вильфорыг эмийн санд өөрөө очиж, харж байж найруулуулаад авчирч охиныхоо өрөөнд хүлээж бай гэж тушаав.

Дараа нь Валентинад өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр юу ч өгч болохгүй гэж дахин тушаагаад Нуртэ дээр ирж хаалгаа сайн хаагаад хэн ч тэр хоёрын яриаг чагнаж чадахгүй гэж мэдээд ийн хэллээ.

- Та ач охиныхоо өвчний тухай ямар нэг юм мэдэж байна уу?
- Мэднэ гэж өвгөн дохил.
- Бид цаг алдаж болохгүй, би асуугаад л та хариулаад л байгаарай. Нуртэ хариулахад бэлэн гэж дохилоо.

- Та Валентинаг өвдөнө гэж мэдэж байсан уу?
- Тэгсэн.

Д Авринь хором хяраатай юм бодсоноо Нуртэгийн дэргэд очиж,

- Та миний одоо хэлэх гэж байгаа вмыг уучлаарай. Гэвч бидний одоогийн байж байгаа аймшигтай байдалд юу ч орхигдож болохгүй. Та хөөрхий Барруагийн үхэхийг харсан шүү дээ? гэв.

Нуртэ өөдөө харлаа.

- Тэр юунаас болж үхсэнийг та мэдэх үү? Гэж д Авринь Нуртэгийн мөрөн дээр гараа тавьж хэлэхэд өвгөн
- Мэднэ гэж дохилоо.
- Та үүнийг ердийн үхэл гэж бодож байна уу?

Нуртэгийн амьгүй уруул дээр инээмсэглэлэрхүү юм гарч ирлээ.

- Тэгвэл та Барруаг хорлогдсон гэж сэжиглэж байна уу?
- Тийм.
- Түүнийг алсан хорыг түүнд зориулж өгсөн гэж бодож байна уу?
- Үгүй.
- Санамсаргүй, гай болж Барруаг алсан тэр гар өнөөдөр валентинаг дайрлаа гэж бодож байна уу?
- Тийм.
- Тэгвэл бүсгүй бас л үхэх үү? Гэж Нуртэгийн ажигламтгай харцнаас нүд салгалгүй байж д Авринь асуулаа.

Энэ үг өвгөнд ямар нөлөө үзүүлэхийг хүлээж бай. Гэтэл өвгөн,

- Үгүй гэж хариулсан нь хамгийн ухаалаг тааварлан мэдэгч хүнийг ч гэсэн гайхаж хоцруулахаар юи болов.
- Тэгвэл танд горьдлого байна уу? гэж д Аврины гайхан асуулаа.
- Тийм.
- Та юунд найдаж байна?

Өвгөн хариулж чадахгүй байгаагаа дохиж мэдэгдлээ.

- Өө, нээрээ тийм л дээ гэж д Аврины шивгэнээд, дахин Нуартъезд хандаж – Яргачин ухарч буцна гэж та бодож байна уу?
- Тийм.
- Та түүнийг хорлох гэж оролдсоныг надаас доргүй мэдэж бхйгаа бимз гэж д Авринь үргэлжлүүлэн хэлэхэд өвгөний харц энэ талаа° ямар ч эргэлзэх юм бхйхшүй гэж мэдэгдлээ.
- Та яагаад Валентинаг аюулаас аврагдана гэж бодож байна.

Нуартъе нэгэн зүг өөд ширтэн хараад байв.д Аврины өвгөний харцыг дагуулан харвал өглөө бүр авчирч өгдөг шилтэй эмийг нь олж харлаа.

- Аа, ийм учиртай байж гэнэт ухаанд нь нэгэн бодол гэрэлтэн орсонд д Аврины хэлээд, - Үнэхээр та... гэтэл Нуартъе түүний үгийг хэлж дуусгалгүй,
- Тийм гэж дохилоо.
- Түүнийг хорын нөлөөнөөс урьдчилан хамгаалсан уу?
- Тийм.
- Бага багаар дасгасаар байгаад...
- Тийм, тийм, тийм гэж Нуартъе санааг нь ойлгосонд баярлан олон дахин дохилоо.
- Танд өгдөг эмд гожил гэдэг хор ордог юм гэж намайг ярьж бахихыг дуулаа юу?
- Тийм.
- Та хор өгч дасгасаар байгаад валентинаагийн бие хор нөлөө үзүүлж чадахгүй болгосон юм уу?

Нуартъегийн нүд баяр хөөрөөр гэрэлтэв.

- Та санасандаа хүрчээ. хэрэв та ийм урьдчилан болгоомжилсон арга хэмжээ аваагүй бол энэ хор өнөөдөр Валентинаг эгшин зуурын дотор хайр найргүй алах байсан юм. Тун хүчтэй дайрлага байдаг шүү. Гэвч Валентинагийн бие зөвхөн нөлөөлөгдөөд өнгөрсөн учир энэ удаа үхэхгүй.

Хязгааргүй баярлан дээш харсан Нуартъегийн нүдэнд аязгааргүй баяр хөөр гэрэлтэж байв.

Энэ еэр Вильфор ирж,

- Эмч таны бичсэн эм байна гэж хэлэв.
- Таны дэргэд найруулсан уу?
- Тэгсэн гэж вангийн прокурор хариулав.
- Та түүнийг гараасаа салгаагүй биз?
- Үгүй.

Д Аврины шилтэй эмийг авч хэдэн дуслыг алган дээрээ дусаагаад амсаж үзлээ.

- За сайн, одоо Валентина дээр очье. Би танд юу хийхийг зааж өгнө. Харин түүний хэн ч зөрчиж болохгүйг та өөрөө харж хянаж байх хэрэгтэй.

Д Аврины Вильфцорыг дагуулан Валентинагийн өрөөнд орсон яг тэр үед жигд алхаатай, тайван тогтуун яриатай нэгэ итали лам Вильфорын байшингийн зэргэлдээ байгаа байшинг хөлслөн авчээ.

Ямар наймаа болсныг бүү мэд, байшинд оршин суугчид хоёр цагийн дараа цөм нүүгээд явчихжээ. Энэ байшингийн суурь нь муудаж нурах болж байгаа гэж ярилцаж байгаа боловч, тэр өдрийнхөө таван цагийн үед лам өөрийн багахан хогшилтой нүүж ирэхэд нь л лав саад болсонгүй ажээ.

Шинэ зэн байшинг гурав зургаа ч юм уу есөн жилээр хөлслөн авч зохих ёсоор хагас жилийн хөлсийг төлжээ. Энэ шинэ ирсэн хүн нь бидн й түрүүнд хэлсэнчлэн итали лам Жакопо Бжзони гэгч байв.

Тэр доороо ажилчид дуудаж мөн тэр шөнө нь гудамжны адгнаар явсан хүмүүс мужаан чулуучингууд муу өмхөрсөн байшингийн суурийг засаж байхыг харж гайхжээ.

18.БАНКНЫ ЭЗЭН БА ТҮҮНИЙ ОХИН

Хатагтай Данглар, хатагтай Вильфор дээр ирж мадмаузель Эженийг Андреа Кавалькантитай суулгах гэж байгаа тухайгаа албан ёсоор зарласныг бид түрүүчийн бүлгээс мэдсэн билээ.

Ингэж албан ёсоор мэдэгдсэн явдал нь бүх сонирхогч талууд тохиролцжээ гэдгийг харуулж байлаа. Гэвч үүний өмнө нэгэн явдал болсныг бид уншигч авгай нартаа өгүүлэх ёстой боллоо.

Тийм учраас бид тэрхүү тэмдэглэлт өдрийн өглөөнөөс бага зэрэг наашилж бидн йдээр дүрслэн үзүүлсэн эзэн нь болох Данглар түшээ гүнгийн бахархдаг алтадсан гоё сайхан зочдын өрөөнд буцаж орохыг хүсье.

Өглөөний арван цагийн хэрв бодлогоширч, ямар нэгэн юманд санааширсан түшээ гүн энэ зочдынхоо өрөөн дотуур хойш урагшаа алхаж, хаалга өөд байн бөайн харж, чимээ гарах бүрд сэртэсхийж байлаа.

Тэгээд тэсэж чадахаа болиод хиагаа дуудаж,

- Этьен чи яваад мадмуазель Данглар яах гэж намайг энэ зочдын өрөөнд хүлээхийг хүсэж, ямар шалтгаанаар ингэж удаан хүлээлгээд байгааг мэдээд ир гэж хэллээ.

Түшээ гүн ингэж муухай аашаа гаргаж аваад бага зэрэг тайвширчээ.

Үнэндээ ч мадмуазель Данглар сэрмэгцээ шивэгчнээ явуулж аавтайгаа уулзах зөвшөөрөл гуйлгаад, зочдын алтадсан өрөөнд уулзана гэж тохирчээ. Энэ хүсэлтийн ер бишийн байдал, ялангуяа албан ёсны байдал нь банкны эзний гайхшийг багагүй төрүүлж охиныхоо хүсэлийг биелүүлэх Гэж яаран зочдын өрөөнд түрүүлж орж ирсэн нь тэр байжээ.

Этьен удсан ч үгүй хариу авч ирлээ.

- Мадмуазель Эжений шивэгчин хүүхэн авхайг хувцаслаж дуусаж байна, одоо удахгүй очно гэж хэлж байна гэв.

Данглар хариултад ханасны тэмдэг болгож тоолгой дохилоо. Данглар бол дээдсийн хүрээлэн, тэр ч байтугай зарц нарынхаа нүдний өмнө сайхан сэтгэлтэй% сайн эцэг гэж хэлэгддэг хүн. Өарийн нь гүйцэтгэж Үайгаа инээдэмт жүжгийн

ардчилсан үзэлтэй зүтгэлтний үүрэг нь түүнээс ийм байдлыг шаардана. Түүнд энэ нь тохирч байна гэж санагддаг ажээ. Эртний жүжгүүдэд эцэг хүний нь баг нь уруулын нь баруун өнцөг бага зэрэг дээшээ өргөгдөж инээмсэглэсэн байдалтай, харин зүүн үзүүр нь доошоо унжиж, уйлах гэж байгаа юм шиг байдаг.

Шэр бүлийнхээ хүрэн дотор байхдаа инээж байгаа уруул нь уур хилэнгийн байдалд орчихдог гэдгийг яаран нэмж хэллэггүй болохгүй. Тэгэхэд сайхан зантай хүний нь байдал бүдүүлэг муухай зантай нөхөр, хатуу ширүүн эцэг байдлаар нь солигдох нь олонтаа тохиолдоно.

- Тэр галзуурсан охин надтай ярих хэрэгтэй юми бол тасалгаанд минь ирээд л ярина биз? Түүнд надтай ярих хэрэг юу болоо юм бол? гэж Данглар буйтнав.

Данглар өөрийгөө түгшүүлсэн энэ санааг хориод удаа бодож гайхаж байтал хаалга онгойж Эжени орж ирлээ. Тэрээр цэцгэн хээтэй хар торгон даашинз өмсөж малгайгүй боловч, харин бээлийн хий Италийн дуурийн театрт юм үзэхээр яваа юм шиг байв.

- Эжени юу болоо вэ? Миний тасалгаанд тохитой суугаад ярилцаж болох байтал ёслолын өрөөнд орох хэрэг юу байна? гэж Данглар хэллээ.
- Таны хэлдэг маш зөв гэж Эжени хэлээд эцгийгээ суухыг урьж – Бид хоёрын яриаг дүүрэн хангаж чалах хоёр асуулт та тавилаа. Тийм учраас би танд хоёуланд нь хариулт өгье. Харин заншсан ёсоос зөрж хоёрдугаар асуултаас нь эхлэн хариулъя. Яагаад гэвэл энэ асуултыг хариулахад арай амархан юм. Би банкны эзний тасалгааны эдгүй сэтгэгдэлтөрүүлэх байдал ба нөлөөнөөс зайлсхийж зочдын өрөөг шилж авсан юм. Хэдийгээр алтадсан боловч кассын дэвтрүүд, хамжлагын үеийн хаалга шиг түгжээтэй байдаг шүүгээнүүд, ханаас ч авдаг нь мэдэгдэхгүй зээллэгийн билетүүд Англи, Голланд, Испани, Энэтхэг, Хятад, Перугээс ирсэн овоолготой захидлууд энэ бүхэн эцгийн минь сэтгэл санаанд хачин нөлөө үзүүлж, энэ дэлхий дээр албан тушаал ба итгэмжлэгчдийн нь саналаас өөр илүү чухал ариун гэгээн юм гэж байдгийг мартуулах юм. Тийм учраас би ээжийн баяр цэнгэлтэй инээмэглэсэн зураг, бас олон янзын сайхан байгалийн зураг дүүжлээстэй байдаг зочдын өрөөг сонгож авсан юм. Би гадаад сэтгэлдлийн хүчинд их итгэдэг. Ялангуяа таны тухайд тэгж боддог юм. Би ташаарч байж ч болно. Өөр яах вэ? Би зарим нэг хий дэмий юмыг үзүүлж байхгүй бол жүжигчин хүн байж чадахгүй шүү дээ.
- Маш сайн гэж Данглар энэ үргэжилсэн яриаг чагнаж байгаад хэллээ. Гэвч өөрийн бодолдоо автан, охиныхоо санааг таах гэж оролдож байсан учир түүний яринаас юу ч ойлгоогүй ажээ.
- Тэгэхлээр бид хоёр, хоёрдугаар асуултыг ямар нэг хэмжээгээр шийдвэрлэлээ гэж Эжени өчүүхэн ч зовохгүйгээр түүний яриа ба хөдөлгөөнийг ялгаруулдаг эрэгтэй хүний биедээ итгэсэн байдалтайгаар хэлээд – Та миний тодорхойлолтыг сонсоод бүрэн хангагдсан юм шиг санагдаж байна. Одоо нэгдүгээр асуултад эргэж оръё. Би тантай уулзах гэж зөвшөөрөл авсан. Тийм учраас би танд хоёрхон үгээр хариулъя. Би Андреа Кавальканти гүнтэй суух дургүй байна.

Данглар сандлаасаа ухасхийн бослоо.

- Би таны гайхаж байгааг харж байна гэж Эжени мөн л тайван байдлаараа үргэлжлэн хэлээд – Миний саналыг асуугаагүй хүмүүсийн санаа зоригийн эсрэг хэрэгтэй цагт нь эрс шийдвэртэй эсэргүүцэж чадна гэж итгэж байсан учир энэ гэрлэлтийн тухай ярьж байх үед ганц ч үгээр татгалзаагүй байсан билээ. Энэ удаад миний тайван идэвхгүй байдал гүн ухаантнуудын ярьдгаар өөр эх үндэстэй байсан юм. Би эцэгтээ хайртай, дуулгавартай охины ёсоор... \Охины улаан уруул дээр хөнгөн инээмсэглэл тодорно\ таны хүсэлд захирагдах гэсэн юм гэлээ.

- Тэгээд яагаа вэе гэж Данглар асуухад,

- Харин би бүх чадлаараа хичээж байсан боловч одоо цагийг нь болоод ирэхээр хичэн чармайсан ч дуулгавартай байж чадахгүй нь гэж Эжени хариуллаа.

Тэгэхэд нь Данглар төдий л ухаалаг хүн биш байсан учир охины хатуу үориг холыг харах ухаантайн тэмдэг болсон энэ учиртай үг, хайхрамжгүй байдлыг хараад бүр гайхчихжээ.

- Эжени чиний татгалзаж байгаагийн шалтгаан юу вэ? гэж асуулаа.

- Шалтгаан гэнэ ээ? Бурхан минь ! Андцра Кавальканти муухай, тэнэг, жигшмээр хүн биш л дээ. Эрэгтэйчүүдийг нүүр царай, биеийн нь хэлбэрээр үнэлэн дүгнэдэг хүмүүсийн нүдэнд бол нэлээд зүгээрт нь орж болох юм. Тэр ч байтугай миний зүрхэнд өөр хэнээс ч дооргүй бодогдож байна. Би хэнд ч дурладаггүйг эрхэм та мэлэх үү? Тэгээд ч ер нь онцын чухал хэрэгцээгүйгээр бүх л амьдралынхаа туршид нэг юм чирч явах хэрэг юу байна. Нэг мэргэн хүн “илүү юм огт үгүй нь дээр” бас нэг хүн “Өөрийнхөө юмыг өөрөө л авч явсан нь дээр” гэж хэлсэн байдаг. Тэр ч байтугай энэ хоёр сургаалыг надад латин грег хоёр хэлээр тогтоолгосон юм. Хэрэв би ташаараагүй бол энэ хоёр үгийн нэгийг нь Федр, нөгөөг нь Биант хэлсэн шиг билээ. Амьдрал гэдэг бол бидний найдвар горьдлогын мөнхийн уналт болохоор би энэ хэрэггүй зүйлийг замын хажуу уруу хаяж байгаа юм. Тэгээд л тэр. Би ганцаараа байх эрхтэй бөгөөд тэгэхээр өөрийн эрх чөлөөтэй байдлыг хадгална.

- Золгүй амьтан! Гэж Данглар бувтналаа.

Тэрээр зам дээр тохиолдсон энэ саад тотгор давшгүй болохыг туршлагаасаа мэдэж байжээ.

- Золгүй гэнэ ээ? гэж Эжени давтан хэлээд – Огтхон ч тийм биш! Таны энэ дуу алдаж байгаа чинь жүжигт гарч байгаа юм шиг дэндүү хиймэл байна. Харин ч би зол жаргалтай хүн. Надад юу дутагдаж байна хэлээч! Намайг хүмүүс сайхна зүс царайтай гэдэг. Энэ маань хаана ч аятайхан хүлээн авах боломжийг өгдөг юм. Намайг хүмүүс сайн сайхнаар хүлээн авахад бу дуртай бөгөөд талархлын царай бол тийм ч муухай юм биш шүү. Би тэнэг биш, юмыг ухааран авах чадвартай болохоор сармагчин самар хадгалж дотроос нь идээгий нь ваад илдчихдэг шиг би амьдралаас аль өөртөө хэрэгтэйг нь тунгаан авдаг. Та Францад хамгийн их хөрөнгөтэй хүний нэг болохоор би баян хүүхэн_. Би бол таны ганц охин, та ч бас жүжигт гардаг эцгүүд охиноо ач үр төрүүлж өгсөнгүй гэж үе залгамжлуулах эрхийг нь хасдаг шиг тийм зөрүүд хөшүүн хүн биш. Тэгээд ч бас урьдчилан хардаг

хууль та намайг хүчээр хүнтэй суулгах эрхийг чинь хассан адил надад өмч хөрөнгөө өвлүүлэхгүй байх эрхийг чинь хасаан билээ. Тэгэхээр гоо сайхан, ухаантай, авьяас билэгтэй, бас инээдмийн жүжигт гардаг шиг баян хүүхэн байна шүү дээ! Эрхэм минь, энэ чинь аз жаргал мөн биз дээ! Тэгэхэд та намайг золгүй амьтан гэж байдаг гэлээ.

Данглар охиныхоо бардам янзын инээмсэглэлийг тэсвэрлэж чадсангй дуугаа өндөр болголоо. Гэвч Эженийн асуусан харц, хар хөмсгөө гайхан зангидахыг нь хараад тэр доороо биеэ барьж номхров.

- Энэ бүгд үнэн. Нэг л юмнаас бусдаар чи яг хэлж байгаа шигээ тийм хүн, охин минь. Би тэр зүйлийг шууд хэлчихийг хүсэхгүй байна. Чамайг өөрөө тааж олбол дээр байх гэж бодож байна гэж инээмэглэн хэллээ.

Эжени толгой дээрээ бардмаар хатгасан сувдан чимэгний нь нэгийг хуурамч үзэж байгаагийн учрыг үл ойлгон гайхаж Данглар өөд харлаа.

- Чам шиг ийм охиныг хүнтэй суухаас татгалзуулж байгаа юм юу болохыг чи надад сайхан тайлбарлаж өглөө. Тэгэхээр одоо над шиг эцэг чамайг хүнтэй суулгах гэж зүтгээд байгаа ямар учир байгааг чамд хэлэх миний ээлж боллоо.

Эжени эцгийнхСэ үгийг дуулгавартай сонсдог дуулгавартай охины журмаар биш харин эсэргүүцэхэд бэлхэн байгаа хүний ёсоор мэхийн ёсоллоо.

- Эцэг нь охиноо хүнтэй суулгах гэхдээ энэ гэрлэлтийг хүсэх шндэс шалтгаан заавал байдаг. Зарим нь чиний саяын хэлсэн ач үрсийнхээ дунд амьдрахыг хүсдэг. Харин надад имй сул тал байхгүй гэдгийг шууд хэлье. гэр бүлийн баяр хөөр гэдгийг би төдий л хайхардаггүй_ Энэ хайхрамгүй байдлыг гэмт хэрэг гэж ойлгохооргүйгээр юмыг гүн ухааны үүднээс харж үздэг охиндоо гэж хэлж байгаа юм гэж Данглар цааш ярихад
- Маш сайхан хэрэг. Илэн далангүй яривал хамаагүй дээр дээ гэж Эжени хэллээ.
- Би чиний энэ дэндүү илэн далангүй байдалтай чинь санал нийцэхгүй ч гэсэн байдал ийм болсноос аойш бас л илэн далангүй ярья. Ингээд би цааш нь яриья. Би чиний аз жаргалыг бодож нөхөртэй суулгах гээгүй, би тэр минутад чиний тухай бага бодсон. Би илэн далангүй байгаа биз. Ашиг хонжооны талаас үзэхэд, чи тэр залуу хүнтэй даруй суух нь надад хэрэгтэй байна гэж Данглар хэллээ.

Эжени хөмсгөө өргөлөө.

- Ажил хэрэг миний чамд хэлж байгаагаар болж байна. Битгий уурлаарай, чи өөрөө буруутай. Би өөрийнхөө дур хүслээр энэ вэгүй сэтгэгдэл төрөхөөс айж, банкны эзний албан тасалгаанд орохоос айж байгаа жүжигчний авьяастай хүнтэй санхүүгийн тооцооны тухай ярихад хүрч байна.

Сар бүр чамд өгдөг мянган франкийг авах гэж чи миний тасалгаанд уржигдархан @рсон. Энэ тасалгаа бол хүнтэй суухыг хүсдэггүй залуу авхайд ч гэсэн их юм сургаж өгнө шүү. Жишээлбэл тэнд орсон хүн, банкны эзэнд зээллэг бол хүний биеийн хүнс гэсэн үг юм гэзгийг ойлгоно. Би энэ үгийг тасалгаандаа оруулж эвгүй сэтгэгдэл төрүүлэхгүйн тулд энэ зочдын өрөөнд хэлчихье.Амьсгал хүний биеийг сэргээн амьдруулж байдгийн адил зээллэг бол түүнийг дэмжин тэтгэж байдаг юм. Монте-Кристо гүн энэ талаар надад нэг лекц уншсаныг нь би хэзээ ч мартахгүй. Бас

тэр тасалгаанл зээллэг алга болохын хэрээр банкны эзний бие нь хүүр болон хувирахыг мэдэж болно. Тэгэхээр тун ойрхны вмыг ухаалгаар ухан боддог охинтой эцэг байх гавьяатай тэр банкны эзэнд ийм явдал тохиолдох гэж байна.

Эжений энэ цохилтын доор бөхийхийн оронд бадмаар нуруугаа эгцлэн,

- Та хоосорч байна уу! гэж хэллээ.
- Охин минь чи тун зөв нэрлэлээ гэж Данглар нударгаа зангидсан боловч хөрзгөр царайгаараа тэнэг хүний хаягтай биш ч санаа муутай хүний хорон инээмсэглэлээр инээмсэглэж – Тиймээ би хоосорлоо гэж хэлэхэд, Эжени,
- Өө тийм бий! Гэлээ.
- Тиймээ хоосорлоо! Яруу найрагч нарын хэдлгээр үхлийн нууц илэрлээ. Тэгэхээр охин минь чи энэ тохиолдож байгаа гай зовлонд миний төлөө биш, өөрийнхөө ямар тусламж үзүүлж чадахаа сонс.
- Та ер нь хүний сэтгэлийн зүйг муу мэдэх хүн юм. Энэ сүйрэлт миний сэтгэлийг зовоох юм гэж та санаж байх шив гэж Эжени хэллээ.
- Би хоосорлоо гэж үү? Энэ чинь надад ямар хамаабайа? Миний авьяас надад үлдэж байна. Би Паст, Млибран буюу Гризи нар шиг өөрөө өөрийгөө хангаж, таны баялаг надад хэзээ ч өгч чадахгүй жилд зуун тавин мянган алтан зоосны орлого олж байх болно. Үүндээ би хэний ч ачийг хариулна гэж бодож явахгүй шүү дээ. Тэгээд бас танаас авч байгаа энэ өчүүхэн арван хоёр мянган фкранийг үрэмтгий гэж зэмлүүлж муухай харуулж байж авахын оронд, би тэдгээр мөнгийг нижигнэсэн алга ташилтын доор цэцэг навчаар бүрхүүлэн байж авах болно, шүү дээ. Таны энэ үнэмшихгүй инээмсэглэж байгаа надад авьяас чадвар байдаггүй юм гэхэд энэ ертөнц дээр амь наснаасаа ч илүүгээр, эрдэнэс бүхнээс илүүгээр хайрлаж явдаг эрх чөлөөтэй, хэнээс ч хараат биш байдлыг хүсэх минь надад үлдэнэ шүү дээ.

Үгүй, би хувь заяандаа зовохгүй байна. Би өөрөө өөрийнхөө хувь заяаг хэзээ ч зохиож чадна. Надад миний номууд, харандаанууд, миний төгөлдөр хуур үлдэнэ. Энэ бүгд хямд үнэтэй учир олж авч чадна. Та намайг хатагтай Дангларын төлөө зовно гэж бодож байж магадгүй. Үгүй, би тэгэхгүй. Би хэрэв ташаараагүй бол хатагтай урьдчилсан бүх арга хэмжээнүүдмийг авсан. Танд тохиолдох гэж байгаа сүйрэл түүнийг хөндөхгүй. Тэр одоо бүрэн аюулгүй байдалд орсон. Энэ нь лав л миний төлөө санаа зовсноос тэгсэн хэрэг биш. Бурхан минь, миний эрх чөлөөтэй байх дуртай гэдгээр минь шалтаг барьж, миний амьдралд оролцдоггүй юм.

Үгүй, эрхэм минь, би бүр багаасаа орчин тойрондоо болж байгаа явдлуудыг харж байсан. Би бүгдийг дэнжүү сайн ойлгож байсан бөгөөд таны дампуурал надад ач тус болж байснаасаа илүү сэтгэгдэл төрүүлэхгүй. Би өөрийгөө мэдэх болсон цагаас хойш хэн ч намайг хайрлаж байгаагүй. Тэгэхээр би хэнд ч хайргүй байх нь зүйн хэрэг! Та одоо миний бодлыг мэдэв үү?

- Тэгэхээр чи намайг хоосорч гүйцэг гэж зүтгээд байна уу? гэж Данглар гомдсон эцгийн ёсоор биш харин хорссон байдлаар асуулаа.
- Хоосруулж гүйцэг гэнэ ээ? Би юу? ойлгохгүй байна гэж Эжени хэллээ.
- Энэ чинь надад итгэж найдах өчүүхэн сэжмийг өгч байгаа учир би их баярлаж байна. Чи миний хэлэхийг сонс.

- Би сонсож байна гэж Эжени эцэг өөдөө ширтэн харж хэлэхэд, цаадах нь охины захирангуй харцнаас далдирахгүйн тулд хүч гаргаж, биеэ барих хэрэгтэй боллоо.
- Завальканти ноён чамтай суухыг хүсэж байгаа бөгөөд тэгэхдээ миний дансанд гурван саяыг оруулахыг зөвшөөрч байгаа юм гэж Данглар цааш нь ярихада, Эжени бээлийгээ илж, жигшсэн байдлаар
- Их сайхан хэрэг байна даа гэж хэллээ.
- Чи намайг өөрийнхөө тэр гурван саяыг хэрэглэнэ гэж бодож байна уу? Үгүй шүү, тэр гурван сая арван хувийн орлого оруулна. Өөр нэг банкны эзэн бид хоёр төмөр замын концесс авахаар болсон юм. Энэ бол нэгэн цагт Лоу өөрийн зохиомол Миссипээр манай сайн санаат Парисынханд олж байсан шиг одоо манай үед асар их амжилт олж болох үйлдвэрийн ганц салар байгаа юм. Миний тооцоогоор бол Огайо голын эрэг дээрх атар газрын акрыг эзэмшиж байсан шиг төмөр замын саяны нэг хувийг л эзэмшвэл хангалттай гэж бодогдож байна. Энэ бол мөнгөө барьцаанд өгч оронд нь арван тав, хорь, зуун фунт төмөр авч байгаа болохоор дэвшилт юм. Өнөөдрөөс эхлээд долоо хоногийн дараа би өөрийн талаас дөрвөн саяыг оруулах ёстой! Энэ дөрвөн сая нь миний түрүүчийн хэлснээр арав арван хоёр хувийн орлогыг оруулна.
- Уржигдар би танай өрөөнд ороход та таван сая хагасыг хүлээн авч дансандаа оруулж байсан. Та миний орсныг сайн санаж байгаа шүү дээ. Тэр ч байтугай та, тэрхүү хоёр билетийг надад үзүүлээд намайг аянга цахилгаан адил гялбуулаагүйд их л гайхаж байсан шүү дээ гэж Эжени хэллээ.
- Тийм ээ энэ таван сая хагас чинь миний мөнгө биш, зөвхөн итгэл хүлээдгийн минь нотолгоо болж байгаа юм. Миний ардчилсан үзэл асрамжийн газрын захиргааны итгэлийг хүлээдэг бөгөөд тэр таван сая хагас тэдний мэдлийн мөнгө байгаа юм. Би өөр цагт бол тэдгээрийг юу ч бодолгүй хэрэглэж болох бөгөөд харин зээллэгээ алдаж их гарз хохиролтой байгааг минь бүхнээрээ мэдэх учир тгэж ашиглаж болохгүй. Асрамжийн газрын захиргаа тэр оруулсан мөнгөө дуртай цагтаа шаардаж мэдэх бөгөөд хэрэв би түүнийг нь гүйлгээнд оруулчихсан байвал өөрийгөө дампуурчихсан гэж зарлахад хүрнэ. Би дампуурлын эсрэг брш, харин пампуурал бол хоосруулах биш, баяжуулдаг байх ёстой. Хэрэв чи Кавальканти тэй суугаад би тэр гурван саяыг нь авах ч юм уу, үгүй ядахдаа түүнийг авах юм гэж хүмүүс бодвол миний зээллэг даруй сэргэх болно. Тэгвэл миний хөрөнгө бэхжиж, миний хөл доор ган цав гарч байгаа юм шиг санагдаад байсан муу ёрын бодол арилж чөлөөтэй амьсгалах болно. Чи миний хэлж бахйгааг ойлгов уу?
- Бүрэн дүүрэн ойлголоо. Та намайг гурван саяын барьцаанд өгөх гэж байгаа юм байна.
- Мөнгөний хэмжээ хичнээн их л бол энэ чинь төдийчинээ сайхан бахйх юм. Түүний хэмжээ чиний гүнийг тодорхойлж байгаа юм.
- Баярлалаа тэнд. Бас нэг үг хэлчихье. Харин та эрхэм Кавалькантийн үндсэн хөрөнгийг нь биш, оруулсан хөрөнгөнөөс нь ашиглахыг зөвшөөрч ам

өгөх үү? Би хувиа бодсоноосоо биш хүний юмнаас нарийлах үүднээс хэлж байгаа юм шүү. Би таны хөрөнгийг сэргээн өөд татахад туслахыг зөвшөөрнө. Харин бусад хүмүүсийг хохироулах явдалд чинь хань хамсаатан болж чадахгүй шүү.

- Би энэ гурван саяын чинь тусламжтайгаар...
- Та тэр гурван саяд гар хүрэлгүйгээр энэ байдлаасаа мултран гарч чадах уу?
- Хэрэв энэ гэрлэлт болж бүтвэл би тэгж болно гэж найдаж байна.
- Та надад инж болгож өгөх тэр таван зуун мянган франкийг Кавалькантид өгч чадах уу?
- Та хоёрыг хотын захиргаанаас ирмэгц Кавадльканти тэрхүү мөнгийг хүлээн авах болно.
- За сайн!
- За сайн гэдэг чинь юу гэсэн үг вэ?
- Энэ бол би гарынхаа үсгийг өгөөд өөрөө биеэ мэдье гэсэн үг.
- Тэгэлгүй яахав.
- Тэгвэл сайн. Би эрхэм танд, эрхэм Кавалькантий суухад бэлхэн байгаагаа илэрхийлье.
- Энэ бол миний нууц. Би таны нууцыг мэдчихээд өөрийнхөө нууцыг илчилчихвэл юугаараа танаас давуу байх билээ?

Данглар хөмхийгөө зуулаа.

- Чи тэгвэл албан ёсоор орж хэлэх айлуудаар явахыг зөвшөөрч байна уу? гэж асуухад
- Тийм ээ гэж Эжени хариуллаа.
- Бас гурав хоногийн дараа гэрээнд гарын үсэг зурахыг зөвшөөрөх үү?
- Тийм ээ.
- Тэгвэл би бас өөрийн ээлжинд чамд, за сайн гэж хэлье.

Тэгээд Данглар охиныхоо гарыг атгалаа.

Харин ингэж гар барихдаа эцэг нь “Чамд баярлалаа” гэж хэлэхгүй, охин нь эцэгтээ инээмсэглэх ч үгүй нь хачирхалтай.

- Бидний хэлэлцээр дуусав уу? гэж Эжени босож хэллээ.

Данглар өөр ярих юмгүй хэмээн дохилоо.

Таван минутын дараа мадмуазель д.Армилийн гар доор баян хуур хөгжим эгшиглэж, мадмуазель Данглар Брабанцио Дездемоныг зүхэн дуулдаг дууг дууллаа.

Дөнгөж дуулж дуусмагц Этьен орж ирж морьд бэлхэн болж хатагтай түүнийг хүлээж байна гэж Эженид айлтгалаа.

Хоёр авхай Вильфорын очсон ба дараах айлуудаар очихоор хэрхэн гарсныг бид дээр дурдсан билээ.

19.ГЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

Бидний энэхүү өгүүлэн буй явдлаас гурав хоногийн дараа мадмуазель Эжени Данглар, банкны эзний ноён гэж нэрлэх дуртай Кавалькантийн хооронд гэрлэлтийн гэрээнд гарын үсэг зурахаар тогтоосон өдөр боллоо. Оройн таван цагийн орчим болж байсан бөгөөд Монте-Кристогийн байшингийн өмнөх цэцэрлэгт моддын навчис сэнгэнэсэн элхэнд сэржгэнэнэ. Гүн явах гэж морьд туурайгаараа газар цавчлан,

арван таван минцут хэртэй хүлээн сууж байгаа хөтөч тэдгээрийг арай ядан тогтооно. Энэ үед бидний хэдэн удаа дайралдсан, тэр ч байтугай Отейльд болсон дайллага дээр ч ирсэн гоё сайхан хөнгөн сүйх хаалгаар давхин орж ирж, түүн дотроос вангийн гэр бүлтэй хүж барих гэж байгаа юм шиг гялалзсан сайхан царайтай болсон Андера Кавальканти буух ч биш үсрэн гарч ирлээ.

Тэр гүнгийн эрүүл мэндийг ердийнхөө задгайдуу зангаар лавлаад, хоёрдугаар давхрын шатаар хөнгөхнөөр гүйн гарч тавцан дээр өөртэй нь дайралдав.

Орж ирсэн хүнийг хараад гүн зогслоо. Харин Кавальканти эрч авсан байсан тул түүнийг юу ч зогсоож чадсангүй.

- Сайн байна уу, эрхэмсэг гүнтэн? Гэж Монте-Кристорд хэллээ.

Тэгэхэд цаадах нь ердийн ёжтой байдлаараа

- Өө, эрхэм Андера юу! За ямаршуу байна даа? гэж хэллээ. Маш сайн. Танд хэлэх өчнөөн юм байна. Харин юуныб өмнө та явах гэж байгаа буюу ирж байгаа алигн болохоо надад хэлж өгнө үү?

- Явах гэж байна.

- Тэгвэл танл саад болохгүйн тулд таны сүйх тэргэнд суугаад явъя. Харин Том биднийг дагаад явна биз.

Тэгэхэд гүн энэ залуутай хамт явж байж хүмүүсийн нүдэнд харагдахгүйг хүсэх учир үл мэдэгдэм жигшсэн байдлаар инээмсэглээд,

- Үгүй, би эрхэм Андреа таны ярихыг эндээ байжэ байгаад сонсвол дээр гэж бодож байна. Таны яриаг замаас нь сонсчих хөтөч байхгүй гэрт яривал илүү тохирожтой Үайх болно гэлээ.

Тэгээд гүн хоёрдугаар давхрын зочдын жижиг өрөөнд орж сандал дээр хөлөө ачин сууж зочноо мөн суухыг урилаа.

- Өнөөдөр гэрлэх ёс гүйцэтгэнэ гэдийг та дуулсан биз гэж Андреа тун ч баясгалантайгаар хэлээд

- Өнөө орой есөн цагт хадмынд гарын үсэг зурна гэлээ.

- Өө тийм бий! Гэж Монте-Кристо хариуллаа.

- Яалаа гэнэ ээ, та дуулаагүй байсан юм уу? Данглар танд цаг дуулгаагүй байсан гэж үү?

- Яалаа гэж, би өчигдөр түүнээс захидал авсан. Харин танд цаг заагаагүй байсан шиг санагдаж байна.

- Тийм байж магадгүй. манай хадам хүмүүсийг мэдэж байгаа гэж бодсон юм байлгүй.

- За яах вэ, эрхэм Кавалькантид баяр хүргэе. Сайхан гэр бүл болно доо. Тэгээд ч бас мадмуазель Данглар тун ч муугүй царайтай хүн гэж Монте-Кристо хэлэхэд,

- Тийм шүү гэж Андреа Кавальканти даруухан байдлаар хариу хэллээ.

- Хамгийн гол нь тэр бүсгүйн маш баян. Би тэгж л сонссон юм гэж Монте-Кристо хэлэв.

- Та түүнийг их баян бүсгүй гэж бодож байна уу?

- Эргэлзэх юмгүй. Данглар хөрөнгөнийхөө хагасыг нуудаг юм гэж ярьцгаах юм билээ.

- Өө тэр өөрөө бол арван тав, хорин саяын хөрөнгөтэй гэж хэлдэг юм байна билээ гэж Андреа баярлан нүд нь гялалзан хэллээ.

- Түүнээс гадна тэр Нэгдсэн улс, Англид нэлээд ердийн заншил болсон боловч Францад цоо шинэ зүйл болох нэг мөнгөний ажиллагаа хийх гэж байгаа гэнэ билээ гэж Монте-Кристо нэмж хэлэв.
 - Тийм ээ мэднэ, та саяхан түүний хүлээн авсан төмөр замын концессын тухай ярьж байна уу?
 - Чухам тийм. Олны бодож байгаагаар бол тэр энүүгээрэс дор хаяж арван саяыг хожих юм бхйх.
 - Арван сая ий! Та тэгж бодож байна уу? Энэ бас сайхан хэрэг дээ! гэж Кавальканти алтны тухай ярихад алтан зоосны дуу чихэнд нь хангинах шиг болж хэллээ.
 - Энэ бүх хөрөнгө танд ногдох болно гэдгийг хэлээд ч яах вэ. Мадмуазель Данглар түүний ганц охин болохоор бүр ч зүйн хэрэг. Бас таны өөрийн чинь хөрөнгө, эцгийн чинь надалд ярьснаар болзоот хүүхнийхээ хөрөнгөнөөс тун ялихгүй бага шүү дээ. За яах вэ, энэ мөнгөнийхөө яриаг орхиё. Эрхэм Андера, та энэ хэргийг тун түргэн чадамгай амжуулчихлаа шүү.
 - Тиймээ, муугүй шүү. Би ер нь төрөлхийн дипломат хүн шүү гэж Андреа хэллээ.
 - Та дипломат болно доо. Дипломатыг сурдаггүй юм, төрөлхийн сэрэхүй хэтэгтэй байдаг.... Тэгвэл таны зүрх баривчлагдаж дээ.
 - Тэгсэн л байх гэж айж байна хэмээн Андреа Францын театрын тайзан дээрээс Дорнат буюу эсвэл Валер хоёр альцестэд хариулдаг шиг хариуллаа.
 - Танд бас хариугий нь өгч л таарна биз дээ?
 - Надтай сууж байгаа хойно тэгэлгүй яах вэ гэж Андреа хэлээд их л дийлсэн байдалтай инээмсэглээд
 - Гэвч нэг гол чухал зүйлийг мартаж болохгүй гэлээ.
 - Ямар?
 - Миний энэ хэрэгт ер бишийн туслалцаа үзүүлсэн тухай.
 - Тэр яах вэ?
 - Эргэлзэх юмгүй.
 - Ямар?
 - Үгүй, та өөрөө шүү дээ.
 - Би юу? Боль доо ноён гуай гэж Монте-Кристо хэргэмээр нь онцлон дуудаад – Би танд тус болох юу хийж чадах билээ? Таны нэр, таны нийгмийн байдал хувийн чёнь нэр төр хангалттай байсан гэж үү? Гэв.
 - Үгүй, гүн та юу ч гэж хэлсэн бил дээдсийн хүрээлэнд эзэлж байгаа байр суурь тань миний нэр, нийгмийн байдал, хувийн нэр төрөөс илүү юм хийсэн гэж баталсаар байх болно гэж Андреа хариулав.
- Тэгэхэд Монте-Кристо түүний үгэн дэх зальтай шинжийг мэдэрч,
- Эрхэм та гүнээ ташаарч байна. Би таны хүндэт эцгийн баялаг хөрөнгө, эрх ямбыг мэдсэний дараа таныг дэмжих болсон билээ. Тантай танилцсандаа би хэнд баярлах ёстой вэ? Би таныг, таны нэр төртэй эцэг эхийг үзээгүй байсан. Миний хоёр найз Лорд Уилмор лам БУзони хоёрт л баярлах ёстой. Таныг батлан даах биш, харин дээдсийн хүрээлэнд оруул

гэж намайг юу шаардав? Италид ихэд нэрд гарч хүндэтгэгдэх болсон эцгийн тань л нэр намайг тэгж шаардсан юм.

Гүн тайван чөлөөтэй байх нь Андреад өөрийг нь хүчтэй гараар барьж, энэ бахинаас тийм ч амархан мултрахгүй юм шиг санагдаж байв.

- Гүн гуай, миний аав үнэхээр тийм баян юм уу? гэж асуухад
- Тийм байх гэж Монте-Кристо хариуллаа.
- Миний Дангларт оруулах мөнгө хүрч ирсэн үү?
- Мэдэгдэл бичгийг нь хүлээн авлаа.
- Тэгэхээр гурван сая....
- Замд л ирж яваа бололтой.
- Би түүнийг хүлээж авах уу?
- Танд өгөх ёстой бүхнийг та одоо хүртэл авсаар байсан шүү дээ гэж гүн хариуллаа_

Андреа минут хэртэй бодлогошрон их гайхлаа. Хэсэг дуугүй байснаа,

- Тэгвэл би танд нэг юм хэлэх хэрэгтэй болж байна. Миний энэ хэлэх зүйл танд эвгүй санагдлаа ч гэсэн та миний хэлэх үгийг ойлгох байх гэж итгэж байна гэхэд,
- ХСл, хэл гэж Монте-Кристо хэллээ.
- Би хөрөнгө чинэСнийхээ ачаар олон хүнтэй танилцаж одоо бөөн найз нөхөдтэй боллло. Би Парисын дээдсийн хүрээлэнгийн өмнө, ингэж гэр бүл болохдоо нэр, алдартай хүнийг түших хэрэгтэй байна. Хэрэв намайг шүтээний өмнө аваачих болбол эцгийн минь гар биш, харин тэр хүний хүчирхэг гар хөтөлж аваачих ёстой байна. Миний аав ирэхгүй шүү дээ тийм ээ?
- Тэр чинь хариугүй бие муутай, аян замд жуулчлан явахаар хуучин шарх нь өвдөж зовоодог юм.
- Ойлголоо. Тэгэхээр би танаас нэг юм хүсье.
- Надаас уу?
- Тийм ээ, танаас.
- Бурхан минь, юу тэр вэ?
- Түүнийг минь орлож өгөөч.
- Эрхэм минь яалаа гэнэ ээ? Та надтай олон удаа ярилцсан боловч, миний занг мэдэхгүй учраас надаас ийм юм хүсэж байх юм даа. Тэрүүн дорхноо надаас хагас сая франк зээлүүл гэж хэлбэл чинь ийм зээлдэлт олон тохиолдохгүй ч гэсэн намайг тавгүй байдалд оруулахгүй дэ. Би танд Монте-Кристо хэдийгээр эндхийн нийгмийн амьдралд оролцож байгаа ч гэсэн итгэж заншсан Дорнодынхоо заншлыг хэзээ ч мартдаггүй юм, гэж хэлэх байна. Надад Каирт, Смирнэд, Константинопольд охидын хүрээлэн бий. Би эцгийг чинь орлож хэрхэвч чадахгүй.
- Тэгэхээр та татгалзаж байна уу?
- Эрс татгалзаж байна. Та миний хүү ч байсан% дүү ч байсан ялгаагүй би танд татгалзах байсан.
- Ямар бүтэлгүй хэрэг вэ? гэж гунихарсан Андреа дуу алдаад, - Тэгээд би яах вэ! гэв.
- Та өөрөө өчнөөн төчнөөн найз нөхөд бий гэсэн шүү дээ.

- Тийм ээ, тэгсэн ч та намайг Дангларын гэрт оруулж өгсөн шүү дээ.
- Огтхон ч үгүй! Баримтыг сэргээж үзье л дээ. Та тэдэнтэй хамт Отейльд манайд хоол идсэн, тэгээд та өөрөө тэдэнтэй танилцсан шүү дээ. Энэ чинь их том ялгаа байгаа биз.
- Тийм ээ харин намайг эхнэр авахад... та тусалсан...
- Би юу? Өчүүхэн ч үгүй. Таныг өөрийнхөө нэрийн өмнөөс Дангларын охиныг гуйж өгөөч гэж ирэхэд чинь би танд юу гэж хариулсныг санаад үз л дээ. Хонгор ноён минь, би хэзээ ч ямар ч гэрлэлт зохион байгуулдаггүй. Энэ бол миний зарчим байгаа юм.

Андреа уруулаа хазаж,

- Та өнөөдөр тэнд очих уу? гэж асуулаа.
- Тэнд бүх Парис очих уу?
- Мэдээж хэрэг!
- Тэгвэл би ч бас очно гэж гүн хэллээ.
- Та гэрлэлтийн гэрээнд гарын үсэг зурах уу?
- Надад түүнээс зөрөх юм юу ч алга. Миний заншил итгэл тийм хол үргэлжилдэггүй.
- Одоо яая гэх вэ. Та илүү зөвшөөрөхгүй гэж байгаа бол таны энэ зөвшөөрсөн зүйлээр ч хангагдаж дээ. Гүн танд, бас нэг үг хэлчихье.
- Болно, болно.
- Надад зөвлөгөө өгөөч.
- Энэ чинь тоглоом биш шүү. Зөвлөгөө гэдэг чинь тус хүргэхээс илүү юм байгаа юм.
- Та надад тийм зөвлөгөө өгч болно. Энүүдн танд хүлээх ямар ч үүрэг ногдохгүй.
- Хэл л дээ.
- Миний эхнэрийн инж таван зуун мянган ливртэй тэнцэх үү?
- Энэ тоог түшээ гүн Данглар өөрөө хэлж байсан.
- Би түүнийг өөрөө авах уу, нотариуст үлдээх үү?
- Заншсан заншил нь ийм байдаг юм. Гэрээнд гарын үсэг зурах үед хоёр нотариус хоорондоо маргааш нь буюу нөгөөдөр нь уулзахаа^о тохирдог юм. Тэд энэ уулзалт дээр хоёр талын инжийг солилцож өгөөд тус бүр гар»н үсэг зурж, ёс гүйцэтгэсний дараа энэ бүх мөнгийг өрхийн тэргүүлэгчийн хувьд танд өгнө дөө.
- Манай хадам бидний хөрөнгийг таны саяын ярьсан тэр гайтай төмөр замынхаа концесст оруулах гээд байгаа бололтой шиг болохоор нь тэгж асууж байгаа юм гэж Андреа сэтгэл зовсноо муухан нууж хэллээ.
- Тэгэхэд яах вэ! Улсын ярьдгаар энэ аргаар таны хөрөнгө нэг жилийн дотор гурва дахин нэмэгдэнэ шүү дээ. Данглар гэдэг чинь сайн эцэг, юмыг тооцон үзэж чаддаг хүн шүү.
- Тэгвэл та гуйлтыг минь үл зөвшөөрөн сэтгэлийн гүнд ортол гоморхуулснаас бусад нь маш сайхан боллоо гэж Андреа хэллээ.
- Түүнийг иймэрхүү юман дээр хэн бүхэнд байж брлох биеэ зайлах сэтгэлээс өөр юу ч биш гэж бод.
- За яах вэ, таныхаар болог. Орой болтол баяртай! Гэж Андреа хэллээ.

- Баяртай.

Монте-Кристогийн царайсан уруул нь инээмсэглэж байсан боловч мэдэгдэм дургүйцэхийг нь хайхралгүй, Андреа гүнгийн гарыг барьж авч атгаад хөнгөн мүйх тэргэндээ сууж давхин одлоо.

Андреа орой болтол үлдсэн хугацаандаа үүгээр түүгээр явж найз нөхдөдөө банкны эзнийд очих хүсэл төрүүлэхийн тулд одоохнодоо Дангларын гарт байгаа боловч ойрын саруудад бүхний толгойг эргүүлэх шидэь акцийнхаа тухай ярьж явлаа.

Оройн найман цаг хагаст ёслолын өрөө ба түүний залгаа зочдын өрөө, бас энэ давхрын хоёр зочдын өрөө талархах гэж ирэхээсээ ямар нэг шинэ сонин юм олж үзэх байх гэж их хүсэлд автагдсан зочдоор дүүрсэн байв.

- У°илгын үдэшлэг бол тогтворгүй эврээхий, өлсгөлөн зөгий, жингэнэлдэх ялааг өөртөө татдаг цэцгийн цоморлиг гэж Академийн гишүүн хэлэх байсан биз.

Зочдын өрөөнүүдэд олон лаа асааж, алтадсан сийлбэр, өнгөлсөн хана гэрэлд гялалзах боловч ая нийцийг нь тохируулаагүй нь зөвхөн баян чинээлгийг илтгэн нүд гялбуулж байсныг хэлэх юун.

Мадмуазель Эжени энгийн сайхнаар хувцаслажээ. Цагаан цэцэг хатгамалсан цагаан даашинз, тас хар үсэндээ цагаан сарнай цухуйлгасхийн шигтгэж гоёсон нь түүний бүх гоёо бөгөөд нэг ч үнэт эрдэнэсээр чимээгүй ажээ. Өөрөө инээдэмтэй, хуурамч гэж үздэг охин хүний энэхүү хувцас нь хязгааргүй биеэ тоосон харцад нь зохиогүй гэлтэй.

Түүнээс хэдхэн алхмын зайтай газар хатагтай Данглар, Дебрэ, Бошан Шато-Рено нартай ярилцаж зогслоо. Дебрэ энэ баярт өдрийг тохиолдуулан энэ байшинд орж ирсэн боловч ямар ч эрх ямбагүй ердийн зочны ёсоор иржээ.

Депутат, санхүүгийн ямбатнуудаар хүрээлүүлсэн Данглар засгийн газар өөрийг нь сайд бол гэж зайлшгүй урих цагт явуулах татварын шинэ системийнхээ тухай саналаа ярьж байв.

Андреа Операд байнга очигчдын нэг хээнцэр залууг сугдан жилд зуун далан таван мянгын орлоготой хөрөнгийг эзэмшихээрээ Парисын дээдсийн хүрээлэнд заншил болгон оруулах хээнцэр дэгжин байдлын тухай бодлоо задгайдуу байдаотайгаар ярьж байв. Хүнд инээдтэй эвгүй харагдахгүйн тулд ийнхүү задгай зайдан байхад мүүрдэг ажээ.

Зочдын бусад хэсэг нь өнгө бүрийн эрдэнэс гялалзуулан зочдын өрөөнөөс нөгөөд нь дамжин явцгааж байв.

Хэзээнйхээрээ натай авгайчуул сүржин гоёсон бөгөөд тэнэг хүүхнүүд олны өмнө гоц харагдах гэж маяглана. Харин гоо сайхан цагаан лянхуа буюу анхилуун үнэрт саргай цэцгүүдийг альё гэвэл чалма хэмээх ороолт малгай өмссөн эхийнх нь буюу диваажингийн шувуу гэгчээр чимэглэсэн авгай эгчийнх нь араар эрэх хэрэгтэй ажээ.

Энэ үймээн шуугиан дудн, зарц нар байн байн дэлхийд алдартай санхүүгийн эрхтэнгүүд, цэргийн хүндэт хүмүүс утга зохиолын нэрт хүмүүсийн нэр хашхирах нь дуулдаж, зочид шинээр ирсэн хүнтэй уулзаж золгоно.

Зраим нэрс нь, энэ хүнэн тэнгисийг долгилуулан давалгаалуулж байхад, зарим нэрийг нь хэлэхэд хүмүүс хайхрахгүй буюу жигшиж ярвайн угтана.

Нойрсож байгаа Эндимионы дүрстэй алтан тоотой цагийн зүү ес болсныг зааж, түүний нарийн чанд санааг илэрхийлэгч хонх есөн удаа дуугарах тэр үед, Монте-Кристо гүнгийн нэр дуулдаж хүмүүс цахилгаанд цохиулсан мэт үүд рүү эргэн харцгаав.

Гүн ердийнхөө заншлаар хар франк өмсжээ. Цагаан хантааз нь түүний өргөн цээжийг чавхайлгаж, хар зах нь улам ч хар юм шиг харагдаж, эрэлхэг цагаан царайг нь улам дотруулна. Түүний хэрэглэж яаа ганц үнэт зүйл болох цагийн гинжин оосор нь цагаан хантааз дээр нь алтан утас мэт зурайн харагдахаар тийм нарийхан ажээ.

Тэрхэн зуур үүдий дэргэд хүмүүс цугларав.

Зочдын өрөөний нэг буланд хатагтай Данглар, нөгөө буланд нь Данглар, хаалганы өөдөөс харж Эжени зогсож байхыг харуй ажиглав.

Эхлээд хатагтай Вильфортой хамт зогсож байгаа хатагтай Данглар дээр очиж мэндлэв. Валентинагийн бие сайн илааршаагүй байсан тул хатагтай Вильфор ганцаараа ирсэн байжээ. Гүн даарө нь зам тавьж өгсөн олны дундуур гарч тэнд зогсож байсан Эженитэй хуурай, хямсгар байдлаар мэндлэхэд бардам зантай жүжигчин бүсгүй гайхаж орхижээ.

Түүний дэргэд Луиза д Армильи зогсож байв. Тэр бүсгүй Тиалид явахад, тэндхийн зохих хүнд танилцуулах захидал бичиж өгсөн явдалд баярласнаа хэлээд, удахгүй явах санаатай байгаагаа дуулгав.

Тэр охидуудтай мэндлээд эргэж харвал Данглар гар барихаар ирж явлаа.

Монте-Кристо бүр шаардагдах ёсыг гүйцэтгээд, тодорхой хүрээлэхнгийн ялангуяа тодорхой жингийн хүмүүсийн онцлог болсон царайгаар “Би хэрэгтэй бүхнийг хийлээ. Харин одоо хүмүүс миний тухайд гүйцэтгэх юмаа гүйцэтгэг” гэсэн мэт зогслоо.

Зэргэлдээ зочдын өрөөнд байсан Андреа хүмүүсийн хөдөлгөөний байдлаар Монте-Кристо гүн ирснийг мэдэж уулзахаар яаран алхлав.

Түүнийг очиход гүн олон зочноор хүрээлэгдсэн байв. Цөөн үгтэй, тэр мөртөө огт хэрэггүй дэмий юм ярьдаггүй хүний үгийг хүмүүс анхааралтай сонсдогийн адил гүнгийн үгийг хүмүүс ихэд шимтэн чагнаж байв.

Энэ үед баталгааны газрынхан орж ирж гэрээнд гарын үсэг зурахад бэлтгэсэн алтадсан модон ширээ бүтээсэ хилэн бүтээлэг дээр бичиг цаасуудаа дэлгэн тавилаа.

Хоёр нотариусын нэг нь сууж, нөгөөх нь зогсоно.

Тэгээд тэнд байгаа хүмүүс өөрөөр хэлбэл Парисын хагас хувьд нь гарын үсэг зурах гэрээг уншиж сонсголоо.

Бүх хүмүүс, үнэнээр нь хэлбэл эмэгтэйчүүд тойрон сууцгааж, Баулогийн хэлснээр “хурц байдлыг” ойшоон үздэггүй эрэгтэйчүүд Андреагийн сэтгэл ихэд хөдөлсөн, Данглар бодлогоширсон, Эжени огтхон ч зовсон шинжгүй, хатагтай дангларын урьдынхаа адил хөнгөн хийсвэр, хөгжилтэй байгааг шүүмжлэн ярилцаж байв.

Гэрээг уншихад хүмүүс цөм чимээ аниргүй байв. харин гэрээг дөнгөж уншиж дуусмагц зрчдын өрөөнүүдэд урьдынхаасаа хоёр дахин чанга яриа шуугиан дэгдлээ. Ирээдүйн хосыг гялалзуулж буй энэ мөнгөний хэмжээ, олон сая фррак, бас түүн дээр тусгай өөөнд үзэсгэлэн болгон тавьсан сүйт бүсгүйн инж очир эрдэнэүүд атаач олны гижгийг хөдөлгөлөө.

Хүүхнүүдийн тухайд гэвэл тэд сая сая хөрөнгөнд атаархах боловч өөрсдийн гоо сайхныг мөнгөнөөс илүүд үзэж байв.

Андреа найз нараараа хүрээлүүлж баяр хүргэж, тал засах үгсийг сонсож энэ зүүдээ үнэхээр үнэн болох нь гэж итгэж эхлэн толгой нь эргэжээ.

Батлагч баяр ёслолын байдлаар үзгээ гартаа авч, толгой дээрээ өргөөд,

- Ноёд оо гарын үсэг зурах ажилдаа орцгооё гэж хэллээ.

Эхлээд түшээ гүн, дараа нь эцэг КавальӨантийн онц эрхт төлөөлөгч, дараа нь хатагтай Данглар, дараа нь гэр бүл болж байга хоёр гарын үсэг зурах ёстой байв.

Түшээ гүн үзэг авч гарын үсэг зурлаа. Дараа нь онц эрхт төлөөлөгч гарын үсэг зурлаа.

Хатагтай Данглар хатагтай Вильфортой хөтөлцөн очоод үзэг авч, нөхөртөө,

- Найз минь яасан муу хэрэг вэ. Монте-Кристо гүнгийн арай л алагдаж, талагдчихаагүй тэр гэнэтийн явдлаас болоод эрхэм де Вильфор манайд ирж чадсангүй гэж хэлэхэд Данглар “Надад огтхон ч хамаагүй” гэсэн байртай,

- Ай, бурхан минь! гэлээ.

Монте-Кристо тэдний дэргэд очин,

- Түүний ирээгүй явдлын буруутан нь би болох бий гэж айж байна гэж хэлэхэд хатагтай гарынхаа үсгийг зураад,

- Гүн та юу? Яагаад тэр билээ? Хэрэв тийм бол болгоомжтой байгаарай.

Би хэзээ ч таныг уучлахгүй шүү гэв.

Андреа сэрдхийв.

- Гэхдээ би үнэндээ түүнд хамаагүй л дээ. Энэ хамаагүй гэдгээ та нарт нотольё гэж гүн хэлэв.

Монте-Кристо ярьж эхлэхэд хүмүүс чих тавин чагнав. Түүний ярих нь төдий л олон тохиолдохгүй билээ.

- Манайхыг талах гэж ороод гарахдаа өөрийн хамсаатанд алагдсан өнөөх золгүй амьтан манай гэрт үхсэнийг та нар лав санаж байгаа байх гэж гүн чимээ аниргүй зогссон олны дунд хэлэхэд

- Тийм ээ гэж Данглар хариулав.

- Түүнд туслах гэж хувцсыг нь тайлаад өрөөний буланд хаячихсан байсныг мөрдөн байцаах газрын хүмүүс аваачсан билээ. Тэд цамц өмдийг нь аваад харин хантаазыг нь мартчихжээ.

Андреа мэдэгдэм зэвхийж үүд рүү сэм дөхөж эхлэв. Тэрээр тэнгСрийн хаяанд аянгын хар үүл гарч ирснийг харж, тэнгэр ниргэх бий гэж болгоомжилжээ.

- Гэтэл өнөөдөр тэр гайтай хантааз нэл цус бол-ихсон, зүрхнийхээ тус газар цоорхойтой олдлоо.

Авгайчуул дуу алдан хашхирч, зарим нь бүр ухаан алдаж ойчих гэж бэлтгэлээ.

- Тэгээд надад авчирчээ, энэ новш хэнийх болохыг хэн ч тааварлан мэдэж чадсангүй. Харин ганцхан миний толгойд өнөөх алагдсан хүнийх байх нь гэж бодогдлоо. Гэнэт миний даамал тэрхүү бузар хантаазны хармаанд нэгэн бичиг байхыг тэмтрэн гаргаж ирэв. Энэ бол захидал байлаа. Та хэнд хаягласан захидал байсан гэж бодож байна? Түшээ гүн танд шүү,

- Надад уу? гэж Данглар дуу алдлаа

- Тийм ээ танд. Цус болсон цаасан дээр таны нэр байсныг би гаргаж уншсан гэж Монте-Кристо гайхан дуу алдахын хажуугаар ярив.
- Тэгээд тэр хэрэг яагаад эрхэм Вильфорын ирэхэд саад болдог билээ? гэж хатагтай Данглар асуугаад нөхөр өөдөө зовсон байдалтай харав.
- Хатагтай минь, тун амархан хэрэг. Энэ хантааз, захидал хоёр бол эд мөрийн баримтууд мөн. Би тэгээд хоёуланг нь вангийн прокурорт хүргүүлсэн. Эрүүгийн хэрэгт хууль ёсоор нь гүйцэтгэх явдал хамгийн чухал байдаг юм. Таны эсрэг ямар нэг хорт санаа агуулагдсан юм биш байгаа даа гэж Монте-Кристо хэлэв.

Андреа, Монте-Кристо өөд ширтэн харснаа, хоёр дахь зочдын өрөөнд орж нуугдав.

- Тун ч магадгүй шүү. Тэр алагдсан хүн хуучин ялт хөдөлмөрийн хэрэгтэн байсан юм гэл үү? Гэж Данглар хариуллаа.
- Тийм ээ, Кадрусс гэдэг нэртэй ялтан б йсан гэж гүн хариуллаа.

Дангларын царай бага зэрэг зэвийж, Андреа хоёр дахь зочдын өрөөнөөс гарч үүдний өрөөнд орлоо.

- За та юунд гарын үсэг зурахгүй байна вэе гэж Монте-Кристо асуугаад, - Миний яриа бүхний сэтгэлийг хөдөлгөчих шиг боллоо. Хатагтай, мадмуазель Данглараас уучлахыг гуйя гэлээ.

Хатагтай гарынхаа үсгийг дөнгөж зурж дуусаад үзгээ батлагчид өглөө.

- Кавальканти ноён гэж батлагч дуудаад – Кавальканти ноён та хаа байна вэ? гэлээ.
- Андреа, Андреа гэж нэрт итали залуутай найзархаж, нэрээр нь дуудах болсон хэдэн залуу хүмүүс хашхирав.
- Ноёыг дуудаач, түүний гарын үсэг зурахыг хүлээж байна гэж түүнд айлтгаач! Гэж Данглар нэг зардцаа хашхиран хэлэв.

Гэтэл яг тэр үед тасалгаан дотор аймшигт мангаж идэш эрэн орж ирэх мэт, гол зочдын өрөөнд байсан хмүүүс айн хуйларлаа.

Нээрээ чайж сандарч хашхирахаар юм байсан ажээ.

Цагдаагийн дарга зочдын өрөөний хаалга бүр дээр хоёр хоёр цагдаа зогсоож, комиссарын араас Дангларыг чиглэн явлаа.

Хатагтай Данглар дуу алдан хашхираад ухаан алдан уналаа.

Данглар өөрийнхөө төлөө айсан учир зарим хүний сэтгэл хэзээ ч төвшин байдаггүй юм\ зочдодоо айсан царайгаа харууллаа.

Монте-Кристо комиссарын өөдөөс нэг алхаж,

- Эрхэм танд юу хэрэгтэй сэн бол? гэж асуулаа. Тэгэхэд цагдаагийн комиссар гүнд хариу хэлэлгүйгээр,
- Эрхмүүд ээ, та нарын хэн чинь Андреа Кавальканти гэдэг вэ? гэж асуулаа.

Зочдын өрөөн дэх хүмүүс нэгэн зэрэг дуу алдан хашхиралдав.

Тэгээд хүмүүс хаачив ийчив гэж бие биесээ асууцгааж эхэллээ.

- Тэр Анд^оеа Кавальканти гэдэг чинь хэн гээч хүн байна даа? гэж гайхаж орхисон Данглар асуув.
- Тулоноос оргосон ялт хөдөлмөрийн ялтан хүн.
- Тэр ямар гэмт хэрэг хийсэн юм бэ?

- Тэр бол өөрийн нөхөр Кадрусс гэгчийг Монте-Кристо гүнгийнхээс гарч ирэхэд нь алсан хэрэгт татагдаж байгаа хүн гэж комиссар ажиг ч үгүй хариу өгүүллээ.

Монте-Кристо түргэн гэгч эргэн тойрон харлаа.

Андреа алга болчихжээ.

20. БЕЛЬГИ ОРОХ ЗАМ

Дангларын гэрт цагдаагийн дарга ирж, тэрхүү явдлыг хэлсний дараа тэнд байсан хмүүүс тарваган тахал дэлгэрснээс илүү хурдан тарж, уужим шилтгээн түргэн зуурын дотор хоосорлоо. Зочид хоёр хааога ба бүх шатаар сандран гарч одлоо. Энэ бол их гай тохиолдоход хамгийн санй найз нөхрөөсөө дуулахад ч хэцүү байдаг, тийм тайвшруулах үг хэлэх хэрэггүй байдаг тохиолдлын нэг байлаа.

Бүх л байшинд ганц Данглар үлдэж тасалгаандаа орж хаалгаа түшжээд цагдаагийн даргад мэдүүлэг өгч байв. Айж сандарсан хатагтай Данглар бидний мэдэх жижиг өрөөндөө байв. Эжени салшгүй найз охин Луизатай хамт бардмаар жигшсэн янзтай явж өрөөндөө орлоо.

Олон тооны зарцын тухай гэвэл тэд өнөөдөр улам ч олон болж баярт өдрийг тохиолдуулан мөхөөлдөс худалдаачид, Кафе-ке-Парийн тогооч нарыг урьж ирүүлсэн байсан тул өөрсдийгөө гомдоолоо гэж гал тогооны өрөөнд цуглран шуугилдаж, аяндаа зогссон үйлчилгээгээ анхаарахгүй шахам байв.

Хамгийн олон янзын сэтгэгдэл төрсөн эдгээр олон янзын хүмүүсийн дотроос зөвхөн хоёр хүн бидний анхаарлыг татна. Энэ бол Эжени Данглар, Луиза д Армильи хоёр юм. Бидний дээр хэлснээр сүйт бүсгүй жигшсэн ихэмсэг байдлаар зайлж явахад найз бүсгүй нь түүний хойноос улам ч илүү сандран тэвдэж даган явлаа. Эжени өрөөндөө орж ирээд хаалгаа цоожлоход Луиза зөөлөн сандал дээр очиж суулаа.

- Ай, бурхан минь, ямар аймшигтай юм бэ? Хэн тэгж бодох билээ? Андреа Кавальканти гэдэг чинь мэхлэн хуурагч, яргачин.... Оргодол ялтан.... юм байжээ! Гэж Луиза хэлжээ.

Ингэж хэлэхэд нь Эжени дооглосон маягтай ярвайв.

- Намайг нэг л муу ёр дагаад байна аа! Морсероос арай гэж салтал Кавалькантитай тохиолдчихлоо гэж түүний хэлэхэд,
- Эжени чи тэр хоёрыг зэрэгцүүлж үзэж байгаа юм уу? гэж асуув.
- Дуугүй бай, эрэгтэй хүн бүхэн зальхай амьтад, харин би одоо тэднийг зөвхөн үзэн ядагч биш, бас жигшиж болох болсондоо баяртай байна.
- Тэгээд одоо бид яах вэ? гэж Луиза асуув.
- Яах вэ гэнэ вэ?
- Тийм ээ.
- Гурав хоногийн дараа хийх гэж байсан тэр юмаа л хийнэ... Бид одоо явна.
- Хурим хийхгүй болсон ч гэсэн чи бас явах уу?
- Луиза чи дуулж бай. Би манай нотны цаас шиг хэмжээ дамжаатай, хэв ёстой энэ дээдсийн хүрээлэнгийн амьдралыг үзэн ядаж байна. Миний үргэлжид хүсэж эрмэлзэж байсан зүйл бол жүжигчний амьдрал өөрөө өөртөө ач тус хариулахаас биш өөр хэнд ч найдахгүй эрх чөлөөт амьдрал

юм. Энд үлээх гэнэ ээ? Яах гэж тэр билээ? ‘арын дараа бас л хүнтэй суулгах ар өгөг гэж үлдэх хэрэг үү?

Хэнтэй суух вэ? Дебрэд өгч магадгүй. Энэ тухай бас нэг үе яриад авсан юм. Үгүй, Луиза, үгүй, Өнөөдөрийн болсон явдал надад сургамж боллоо. Би үүнийг эрж сураглаж, хүсэж гуйгаагүй, харин бурхан өөрөө надад илгээж, би түүнд нь баярлаж байна.

- Чи ямар их зоригтой хүн бэ! гэж эмзэгхэн биетэй шар үстэй охин, хар үстэй найз охиндоо хэллээ.
- Чи намайг мэдээгүй байсан юм гэж үү? За тэр ч яах вэ. Ажил явдлынхаа тухай ярья. Ингэхэд аяны сүйх тэрэг...
- Аз болоход гурав хоногийн өмнө худалдааж авсан.
- Чи нөгөө газартаа очихыг тушаасан биз дээ?
- Тэгсэн.
- Аа бидний паспорт?
- Энэ байна!

Эжени ердийн хайнга байдлаараа баримт бичгээ дэлгэн үзэж: “Эрхэм Леон д Армиль, хорин настай, зураач, хар үстэй, хар нүдтэй, хоин дүүтэйгээ жуулчилж яваа” гэж уншлаа.

- Маш сайн! Чи яаж паспорт олоо вэ?
- Би Монте-Кристо гүнээс Ром ба Неаполийн театрын захирлуудад итгэмжилсэн захидал бичиж өгөөч гэж гуйхдаа түүнд эмэгтэй хүний хувцастай явахаасаа айж байна гэж хэлсэн юм. Тэр надтай санал нийлж надад эрэгтэй хүний паспорт олж өгөхийг амласан юм. Тэгээд хоёр хоногийн дараа энэ паспортыг авч дээр нь “охин дүүтэйгээ жуулчилж яваа” гэж нэмж бичсэн юм.
- Тэгвэл бид хоёр юмаа бэлтгэхээс өөр юм үлдээгүй шив. Хуримын үдэш явахын оронд гэрээдн гары үсэг зурах орой л яваа биз. Өөр юм алга гэж Эжени баяртай хэлэв.
- Эжени минь сай бодоорой.
- Надад өөр бодоод ба©х юм байхгүй. Испанийн фонд, га©тийн зээллэг, дээшиллээ, доошиллоо гэдэг мөнхийн яриаг сонсох залхуутай байна. Харин үүний оронд эвэр агаар, эрх чөлөө шувуухайнуудын жиргэх, Ломбардын тал, Венецийн суваг, Ромын ордон харш, Неаполийн эргийг харж явбал дээр байхгүй юу. Бидэнд хэчнээн мөнгө байна?

Луиза цоожтой бичгийн ширэнээс түрийвч гарган ирж, түүн дотор зээллэгийн билет хорин гурван ширхэг байхыг үзээд,

- Хорин гурван мянган франк байна гэж хэллээ.
- Мөн энэ хэмжээний үнэд хүрэх сувд, очир, алмас, алтан эдлэл бий. Бид хоёр баян охид шиг хоёр жил, дүүрэн амьдралтай гурван жил амьдарч чадна. Бид хагас жил ч бололгүй урлагаараа энэ хөрөнгөө хоёр дахин өсгөнө. Тэгэхээр чи мөнгөө барьж, би эрдэнэсээ барья. Хэрэв бид хоёрын нэг маань хөрөнгөө гээчихвэл нөгөөд маань тал нь үлдэнэ. За одоо юмаа бэлтгэе гэж Эжени хэлэв.
- Байг гэж Луиза хэлээд хатагтай Дангларын үүд рүү харсан хаалганы дэргэд очиж чагнав.

- Чи юунаас айсан юм бэ?
- Биднийг гэнэт бариад авбал яана.
- Хаалга цоожтой байгаа шүү дээ.
- Биднийг онгойлго гэж тушааж болох юм.
- Тушаавал тушааж л байг. Бид онгойлгож өгөхгүй.
- Чи ёстой зоригтой хүн юмаа, Эжени,
Тэгээд хоёр бүсгүй замд хэрэгтэй гэсэн юмаа чемодануудад хийж эхлэв.
- За гүйцлээ гэв.

Намайг хувцсаа сольж өмсөж байх хооронд чи чемоданаа хаачих гэж Эжени хэлэв.

Луиза хамаг хүчээ гаргаж булбарайхан цаг ан гараараа чемоданы амыг хаахад дарав.

- Би чадахгүй нь миний хүч хүрэхгүй байна. Чи өөрөө хаа гэж охин хэлэхэд Эжени инээж,
- Би Геркулес, чи минь хөөрхий Омфала гэдгийг мартчихаж ч дээ гэснээ шөрмөслөг цуагаан гараараа чемоданы хоёр талыг нийлтэл хүчлэн дарлаа. Луизаа ч цоожлоод авав. Эд бүгдийг хийсний дараа Эжени замын дулаан нөмрөгөө гаргаж,
- Харж байна уу. Би бүх зүйлийн тухай бодсон. Чи ийм нөмрөгтэй явахад даарахгүй гэж хэллээ.
- Чи өөрөө яах болж байна?
- Би даардаггүйг чи мэднэ шүү дээ.

Тэгээд бас миний энэ эрэгтэй хүний хувцас...

- Чи эндээ хувцсаа солих гэж байна уу?
- Тэгэлгүй яах вэ.
- Амжих уу?
- Аймхай хулчгар минь битгий ай. Гэрт байгаа хүмүүс саяын будлианд автчихаад байгаа. Түүнээс гадна намайг өрөөндөө ороод түгжчихэд хэн ч гайхахгүй. Би чинв ихэд гунихарч зовсон хүн байх ёстой!
- Тимй ээ, нээрээ зовхогүй байж болох юм.
- За алив, надад туслаарай.

Тэгээд өнөөх нөмрөг гаргаж ирсэн шүүгээнээсээ гутлаас эхлээд цахлай цамц хүртэл бүрэн бүтэн эрэгтэй хүнд хэрэгтэй хувцас гаргаж ирэв. Дараа нь Эжени эрэгтэй хүний хувцас нэг биш удаа өмсөж байсны шинж болсон шалмаг байдлаар гутал, өмдөө өмсөж, зангиа зүүж, хантаазаа точдон нарийхан гоолиг бичеийг нь барьсан сюртук өмслөө.

- Ямар сайхан зохиж байна вэ. Нээрээ их сайхан зохиж байна шүү! Харин хүүхэн хүний атаархдаг энэ сайхан гэдгээ яаж эрэгтэй хүний бүрх малгай дор далдлах юм бэ? гэж Луиза түүн өөд бахдан харж хэлэв.
- Чи харнаа гайгүй гэж Эжений хэлээд зүүн гартаа баштаж ядсан гэзгээ атгаж баруун гараараа хайч шүүрэн авч, өнөө сайхан үсэнд нь ган хайч шаржигнаж, хувцсан дээрээ унагаахгүй гэж гэдийсэн охины хөлний дэргэд бөөн бөөнөөрөө уналаа.

Дараа нь Эжени чамархайныхаа үсийг хайчилж хаяв. Ингэхдээ огтхон ч хайрласан шнижгүй, харин даиврхай мэт гялалзсан хар нүд нь урьд урьдынхаасаа улам ч тод гялалзаж байв.

- Ээ, хайран үс! Гэж Луиза харамсан дуу алдлаа. Тэгэхэд Эжени өөрийн богинохон буржгар үсээ илбэж,
- Энэ нь дуу адхни дээргүй гэж үү? Ингэчхээр улам сайхан болохгүй гэж үү? Гэлээ.
- Чи бол гоо сайхан охин, хэзээ ч ямар ч байлаа гэсэн гоо сайхан хүүхэн! Харин одоо бид хаашаа явах вэ? Гэж Луиза дуу алдлаа.
- Чи л дургүйцэхгүй бол Брюсель ч орсон яах вэ. Энэ бол хамгийн ойрхон байгаа хил. Бид Брюсель, Льеж, Аахеныг дайрч Рейн голоор өгсөж Страсбург хүрээд Швейцариар дайрч Сен-Готараар бууж Итали хүрнэ. Чи үүнийг зөвшөөрөх үү?
- Тэгэлгүй яах в.
- Чи намайг яагаад хараад байгаа юм бэ?
- Чи ийм байхад их гоё юм. Хүн яамайг намайг хулгайлаад явж байгаа байх гэж бодож болно.
- Чөигө ав, тийм л юм чинь!
- Эжени, чи бас харааж сураадхаж дээ?

Тэгээд бусад хүмүүсийн бодлоор бол, нэг нь өөрийнхөө төлөө, нөгөө нь найз охиныхоо төлөө улийж унжиж байвал зохих ёстой хоёр бүсгүй инээлдэж, эмх замбараагүй болгосон юмныхаа ул мөрийг арилган эмхэлж цэгцэлж эхлэв.

Даара нь оргох гэж байгаа хоёр бүсгүй гадагшаа хашаа руу харсан нууц шат руу харсан хаалгыг нээж лаагаа унтраагаад ийш тийшээ харж, чимээ анир чагнав. Нжени чемоданыхаа нэг бариулаас барьу түрүүлэн явахад Луиза нөгөө бариулаас нь хоёр гараараа арай гэж өргөн явав. Хашаан дотор хоосон байв. Шөнө дцнд болж цаг цохилоо. Хаалгач унтаагүй байлаа. Эжени сэмээрхэн урагш алхан, хүндэт манаач зөөлөн сандал дээрээ үүрэглэж байхыг хараь. Тэгээд Луиза дээрээ хүчр ирээд газар тавьсан чемоданаа дахин өргөж хана даган явлаа. Хэрэв хаалгач харвал нэг л хүн харагдахаар Луизаг сүүдрээр явуулж, Эжени өөрөө гэрэлд шууд тусахаар ил гарч явлаа.

- Онгойлгоорой! Гэж бүсгүй хаалганы шил цохиж хашхирав.

Эжений бодсоноор хаалгач сандлаас босож ямар хүн гарч байгааг харах гэж хэд алхав.

Тэгээд гарах гэж яарсан бололтой нарийхан таягаараа гутлаа тогшиж байгаа залууг хараад яаран хаалганы оосрыг татав. Хаалга онгоймогц Луиза сэмхэн гарч Эжени гаднаа тайван боловч зүрх нь ердийнхөөс түргэн цохилж, мөн гадагш гудамжинд гарлаа_

Тэр хоёр чемоданаа хажуугаараа өнгөрсөн хөлсний зөөгч хүнд үүрүүлж өөрсдөө хойноос нь дагаж явав. Тэр хүнд Виктуар гудамжны 36 дугаар байшин гэдэг хаяг өгөөд, ханьтай бослон учир Луиза сэтгэл тайван байв. Харин Эжений тухайд гэвэл, энэ бүсгүй Юдифь, далила шиг айхыг мэдэхгүй хүн байв.

Очих б йшиндаа хүрч ирээд үүрэгч хүндээ чемаданыг газар тавиых тушаагаад хөлсийг нь өгч цонхны хаалга тогшиж, хүргэж ирсэн хүнээ явуула.в

Оргодол хүүхнүүдийн ирсэн байшинд нэгэн даруухан, дотуур хувцас оёгч хүүхэн суудаг бөгөөд урьд нь ярилцаж тохирсноор унтаагүй хүлээж байгаад даруйхан хаалга тайлж өгөв.

- Мадмуазель, та хаалгачийг саравчин дотроос мүйх тэрэг гаргаад, шуудангийн станц дээр очиж морь авчир гэж хэлээдхээч. Энэ таван франкийг хөлс нь гээд өгчихөөрэй гэж Эжени хэлэв.
- Би чамайг бахархаж, тэр ч байтугай хүндэтгэхэд хүрч байна гэж Луиза хэлэв.

Нөгөө оёдолчин хүүхэн тэднийг гайхан харсан боловч, өөрт нь хорин луидор өгнө гэж амласан болохоор юу ч хэлсэнгүй.

Арван таван минутын дараа хаалгач, хөтөч ба морьд авчирч, тэр доор нь хөллөөд чемоданыг тэрэгний ард даруулж уяв.

- Залуу эзэн минь, ямар замаар явах сан бол? гэж хөтөч асуув. Тэгэхэд Эжени бараг эрэгтэй хүний дуугаар,
- Фонтенблогийн замаар гэж хэлэхэд,
- Яалаа гэнэ ээ? Чи юу ярьж байна гэж Луиза асуув_
- Би мөрөө баллах гэсэн юм. Бидний хорин луидор өгсөн энэ хүүхэн маань биднийгээ дөчин луидороор худалдаж мэднэ. Модот гудамжнуудад хүрэхээрээ өөр замаар явахыг тушаана гэж Эжени хэлэв.

Тэгээд бүсгүй гишгүүр дээр бараг хүрэлгүй сүйх тэргэнд суув. Луиза найзынхаа хажууд суугаад,

- Чиний хэлдэг бас л зөв юм гэлээ.

Арван таван минутын дараа хөтөч, Эжений заавраар чигээ өөрчилж, ташуураа тачигнуулан дуугаргаж Сен-Мартений харуулыг өнгөрөн гарав.

- Бид ашгүй нэг Парисаас гарлаа даа! гэж Луиза тайвширсан янзтай санаа алдан хэлэхэд,
- Тэглээ, хайрт найз минь, хүүхэн хулгай хийсэн явдал маань амжилттай боллоо гэж Эжени хариулав.
- Тийм ээ, гэхдээ хүч хэрэглэлгүйгээр шүү гэж Луиза харуулав.
- Энэ бол ял бурууг зөөлрүүлэх нэг зүйл гэж хариуллаа.

Энэ үг Ла-Вилетийн зам дээгүүр давхиж явсан сүйхэ тэргэний дугнуй чимээн дунд замхран алга боллоо.

Данглар ийнхүү охингүй боллоо.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

1. “ХОНХ, ЛОНХ” ХЭМЭЭХ ЗОЧИД БУУДАЛ

Мадмуазель Дангларыг найз охины нь хамт Брюсельийн зам дээр орхиод, аз жаргалын төлөө нисэх замд нь саад тохиолдон баларсан хөөрхий Андреа Кавальканти юу болсныг эргэж үзье.

Энэ Андреа Кавальканти хэдий бага залуу хүн боловч зэгсэн зальтай ухаалаг хүн ажээ.

Тийм ч учраас зочдын өрөөнд хөдөлгөөн орж эхэлмэгч үүд рүү дөхөж хоёр тасалгаа өнгөрч алга болсныг бид мэдэх билээ.

Бид, орхиж болохгүй нэгэн бяцхан зүйлийн тухай өгүүлэхээ мартжээ. Кавалькантийн дайрч гарсан хоср тасалгааны нэгэнд инж хэмээгдэх хайрцагтй очир эрдэнэ, кашимир даавуу алчуур, англи даавуу ер нь зөвхөн нэрсийг нь хэлэхэд охидуудын зүрхийг донсолгох зүйлс байв.

Андреа энэ тасалгаагаар өнгөрөхдөө зөвхөн зальтай, ухаалаг болохоо харуулаад зогсохгүй бас ирээдүйг харагч хүн болохоо харуулж, тэнд тавьсан эрдэнийн чулууны дотроос хамгийн томыг нь аваад гарчээ.

Андреа ингэж бэлтгэлтэй болж аваад, улам ч бие нь хөнгөрснөө мэдэрч, цонхоор харайн цагдаа нараас зайлж одлоо.

Эрт цагийг тамЁрчин шиг булчин шөрмөслөг биетэй Андреа арай баригдчихаагүй зайлсан газраасаа аль болох холдох гэж хашааа явж байгаага ч мэдэхгүй гүйж явав.

Залуу Мон Блан гудамжнаас эргэж, туулайг үүрэнд нь, хулгайчийг хотын зах уруу аваачдаг сэрхүйгээр удирдуулан явсаар Лафаэт гудамжны адагт хүрлээ.

Хамаг биеийн нь хөлс гоожин амьсгаадан зогслоо.

Цор ганцаараа байв. Зүүн талд нь Сен-Лазарын тал цэлийж баруун талд нь аварга Парис сүндэрлэж байв.

- Би ингээд өнгөрлөө гэж үү? Үгүй шүү, би дайснаасаа илүү хүч гаргавал баригдахгүй. Миний аврагдах эсэх хоорондох зайнаас л шалтгаалах болно гэж бодож явав.

Тэгтэл Пуассоньероос явж байгаа хөлсний тэргийг олж харав. Амандаа гаанч зуусан уруу царайтай хөтөч Сен-Дени орох гэж яваа бололтой

- Хүүе найз аа! гэж Бенедетто дуудахад
- Та юу тушаах сан бол? гэж хөтөч асуулаа.
- Таны морьд ядарсан уу?
- Ядрах ий? Яалаа гэж трэ вэ! Бүтэн өдрийн турш юу ч хийсэнгүй. Дөрөвхөн удаа явж цайны хорин сүү, бүгд долоон франк олсон, үүнийхээ арвыг нь эзэндээ өгдөг ёстой.
- Долоон франк дээрээ бас хорин франк нэмэхийг хүсэх үү?
- Дуртай байлгүй яах вэ, хорин франк гэдэг чинь багч юм биш дээ. Тэгээд би юу хийх ёстой болж байна?
- Хэрэв таны морьд эцээгүй бол амархан ажил даа.
- Би танд түүнийг салхин мэт хурдан давхина гэж хэлсэн шүү. Харин чух м хаашаа явахыгаа л хэл.
- Луврийн тийш явна.

- Би мэднэ ээ, жимсний нэрмэл хийдэг газар.
- Чухам тийм. маргааш Шапелен-Сервальд ан хийх гэж болзсон нэг найзыгаа гүйцэх гэсэн юм. Тэр намайг өөрийхөө тэрэгтэй арван нэг хагас хүртэл энд хүлээх ёстой байсан юм. Одоо арван хоёр болж байгаа болохоор хүлээж залхаад ганцаараа яваад өгсөн юм байх.
- Тэгсэн байж таарна.
- За тэгвэл түүнийг гүйцэх гэж оролдоолд үзэх үү?
- Тэгье.
- Хэрэв бид түүнийг Бурж хүртэл гүйцэхгүй л бол та хорин франк авах болно. Хэрэв Лувр хүртэл гүйцэхгүй бол гучийг авна.
- Аа хэрэв гүйцчихвэл яах вэ?
- Дөчийг гэж Андреа хэлээд хэсэг бодсоноо ингэж амласнаар юу ч алдахгүй юм гэж шийдлээ.
- Тохирлоо! Суугтун! Гэж хөтөч хэлэв.

Андреа хөлсний тэргэнд сууж Сен-Депийг өнгөрөн Сен-Мартеныг туулж, Ла-Вилегийн хязгааргүй талд орлоо.

Сайхь үлгэрийн найзыг гүйцнэ гэдэг амаргүй байв. Гэсэн ч оройтсон зарим нэг зорчигчид ба хаагаагүй байсан замын гуанзнуудаас Кавальканти ногоон сүйх тэрэг асууж сурагласаар явсан бөгөөд Нидерландын замаар арван сүйх тэрэг явахад ес нь ногоон өнгөтэй байдаг учир алхам бүрд нь л хариу дуулдана.

Тэрхүү сүйх тэргийг хүн бүр л үзсэн байх бөгөөд таван зуу, хоёр зуу эсвэл зуун алхмын урьд явж байсан гэх боловч арай гэж гүйцээд очихоор өнөөх тэрэг нь биш байдаг байлаа.

Нэг удаа тэднийг өөрсдийг нь нэгэн сүйх тэрэг гүйцэж түрүүлээ. Энэ бол хос морь хөллөсөн шуудангийн ±йх тэрэг байв.

“Надад л энэ сүйх тэрэг байгаасай. Хос сайн морьтой, хамгийн гол нь шуудангийн тэрэг байвал сайн сан” гэж Кавальканти бодлоо.

Тэгээд гүнээ санаа алдав.

Энэ бол мадмуазель Данглар, Д Армиь хоёрын явж байсан сүйх тэрэг байв.

- Хурдал, хурдал! Одоо бид түүнийг гүйцэх дөхөж байх ёстой гэж Андреа хэлэв.

Хөөрхий морь дахин хар хурдаараа давхиж, харуулаас Лувр хүрч иртэл хөөс сахруулан хөлөрч орж ирэв.

- Бид найзаа гүйцэхгүй дэмий л морийг чинь зовоочихлоо. Тэгэхлээр би эндээ үлдсэн нь дээр боллоо. Энэ таны гучин франк, би өөрөө “зээрд морь” гэдэгт хоноод хамгийн түрүүнд ирсэн шуудангийн тэргэнд суудал авч цаашаа явъя даа. За найз минь сайхан нойрсоорой гэж Андреа хэллээ.

Тэгээд Андреахөтчийн гарт тав таван франкийн зургаан зоос атгуулаад үсрэн буув.

Хөтөч баяртайгаар мөнгөө хармаалаад, Парисын зүг гэлдрүүлэн явав. Андреа “Зээрд морь” зочид буудал руу очих гэж байгаа дүр үзүүлээ. Тэгээд хаалган дээр нь зогсож тэрэгний дугуйн чимээ сонсож байгаад, цааш тамирчин хүн гиг алхаж бас хоёр бээр газар явав.

Тэгээд зогсож амарлаа. Тэр өөрийн очих гэж явсан Шапелан Сервальд ойрхон ирсэн бололтой санагджээ.

Андера Каюальканти ядарсандаа зогссон биш, харин ямар нэг шийдвэр гаргаж, төлөвлөгөө хийх хэрэгтэй болжээ.

Аяллын тэргэнд сууж болохгүй, шуудангийн сүйх тэрэг хөлсөлж бас болохгүй байв. Эдгээрийн алинаар нь ч явахад паспорт хэрэгтэй.

Ихэр нэртэй, илүү сайн хамгаалагдсан Уазын мужид хоцорч болохгүй гэдгйг эрүүлгийн хууль сайн мэдэх бэлсон Андера юу андах аж.

Андреа сувгийн ирмэг дээр суугаад хоёр гараараа толгойгоо түшиж бодлогошрон суув.

Тэгээд арван минут хэр болоод толгойгоо өндийлгөв. Нэгэн зүйлийг шийдвэрлэжээ.

Тэрээр үүдний өрөөнөөс авч, цахлай цамцан дээрээ өмсөж амжсан пальтогоо шороо болгоод, Шاپелан Серваль хүрч тэндхийн ганц зочид буудлын хаалгыг цохив.

Эзэн нь түүнд хаалгаа онгойлгож өгөв.

- Найз минь, би Морфонтенаас Санлис орох гэж дан морьтой явж байтал морь маань бусгаж, намайг хаячихлаа. Би өнөө шөнө Компьень орохгүй бол манай гэр бүл зовох болно. Танайхаас морь олодхо уу? гэж Андреа асуулаа.

Аль ч буудлаас сайн муу ямар ч морь олдоно.

Буудлын эзэн адууныхаа хүнийг дуудаж, Буурлыг эмээллэхийг тушаагаад энэ эрхэмсэг хүнтэй сундлан явж морио буцааж авчрах ёстой гэж долоон настай хүүгээ сэрээв.

Андреа буудлын эзэнд хорни франк өгөв. Мөнгөө гаргахдаа хармаанаасаа нэрийн хуудас унагажээ.

Түүний унагасан нэрийн хуудас бол Кафе-де-парид наргидаг найз нарынх нь хуудас бөгөөд буудлын эзэн Андреаг явсны дараа авч үзээд, морио Мен-Доминик гудамжны 25 дугаар байшинд суудаг Молеон гүнд өгчээ гэж мэдэв. Энэ бол нэрийн хуудсан дээр байсан овог хаяг байв.

Буурал нь хурдан биш боловч жигдхэн хатируулна. Андреагурван цаг хагас яваад Компьенаас есөн бээр холджээ. Тэрэг зогсдог талбайд орж ирэхэд дөрвөн цаг болж байв.

Компьенед ганц удаа буусан хүн ч мартдаггүй нэг сайхан зочид буудал бий.

Андреа, Парисын ойролцоо явж байхдаа энэ зочид буудалд нэг хоносон юм санжээ. Андреа “Хонх, лонх” буудлыг санаж талбай өөд харж, зам заасан хаягийг олж харлаа. Тэгээд хармаанаасаа байсан бүх завгай мангийг жаал хүүд шавхаж өгөөд одоо өөрт нь дөрдөн цагийн зай байгаа болохоор сайн хоол идэж, бөх унтаад явах нь зүйтэй гэж шийдээд хаалгыг нь цохив.

Зарц түүнд хаалга онгойлгож өгөв.

- Би Сен-Жан-л-Буагаас ирлээ. Тэнд өдрийнхөө хоолыг илсэн. Тэгээд шөнө дунд өнгөрдөг шуудангийн тэргэнд суух гэсэн боловч тэнэг амьтан шиг дөрвөн цаг ойд төөрчихлөө. Надад хашаа руу харсан нэг тасалгаа өгч, тахианы хүйтэн дэгдээхий, шил дарс авчраарай гэж Андреа хэлэв.

Зарц юу ч сэжиглэсэнгүй. Андреа хармаандаа гараа хийж, амандаа янжуур зуу огтын тайван ярих ажээ. Дэгжин хувцастай сахлаа хусчихсан, гялалзсан гуталтай тэрээр яарч яваа хүний дүртэй ажээ.

Зарц түүнд өрөө бэлтгэж байх хооронд зочид буудлын эзэгтэй орж ирлээ. Андреа түүн өөд их л учиртайхан инээмсэглээд, сүүлчийн удаа Компьенид ирэхдээ хоносон гуравдугаар өрөөг өгөхгүй юу гэв. Гэтэл гуравдугаар өрөөнд охин дүүтэйгээ жуулчилж яваа залуу хүн орчихсон байсан нь харамсалтай.

Андреа их л харамссан боловч түүнд бэлтгэж байгаа 7-р өрөө нь, 3-р өрөөтэй яг адилхан байрлалтай болохыг сонсоод сая нэг тайвширчээ. Задгай зуухны дэргэд хөлөө ээж, Шантильд болсон сүүлчийн морин уралдааны тухай ярьж өрөө бэлхэн болсныг мСдэгдэхийг хүлээж суув.

Андреа хашаа руу харсан хаалгыг зүгээр ч санасан хэрэг биш байжээ. “Хонх” буудлын хашаа нь үзвэрийн тасалгаа мэт гурав үелсэн гудамлагтай, мэлрэг тарьсан зочид буудалд байж л болох үзэсгэлэнтэй сайхан хашаа байв.

Тахианы дэгдээхий нь шинэхэн, дарс нь хуучин, гал нь хөгжилтэйгээ тачигнан асаж байв. Андреа юу ч болоогүй юм шиг ийм дуртай идэж байгаадаа өөрөө ч гайхав.

Дараа нь хэвтэж, сэтгэл нь цэвэр биш ч гэсэн хорин настай залуу хүний унтдагаар дороо нойрсов.

Тэгээд ч бас Андреад сэтгэл зовох юмгүй байв.

Андреагийн их л итгэж найдаж байсан төлөвлөгөө ийм ажгуу.

Өглөө эрт үүрээр босоод зочид буудлаасаа гарч зохих ёсоор хөлсийг нь төлөөд ойд хэрч, зураг зурах гэдэг нэрийдлээр нэгэн тариачин хүний гэрт сууж, түлээчин хүний хувцас олж өмсөөд дээдсийн хүрээлэнгийн царайгаа ажилчин хүний байдлаар солих гэж шийджээ.

Дараа нь гараа борлож, тугалган самаар самнаснаас болж үс нь бараантаж, нүүр нь наранд түлэгдэхэд Тулонд байхад найз нөхдийнхөө зааж өгснөөр, өдөр нь гуу жалга шугуйд унтаж, үдэш нь явж хааяа нэг талх авахын тулд хүн амьтан суудаг газарт ойртож явсаар ойд хүрч ойр газраар хил давах ажээ.

Залуу хил давж гараад очир эрдэнээ мөнгө болгож, юмыг яаж мэдэх вэ гэж ямагт авч явдаг арваад зээллэгийн билетэндээ нийлүүлээд тавиад мянган ливртэй болох ажээ. Энэ мөнгө арга ядсан үед муу ч үгүй мөрөнгө болно. Түүнээс гадна Дангларынхан тохиолдсон золгүй явдлыг нуун дарахад бүхнийг хийнэ гэж шийджээ.

Андреа эрт босохын тулд цонхныхоо хаалтыг хаалгүй, харин хаалгаа дотроос нь түгжээд, урьд нь нэг бус удаа шалгаж үзсэн биеэсээ салгадаггүй авч явдаг хурц хутгаа ширээн дээр тавив.

Өглөөний долоон цагийн хэрд нүүрэн дээр нь нарын хурц дулаан илж тусаж Андреаг сэрээв.

Зөв ажиллаж байгаа уураг тархинд гол санаа бодол нь нойр нь сэрснээс сүүлд сэргэдэг билээ.

Андреаг бүрэн сэргэж амжаагүй байхад гол санаа бодол нь ажиллаж эхлэн, дэндүү их унтсаны нь хэлж байв. Орноосоо ухасхийн босоод цонх өөд гүйж очив.

Хашаан дотор нэг цагдаа явж байв.

Цагдаа гэдэг бол энэ дэлхий дээр хамгийн нүгэл хилэнцгүй хүмүүстч гэсэн содон харагддаг зүйл. Харин айх үндэс шалтгаан бүхий хүнд бол түүний хувцасны шар хөх, цагаан өнгө нь энэ дэлхий дээр хамгийн хорт муухай өнгө болж харагдана.

- Яагаад цагдаа байж байна вэ? гэж Андреа өөрөөсөө асуув.

Гэвч дороо эргэцүүлэн бодож,

- Зочид буудалд цагдаа ирэхэд хачирхах юм огт алга. Харин хувцсаа өмсөх болжээ гэв.

Тэгээд Парист хэдэн сар сууж зарцаар хувцаслуулахдаа мартаагүй байсан түргэн заншлаараа хувцаслав.

- За яах вэ, явахыг нь хүлээж байгаад яваад өгөхөөр нь алга болчихъё гэж Андреа хувцаслаж байхдаа бодож суув.

Ингэж бодоод дахин цонхоор болгоомжтойгоор харав.

Түрүүчийн цагдаа яваагүйгээр барахгүй дээр нь бас нэг хөх шар, цагаан өнгийн хувцас нэмэгдэн, гарах шатыг нь сахиж, гартаа буу барьсан морьт[®]й цагдаа гудамж өөд гарах ганц хаалгыг нь хамгаалан зогсож байв.

Энэ гурав дахь цагдаа хамгийн сүртэй нь байсан тул сонирхсон хүмүүс түүний өмнө хаалганы дэргэд шавааралдан зогсжээ.

“Намайг эрж байна даа. Ай, чөтгөр!” гэдэг бодол Андреад хамгийн түрүүн орж ирэв.

Царай нь зэвхийрч тайван биш байдлаар ийш тийшээ харав.

Тасалгаа нь энэ давхрын бүх тасалгаа шиг олны өмнө ил гудам руу харсан хаалгатай байв.

“Би өнгөрөв өө!” гэдэг бодол төрөв.

Нээрээ ч Андреа шиг болсон хүн баригдана гэдэг бол шүүх, ялын төлөвлөгөө, тэгээд үхэл гэсэн үг юм. Үхэл үхэлдээ бүр хайр найргүй үхэл юм.

Тэгээд татвагнан толгойгоо барив.

Энэ үедээ айснаас болж арай л галзуурчихсангүй.

Гэвч тархин дотор нь эргэцүллэн харвар, хэрэгтэй зүйл болох үзэ, бэх, цаас ширээн дээр байв.

Үзгээ бэхэнд дүрж, хүчээр гараа чанга барьж эхний нь хуудсан дээр дараах зүйлийг бичлээ.

“Надад тооцоо хийж төлөх бэлэн мөнгө алга. Гэвч би үнэнч шударга хүн. Оронд нь миний өрнөөс арав дахин илүү үнэд хүрэх зүүгээ барьцаалж орхив. Зугтаасан явдлыг уучлаарай. Надад ичгэвтэр байлаа шүү дээ” гэжээ.

Андреа зангианаасаа хавчаар зүү салган авч, бичсэн цаасан дээрээ тавив.

Дараа нь хаалгаа хааж түгжээтэй орхихын оронд гарахдаа хаахаа мартсан мэт нээлттэй орхиод задгай зууханд орж ийм ажилд дадсан хүний янзаар Ахилла Деидамий хоёрын зурагтай цаасан хаалтыг нь татаж хаагаад үнсэн дээрх мөрөө баллаж авралын ганц зам болсон яндангийн нүхээр дээш авирав.

Яг энэ үед Андреагийн анх харсан цагдаа комиссараа дагуулж шатаар өгслөө. Шатыг хоёр дахь цагдаа нь хамгаалж үлдэв. Тэрээр хаалга манаж байсан цагдаагаасаа дэмжлэг авч болох ажээ.

Андреа хэчнээн төвөгтэйгээр зайлсхийхийг хичээж явсан юм нь тохиолдох нь энэ ажгуу.

Парисын цахилгаан мэдээний газар өглөө эртээс ажиллаж, орчин тойрны хот, суурингуудад мэдэгдэж, мэдээ хүлээн авсан газрууд нь Кадруссыг алсан хүнийг эрж олохоор хөл дээрээ босжээ.

Компъень бол вангийн өргөө, Компъень бол вангийн ан хийдэг газар, цэргийн хуаран хот учир түшмэл, цагдаа, цагдаагийн комиссар нараар буцалж байдаг хот юм. Цахилгаан мэдээгээр ирсэн тушаалыг хүлээн авмагц эрэл хийж эхэлсэн бөгөөд

“Хонх,лонх” хотдоо тэргүүн зэргийн зочид буудал учир түүнээс эхлэх нь зүйн хэрэг ажээ.

Тэгээд ч бас энэ шөнө “Хонхтой” зэргэлдээ байдаг хотын захиргааны байшинг хамгаалж хоносон цэргийн үгээр бол зочид буудалд хэд хэдэн хүн иржээ.

Тэр бүү хэл зургаан цагт буусан манаач түүнийг байраа эзлэх яг тэр бүед таван цагаас өмнө ардаа тариачны хүүхэд сундалсан бор морьтой залуу ирж хүүхэд сорь хоёроо буцаагаад, “Хонх” буудлын хаалгыг цохиод буудал хаалгаа нээж оруулсан гэж хэлжээ.

Ээ оройтож ирсэн хүн дээр сэжиг буужээ.

Энэ нь Андреагаас өөр хэн байх билээ. Цгдаагийн комиссар, дунд даргын хамт Андреагийн өрөөний хаалган дээр ирлээ.

Хаалга онгорхой байв.

- Өө гэж элдвийн заль мэх бишгүйдээ үзсэн цагдаа дуугараад, - Нээлттэй, хаалга гэдэг чинь муу ёр! Би түүнийг гурван цоожоор цоожилчихсон байвал илүү дээрд үзэхсэн! Гэж хэлэв.

Андреагийн бичиж орхисон бичиг, зүү хоёр муу явдлын үнэнийг заасан чухамдаа гэвэл баталж байлаа.

Андреа оргожээ.

Цагдаа бол анхныхаа үзсэнд итгэчихдэг биш болохоор бид “заасан” гэж ярьж байгаа юм.

Цагдаа эргэн тойрон харж, орон доогуур шагайж, шүүгээ онгойлгож хараад сүүлд нь задгай зуухны тийш очив.

Андреа урьдаас болгоомжилсны хүчинд ямар ч ул мөр үлдсэнгүй.

Гэлээ ч энэ нь ямар ч гэсэн гадагш гарах сүв учир энэ удаад гадагш гарч болох нүх бүхнийг нарийвчлан үзэх хэрэгтэй байв. Тийм учраас цагдаа мөчир, сүрэл авчрахыг тушаав. Тэгээд энэ бүхнийг зууханд хийж шатаав.

Зуухан дотор дөл шуугьж утааны яндангаар өтгөн утаа баагьж байсан боловч цагдаагийн бодсоноор оргодол унаж ирсэнгүй.

Андреа бага наснаасаа эхлэн нийгэмтэй тэмцэж ирсэн учир ямар ч цаглаа, тэр ч байтугай бага дарга нь ч байсан түүнээс илүү хашир байж чадах болжээ. Андреа галаар шалгаж магалдгүй гэж бодоод дээвэр дээр гарч, яндангийн цаана нуугдчихжээ.

Дунд дарга хочр цагдаадаа,

- Тэр энд алга байна гэж чанга хашхирахыг сонсоод Андреад аўрадагж ч магадгүй нь гэдэг найдлага төрлөө.

Тэгээд болгоомжтойгоор өлийвөл, ийм үг дуулаад явж таарах цагдаа нар явахын оронд харин анхаарлаа улам хүчтэй болгосон байв.

Тэр бас өөрийн ээлжинд эргэн тойрноо харвал, ХҮ1 зууны үед барьсан хотын захиргааны байшин баруун талд нь бат цайз бараантан харагдав. Барилгын цонхноос Андреагийн нуугдаж байгаа байшингийн дээврийг өндөр уулан дээрээс өргөн талыг харах мэт тодорхой харж болох байв.

Эдгээр цонхнуудын аль нэгээр цагдаагийн толгой цухуйна гэдгийг Андреа ойлгож байв.

Хэрэв түүнийг харвчивал өнгөрөх нь тэр. Дээвэр дээгүүр гүйгээд амжилт олох найдвар тун бага байв.

Тэгэхээр нь гарч ирсэн замаараа биш өөр замаар буухаар шийдлээ.

Утаа гараагүй байгаа яндан олж хэнд ч мэдэгдэлгүй түүгээр буув.

Яг энэ үед захиргааны байшингийн цонх нээгдэж цагдаагийн толгой цухуйв. Тэр толгой байшинг чимэглэсэн чулуун баримал мэт минут хэртэй хөдлөлгүй байснаа гайхаш нь тасарсан байдалтай гүнээ санаа алдаад цааш орлоо.

Ихэмсэг тайван байдалтай цагдаагийн бага дарга олны асуултад хариу хэлэлгүй дундуур нь гарч зочид буудалд буцаж ирэв.

- За яав, гэж хоёр цагдаа асуухад,
- Хүүхэд минь, дээрэмчин биднээс өмнө өглөө эртлэн оргоод явчихсан бололтой. Бид одоо Вилле-Котре, Нуайоны зүг хүн вяуулж ойг самнаж түүнийг заавал барьж авна гэв.

Хуулийг сахиулагч хэндэт бага дарга энэ үгээ ёстой л даргын дуугаар хэлж гүйцээгүй ыайхад айж хашхирах, сандран тэвдэж хонх дуугаргах чимээ зочид буудал даяар дэгдлээ.

- Байз хө, энэ юу болж байгаа нь энэ вэ? гэж цагдааг асуухад зочид буудлын эзэн,
- Нэг хүн тоглоомгүй их яарч байх шиг байна. Аль өрөөнөөс хонхдоод байна даа? гэв.
- Гуравдугаараас.
- Жан. Гүйгээрэй.

Энэ үед хашхирах, хонхдох нь улам ч хүчтэй, чанга боллоо.

Зарц шат өөд гүйв.

- Байг, байг гэж цагдаа түүнийг зогсоогоод, - Хонхдож байгаа хүмүүст та нарын туслалцаа шаардагдаагүй бололтой. Бид очиж тэндэнд үйлчилье. Гуравдугаар өрөөнд хэн байгаа юм бэ? гэж асуув.
- Урьд шөнө шуудангийн сүйх тэргээр дүүтэйгээ хамт ирсэн нэг залуу хоёр ортой өрөө шаардаж тэнд орсон юм.

Түгшүүрийн хонх гурав дахь удаагаа дуугарлаа.

- Эрхэм комиссар аа! Нааш ир! Миний хойноос яваарай! Гэж бага дарга дуудлаа.
- Байзаарай та минь гэж зочид буудлын эзэн хэлээд – Гуравдугаар өрөө рүү хоёр шатаар гардаг юм шүү. Гадаад талын, дотоод талын хоёр шат байгаа гэхэд бага дарга,
- За, за би дотоод шатаар нь явъя. Энэ бол миний хариуцсан зүйл байгаа юм. Буугаа сумласан уу? гэж асуулаа.
- Тушаал ёсоор сумласан.
- Харин та гадна талын шатыг сахиж бай. Хэрэв зугтаах гэвэл буудаарай. Цахилгаан мэдээний байдлаас үзэхэд том хэрэгтэй бололтой.

Бага дарга комиссарын хамт дотоод талын шгатаар өгсөж далд ороход, түүний хэлсэн үгэнд сэтгэл догдолсон олон хүмүүс элдвийг ярьж шуугилдан байв.

Ийм явдал болсон ажээ.

Андреа яндангийн гурваны хоёрыг их л чадмаг явж буусан бөгөөд харин тэндээс гэнэт мултарч хоёр гараараа тэлсэн боловч доош гулсан буужСэ. Хамгийн гол нь хүссэнээсээ и«үү их шуугиан чимээтэй буучхав.

Хэрэв тасалгаанд хүн байгаагүй бол энэ бага зэрэг байсан аж. Даанч хүнтэй өраа таарчихсан байжээ.

Хоёр хүүхэн нэг орон дээр унтаж байв. Гэтэл шуугиан чимээ гарч тэр хоёрыг сэрээжээ.

Тэр хоёр чимээ гарсан зүг рүү харвал задгай зухны амсраар залуу хүн харагдав.

Хоёр хүүхний шаргал үстэй нь байшин дүүрэн аймшигтайгаар хашхирч, нөгөө хар сүтэй хүүхэн нь хонх шүүрэн авч байдаг чадлаараа дуугаргав.

Андреаг гай дагж явсан нь илтэд байв.

Тэгээд айж сандран, царай нь зэвхийрч, хэнд ч хэлж байгаагаа мэдэхгүй,

- Бжрхныг бодож намайг бүү алаач! Бүү хонхдооч! Би та нарт ямар ч муу юм хийхгүй гэж дуу алдан хэлэв.
- Андреа, яргачин! Гэж хоёр бүсгүйн нэг хэлэхэд, Андреа айснаасаа илүү гайхан,
- Эжени! Мадмуазель Данглар гэж шивгэнэв.
- Туслаарай! Туслаарай! Гэж мадмуазель д Армильи хашхираад Эженийн гараас мултран унасан хонхыг шүүрэн авч улам ч ширүүнээр сэгсчлээ.
- Намайг хөөж явна. Намайг авраач. Намайг өрөвдөөч, битгий барьж өгөөч гэж Андреа гуйхад,
- Хожимджээ, тэд одоо шатан дээр хүрээд ирлээ гэж Эжени хариулав.
- Тэгвэл намайг нуугаач. Шатлгаангүйгээр зүгээр л айчихлаа гэж хэлээч. Тэгвэл та нар сэжиглэлийг төөрүүлж, намайг аварна шүү дээ.

Хоёр охин хөнжилдөө шигдэн бие биедээ наалдаж энэ гуйж царай алдаж байгаа дууг жигшин, айж сандран сонсож байв.

- За яах вэ. Ирсэн замаараа буц. Золгүй чамайг бид хэлэхээ байя гэж Эжени хэлэхэдэ ха лганы цаанаас
- Тэр байна! Тэр байна! Би түүнийг харж байна гэж хашхирах дуу сонстлоо.

Энэ бол ццооны нүхээр харж, гараа дөрүүлдэн гуйж байсан Андреаг үзээд дуугарсан бага даргын дуу байв.

Бууны бөгсөөр нэг удаа хүчтэй цлхиж цоожийг нь эвдээд, хоёр удаа цохиж нугасыг нь мултлав. Эвдэрсэн хаалга тасалгаанд унав.

Андреа хашаа руу гарсан нөгөө хаалга өөд ухасхийж онгойлговол тэнд зогсож байсан цагдаа буугаа түүн өөд чиглүүлэв.

Андреа байрандаа хөдлөлгүй зогсов. Хэрэггүй болсон хутгаа татваганасан гартаа атгаж, үл ялим гэдийн зэвхий царайлан зогсов.

Айх нь гайгүй болж өрөвдөх сэтгэл төрсөн мадмуазель д Армильи,

- Зугтаагаач, зугатаагаа! Гэж хашхирахад Эжени ромын боолчуудын тоглолтыг үзэж суугаа хүн дийлсэн хүнийг зүйл дуусга гэж дохио өгч байгаа юм шигээр,
- Эсвэл өөрийгөө алаач! Гэж хэллээ.

Андреа татвасхийн өчүүхэн сэтгэл нь нэр төрийнхөө төлөө тийм том юм шаардагддагийг ойлгохгүй буйгаа харуулан бүсгүй өөд жигшсэн байртай инээмсэглэж,

- Өөрийгөө алах гэнэ ээ? Яах юм бэ? гэж хэлээд хутгаа хаяв.

- Та л өөрөө адгийн муу хэрэгтний ёсоор алагдана, цаазлагдаан гэж хэлсэн шүү дээ гэж Эжени Данглар хэлэхэд,
- Бага хэрэг. Найз нахадтэйн хэрэг юу билээ гэж Андреа хэлээд, бага даргыг түүн уруу сэлмээ сугалан очиход,
- За, за найз минь сэлмээ далд хий. Бууж өгч байхад ингэж сүр бадруулж шуугиан дэгдээгээд яах вэ! гэж хэллээ.

Тэгээд хоёр гараа сунгахад, тэр доор нь гарт нь гав зүүлээ.

Бүсгүйчүүд энэ жигшмээр өөрчлөлтийг айн харж байв. Тэдний нүдний өмнө хүн дээдсийн хүрээлэнгийн дүрээ алдаж ялт хөдөлмөрийн хоригдлын дүрийг олжээ.

Андреа тэдэн уруу харж зальтайгаар инээмсэглээд,

- Би Парист буцаж очих бололтой. Тэгэхээр мадмаузель Эжени та эцэгтээ хэлүүлэх юм байхгүй сэн болов уу? гэв.

Эжени хоёр гараараа нүүрээ дарав.

- Битгий зов. Би таныг хойноос минь хөөж ирсэн явдалд гомдоогүй.... Би бараг таны нөхөр чинь болсон байсан шүү дэ гэж Андреа хэллээ.

Андреа энэ үгийг хэлээд цугларсаг олоноос ичин зовсон хоёр оргодол бүсгүйг охирод гарч одлоо. Цагийн дараа хоёр бүсгүй хоуёл эмэгтэй хувцсаа өмсөж тэргэнд сууж явлаа.

Тэднийг бусдын ншднээс далдлахын тулд зочид буудлын хаалгаг түгжсэн боловч, гарч явахдаа сонирхсон олны дундуур өнгөрч, тэдний шивгэнэх дуу, шоолж доромжилсон харцыг харж явлаа.

Эжений цонхныхоо хөшгийг хаав. Тэрээр юу ч хараагүй боловч, харин доог хийсэн дууг сонсжээ.

- Ертөнц гэдэг чинь яагаад хоосон цөл газар байсангүй вэ! гэж хашхираад найз охиныхоо өвөр дээр унахад, ром»н ардууд ганц цавчаад хаячих ганцхан толгойтой байгаагүйд харамсаж байсан Нероны харц шиг бүсгүйн хару хорсолтойгоор гялалзаж байв.

Маргааш нь тэр хоёр Брюссельд хүрэлцэн ирж Отель де Фландрт буув.

Андреа түүний урьд өдөр нь Консьержерийн гянданд хоригджээ.

2.ХУУЛЬ

Бид мадмуазель Данглар, мадмуазель д Армильи хоёр амжилттай оргож зайлсныг үзлээ. Хүн бүр хэтэрхий зав чөлөөгүй байсан болохоор тэдний тухай хэн ч бодсонгүй.

Банкны эзэн холгүй сүүмэлзэж байгаа дампуурлыг харж духан дээр нь хүйтэн хөлс бурзайн алдагдлаа бодож суух зуур, дайрсан уохилтын дараа ухаан нь сэргэж өөрийн байнгын зөвлөгч Люсьен Дебрэ дээр очих гэж яаран яваа хатагтай Дангларын хойноос дагаж үзье.

Эженийг асрамжилж байх үүргээсээ чөлөөлөгдөхийн тулд хатагтай Данглар охиноо хүнтэй суулгахыг тэсгэлгүй их хүсэж байжээ. Эжений зан араншин хэцүү учир ингэж асрамжилж байх нь түүнд ярвигтай дарамт болж байв.

Хатагтай Данглар, Эжений сонор соргог байдал, мадмуазель д Армилийн зөвлөгөөнөөс айдаг байв. Охин нь Дебрэг жигшин харах нь эхийн нүднээс зайлж үл чадна. Энэ харц нь сайдын нарийн бичгийн даргатай, түүний явалддагийг, мөнгөний холбоотой байдгийг мэддэг болохыг илчлэх шиг санагдана. Гэвч хатагтай илүү соргог

хүн байсан бол Эжени Дебрэг эцгийнх нь гэрт ирж хов жив, элдвийн вми эх үүсвэр болдогт нь дургүйцдэггүй, харин Диоген хүн гэж зөвшөөрдөггүй хоёр хөлтөн. Платон хоёр хөлтэй, өд сөдгүй адгуус гэж нэрлэдэгчлэн түүнийг зүгээр л хоёр хөлт амьтан гэж үздэл учраас тэгдгийг нь ойлгох байсан биз.

Ингэж х тагтай Дангларын үзлээр бол хурим хийгдэхгүй болсон нь үлэмж гунигтай хэрэг агаад, хүн бүрд нөгөө хүнийхээ үзлийг танин мэдэхэд нь саад болдог өөрийн нь үзэл байдаг нь харамсалтай. Энэ гэрлэлт бүтэлгүй болсон явдал нь мадмуазель Эженид тохирох аз жаргал өгөхдөө бус харин хатагтай Дангларыг бүрэн эрх чөлөөтэй болгох байсан учраас хатагтай тэгтлээ гунихарчээ.

Ингээд хатагтай, Дебрэгийн уруу явсныг бид дээр өгүүлсэн билээ. Люсьен Парисын бүх дээдсийн хүрээлэнгийнхний адил дангларын баярт оролцож, болсон будлиант явдлыг үзсэн билээ. Тэгээд өнөөдрийн болсон явдалд дэлхийн нийслэл гэж нэрлэгдсэн хов живийн хотынхны дөрөвний гурваын ярилцаж байгаа зүйлийг нь найз нөхөд нь хэлэлцэн байгаа кулб руу яаран явжээ.

Энэ үеэр хатагтай Данглар та схар даашинз өмсөж, нүүрэндээ хар гивлүүр унжуулаад хаалгач нь Люсьенийг гэртээ байхгүй гэсээр байтал Люсьений өрөө рүү орсон шатаар өгслөө. Люсьен энэ үеэр сайхь будлиантай явдлын дараа гэр бүлийн найз нөхрийн хувьд мадмуазель Эжени ба түүний хоёр сая франктай суух ёстой гэдгийг нотолж байсан нөхөдтэйгээ клубт маргалдаж байжээ.

Дебрэ тэдний ятгалгад ороход бэлхэн байгаа хүний янзаар сулхан шиг биеэ хамгаалж байв. Ийм бодол нэг биш удаа түүний толгойд орж ирдэг байжээ. Гэвч Эжений биеэ даасан байдал, ихэмсэг зангий нь мэдэх учир энэ бүтэхгүй ажил гэж өөртөө ийм хилэнцэт танаа төрсөнд өөрийгөө буруушаан боддог байжээ. Яриа нь чухал зүйлтэй холбоотой учир цай ууж, тоглож ярилцсаар шөнийн нэг цаг хүргэжээ.

Тэр завсар хатагтай Данглар, Люсьений бяцхан ногоон зочдын өрөөнд орж гивлүүрээ ч авалгүй өгдөөхөн Дебрэд ирүүлсэн цэцгүүдийнхээ дунд суулаа. Дебрэ тэдгээр цэцгүүдийг их л нямбайлан янзалж тавьсан учир хөөрхий бүсгүй түүний эзгүй байсныг ч уучлахад хүрчээ.

Хатагтай Данглар арван хоёр цагт хорин минут дутуу байхад хүлээж цөхрөөд хөлсний тэрэг авч гэртээ харив.

Нэр төртэй айлын авчгайчуул бэлтэй янхнуудын адил шөнийн арван хоёр цагаас хойш гэрээсээ гадуур яьдаггүй ажээ.

Эжений эцгийнхээ гэрээс сэмхэн гарч явсны адилаар хатагтай болгоомжтойгоор гэртээ орж ирэв. Хатагтай зүрх нь цохилон шатаар гарч Эжений өрөөтэй зэргэлдээ байдаг өрөө рүүгээ чимээгүй орлоо.

Хатагтай элдвийн яриа хөөрөөнөөс ихэд айжээ. Охиноо гэр бүлдээ үнэнч хайртай гэж итгэж байв.

Хатагтай харьж ирээд Эжений өрөөний хаалганы дэргэд очиж чагнаад юу ч сонстохгүй болохоор нь орох гэж татаж үзвэл цоожтой байв.

Үдшийн болсон явдлаас ядарч зүдэрсэн Эжени хэвтээд унтчихсан юм байх гэж боджээ.

Тэгээд шивэгчин хүүхнийг дуудаж асуув.

- Мадмуазель Эжени, мадмуазель д Армилийн хамт өрөөнпөө орсон. Тэр хоёр хамт цай уугаад, миний хэрэг байхгүй гэж амайг явуулсан гэж хариулав.

Түүнээс хойш шивэгчин хүүхэн галын өрөөнөөс гараагүй, тэр хоёрыг өрөөндөө бий л гэж бусдын адил бодож суужээ.

Ийч учраас хатагтай данглар огтхон ч сэжиг төрөлгүй унтахаар хэвтэв. Шивэгчин хүүхний үг охиныхоо төлөө түгшсэн сэтгэлийг нь тайвшруулжээ.

Цааш бодох тусам тэднийд тохиолдсон гай гамшгийн хэр хэмжээ улам их болж байв. Зөвхөн маргаан будлиан биш, харин ниргэлт болжээ. Зөвхөн гутамшиг биш нэр төрөө алдсан хэрэг байлаа.

Тэгэхэд л нөхөр хүүхэд хоёроосоо болж мөн ийм золгүй явдалд учирсан Мерседесийг өрөвдөөгүй байснаа тодхон санах. “Эжени өнгөрлөө. Бид ч бас адмилхан. Манай нийгэмд шоллж инээх нь хүнд эдгэшгүй шарх олгодог учир биднийг сүйдэлжээ” гэж бодож байв.

- Намайг тэгж дандаа айлгаж байдаг хачин аашийг бурханд түүнд хайрласан нь ямар азтай хэрэг вэ! гэж хатагтай шивгэнэв.

Тэгээд тэр хүүхэн үл үзэгдэх их хүчний ачаар сайн сайхан ирээдүй, гачигдал зовлонг хүнд ирүүлж байдаг тэнгэр өөд харав.

Дараа нь түүний санаа бодол шувуу мэт далавчилж ан хавцлын дээгүүр гарч Кавальканти дээр зогслоо.

Энэ Андреа үл бүтэх амьтан, хулгайч алуурч байжээ. Гэсэн ч тэр мэдэгдэм хүмүүжилтай хүн байв. Тэрээр нэр хүндтэй хүмүүсээр дэмжигдэн, их хөрөнгөтний эзэн гэж дээдсийн хүрээлэнд гарч ирсэн билээ.

Энэ будлианы учрыг яаж олох вэ? Энэ аймшигт байдлаас гарахад хэн туслах вэ?

Хайртай сайн хүнээ хэмээн хандсан Дебрэ нь түүнд зөвхөн зөвлөгөө өгөхөөс хэтрэхгүй. Аль нэг илүү хүчирхэг хүнд хандах хэрэгтэй болжээ.

Тэгэхэд л матагтайн санаанд Вильфор орлоо.

Вильфор Кавалькантийг баривчлуулсан өөрт нь огт хамаагүй юм шиг хатагтайн гэр бүлд будлиан дэгдээжээ.

- Үгүй, вангийн прокурор бол сэтгэлгүй хүн биш. Тэр бол шударга үнэний шүүхийн төлөөлөгч, албан үүргийнхээ боол хүн. Үнэнч туйлбартай найз нөхөр. Тэр бол идээлсэн шархыг итгэлтэй гараар эмнэгч мэс засалч болохоос биш, алуурчин яргачин биш ээ. Тэрээр Дангларынхаа нэр төрийг нэгэнт өнгөрсөн залууг бузарлахаас хамгаалах гэж хэрэгтэй бүхнийг хийсэн гэж санаагаа засав.

Вильфор, Дангларын гэр бүлийн найз болохоор, Андреад саад болж түүнийг хайхад саад хийж чадах байсан гэж бодож болохгүй юм.

Ингэж Вильфорын байдал хатагтайн санаанд шал өөр маягаар бууж, түүнээс өөрт улам аятайхан санагдсанаараа үргэлжлүүлэн бодов.

Харин вангийн прокурор үүн дээр л зогсох ёстой. Маргааш хатагтай түүн дээр очиж, албаных нь үүргийг эс зөрчүүллээ ч гэсэн нааштай хандуулж чадна гэж шийдлээ.

Хатагтай өнгөрсөн явдлаа дурсан ярихад санаанд нь өнгөрсөн үеийг санагдуулах ажээ. Хатагтай нүгэлт үе буюу залуу үеийн нь хамгийн жаргалтай цагийг сануулж гуйна. Тэгэхэд Вильфор хэрэг ядлыг бүрхэгдүүлэн орхих буюу эсвэл Кавалькантид оргох боломж олгох болно. Үүний тулд тэр зөвхөн өөр тийшээ харж л орхивол гүйцэх нь тэр.

Хатагтай ингэж бодон тайвшраад унтлаа.

Маргааш өглөө нь хатагтай арван цагт босоод шивэгчин хүүхнээ дуудалгүй, өчигдрийнх шигээ жирийн байдлаар хувцаслаад хэнд ч харагдалгүй гарч Проуанс гудамж хүрээд тэрэг хөлслөн авч Вильфорын хүргэж өгөхийг тушаав.

Энэ нүгэлт байшин бүтэн сарын турш тахлын үүр мэт харагдаж байв. Тасалгаануудын хагас нь гадна дотноосоо хаалттай бөгөөд цонхны хаалтуудыг зөвхөн агаар оруулах гэж түр онгойлгоод хаадаг байв. Энэ үед зарц нарын аймхай царай харагдана. Дараа нь цонхнууд нь авснч таг таглагдах мэт хаагдаж айлын хүмүүс нь:

- Өнөөдөр бас вангийн прокурорын гэрээс авс гаргах юм болов уу? гэж ярилцдаг болов.

Хатагтай Данглар энэхүү баргар цуарайтай байшинг хараад цочин дагжлаа. Хатагтай хөлсний тэрэгнээж бууж түгжээтэй хаалга цохиход өвдөг нь чичирч байв.

Хатагтайг гурав дахь удаагаа цохиход сая л хаалгач нь хүрч ирж явган хаалгаа ялимгүй онгойлголоо.

Хаалгач гоёмсог хувцастай дээдсийн хүрээлэнгийн хүүхэн зогсож байхыг харсан боловч хаалга онгойх төдий хэвээр хоцорлоо.

- Наадхаа онгойлгооч! Гэж хатагтай хэлэв.
- Хатагтай минь хэн гэгч болохоо урьдаар хэлнэ үү? Гэж хаалгач асуув.
- Би юу? Та намайг маш сайн танина даа.
- Хатагтай минь бид одоо хэнийг ч мэдэхгүй, танихгүй.
- Та чинь галзуураа юу! гэж хатагтай хэлэв.
- Та хэний өмнөөс явж байна?
- Үгүй, энэ чинь дэндэж байна!
- Хатагтай минь уучлаарай_. Тэгж л тушаасан юм. Таны нэр хэн гэдэг вэ?
- Хатагтай Данглар. Та намайг лав зуу дахин харс н байх.
- Магадгүй, магадгүй хатагтай минь. Танд одоо юу хэрэгтэй?Ээ хэлчих.
- Ямар балай юм бэ? Би эрхэм де Вильфорт гомдол гаргана шүү.
- Хатагтай минь энэ бол булай юм биш, болгоомжилж байгаа хэрэг юм. Эднийд зөвхөн д Авриньийн зөвшөөрөлтэй эсвэл вангийн прокурорт айлтгасны дараа оруулдаг юм.
- Тэгвэл надад яг л вангийн прокурортой уулзах хэрэг байна?
- Яаруу хэрэг үү?
- Би жнд байгаад байгаа болохоор тийм байлгүй. за болно, энэ нэрийн хуудсыг эзэндээ аваачиж өг.
- Намайг иртэл хүлээж байх уу?
- Тэгнэ, за яв.

Хаалгач хатагтай Дангларыг гадаа гудамжинд орхиод хаалгаа түгжиж орхилоо.

Хатагтай удаан хүлээхэд хүрсэнгүй. Удалгүй хаалга дөнгөж хатагтай багтаж орохоор онгойлгоод, түүнийг ормогц дахин хаагдлаа.

Хаалгач хашаан дотор ороод хаалганаас нүд салгалгүй байж хармаанаасаа шүгэл гаргаж шүгэлдэв.

Шатан дээр Вильфорын зарц гарч ирлээ.

- Хатагтай минь энэ үнэнч хүнийг уучлахыг хүсье. Түүдн тэгж тушаасан болохоор өөрөөр байх аргагүй байсан юм гэж эрхэм Вильфор хэлүүллээ гэж хатагтайг тосон ирж хэлэв.

Хашаан дотор мөн л тийм янзаар орж ирсэн худалдаачин зогсох агаад нэгэн зарц бараагий нь үзэж байв.

Хатагтай шатаар өгслөө. Энэ уйтгар гунигт байдлыг хараад хатагтайн уйтгар гуниг улам лавшран гүнзгийрэх шиг болж, өөрөөс нь өчүүхэн зуур ч хөндийлөргүй дагаж зарцын араас вангийн прокурорын өрөөнд орлоо.

Хатагтай Дангларыг ийшээ авчирсан шалтгаан нь хэдий чухал ч, өөрийг нь угтан авч байгааг бодохоос гомдолтой санагдаад явчхав.

Хатагтай Данглар Вильфорын гэрт болж байгаа аймшигт явдлын тухай ярилцахыг олон удаа сонссон боловч, ийм айхавтар байдалд хүргэх юм гэж нүдээр үзэхээсээ нааш итгэхгүй байжээ.

- Та бас золгүй хүн болоод байна уу? гэж хүүхэн асуув:
- Тийм ээ, хатагтай минь гэж прокурор хариулав.
- Та намайг өрөвдөж байна уу?
- Хатагтай минь, үнэхээр харамсаж байна.
- Намайг ирсний учрыг ойлгож байна уу?
- Та гэртээ болсон явдлын тухай ярилцах гэж ирэв үү?
- Энэ бол аймшигтай золгүй явдал шүү.
- Өөрөөр хэлбэл эвгүй явдал.
- Эвгүй гэнэ ээ гэж хатагтай дуу алдав.
- Хатагтай минь, би золгүй явдал гэж зөвхөн засаж залруулж болшгүй хэргийг л нэрлэх болчихоод байна гэж вангийн прокурор тайван хэлэв.
- Та энэ явдлыг үнэхээр мартагдана гэж бодож байна уу?
- Хатагтай минь юм бүхэн мартагддаг юм. таны охин өнөөдөр хүнтэй суучихгүй бол маргааш хүнтэй сууна, маргааш муудаггүй юм гэхэд долоо хоногийн дараа сунаа. Мадмуазель Эженийн болзоот нөхрийн тухайд гэвэл танд санаа зовох юмгүй гэж бодож байна.

Вильфорын бараг доог хийсэн байрын тайван байдлыг хараад хатагтай Данглар түүн өөд гайхан харлаа.

- Би найз хүн дээрээ ирж үү, үгүй юу? гэж хатагтай ихэмсэг байдлаар асуув.
- Тийм гэдгийг та өөрөө мэдэж байгаа шүү дээ гэж Вильфор хариулахад хацар нь бага зэрэг цлайв.

Энэ үг нь тэр хоёрын энэ минутад болж байгаа зүйлийг биш харин өөр нэг явдлын тухай санагдуулжээ.

-Тэгвэл хайрт Вильфор минь чи надтай шүүгчийн хувиар биш харин найз хүний ёсоор хандаж, гүнээ зовж зүдэрч байхад минь заавал хөгжилтэй бай гэж надад бүү тулгаач гэж хатагтай хэлэв.

Вильфор мэхийн ёслов.

- Сүүлийн гурван сарын дотор надад нэг хувиа бодсон заншил бий боллоо. Би хүнд тохиолдсон золгүй явдлын тухай сонсохдоо өөрийн эрхгүй өөрийнхтэйгээ харьцуулж үзэх боллоо. Тиймээс танд тохиолдсон явдлыг өөрийнхтэйгээ зэрэгцүүлж үзэхээр таных зүгээр л эвгүй явдал мэт

санагдсан юм. Миний эмгэнэлт байдлын дэргэд таны байдал бол атаархмаар санагдаж байна. гэвч миний хэлж байгаа үг таны зэвүүг хүргэх учир хойш тавья. Тэгэхээр хатагтай та юу гэж хэлэх гээ вэ?

- Найз минь, тэр хүний нэг зээлдсэн хүнийг яах гэж байгааг мэдэх гэж Ирсэн юм гэж хатагтай хэллээ.
- Хэний нэр зээлдэгч гэнэ ээ? гэж Вильфор давтан хэлээд, - хатагтай та санаатайгаар заримдаа багасгаж, заримдаа хэтрүүлж байгааг чинь харж байна. Андреа Кавальканти үнэнээр нь хэлбэл Бенедетто хүний нэр зээлдсэн хүн гэж үү? Хатагтай та андуурч байна. Бенедетто гэдэг чинь ёстой алуурчин хүн байхгүй юу.
- Эрхэм таны засан хэлж байгааг би маргахгүй. Гэвч түүнийг хичнээн чанга шийтгэх тусам манай гэр бүлд тусах тусгал нь төдийчинээ хүчтэй болно. Түүнийг жаахан мартаж, нэхэл дагал бололгүй байж байгаад оргуулчих.
- Хатагтай минь хожимдож, би тушаалаа өгчихсөн.
- Тэгвэл түүнийг барьж авбал... Та түүнийг Уарьчихна гэж бодож байна уу?
- Тэгнэ гэж найдаж байна.
- Хэрэв түүнийг барьж авбал _Би шоронгууд дүүрэн гэж тал бүрээс сонссон\ шоронд л хийчих.

Вангийн прокурор толгой сэгсэрлээ.

- Үгүй дээ л охины минь хүнтэй суутал шоронд байлгаач гэж хатагтай нэмж хэлэв.
- Болохгүй, хатагтай минь, шударга үнэний шүүх гэдэг чинь өөрийн дэг журамтай байдаг юм.
- Миний төлөө ч гэсэн болохгүй гэж үү? Хэмээн хатагтай тоглоом, үнэн хоёрын хооронд хэллээ.
- Хүн бүрд, надад ч бусад хүмүүст ч гэж вангийн прокурор хэлэхэд,
- Тийм байж... гэж хатагтай юм хэлэх гэсэн санаагаа нууж дуугарлаа.

Вильфор түүн өөд ширтэн харж,

- Миний гэрт гурван сарын турш үргэлжилж байгаа үхлийн тухай, түүнээс Валентина ид шидээр аврагдсан тухай хот даяар тархсан ярианы тухай% энэ бүхэн тохиолдлын үхэл биш гэж хэлэх гэж байна уу? гэв.
- Би энэ тухай огтхон ч бодоогүй шүү гэж хатагтай яаран хэлэв.
- Үгүй хатагтай та энэ тухай бодсон, та энэ тухай бодохгүй байж чадахгүй чинь шударга явдал. Ялт хэргийг цээрлүүлэн шийтгэдэг хүн байж, өөрийг чинь тойроод гарч буй гэмт хэрэг цээрлүүлэгдэхгүй байдгийн учир юу вэ, хэлээч гэж бодож байгаа чинь зүйн хэрэг.

Хатагтайн царай зэвхийрлээ.

- Хатагтай та энэ тухай өөр зуураа ярьсан биз тийм ээ.
- Тийм ээ, үнэн.
- Би танд хариулья.

Вильфор зөөлөн сандлаа хатагтай Дангларын сандал уруу дөхүүллээ. Тэгээд хоёр гараараа бичгийн ширээ тулж ердийнхөөрөө аяархан дуугаар ярьсан нь:

- Гэмтэн нь мэдэгдэхгүй учр ас цээрлүүлэгдэлгүй, харин гэмгүй хүн цээрлүүлэгдэж өнгөрдөг гэмт хэргүүд байдаг. Харин гэмт хэрэгтнүүд нь илэрмэгц \Вильфор хананд байгаа том загалмай уруу гараа сунгав\ тэр нь хэнч бөйлаа гэсэн үхэх ёстой гэдгийг бурхны өмнө тангараглая! Одоо намайг ингэж тангараг тавьсны дараа надаас тэр үл бүтэх этгээдийг энэрч өршөөхийг зүрхэлж гуйх гэж үү?
- Та түүнийг улс амьтны яриад байгаа шиг хэрэгтэй гэж байна уу? гэж хатагтай Данглар асуув.
- Түүний хэрэг ийм байна. Бенедетто арван зургаан настай байхдаа таван жил ялт хөдөлмөрөөр шийтгэгдэж, дараа нь оргоод, сүүлд нь хүн алсан байна.
- Тэр золгүй амьтан чинь... хэн юм бэ дээ?
- Хэн мэдэх вэ? Тэнэмэл, корс хүн биз.
- Хэн ч түүнийг танихгүй юм уу?
- Хэн ч үгүй юм. Эцэг эх нь мэдэгдэхгүй юм.
- Тэр Луккээс ирсэн хүн юу юм бол?
- Мөн л өөр шиг нь зальхай этгээд. Түүний хамсаатан ч байж болох юм. Хатагтай гуйсан янзтай гараа зөрүүлээд, хамгийн зөөлөн эелдэг дуугаар,
- Вильфор! Гэж хэллээ.
- Бурхан минь, хатагтай та хэзээ ч надаас ялтан гэмтэн хүний төлөө өршөөл битгий гуйгаарай! Гэж вангийн прокурор нэлээд эрс хүйтнээр хариулав.
- Би юу вэ? Хууль. Хулуинд чинь, таны уйтгар гунигийг харах нүд байдаг мю гэж үү? Хуулинд чинь, таны зөөлөн дууг сонсох чих бий гэж үү? Хуулинд чинь таны санаа бодолд хариулах тархи толгой бий гэж үү? Үгүй, хатагтай минь хууль гэдэг чинь захирч тушаадаг юм. Нэгэнт хууль захирч тушаавал ниргэж орхидог юм.

Та намайг амьд амьтан, хуулийн зүйл анги биш гэж хэлэх байх. Но ч биш хүн гэх биз. Хатагтай минь та намайг, мини© орчин тойрныг хар л даа. Намайг хүмүүс ах дүүгээ шиг үздэг гэж үү? Тэд намайг хайрлагддаг гэж үү? Хэн нэгэн хүн Вильфорыг хайрлаж өршөөж байсан гэж үү? Үгүй, үгүй!

Та намайг нүүрий минь улайхад хүргэдэг тэр зүйлийг санагдуулдаг гайхам сайхан нүдээрээ намайг хар л даа. Тиймээ таны мэддэг зүйлийн төлөө царай минь улайдаг юм. Өөр юм ч байж магадгүй.

Би бусдаас доорд унасан үеэсээ эхэлж, идээлсэн шархыг нь олох гэж хүмүүсийн хувцсыг тайчин тэр шархыг олдог боллоо. Би бүр түүнийг олохдоо баярлаж байдаг. Энэ бол хүний сул дорой, буруу хорон сэтгэлийн тэмдэг юм.

Миний цээрлүүлэн шийтгэж байгаа хэрэгтэн бүр надад би бусдаас ангид хүн биш гэдгийн амьд баталгаа нотолгоо болдог. Хатагтай минь бүр хорт бузар амьтан. Үүнийг нотлон хорт санаатныг гайхуулъя.

Вильфор энэ үгийг бараг хатуу ширүүн тэр бүү хэл хилэнтэйгээр хэлэв.

- Ингэхэд та тэр залууг өнчин, тэнэмэл, бүхэнд хаягдсан хүн гэж хэлээ биз дээ гэж хатагтай Данглар сүүлчийн оролдлого гарган асуув.
- Тэгэх тусмаа муу хэрэг, чухамдаа сайн хэрэг. Бурхан түүнийг хэн ч харамсаж, уйлахгүйгээр төрүүлсэн ажээ.

- Эрхэм та, ядуу дорой хүн өөд довтолж байна!
- Алуурчин хүн сул дорой хүн байдаг юм уу?
- Түүний шившигт явдал миний гэрийг бузарлаж байна.
- Миний гэр үхлийн гэр гэж тэмдэглэгдээгүй гэж үү?
- Та бусдыг хайрладаггүй хүн юм. Тэгэхээр та миний хэлэх үгийг сонсож бай. Хүчүүс таныг бас адилхан хайрлахгүй болно шүү дээ.
- Тэгвэл тэгэг! Гэж хэлээд Вильфор заналхийлэн гараа өөд өргөв.
- Хэрэв түүнийг барьчихвал золгүй амьтны хэргийг дараагийн чуулган хүртэл хойшлуулаач. Хагас жил өнгөрөхөд хүмүүс мартагнана шүү дээ.
- Үгүй, надад одоо таван хоногийн хугацаа байна. мөрдөн байцаалт дууссан. Тав хоног надад бүрэн хангалттай. Хатагтай минь, надад ч бас мартагнах хэрэг байгаа гэдгийг мэдэхгүй байна гэж үү. Би ажиллаж эхлэхээрээ өдөр шөнөгүй ажилладаг, ажил хийж байхдаа бүхнийг мартдаг. Бүхнийг мартахаараа үхсэн амьтан шиг аз жаргалтай болдог юм. Энэ бол зовж зүдэрснээсээ илүү дээр дээ.
- Нэгэнт тэр хүн нуугдчихсан болохоор түүнийг оргох бололцоо өгөөч. Орлоцхогүй байх гэдэг чинь өршөөл энэрлийн хамгийн хялбар арга.
- Одоо оройтсон гэж би танд хэлсэн шүү дээ. Цахилгаан мэдээгээр бүр үүрээр тушаал өгсөн. Одоо лав... гэж Вильфор хэлтэл хиа нь орж ирээд,
- Дотоод явдлын яамнаас мэдээ иржээ гэж айлтгав.
Вильфор дугтуйтай бичгийг шүүрэн авч яаралтай задлав.
Хатагтай Данглар айн чичрэхэд Вильфор баярлан догдоллоо.
- Барьжээ! Түүнийг Компьеноос барьжээ. Одоо гүйцэх нь тэр гэж Вильфцор дуу алдав.
Хатагтай Данглар босохоод царай нь зэвхийрсэн байв.
- Баяртай, эрхэм минь гэж хатагтай хүйтнээр хэлэхэд вангийн прокурор түүнийг бараг баяртайгаар үүд хүртэл үдэж өгөөд,
Дараа нь бичгийн ширээ рүү очиж,
- Одоо бичиг баримт хуурмагаар үйлдсэн нэг хэрэг, хулгайн хэрэг гурав, галдан шатаасан хэрэг хоёр ба©на. Харин ганцхан хүн алсан хэрэг л дутаад байсан юм. Тэр маань одоо бий боллоо. Маш сайхан чуулган болно доо гэж мэдээг гараараа цохилон байж хэлэв.

3.ХИЙ ҮЗЭГДЭЛ

Вангийн прокурор хатагтай Дангларт хэлсэнчлэн Валентина өвчтэй хэвээр байв.

Тамирдаж доройтсон бүсгүй орноосоо босож чадахгүй байв. Эжени оргон явсан, Андреа Кавальканти чухамдаа Бенедетто баривчлагдсан, түүнийг хүн алсан хэрэгт татсан тухай залуу бүсгүй хатагтай Вильфорын амнаас сонсжээ.

Гэвч Валентинагийн бие сул тамирдуу байсан учир энэ яриа нь эрүүл байхад нь ярьснаас их л бага сэтгэгдэл төрүүлжээ.

Түүний өвчтэй тархинд төрдөг хачин бодол санаа эгшин зуурын дотор нүдний нь өмнө харагдан өнгөрдөг хий үзэгдлүүд дээр бас хэдэн тодорхойгүй санаа бодол, бүдэгхэн дүрсүүд нэмэгдэн харагдах бөгөөд эдгээр нь өөрт нь мэдрэгдэхгүйгээр арилагддаг ажээ.

Өдөр нь өвгөн Нуарьтегийн байхад Валентина амьдралтай холбогдох бөгөөд, өвгөн ач охиныхоо тасалгаанд оруулахыг шаардаж өвчтэн бүсгүйг нүд салгалгүй ширтэн сууж өдрийг өнгөрөөдөг байлаа. Вильфор шүүхээсээ хүрч ирээд, эцэг охин хоёртойгоо нэг хоёр цаг хамт суудаг байв.

Зургаан цагт Вильфор өрөө рүүгээ явна. Найман цагт Валентинагийн шөнө уух ундааг д Авриньи бэлтгэж авчирч өгнө. Дараа нь Нуартъег аваана.

Эмчийн урьж ирүүлсэн сахиул хүүхэн бүгдийг орлож үлдээд арав буюу арван нэгэн цагт Валентинаг унтсан хойно явдаг байв. Тэр сахиул хүүхэн явахдаа хаалгаа цоожлоод түлхүүрийг нь Вильфорт өөрт нь аваачиж өгдөг учир зөвхөн хатагтай Вильфор ба бяцхан Эдуардын өрөөгөөр дамжин орж болох байв.

Моррель өдөр бүр Валентинагийн биеийг асуух гэж Нуартъе дээр ирнэ. Моррель өдөр өнгөрөх бүр улам тайвширч байв.

Валентина бие нь хэдий дорой байгаа боловч өдрөөс өдөрт сайжирч байгаага мэдэрч байв. Тэгээд ч бас Моррелийг ухаан жолоогүй гүйж очиход нь Монте-Кристо түүнд хэрэв Валентина хоёр цагийн дараа үрчихдэггүй юм бол аврагдана гэж хэлсэн биш билүү.

Одоо Валентина амьд мэнд дөрөв хонож байна.

Валентинагийн сэтгэлийн хөдөлгөөн нь шөнө унтахад өөрөөр хэлбэл зүүрмэглэхэд нь ч гэсэн түүнээс салахгүй эзэмдэн авна. Тэгэхэд задгай зуух дээр тавьсан шөнийн дэнгийн бүдэг гэрэлд өвчтөний тасалгаа дотуур хий үзэгдэл сүүдэгнэж, чичрэг өвчний үл үзэгдэх далавчийн дэлэлт доор холхин хөдөлнө.

Тэгэхэд, нүд нь гялалзсан хойд эх, гараа түүн рүү сарвайж байгаа Моррель, бас огт хамаагүй элгийн хүмүүс болох Монте-Кристо гүн зэргийн хүмүүс харагдана. Тэр ч байтугай тасалгаанд тавьсан модон хэрэглэл хүртэл амь орж тасалгаан дотуур хөдлөн явах шиг болно. Энэ нь хүнд нойронд дарагддаг гурван цаг хүртэл үргэлжлэх бөгөөд нэг ингэж унтвал өглөө болтол үл сэрнэ.

Валентина мадмуазель Эжений оргосон, Бенедетто баригдсан тухай дуулсан тэр үдэш, Вильфор, д Авриньи, Нуартъе гурвыг явсны дараа гэгээн Филипп Рулийн сүмийн цаг арван нэг болсныг зааж цохиход сахиул хүүхэн өвчтөн бүсгүйн дэргэд бэлтгэсэн ундааныг нь тавиад хаалгыг нь цоожилж гал тогооны өрөөнд очиж вангийн проккурорын зарц нарын сэтгэлийг гурван сарын турш зовоож байгаа аймшигт явдлын тухай яриаг снослоо. Яг энэ үед нямбайлан цоожилсон Валентинагийн өрөөнд нэг гэнэтийн явдал болжээ.

Сахиул хүүхнийг явснаас хойш арваан минут өнгөрчээ.

Валентина шөнө бүр халуурдгаараа халуурч, түүний тархинд санаа зоригоос нь хамаарахгүйгээр шаргуу ажил явагдаж, өнөө л санаа бодол, дүрс зогсолтгүй нүдэнд нь харагдаж байв.

Тэгтэл гэнэт шөнийн гэрлийн бүдэг гэгээнд задгай зуухны нь дэргэд, хананд хонхойлон суулгасан шүүгээний үүд алгуурхан чимээ аниргүйгээр нээгдэх шиг болжээ.

Өөр цагт сан бол Валентина хонхоо шүүрэн авч туслахыг хүсэн дуугаргах байсан боловч хагас ухаантай байсан учир огтхон ч гайхсангүй.

Түүнд үзэгддэг энэ хий үзэгдлүүд дэмийрч байгааг нь болдог гэдгийг ойлгоод байжээ. Өглөө нь үүр цайж гэрэл тусахад замхран арилдаг энэ бүх шөнийн үзэгдлүүдийн үл мөр байдаггүй байв.

Шүүгээнээс хүн гарч ирэв.

Валентина хий үзэгдэлд нэгэнт дассан байсан учир айсангүй. Харин Моррель харагдаж магадгүй хэмээн горьдож нүднн том болгон харав.

Хий үзэгдэл оронд нь дөхөж ирээд чагнах мэт зогсов.

Энэ үед гэрлийн туяа шөнийн зочин дээр тусав.

- Үгүй тэр биш байна гэж бүсгүй шивгэнэв.

Залуу бүсгүй судсаа тэмтрэн барьж түргэн цохилтыг нь чагн н хэрэв жаахан юм уучихвал энэ хий үзэгдэл салж арилна байх гэж боджээ. Валентинаг халуурч байна гэж гомдол гаргахад эмч бэлтгэж өгсөн сэрүүцүүлэх, ундааныг уухад ухаан санаа нь сэргэдэг байв. Энэ ундааныг уух бүрд ухаан нь сэргэж хөнгөхөн сайхан болдог байв.

Валентина суларч чичирсэн гараараа болор дийзэн дээрээс шилэн аяга авах гэж сарвайв. Гэтэл хий үзэгдэл ор руу нь түргэн хүрч ирж амьсгаа нь Валентинад мэдэгдхээр тийм ойрхон ирж гар нь ч хүрэх шиг болжээ.

Валентинагийн өрөөнд орж ирдэг хий үзэгдлүүд ийм үнэн юм шиг байрх нь огт тохиолдож байсангүй. Тэгээд бүсгүй энэ бүхнийг илтэд болж, ухаан санаа нь балратаагүй юм байна гэж ойлгоод цочих шиг болжээ.

Гарт нь юм хүрэхэд бүсгүй сарвайсан гараа зогсоолоо. Тэгээд валентина сунгасан гараа аяархан татаж авав.

Тэгэхэд өнөө бүсгүйн нүд салгалгүй харж, айхаасаа итгэх нь илүү болж байсан хий үзэгдэл аягатай ундааныг нь авч, хивсэн дээгүүр чимээгүй алхлан шөнийн дэнлүүний гэрэлд аваачиж цэвэр тунгалгийг нь шалган үзэх мэт харав.

Гэвч энэ халти хийсэн шалгалт нь хангалтгүй санагдав бололтой.

Энэ хүн буюу үнэнээр нь хэлбэл хий үзэгдэл тэрхүү ундаанаас халбагаар жаахан хутгаж аваад амсаж үзлээ. Валентина энэ бүгдийг ихэд гайхан харж байв.

Залуу бүсгүй тэрхүү хий үзэгдлийг алга болж оронд нь өөр юм гарч ирнэ гэж горьдсоор байв. Гэтэл нууц зочин нь сүүдэр мэт замрхан алга болохын оронд бүсгүй дээр хүч ирж аягаа өгөөд тэвдсэн дуугаар,

- Одоо ууж болно!... гэж хэлэв.

Тэгэхэд Валентина цочлоо.

Хий үзэгдэл түүнтэй анх удаа амьд юм шиг ярьжээ.

Бүсгүй хашхирах гэтэл өнөө хүн хуруугаа аман дээрээ тавив.

- Монте-Кристо гүн үү! Гэж бүсгүй шивгэнэлээ.

Бүсгүйн айсан нүд, чичирсэн гар, хөнжлөө бушуухан дээш татахыг нь харвал эргэлзээ нь барин тавин болж байгаа явдалд аргагүй сарнив бололтой. Ийм орой болсон үед Монте-Кристо түүний тасалгаанд байж байгаа, ханын цаанаас хачин сэмхэн гараад ирсэн явдлыг түүний мангартсан ухаан ухааран мэдэрч чадахгүй байв.

- Битгий ай, битгий хүн дууд. Таны зүрхэнд сэжиглэж, зовохын сүүдэр ч бүү үлдэг. Таны өмнөө харж байгаа хүн бол Валентина таны зөв, энэ удаа хий үзэгдэл биш хамгийн ээвэргүү эцэг, таны хүсэж болох хамгийн хүндэт найз мөн гэж гүн хэлэв.

Валентина хариу дуугарсангүй. Түүний өмнө хий үзэгдэл биш амьд хүн зогсож байгааг баталсан энэ дуу охиныг айлгасан учир дуугарч чадсангүй. Түүний айсан харц нь хэрэв таны санаа цэвэр бол яах гэж энд байгаа юм бэ? гэсэн мэт байв.

- Монте-Кристо юм нэвт хардаг хүн учир бүсгүйн сэтгэлд юу бодогдсоныг эгшин зуурын дотор ойлгожээ.

- Миний хэлэхийг сонс, чухамдаа гэвэл миний хавагнасан нүдийг ердийнхөөрөө илүү их цонхийсон царайг минь хар. Би дөрвөн шөнийн турш цурам хийлгүй байж, дөрвөн шөнийн туш таныг манай Максимилианд хадгалан хамгаалж байна гэж хэлэв.

Өвчтөн бүсгүйн царай баярлан улайв. Гүнгийн хэлсэн нэр бүсгүйн итгэлгүй байдлын сүүлчийн ул мөрийг арилгажээ.

- Максимилиан!... Максимилиан гэнэ ээ гэж Валентина их л таалаамжтайгаар хэлээд – Тэр танд бүгдийг нь хэлчихсэн хэрэг үү? Гэлээ.

- Бүгдийг нь. Таны амьдрал бол түүний амьдрал болсон тухайгаа ярьсан. Би таныг амьдарна гэж түүнд амласан.

- Та түүнд амьдарна гэж амласан гэнэ ээ?

- Тийм ээ.

- Та намайг хамгаалж, харж байна гэнэ ээ. Та эмч хүн юм уу?

- Тийм ээ, тэнгэр бурхан танд илүү дээрийг илгээж чадахгүй биз.

- Та хэдэн шөнө унтаагүй гэж ярьсан, тэгэхээр та хаана байсан юм бэ? Би таныг хараагүй юм байна гэж Валентина хэлэв.

Гүн номын шүүгээ өөд гараараа заав.

Энэ хаалга миний хөлслөн авсан байшин руу гардаг юм гэж гүн хэлэв.

Валентина ичиж зовж, дугуйцсэнээс болж цааш эргэв.

- Эрхэм таны энэ хийсэн ажил жишээлгүй тэнэг хэрэг, доромжлолтой дэндүү төстэй байна гэж үнэн голоосоо айсан янзтай хэлэв.

- Валентина энэ нойргүй хоносон урт шөнүүдэд би гагцхүү тан дээр хэн орж ирж, танд ямар хоол унд өгч байгааг л харж байв. Тэгээд авчирч тавьсан ундаан аюултай санагдвал сая гарч ирсэн шигээ гарч ирж аягатай ундааныг асгаж үхлийн хорын оронд амьдралыг аврагч ундаанаар сольж хийдэг байлаа.

- Хор! Үхэл гэнэ ээ! гэж бүсгүй дахин халууран дэмийрч байгаа мэт дуу алдаад – Эрхэм та юу ярина вэ?

- Хүү минь чимэсгүй гэж Монте-Кристо дахин уруулаа гараараа дар!, - Тийм ээ, би хор үхэл гэж хэлсэн, дахиад үхэл гээд хэлчихье. Харин одоо үүнийг уучих гэж хэлээд шингэн улаан зүйл агуулсан шил сав гаргаж ирж, аяган дотор хэдэн дуслыг хийв. – Одоо энүүнийг уучих. Тэгээд өнөө шөнө юу ч битгий уугаарай гэж хэлэв.

Валентина гараа сарвайв. Тэгснээ дөнгөж аяганд гараа хүргэмэгцээ буцаан угз татаж авав.

Тэгэхэд Монте-Кристо гүн аягатайг авч хагасыг нь уугаад Валентинад өгөхөд цаадах нь инээмсэглэн байж үлдсэнийг нь уув.

- Би шөнийнхөө ундааны амтыг таньж байна. Энэ ундаан миний цээжийг уужруулж, ухааныг тайвшруулдаг юм гэж бүсгүй хэлэхэд,

- Валентина та дөрвөн шөнө яаж хоносон гэж санана. Би бас яаж байсан гээч? Ямар аймшигтай цагийг би энд өнгөрүүлж байсан гэж санана. Таны аяганд үхлийн хор хийж байхыг хараад яаж зовж шаналж байсан гээч.

Намайг тэр хорыг задгай зууханд асгаж амжихаас өмнө таныг уучих бий гэж хичнээн айж зовж байсныг яана! гэж гүн хэллээ.

- Та миний аяганд хор хийж байхыг хараад шанлан зовж байсан гэж ярив уу? Тэгвэл та тэр хорыг хэн хийж байсныг харсан биз дээ? гэж Валентина өгүүлэхийн аргагүй их айсан байдлаар хэлэв.
- Тэгсээн.

Валентина орон дээрээ өндийв. Тэгээд цаснаас цагаан цээжээ халууран хүйтэн хөлс нь гарснаас болж чийг даасан цамцаар халхлан:

- Та харсан гэж үү? Гэж асуухад гүн,
 - Тийм эс гэж хариу дуугарав.
 - Энэ чинь аймшигтай байна. Та намайг ад чөтгөрийн тухай бодуулахад хүрч байна. Миний эцгийн гэрт, зовж зүдэрч байгаа миний тасалгаанд намайг алах гэж оролдоод байна гэнэ ээ? Эрхэм та эндээс яв. Та миний ариун сэтгэлийг бузарлаж, бурхан тэнгэрийн ивгээл хайрыг гүтгэж байна. ингэж бодохын арга алга, тэгэх ч ёсгүй!
 - Валентина татэр гарт өртөгдөж байгаа анхны хүн гэж үү? Та Сен-Мераныхны яаж үхсэнийг, Барруа бас яаж үхсэнийг хараагүй гэж үү? Хэрэв эрхэм Нуартъег гурван жил хороор эмчилж, хорын эсэрг хор өгч дасгаагүй байсан бол үхэхгүй байсан гэж үү?
 - Бурхан минь, өвгөн аав тийм болоод л сүүлийн үед өөрийнхөө уудаг эмнээс уухыг шаардаад байдаг байсан байжээ гэж Валентина хэлэв.
 - Тэр ундаа хатаасан жүржийн хальс шиг тийм гашуун амттай байсан уу?
 - Тийм, тийм!
 - Надад одоо бүх зүйл ойлгомжтой боллоо. Нуартъе энд хорлож байгааг, тэр ч байтугай хэн хорлож байгааг мэдэж байжээ. Тэгээд хайртай хүүхдээ алагч хоронд дасгаж, тэр нь энэ хорын хүчийг сулруулсан байжээ. Дөрөв хоногийн өмнө танд зайлшгүй үхүүлдэг хор өгөхөд үхээгүй амьд үлдсэний учрыг би яаж ч бодоод олохгүй бөайсан юм гэж Монте-Кристо хэлэв.
 - Үгүй хэн ингэж алж хорлож байна вэ?
 - Одоо би танаас нэг юм асууя. Шөнө тан дээр хүн орж ирж байхыг та харсан уу?
 - Харсан. Ямар нэг сүүдэр л харагдаад байх шиг байдаг юм. Сүүдэр хүрч ирээд чуцаад явчихыг нь хардаг юм. Гэвч би түүнийг хий үзэгдэл гэж боддог байсан. Өнөөдөр таныг орж ирэхэд бас л зүүд зэргэлээ байх гэж санаж байсан шүү.
 - Тэгвэл таны амьдрал өөд мэн довтолж байгааг мэдэхгүй байх нь ээ?
 - Үгүй, хэн миний үхэхийг хүсэх билээ? гэж Валентина хэлэхэд гүн юм чагнаснаа,
 - Та одоо үзэх болно гэж хэлэв.
- Тэгэхэд Валентина ийш тийшээ харж,
- Яаж үзэх юм бэ? гэж асуув.
 - Одоо танд халуун, дэмийрэх юм алга, ухаан чинь саруул байгаа болохоор үзнэ. Одоо шөнө дунд болж цаг уохилж байна. Энэ бол алуурчны ирдэг цаг.
 - Бурхан минь гэж Валентина хөдөрсөн духаа илэв.

Цагийн зүү шөнө дунд болсныг зааж уйтгартай алгуурхан цохиход цохилт бүр нь бүсгүйн зүрхийг төмөр алхаар балбах мэт санагдан байжээ.

- валентина та одоо хамаг хүчээ гаргаж зүрхнийхээ цохилтыг дарж, айж хашхирахгүй унтаж байгаа дүр үзүүлж бай. Тэгвэл үзэх болно гэж гүн хэлэхэд бүсгүй,
- Би чимээ сонслоо. Та одоо яв гэж хэлэв.
- Баяртай, баяхтай ч гэж дээ түр зуурхан баяртай гэж гүн хэлэв.

Гүн эцэг ёсны энэрэнгүй инээмсэглэлээр инээмсэглэж шүүгээний зүг явахад бүсгүйн зүрхэнд баяр талархлын сэтгэл төрөв.

Тэр хаалгаа хаахын өмнө валентина өөд харж,

- Нэг ч хөдөлж, нэг ч үг дуугарч болохгүй. Таныг унтаж байгаа юм гэж бодог. Тэгэхгүй бол намайг аварч амжихаас минь өмнө таныг алчихна шүү гэж хэлэв.

Гүн энэ аймшигт зүйлийг захиж хэлээд чимээгүй хаагдсан хаалганы цаагуур орж алга боллоо.

4.ХОРЛООЧ

Валентина ганцаараа хоцорлоо. Филипп Рулийнхээс хоцорч явсан хоёр цаг дараа дараагаараа дуугарлаа. Дараа нь чимээ аниргүй нам гүм болж хааяа нэг алсад яваа тэрэгний дугуйн чимээ дуулдана.

Валентинагийн анхаарал, дүүжинг нь секунд тоолон свачиж байгаа ханын цаганд шилжжээ.

Залуу бүсгүй цагийн секунд тоолж эхлэхэд зүрх нь түүнээс хоёр дахин хурдан цохилж байв.

Гэвч бүсгүй бас л эргэлзсэн хэвээр байв. Хөөрхий Валентина хэн нэг хүн түүний үхлийг хүсэн хүлээж байна гэдгийг үнэмшихгүй байв. Яалаа гэж вэ? Ямар зорилгоор тэр вэ? Өөртөө дайсантай болохоор юу хийчихсэн юм бэ?

Бүсгүй унтах тухай бодож ч чадахгүй байна.

Энэ дэлхий дээр түүний алах гэж оролдсон хүн, одоо дахин алах гэж оролдоод байгаа хүн байна гэдэг аймшигт ганцхан бодол түүнийг тарчилгана.

Алуурчин хороор дийлэхгүй нь гэж бодоод Монте-Кристо гүнгийн хэлснээр ган төмөр хэрэглэхэд хүрьэл яана? Гүн түүнд саад болж амжихгүй бол яана? Түүний амьдралын хамгийн сүүлчийн минут ирж дахин Моррелийгоо харахгүй болбол яана?

Валентинаг ингэж бодохоор бие нь хүйт оргиж хонхдож тусламж гуйхад бэлхэн байв.

Гэвч номын шүүгээний хаалган завсраар Монте-Кристовийн нүд харагдаж байх шиг түүнд санагджээ. Бүсгүй энэ нүдний тухай бодохгүй байж чадахгүй байсан бөгөөд гүнгийн даруу биш санаачилга гаргаснаар үүссэн ичгүүртэй байдлаа, баярласан сэтгэл нь хэзээ нэгэн цагт мартуулж чадах эсэхийг мэдэхгүй байв.

Ингэж хорин зуун шиг санагдсан хорни минут өнгөрлөө. Дараа нь бас арван минут өнгөрлөө. Эцэст нь цаг шуугин дуугарч нэг удаа цохилоо.

Яг энэ үед шүүгээний хаалгыг хумсаар маажлах чимээ гарч, гүн сэргэлэн уовоо байгаагаа мэдэгдэж, Валентинаг бас сэргэлэн цовоо байхыг мэдэгджээ.

Тэр даруй Эдуардын өрөөний тэнд царс модон шал дуугарах чимээ гарав. Валентина болгоомжлон амьсгалаа барьж чимээгүй боллоо. Хаалганы бариул дуугарч

үүд нээгдлээ. Валентина ар тийшээ хэвтэж, тохойгоороо нүүрээ дөнгөж таглаж амжив.

Бүсгүй чичрэн дагжиж, өгүүлшгүй их айсны улмаас зүрх нь базлах шиг боллоо. Гэвч хүлээн хэвтэв.

Нэг хүн тасалгаанд орж ирээд, орны хөшгөнд хүрлээ.

Валентина бүх хүчээ гаргаж унтаж байгаа хүн шиг жигдхэн амьсгалж байв.

- Валентина! Гэж нэг хүн дуудлаа.

Бүсгүй дагжсан боловч хариу дуугарахгүй байж чадлаа.

- Валентина! Гэж дахин дуудлаа.

Дуугарсангүй. Валентина сэрэхгүй гэж гүнд амласан байжээ.

Тэгээд Валентина саяхан юм уусан аяганд нь шингэн юм хийж байх чимээ сонсжээ.

Тэгэхэд л бүсгүй зориг гаргаж нүдээ үл мэдэг нээж толгой доогуураа харлаа.

Гэрийн хөнгөн цагаан даашинзтай хүүхэн түүний аяганд шингэн зүйл хийж байв.

Валентина эгшин зуурын дотор амьсгалаа тасалдуулсан буюу эсвэл хөдөлжээ. Хүүхэн айн зогсож бүсгүйг унтаж байгаа эсэхийг харах гэж ор руу тонгойв. Энэ хатагтай Вильфор байв.

Валентина хойд эхийгээ таниад ороо хөдлөхөөр тийм хүчтэй чичирчээ.

Хатагтай Вильфор хана налж, хөшигний цаана нуугдаад Валентинагийн өчүүхэн төдий хөдлөхийг ч ажиглан харж байв.

Монте-Кристогийн болгоомжлуулж хэлснийг бүсгүй саналаа. Хойд эхийн нь гарт урт гэгчЭйн хурц хутганы ир гялалзах шиг санагдав.

Тэгэхэд Валентина ихэд зориг гарган нүдээ анив. Төдий л зориг шаардах биш энэ ердийн хөдөлгөөн түүнд бараг хүч хүрэхгүй шахам хэцүү юм шиг санагджээ. Үнэн мөнийг нь мэдэх гэсэн сониуч сэтгэл түүний нүдийг үл аниулна.

Валентинагийн жигд амьсгалыг сонсож унтаж байна гэж тайвширсан хатагтай Вильфор орны толгой руу татсан хөшигний цаана хагас нуугдан зогсож байгаад, Валентинагийн аяганд өнөө шингэн зүйлээсээ үлдсэн хэсгийг нь хийж орхив.

Дараа нь Валентинад сонстохооргүй аяархан гарч явав.

Валентина, хорин тавхан настай гоо сайхан хүүхний үхлийн хор хийж байгаа булцгархан гарыг дөнгөж сая харлаа.

Хатагтай Вильфор тасалгаанд нь байсан энэ бүтэн хагас минутын хооронд Валентина юу гээч болсныг хэлэхийн арга алга.

Шүүгээг аяархан маажлах чимээ бүсгүйг тэр байдлаас нь сэргээв.

Бүсгүй хүч гарган толгойгоо өндийлгөв.

Номын шүүгээний үүд чимээгүй нээгдэж Монте-Кристо гүн дахин гарч ирэв.

- За яав? Та бас л эргэлзсэн хэвээр байна уу? гэж асуухад Валентина

- Бурхан минь! гэж шивгэнэлээ.

- Та харав уу?

- Тэглээ.

Валентина гиншлээ.

- Таньсан. Гэвч би итгэж үнэмшиж чадахгүй байна гэж бүсгүй хэллээ.

- Та тэгвэл үхэхийг илүүд үзэж, түүгээрээ Максимилианыг алах гэж байна уу?...

Валентинаа өөрт нь галзуурч байх шиг санагдаж,

- Бурхан минь! Бурхан минь! Ги гэрээсээ оргож зайлж болохгүй юм гэж үү? Гэлээ.
 - Валентина минь, таныг мөрдөн хөөж байгаа гар хаана ч гэсэн таныг гүйцэж очно. Алт таны зарц нарыг худалдан авч таныг газар бүхэл үхэл хүлэх болно. Горхийн уснаас уусан ч, модноос алим жимс таслан амссан ч, ер нь хаана ч гэсэн үхэл хүлээж байх болно.
 - Өвгөн аав намайг хоронд дасгажээ гэж та өөрөө хэлсэн шүү дээ.
 - Тийм ээ, тэгэхдээ нэгэн төрлийн хоронд бага хэмжээгээр дасгасан. Гэвч хороо өөрчлөх эсвэл тунгий нь ихэсгэж мэднэ шүү дээ.
- Тэгээд аягыг авч уруулаа хүргэж үзэв.
- Тийм байх ёстой. Таныг гожилоор биш харин унтуулах бодисоор хордуулах гэж боджээ. Би охинд найруулсан түүний амтыг мэдэж байна. Хэрэв та хатагтай Вильфорын энэ аяганд хийсэн юмыг уучихсан бол үхэх байсан даа гэж тэр хэлэв.
 - Бурхан минь! Яалаа гэж тэр намайг хорлож байгаа билээ? гэж бүсгүй дуу алдлаа.
 - Таны зүрх тийм цэвэр, ариун, хүний хүргэдэг хор хөнөөлөөс ангид гэж үү? Хэмээн асуухад,
 - Үгүй, би түүнд ямар ч муу юм хийгээгүй гэж Валентина өгүүллээ.
 - Валентина та чинь баян, жилдээ хоёр зуун мянган ливрийн орлоготой хүн. Та тэр хоёр зуун мянгыг түүний хүүгээс булааж авсан хүн шүү дээ.
 - Яагаад тийм байх билээ? Энэ чинь түүний хөрөнгө биш, эмээ өвөөгөөс надад авлагдсан хөрөнгө.
 - Тэгэлгүй яахав. Тэгээд л Сен-Мераныхан үхсэн юм байхгүй юу. Тэднийг үхсэний дараа хөрөнгө мөнгийг нь та өвлөн авах хэрэгтэй бөйв. Ийм учраас ч та бас үхэх ёстой болжээ. Тэгмэгц таны эцэг таны дараа бүх хөрөнгийг өвлөн авах бөгөөд, түүнийг үхсэний дараа ганц хүү нь болох Эдуар эцгийнхээ өв хөрөнгийг өвлөн авах юм.
 - Эдуард хөөрхий жаал! Ганцхан түүнээс л болж энэ бүх ялт хэрэг хийгдэж байгаа ажээ!
 - Одоо та ойлгов уу?
 - Бурхан минь, энэ бүхэн түүнд бүү гай болог.
 - Валентина, та ёстой тэнгэрлэг охин юм.
 - Өвгөн аавыг минь өрөвдсөн юм биз дээ?
 - Таныг үхсэний дараа түүний хөрөнгө ялгаагүй л таны дүүд шилжиж ирнэ, тэгээд ч ер нь түүнийг алах явдал онц аюултай учраас ашиггүй болжээ.
 - Эмэгтэй хүний ухаанд ийм төлөвлөгөө урган гарч ирдэг юм байжээ! Бурхан минь!
 - Перуджа дахь Шуудангийн зочид буудлын усан үзмийн модот сүүдрэвч, таны хойд эх хүрэн цувтай хүнээс ургамлын хорын тухай асууж байсныг санаж байна уу? тэгэхэд л энэ аймшигт санаа түүний тархинд боловсорсон байна.
 - Ай гүн минь, би тэгвэл үхэх үйлтэй хүн болж байна уу! гэж бүсгүй нулимс гоожуулан асуув.

- Үгүй, Валентина үгүй. Би бүгдийг урьдчилан харсан, таны дайсан танигдсан хойно тэр одоо ялагдсан. Валентина та үхэхгүй, амьдрах болно. Та дурлаж, дурлуулж байхын тулд амьдарна. Өөрөө аз жаргалтай амьдарч, сайн сайхан сэтгэлтэй хүнийг жаргуулахын тулд амьдрах болно. Харин үүний тулд та надад бүрэн итгэх ёстой.
- Гүн минь, би яах ёстойг надад тушаана уу?
- Миний өгснийг уух хэрэгтэй.
- Би ганцаараасан бол үхэхийг илүү дээрд үзэж байгааг минь бурхан хараасай гэж Валентина дуу алдлаа.
- Та хэнд ч тэр ч байтугай эцэгтээ ч нэг ч үг битгий хэлээрэй.
- Харин миний эцэг эн муухай хорт хэрэгт холбогдоогүй биз? гэж Валентина асуув.
- Үгүй, таны эцэг гэмт хэргийг илрүүлэхдээ дадаж мэргэжсэн хнү учир таны гэрт тохиолдож байгаа үхлүүд ер бишийн гэдгийг тааварлаж мэдэх ёстой байсан. Таны эцэг таныг өөрөө хамгаалж энэ үед миний оронд энэ байранд байж байх ёстой байсан юм. Тэр өөрөө энэ шингэнийг асгаж байх ёстой байсан юм. Хий үзэгдэл, хий үзэгдлийнхээ эсрэг босож байна гэж гүн өөрийнхөө бодлыг төгсгөх мэт шивгэнэв.
- Гүн минь энэ ертөнц дээр намайг үхвэл, үхэх хоёр хайртай хүн бий учраас амьдрахын тулд бүхнийг хийе. Энэ хоёр бол өвгөн аав, Максимилиан хоёр минь юм гэж Валентина хэлэв.
- Би таныг хамгаалсан шигээ тэр хоёр чинь хамгаална.
- Би юу хийх ёстой вэ гэж Валентина асуугаад – Бурхан минь юу болдог бол? гэж нэмж шивгэнэв.
- Валентина минь танд юу ч тохиолдлоо гэсэн битгий айгаарай. Та зовж зүдэрч харах сонсох юмгүй болж ухаан балартсан ч битгий айгаарай. Та сэргэхдээ хаана байгаагаа ч мэдэхгүй, тэр ч байтугай авсан дотор байсан ч битгий айгаарай. Тэгэхдээ, ухаан санаагаа чангалж, энэ минутад Максимилиан бид хоёрт аз жаргалыг хүсэж байгаа най хүн минь намайг хамгаалан харж байгаа гэж бодож байгаарай.
- Бурхан минь, үнэхээр тэгэх хэрэгтэй юм гэж үү?
- Та эсвэл хойд эхээ илрүүлчихсэн нь дээр гэж бодож байна уу?
- Үгүй, үгүй үхсэн нь дээр!
- Валентина та үхэхгүй. Танд юу ч тохиолдлоо гэсэн айж сандрахгүй, итгэж найдаж байна гэдгээ надад амлан хэлээч?
- Би Максимилианынхаа тухай бодож байх болно.
- Валентина би таныг төрсөн охин шигээ хайрладаг. Ганцхан би л таныг аварч чадна, аварна чиг.

Валентина залбиран гараа зөрүүллээ. Энэ аймшигт цагт бурхан л түүнийг тэтгэн дэмжиж чадах юм шиг түүнд санагджээ. Тэгээд мөр нь зөвхөн урт үснээс нь өөр юмаар хучигдаагүй, нимгэн даашизны цаанаас зүрхний нь цохилох харагдаж байгааг мартаж хэдэн эв холбоогүй үг хэллээ.

Гүн түүний гарт болгоомжтойгоор хүрч хилэн хөнжлийг нь мөр уруу нь татаж өгөөд эцэг хүний ёсоор инээмсэглэв.

- Хүү минь чи бурхны энэрэл хайр, Максимилианы хайр сэтгэлд итгэдэг шигээ миний үнэнч шударгад итгээрэй гэж хэллээ.

Валентина дуулгавартай хүүхэд шиг түүн өөд талархан харлаа.

Тэгэхэд гүн хантаазныхаа хармаанаас маргад чулуун хөөрөг мэт сав гаргаж алтан таглаагий нь онгойлгож вандуйн чинээ үрэл гаргаж Валентинагийн алган дээр тавив. Валентина түүнийг аваад гүн өөд анхааралтай харлаа.

Түүний аймшиггүй хамгаалагчийн царай дээр агуу хүчирхэг дүр гялалзан харагдлаа. Валентина асууж харахад Монте-Кристо,

- Тийм гэж хариуллаа.

Валентина үрлийг уруулдаа хүргэснээ залгиж орхилоо.

- Хүү минь баяртай, та одоо аврагдсан болохоор би унтахыг оролдъё гэж тэр хэлэв.

- Яв, яв, би ву ч боллоо гэсэн айхгүй гэдгээ танд амлая гэж Валентина хэллээ.

Унтуулах бодисын хүчинд дийлдэж алгуираар нойрсож байгаа бүсгүйг хар! Монте-Кристо удаан зогслоо.

Дараа нь аягыг авч Валентинаг уусан гэж мэдэгдүүлэхийн тулд дөрөвний гурвыг нь задгай зуух руу асугаад үлдсэнийг нь буцааж байранд нь тавиад номынхоо шүгээ рүү очиж Валентина өөд сүүлчийн удаа хараад алга боллоо. Тэнгэрлэг бүсгүй өөрийг бб бүтээгч бурхны хөлийн дэргэд хэвтэж байгаа чигээ тэнгэр шиг тайван нойрсож байв.

5.ВАЛЕНТИНА

Задгай зуухан дээрх дэнгийн гол хөвж байгаа тосны сүүлчийн дуслуудыг шингээн авч асаж байв. Гэрэл улам сүүмийж, шатдаггүй цаасан бүрхүүлийг улбар улаан гэрлээр гэрэлтүүлж, унтарч байгаа гэрэл пад падхийн дуугарч сүүлчийн удаа нэлсхийх нь амьд амьтан үхэхийн өмнө татваганадагтай төстэй харагдана. Валентинагийн орны цагаан даавуун дээр бүдэг гэрэл зэвүүнээр тусна.

Гудамжны чимээ татарч хачин жихүүцмээр нам гүм боллоо.

Тэгтэл Эдуардын өрөөний хаалга онгойж бидний түрүүчийн харсан царай толинд харагдлаа. Энэ бол ундааныхаа хүч чадлыг үзэх гэж ирсэн хатагтай Вильфор байв.

Тэр хүүхэн босгон дээр зогсож, энэ хүн амьтангүй юм шиг тасалгаан доторч дуугарч байгаа ганцхан чимээ болох дэнгийн гол шаржигнахыг чагнаж байснаа, аягаа хоосорсон эсэхийг үзэх гэж шөнийн ширээ өөд аяархан очлоо.

Энэ аяга бидний дээр өгүүлснээр дөрөвний нэгдээ хүртэл дотроо юмтай байв. хатагтай Вильфор аягыг авч доторхыг нь зууханп асгаад үнсэнд сайн шингээхийн тулд хутгачив. Тэгээд аягаа сайн гэгч зайлаад, алчуураараа арчиж, хуучин байранд нь тавив.

Валентинагийн орны дэргэд очиж түүнийг харах гэж зүрхлэхгүй удаан зогсов.

Энэ баргар бүдэг гэрэл, чимээ аниргүй бейдал түүний сэтгэл зүрхний гүнд нөлөөлсөн биз. Хорлогч хүүхэн хийсэн нүглээсээ айж байлаа.

Эцэст нь зориг орж хөшгийг хойш яраад Валентинаг харав.

Бүсгүй амьсгалахгүй байв. Хамгийн хөнгөн өд ч гэсэн түүний хагас ангайсан хөдөлгөөнгүй уруул дээр тавихад хөдлөхөөргүй бөгөөд зовхи нь бага зэрэг сэлхийж хөхрөн сүүдэртэн урт хар соормуус нь шаргалтсан царай дээр нь тодхон харагдана.

Хатагтай Вильфор энэ хөдөлгөөнгүй сайхан царайг хөрж удаан зогслоо. Эцэст нь зориглож хөнжлийг нь сөхөж гараа охины зүрхэн дээр тавив.

Зүрх нь үл цохилно.

Харин өөрийнхөө зүрхний цохилтыг гартаа мэдэрч байв. Хүүхэн цоиж гараа татаж авав.

Валентинагийн нэг гар орноосоо унжжээ. Энэ гар Жермен Пилоны урлан барьсан баримлын гар шиг харагдаж байлаа. Харин гарын нь царвуу татваганаснаас болж бага зэрэг эвгүй болсон бөгөөд хуруунууд нь орны улаан модон дээр тээглэн хөшжээ.

Хумс нь хөхөрчээ.

Хатагтай Вильфорт эргэлзэх юм байсангүй. Бүх зүйл гүйцсэн байв. Түүний бодож төлөвлөсөн хамгийн сүүлчийн санаа бодол хэрэгжин биелжээ.

Түүнд энэ тасалгаанд өөр хийх юм байсангүй. Тэгээд хөшигнөөс барьсан хэвээр, хөлийн чимээгээ хивсэн дээр гарахаасаа айсан мэт аяархан гэдрэг ухрав.

Минут өнгөрөх боловч хатагтай хөшгөө тавьж чадахгүй барьсаар Үайв. Хүүхэн бодож зогссон бөгөөд, хэрэгтэн хүний бодох гэдэг бол зовж шаналах гэсэн үг юм.

Дэнгийн гол улам шаржигнан дуугарлаа.

Тэгэхэд хатагтай Вильфор цочиж барьж байсан хөшгөө тавьчихлаа.

Яг тэр үед дэн унтарч, тасалгаан дотор пад харанхуй боллоо.

Энэ харанхуйн дунд цаг амь орж дөрвөн цаг хагас болсныг зааж дуугарлаа.

Хорлогч хүүхэн сандарч тэмтчин, духан дээр нь хүйтэн хөлс бурзайн өрөө рүүгээ буцлаа.

Бас хоёр цаг хэртэй тасалгаан дотор харанхуй байв.

Дараа нь цонхны хаалтны завсраар гэрэл тусаж алгуурхнаар гэгээ орлоо. Туссан гэгээ улам улам тодорч тасалгаан дотор байгаа юмны өнгө дүрс тодрон харагдав.

Удалгүй шатан дээр хүн ханиах сонсдож, сахиул хүүхэн аягатай цай барьж Валентинагийн тасалгаанд орж ирлээ.

Эцэг нь буюу дурлалт хүн нь харсан бол Валентинаг үхжээ гэж хараад л мэдэх байсан бөйх. Харин эн хөлсний хүнд бол Валентина зөвхөн унтаж байгаа харагдав.

Тэгээд тэр хүүхэн шөнийн ширээний дэргэд очиж,

- Ундааныхаа хагасыг уужээ. Аяганы нь гурваны роёр хоосон байна гэж хэлэв.

Дараа нь задгай зуухны дэргэд очиж гал асаагаад зөөлөн сандал дээр сууж, дөнгөж саяхан хөнжлөөсөө босж ирсэн боловч Валентинагийн унтаж байгааг ашиглаад бас жаахан дуг хийгээд авъя гэж шийдэв.

Тэгээд найман цаг дуугарахад сэржээ.

Тэгээд Валентинагийн сэрээгүй унтаж байгааг гайха!, гар нь унжсан хэвээр хөдлөөгүй байгааг харж айн босож, орны нь дэргэд очиж уриул, цээж нь хөрсөн байхыг сая л ажиглав.

Валентинагийн гарыг өргөх гэсэн боловч хөшсөн гар хөдөлж өгсөнгүй учир, сахиул хүүхэн бүх учрыг мэдэв.

Тэгээд айн хашхирч үүд рүү гүйв.

- Туслаара! Туслаарай! Гэж хашхирав.
- Юу болов? гэж д Авринь дуугарах дуулдав. Энэ бол эмчийн ирдэг цаг байжээ.
- Юу болов? гэж Вильфор тасалгаанаасаа яаран гарч ирээд асууж, - Эмчээ, туслаарай гэж дуудаж байгааг сонсож байна уу? гэв.
- Тийм байна. Валентина дээр бушуухан очъё гэж д Авринь хэлэв.

Гэвч эцэг эмч хоёрыг хүрч очихоос өмнө гудам тасалгаануудаар байсан зарц нар гүйн очиж Валентинагийн өрөөнд орж түүнийг орон дээрээ зэвхий царайтай блчихсон хөдлөлгүй хэвтэж байхыг харж халаг хоолой бололцлоо.

Вангийн прокурор тасалгаанд айсан мэт босгон дээр зогсож,

- Хатагтай Вильфорыг дуудаарай, хатагтай Вильфорыг сэрээгээрэй гэж хашхирав.

Гэвч зарц нар хариу хэлэлгүй тасалгаанд орж, валентина өөд гүйж очоод түүнийг өргөж үзэж байсан д Авринийг харж зогсоно.

- Энэ нь бас! Ай, бурхан минь, хэзээ нэг төгсөх юм бол доо? гэж хэлээд эмч охиныг доош тавив.

Вильфор тасалгаанд гүйн орж ирж,

- Бурхан минь та юу гэж хэлэв? Гэж тэвдэн хашхирав. Тэгэхэд Д Авринь,
- Валентина үхчихжээ гэж би хэлж байна гэж дийлсэн мэт сүртэй байдлаар хэлэв.

Вильфор Валентинагийн хөнжил дээр толгойгоо шааж хадуурт ши°вүүлсэн мэт сөхрөн унав.

Эмчийн үг, эцгийн дуу алдахыг сонссон зарц нар ам амандаа хараал зүхэл тавьсаар гарч Лүйлдэв. Шат, гудмаар тэдний дуу шуугиан дуулдаж хашаан дотор дуу гарлаа. Дараа нь цөм нам гүм боллоо. Зарц нар цөм энэ хилэнцэт байшингаас зайлан зугтжээ.

Тэгэхэд хатагтай Вильфор алчуур мөрөн дээгүүрээ хаячихсан хүрч ирээд хаалганы хөшиг сөхөж гайхсан мэт дүр үзүүлэн хэдэн дусал нулимс гаргах гэж хичээн босгон дээр зогслоо.

Хүүхэн гэнэт царай нь дэвхийрэн гараа сарвайн шөнийн ширээ рүү ухасхийв.

Хүүхэн өөрийн гараар шөнө нь асгаж цэвэрлэсэн аягыг нь д Авринь анхааралтайгаар тонгойн үзэж байхыг харжээ.

Хатагтайн зуухны үнс рүү асгасны чинээ хэмжээний шингэн зүйл гэж аяган дотор байж байв.

Валентинагийн сүнс босож ирж түүний өмнө зогссон ч гэсэн ингэж айж сандрахгүй байсан биз.

Энэ ундааны өнгөн Валентинагийн аяганд хийж өгөөд уулгачихсан тэрхүү ундааны өнгө мөн байв. Энэ хор д Авринийн нүдийг хуурч чадахгүй бөгөөд д Авринь түүнийг анхааралтай харж байв. Энэ бол бурхны бүтээсэн гайхамшиг бөгөөд ялт хэргийн ул мөр, нотолгоо үлджээ.

- Энэ хүнцэл лав биш байна. Юу болохыг нь үзье л дээ гэж эмч шивгэнэв.

Тэгээд эмчийн сан болж хувирсан шүүгээ рүү очиж шилэн лонхтой азотын хүчил гаргаж шингэн дээр хийвэл тэр нь цусан улаан өнгөтэй болж хувирав. Тэгэхэд д Авринийн нүдийг хуурч чадахгүй бөгөөд д Авринь нарийн төвөгтэй бодлогыг шийдвэрлэсэн эрдэмтэн шиг баярлан,

- Ийм байдаг байж! Гэж хэллээ.

Хатагтай Вильфор ийш тийшээ харав. Нүд нь очоор гялалзсанаа унтрав. Хүүхэн гуйвж, гараа^оаа тэмтчин хаалга олон гарч алга боллоо.

Минутын дараа нэг хүн ойчих бөглүү дуу гарав.

Гэвч хэн ч түүнийг анхаарсангүй. Сахиул хүүхэн эмчийн хийж байгаа юмыг харж, Вильфор өнөө л хэвээрээ хэвтэж байв.

Ганцхан д Авринь л хатагтай Вильфорыг ажигласан бөгөөд яаран гарч явахыг нь харсан ажээ.

Тэгээд хөшиг сөхөж Эдуардын тасалгаа дамжуулан унлагын өрөө рүү харвал хатагтай Вильфор шалан дээр хөдлөлгүй хэвтэж байв.

- Тийшээ оч, хатагтай Вильфорын бие муу байна гэж сахиул хүүхэнд хэлэв.

- Үгүй мадмуазель Валентинаг яах вэ? гэж тээнэгэлзэн хэлэхэд нь

- Мадмуазель Валентинад одоо тусламж хэрггүй болсон. Энэ бүсгүй үхчихжээ гэж д Авринь хэлэв.

- Үхчихлээ! Үхчихлээ! Гэж Вильфор, энэ төмөр зүрхнээс анх гарч байгаа шинэ, огт үзэгдэж харагдаагүй сэтгэл шимшрүүлсэн зовлонт дуугаар гиншлээ.

- Би юу дуулав! Үхчихлээ гэнэ үү? Валентина үхсэн гэж хэн хэлж байгаа юм бэ? хэмээн гурав дахь хүн дуугарах сонстлоо.

Вильфор эмч хоёр эргэж харав. Үүдэн дээр сэтгэл нь донслон, царай нь зэвийж хачин аймаах болчихсон Моррель зогсож байв.

Ийм явдал болжээ.

Моррель ирдэг цагтаа Нуартъегийн өрөө рүү орчин жижиг хаалгаар орж ирлээ.

Хаалга нь ердийн заншлаар түгжээтэй биш байв. Тийм учраас хонхдож дуудах хэрэг болсонгүй зүгээр ороод иржээ.

Үүдний өрөөнд хүрч ирээд Нуартъе дээр хүргүүлэх гэж зарц нарас нь дуудахад хэн ч хариу дуугарсагүй. Зарц нар тэднийхийг хаяад явчихсан байсныг бид мэднэ.

Моррель төдий л зовох шалтгаангүй байв. Монте-Кристо түүнд Валентинаг амьдрах болно гэж хэлсэн бөгөөд тэр амлалт нь одоо хүртэл биелэгдэж байсан ажээ. Орой бүхэн гүн түүнд сайхна мэдээ авчирч өгөх бөгөөд маргааш нь Нуартъе түүнийг нь нотолдог байв.

Гэсэн ч энэ хүн амьтангүй зэлүүд байдал түүнд аймшигтай санагджээ. Тэр дахиж дуудав. Гурав дахь удаагаа дуудлаа. Мөн л чимээ аниргүй хэвээр байв.

Тэгэхээр нь дээшээ гарахаар шийдлээ. _

Бусад хаалгануудын адил Нуартъегийн өрөөний үүд онгорхой байв.

Моррельд хамгийн түрүүдн ердийн байдлаар сандал дээрээ сууж байгаа Нуартъе харагдлаа. Түүний царай маш цонхигор бөгөөд бүлтгэр нүдэнд нь айсан шинж тогтжээ.

- Эрхэм та сайн байна уу? гэж Моррель тайван бишээр асуув.

- Сайн, сайн гэж өвгөн хариулав.

Гэвч түүний царайд их л түгшүүртэй байдал илэрхий.

- Та ямар нэг юманд сэтгэл зовоо юу? Зарц нарын аль нэгийг дуудуулах уу? гэж Моррель асуув.

- Тийм гэж Нуартье дохив

Моррель байдаг чадлаараа хонходлоо. Гэвч хонхны оосроос хичнээн дугтравч хэг ч ирсэнгүй.

Тэгээд Нуартье өөд харахад түүний царай улам зэвхийрч, улам ч түгшүүртэй болж байв.

- Бурхан минь! Яагаад хэн чирэхгүй байна вэ? Бас хэн нэг нь өвдчихсэн юм биш байгаа даа? гэж Моррель хэлэв.

Нуартьегийн нүд аяганаасаа бүлтэрчих шахаж байв.

- Та яаж байна? Та намайг айлгачихлаа. Валентина?... гэж Моррель хэлэхэд,

- Тийм тийм! гэж Нуартье хэллэв.

Максимилиан амаа ангайсан боловч нэг ч үг дуугарч чадсангүй гуйвж хана түшив.

Дараа нь тэр хаалга өөд заав.

- Тийм, тийм, тийм! гэж өвгөн дохив.

Максимилиан жижигхэн шат өөд ухасхийн хоёрхон харайгаад дээр нь гарахад Нуартьегийн нүд түүний хойноос “бушуул, бушуул!” гэж хашхирах мэт харж байв.

Моррель минутын дараа хэд хэдэн тасалгааг дайран гүйхэд бас л бүх байшингийн адил хов хоосон бөгөөд валентинагийн тасалгаанд хүрэхэд түүнд хаалга онгойлгох хэрэг тохиолдсонгүй. валентинагийн өрөөний хаалга тэлчихсэн байв.

Хамгийн түрүүнд хүний мэгшин уйлахыг сонслоо. Тэгээд цагаан даавуунд шурган өвдөг дээрээ суусан хүний бараан дүрсийг харав. Үхлийн аймшиг түүнийг босгон дээр хадаж зогсоолоо. Тэгэхэд л тэр Валентинаг үхчихсэн гэх дууг, нөгөө хүн нь түүний хариу цуурай мэт “Үхчихжий? үхчихжий?” гэж хэлэхийг сонсжээ.

6. МАКСИМИЛИАН

Вильфор ийм гутаж гунихарсан байдалд байхыг нь хүн харсан явдалд бараг ичиж босож ирлээ.

Хорин таван жил аймшигт яллагчийн үүрэгт ажил хийсэн нь түүнийг хүнээс илүү ч юм уу магадгүй хүнээс доор амьтан болгочихжээ. Түүний гайхаж мэлэрсэн харц нь Максимлиан дээр туслаа.

- Эрхэм та чийн хэн гээч байна даа? Хаанаас гараад ирэв? Үхэл орогнож байгаа гэрт ингэж орж болдоггүй юм. Одоо зайл! Гэж Вильфор хэлэв.

Моррель хөдлөхгүй боловч тэрхүү аймшигт үзэгдэл, үрчийсэн хөнжи», дэр дээрх цонхигор нүүрнээс нүд салгалгүй зогсож байв.

- Яв, яв! Дуулж байна? гэж Вильфор хашхирав.

Д Авринь бас Максимилианыг гаргах гэж дэргэд нь очлоо.

Тэгэхэд тэр ухаангүй нүдээр валентина, хоёр эрэгтэй хүн ба тасалгааг харж ямар нэг юм хэлэх гээд үгээ олохгүй байх шиг байснаа гэнэт толгойгоо атган үүд рүү

гүйв. Өөр өөрсдийн бодлоос нэгэн минут хэр хөндийрсөн Вильфор, д Авриньи хоёр түүний хойноос харснаа “Энэ галзуу хүн байна” гэж хэлэх мэт өөд өөдөөсөө харлаа.

Гэвч таван минут ч өнгөрөөгүй байтал, хүнд хөлийн доор шат шаржигнан чихарч, Моррель хүний хэрээс хэтэрсэн их хүчээр Нуартъег санадтай нь өргөн хочрдугаар давхарт гаргаж ирэв.

Моррель шатны дээрх талбайд хүрч ирээд сандлыг нь доош тавьж түргэн түрж Валентнагийн өрөөнд оруулав.

Тэр бүхнийг айж сандарсан хүний арван давхар хүчээр хийжээ.

Моррель өвгөнийг Валентинагийн орны дэргэд иүрж авчрахад Нуартъегийн царай бүхнээс илүү аймшигтай муухай байлаа. Энэ нүүр дээр ганцхан нүд л амьд үлдсэн бөгөөд саа дайрсан өвгөний бүх л хүч чадал энэ нүдэнд хуран цугларна. Энэхүү асах мэт гялалзан байгаа нүдтэй цагаан царайг хараад Вильфор айлаа.

Вильфор амьдралынхаа туршид эцэгтэйгээ дайралдах бүрд ямар нэг аймшигт явдал болдог байжээ.

- Эдний хийсэн юмыг хараач! гэж Моррель нэг гараараа түлхэж ирсэн сандлаа түшиж нөгөө гараараа Валентина өөд зааж хэлээд – хараач эцэг минь! гэлээ.

Нуартъе эцгээ гэж нэрлэж байгаа бараг танихгүй залууг хараад Вильфор гайхаж, гэдрэг ухарлаа.

Өвгөний бүх сэтгэхүй нь цусаар зүүрсэн нүдэнд нь шилжсэн юм шиг харагдаж байв. Хүзүү, хацар, духны нь судсууд гүрийн хөхөрчээ. Түүний бүх биеийг дайрсан дэлбэрэлтэд ганцхан хашхирах дуу л дутаад байв.

Д Авриньи өвгөн өөд ухасхийн спирт үнэртүүлээ. Тэгэхэд Моррель саад дайрагдсан өвгөний хөдөлгөөнгүй гараас барьж,

- Намайг хэнэ болохыг, энд байх ямар эрхтэй юм бэ? гэж асууж байна. Та мэдэх учир эдэнд хэлж өгнө үү? Гэж хэллээ.

Мэгшин уйлах нь түүний дууг дарна.

Тасалдсан амьсгаа өвгөний цээжийг доргиулж энэ нь ухаан алдаж унахтай адил болж байв.

Эцэст нь Нуартъегийн нүднээс нулимсгүй мэгшиж байгаа Моррелийнхийг бодвол илүү дээр нулимс урсан гарав. Өвгөн толгойгоо тонгойж чадахгүй учир нүдээ анив.

- Би түүний болзоот хархүү нь байсан юм гэж эдэнд хэлээч. Валентина энэ дэлхий дээрх миний ганц найз нөхөр, ганц хайр минь байсан юм гэж хэлээч! Түүний амьсгаагүй бие минийх гэдгийг эдэнд хэлж өгөөч! гэж Моррель үргэлжлэн хэлэв.

Тэгээд орны өмнө очиж сөгдөн унаж охины гараас зууран авав.

Уй гашууд дарагдсан энэ хүчирхэг том хүнийг харахад зовууртай тул д Авриньи хөдөлсөн сэтгэлээ нуух гэж эргэж харлаа.

Вильфор хайрлаж, харамсан уйлж хайлж байгаа хүнд нь хайртай дотно сэтгэлт хүнийг хараад өөр тайлбар шаардсангүй түүнд гараа өглөө.

Гэвч Максимилиан юу ч харсангүй. Валентинагийн хөрч мөс шиг болсон гарыг барьж, уйлж унжиж сураагүй учир орны даавууны нь сэжүүрээс шүдээрээ хазалж, бүдэгхэн гиншиж байв.

Энэ тасалгааны дотор хэдэн минутын туршид зөвхөн уйлах, орилох, харааж зүхэх, мөргөж залбирах дуу л сонстож байв.

Гэсэн ч нэгэн дуу тэдэн дундээс ноёлж байв. Энэ бол Нуартъегийн аймшигтай сөөнгө амьсгал байв. Амьсгал авах бүрд нь түүний цээжин дэх амьсгалын судас тасарч байх шиг санагдаж байв.

Эцэст нь Максимилианд байраа тавьж өгсөн мэт байсан Вильфор бусдаас илүү биеэ барьж түрүүлэн дуугарлаа.

- Эрхэм та валентинад дурлаж, түүний болзоот хархүү нь байсан гэж ярив уу? Би энэ дурлалын тухай, та нарын ярилцаж тохирсон тухай мэдээгүй. Гэвч түүний эцгийн хувьд таны үүнийг уучилъя. Таны уй гашуу их бөгөөд үнэнхүү байгааг би харж байна.

Би хорсож уурлахын аргагүй миний сэтгэл тийм их уйтгар гунигтай байна.

Танд аз жаргалыг авчрах гэж байсан тэнгэрлэг охин газар дэлхийг орхин одлоо. Одоо тэр бурхны өмнө очсон учир газрын хүн хүсэн мөрөөдөх хэрэггүй болсон. Та түүний бие цогцостой салах ёс гүйцэтгэж хүсэн хүлээж байсан гарыг нь үнэсээд үүрд салж яв даа. Одоо Валентинад зөвхөн хойтохыг унших лам л хэрэгтэй.

Вильфорыг ингэж хэлэхэд Моррелийн зүрх хэзээ ч өвдөж байгаагүйгээрээ өвдөж, өрөөсөн өвдөг дээрээ өндийж,

- Эрхэм та ташаарч байна. Та андуурч байна. Валентина үхсэн, хэдий тийм боловч Валентинад бол зөвхөн лам шаардагдах биш, бас өшөө авагч шаардагдах тийм үүлээр үхсэн! Эрхэм де Вильфор та ламд хүн явуул, харин өшөө авагч нь би болно! гэв.

- Эрхэм та юу гэх гээ вэ? гэж Вильфор бувтналаа.

Гэвч Моррелийн хагас ухаантай хашхирах дуу түүнийг цочоон зог тусав.

- Би таныг хоёр хүн гэж хэлэх гэж байна гэж Моррель үргэлжлэн хэлээд, - Эцгийн хувьд хангалттай уйлж унжлаа. Харин одоо вангийн прокурор нь гарч ирэх хэрэгтэй байна гэв.

Нуартъегийн нүд гялалзаж, д Авринь түүн өөд ойртож очлоо. Моррель тэнд байгаа хүмүүсийн царайгаар сэтгэлийн нь байдлыг тааварлан мэдэж,

- Эрхэм минь, би юу ярьж байгаагаа мэдэж байна. Та нар миний хэлэх гэж байгаа юмыг надаас доргүй мэдэж байгаа. Валентинаг алсан шүү дээ гэв.

Вильфор доош тонгойж, Д Авринь бас нэг алхам дөхлөө. Нуартъе өвгөн батлан зовхио доош буулгалаа.

- Одоо манай үед Валентинагийнх шиг залуу сайхан амийг түүний үхлийн тооцоог хийлгүйгээр алдаж бөөлөхгүй. Эрхэм вангийн прокурор, энд өрөвдөж хайрлах юм байхгүй! Би танд гэмт хэргийг нь зааж өгье. Харин та алуурчныг эрж олоорой! Гэж Моррель улам шийдэмгийгээр үгээ төгсгөв.

Түүний цөхөршгүй харц Вильфороос хүсэн гуйх мэт харах бөгөөд Вильфор өөрөө Нуартъе, д Авринь хоёр өөд харна.

Гэтэл эцэг, эмч хоёр Вильфорыг дэмжихийн оронд мөн л цөхөршгүй янзаар харж байв.

- Тийм гэсэн янзтай өвгөн харав.
- Үнэн гэж д Авринь хэлэв.

Тэгэхэд Вильфор гурван хүний санаа зоригийг дагаж хөдөлсөн сэтгэлээ дарж,

- Эрхэм та ташаарч байна. Миний гэрт гэмт хэрэг хийгдээгүй. Н майг хувь заяа минь ниргэж, бурхан тэнгэр хшндээр шалган туршиж байгаагаас биш, манайд хэн ч хэнийг ч алаагүй! гэж хэллээ.

Нуартъегийн нүд гялалзаж, Д Аврины юм хэлэх гэж ам ангайхад Моррель чимээгүй байхыг уриалан дуудаж гараа сунгаж чанга биш боловч аймшигтайгаар,

- Энд алж байна гэдгийг би танд хэлж байна шүү. Энэ бол дөрвөн сарын дотор дөрөв дэх удаа тохиолдож байгаа үхэл! Гэж би танд хэлж байна.

Дөрөв хоногийн өмнө Валентинаг хорлох гэж оролдсон боловч Нуартъе гуай урьдаас болгоомжилсны ачаар энэ явдал бүтээгүй юм гэдгийг хэлж байна.

Д Аврины гжйа танд энэ талаар эмч, найзын хувьд урвдаас сануулан хэлж байсан учир та энэ бүгдийг надаас илүү мэдэж байх ёстой гэдгийг би хэлж байна гэв.

- Та дэмийрч байна гэж Вильфор өөрийгөө улам улам боож байгаа гогцооноос мултрах гэж оролдож хэлэхэд,

- Би дэмийрч байна гэж үү? Гэж Моррель дуу алдаад – Тэгвэл би эрхэм Авриньид хандаж асууя л даа. Эрхэм та түүнээс Сен-Мераныг үхсэн үдэш энэ байшингийн өмнөх цэцэрлэг дотор хэлсэн үгээ санаж байна уу гэж асуу л даа. Тэгэхэд та нар хоёулхнаа байна гэж бодож байгаад энэ эмгэнэлт үхлийн тухай ярьж байсан шүү дээ. Та хувь заяа ийм хэмээн бурхан тэнгэрийг шударга бишээр зэмлэж байна. Хувь заяа, бурхан тэнгэр энэ үхэлд Валзнтинаг алагчийг бүтээхнээрээ л оролцож байна! гэж хэллээ.

Вильфор, д Аврины хоёр өөж өөдөөсөө харлаа.

- Тийм ээ та хоёр хоёулхнаа байж, нам гүмийн дуд ярьсан гэж бодож байгаа байх. Гэтэл энэ яриа чинь шөнийн харанхуйд тархаж, миний чихэнд дуулдсан юм.

Би энэ үдшийн дараа эрхэм де Вильфор ойрхны хүмүүсээ энэрэн уучилж байгааг хараад ялт хэрэг хийж байгааг би дээд эрх мэдөийн газарт илчлэн мэдэгдэх ёстой байсан юм. Тэгсэн бол хайрт Валентина чамайгаа үхүүлсэн буруутны нэг нь болохгүй байсан билээ! Гэвч гэм буруутан би өшөө авагч болон хувирна. Хэрэв эцэг чинь чамайг орхивол би чамайг алсан алуурчныг мөрдөн дагаж өшөөгий чинь авна!

Өөрөө өөрийгөө хүчинд нугарахад бэлхэн байсан энэ хүнийг байгаль ертөнц энэрэн хайрлах мэт болж сүүлчийн үг хоолой дээр нь тээглэн зогсож мэгшин уйлж уухилах чимээ цээжнээс нь гарч, гуйвалзаад Валентинагийн орны дэргэд сөхрөн унав.

Тэгэхэд д Аврины ээлж боллоо.

- Би Моррель гуайтай санал нийлж шударга үнэнийг шүүхийг шаардаж байна гэж тэр чанга хэлээд – Миний энэрэнгүй биш сэтгэл алуурчийг өөгшүүлснээ бодоход зүрх минь хагарах гэж байна гэлээ.

- Бурхан минь гэж Вильфор дөнгөж сонстох төдий шивгэнэлээ.

Моррель толгойгоо өндийлгөж өвгөний нүд хүний биш галаар гялалзаж байхыг хараад,

- хараач, эрхэм Нуартъе юм хэлэх гэж хүсэж байна гэв.

- Тийм гэж Нуартъе улам ч аймшигтайгаар хэллээ.

Золгүй энэ өвгөний бүх л чадал ганцхан энэ нүдэнд нь бөөгнөрсөн учир тийм аймшигтай харагдж байжээ.

- Та алуурчныг мэдэх үү? Гэж Моррель асуухад Нуартъе,

- Тийм гэж хариуллаа.
- Та түүнийг бидэнд зааж өгөх үү? Бид чагнаж байя? Эрхэм д Авринь та чагнаарай! Гэж Моррель хэлэв.

Тэгэхэд Нуартье Валентинаг тэгж их баярлуулдаг байсан тэр уйтгартай эелдэг зөөлөн инээмсэглэлээрээ инээмсэглэв.

Дараа нь тэр ярилцаж байгаа хүнийхээ харцтай хараагаа тулган үүд рүү чиглүүлэв.

- Та намайг гарахыг хүсэж байна уу? гэж Моррель гунигтайгаар асуухад,
- Тийм гэж өвгөн хариуллаа.
- Намайг өрөвдөөч!

Өвгөний нүд хаалга руу харсан хэвээрээ байв.

- Дараа нь би орж ирж болох уу? гэж Максимилиан асуув.
- Болно.
- Би ганцаараа гарах ёстой юу?
- Үгүй.
- Би хэнтэй хамт гарах ёстой вэ? Эрхэм Вильфортой юу?
- Үгүй. Эмчтэй юу?
- Тийм.
- Та эрхэм де Вильфортой хоёулхнаа үлдэх гэж хүссэн юм уу?
- Тийм.
- Тэр таны хэлэхийг ойлгох уу?
- Ойлгоно.

Бүү санаа зов, би эцгийнхээ санааг бүрэн ойлгодог юм гэж хоёулхнаа үлдэхэд баярласан Вильфор хэлэв.

Вильфор энэ үгийг баярласан царайтай хэлж байсан боловч шүд нь тачигнаж байв.

Д Авринь Максимилианы гараас сугадан зэргэлдээх өрөөнд орлоо.

Тэгэхэд тасалгаан дотор үхлийн нас гүмээс илүү анир чимээгүй байдал тогтлоо.

Тэгтэл арван таван минут хэртэй болсны дараа хүний хөлийн чимээ гарч д Авринь, Моррель хоёр нэг нь бодлогошрон, нөгөө нь гашуудан амьсгаадаж суусан зчодын өрөөнд Вильфор орж ирэв.

- Явцгаая гэж Вильфор хэллээ.

Тэгээд тэлнийг Нуартье дээр дагуулан орлоо.

Моррель анхааралтайгаар Вильфорыг харлаа.

Вангийн прокурорын царай үхээрийн зэвхий цагаан ыболсон байв. Духан дээр нь хүрэн толбо гарсан байв. гарын нь хуруунууд өдөн үзгээ жижиг жижгээр хугачна.

- Эрхмүүд ээ, энэ аймшигт нууц, үхтэл маань бидний зүрхэнд хадгалагдана гэж надад амлаж хэлээч! Гэж д Авринь Моррель хоёрт хандаж хэлэв.

Тэд нар өөрийн эрхгүй хөдөлцгөөлөө.

- Би гуйя та нараас гэж Вильфор хэлэхэд,
- Тэр гэм буруутан, алуурч, хорлогч хэн бэ? гэж Моррель асуулаа.
- Эрхэм минь, шударга үнэнийн шүүх ажиллах болно, битгий зов. Миний эцэг тэрхүү хэрэгтэн хүний нэрийг надад хэлж өгсөн. Миний эцэг бас та нар

шиг өшөө авахыг тэсгэлгүй хүэж байна. Гэвч тэр, миний адилаар гэмт хэргийн нууцыг хадгалж байхыг хүсэж байна. Тийм ээ аав минь? гэж Вильфор хэлэв.

- Тийм гэж Нуартье өвгөн баттай хэлэв.

Моррель итгэхгүй янзтайгаар, өөрийн эрхгүй хөдлөн гуйвлав. Тэгэхэд Вильфор түүний гараас түшиж,

- Эрхэм минь, миний эцэг бол цөхөршгүй зоригтой хүн болохоор нэгэнт л танд тэгж хэлж байгаа бол Валентинагийн өшөөг хатуу ширүүнээр аван гэдэгт итгэж байгаа хэрэг гэв.

Өвгөн тийм гэсний тэмдэг болгон дохилоо.

Вильфор цааш үргэлжлүүлэн,

- Тэр намайг мэднэ. Би түүнд ам тангараг өгсөн. Эрхмүүд ээ та нар тайван байж болно. Би та нараас гурав хоногийн хугацаа гуйя. Энэ бол шүүх та наараас хүсэхээс илүү бага хугацаа шүү. гурав хоногийн дараа миний охиныг алсан хүн дээр тусах өшөө хорсол нь хамгийн хайхрамжгүй сэтгэлтэй хүний зүрхийг ч донсолгох болно. Тийм ээ аав аа? гэв.

Тэр энэ үгийг хэлэхдээ шүдээ хавирч, өвгөний мэдрэлгүй гарыг атгав.

- Эрхэм Нуартье, энэ амлалт биелэгдэх үү? Гэж Моррель асуухад, д Авриньийн харц бас тэгж асууж байв.

- Тийм ээ! гэж Нуартьегийн нүд хариу дохив.

Тэгэхэд Вильфор д Авринь ба Моррель хоёрын гарыг нийлүүлж,

- Эрхмүүд ээ, та нар миний гэрийн нэр төрийг хамгаалж, өвөө авах явдлыг ганцхан надад даатгаж орхи гэж хэллээ.

Д Авринь эргэж дургүйхэн шигээр “за” гэж шивгэхэд Моррель гараа Вильфорын гараас суга татан авч, ор руу ухасхийн очиж Валентинагийн хөхөрсөн уруулыг үнэсээд уртаар гиншин уйлж гарав.

Бүх зарц нар зайлж алга болсныг бид дээр өгүүлсэн билээ.

Тийм учраас манай шиг том хотод, тэгээд ч бас ийм сэжигтэй үхлээр хүн үхэхэд шаардагдах бүх л олон талын ажлыг д Авриньийг хариуцан хийж өгөөч гэж Вильфор гуйжээ.

Нуартьегийн тухайд гэвэл, энэхүү хөдөлгөөнгүй уй гашуу, үл үзэгдэх нулимсыг харахад ч аймаар байв.

Вильфор өрөөндөө ороод таг сууичхлаа. Д Авринь –“Үхэгсдийн эмч” гэж нэрлэгддэг хүний үхсэн тухай гэрчилгээ олгох хотын эмч дээр очиж уулзахаар явлаа.

Нуартье ач охиноосоо хагацаж салах дургүй байв.

Д Авринь хагас цагийн дараа хотын эмчийн хамт ирлээ. Гадна хаалга хаалттай байв. Бүх зарц нар тэднийхийг хаяж явсан учир Вильфор өөрөө ирж хаалга онгойлгож өгөв.

Харин Валентинагийн үүдэн дээр очоод зогслоо. Дахин тийшээ орох хүч түүнд байсангүй.

Хоёр эмч орлоо.

Нуартье орны эргэд өөрөө үхсэн юм шиг чимээ аниргүй, хөдөлгөөнгүй сууж байв.

Үхэгсдийн эмч амьдралынхаа хагасыг үхэгсэдтэй өнгөрүүлж байгаа хүний анзааргагүй байдлаар орны дэргэд очиж бүсгүйн бүтээлгийг ярж, уруулыг нь татаж үзэв.

- Хөөрхий бүсгүй үхсэнд эргэлзэх юм алга гэж д Авринь санаа алдан хэлэхэд,

- Тийм байна гэж үхэгсдийн эмч товчхон хариулав.

Валентинагийн нүүрийг дахин бүтээв.

Нуартье будэгхэн хурхирах шиг боллоо.

Д Авринь эргэж харахад түүний нүд нь гялалзаж байв.

Тэр ач охиноо харах гэж хүсэж байгааг д Авринь ойлголоо. Тэгээд нөгөө эмчийг Валентинагийн уруулд хүрсэн хуруугаа хлорын усанд дүрж байх зуур ор руу очиж цнтаж байгаа тэнгэрлэг охины царайтай адил тайван цагаан царайг харуулав.

Нуартыегийн нүдэнд мэлтгэнэсэн нулимс нь түүнд гүнээ талархсанаа илэрхийлж байгааг д Авринь ойлголоо.

Үхэгсдийн эмч тэр дороо Валентинагийн тасалгаанд ширээний хажууд гэрчилгээ хийж өгөөд д Авриньтай хамт гарлаа.

Вильфор тэр хоёрыг шатаар буухыг сонсоод өрөөнөөсөө гарч ирэв.

Тэгээд эмчид баярлаж хэдэн үг хэлээд д Авриньид хандаж,

- Одоо лам хэрэгтэй гэв.

- Танд өөрт чинь урих гэж бодсон ямар нэг лам бий юу? гэж д Авринь асуухад, Вильфор,

- Байхгүй, аль ойрыг л гуйя гэлээ.

- Ойрыг нь ий? Тэгвэл танай зэргэлдээ байшинд ирж суусан италийн ширээт лам байна. Хэрэв таныг хүсвэл би замдаа гуйя л даа гэж хотын эмч хэлэв.

- Д Авринь та эрхэм эмчтэй хамт явахгүй юу. Таны гарч орж байхад чинь амар байг. Энэ түлхүүрийг ав. ламыг авчраад хөөрхий муу охины минь өрөөнд оруулаатхаарай гэж Вильфор хэлэв.

- Та түүнтэй уулзах хэрэг бий юу?

- Үгүй, би ганцаараа байхыг хүсэж байна. та намайг уучлаарай. Лам хүн бол бэр зовлон зүдгүүр, тэр ч байтугай эцэг хүний зовлон гасланг ойлгох ёстой.

Вильфор түлхүүрээ д Авриньид өгөөд, хотын эмчиддахин мэхийн ёслоод өрөөндөө очиж ажилдаа орлоо.

Ажил хөдөлмөр л бүх гаслан зовлонгоос эмчлэх эмч нь болсон хүмүүс байдаг юм.

Хоёр эмч гудамжинд гараад, санваартны хар хувцастай хүн зэргэлдээ байшингийн босгон дээр зогсож байхыг харлаа.

- Миний өнөө хэлсэн хүн чинь тэр байна гэж үхэгсдийн эмч хэлэв.

Д Авринь ламын дэргэд чоиж,

- Эрхэм та охин нь тун саяхан талийгаач болчихсон зовлонт нэгэн эцэг, вангийн прокурор Вильфорт тус болж өгөөч гэв.

- Тимй ээ, тэр байшинд үхэл шүгэлчихсэнийг би мэднэ гэж лам их л итали аялгуутайгаар хариу өгүүллээ.

- Тэгвэл тэр танаас ямар тусламж гуйж байгааг би танд хэлэх хэрэг юу байх вэ дээ.
- Би ямар тус хэрэгтэй ба@на гэж асуух гэж явсан юм. Бид ийм үүрэгтэй улс шүү дээ.
- Залуухан бүсгүй шүү.
- Тимй ээ, би мэднэ. Зарц нар нь надад хэлсэн юм. тэднийг байшингаас зугтаж байхыг би харсан. Валентина гэдэг нэртэй юм байх шиг байна. Би мэдээд түүний төлөө залбирч суулаа.
- Баярлалаа танд. Та нэгэнт ариун гэгээн үүрэгт ажлаа эхэлчихсэн хойно түүнийгээ үргэлжлүүлэхгүй юу? Тэнд очвол тайтгаршгүй болчихсон гэр бүл танд баярласнаа хэлэх бол.о
- Очьё, эрхэм минь. Минийхээс илүү халуун мөргөл гэж байхгүй гэж зориглож хэлье хэмээн лам хэллээ.

Д Авринь ламыг сугадан явж шөнө нь үүрд нойрсон оронд нь оруулах гэж байгаа бүсгүйн өрөөнд орууллаа. Тэд замдаа Вильфортой тааралдсангүй. тэр өрөөндөө орж түгжихээд сууж байсан ажээ.

Тэр хоёрыг тасалгаанд ороход Нуартье, лам хоёрын харц мөргөлдөв. Нуартье ламаас дахин нүдээ салгасангүй нь тэр ямар нэг ер бишийн юм үзсэн бололтой.

Д Авринь зөвхөн талийгаачийн биш, бас амьдыг нь ширээт ламын асрамжинд орхиход, цаадах нь Валзнтина ба Нуартье хоёрын хоёулангий нь төлөө мөргөж залбирна гэж амлажээ.

Ламын амлалт сүртэй сонстлоо. Валентинагийн төлөө мөргөхөд нь, Нуартьегийн тайван гуниглаж суухад нь саад болохоос болгоомжлон лам эмчийн гарсан хаалга, хатагтай Вильфорын өрөөтэй залгаа хаалгыг түгжлээ.

7.ДАНГЛАРЫН ГАРЫН ҮСЭГ

Энэ өглөө бүрхэг уйтгартай өглөө боллоо.

Шөнө нь авсчингууд орон дээр хэвтэж байсан хүүрийг амьд ахуй цагтаа шохоорхон хайрлаж байсан зүйлийн нь сүүл-ийн дурсгал болсон гашуудлын цав цагаан нөмрөгт ньхийж очод оршуулахад бэлхэн б@лголоо.

Энэ бол хоёр долоо хоногийн өмнө Валентинагийн худалдаж авсан нарийн ширхэгт даавуу бөйлаа.

Нуартьеэг үдэш нь Валентинагийн тасалгаанаас өөрийн нь тасалгаанд авчирчээ. Өвгөнийг тийш нь аваачихад ач охиноосоо салахгүй гэж зөрсөнгүй нь бодож байснаас өөр болов.

Лам Бузоны өглөө болтол тэнд байж байгаад үүрээр хэнд ч, нэг ч үг хэлэлгүй яваад өглөө.

Найман цагт д Авринь хүчр ирлээ. Тэгээд тэр Нуартьегийн өрөөнд очихоор явж байсан Вильфортой дайралдаж, өвгөний яаж хоносныг асуухаар хамт явлаа.

Тэр хоёрыг ороход өвгөн өөрийн ор болдог том сандал дээрээ сууж байв. Өвгөн маш тайван унтаж байв.

Тэр хоёр гайхан босгон дээр зогслоо.

- Хараач, байгаль гэдэг ч хамгийн их уй гашууг хүртэл тайвшруулж чаддаг байна шүү. Эрхэм Нуартье ач охиндоо хайргүй гэж хэн ч хэлэхгүй дээ. Гэсэн ч ингээд унтаж байдаг гэж д Авринь Вильфорт хэлэв.

- Тийм байна. Унтаж байна. Их хачин юм. Өчүүхэн төдий юм болоход л бүтэн шөнөөр унтахгүй байж чаддаг хүн байгшаа юм гэж Вильфор гайхан хэлэхэд,

- Уй гашуу нь түүний зоригийг хугалж дээ гэж д Авриньи хэллээ.

Тэгээд тэр хоёр гүн бодлого болон вангийн прокурорын өрөөнд орлоо. Вильфор засаад хөдөлгөөгүй байгаа ороо зааж д Авриньид,

- Харин би бол жнтаагүй л дээ. Уй гашуу миний зоригийг хугалж чадаагүй. Би одоо хоёр дахь шөнөдөө унтаагүй байна. Харин мий ширээг хар л даа. Энэ хоёр өдөр, хоёр шөний дотор бичсэн вмыг хараач!... Бенедеттогийн ялын төлөвлөгөөнд хичнээн засвар хийв дСэ! Ажил л сэтгэлийг минь амрааж, зовсон сэтгэлийг дийлж чадах ганц зүйл мөн! гэв.

Тэгээд д Авриньийн гарыг салганан атгав.

- Би танд хэрэгтэй байна уу? гэж эмч асуухада

- Үгүй, хэрэггүй. Харин арван нэгэн цагт ирээрэй, арван хоёр цагт гаргана. Бурхан минь, хөөрхий охин минь! гэлээ.

Тэгээд вангийн прокурор дахин хүн шиг болж дээшээ харж санаа алдлаа.

- Та гашуудлаа илэрхийлж байгаа хмүүүстэй уулзах уу?

- Үгүй, тэрхүү зовлонтой ажлыг нэг хамаатан маань хийх болно. Эмч минь би ажиллах хэрэгтнй. Ажил хийж байхад бүх зүйл мартагддаг юм.

Эмчийг хаалга хүрч амжаагүй байтал вангийн прокурор дахин бичиг цаасаараа оролдож эхлэв.

Д Авриньи шатан дээр өнөөх Вильфорын хэлсэн хамаатангийг нь хүнтэй дайралдав. Тэр хүн бол энэ туужид ч гэсэн, амьдралд ч гэсэн тоо бүртгэгчийн үүрэг гүйцэтгэх тавилантай төрснө хүн юм.

Хар хувцас өмсөж цаг үеийн байдалд тохируулан царайгаа өөрчлөөд ёслол өнгөрч хэрэгцээ нь дуусахаар хуучин хэвэндээ ороход бэлхэн байв.

Арван нэгэн цагт гашуудлын сүйх тэргүүд хашаанд орж ирж, Сент-Онорид хөл хөдөлгөөнтэй болж, баячуудын баяр ёслол, уй гашууг нэгэн адил хорхойтон сонирхож, бээлийн хуримд очих гэж яарч яваа юм шиг гашуудлын ёслол өөд яаран гүйлдэж байв.

Авставьсан зочдын өрөөнд хүмүүс цөөн цөөнөөрөө орж ирлээ. Эмчид бидний зарим хуучин таних хүмүүс, Дебрэ, Шато-Рено, Бошан, дараагаар нь шүүх цааз, утга зохиол, цэргийн нэртэй нэртэй хүмүүс ирлээ. Эрхэм де Вильфор бол нийгмийн дотор эзлэх эрх тушаалаараа ч биш, хжвийнхаа чанараар Парисын дээдсийн хүрээлэнд тэргүүн байр эзлэх хүмүүсийн нэг байсан болой.

Өнөөх хамаатангийн нь хүн үүдэнд зогсож байгаа хүмүүсийг хүлээж авах бөгөөд зовсон шинжгүй энэ хүний царайг харахад сэтгэлд амар бөгөөд эцэг эх, ах дүү, болзоот хүний нь хару зориуд уйтгартай царай үзүүлэх шаардлагагүй байв.

Таних хүмүүс хоорондоо бие биеийгээ нүдээрээ дохиж бөөгнөрөн зогсоно. Дебрэ, Шато-Рено, Бошан нар нэг ийм бүлэг болж зогслоо.

- Хөөрхий амьтан! Тийм баян, тийм гоо сайхан байж! Шато-Рено гурван долоо хоногийн өмнө тэрхүү болж бүтээгүй гэрээнд гарын үсэг зурах ёслолд ирэхдээ та ийм юм болохын чинээ санаагүй биз дээ? гэж Дебрэг асуухад,

- Үнэнээ хэлэхэд үгүй шүү гэж Шато-Рено хэлэв.

- Та түүнийг таньдаг байсна уу?
- Би хатагтай Морсерын бүжигт найран дээр хоёрхон удаа л ярилцсан юм. Сэтгэл татам сайхна хүүхэн билээ. Үгүй хойд эх нь хаана байна?
- Хатагтай биднийг угтаж авсан энэ хүндэт эрхмийн эхнэртэй хамт тэднийд өнжих юм гэнэ билээ.
- Энэ чинь ямар хүн бэ?
- Хэнийг хэлж байна?
- Биднийг угтаж авсан эрхэм. Тэр депутат хүн үү?
- Үгүй, би манай хууль батлагчдыг өдөр бүр хардаг албатай хүн. Тэгэхэд ийм царай ер харагдаагүй шүү гэж Бошан хэллээ.
- Та энэ үхлийн тухай сониндоо цухуйлгасан уу?
- Өөр хүн бичсэн.Тэгэхдээ нэлээх шуугиан дэгдээсэн нь Вильфорт тийм ч таатай санагдахгүй байх даа. Тэр тэмдэглэлд хэрэв ийм дөрвөн үхэл вангийн прокурорынхоос өөр айлд тохиолдсон бол прокурор их л сэтгэл нь түгших байсан даа гэж бичсэн байна билээ.
- Манай ээжийг эмнэж байгаа эмч д Аврньюи Вильфорыг тун их гуниглаж байгаа гэж хэлж байна билээ гэж Шато-Рено дуугарав.
- Дебрэ та хэнийг эрээ вэ?
- Монте-Кристо гүнг.
- Би наашаа ирж явахдаа түүнтэй гудамжинд дайралдсан Явах гэж зэхэж байгаа бололтой байна билээ. Гүн өөрийнхөө банкны эзэн рүү явж байна лээ гэж Бошан хэллээ.

Тэгэхэл Шато-Рено Дебрэгээс,

- Түүний банкны эзэн нь Данглар уу? гэв.
- Тийм байх. Энд зөвхөн Монте-Кристо биш, Моррель алга байна шүү дээ гэж сайдын нарийн бичгийн дарга бага зэрэг зовсон байдалтай хэлэв.
- Моррель ий? Тэр эднийхэнтэй танил юм уу? гэж Шато-Рено асуув.
- Тэр зөвхөн де Вильфортой л танилцсан байх аа.
- Тэгсэн ч гэсэн ирэх л байсан юм. Орой юугаа ярих юм бол доо? Энэ оршуулах ажил энэ өдрийн ганц сонин шүү дээ. За чимээгүй, хууль цаазын сайд ирлэ. Тэр гунихарч гашуудсан хамаатангийн нь хүнд эмгэнэлийн товч үг хэлнэ дээ гэж Дебрэ хэлэв.

Тэгээд залуу хүмүүс хууль цаазын сайдын хэлэх үгийг сонсохоор хаалга өөд дөхөж очлоо.

Бошан үнэн хэлжээ. Тэрээр гашуудлын ёслолд ирж яваад Шоссе-д Антен гудамж руу Дангларынд очихоор явж байсан Монте-Кристотой дайралдсан байжээ.

Банкны эзэн гүнгийн сүйх тэрэг хашаан дотор орж ирэхийг цонхоороо хараад өөдөөс нь уйтгартай боловч б яртай царай гарган угтан очлоо. Тэгээд Монте-Кристорд гараа сунгаж,

- Гүн та миний төлөө санаа зовсноо хэлэх гэж ирсэн байх шив. Манайд тун их золгүй явдал боллоо. Би таныг хараад, хөөрхий Морсерынд золгүй яудлыг хүссэн юм биш байгаа чгэж ч бодлоо. Энэ бол “өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр” гэсэн зүйр үгтэй л адил болж байна. Үгүй, би Морсерт муу юм хүсээгүй. Тэр над шиг хоосон гартай гарч ирсэн хүн гэхэд дэндүү биеэ тоосон, ихэмсэг хүн байсан юм. гэсэн ч хүн бүрд дутагдал байдаг

хойно яая гэх вэ. Гүн минь болгоомжтой байгаарай. Бидний үеийн хүмүүст... уучлаарай, та надаас залуу болохоор миний үеийн хүмүүст энэ жил их л му жил болж байна даа. Жишээгий нь хэлбэл бидэн дундаа пуритан вангийн прокурор тун саяхан охиноо алдчихлаа. Вильфорынхон хачин үхлээр үхэж байна даа. Морсер гутамшигт унаж, амиа хорлолоо. Би тэр Бенедеттогоос болоод амьтны инээдэм болчихлоо. Тэгээд бас дээр нь... гэхэд,

- Юун дээр нь гэж ? гэж гүн асуув.
- Та мэдэхгүй гэж үү?
- Бас дахиад золгүй явдал болоо юу?
- Миний охин...
- Мадмуазель Данглар уу?
- Эжени биднийг хаяад явчихсан.
- Яалаа гэнэ э!
- Тимй ээ эрхэм минь. Та эхнэр хүүхэдгүй чинь азтай хэрэг юм даа!
- Та тэгж бодож байна уу?
- Тэгэлгүй яах вэ!
- Мадмуазель Эжени...
- Эжени тэр бузар амьтны тарьсан шившгийг тэсвэрлэж чадалгүй надаас жуулчлан явах зөвшөөрөл аваад явчихсан.
- Тэгээд яваад өгсөн хэрэг үү?
- Урьд шөнө явса.
- Хатагтай данглартай юу?
- Үгүй, манай нэг хамаатан хүүхэнтэй явсан.... цмао ч л гэсэн охиноосоо салж хагацлаа. Тийм зантай хүн хэзээ нэг цагт Францад эргэж ирнэ гэж үү дээ!
- Одоо яая гэх вэ эрхэм түшээ гүн. Гэр бүлийн нь гунигт явдал ганц хүүхдээс өөр баялгагүй ядуу хүнд бол үнэхээр нуралт, харин тань шиг сая хөрөнгөтэй хүнд бол тимй ч аймшигтай зүйл бишээ. Гүн ухаантнууд юу ч гэж чрьж байсан ажил хэргийн хүмүүс тэдэнд өөрөөр нотлон харуулдаг юм. Мөнгө бол олон янзын зовлонгоос тайтгаруулж чаддаг юм. Тэгэхээр та түүний эмчлэх их хүчинд итгэж чадвал удахгүй тайтгарах ёстой. Та бол санхүүгийн хаан, хүчирхэг их хүчний уулзвар цэг шүү дээ гэж Монте-Кристо хэлэв.

Данглар түүн өөд тоглоом хийж байна уу үнэхээр хэлж байна уу гэсэн янзтай ажиглан харлаа. Тэгээд,

- Хэрвээ баялаг хөрөнгө хүнийг тайтгаруулдаг бол би тайтгарах л ёстой. Би баян хүн дээ гэв.
- Эрхэм түшээ гүн таны баялаг цац суварга шиг бөгөөд түүнийг эвдлэн нураая гэж хэн ч зориглохгүй. Зориглолоо ч гэсэн чадахааргүй баян хүн шүү дээ.

Данглар гүнгийн итгэмтгий сайхна занг хараад инээмсэглэлээ.

- Би таныг орж ирэх үеэр таван бичиг дээр нарын үсэг зурж байсан юм. Хоёр дээр нь гарын үсэг зурчихсан. Бусад гурав дээр нь зураад дуусгачихыг зөвшөөрнө үү?

- Тэг, тэг, гүнтэн.

Чимээ аниргүй болж банкны эзний үзэг хяхтнах л дуулдаж байв. Гүн алтлан гоёсон таазыг харж суув.

- Испанийх уу? Гаитийнх уй? Эсвэл Неаполитаных уу? гэж Моте-Кристо асуув.
- Үгүй биш Францын банкинд бичиж байгаа чек. Би санхүүгийнхний хаан бол та бүр эзэн хаан нь. Тэгэхээр та сая саяын үнэтэй ийм алгын чинээ цаас олны үзсэн дээ? гэж Данглар их л хангалуун хариулав.

Дангларын тэгж бахархан өгсөн таван хэсэг цаасыг Монте-Кристо цэгнэн үзэх гэж байгаа юм шиг авч уншсан нь:

“Эрхэм банкны эзэн захирал аа, миний тооцоогоор нэг сая цранк өгөн үү? Түшээ гүн Данглар” гэжээ.

- Нэг, хоёр, гурав, дөрөв, тав. Таван сая байна! Далайц гэдэг чинь энэ дээ! гэж Монте-Кристо хэлэхэд
- Би ажил хэргээ ингэж л явуулдаг хүн дээ гэж Данглар хариуллаа.
- Хэрэв энэ мөнгө бэлэн мөнгөөр төлөгдвөл бүр ч гайхалтай хэрэг болно.
- Бэлэн мөнгөөр өгөлгүй яах вэ гэж Данглар хариу дуугарлаа.
- Ийм зээллэгтэй байх ч сайхан хэрэг ээ. Нээрээ ч зөвхөн Францад л ийм юм үзэгдэх юм даа. Таван саяын үнэтэй таван хэсэг цаас байна даа. Үүнийг үнэмшихийн тулд харах хэрэгтэй юм.
- Харин та эргэлзэж байна уу?
- Үгүй.
- Таны энэ ярьж байгаа үгний чинь аялгуу... Та тааллаараа бол л доо. Та миний итгэмжилсэн хүнтэй хамт миний гарын үсэгтэй зурвасыг авч банкинд очвол мөн тэр хэмжээний мөнгөний тэмдэгтэй гарч ирэхийг үзнэ дээ.
- Үгүй, нээрээ сонирхолтой юм гэж гүн хэлээд таван чекээ эвхэж, - Би өөрөө туршаад үзье. Миний зургаан сая франк таны банканд байсан, би түүнээс есөн зуун мянгыг нь авсан. Тэгэхээр одоо таван сая нэг зуун мянган франк үлдсэн байх ёстой. Би таны гацхан гарын үсгийг чинь хараад л энэ хэсэг цаасыг чинь алтан зоосны оронд авлаа. харин танд бүр зургаан саяа авсны батлагаа гарын үсгийг өгчихье. Надад өнөөдөр мөнгө маш хэрэгтэй болсон учир гарынхаа үсгийг урьдчилан зурж бэлтгэчихээд ирсэн юм гэв.

Тэгээд чекүүдийг хармаандаа хийж, нөгөө гараараа гарынхаа үсэг зурсан цаасыг өглөө.

Дангларын хөлд цахилгаан буусан ч гэсэн түүнийг ингэж ниргэхгүй байсан биз ээ.

- Яах нь тэр вэ? Та энэ мөнгийг авах нь уу? Уучлаарай, би энэ мөнгийг өнчин хүүхдүүднд өнөөдөр шилжүүлж өгнө гэж хэлчихсэн юмсан.
- Өө тэгвэл өөр хэрэг. Би заавал энэ чекүүдийг авна гэхгүй, өөр үнэт зүйлээр төлөөд өгчихсөн ч болно. Би зүгээр л Дангларын банк таван минутын төдий ч хугацаа хойшлуулахгүйгээр, урьд нь мэдэгдээгүй байхад таван сая цранк надад шууд төлж өгч байсан гэж улс амьтанд ярихад сонин юм гэж тэгсэн юм. Энэ их сайхна яриа болно доо! Май, та энэ чекүүдээ ав. Харин өөр л юмаар төлөөд өгчих л дөө гэж Монте-Кристо хэлэв.

Тэгээд гүн Дангларт чекүүдийг нь буцаан өгөхөд цаадах нь махаа булаагдсанг элээ торны цаанаас махныхаа хойноос савраа сарвайж байгаа юм шиг гараа сарвайх гэв.

Гэвч гэнэт зогсож хүч гарган биеэ барилаа. Дараа нь инээмсэглэж, эвгүй Болсон царай нь зөөлөрлөө.

- Таны гарыг үсэг гэдэг чинь бас л мөнгө гэсэн үг дээ гэж тэр хэллээ.
- Тэгэлгүй яах вэ! Таныг Ромд очвол Томсон Френч хоёр бас л миний гарын үсгээр таны саяын хэлэдэг шиг хөнгөн ёуурхай үйлчилнэ дээ.
- Уучлаарай намайг, гүн минь уучлаарай.
- Тэгвэл би энэ мөнгийг өөртөө авч болох уу? гэхэд Данглар хөлөрсөн духаа арчиж,
- Тийм, тимй, та ав гэж хэллээ.

Монте-Кристо чекүүдийг буцааж хамраандаа хийхэд түүний царайд “харамсаад байвал хожимдоогүй байна шүү” гэсэн шинж тодорч байв.

- Үгүй, үгүй, та тэр чекүүдийг өөрөө ав. Бид санхүүгийн улс нягт нарийн байдгийг та мэднэ. Би энэ мөнгийг өнчин ядууст өгөх гэж бичсэн юм. Би чухам л энэ чекээр тэр мөнгийг нь төлөөгүй бол тэднээс хулгайлж байгаа юм шиг санагдаад байна. Уучлаарай намайг! Гэж Данглар хэллээ.

Тэгээд чанаг боловч сэтгэл нь тавгүй байдлаар инээлээ.

- Уучиллаа, одоо мөнгөө хармаалчихъя гэж Монте-Кристо найрсгаар хэлээд, чекүүдийг далд хийлээ.
- Манайд бас зуун мянган франк чинь үлдсэн шүү дээ гэж Данглар хэлэхэд,
- Өө тэр ч бага хэрэг! Төлбөр нь бараг төдий чинээ байх биз. Тэр мөнгийг та өөртөө үлдээ. Та бид хоёр өр ширгшй болох нь тэр гж Монте-Кристо хэллээ.
- Гүн та үнэнээсээ хэлж байна уу?
- Би хэзээ ч банкны эзэдтэй тоглоом тохуу хийдэггүй гэж гүн бараг дээрэлхсэн янзтай хэлээд үүдний зүг явахад зарц орж ирээд,
- Өнчин ядуусын захиргааны сангийн ерөнхий нярав де Бовиль гуай ирлээ гэж эзэндээ айлтгалаа.
- Би таны чекийг ашиглан цагийг нь яг олж ирсэн байгаа биз. Таны чекийг хүмүүс булаацалдаад д авчих юм гэж Монте-Кристо хэллээ.

Дангларын царай дахин дэвийгээд, гүнтэй салах ёсыг гүйцэтгэв.

Монте-Кристо гүн, үүдний өрөөнд хүлээж байсан Бовиль гуайтай ёсорхгоор мэндлээд гарч явахад тэрээр даруй Дангларын тасалгаанд орлоо.

Үргэлж төвхөн байдан гүнгийн царайд, өнчин ядуусын гаурын сангийн нярав түрийвч барьсан байхыг хараад эгшин зуурын инээмсэглэл тодорлоо.

Үүдний дэргэд түүнийг сүйх тэрэг хүлээж байсан учир банк руу явахыг тушаалаа.

Тэр завсар Данглар хөдөлсөн сэтгэлээ дарж ядан ирсэн хүнийг угтан авлаа.

Түүний уруул инээмсэглэнсэн хэвээр хөшсөнийг хэлээд ч яах вэ.

- Сайн байна уу? эрхэм зээлдээлэгч, над дээр чухамхүү зээлдүүлэгч хүн исрэн гэдэгт мөрийцөхөд ч бэлхэн байна гэж Данглар хэлэхэд

- Түшээт гүн та таачихлаа. Манай өнчин ядуусын газрын бэлэвсэн эмэгтэйчүүд, өнчин хүүхдүүд надаар дамжуулан таван сая франк гуйж байна гэж Бовильд хэллээ.
 - Өнчин өрөөсөнчүүдийг өрөвдөх ёстой гэж ярьдаг юм! Хөөрхий хүүхдүүд! гэж Данглар тоглоомоо үргэлжлүүлэн хэллээ.
 - Тэгээд л би тэдний нэрийн өмнөөс ирлээ. Та миний захидлыг өчигдөр авсан байх ёстой... гэж Бовиль хэлэхэд,
 - Тийм ээ гэв.
 - Тэгээд л би мөнгө хүлээн авсан тухмы гарын үсгээ бэлтчихээд ирлээ.
 - Эрхэм хүндэт де Бовиль, таны өнчин өрөөсөнчүүдэд хорин дөрвөн цаг хүлээхгүйсэн болов уу. дөнгөж саяхан эндээс гарсан Монте-Кристо гүн... та сая түүнтэй дайралдаа биз дээ? гэж Данглар хэлэв.
 - Тэгсэн, тэгээд юу гэж?
 - Тэр гүн манайд Ромын Томсон ба Френчийн банкаар хязгааргүй зарцуулах мөнгөний данс нээлгэсэн юм. Тэгээд надаас таван сая франк нэгмөсөн нэхэж банк руу чек аваад явчихсан. Би мөнгөө тэнд хадгалж байдаг юм. Би нэг өдөр арван саяыг аван гэвэл миний банкны эзэн гайхах бхйгаа даа. Хоёр хоногт бол өөр хэрэг шүү дээ гэж Данглар нэмж хэлээд, инээмсэглэлээ.
 - Яаж байгаа нь тэр вэ? Надтай танил юм шиг толгой дохиж мэндэлчихээд гарсан тэр эрхэм хүнд таван саяыг өгчихлөө гэнэ ээ? гэж Бовиль итгэлгүй янзтай хэллээ.
 - Та түүнийг танихгүй ч байлаа гэсэн тэр таныг таньдаг байж болно. Монте-Кристо гүнд мэдэхгүй танихгүй хүн гэж байдаггүй юм.
 - Таван саяар нь гэнэ ээ!
 - Гарын үсэг нь энэ байна. Фома найдан шиг барьж тэмтэрч үз л дээ. Дангларын өгсөн цаасыг Бовиль авч уншсан нь:
“Би түшээ гүн Дангларгаас таван сая нэг зуун мянган франк хүлээн аялаа. Энэ мөнгийг түүний хүссэн үед томсон ба Френчийн банк буцаан төлөх болно”
 - Яриагүй үнэ байна! гэж хэллээ.
 - Та Томсон ба Френчийн банкиг мэдэх үү?
 - Мэднэ ээ. Би тэднийхтэй нэг удаа хоёр зуун мянган франкийн гүйлгээ хийсэн юм. Түүнээс хлйш тэдний тухай юу ч дуулаагүй гэж Бовиль хэлэхэд Данглар гарын үсэг зурсан цаасыг авч хайхрамжгүйхэн ширээн дээр чулуудчихаад,
 - Энэ бол Европ дахь хамгийн шмлдэг банкны нэг байгаа юм гэв.
 - Зөвхөн танайд л таван сая франктай байсан уу? Тэр Монте-Кристо гүн гэдэг чинь ёслой хязгааргүй баян хүн юм даа!
 - Би түүнийг чухам ямар хүн болохыг мэдэхгүй. Ямар ч л гэсэн түүнд хэмжээгүй зарцуулах мөнгөний данс гурван газар нээлттэй байгаа юм. Нэг нь манайд, нөгөөх нь Рочильдад, гурав дахь нь Лаффитад байдаг юм. Түүнээс гадна намайг хүндэтгэн үзэж зуун мянган франкаа орхиод тооцоогоо хийж гүйцсэнд тооцож байна билээ гэж Данглар хэллээ.
- Бовиль улам их гайхаж байв.

- Түүнтэй уулзах хэрэгтэй юм байна. Манай энд ямар нэг тэтгэврийн газар байгуулж өгөөсэй гэж хэллээ.
- Энэ зүйтэй хэрэг. Тэр ганцхан сард л хорь гаруй мянган франкийн хишиг хүртээдэг юм.
- Сайхан хэрэг ээ! Би түүнд хатагтай Морсер түүний хүүгийн жишээг ярьж өгнө.
- Ямар талаар билээ?
- Тэд бүх хөрөнгөө тэтгэвэрийн газарт зориулчихсан гэв...
- Ямар хөрөнгө тэр вэ?
- Тэдний өөрсдийнх нь, бас талийгаач генерал де Морсерын хөрөнгө.
- Яагаад тэр вэ?
- Яагаад гэвэл тэд ийм бузар аргаар олсон хөрөнгийг хэрэглэхгүй гэсэн юм байх.
- Тэгээд юугаараа амьдрах юм бэ?
- Эх нь хөдөө гарч, хүү нь цэргийн албанд орсон гэнэ билээ.
- Тэр ч дэндүү арвигүй зан гаргасан хэрэг байна аа гэж данглар дуу алдлаа.
- Би дөнгөж өчигдөрхөн хүлээж авсан баримт бичиж бүртгэж авсан.
- Хичнээн юм байна?
- Тийм ч их биш ээ. нэг сая хоёр зуун мянга гаруй л юм байна билээ. за тэр ч яах вэ. Харин өөрсдийнхөө мөнгөний тухай ярилцъя.
- Тэр мөнгө танд тун яаралтай хэрэг болоод байна уу? гэж Данглар ердийн дуугаараа хэллээ.
- Маш их. Маргааш манай кассад шалгаж ирнэ.
- Маргааш ий! Яагаад та үүнийгээ түрүүний хэлээгүй юм бэ? Маргааш болтол чиньв бүтэн жил шиг хугацаа байн шүү дээ? Хэдэн цагт тооллого болох юм бэ?
- Хоёр цагт.
- Тэгвэл үд дунд хүн ирүүлээрэй гэж Данглар инээмсэглэв. Бовиль хариуд нь дөнгөж толгой дохилоо.
- Эсвэл ингэвэл дээр болох байх... гэж Данглар хэлэхэд,
- Яавал дээр гэж? хэмээн асуув.
- Монте-Кристо гүнгийн гарын үсэг гэдэг чинь мөнгө л гэсэн үг. энэ гарын үсгийг Рочильд эсвэл Лаффитийн банкинд аваачиж өг. тэгэхэд түүнийг тэр доор нь хүлээн авна.
- Тэд Ромтой тооцоо хийх байсан ч авна гэж үү?
- Мэдээж хэрэг. Та тав зургаан мянгыг л алдана байх.
- ТЭГЭХЭД сангийн нярав ухасхийн босож,
- Үгүй, үгүй, би маргааш болтол хүлээе. Та яасан амархан юм ярих юм бэ? гэв.
- Уучлаарай. Би таныг үл ялих дутуугаа л нөхөх гэж байгаа юм байх гэж бодсон юм гэж Данглар хэлэхэд,
- Яалаа гэж! хэмээн сангийн нярав дуу алдлаа.
- Манайд ийм явдал болдог вч. Тэгэхээр хохирохоос өөр аргагүй болдог юм даа.

- Бурхан минь, үгүй, үгүй гэж Бовиль хэллээ.
- Тэгвэл маргааш болтол хойшлуулъя. Эрхэм минь.
- За яах вэ, маргааш больё. Харин маргааш заавал биз?
- Та бүү даажигнаарай. Маргааш үдийн арван хоёр цаг болоход хүн явуулаарай. Би банкинд хэлчихнэ.
- Би өөрөө ирнэ.
- Тэгвэл бүр ч сайн. Би тантай дахин уулзахдаа баяртай байна.

Тэгээд тэр хоёр гар барилаа.

- Үгүй ингэхэд та өнөөдөр мадмуазель де Вильфорыг оршуулах ёслолд очихгүй юм уу? Намайг Бульварт явж байхад цуваа нь гарч явсан гэж Бовиль хэлэхэд, банкны эзэн,
- Үгүй. Би тэр Бенедеттогийн явдлаас хойш бага зээг ичиж гадагшаа гарахгүй байгаа гэв.
- Дэний юманд тэгэх юм. Танд ямар буруу байгаа юм бэ?
- Эрхэм минь над шиг хиргүй тунгалаг нэртнэй хүн элдвийн ванд соргог болчих юм байна шүү дээ.
- Хүн бүхэн таныг, ялангуяа охиныг чинь өрөвдөж байна.
- Хөөрхий Эжени, тэр минь үсээ авахуулж байгаа гэдгийг дуулсан уу? гэж Данглар гүнээ санаа алдаж дуугарав.
- Үгүй ээ.
- Золгүй явдлаас л болж тэгсэн шүү. Тэр явдал болсны маргааш нь нэг найз-лам хүүхэнтэйгээ яваад өгсөн. Итали Писаднийн алт нэг хатуу ширүүн сүмд очиж суух юм байх.

- Энэ чинь аймшигтай хэрэг ээ!

Эрхэм Бовиль золгүй эмгэнэлээ илэрхийлээд гарч одлоо.

Данглар түүнийг гармагц Роберт-Макер жүжгийн дүр Фредерик тоглож байгаа юм шиг царай гарган,

- Чалчаа саарал!!! Гэж дуугараад Монте-Кристогийн гарын үсгийг жижиг түрийвчиндээ хийв.
- Маргааш үд дунд ирээрэй! Үд дунд болоход би ихээ хол явчихсан байна даа гэв.

Дараа нь хаалгаа дотроос нь түгжээд кассын бүх нүднүүдийг уудалж% тавин мянган франкийн зээллэгийн билет олж аваад, зарим бичиг цаасыг шатааж, заримы нь ил тавьж орхиод захидал бичлээ. Бичиж дуусаад дугтуйгий нь нааж:

“Хатагтай Дангларт” гэж хаяглав

- Орой би өөрөө энэ захидлыг ширээн дээр нь аваачиж тавина нэж бвутнаад шүүгээнийхээ нүднээс паспорт гаргаж аваад – Маш сайн хэрэг. БӨас хоёр сарын дотор хүчинтэй байх нь гэлээ.

8. ПЕР-ЛАШЕЗ ХЭМЭЭХ ОРШУУЛГЫН ГАЗАР

ВалГнтинаг тайван нойрсох сүүлчийн нь газар хүргэн өгөх гашуудлын цуваатай Бовиль үнэхээр дайралджээ.

Тэнгэр бүрхэг үүлтэй байв. Одоогоор бүлээн боловч, шарласан навчинд үхлийн аюултай салхи нүцгэрч байгаа мөчрөөс навчийг нь хийсгэн авч гудамжнаа цугларсан олны дээгүүр эргэлдүүлэн хуйлруулна.

Вильфор жинхэнэ Парис хотын хүн тул Пер-лашезийн оршуулгын газрыг Парисын баячуудын гэр бүлийнхний хүүрийг оршуулахад ёстой тохирох ганц газар гэж үзэж бөайлаа. Бусад бүх л хүүр оршуулах газрыг дэндүү хөдөөгийн маягтай нэг л төхөөрөмжилсөн үхлийн тасалгаа мэт санадаг байжээ. Зөвхөн Пер-лашезийн оршуулах газарт л баячуудын хүрээлэнгийнхнээс үхсэн хүн гэртээ байгаа юм шиг байж чадах байжээ.

Вильфор бидний дээр өгүүлснээр, үүрд эзэмших газрыг эндээс худалдан авч, бунхан барьсны дотор түрүүчийн нь гэр бүлийн гишүүд маш хурдан нүүж ирж бунхан нь өргөжжээ.

Валентинагийн ээж хөөрхий Ренегийн гэрээс, сүүлчийн нь хүсэл зоригийг биелүүлэн бунхны үүдэнд: “Сен-Меран ба Вильфорын гэр бүл” гэж бичжээ.

Ийнхүү гашуудлын сүржин цуваа Сен-Онорегоос Пер-лашез орохоор явж байв. Энэ цуваа Парис дундуур гарч, Тамплийг өнгөрөн дараа нь Модот гудамжийн их тойргоор оршуулгын газар руу чиглэлээ. Гашуудлын хорин сүйх тэрэгний араас тавь гаруй хувийн сүйх тэрэг дагалдан, энэ тавин сүйх тэрэгний хойноос таван зуу гаруй явган хүн дагажээ.

Эдгээр нь Валентинагийн нас эцэслэсэнд гайхаж гашуудсан бараг бүгдээрээ залуу хүмүүс байв. Хайхрамжгүй хүйтэн зууныг ч тоолгүй цэцэглэж яваа насандаа амь үрэгдсэн сэтгэл булаам охины гоо сайханд автсан улс байжээ.

Гашуудлын цуваа харуулын дэргэд хүрч ирэхэд дөрвөн омголон морь хөллөсөн сүйх тэрэг гарч ирээд даруй зогслоо. Морьдын хөл ган төмөр гадас адил хүчлэн зогслоо. Монте-Кристо гүн хүрч иржээ.

Гүн сүйх тэрэгнээсээ гарч ирээд гашуудлын тэргийг дагасан явган цуваанд нийллээ.

Шато-Рено түүнийг харчхаад өөрийн сүйх тэргийг орхиж түүнтэй нийлэв. Бошан бас хөлсөлж авсан сүйх тэргээ орхиж буув.

Гүн олны дундаас хүн эрсэн байдалтай анхааралтай харна. Тэгээд сүүлд нь тэссэнгүй,

- Моррель хаана байна? түүний хаана байгааг хэн нэг чинь мэдэхгүй биз? гэж асуув.
- Бид бүр талийгаачийн гэрт байхдаа бие биеэсээ асуусан юм. Бидний хэн ч хараагүй гэж Шато-Рено хэллээ.

Гүн дуугүй болж бас л ийш тийшээ харсаар байв.

Ингэж явсаар оршуулгын газар хүрч ирлээ.

Монте-Кристо тэс нарсны төглийг ажиглан хараад даарс нь сэтгэл зовохоо болилоо. Тэнд бараан зүрс харагдахыг Монте-Кристо өнөө эрсэн хүн нь мөн болохыг таньсан бололтой.

Энэ нүд алдам оршуулыгн газар хүн хөдөөлүүлнэ гэдэг юу болохыг мэдэхгүй хүнгүй билээ. Явган хүний замаар тарсан хар хуцвастай бөөн бөөн хүмүүс, тэнгэр ч газар ч чив чимээгүй дүнхийж, хугарч байгаа мөчирч юм уу, булшийг бүчсэн амьд хашаа энэхүү нам гүмийг хааяа нэг эвдлСж, санваартны гунигтай дуу сонстон, эмэгтэй хүнЁй орь дуу тавих залган авна.

Монте-Кристовийн харсан сүүдэр Элоиза, Абеляр хоёрын булшны цаад талын төглийг түргэн өнгөрч, цувааны түрүүнд яваа бамбар баригчидтай зэрэгцэн, тэдэнтэй хамт оршуулгын газарт хүчр очлоо.

Хүн бүрийн харц нэгнээс нөгөөд тусах бөгөөд харин Монте-Крристо гүн л бусдад бараг үл ажиглагдам сүүдрийг нүд салгалгүй харна.

Тэр хүн цувныхаа цаад талд нуусан зэвсгээ эрж тэмтэрч байна уу, үгүй юу гэдгийг харах гэж Монте-Кристо хоёр цулаа эгнээнээсээ гарлаа.

Ёслолын цуваа зогсоход тэр сүүдэрх маань Моррель болохыг таньцгаалаа. Тэрээр гартаа барьсан бүрх малгайг базалж, сюртук хэмээх цамцаа хоолойндoo хүртэл товчилж, нүд нь бүлцийн царай нь зэвхийрч, гунигт ёслолын бүх явцыг сайн харах гэж бунхны дээд талд ургасан мод түшин зогсож байв.

Бүх зүйл заншил ёсоороо гүйцэтгэгдлээ. Бусдаасаа илүү багаар гашуудаж гунигласан хэдэн хүн үг хэллээ. Тэдний зарим нь ингэж цагаасаа өмнө нас барсан явдалд харамсан гашуудаж, зарим нь эцгийнх нь уй гашуудлын тухай ярина. Бас Валентина гэм буруутанд өршөөл гуйж вангийн прокурорын далайсан шударга үнэний шүүхийн илдийг зайлуулж байсан юм гэж ч хэлэх хүн гарлаа. Ер нь л гоёж чимж элдэв янзаар өөрчлөн ярихдаа харамссангүй элбэг арвинаар ярьж байв.

Монте-Кристо юу ч сонссонгүй. Тэрээр зөвхөн Моррелийг ажиглан харж, түүний дотор чухам юу болж байгааг сайн мэдэхийн учир энэхүү хөдлөхгүй тайван зогсож байгаад сэтгэл нь зөвж хараа салгахгэй байв. Гэтэл Бошан гэнэт, Дебрэ өөд хандаж,

- Хараач! Моррель байна! Тэр яаж байгаа нь энэ юм бол? гээд Шато-Ренoд бас зааж өгөв.
- Царай нь яасан цонхигор юм бэ?
- Даараа биз гэж Дебрэ өгүүлэхэд Шато-Рено аажимхнаар,
- Үгүй сэтгэл нь догдолсон байх. Максимилиан маш амархан сэтгэл хөдөлдөн хүн байгаа юм гэхэд,
- За, үгүй дээ! Тэр чинь мадмуазель Валентинаг бараг танихгүй байсан юм. Та өөрөө тэгж хэлсэн биз дээ гэж Дебрэ хэллээ.
- Тэг үнээн, гэвч хатагтай Морсерынд болсон бүжигт наадам дээр Валентинатай гурван ч удаа бүжиглэснийг санаж байна . та хүмүүст сэтгэгдэл төрүүлсэн тэр бүжиг наадмыг санаж байгаа биз, гүн гуай гэхэд,
- Үгүй, санахгүй байна гэж Монте-Кристо хэнд юуны тухай асуухад нь хариулж байгаагаа мэдэхгүй хэллээ.

Тэрээр, амьсгаа авахгүй гэж хичээн хураасан хүн шиг хацар нь улайн зогсож байгаа хүнийг ширтээд бусад бүхзүйлийг мартчихсан байжээ.

- Үг хэлж төгслөө, эрхмүүдээ баяртай гэж хэлээд явах дохио өгсөнд хүмүүс түүний хаашаа явсныг ч ажиглан харахын завгүй алга болжээ.

Гашуудлын ёслол төгсөж хүмүүс буцацгаав.

Ганцхан Шато-Рено л Моррелийг нүдээрээ хайсан боловч, цаашаа явж байсан Монте-Кристоргийн хойноо харах хооронд нь Моррель байсан газраасаа яваад өгчихсөн тул Шато-Рено түүнийг олсонгүй Дебрэ, Бошан хоёрын хойноос явлаа.

Сонирхон ирсэн хүмүүсийн сүүлчийн хэсэг ба авсчингууд явсан хойно Монте-Кристо гүн бутан дотор нуугдаж, бунхан өөд дөхөж яваа Моррелийн хөдлөх бүрийг ажиглаж харж байв.

Моррель ийш тийшээ харна. Түүний цаашаа харах хооронд нь Монте-Кристо мэдэгдэлгүй бас арваад алхам дөхөж очлоо.

Максимилиан сөхрөн суулаа.

Гүн түрүүчийн дохиогоор ухасхийн хүрэхэд бэлхэн түүн өөд оритсоор байв.
Моррель чулуун хашилт духаараа налж хоёр гараараа сараалжнаас нь зууран барьж,

- Валентина! Гэж шивгэнэлээ.

Гүнгийн зүрх түүний дуунд тэсвэрлэсэнгүй урагш нэг алхаж Моррелийн мөрнөөс татаж,

- Найз минь, та энд байгаа юм бий. Би таныг хайлаа шүү дээ гэж хэллээ.

Монте-Кристо түүнийг гомдож гаслах байх гэж бодож байсан чинь ташаарчээ.

Моррель түүн өөд хараад гаднаа тайван байдалтайгаар,

- Би залбирч байна! гэж хариу өгүүлэв.

Монте-Кристо түүнийг улнаас ньт толгойг хүртэл ажиглан ширтэв. Ингэж хараад гүнгийн сэтгэл тайвшрав.

Тэгээд Моррельд,

- Би таныг хот руу хүргэж өгөх үү? Гэж хэлэхэд цаадах нь,

- Хэрэггүй баярлалаа гэв.

- Танд ямар нэг юм хэрэгтэй байна уу?

- Мөргөх залбирахад минв бүү саад хийгээч.

Гүн үг дуугүй зайлан явсан боловч, Моррелийг үл үзэгдэх газраасаа нуугдан харж байх гэж зайлсан ажээ. Эцэст нь Моррель босож, өвдөгнийхөө тоосыг гөвж арилгаад Парис орох замаар нэг ч эргэж хараалгүй явж одлоо.

Залуу Ла-Рокет гудамжийг өнгөрөв. Гүн оршуулгын газрын үүдэнд хүлСэж байсан сүйх тэргээ явуулаад Максимилианы араас зуугаад алхмын зайтай дагаж явав.

Максимилиан суваг өнгөрч модтой гудамжаар үвж Меле гудамж хүрлээ.

Хашааны бяцхан хаалга Моррелийг орсноос хойш тавхан минутын дараа Монте-Кристок ороход нь онгойлоо.

Цэцэрлэгчийнхээ мэргэжилд ихэд нямбай ханддаг Пенелон бенгалийн саргай цэцэг мөчрөөр нь тарьж ургуулахаар огтолж байхыг Жюди анхааралтай харан зогсож байв.

- Монте-Кристо гүн ирлээ гэу Меле гудамжинд хүчр ирэх бүрд нь баярладгаараа залуу бүсгүй үнэн сэтгэлээсээ дуу алдлаа.

- Максимилиан дөнгөж саяхан ирсэн, тийм үү? Гэж гүн асуухад,

- Тэгсэн, ирэх шиг болсон шүү. Би Эмманюелийг дуудуулаад орхиё гэж Жюли хэллээ.

- Уучлаарай хатагтай минь, би одоохон Максимилиан дээр орох хэрэгтэй явна. Би түүнтэй уулзах маш чухал хэрэгтэй байна гэж Монте-Кристо зөрж хэллээ.

Тэгэхэд залуу бүсгүй,

- Тэгвэл ор ор гэж хэлээд түүнийг далд ортол хонгор сайхан инээмсэглэлээрээ үдэн хоцров.

Монте-Кристо гүн Максимилианы суудаг гуравдугаар давхарт түргэн гарч ирэв. Тэгээд шатны тавцан дээр зогсоод чагнавал нам гүм байлаа. Хуучиг цагийн байшинд байдгийн адилаар ганцхан шиллэсэн хаалга харагдана.

Харин шилэн цонхтой хаалганд түлхүүр байсангүй.

Максимилиан дотроос нь түгжчихсэн ажээ. Дотроос нь улаан торгон хөшиг татчихсан учир цаад талд нь юу байгаа нь үл харагдана.

Гүнгийн сэтгэл түгшүүртэй болох үедээ хацар нь улайдаг. Энэ бол сайхь анзааргагүй маягийн хүний сэтгэл ер бишийн ихээр хөдөлсөн тэмдэг билээ.

- Яавал дээр вэ? гэж амандаа шивгэнээд минут хяраатай бодлогоширлоо.
- Хаалгыг нь цохих уу? Үгүй, заримдаа хаалга дуугарч хүн ирэх явдал Максимилиан шиг ийм байдалд орсон хүний шийдвэрийг түргэсгэж өөр дуу хариуд нь дуугарч болох юм.

Монте-Кристогийн хамаг бие нь чичирч, ямар нэг юмыг маш түргэн шийддэг зангаараа хаалганы нь шилийг тохойгоороо хүчтэй ёвроход шил нь хагарав. Тэгэд цонхны хөшгийг сөхөж харвал Моррель ширээний цаад талд суугаад үзгээр юм бичиж байснаа шил хагарах чимээ сонсоод түргэн эргэн харлаа.

- Энэ яах вэ. Бурхныг бодож намайг уучлаарай хүндэт найз минь. Би халтираад танай хаалганы шилийг тохойгоороо ёворчихлоо. Нгэнэт хагарчихсан болохоор энэ завшааныг ашиглаад орчихъё. Бүү зовоорой, бүү зов гэж гүн хэлээд хагархай шилний зайгаар гараа оруулж хаалга онгойлголоо.

Моррель зэвүү нь хүрсэн бололтой босож, Монте-Кристо угтан авахаас ороход нь саад болох гэж өөдөөс нь тосож ирлээ.

- Үнэндээ энд танай зарц нар л буруутай болж байна. шалыг чинь толь шиг гялалзтал нь арччихсан байна гэж Монте-Кристо хэлээд тохойгоо арчлаа.
- Та биеэ гэмтээчихээгүй биз? гэж Моррель хүйтнээр асуулаа.
- Мэдэхгүй. Та юу хийж суув. Юм бичиж байв уу?
- Би юу?
- Таны хуруу чинь бэх болчихсон байна.
- Тимй ээ би юм бичсэн юм. Би хэдийгээр цэргийн хүн боловч хааяа юм бичих хэрэг тохиолддог юм.

Монте-Кристо тасалгаан дотуур хэд алхлаа. Максимилиан түүнийг оруулахгүй байж чадсангүй, хойноос нь дагаж явлаа.

- Та юм бичиж байв уу? гэж Монте-Кристо асуугаад түүнийг шинжих мэт харахад,
- Би танд тийм хэнээн харуилсан сан билээ гэж Моррель дуугарав.

Гүн ийш тийшээ харлаа.

- Бэхнийхээ савны дэргэд буугаа тавьчхаад уу? гээд ширээн дээр хэвтэж байсан Моррелийн бууг зааж хэллээ.
- Би жуулчлан явах гэж байна гэж Максимилиан хариулахад, Монте-Кристо гүн хязгааргүй эелдэг зөөлөн дуугаар,
- Найз минь! Гэлээ.
- Юу гээ вэ, эрхэм та!
- Максимилиан минь эцсийн шийдвэрт хүрэх хэрэггүй гэж би чамаас гуйя.
- Эцсийн шийдвэр ий? гэснээ Моррель далаа хавчаад, - Яагаад жуулчлах явдал эцсийн шийдвэр болдгийг хэлж өгнө үү? гэв.
- Максимилиан, багаа авч хая. Би өөрийнхөө өнгөц санаа зовсон байдлаар таныг хуурч чадахгүйн адил та намайг хиймэл тайван

байдлаараа хуурч чадахгүй. Би саяынх шиг цонхыг чинь хагалж, түгжээтэй хаалга онгойлгож, найз нөхөр дээрээ орж ирж байгаа явдал бол надад айж болгоомжлох юм байна, өөрөөр хэлбэл аймшигтай юманд итгэсэн гэдгийг харуулж буй болохыг та ойлгож байгаа байх. Моррель та өөрийгөө алах гэж байна гэж Монте-Кристо хэлэв.

- Яалаа гэж, гүн та яагаад тэгж хэлж байна вэ? гэж Моррель цочих мэт болж хэллээ.
- Би таныг өөрийгөө алах гэж байна гэж хэлж байна. Нотолгоо нь энэ байна хэмээн гүн хэлэв.

Тэгээд ширээ рүү очиж, бичиж эхэлсэн захидлаа таглаж тавьсан цагаан цаагыг нь сөхөж, захидлыг нь авлаа.

Моррель захидлыг булаан авах гэж ухасхийлээ.

Гэвч Монте-Кристо ингэнэ гэж мэдэж байсан учир түүнээс урьтаж амжлаа. Тэрээр Максимилианы сарвуунаас атгаж хөдөлж байсан пүршийг ган гинж зогсоох адил зогсоолоо.

- Моррель та өөрийгөө алах гэж байсан. Үүнийгээ цагаан цаасан дээр хар бэхээр бичсэн байна гэж гүн хэлэхэд,
- Яах вэ дээ! Би энэ бууны амыг өөр өөдөө зангах ч байлаа гэсэн хэн надад саад болдог юм бэ? гэж Моррель хиймэл тайван дүрээ дорхноо үгүй хийж хэллээ.

Хэн намайг хориглож зүрхлэх билээ?

Миний бүх найдвар горьдлого нурж, зүрх минь харлаж, амьдрал минь унтарч, орчин тойронд харанхуй бүрхэж, газар дэлхий хүүрийн шороо болсон мэт санагдаж байгаа надад хүний дуу дуулна гэдэг тамлагдан тарчлах мэт санагдаж байна.

Та миний үхэхэд бүү саад хийгээч, энэ бол энэрэнгүй сэтгэл болно, хэрэв та миний үхэхэд саад болох юм бол би ухаан солиорч галзуурах болно.

Үнэхээр арга тасран, уйлан хайлж үүнийг хэлэхэд хэн чи буруу хэрэг хийж байна гэж хэлэх юм бэ? Зол завшаангүй элдвийг үзэж зовж тарчлахдаа болиход минь хэн саад болох юм бэ? Гүн та арай тэгж зүрхлэх юм биш биз?

- Тимй ээ, Моррель гэж Монте-Кристо Максимилианы сэтгэл хөдөлсөнтэй огт хавьтахгүй тайван итгэлтэй дуугаар хэлээд, -Тийм ээ, би гэв.
- Та юу? гэж Моррель улам хилэн нь бадарч хэлээд, - Та намайг хоосон горьдоож, хий амлаж саад хийгээгүй бол ямар нэг шийдвэртэй юм хийж түүнийгээ аврах ч юм уу эсвэл үхэж байхад нь тэвэрч бараагий нь амьдад нь харах байсан юм. Та хүний оюун ухааны бүх л хэрэглүүрийг, байгалийн бүх хүчин чадлыг эзэмшсэн гэж бардамнадаг байсан. Та тэнрэр бурхныг орлож чаддаг гэж гайхуулаад байсан чинь хорлогдсон охинд эм ч өгч чадаагүй шив! Үгүй, та надад жигшлийг төрүүлээгүй сэн бол хөөрхий ядарсан амьтан гэж өрөвдөх сэтгэлийг төрүүлэх байсан юм гэв.
- Моррель!
- Тимй ээ, та надад багаа авч хаяхыг зөвлөсөн. Тэгэхээр миний багаа авч хаясанд минь баярлаж үз. Оршуулгын газарт миний хойноос очиход чинь би сайн санаанч зүгээс үг хариулж байсан, таныг наашаа орох гэхэд чинь би оруулсан... гэтэл та миний тэвчээрийг буруугаар ашиглаж, булшинд орсон юм шиг гэртээ гуундахад минь хойноос мөрдөж мөшгин, дууссан гэж

бодож байсан шаналал зовлонг дахин амсууллаа. Тэгэхэд надад сайн схийныг бүтээгч, намайг аврагч Монте-Кристо гүн гуай та сэтгэл чинь ханаж болно. Таны муу найз нүдэн дээр чинь үхлээ гэж Моррель хэлээд ухаангүйгээр инээд алдаж хоёр дахь удаагаа буу руугаа ухасхийлээ.

Монте-Кристо үхээр мэт царай нь зөвхийрч, цахилгаан цохих мэт ширтэн буугий нь гараараа дарж хэлсэн нь:

- Та өөрийгөө алахгүй гэж давтан хэлье! гэв.
- Та надад саад болхо юм уу? гэж Моррель сүүлчийн удаа хүч гарган хэлсэн нь гүнгийн төмөр мэт гарыг мөргөн няцаав.
- Тийм ээ би саад хийнэ.
- Та ер нь хэн гээч вэ? Та яагаад чөлөөтэй, бодолтой бол хүмүүсийг захираад байгаа юм бэ? гэж Максимилиан дуу алдлаа.
- Би хэн бэ гэж үү? Би бол эцгийн хүү нь болох чамайг өнөөдөр үхэхийг чинь хүсэхгүй байна гэж энэ дэлхий дээр хэлж чадах ганц хүн байгаа юм даа.

Тэгээд Монте-Кристо дөлгөөн төвшин, ихэмсэг байдлаар гараа цээжиндээ зөрүүлэн барьж, байж ядан байгаа Максимилиан өөд очиход цаадах нь энэ хүний тэнгэрийн хүч мэт их хүчинд автан алхам ухарч гэдрэг боллоо.

- Та миний эцгийн тухай юунд ярьж байна вэ? Мини й эцгийн нэрийг өнөөдөр болж байгаа явдалтай холбон дурсах ямар хэрэг байна? гэж Максимилиан шивгэнэн хэллээ.
- Яагаад гэвэл түүнийг чам шиг бас ингэж үхэх гэж байхад нь би амийг нь аварсан учраас тэгж байгаа юм. Яагаад гэвэл чиний дүүд чинь түрийвч, өвгөн Моррельд “Фараон” онгоцыг нь өгч явуулсан хүн бол би байгаа юм. Чиний өвөр дээр нь тоглож өссөн Эдмон Дантес бол би байна гэв.

Гайхан хоцорсон Моррель хүндээр амьсгаа авч бас нэг алхам ухарлаа. Дараа нь түүний тамир тасарч, Монте-Кристингийн хөлд хашхиран сөхрөв.

Сайхан сэтгэлт энэ хүний оюун ухаанд хоромхон зуурын өөрчлөлт болж, ухасхийн босоод, байдаг чадлаараа хашхиран шат руу гүйлээ.

- Жюли! Эмманюель!

Монте-Кристо түүний хойноос гарах гэсэн боловч Моррель хаалгыг нь барьчхаад үхсэн ч тавихгүй гэж татаж байлаа.

Максимилианы хашхирахыг сонсоод Жюли Эмманюель хоёр, Пенелон бусад зарц нарын хамт гүйж ирлээ.

Моррель тэдний гараас барьж хаалга онгойлгоод,

- Сөхөрцгөө! Гэж нулимсандаа багтарсан дуугаар хэлээд, - Бидэнд сайн сайхныг олгож, эцгийг минь аварсан хүн энэ байна. Үнэ бол... гээд... Эдмон Дантес! Гэж хэлэх гэтэл гүн гарыг нь шүүрэн авч үгийг нь тасаллаа.

Жюли гүнгийн гарт хацраа нааж, Эмманюель түүнийг аврагч бурхан мэт үнэслээ. Моррель дахни өвдөг дээрээ сөхөрч, газар хүртэл бөхийн мөргөлөө.

Тэгэхэд энэ төмөр мэт зоригтой хүни й зүрх нь дэлбэрчих гэж байгаа юм шиг болж халуун гал төөнөх мэт нүдэнд нь нулимс бүрхээд тэргүүнээ гудайлган уйллаа.

Энэ тасалгаанд хэдэн минутын туршид уйлж, санаа алдах дуу гарч энэ нь бурхан тэнгэрт ч болов таалалтай сайхан санагдахаар байсан биз.

Жюли дөнгөж ухаан ормогц тасалгаанаас гүйн гарч доод давхарт бууж зочдынхоо өрөөнд давхиж ороод Мельяны модот гудамжинд тэр нэгэн үл таних хүний бэлэглэн өгсөн түрийвчийг шилэн хавхгийг өргөж авлаа.

Тэр завсар Эмманюель тасалдсан дуугаар Монте-Кристо гүнд,

- Ай гүн минь, бид өөрийн үл мэдэх аврагчийн тухай их ярьж, дурсгалыг нь хичнээн их хүндэтгэн хадгалдгийг яаж та мэдэх вэ дээ. Та бидэнд биеэ мэгэдэж гийгүүлэхгүй юунд ийм удаан хүлээлгээ вэ? үнэндээ энэ чинь бидэнд Та өөрөө өөртөө ч гэсэндээ дэндүү хатуу сэтгэл гаргасан хэрэг шүү дээ гэв.

- Найз минь учрыг нь ойлгооч. Та нар өөрсдөө мэдэлгүйгээр арван нэгэн жил миний найз нөхөд болж яваа болохоор би тэгж нэрлэе. Онцын чухал хэрэг болоод энд нууцаа илчлэх боллоо. Чухам ямар хэрэг болхоыг нь хэлж чадахгүй. Би энэ нууцыг бүх амьдралынхаа туршид хадгалах гэж бодсон юм. Харин Максимилиан л айлгаж байгаад энэ нууцыг минь хүчээр булаан авч мэдчихлээ. Гэвч тэр өөрийн буруутайг мэдэж байгаа биз гэж гүн хэлэв.

Максимилиан, жаахан зайтай газар сөхрөн сууж нүүрээрээ сандал налж суусан хэвээр байв.

- Түүний хойноос сайн харж байгаарай гэж Монте-Кристо нэмж хэлээд, Эмманюелийн гарыг учиртайхан атгахад цаадах нь,

- Яагаад тэр билээ гэж асуув.

- Би учрыг нь хэлж өгч чадахгүй. Харин сайн л харж байгаарай.

Эмманюель ийш тийшээ харснаа Моррелийн гар бууг олж харлаа. Түүний нүд буун дээр айсан янзтай тусаж, түүнийгээ Монте-Кристорд зааж харуулаад, гараа ширээний ирмэгт хүртэл өргөлөө.

Монте-Кристо толгойгоо бөхийлгөв.

Эмманюель буу өөд сарвайх гэсэн боловч гүн түүний гарыг зогсоолоо.

Дараа нь Моррелийн дэргэд очиж түүний гараас барив. Дөнгөж саяхан Максимилианы зүрхийг донсол гож байсан тэр оргилсон сэтгэгдэл нь хөдөлгөөнгүй хөшингө байдлаар солигдлоо.

Жюли торгон түрийвч барьсаар буцаж ирлээ. Өглөөний шүүдрийн дусал шиг баярын хоёр нулимс хацар дээгүүр нь бөнжийн гялтганана.

- Бидний хадгалж явдаг үнэт дурсгал энэ байна. Бид эзнийг нь мэдээд энэ зүйлээс хайрлахаа багасгана гэж бүү бодоорой гэж бүсгүй хэлэхэд Монте-Кристогийн царай улайж,

- Хүү минь энэ түрийвчийг авахыг зөвшөөрнө үү. Та нар одоо амайг мэдэх болсон болохоор зөвхөн найзархаг харьцаа минь намайг дурсгуулж байхыг хүсэж байна гэв.

- Үгүй, үгүй, өгөхгүй, гуйя танаас гэж Жюли түрийвчийг элгэндээ тэвэрч - Та яваад өгчхөж болно. Та бид нарыг орхиж явах гунигт өдөр болж мэднэ. Тэгвэл бид яах вэ? гэлээ.

- Таны хэлдэг үнэн. Эцгийг минь өлсөж үхсэн тэр үед аз жаргалтай амьдарч байсан тэдгээр хүмүүс тэнгэрийн цээрлэл хүлээсэн энэ орныг би долоо хоногийн дараа орхиж явна гэж Монте-Кристо гүн инээмсэглэн хэлээд “Энэ орныг долоо хоногийн дараа орхиж явна” гэсэн үг Моррелийг гунигт байдлаас гаргаж чадах эсэхийг харлаа. Гэвч энэ үг нөлөө үзүүлж

чадсангүй. Тийм учир нөхрийнхөө уй гашуутай тэмцэх сүүлчийн аргаа хэрэглэхээо шийдвэрлэв. Тэгээд Жюли Эмманюель хоёрын гараас барьж эцэг ёсны зөөлөн боловч захирангуй дуугаар,

- Найз нөхөд минь Максимилиан бид хоёрыг, хоёулхны минь “орхихыг хүсье” гэж хэллээ.

Энэ үг нь Монте-Кристогийн мартаж орхмсон үнэт дурсгалаа аваачих боломж өгсөнд Жюли олзуурхан нөхрөө явуулж,

- Эднийг орхиод гаръя гэж хэллээ.

Баримал хөшөө мэт үл хөдлөх Максимилиантай хамт гүн үлдлээ. Тэгээд мөрөнд нь гараа хүргэж,

- Максимилиан чи, буцаж хүн шиг болж үзээч гэж захирангуй янзтай хэллээ.
- Би дахиад л зовж эхэллээ шүү дээ.

Гүн хөмсгөө зангидсан нь их л эргэлзэж байгааг нь харуулна.

- Максимилиан! Ийм бодол христос шашинтай хүнд таарахгүй гэж гүнг хэлэхэд Максимилиан гүн өөд толгойгоо өндийлгөж хязгааргүй гунигтай байдлаар инээмсэглээд,
- Найз минь тайвшир, би үхэхгүй гэлээ.
- Буу зэвсэг, уйтгар гашуу байхгүй болов уу, тэгвэл? Гэж Монте-Кристо асуув.
- Үгүй, сэтгэлийнхээ өвчнөөс салахад буу зэвсэг, хутганы ирнээс илүү юм надад бий.
- Хөөрхий тэнэг амьтан!... тэр чинь юу гээч вэ?
- Миний өөрийн сэтгэлийн өвчин. Энэ өвчин намайг алж орхино.
- Найз минь, чи миний хэлэхийг сонс гэж Монте-Кристо бараг өөр шиг нь гунигтайгаар хэлээд - Чинийхтэй адил тийм ганихралт явдал тохиолдоход би ч бас амиа хорлох гэж шийдэж байсан удаатай. Бас чиний эцэг чинь өөрийгөө алах гэж хүсэж байсан үе бий.

Эцэг чинь бууны ам духандаа тулган байсан тэр цагт эсвэл би өлсөж үхэрээр шийдээд шоронгийн талх гурав хоног идэлгүй орноосоо холдуулж тавьчихаад байсан тэр үед хэн нэгэн хүн:

- “Амьд бай! Нэг л өдөр аз жаргалтай сайхан амьдрах цаг чинь хүрээд ирнэ” гэж хэлбэл дуу хаанаас ч гарсан байсан бид эргэлзэнгүй инээмсэглэл, үл итгэх гунигаар угтан сонсох байсан шүү дээ. гэтэл эцэг чинь чамайг үнэсэж, амьд яваадаа залбирах цаг хичнээн удаа... гэхэд Моррель түүний үгийг тасалж,
- Та зөвхөн эрх чөлөгнөө алдсан байсан. Миний аав бол зөвхөн баялгаа алдсан байсан. Харин тэгэхэд би Валентинагаа алдчихаад байна шүү дээ гэв.
- Максимилиан чи намайг хар гэж гүн дийлсэн баатрын дүртэй хэлээд – Миний нүдэнд нулимс гүйлгэнэж, цусанд минь халуун оргиогүй, зүрх минь гунигтай цохилоогүй байна. Гэтэл төрсөн хүү шигээ хайрлан явдаг Максимилиан чи зовж шаналж байгаа харагдана. Амь насыг чинь хайрлаж хадгалж өгсөн явдалд минь баярлах өдөр чамд тохиолдох учиртаа би сайн мэдэх учир чамайг амьдрахыг гуйж, тушааж байна гэлээ.

- Бурхан минь! гэж залуу хүү дуу алдаад, - Гүн та юунд ингэж ярьж байна? Болгоомжлоорой! Та хэзээ ч дурлаж явж үзээгүй байж мэдэх юм шүү дээ? гэхэд,

- Хүү минь! гэж хариу дуугарлаа.

- Үгүй, ийм их халуунаар дурлаж яваагүй байлгүй гэж би хэлэх гэсэн юм. Би бага наснаасаа цэрэгт байсан хүн. Би жинхэнэ дурлал гэгчийг үзэлгүй хорин есөн нас хүрсэн юм. Тэгээд хорин есөн настайдаа Валентинаг анх харж, түүнээс хойш хоёр жилийн турш хайртай сайн байгаа билээ. надад дэлгэсэн номын үсэг мэт илтэд харагдах бурхан тэнгэрийн мутраар адисласан тэр зүрхийг сайн сайхан зүрх гэж мэдсэн юм.

Гүн минь, Валентина бол надад дэлхий дээр дэндүү их үзэгдэж, дуулаагүй, ариун аз жаргал байсан. Би энэ дэлхий дээр тэрхүү жаргалыг эдлэх хувьгүй юм бол, Валентина үгүйгээр надад уйтгар гаслангаас өөр юу ч байхгүй болно.

- Би танд найдаж яв гэж хэлсэн шүү дээ гэж гүн давтан хэллээ.

- Болгоомжлоорой гүн минь гэж хоёр дахь удаагаа давтан хэлье. Хэрвэ би ингэж орхивол валентинатайгаа уулзаж болохоор юм бодсоор байгаад галзуурчихаж мэднэ шүү дээ гэв.

Тэгэхэд гүн инээмсэглэв.

- Найз минь_, эцэг минь! гэж Моррель арга нь барагдан дуу алдаад, - Болгоомжлоорхой гэдгийг гурав дахь удаагаа хэлье. Би таны үгнээс гарч чадахгүйдээ айж байна. Та үгээ асар их хүчтэй болохыг мэдээрэй. Таны энэ үгийг дуулаад нүд минь сэргэж, зүрх минь дахин амь орох шиг боллоо. Би ер бишийн хүчинд итгэхэд бэлхэн байгаад минь болгоомжлоорой!

Та надад Иаиры охины булшны чулууг авч хаяад ир гэж хэлсэн ч гсэн би түүнийг гүйцэтгэхэд бэлхэн байна. Болгоомулохгүй бол таны үгэнд дээд тэнгэрийн сүр хүчинд, итгэхэд бэлхэн байна шүү гэхэд,

- Итгэ, итгэ найз минь гэж гүн хэллээ.

Тэгэхэд Моррель сэхэж ирснээ дахин уйтгар гунигтаа автан,

- Та надаар сайхан сэтгэлтнй эх хүн шиг тоглож байна. Чухамдаа гэвэл хүүхдийнхээ уйлахаас хаширчхаад, өвчтэй хүүхдээ сайхан үгээр хуурдаг амиа бодсон эх хүн шиг л байна. Би таныг болгоомжлоорой гэж хэлсэн минь буруу байна. Бүү айгаарай. Би өөрийн уйтгар гунигийг таны хүрэхгүйгээр тэртээ алсад зүрхнийхээ гүнд далд хийж орхиё. Баяртай найз минь баяртай гэв.

- Үгүй, харин өнөөдрөөс эхлээд чи миний дэргэд амьдрах болно. Бид хоёр одоо салахгүй. Долоо хоногийн дараа бид Францад байхгүй болно гэж гүн хэллээ.

- Та бас л түрүүчийнхээрээ намайг итгэж НАЙДАЖ БАЙ ГЭЖ ХЭЛЖ байна уу?

- Би чамайг эдгэрүүлэх арга мэдэж байгаа учир чамайг итгэж найдаж бай гэж хэлж байгаа юм.

- Гүн та намайг улам их зовоох юм. Та надад тохиолдсон золгүй явдлыг зөвхөн их хэмжээний уйтгар гуниг гэж үзсэн учраас намайг бас тийм их хэмжээний хэрэглүүр болох жуулчлалаар тайтгаруулах гэж бодож байна гэж Мор°ель хэлээд итгэлгүй дургүйцсэн янзаар толгойгоо сэгсэрлээ.

- Чи надаар юу хэлүүлэх гэж хүсэж байна? Би өөрийнөө амлаж хэлсэн үгэд итгэж байгаа учир оролцоод үзэх бололцоо олгож өг гэж Монте-Кристо хэллээ.

- Та миний амь тавихыг зөвхөн удаашруулж байна.

- Ингэхэд, сэтгэлгүй амьтан минь, найз нөхрөө оролдоод үзэхэд нь хэдхэн өдөр бэлэг болгоод өгчих чадалгүй байна уу? Ер нь тэгээд Монте-Кристо гүн юу чаддаг хүн болохыг мэдэх үү?

Газрын ямар хүч надад захирагддагийг чи мэдэх үү?

Итгэвэл уулыг ч хөдөлгөнө гэж хэлсэн тэрхүү бурхны гайхамшгийг олж авахын тулд би бурханд нэлээдгүй итгэдэг юм.

Миний итгэж найдаж байгаа тэр гайхамшгийг хүлээ, эсвэл... гэхэд,

- Эсвэл... гэж Моррель давтан хэллээ.

- Эсвэл би чамайг ач тус мэддэггүй амьтан гэж нэрлэж мэднэ шүү. Моррель, гэв.

- Намайг өрөвдөж үзээрэй!

- Максимилиан, би чамайг их өрөвдөж байна. Би чамайг яг нэг сарын дараа, яг энэ өдөр цагт эмнэж эдгэрүүлж чадахгүй бол би өөрөө чамд цэнэгтэй буу ч юм уу эсвэл валентинаг алсан хорноос илүү итгэлтэй Италийн хамгийн шилдэг хорыг өмнө чинв авчирч тавина.

- Та үүнийгээ бүр амлаж байна уу?

- Би өөрөө үхэхийг хүсдэг учир тэгж амлаж байна. Надад золгүй явдал огтхон ч тохиолдохгүй болчихсон хүн болохоор би мөнхийн сайн сайхан норыг хүсэж суудаг юм.

- Та надад амлаж байгаа чинь үнэн байх нь ээ? гэж Максимилиан тайвшран хэлэхэд, Монте-Кристо гүн гараа өргөж,

- Би зөвхөн амлаж байгаа юм биш, т нгараглаж байгаа юм гэв.

- Хэрэв би нэг сарын дараа тайтгарахгүй бол та надад амьдралаа мэдэх эрх олгож, намайг а тусын хариу мэддэггүй хүн гэж хэлэхгүй биз?

- Нэг сарын дараа, яг л энэ өдрөө шүү. Нэг сарын дараа яг л энэ цагтаа. Энэ өдөр бол гэгээн саруул дурсгалтай өдөр болхоыг чи санаж байна уу? Өнөөдөр есдүгээр сарын таван. Би үхэх гэж байгаа эцгийг чинь аварснаас хойш өнөөдөр арван жил болж байна гэж хэлэхэд Моррель, гүнгийн гарыг шүүрэн авч үнэсэв.

Тэгэхэд цаадах нь ингэх нь зүйтэй хэрэг гэсэн шиг дургүйцсэнгүй.

- Нэг сарын дараа чи бид хоёрын суух ширээн дээр сайн буу, хялбархан үхэж болох хор байх болно. Харин чи үүний хариуд тэр бөдрийг хүртэл амьд байна гэдгээ амлаж хэлэх үү? Гэж Монте-Кристо хэлэхэд Моррель,

- Би бас тангараглана! Гэв.

Монте-Кристо түүнийг элгэндээ чанга тэврэв.

- Чи өнөөдрөөс эхлээд надтай хамт суух болно. Гайдегийн өрөөнд ор. Охины минь оронд хүү бий болж байгаа хэрэг гэв.

- Аа Гайде хаачсан бэ? гэж Моррель асуухад гүн,

- Урьд шөнө яваад өгсөн гэв.

- Таныг орхид явчихсан гэж үү?

- Үгүй, намайг хүлээж байгаа... Над дээр Елисейн Талд нүүж ирэхээ бэлтгэ. Харин одоо намайг хэнд ч харагдалгүй гаргаад орхи.

Максимилиан дуулгавартай хүүхэд шиг чухамдаа бурхны шавь шиг толгойгоо бөхийлгөв.

9.ХУВААЖ АВСАН НЬ

Альбер де Морсер ээждээ болон өөртөө зориулж авсан Сен-Жермен де Пре гудамж дахь байшингийн тусдаа сууц болж болохор хоёр давхрыг нь үл таних нэгэн хүн хөлслөн авчээ.

Энэ бол эрэгтэй хүн байсан бөгөөд хаалгач нь түүн йг орж гарахад царайгий нь нэг ч удаа харж чадаагүй ажээ. Өвлийн цагт бол театрын үүдэн дээр эздээ хүлээж зогсож байдаг баян айлын хөтөч нарынх шиг улаан хүзүүний ороолтоор эрүүгээ ороож нуудаг бөгөөд зун бол хаалгачийн хажуугаар өнгөрөх яг тэр үедээ алчуураар нүүрээ таглаж нусаа нийнэ. Харин энэ хүний араас хэн ч ажиглан харахгүй нь ердийн заншлаас ангид байсныг хэлэх хэрэгтэй. Энэ нууц байдлын доор томоохон холбоо харилцаа бүхий үлэмж өндөр тушаалын хүн нуугдаж байгаа юм гэдэг цуу яриа нь түүний нууцыг хүндэтгүүлнэ.

Тэр хүн нэг л тогтсон цагт ирэх бөгөөд хааяа нэг бага зэрэг эрт буюу орой ирнэ. Өвөл зуны алинд ч гэсэн бараг л цаг үргэлж шахам дөрвөн цагийн үед байрандаа ирэх боловч эндээ хонох нь хэзээ ч үгүй.

Өвлийн цагт байр харгалзаж байгаа үг дуу цөөнтэй зарц хүүхэн гурван цаг хагасын үед задгай зууханд гал түлнэ. Харин зуны цагт мөн л зарц хүүхэн гурван цаг хагаст мөхөөлдөс авчирч тавина.

Бидний дээр өгүүлснээр дөрвөн цагт өнөө нууц хүн ирнэ.

Түшнээс минутын дараа сүйх тэрэг байшингийн дэргэд хүрч ирэхэд, хар хөх хувцастай, шигүү гивлүр нүүр рүүгээ унжуулсан хүүхэн гарч хаалгачийн дэргэдүүр сүүдэр мэт хөнгөхөн алхалж, үл дуулдах алхаагаар алхаж өгсөнө.

Эмэгтэйг хаашаа орох нь вэ гэж асуух нь нэг ч удаа тохиолдсонгүй. Ингэж эмэгтэйн царай, нөгөө үл танигдах эрэгтэйн адил хоёр хаалгачийн алинд ч харагдсангүй. Энэ хоёр хаалгач бол нийслэлийн хаалгач нарын асар том гSp бүл дотор ийм даруу зан гаргаж чадах хоёрхон хүн ч байсан байж магадгүй.

Тэр авхай хоёрдугаар давхраас дээш гардаггүй нь мэдээж хэрэг. Тэр хүүхэн тохирсон ёсоор хаалга тогшиход үүд нээгдээд дараа нь чанга хаагдана. Тэгээд л гүйцэх нь тэр.

Гэрээс гарахдаа орсны даил янзаар гаран. Үл танигдах хүүхэн нөгөө л орж ирсэн шигээ нүүрээ гивлүүрээр бүтээж, түрүүлэн гарч ирэх бөгөөд сүйх тэргэнд суухад, тэрэг түүнийг авч заримдаа гудамжны нэг үзүүр рүү, заримдаа нөгөө үзүүр рүү алга болно. Харин минутын дараа нөгөө эрэгтэй хүн хүзүүний ороолт алчуураар нүүрээ таглан гарч ирээд бас л алга болж өгнө.

Монте-Кристо гүн Данглар дээр очсон ба Валентинаг оршуулсны маргааш өдөр нь өнөө үл таних хүн урьдын адил дөрвөн цагт биш, харин өглөөний арван цагийн үед хүрч ирэв.

Тэгтэл хөлсний тэрэг урьдын адил завсарлагагүйгээр үүдэнд хүрэлцэн ирж, гивлүүрээр нүүрээ бүтээсэн авхай шатаар маш түргэн өгсөв.

Хаалга онгойлгоод дахин хаагдав.

Харин хаалга бүрэн хаагдаж гүйцэхээс өмнө авхай

- Люсьен, найз минь! гээ хашхирав.

Имй янзаар хаалгч өөрийн эрхгүй энэ дууг сонсож, өнөөх хүнийг Люсьен гэдэг юм байна гэж анх удаа мэдэж авчээ. гэвч энэ үлгэ жишээ хаалгач байсан учир түүнийг эхнэртээ ч хэлэхгүй гэж өөртөө ам тангараг өгчээ.

- Юу болов, хайрт минь! Бушуухан хэлээч! Гэж нүүр рүүгээ гивлүүр унжуулсан авхайн сандран тэвдэж байгааг ажигласан хүн асуув.

- Би танд найдаж болох уу?

- Мэдээж хэрэг, та өөрөө мэднэ шүү дээ. Тэгээд юу болоо вэ? Таны ирүүлсэн зурвасыг үзээд бүр гайхаж орхилоо. Маш их яарч жигдхэн биш бичсэн байна билээ.... намайг тайвшруулаач, эсвэл бүр айлгаж орхиоч!

- Ийм явадл боллоо! Гэж хэлээд авхай Люсьенийг шалгасан мэт ширтэн харснаа – Данглар урьд шөнө яваад өглөө гэв.

- Явчихлаа гэнэ ээ! Данглар явчихлаа гэнэ ээ? Хаашаа тэр вэ?

- мэдэхгүй.

- Яалаа гэж! Мэдэхгүй гэнэ ээ? Тэгээд бүр явчхаа юу?

- Тэгсэн бололтой. Арван цагт өөрийнхөө тэргээр Шарантоны харууд өөд явжээ. Тэнд хөлсний сүйх тэрэг хүлээж байжээ. Тэгээд өөрийнхөө зарцтай хоёул сүйх тэргэнд чууж Фонтенбло орно гэж хбтчид хэосэн байна.

- Тэгээд яана гэж? харин та...

- Байзаарай, найз минь. Тэр надад захидал орхисон байна.

- Захидал йи?

- Тийм ээ, уншаач.

Хатагтай ингэж хэлээд задалсан захидал Дебрэд өгөв.

Дебрэ уншиж эхлэхээсээ өмнө энэ захидалд юу гэж бичсэн болохыг тааварлан мэдээх чухамдаа юу ч гэж бичсэн байлаа гэсэн шийдвэрээ урьдчоан гаргах гэж бага зэрэг бодлоо.

Тэгээд шийдвэрлэсэн бололтой хэдэн хормын дараа уншиж эхлэв.

Хатагтай Дангларыг сандралд оруулсан захидалд өгүүлсэн нь:

“Миний үнэнч хань, эрхэмсэг хатагтай” гэж уншаад Дебрэ өөрийн эрхгүй зогсож, хатагтай өөд харахад цаадхын нь царай ув улаан болж

- Унш, унш гэв.

Дебрэ цааш уншсан нь:

“Та энэ захидлыг хүлээн авахад тандэр нөхөр байхгүй болсон байх болно. Сэтгэлээ бүү их зовоогоорой. Та охингүй болсныхоо адил нөхөргүй болов. Өөрөөр хэлбэл би Францаас гарч явдаг гуч, дөрчин замын нэгэн дээр явж байх болно.

Та надаас тайлбар хүлээж байгаа байлгүй. Та үүнийг ойлгож чадах бүрэн чадвартай эмэгтэй болохоор танд учраа тайлбарлая.

Та сонсож бай.

Өнөөдөр надаас таван саяыг төлөхийг нэхэхэдп би биелүүлэв. Яг дараахан нь мөн энэ хэмжээний мөнгө нэхэж ирэв. Би үүнийг маргааш төлөхөөр хойшлуулав. Тийм учраас надад дэндүү эвгүй санагдах маргааш өдрөөс зайлсхийхийн тулд би өнөөдөр явлаа.

Үнэт сайхан эхнэр, хатагтай та үүнийг ойлгож байгаа, тийм ээ?

Та миний ажил хэргийг надаас дооргүй мэддэг учир би тэгж “та үүнийг ойлгож байгаа” гэж бичиж байна. Тэр ч байтугай та үүнийг надаас ч илүү мэднэ. Саяхан болтол овоо их байсан миний хөрөнгөний тал хувь нь хаашаа орчихсоныг тайлыбарлах хэрэг гарлаа гэхэд намайг чадахгүй байхад, та л үүнийг маш сайн гүйцэтгэнэ гэдэгт би итгэлтэй байна.

Алддаггүй мэддэг сонорч чадвар хүүхнүүдэд бейдаг бөгөөд тэдэнд өөрсдийн нь бүтээсэн тоо бодлого байдаг болохоор ямар ч гайхамшгийг танд тайлбарлан өгч чадна. Харин би бол зөвхөн өөрийн тоонуудыг мэддэг байсан бөгөөд, тоо маань намайг хуурч эхлэхээр би гэдэг хүн юу ч ойлгохоо больчхов.

Миний эрс түргэн уналтыг гайхах явдал хатагтай танд тохиолдож байв уу?

Миний алт мөнгө хаврын цас адил хурдан хайлахыг хараад гайхаж байна уу?

Үнэнээ хэлэхэд намайг дайрсан аянга цахилгаанд би бүр сөхөрч гүйцлСэ. Харин таныг үнсэн доороос нь бага зэрэг алт олсон байх гэж найдъя.

Сэтгэлийг тайвшруулах ийм найдлагатайгаар би холдон явлаа. Ухаант эхнэр, хатагтай минь. Таныг орхиж явахдаа дотоод сэтгэл минь өчүүхэн ч эмзэглэхгүй байна. Танд найз нөхөд, дээр өгүүлсэн үнс үлдсэн бөгөөд би танд буцааж өгөх гэж ингэтлээ яарч байгаа жаргалтай сайхан амьдрал, эрх чөлөөгөө бүрэн төгч болгож авна биз.

Гэвч хатагтай минь, энд хэдэн үг илэн далангүй хэлэх нь зүйтэй байна.

Таныг манай гэрийн ашиг тусын тулд, манай охины эрх ашгийн тул ажиллаж байна гэж найдаж итгэж байхдаа гүн ухаантны ёсоор нүдээ аньж байв. Гэтэл та энэ айлыг бүрэн хоосруулж орхихоор чинь, би бусдын сайн сайхан амьдралын суурь дэвсгэр болж үйлчлэхийг хүссэнгүй.

Би таныг баян чинээлэг авсан боловч багахан хүндэтгэгддэг байсан.

Илэн далангүй ярьж байгааг минь уучлаарай. Зөвхөн та бид хоёрын тухайд ярьж байгаа гэж санах учир гоёж чимэхийг хэрэггүй гэж үзэж байна.

Би хоёулныхаа баялгийг нэмэгдүүлэж байсан бөгөөд тэр маань арван тав гаруй жилийн дотор өсөн нэмэгдэж байв. гэтэл надад өөрт минь ч үзэгдэж ойлгогдохгүй хоосрод тохиолдож түүнийг минь устгаж орхилоо. Тэгэхэд миний буруугаар биш гэдгийг би зоригтой хэлж чадна.

Харин хатагтай та өөрийн хөрөнгийг л нэмэгдүүлэх гэж хичээсэн бөгөөд үүндээ амжилт олж ч чадсан гэдэгт би итгэж байна.

Ингээд би таныг ямраар авсан тэр хэвээр чинь үлдээж орхив. Та баян боловч бага хүндэтгэгдэж байсан билээ.

Үүрд баяртай.

Би ч бас өнөөдрөөс эхлээд гагцхүү өөрийн төлөө санаа тавьж явах болно.

Үлгэр дууриал үзүүлсэн явдалд чинь би их баяртай байна, түүнийг чинь дагаж явах болно.

Таны үнэнч нөхөр түшээ гүн Данглар”

Энэ урт яршигтай уншлагын үед Дебрэгийн царайг хатагтай их л анхааралтай ажиглан харж байлаа. Хэдийгээр биеэ барьж байсан боловч царай нь хоёр ч удаа өөрчлөхийг ажиглажээ.

Тэгээд захидлаа уншиж дуусаад аажимхнаар эвхэж, дахин бодлогошров.

- За юу гэж бодож байна вэ? гэж хатагтай харваас түгшсэн байдлаар асуув.

- Юу гэнэ ээ, хатагтай!
- Та энэ тухай юу гэж бодож байна вэ?
- Данглар сэжиг авсан байх гэж бодож байна, хатагтай минь.
- Тийм ээ, мэдээж хэрэг. Харин таны надад хэлэх зүйл чинь ердөө л энэ үү?
- Би таны хэлж байгааг ойлгохгүй байна гэж Дебрэ маш хүйтэн байдлаар хэлэв.
- Данглар явчихсан! Бү явчихсан! Эргэж ирэхгүйн тулд бүр явчихсан.
- Хатагтай та энүүнд бүү итгэ гэж Дебрэ хэлэв.
- За үгүй дээ, одоо эргэж ирэхгүй. Би түүнийг сайн мэднэ. Эрх ашгийг нь хөндсөн үед юунд ч бууж өгөхгүй хүн байгаа юм. Хэрэв ашигтай гэж үзсэн бол намайг аваад явах байсан юм. Гэтэл намайг Парист үлдээж байна. Тэгэхээр салж хагацах явдал түүний төлөвлөгөөнд орсон юм байлгүй. Ийм болохоор энэ явдал эргэж буцалтгүй болсон би үүрд чөлөөтэй боллоо гэж хатагтай Данглар царайчилж гуйсан дуугаар хэлэв.

Гэвч Дебрэ юу ч хариулсангүй, харин хатагтайг харан сэтгэлээ түгшсэн байдалтай хэвээрэн нь үлдээлээ.

- Одоо яая гэх вэ. Та үг дуугарахгүй байх шив гэж хатагтай хэлэв.
- Би танаас ганц юм асууя. Та яах бодолтой байна?
- Энэ тухай танаас асуухыг би өөрөө хүссэн юм гэж хатагтай Данглар хэлэхэд зүрх нь хүчтэй цохилж бөйлаа.
- Тэгвэл та надаас зөвлөгөө хүсэж байна уу?
- Тийм ээ зөвлөгөө өгөхийг хүсэж байна гэж хатагтай дорой дуугаар хэлэв.
- Тэгвэл ийм байна. Би таныг жуулчлан явахыг зөвлөж байна.
- Жуулчлах ий? гэж хатагтай Данглар аман дотроо шивгэнэв.
- Мэдээж хэрэг. Дангларын хэлснээр та баян, эрх чөлөөтэй хүн шүү дээ. Мадмуазель Эжений хурим бүтээгүй мөн Данглар алга болчихсон ийм хоёр будлианы дараа Парисаас зайлж явах хэрэгтэй.

Зөвхөн хүмүүс таныг хаягдаж хоцорсон ядуу хүүхэн гэж үзэх нь чухал. Дампуурсан хүний эхнэр баян чинээлэг өргөн дэлгэр амьдралтай байхыг хэзээ ч уучилдаггүй юм.

Хаягдаж хоцорсон хүүхэн гэж итгүүлэхийн тулд Парист бас хоёр долоо хоног байж дайралдсан хүн бүрдээ Данглар намайг хаячихаад яваад өгсөн гэж яриад байвал найз хүүхнүүд чинь үүнийг цааш нь тараах болно.

Дараа нь та гэрээсээ зайлан явж очир эрдэнэсээ орхиж өөртөө ногдох эд хөрөнгөөс татгалзвал таны харамгүй сэтгэлийг өндөрт гаргаж, таныг магтан сайшаах болно.

Ингэвэл таныг хаягдаж хоцорсон хөрөнгө хогшилгүй хүн гэж бүх хүн мэдэх болно. Харин ганцхан би л тан» санхүүгийн байдлаг мэдэх учир үнэнч хамт зүтгэгчийн хувьд тайлан гаргахнаа ч бэлхэн байна.

Хатагтай Данглар энэ аймшигт яриаг сонсоод царай нь цонхийход Дебрэ маш тайван хайхрамжгүй байдалтай байлаа.

- Хаягдаж хоцорсон гэнэ ээ? Таны хэлдэг зөв. Би хаягдаж хоцорсон хүн. Намайг ганцаардсан хүн болсонд эргэлзэх хүн байхгүй.

Энэ бол тэрхүү тачаадан дурлаж байсан, бардам зантай хүүхний Дебрэд хэлж чадах ганц үг нь ажээ.

Дебрэ бичиг цаас түрийвчнээсээ гаргаж, ширээн дээр дэлгэн тавиад

- Гэхдээ л та бол баян, тэр ч байтугай дэндүү баян хүн гэж хэлэв.

Хатагтай Данглар цохилсон зүрхээ намдааж, нүдэндээ гүйлгэнэсэн нулимсыг зогсоохыг хичээн дуугүй харж суулаа. Гэвч эцсийн эцэст нэрээ бодох сэтгэл нь дийлж, зүрхнийхээ цохилтыг намдааж чадаагүй ч гэсэн нэг ч дусал нулимс гаргасангүй.

- хатагтай минь, та бид хоёр, жил хагасын өмнөөс хоршоо нөхөд болсон билээ. Та нэг зуун мянган франк оруулсан. Энэ бол энэ жилийн дөрөвдүгээр сард болсон шүү дээ. Бидний гүйлгээний ажил тавдугаар сард эхэлсэн. Бид тавдугаар сард дөрвөн зуун тавин мянгыг борлуулж чадсан. Зургадуугар сард орлогын хэмжээ есөн зуун мянгад хүрсэн. Бид долдугаар сард үүн дээрээ сая долоон зуун мянгыг нэмсэн. Энэ бол испанийн тэмдэгт цаасны сар байсныг та санаж байгаа биз.

Бид наймдугаар сард, сарын эхээр гурван зуун мянган франк алдсан. Гэвч арван тавдын үеэр алдсанаа буцааж олж чадсан бөгөөд сарын сүүлчээр даагаа нэхэж чадсан. Таван сараас өчигдөр өдрийг хүртэлх манай ажиллагааны дүнг би бодож гаргалаа. Бидэнд одоо хоёр сая дөрвөн зуун мянган франк буюу хүн бүрт сая хоёр зуун мянган франк бэлэн мөнгөөр байна гэж Дебрэ яриад биржийн худалдаачны тайван байдлаар тэмдэглэлийнхээ дэвтрийг эргүүлэн байж, - Түүнээс гадна бид миний гар дээр үлдсэн хөрөнгөнд наян мянган франкийн нарийн хүүтэй байна гэж хэлэхэд, хатагтай түүний үгийг тасалж,

- Хаанаас энэ хүү гараад ирэв? Та энэ мөнгийг хэзээ ч гүйлгээнд оруулж байгаагүй шүү гэж хэлэв.

- Хатагтай минь уучлаарай гэж Дебрэ хүйтнээр хэлээд – энэ мөнгийг гүйлгээнд оруулах онц эрхийг би танаас авсан байсан тул үүнийгээ ашигласан юм. Тэгэхлээр таны хувьд дөчин мянган франкийн хүү, бас анхны татварт өгсөн зуун мянган франк, өөрөөр хэлбэл сая гурван зуун дөчин мянган франк ногдож байна. тэгэхийн хамт хатагтай минь би дөнгөү уржигдархан таны хувийг мөнгө болгочихсон билээ. Би танд гэнэт тайлан гаргах болно гэж мэдсэн юм шиг байгаа биз.

Таны мөнгө энд байна. Хагас нь зээллэгийн билетээр хагас нь чекээр байна. Энэ мөнгө яг энд байгаа юмаа. Миний гэр надад найдвар багатай санагдсанаар ч барахгүй нотариатын хүмүүсийг дуугүй байж чадахгүй гэж би үзсэн юм. Үл хөдлөх хөрөнгө гэдэг нотариусаас ч илүү их мэдэгдүүлчихдэг юм. Эцэст нь танд нөхрийн мөнх хамт ногдох хөрөнгөнөөс өөр хөрөнгө эзэмших эрх байхгүй. Тийм учраас би таны ганц баялаг болох энэ мөнгийг Энэхүү шүүгээнд нууцлан хийсэн хайрцагт хадгалж байсан юм. Их найдвартай байлгахын тулд үүнийг би өөрийн гараар хийсэн юм гэв.

- Тэгэхээр хатагтай минь гэж Дебрэ үргэлжлэн хэлээд шүүгээгээ дараа нь нууц хайрцгийг онгойлгож, - найман зуун мянган франкийн банкын билет энэ байна. Эднийг зузаан цомог шиг үдсэнийг харж байгаа биз. Би үүн дээр хорин таван мянган франкийн түрээсийн тасалбар нийлүүлнэ. Ингээд зуун арав шахам мянган франк үлдэж байна. Миний банкны эзэнд үзүүлж

мөнгөө авах чек энд байна. Харин банкны эзэн маань Данглар шиг хүн биш болохоор санаа зовохгүй байж болно. Зохих ёсоор мөнгийг чинь өгөх болно гэв.

Хатагтай Данглар мөнгөний чек, түрээсийн тасалбар, багцтай зээллэгийн билетүүдийг хар аяндаа авлаа.

Ширээн дээр дэлгэн тавьсан энэ их баялаг бөөн цаас шиг санагдана.

Нулимс гараагүй хуурай нүдтэй хатагтай Данглан мэгшихээ болиод, цомгийг барьж явсан цүнхэндээ, түрээсний тасалбар, чек хоёрыг түрийвчиндээ хийж орхиод имй баян болсныг нь тайтгаруулах зөвөрхүү зөөлөн үг хэлэхийг хүлээж цонхигор царай гарган анир чимээгүй байлаа.

Гэвч хүүхэн дэмий горьджээ.

- Одоо хатагтай та маш сайхан хангагдлаа. Та одоо жилд жар шахам мянган ливрийн орлоготой боллоо. Энэ бол одоо үгүйдээ л жилээс доошгүй хугацаанд ил задгай амьдарч болохгүй хүүхэнд асар их хөрөнгө дөө. Та одоо санаандаа орсноор ямар ч зүйлээр шалиглан зугаалж болно. Хэрэв энэ хөрөнгө таны авч чадалгүй хагацсан тэр хөрөнгөтэй зэрэгцүүлэхэд хангалтгүй юм шиг санагдвал миний хувьд ногдоход хандаж болно шүү хатагтай минь. Харин тэгэхдээ би харицлан өгч авах журмаар танд өөртөө байгаа хөрөнгө болох сая жаран мянган франкаа өгөхөд бэлхэн байна гэж Дебрэ хэлэв.
- Эрхэмсэг танд баярлалаа. Надад ногдсон хувь бол удаан хугацаагаар олны дунд гарахгүй гэж бодож бөайгаа золгүй хүүхэнд хэрэгтэй хэмжээнээсээ хэтэрхий их болохыг та өөрөө ойлгож байгаа шүү дээ гэж хатагтай хэлэв.

Дебрэ гайхсан боловч биеэ барьж, “таны тааллаар болог!” гэсэн маягаар дохисныг нь эелдэг зөөлөн илэрхийлэл гэж тайлбарлаж болохоор байв.

Хатагтай Данглар бас л ямар нэгэн юм горьдон хүүээж байсан байж болох юм. Гэвч энэ хайхрамжгүй дохио, Дебрэгийн зайлсхийсэн харц, түүнчлэн гүнээ мэхийн ёсолсон болон ихэд учиртайгаар дуугүй байхыг хараад толгойгоо дээш болгож, хаалга онгойлгоод хорсон тэвдсэн шинжгүй шууд гарч, явах бололцоо олгосон хүнд өөд толгой ч дохисонгүй шат руу гүйв.

- Дэмий хэрэг! Гэж Дебрэ хүүхнийг гарч явсны дараа хэлээд, - Энэ бүхэн бол хоосон яриа. Энэ хүүхэн гэртээ үлдэж, бриж дээр тоглож чадахгүй учир роман уншиж, хүн хөлслөн тоглож байх болно гэв.

Тэгээд тэмдэглэлийнхээ дэвтрийг дахин авч, төлсөн мөнгөний хэмжээг хичээнгүйлэн зурав.

- Надад сая жаран мянган франк үлдэж байна. Вильфорын охин Валентина үхчихсэн нь харамсалтай. Тэр бүсгүй надад бүх талаараа тохирох хүн байсан юм. Ээж хэлэв.

Тэгээд заншсан ёсоороо, хатагтай Дангларын явсны дараа хорин минутын дараа гарахаар шийдэв. Дебрэ энэ хорин минутын хугацаанд цагаа урдаа гаргаж тавьчхаад тооцоогоо бодож эхлэв.

Дебрэгийн тооцоо хийж байгаа Сен-Жермен-Де-Пре гудамжны ядуухан байшингийн дээврийг, доторхыг нь харах гэж байшингийн дээврийг сөхдөг Асмодей шиг сөхөж харвал тун сонин юмыг олж харах байлаа.

Дебрэ хатагтай данглартай хоёр сая хагасыг хувааж авч байсан тасалгааны дээд талд бас өөр нэг тасалгаа байсан бөгөөд тэнд суугчдыг бид таних ба анхаарал татах хүмүүс байв.

Энэ тасалгаанд Мерседес Альбер хоёр байжээ.

Сүүлийн өдрүүдэд Мерседесийн байдал эрс өөрчлөгдөв. Баян чинээлэг явсан үедээ бардам ихэмсэг сайхан байсан авгай ердийн даруу төлөв болсон доо биш, харин Мерседесийн нүдний нь гал буурч, уруул нь дахин инээмсэглэхээ больж, нэгэн цагт төчнөөн ухаалаг байсан оюун ухааныг нь ямар нэгэн зовиуртай санаа бодол эзэмдэн авч, гялалзаж явсан үеийн нь яриа хөөрөө үгүй бослноос өөрчлөгдсөн ажээ.

Ядуу зүдүү байдал Мерседесийн оюун ухааныг мохоосонгүй, энэ ядуу зүдүү байдал түүнд дарамт болсноос энэ эмэгтэй мохоо хулчгар болсонгүй. Мерседес ижил дасал болсон орчин тойрноо орхиж, өөрийн шилж авсна харь хөндий орчинд орж, хурц гээлтэй тасалгаанаас гарч, харанхуйн дунд гэнэт орсон юм шиг болжээ. Энэ эмэгтэй орд харшаас гарч арчаагүй муу оромд нүүж ирээд, зөөлөн дулаан ор дэрийг нь орлосон муу дэвсгэрээ хараад өөрөө ч өөрийгөө танихаа больж% шавар домбоо өөрөө ширээн дээр авчирч тавих ёстой болсон хатан хаан мэт байлаа.

Гоо үзэсгэлэнт каталон бүсгүй, өөрөөр хэлбэл сайн санаат хатагтайн бардам сэхүүн харц, үзэсгэлэн төгөлдөр инээмсэглэл үгүй болжээ. Яагаад гэвэл эргэн тойрондоо цйтгар хүргэм, нямбай нарийн эзэд хиртэхийг нь бодож бор цаасаар цаасалсан хана, дэвсгэргүй нүцгэн чулуун шал, бүдүүн хийцтэй ядуу доройгоороо нүдэнд чимэггүй модон хэрэглэл, ер нь л өнгө хослон зохисон үзэмж сайхныг харж дассан хүний харцыг гутаамаар юмсыг харж суух болсноос тийм болжээ.

Морсер хатагтай гэрээ орхиж гарснаас хойш энд суух болжээ. Энэхүү мөнхийн анир чимээгүй байдлаас болж, гүн хавцлын ирмэгт тулж, ирсэн аяны хүн мэт толгой нь эргэжээ. Альбер түүний санаа бодлыг таах гэсэн юм шиг сэм сэмхэн хару, гагцхүү уруулаараа инээмсэглэж сурчээ. Нүдний зөөлөн туяагаар гийгүүлэгшдээгүй энэхүү хөшиж орхисон мэт инээмсэглэл нь амьдруулагч илчгүй гэрлийн цацралтай адил байлаа.

Альбер ч бас уйтгарлаж ичиж зовсон байдалтай байлаа. Түүнийг шинэ байдалдаа дасахад баян чинээлэг явсан цагийн нь үлдэгдэл саад болж байв. Тэрээр бээлий хийлгүй гэрээсээ гаръя гэхэд нь гар нь дэндүү цагаан байлаа. Явган явах гэхэд шаахай гнь дэндүү тодхон гялалзана.

Гэвч эх үрийн хайраар салшгүй холбогдсон энэ сайн сэтгэлт ухаалаг хоёр хүн бие биеийн санаа бодлыг үг дуугүй болгох бөгөөд амьдралын материаллаг үндсийн тухай яриа болоход ойр дотны найз нөхдийн хооронд зайлшгүй гардаг дохио санамж үг цухуйлгах явдалгүйгээр ойлгогддог байлаа.

Ер нь хэлэхэд, Альбер ээжийгээ айлгахгүйгээр,

- Ээж ээ манайд одоо мөнгө байхгүй гэж хэлж чаддаг байв.

Жинхэнэ гуйланчлал гээчийг Мерседес хэзээ чүзээгүй байсан юм. Тэр, залуу байхдаа өөрийгөө ядуу зүдүү гэж байнга нэрлэдэг байжээ. Гэвч энэ хоёр бол адил биш ажээ. Хэрэгцээ, гуйланчлал гэдэг хоорондоо эрс хол ойлголт юм.

Каталанд байхад Мерседест тун олон юм хэрэгтэй байсан боловч түүнд их олон зүйл быайсан юм. Тор бүтэн байвал загас баригдана. Загас баригдаж байвал тороо сэлбэх ужтас байдаг байсан ажээ.

Орй дотнын хүн байхгүй ч байлаа гэсэн ахуй амьдралын өчүүхэн зүйлүүдийг үл хайхрагч хайр сэтгэл байсан бөгөөд зөвхөн өөрийн тухай бодож, өөрийн төлөө хариуцаж байв.

Мерседес өөрт байсан тэдгээр өчүүхэн зүйлийг буадтай харамгүй өгөөмөр хуваалцаж байсан бол харин одоо түүнд байх юм үгүй болж, зөвхөн хоёр биенийхээ тухай бодоход хүрчээ.

Өвөл болох дөхөж байлаа. Хатагтай Морсерын гэрийг олон хоолойтой пийшин үүдний нь өрөөнөөс заслал чимгийн нь өрөөг хүрлэл халаадаг байсан бол одоо энэхүү тохьгүй бөгөөд хүйтэн болж эхэлсэн тасалгаанд гал түлэх түлшгүй ажээ. Хатагтайн өрөө нь алтаар үнэлэгдэх ховор сайхан цэцгийн дунд байсан бол одоо түүнд өчүүхэн жижиг цэцэг ч байсангүй.

Гэвч түүнд хүү байлаа.

Цааргалахын урамшил хэтэрхий их болохоор тэднийг амьдралын ердийн байдлаас дээр тавьсаар байлаа. Урамшил гэдэг бараг онго орох гэсэн үг юм. Онго орох гэдэг нь оюун сэтгэхүйг юм бүгдийн дээр аваачна.

Гэвч анхны сэтгэл хөдөлтийн онго буурч, санагалзан бодохын орноос бодит ертөнцөд алгуур алгуурхнаар буухад хүрэв.

Туйлын хүслэнгийн тухай ярьж ярьчихаад дараа нь амь зуух ердийн зүйлсийн тухай ярих цаг болжээ.

Хатагтай данлар шатаар бууж явсан яг тэр үед Альбер эхдээ,

- Ээжээ, хөрөнгөө тоолж үзье. Би ажиллах төлөвлөгөө хийхий тулд днүгий нь мэдэх хэрэгтэй байна гэв.
- Дүн нь: тэг гэж Мерседес гашуунаар инээмсэглэн хэлэхэд Альбер,
- Үгүй, ээж ээ, дүн нь гурван мянган франк байх ёстой. Энэ гурван мянгаар маш сайхан тохижих санаатай байна гэж хэлв.
- Хүү минь! гэж Мерседес санаа алдлаа.
- Хайрт ээж минь би мөнгөний үнэ цэнийг мэдэхүйц хангалттайгаар мөнгийг үрсэн нь харамсалтай. Гурван мянган франк гэдэг чинь асар их мөнгө, тэгэхээр энэ мөнгөөр мөнхийн сайхан байдлын шидэт барилгыг барьж босгоно гэж Альбер хэлэхэд,
- Хүү минь чи тоглоом хийж байна уу? Бид тэр мөнгийг хүлээж ваха юм гэж үү? Гэж Мерседес асугаад царай нь угайв.

Үүнийг шийдчихсэн шиг надад санагдаж байна. Энэ мөнгө Марсель хотын Меляны модот гудамжин дахь бяцхан байшингийн цэцэрлэг дотор булсан байгааг та мэдэх учраас тэгээд ч бүр бидэнд мөнгө байхгүй байгаа болохоор бид түүнийг хүлээн авна. Та бид хоёр, хоёр зуун франкаар нь Марсельд очно гэж Альбер шийдмэг хэллээ.

- Хоёр зуун франкаар ий? Альбер чи юу ярина вэ? гэж Мерседес хэлэхэд, Алтбер,
- Тийм ээ шуудангийн хороо, хөлөг онгоцын гшазруудаас асууж тооцоо хийсэн юм. Та Шалон хүртэл шуудангийн сүйх тэргэнд суудал захиарай. Ээж та хатан хаан шиг жуулчлах нь байна шүү дээ гэж хэлээд үзэг авч бичсэн нь:

Сүйх тэрэг..... 35 фр

Шаланоос Лион хүртэл хөлөг онгоцонд6

Лионоос Авиньон хүртэл хөлөг онгоцонд 1.

Авиноноос Маресль хүртэл 7

Замын зардалд 50

БҮГД ДҮН 114 фр

- За яах вэ нэг зуун хорь ч болог гээд Альбер инээмсэглэж, - Ээж ээ, би их өгөөмөр байгаа биз дээ. Залуу хүнд их тавлаг байдал хэрэггүй байдаг юм. Тэгээд ч би туршлагатай жуулчин хүн.
- Өөрийнхөө сүйх тэргэнд зарцтайгаар уу?
- Ээж минь бүх л арга хэрэгслээр явна.
- За тийм байг. Харин хоёр зуун франк хаанаас олох вэ? гэж Мерседес асуув.
- Энэ байна. Бас дахиад хоёр зуу байна. Би цагаа зуун франкаар бас цагнахаа гинжин унжлагыг гурван зуугаар худалдчихсан. Та бодооч! Унжлага нь цагнаасаа хоёр дахин үед хүрчихлээ. Илүү дутуу хэрэгтэй хэрэггүй чимэг ямагт илүү үнэ хүрдэг нь хуучин ёс хойно доо! Одоо бид хоёр баян боллоо. Танд замд хэрэглэх зуун арван дөрвөн франкийн оронд хоёр зуун тавин франк байна.
- Энд ч бас төлөх хэрэгтэй шүү дээ.
- Арван гурван франк. Би үүнийг өөрийнхөө зуун тавиас төлчихнө. Надад замд явахад зөвхөн наян франк хэрэгтэй учраас би зүгээр л элбэг, дэлбэгт умбах болно. Энүүгээр ч бас дуусахгүй шүү. Ээж та үүнийг юу гэх вэ?

Тэгээд Альбер эртнээс хойш саваагүйтэн хадгалж явсан ч юм уу эсвэл ирснээ мэдэгдэж бяцхан хаалга сэм цохидог байсан гивүлүүртэй үл таних бүсгүйчүүдийн аль нэгний тухай эвэргүү зөөлөн дурдатгал ч байж болох алтан точвтой тэмдэглэлийн дэвтэр гаргаж ирэв. Тэгээд Альбер тэмдэглэлийнхээ дэвтэр дотроос мянган франкийн тэмдэгт цаас сугалж гаргав.

- Энэ чинь юу юм бэ? гэж Мерседес асуув.
- Мянган франк. Ёстой мөнгө шүү дээ ээж ээ.
- Чи үүнийг хаанаас олоо вэ?
- Ээж ээ, миний хэлэхийг сонс! Харин бүү сэтгэл зовоорой.

Тэгээд Альбер ээждээ дөхөж очоод хоёр хацар дээр нь үнэсээд дараа нь хойшоо болж, ажиглан харав.

- Ээж ээ, та өөрийгөө ямар сайхан гоо сайхан болохыг ч мэдэхгүй гэж төрсөн үрийн гүн хайрын сэтгэлээр хэлээд – Та бол энэ дэлхий дээр хамгийн гоо үзэсгэлэн, хамгийн сайхан сэтгэлтэй эмэгтэй гэв.

Тэгэхэд Мерседес сормуусан дээрээ бөнжигнөж байгаа нулимсыг тогтоох гэж дСмий оролдон,

- Хайрт хүү минь! гэж хэллээ.
- Нээрээ шүү, миний хайр, хүндэтгэл болж хувирахад танд гагцхүү золгүй явдал тохиолдох л дутуу байжээ.
- Надад хүү байгаа цагт би золгүй хүн биш. Тэр маань надтай хамт байхад би золгүй хүн болохгүй гэж Мерседес хэлэхэд,
- Тийм ээ. Харин түүнд л хамаг учир оршиж байгаа юм. Бид юу гэж шийдвэрлэснийг та санаж байна уу? гэж Альбер асуулаа.
- Бид ямар нэг юм шийдсэн гэж үү? Гэж Мерседес асуухад, Альбер,

- Тийм ээ, та Марсельд суурьшиж, би Африк руу явж, зүүж явахаасаа татгалзсан нэрийнхээ оронд хүлээж авсан нэрээ хамгаалах гэж шийдсэн шүү дээ гэж хэлэхэд Мерседес санаа алдлаа.
- Би өчигдрөөс эхлэн морни цэрэгт бүртгэгдсэн гэж хэлэхдээ энэ доромулогдолд нь хичнээн их гавьяа байгааг өөрөө ч мэдэлгүй ичингүйхэн доош харж – Миний бие наддаа хамаарагдах учир би түүнийг худалдаж болно гэж шийдсэн юм. Би өчигдрөөс эхлээд өөр хүн орлох боллоо. Би өөрийгөө худалдчихлаа. ХХарин тэгэхдээ өөрийнхөө үнээс илүү үнэтэй. Хоёр мянган франкаар худалдчихсан гэж инээмсэглэхийг оролдон хэлэв.
- Энэ мянга уу?... гэж Мерседес цочин асуулаа.
- Энэ бол хагас мөнгө нь байгаа юм. Үлдсэнийг нь би нэг жилийн дараа авна.

Мерседес ямар ч үгээр дүрслэхийн аргагүй царайгаар тэнгэр өөд харахад, хоёр ахцар дээгүүр хос нулимс алгуурхан бөнжигнөн урсав. Тэгээд,

- Цусных нь үнэ! Гэж шивгэнэн дуугарлаа.
- Тийм ээ, хэрэв намайг албал гэж А«ьбер инээж хэлээд, - ээж минь би өөрийгөө галзуурсан мэт хамгаа«на гэж танд итгүүлэн хэлье. Би амьд явахыг одоо шиг хэзээ ч хүсСж байгаагүй юм гэхэд Мерседес,
- Бурхан минь! гэж аснаа алдлаа.
- Ер нь ингэхэд та намайг яагаад алагдчих байх гэж бодож байгаа юм бэ? Өмнөдийн Ней гэгддэг Ламорсьер алагдсан гэж үү? Шангарные алагдсан гэж үү? Бидний танил Моррель алагдсан гэж үү? Намайг гял цал болсон ёслолын хувцас өмсөөд хүрч ирэхэд та яаж их баярлах бол оо! Надад энэ хувцас ямар их зохихыг бодоорой. Би гоё сайхныг нь бодож морин цэргийн хороо сонгож авсан юм.

Мерседес инээмсэглэхийг оролдсон хирнээ санаа алдлаа. Хохирлын хамаг хүндийг энэ хүү өөртөө үүрсэн нь сайхь гэгээн хүүхнийг шаналгана.

- Тэгэхээр ээж танд одоо дөрвөн мянга гаруй франк байна. Та энэ дөрвөн мянга гаруй франкаар хоёр жил ядуу биш амьдарна гэж Альбер үргэлжлэн ярив.
- Чи тэгж бодож байна уу? гэж Мерседес хэлэхэд түүний энэ дуу үнэхээр сэтгэл өвдсэн дуу байсан бөгөөд үнэн утга санааг нь Альбер ойлгожээ. Альберын зүрх шимширч эхийнхээ гарыг зөвхөнөө зөөлнөөр атган,
- Тийм ээ, та амьдрах болно! гэж Альбер хэлэхэд, Мерседес,
- Би амьдрах болно, гэхдээ Альбер чи явахгүй, тийм ээ? гэж дуу алдлаа.
- Явна аа ээж ээ гэж Альбер шийдмэг дуугаар хэлээд – Та намайг дэргэдээ авч ашиггүй дэмий амьдруулахад хүргэхээр надад дэндүү их хайртай юм. Тэгээд ч би гэрээнд гарын үсэг зурчихсан гэв.
- Хүү минь чи өөрийн санаа зоригийн даЈуу хийжээ. Харин би бол бурхны хүсэл зоригийн дагуу хэлж байна.
- Үгүй дээ ээж минь би өөрийн санаа зоригийн дагуу биш, харин саруул ухаан, хэрэгцээ шаардлагын дагуу ингэж байгаа юм. Арга барагдан цөхрөх гэдэг юу болохыг та бид хоёр хоёул үзэж мэдсэн. Одоо танд амьдрал гэгч юу вэ? Юу ч биш. Амьдрал гэдэг надад юу вэ? Юу ч биш, дэмий юм гэдэгт ээж та шнэмшээрэй. Хэрэв та бхйгаагүйсэн бол би эцэгтээ эргэлзэж, нэрийг

нь зүүж явахаасаа татгалзсан тэр өдөр л энэ амьдрал тасарч төгсөх байсан юм! Хэрэв та надад найдаж, өөрийн ирээдүйн аз жаргалыг надад даатгаж өгвөл энэ чинь миний хүчийг хоёр дахин нэмэгдүүлж өгнө. Тэгвэл би Алжирын амбан сайд дээр очно. Энэ бол үнэнч хүн, ёстой цэрэг эр байгаа юм. Би түүнд өөрийн гунигт явдлыг хэлнэ. Хэрэв тэр хэлсэн үгэндээ хүрч, миний юу чадахыг харвал, би хагас жилийн дараа офицер болж буцаж ирнэ. Эсвэл ерөөсөө ирэхгүй байх. Хэрэв би офицер болчихвол миний мөнгө та бид хоёрт хүрэлцээтэй болох учраас таны ирээдүй хангагдана. Тэгээд ч бас та бид хоёр миний шинэ нэрээр бахархаж байх болно. Яагаад гэвэл энэ таны жинхэнэ нэр шүү дээ! хэрэв намайг буцаж ирэхгүй бол.... ээж та хэрэв амьд явахыг үл хүсвэл амь наснаасаа хагацаж болн. Тэгвэл бидний золгүй явдал аяндаа эцэс болох нь тэр.

- За тэгье. Чиний зөв хүү миьн, бидний шүүн тунгааж харахын тулд бидний яахыг мөрдөн дагаж, биднийг харж байгаа хүмүүст, харамсаж энэрэхээс өөр аргагүй болохыг нь нотлон харуулъя гэж Мерседес хариулав.

- Ээж минь муухай бодлоо орх! Бид жаргалтай улс, үгүйдээ л жаргалтай байж болно. Та бол ухаантай, даруу хүн. Би жрийн бор хүн, тэгээд ч ухаантай болсон гэж найдаж байна. Би алан хааж байгаа болохоор баян гэсэн үг, та эрхэм Дантесийн байшинд тайван байна. Ээж минь гуйя танаас туршаад үзье гэж Альбер дуу алдан хэлэв.

- Тэгье хүү минь. Яагаад гэвэл хүү минь чи амьд явах ёстой. Чи аз жаргалтай байх ёстой гэж Мерседес хариулав.

- Тэгэхээр бидний хуваарилал төгслөө гэж Альбер зориуд энгийн байдлаар хэлээд, - Бид өнөөдөртөө явж болно. Би танд суудал захиалчихъя гэв.

- Аа, өөртөө?

- Би энд хоёр гурван өдөр байх хэрэгтэй байна. Энэ бол бид хоёрын салалтын эхэн болохоор бид одоогоос дасах хэрэгтэй. Би баталгаат бичиг авах Алжирын тухай мэдэх хэрэгтэй байна. Би таныг Марсельд гүйцэж очно.

- За яах вэ, явъя! Гэж Мерседес хэлээд авч гарсан ганц алчуураа мөрөн дээгүүрээ тохов. Энэ нь маш үнэтэй, хар кашмер алчуур байлаа.

Альбер бичиг цаасаа яаран цуглуулж, эзнийг дуудаж, гучин франк, ээждээ гараа өгч шатан дээр гарав.

Тэдний өмнө нэгэн хүн бууж явснаа торгон даашинз шатны бариулд шүргэн шаржигнахыг сонсоод эргэж харав.

- Дебрэ! Гэж Альбер шивгэнэв.

- Морсер та юу? гэж сайдын нарийн бичгийн дарга зогсож хэлэв.

Дебрэ нууцаа хадгалахыг оролдохоосоо сонирхох хүсэл нь илүү байв. Тэгээд ч бас түүнийг таньчихсан ажээ. Золгүй явдал нь Парист их шуугиан дэгдээсэн хүнтэй энэхүү хэн ч мэдэхгүй модон хэрэглэлтэй байшинд дайралдах нь үнэндээ ч зугаатай хэрэг байв.

- Морсер! Гэж Дебрэ давтан хэлэв.

Харин бүдэг харанхуй шатан дээр алчуур боосон хатагтай Морсерын барааг ажиглаад инээмсэглэн нэмж хэлсэн нь:

- Өө, Альбер, уучлаарай. Танд саад хийхийг зүрхлэхгүй ыбайна гэв. Альбер Дебрэгийн санааг ойлгож,
- Ээж ээ, дотоодын явдлын яамны сайдын нарийн бичгийн дарга, миний найз агсан Дебрэ энэ байна гэж ээждээ хандан хэлэв.
- Яагаад найз агсан гэж% Юа юу хэлэх гэж байна? гэж Дебрэ хэлэв.
- Эрхэм Дебрэ, одоо надад найз нөхөд байхгүй. Би найз нөхөдтэй байх ёсгүй. Та намайг таньж, талархуу байсанд чинь баярлалаа гэж Альбер үргэлжлэн ярив.

Дебрэ хоёр гишгүүр дээш өгсөж, Альберын гарыг чанга атгаж, чадахынхаа хэрээр халууну дотноор,

- Хүндэт нөхөр минь би таны уй гашууд сэтгэл түгшиж байсан бөгөөд хэзээд таны мэдэлд байна гэж хэлэв. Тэгэхэд Альбер инээмсэглэж,
- Эрхэм танд баярлалаа. Бидэнд золгүй явдал тохиолдсон боловч хэнээс ч тусламж гуйхааргүй хүрэлцэхүйц баян байна. Бипд Парисыг орхиж явлаа. Замын бүх заордлаас гадна бас таван мянган франк үлдэж байна гэж хэлэв.

Дебрэ түрийвчиндээ нэг саятай байсан учир царай нь улайлаа. Түүний эрүүл ухаан яруу найргаас хэдий хөндий ч гэсэн, нэгэн байшин дотор хойр хүүхэн байгаад нэг нь зүй ёсоор гутамшиг болсон боловч алчуур дотроо бүтэн хагас аятай мөртлөө гуйлгачин болло гэж гарч байхад нөгөө нь зүй бусаар доромжлогдсон мөртлөө золгүй явдалдаа ихэмсэг уужим байдалтай, өчүүхэн хэдэн зоостой боловч баян гэж бодоод гарч явааг өөрийн эрхгүй бодов.

Энэ зэрэгцүүлэлт нь баатар эрийн сэрлийг нь мартаход хүргэж, илтэд байгаа энэ жишээ түүнийг хачин болгочхов. Дебрэ ёсны төдий хэдэн үг бувтнаад шатаар иүргэн буув.

Энэ өдөр түүний доод хүмүүс яамны түшмэд муу зантай байснаас нь багагүй зүдэрчээ.

Гэвч орой нь Мадлений модот гудамжин дахь таван мянган ливрийн орлоготой сайхан байшингийн эзэн болжээ.

Маргааш орой нь таван цагт Дебрэг худалдааны магадлагаа бичигт гарын үсэг зурж байх үед хатагтай де Морсер хүүгээ зөвөргүү зөөлнөөр үнэсээд, шуудангийн сүйх тэргэнд суулаа. Лаффит шуудангийн буудлын дээд талын давхарга дээрх дутуу нээлттэй цохны цаана нэгэн хүн зогсож байв. Тэр хүн Мерседес сүйх тэргэнд хэрхэн суусан, сүйх тэрэг хөдлөн явсан ба Альбер холдон явахыг харжээ.

Тэгээд эргэлзэлд автсан духаа гараараа илээд, Би булаагаад авчихсан тэрхүү аз жаргалыг энэ гэмгүй хочр хҮнд яаж эргүүлэн өгөх билээ? Бурхан надад тусална гэв.

10.АРСЛАНГИЙН ҮҮР

Ла-Форс гэдэг шоронгийн хамгийн хүнд, аюултай хэрэгтнүүдийг хорьдог хэсгийг гэгээн Бернарын хэсэг гэж нэрлэнэ.

Шоронгийнхон өөрсдийн этгээд хэлээр Арслангийн үүр гэж нэрлээжээ. Яагаад гэвэл тэндхийн хоригдлууд сараалж төмөр, заримдаа манаач нараа ч хүртэл мэргэ орхидог учраас тэгж нэрлэсэн бололтой.

Энэ бол шорон доторр шорон юм. Энэхийн хана нь хоёр дахин зузаан бөгөөд хуягууд бүдүүн сараалжийг өдөр бүр нарийвлан шалгаж үзнэ. Хуягуудын том бие, нэвт ширтэх мэт хүйтэн харуыг харахад өөрсдийн харьяат нарыг айлган сүрдүүлж, дуулгавартай барьж байж чадах хүмүүсийг энд шилж сонгож авсан нь илэрхий.

Тэрхүү хэсгийн хашаа өндөр ханаар хүрээлэгдсэн бөгөөд огторгуйн наран энэхүү зан суртахуун, бие махбодыг зэрэмдэглэгч ёроолгүй харанхуй руу шагайхаар зориглоход түүний туяа ахажуулдан тусна. Энд шударга үнэний шүүхийн илдэн доор орсон хүмүүс үргэжлийн санаа зовингуй, уйтгартай, цонхигор царайлан сүүдэр мэт хэрэн явна.

Тэр хоёр, гурваараа олонхдоо ганцаараа сүх ч юм уу нарын илч илүү туссан хана түшин зогсож энэхүү баргар оромд оршин суугчдын хэн нэгнийг дуудахаар эсвэл нийгэмд гологдож шаарлагдсан шинэ хүнийг түлхэж оруулахад л онгойдог хаалга руу хааяа нэг харна.

Гэгээн Бернарын шорон нь өөрийн тусгай хүлээн авах газартай юм. Энэ бол эргэлт оруулхаара ирсэн хүн хоригдолтой гар баолрих түүнд нэг юм дамжуулан өгч болхогүйгээр нэг нэгнээсээ гурван фут зайтайгаар тусгаарласан сараалжин ханатай урт байшин байв. Энэ хүлээн авах газар нь харанхуй, чийгтэй, ер нь л бүх талаараа ой гутмаар, ялангуяа энэхүү сараалжийн завсраар дусалж байгаа зүйл сараалжийн төмрийг бүрхсэн зэв гэрчлэн харуулж байгаа аймшигт үнэнийг, хүлээх гнь бүрч ой гутмаар ажээ.

Гэвч энд хэдий аймшигтай боловч хоногийн тоо нь тоотой бэлсөн хүмүүс ойр дотны хүмүүстэйгээ дахин нийлж сэтгэл сэтгэж болох диваажингийн орон юм. Арслангийн нүхнээс хүмүүс гагцхүү Сен-Жакийн боомт, эсвэл ялт хөдөлмөр, эсвэл ганц ганцаар хорих тасалгаанд очихын тулд гардаг юм.

Бидний дээр өгүүлсэн чийгтэй, хүйтэн хонгил дундуур хоёр гараа хармаандаа хийсэн нэгэн залуу зугаацан явах бөгөөд түүнийг нүхэнд суугчид их л сонирхон харна.

Хэрэв хувцас нь үрчийж урагдаагүйсэн бол түүнийг гоёмсог ч гэж хэлж болох байв. Цоо шинэ нарийн торгомсог цэмбэ хоригдлыг хуучин өнгөнд нь оруулах гэж илэхэд даруй шинэхэн өнгөө олно.

Шоронд суух хугацаанд өнгө нь өөрчлөгдсөн батист даавуун цамцаа нямбайгаар товлоод, гялгар шаахайгаа өнцөг дээрэ овог, нэрийн эхний үсгийг хатгамалж титмээр шагласан нусны алчуураар зүлгэнэ.

Энэ хоригдол хувцас хунараа яаж янзалж байгааг Арслангийн нүхэнд амьдрагч хэдэн хүн илтэд сонирхон харж байв.

- Хараач, ноён гоёж байна гэж хулгайч нарын нэг хэлэхэд өөр нэг нь
- Тэрэнтэй тэрэнгүй сүртэй эр юм. Сам, энгэсэг байвал цагаан бээлийтэй бүх ноёдын сүрийг дарах байх гэв.
- Хувцас нь шинэхэн бололтой шаахай нь гялалзаж байна. Бидэн дээр ийм шувуухай орж ирсэн нь харин ч бахадмаар юм биш үү. Манай цагдаа нар чинь ёстой дээрэмчид шүү. Ийм гоё хувцсыг урах гэж дээ!
- Их зальхай этгээд гэж ярилцаж байна билээ. Үл ялих юмаар оролддоггүй юм байх... Ийм залуу мөртлөө Тулоноос ирж амжсан байна. Тоглоом биш дээ! гэж гурав дахь нь хэлэв.

Харин энэхүү гайхан шагшрахын бай болсон хүн хэдийгээр үгийн нь учрыг ойлгож чадахгүй боловч энэ магтаалын чимээнд сэтгэл ханамжтай байв.

Тэрээр хувцас хунараа янзалж дуусаад дэргэд нь манаач хана налаад зогсож байсан шоронгийн мухлагийн цонх руу дөхөж очоод,

- Эрхэм минь надад хорин франк өгөөч, би танд удахгүй буцааж өгнө. Манай аав ээж таны хэдэн зоосыг бодвол сая саяар тоолох хөрөнгөтэй болохоор танд ямар ч муу юм болохгүй... За, өгөөч дээ. Би хорин франкаар хөлстэй хэсэгт очиж, нөмрөг худалдаж авмаар байна. Цаг үргэлж фрактай тун эвгүй юм. Ноён Кавальканти фрак өмсөнө гэдэг чинь юу Гэсэн хэрэг вэ! гэж хэлэв.

Манаач мөрөө хавчаад цаашаа харчихлаа. Тэрээр олныг хөгжөөх байсан энэ үгийг сонсоод инээсэн ч үгүй. Ийм юм ханатлаа сонсож дөжирчихсэн бололтой.

- Та сэтгэлгүй хүн юм. За гайгүй, таны хөөгдөхийг чинь үзнэ дээ гэж Андреа хэлэв.

Энэ удаад манаач эргэж хараад чанга инээлээ.

Хоригдлууд ойртон ирж, тэднийг хүрээлэв.

- Би энэ өчүүхэн мөнгөөр хувцаслаж, тусгай өрөөнд шилжинэ гэж танд хэлж байна шүү дээ. Би хэзээ хэзээгүй ирэх хүндэй эрхмийг олигтойхон хүлээж авъя гэж бодсон юм гэж Андреа яри.в
- Үнэн, үнэн! Сайн язгууртнаас гаралтай нь шууд харагдаж байна гэж хоригдлууд ам амандаа хэлэв. Тэгэхэд цагдаа нөгөө талын ханыг өргөн мөрөөрөө налаад,
- Та нар энүүнд хорин франк өгчих л дөө. нөхрийнхөө төлөө ингэх үүрэггүй гэж үү? Гэж хэлэхэд Андреа бардам байдлаар,
- Би энэ хүмүүст нөрөх биш, та намайг доромжлох эрх байхгүй гэв.

Тэгэхэд хоригдлууд бие бие өөдөө хараад сэмхэн ярилцав. Андреагийн хэлсэн үгнээс илүүгээр манаачийн хэлсэн үгнээс хүссэн шуурга салхи язгууртны толгой дээр хуралдаж эхлэв.

Хэт даврахад хүрвэл номхруулж чадна гэдэгтээ цагдаа залхуу хүрмээр шалгаадаг хүнийг сургах, бас урт удаан хугацааны жижүүрээ ямар нэг юмаар зугаацуулахыг хүсэж тэднийг дураар нь тавив.

Хоригдлууд Андреа өөд давшилж эхлэв. Зарим нь шаахайны амт үзүүлээд өгьеб гэлцэнэ.

Энэ хатуу ширүүн тоглоом нь замд унасан нөхрөө шаахайгаар биш, харин тахтай гутлаар өшиглөхөд оршино.

Зарим нь булцуудъя гэнэ. Энэ бол алчуурт элс, чулуу, хэрэв байвал зэс Мөнгө боогоод уг хүний мөр, толгой дундуур ороолгох зугаа юм.

- Энэ хээнцэр амьтныг ташуурдъя! Энэ эрхмийг ташуурдъя гэх дуу гарав.

Харин Андреа тэдэн руу эргэж, анивхийгээд хацраа түсбийлгэж хэлээрээ тасхийж дуугаргав. Энэ бол дуугүй байх хэрэгтэй гэсэн дээрэмчдийн бие биеийг мэдэх дохио юм.

Энэ бол Кадрусс зааж өгсөн тусгай дохио ажээ.

Хоригдлууд өөрийн хүн болохыг танив.

Тэр даруй алчуурт боосон чулуугаа хаяцгааж гол яргачингийн гутал нь эзнийхээ хөлд буцав. Тэгээд энэ ноёных зөв, өөрийнхөө хүссэнээр байж болно.

Хоригдлууд хүн ёсны чөлөөтэй байхын үлгэр дуурайлыг үзүүлэхийг хүсэ! байна гэх дуу гарч эхлэв.

Хүмүүсийн хөдөлгөөн намхрав. Манаач үүнд маш гайхса учир, Арлдсангийн үүрийн зан байдалд гарсан энэ өөрлөлтийг хувийн нөлөөнөөс илүү ноцтой зүйлээс болов гэж үзэж Андреаг гараас нь шүүрэн барьж нэгжиж эхлэв.

Андреа хараал зүхэл тавьсан боловч эсэргүүцсэнгүй.

Гэтэл сараалжтай хаалганы цаанаас харгалзагчийн дуу гарч,

- Бенеддетто! Гэв.

Манаач өөрийн олзыг тавив.

- Намайг дуудаж байна! гэж Андреа хэлэв.

- Хүлээх тасалгаанд! Гэж харгалзагч хашхирав.

- За тэр, харж байгаа биз. Над дээр иржээ. Кавалькантитай жирийн үхэх үйлтэн шиг харьцаж болохгүй гэдгийг хонгор та мэдэх болно.!

Тэгээд Андреа нөхөд болон манаачийг ангайдгаж орхиод сүүдэр мэт хагас онгорхой хаалгын зүг ухасхийв.

Түүнийг үнэхээр хамгаалагч байгаа нь эргэлзээгүй. Юм бүхэн тийм гэдгийг хэлээд өгч байна. гэнэтийн аз жаргал, бүх саад тотгорыг хөнгөн шуурхай давсан, санамсаргүй байтал эцэгтэй болж, өндөр нэр, алт мөнгө, намайг хүлээж байсан гялалзсан авхай энэ бүхэнинэг л биш дээ. Санамсаргүй тохиолдсон амжилтгүй явдал, авран хамгаалагч маань эзгүй байсан явдал намайг балласан, бас горьдлого байна. Хайр хишгийн гар түр холдсон байжээ. Энэ гар дахин намайг ангалын ирмэг дээрээс татаж авна. Болгоомжгүй оролдлого хийхийн хэрэг юу байх вэ? Авран хамгаалагч маань надаас хөндийрчхөж мэднэ. Надад туслах хочр арга түүнд бий: алтаар худалдаж авах битүүлэг орголт, намайг зөвтгөхийн тулд шүүгчид үзүүлэх арга бий. Би бүр орхигдсон гэдэг нь нотлогдох хүртэл диугарахаа ч больё, хөдлөхөө ч боъё. Харин тэгэхэд...” Гэж Андреа эргэцүүлэн бодож байлаа.

Андреад зальтай төлөвлөгөө хэдийнэ бэлхэн байсан юм. Зальхай амьтан аймшигтай дайрч, туйлбартай хамгаалж чаддаг юм.

Шоронгийн зовлон зүдүүр, янз бүрийн дутагдал гачаал түүнд танив юм чинь. Гэхдээ аажим аажмаар угийн заншил болсон зүйл нь дийлэв. Андреа нүцгэн шалдан, бохир, өлсгөлөнгөөс ядарч зүдэрч байв. Түүний тэвчээр нь барагджээ.

Харгалзагчийн дуу түүнийг хүлээх өрөөнд дуудахад, ааш аяг нь иймэрхүү байжээ.

Андреагийн зүрх баяртай цохиллов. Мөрдөн байцаагч дуудлаа гэхэд дэндүү эрт, шоронгийн дарга, эмч дуудлаа гэхэд дэндүү орой байв. Тэгэхээр энэ бол удаан хүлээсэн хүн нь ирж байгаа байх нь.

Андреаг оруулсан хүлээх өрөөний сараалжийн цаана, хаалганы цоож, төмөр торны цаана хөдлөх сүүдийг гунигтайгаар гайхан харж байсан Бертуччогийн ухаалаг ширүүн царайг Андера шунахайран гайхсанаас болж бүлтийсэн нүдээрээ олж харав.

- Хэн бэ? гэж Андреа айн дуугарахад Бертуччо цээжнийхээ тодхон дуугаар,

- Сайн байна уу? Бенеддетто? Гэж хэлэв.

- Та, та юу! гэж залуу хэлээд, айж тийш ийшээ харав.

- Золгүй амьтан чи намайг танихгүй байна уу? гэж Бертуччо асуув.

- Аяархан! Аяархан! Гэж ханын нимгэн сонор болохыг мэдэх Андреа хэлээд – Бурхан минь битгий ийм чанаг яриач! гэв.
- Чи надтай биеэр уулзаж яримаар байсан уу? гэж Бертуччо асуухад Андреа,
- Тийм, тийм гэж хэлэв.
- За тэгвэл болно гэж Бертуччо хэлээ хармаандаа юм эсрэнээ шилэн хаалганы цаана зогсож байсан манаач өөд дохив.
- Үүнийг унш! Гэж түүнийг хэлэхэд,
- Юу юм бэ? гэж Андреа асуув.
- Чамайг тусгай өрөөнд оруулах, мөн би чамтай уулзаж байх тушаал.

Андреа баярлан хашхирснаа, тэр дороо биеэ барьж өөр зуураа, “Бас л хачин жигтэй авран хамгаалагч!” Намайг мартаагүй байх нь! Надтай тусгай өрөөнд ярих гэж байгаа болохоор ямар нэг нууц хадгалагдаж байна. Тэр нь ч миний гарт даа... Бертуччо намайг авран хамгаалагч явуулжээ!” гэж бодов.

Манаач ахлагчтайгаа ярилцсаны дараа сараалжтай хаалгыг онгойлгож, хашаа руу цонх нь харсан хоёрдугаар давхрын тасалгаанд аваачихад Андреа тийм гэхийн аргагүй баярлаж байв.

Шоронгийн заншил ёсоор шохойдсон тасалгаа хөгжилтэй харагдах агаар хоригдолд нүд гялбам мэт санагджээ. Зуух, ор, сандал, ширээ энэ тасалгааны хамаг төхөөрөмж нь байв.

Бертуччо сандал дээр сууж, Андреа ор руу тэмүүлэв.
Манаач гарч явлаа.

- Чи надад юу хэлэх гээ вэ? гэж Монте-Кристо гүнгийн даамал асуухад Андреа,
- Харин та? Гэж өөдөөс нь асуув.
- Эхлээд чи ярь.
- Үгүй, та нэгэнт над дээр ирсэн болохоор та эхэлж ярь.
- За тийм болог. Чи гэмт хэргийн замаар үргэлж явж% хулгай хийж, хүн алжээ.
- Гагцхүү үүнийг хэлэх гэж намайг тусгай өрөөнд авчирсан бол ингэж хөдөлмөр зарцуулах хэрэггүй байсан юм. Би энэ бүхнийг мэднэ. Харин миний мэдэхгүй вухан хээхэн байна. Хэрэв та зөвшөөрвөл энэ тухай ярилцъя. Таныг хэн ирүүлэв?
- Эрхэм Бенедетто та дэндүү яарч байна.
- Тийм ээ, би шууд голыг нь олох гэсэн юм. хамгийн гол нь илүү дутуу үг хэрэг алга. Хэн таныг ирүүлээ вэ?
- Хэн ч ирүүлээгүй.
- Би шоронд байгааг та яаж мэдээ вэ?
- Елисейн Талаар хөнөг сүйх тэрэг тийм их чадмаг жолоодон явсан ичгүүр сонжуургүй гялалзсан хүнийг чамайг гэдгийг би аль хэдийнээ таньсан юм.
- Елисейн Тал дээр гэнэ ээ! Хүүхдийн тоглоомд ярьдгаар “халуун” хэрэг байна даа. Елисейн Тал дээр гэнэ ээ!... Тийм байж, тэгвэл миний аавын тухай ярих уу?
- Би юу юм бэ?

- Та юу, та бол намайг үрчилж авсан хүндэт эцэг... Би тавхан сарын дотор үрж орхисон зуун мянган франкийг та миний мэдэлд өгөөгүй байх гэж би бодож байна. Та намайг италийн язгууртай эцэг эхтэй болгож өгөөгүй байх. Та намайг дээдсийн хүрээлэнд оруулж, одоо ч гэсэн бодохоос шүлс гоожмоор тэр сайхан найранд уриагүй байх. Парисын шилдэг дээдсийн хүрээлэн, тэр ч бөйтугай вангийн прокурор хүрэлцэн ирсэн Отелийг санаж байна уу. Би вангийн прокурортой танилцаагүй нь харамсалтай, тэгсэн бол одоо маш хэрэгтэй байх санж. Балрах золгүй явдлын өмнөхөн хоёр саяыг өгнө гэж та батлан даагаагүй байх.... хэлээч, эрхэм кор хүн, та хэлээч!...
- Чи надаар юу хэлүүлэх гэсэн м бэ?
- Би чамд тусалъя. Чи саяхан Елисейн Талын тухай ярьсан шүү дээ, хүндэт өргөсөн эцэг минь.
- За, тэгээд яагаа вэ?
- Яагаад гэвэл Елисейн Талд нэг маш их баян эрхэмсэг суудаг шүү дээ.
- Байшинд нь чи, хулгай хийж хүн алсан уу?
- Тийм байх аа.
- Монте-Кристо гүн үү?
- Расины хэлсэн шиг чи өөрөө түүний нэрийг хэллээ. Тэгвэл би түүнийг тэврэн авч зүрхэндээ наалдуулаад Пиксерекур шиг “Эцэг минь! эцэг мин!” гэж дуу алдах ёстой юу?
- Чи битгий тоглоом хийгээд байгаарай_ Чиний зүрхэлж хэлсэн шиг энэ нэрийг энд бүү хэлэг гэж Бертучоо ширүүн хэлэв.
- Үгүй ер! Гэж Бертучогийн хүндэтгэсэн дууг сонсоод бага зэрэг бодлогоширсон Андреа хэлээд – Яагаад хэлж болдоггүй юм бэ? гэв.
- Яагаад гэвэл энэ нэрийг зүүсэн хүн тэнгэрт тэтгэгдэж явдаг учраас чам шиг зальхай амьтны эцэг болж болохгүй.
- Ямар аймшигтай ширүүн үг вэ?
- Чи болгоомжлохгүй бол аймшигтай хэрэг болно шүү...
- Өөр шигээ үл ялих юмнуудтай учирч гэж бодоогүй биз дээ гэж Бертучо, Андреаг дотроо давхитэл нь тайван итгэлтэй хэлээд – Ялт хөдөлмөрийнхөнтэй, эсвэл дээдсийн хүрээлэнгийн итгэмтгий гэнэн хонгоруудтай учирчихлаа гэж бодоогүй биз?.. Бенедетто чи одоо хүчирхэг гарт байна. Энэ гар чамайг суллан тавихыг зөвшөөр байгаа болохоор чи үүнийг ашигла. Эгшин зуурт намдсан цахилгаанаар бүү тоглоорой. Хэрэв түүний санаа бодолд саад хийх гэж оролдвол дахин шүүрэн авч чадна шүү гэв.
- Миний эцэг хэн юм бэ? ... Миний эцэг хэн болохыг мэдэхийг хүсэж байна.... гэж Андреа давтан шалгаагаад - Үхдэг байлаа ч мэднэн дээ. Будлиан надад юу болох юм бэ? Зөвхө ашиг хонжоо... нэр алдар... сэтгүүлч Бошаны ярьдаг шиг зар тараах явдал хэрэгтэй. „дээдсийн хүрээлэнгийн та нарт хэлийгээр сая сая хөрөнгө, сүлд тэмдэг байвч будлиан самуун аюултай... Тэгэхээр миний эцэг хэн бэ? гэв.
- Би түүний нэрийг чамд хэлэхэр ирсэн юм.
- Арай гэж нэг ингэдэг байжээ хэмээн Бенедетто дуу алдахад нүд нь баярлан гялалзаж байлаа.

Гэтэл хаалга онгойж хуяг орж ирээд Бертуччод хандаж,

- Уучлаарай эрхэм минь, хоригдлыг мөрдөн байцаагч хүлээж байна гэж хэлэв.
- Өнөөдөр сүүлчийн байцаалт болно. харамсалтай хэргээ! Гэж Андпреа даамалд хэлээд,
- Би маргааш ирнэ гэж Бертуччо хариулав.
- За сайн, эрхэм цагдаа нараа, бид та нарын мэдэлд ирлээ.... Надад хэрэгтэй бүхнийг өгүүлэхийн тулд арваад эки орхичихоорой эрхэм минь гэж Андреа хэллээ.
- Тэр ёсоор болно гэж Бертуччо хэлэхэд Андреа түүн өөд гараа сунгав. Тэгэхэд Бертуччо хармаанаасаа гараа гаргалгүй доторх зооснуудаа хангинуулан дуугаргав. Бертуччогийн хачин тайван байдалд бүр дарагдаж орхисон Андреа ёжтойхон инээмсэглэж,
- Тэгэх байх гэж бодож байсан юм гэж хэллээ.
“Би ташаарлаа гэж үү? Үзнэ дээ” гэж Андреа “шан-цайны сав” гэж нэрлэдэг төмөр сараалжтай том сүйх тэргэнд суух зуураа бодов. Тэгээд Бертуччод хандаж,
- Баяртай эрхэм ээ гэж хэлэхэд,
- Маргааш болтол гэж даамал хариулав.

11.ШҮҮГЧ

Лам узони, Нуартье хоёр валентинагийн тасалгаанд үлдэж, өвгөн лам хоёр үхсэн охины дэргэд хоёулхнаа унталгүй үлдсэнийг уншигч авгай лав санаж байгаа байх.

Ламын христосын сургаал ном, нэвтрэхий энэрэнгүй сСтгэл, үнэмшилтнй үг өвгөнд зориJ оруулсан байж болох л юм. Лам түүнтэй ярилцсаны дараа Нуартье гайхаш нь тасарч байснаа хязгааргүй номхон дөлгөөн болж тайвширсан нь өвгөн Ванлентинад гүн хайртай байсныг мэдэх хүмүүсийн гайхлыг багагүй төрүүлэв.

Охиноо үхсэн өдрөөс хойш Вильфор, өвгөнтэй уулзсангүй. Бүх гэр орныг шинэчилж вангийн прокурорт өөр зарц, Нуартьед бас өөр зарц хөлслөн авчээ. Хатагтай Вильфорт үйлчлэхээр хоёр өөр шивэгчин оржээ. Хаалгачаас эхлээд хөтөч хүртэл эргэн тойрон цөм шинэ хүмүүс болжээ. Тэд энэ нүгэлт байшингийн эздийн хооронд орж, тэртэй тэргүй тэдний хооронд байсан хүйтэн харьцааг бүр тасалж орхижээ. Тэгээд ч бас шүүх таслах ажиллагаа гурав хоноод эхлэх байсан учир Вильфор өрөөндөө орж түгжчихээд Кадруссыг алсан хүний эсрэг ял зэмлэлийг эцэлт цуцалтгүй бэлтгэж байлаа. Энэ хэрэг Монте-Кристо гүнтэй холбогдсон бусад бүх хэргийн адил Парист ихээхэн шуугиан дэгдээсэн бмилээ. Баримт нь барим тавим гэхэд хаашаа ч юм бэ. Хүнд хөдөлмөр хийх ял заагдсан хэрэгтний найз нөхөр агсан тэр хүн үзэн ядах сэтгэлээрээ эсвэл өшөө хорслоосоо болж бичиж амжсан хэдэн үг байлаа. Вангийн прокурорын зүрхэнд гагцхүү итгэл байлаа. Тэрээр Бенедетто буруутай гэж дотроо итгэж байсан бөгөөд энэ ялалт нь хөрс байсан сэтгэлийг нь сэргээж, биеэ өргөмжлөхийн баяр жаргалыг түүнд авчрах байлаа.

Энэ шүүх хурлаар болох гэж буй чуулганыг нээхийг хүссэн Вильфорын цуцашгүй чармайлтын ачаар мөрдөн байцаалт төгсгөлдөө оройтож байв. тэрээр хуралдаанд орох билет өгөхийг гуйсан олон тооны гуйлт гувшилтаас зайлсхийхийн тулд улам ч ганцаар байх хэрэгтэй байлаа.

Түүнээс гадна хөөрхий Валентинаг булшинд хийснээс хойш маш багахан хугацаа өнгөрч, гэр бүлд тохиолдсон уй гашуу шив шинэхэн хэвээр байсан учир уй гашуугаа мартаход нь тусажл байсан үүргээ гүйцэтгэх гэж чармайж байгаад нь хэн ч гайхсангүй.

Бертуччо Бенедеттод эцгийн нь нэрийг хэлэхээр ирсний маргааш буюу ням гаригт Вильфор, өвгөн Нуартъег ганц удаа зэрвэсхэн харжээ. Ажилдаа ядарсан Вильфор цэцэрлэгт гарч, үргэжл дагах хүнд бодолдоо дарагдан намуу цэцгийн хамгийн өндөр толгойг саваагаар шавхчин явдаг байсан Тарквинийн адил цэцэгт замаар явж, нарийн таягаараа зун цагт анхилам үнэр ханхлуулагч сайхан цэцгийн урт ишийг шавхруурдаж байлаа.

Уншигчдын сэтгэлд шингэсэн тэрхүү хоосрсон ногооны газрын дэргэдэх хаалга хүртэл цэцэрлэгийн захад хэдэн удаа хүрээд мөн тэр замаараа, тэр янзаараа алхлан буцаж явтал хүү нь зүггүйтэж шуугьж байсан байшингийн зүг түүний нүд аяндаа харлаа.

Тэгээд нээллтэй цонохн дээр Нуартъе байхыг харжээ. Нуартъе нарны сүүчлийн дулаан илчинд ээх гэж сандлаа энд авчруулсан байжээ. Шингэж бөйгаа нарны зөөлөн гэрэл үхэж байгаа цэцгүүд, тагтанд хүрэн алдан сагсайж байгаа зэрлэг усан үзмийн навсчыг гийгүүлнэ.

Өвгөний харц нэгэн зүгт ширтсэн бөгөөд чухам юу ширтсэнийг нь Вильфор олж харж чадсангүй. Энэ харц үзэн ядах хорслоор дүүрэн бөгөөд тэсэж ядсан байртай байв. Энэ царайны илрэл бүхнийг сайн мэддэг Вильфор сайхь ширүүн хару чухам юунд чиглэж байсныг олж харахын тулд хажуу тийшээ болов.

Тэгээд бараг нүцгэрсэн мөчиртэй далдуу модны доор гартаа ном бариад сууж байгаа хатагтай Вильфорыг харлаа. Хатагтай хүү өөдөө харж инээмсэглэн зочдын өрөөнөөс цэцэрлэг рүү шидээд болохгүй байгаа бөмбөгийг нь буцааж хаяхын тулд ном цуншихаа үе үе завсарлана.

Вильфор өвгөний юу хүсэж байгааг мэдээд царай нь зэвхийрлээ.

Гэтэл өвгөний харц гэнэт хүү дээрээ туслаа. Тэгэхэд Вильфор энэ гал дөл мэт харцны дайралтыг тэсвэрлэн өнгөрөөүүлэх хэрэгтэй болсон бөгөөд энэ харц өөр илүү аймшигтай зүйлийн тухай өгүүлжээ.

Хатагтай Вильфор өөр дээгүүрээ зөрөлдсөн харцыг олж мэдэлгүйгээр бөмбөр барьж аваад хүүгээ бөмбөгөө авахын хамт үнсүүлэхээр ирэхийг дуудлаа. Гэвч Эдуард эхийн нь хайр өөрийн нь хөдөлмөрт хангалттай шагнал биш гэж үзсэн бололтой удаан гуйлгав. Тэгээд шууд цонхоор үсэрч цэцгийн хүрээлэн дээр буугаад хатагтай Вильфор руу гүйж ирлээ. Хатагтай Вильфор духан дээр нь үнэсэхэд, нэг гартаа бөмбөг, нөгөөдөө атга чихэр барьсан жаал хүү буцаж ирэв.

Вильфор могойн харцанд татагдсан шувуу адил давагдашгүй хүчинд автан гэр рүү ээ явав. Түүнийг гэртээ ойртох тусам Нуартъегийн харц улам доошилж нүдний цөцгийн нь гал Вильфорыин зүрхийг төөнөх адил байв. Энэ харцанд хатуу ширүүн зэмлэл, хайр найргүй сүрдүүлэг байгааг олж харжээ. Тэгтэл Нуартъе мартсан ам тангаргийг нь хүүдээ сануулах мэт тэнгэр өөд харлаа.

- Мэдэж байна, эрхэм минь. Тэсэж байж үз. Одоо бас нэг өдөр тэсвэрлээрэй. Би амласнаа санаж байна гэж Вильфор хариулав.

Энэ үг Нуартъег тайвшруулсан бололтой өөр тийшээ харлаа. _

Вильфор хоолойгий нь боож байсан товчоо огцомхон хөдөлгөөнөөр тайлаад чичирсэн гараар духаа илээд тасалгаандаа буцаж орлоо.

Шөнө нь ердийн байдлаар өнгөрлөө. Гэр доторх хүмүүс цөм унтжээ. Ганцхан Вильфор л л хэвтсэнгүй, өглөөний таван цаг хүртэл ажиллаж, урьд өдөр нь байцаасан мөрдөн байцаагчийн байцаалтыг гэрчийн этгээдүүдийн мэдүүлэгтэй тулгаж, урьд нь хийж байснаасаа хамгийн үнэмшилтнй сайхан ялын төлөвлөгөөний нэг болох энэ ажлаа улам тодорхой болголоо.

Даваа гаригийн өглөө чуулшаны анхдугаар хуралдаан болох ёстой байв. Зэвгэр хүйтэн энэ өглөө үүр яаж цайсныг Вильфор харсан бөгөөд цэнхэрдүү туяанд нь улаан бэхээр бичсэн цасан дээрх мөрүүд ягааран байв. Вангийн прокурор хэдэн минут хэвтлээ. Дэнлүү нь асаж дуусаад тас ниясхийхэд Вильфор сэрж, хуруу нь чийгтэй, цусандбудагдсан адил улаан байхыг ааржээ.

Вильфор цонхоо онгойлгоод тэнгэрийн хаяанд бараантан харагдаж байсан тэгш шулуухан улиангар модыг дундуур нь хуваах адил урт улаан шар зурвас татсан байлаа. Хаалганы тэртээ талд орхиДсон ногооны газар дээгүүр болжмор шувуу өндөр нисэж, өглөбнийхөө дууг дуулж тодхон шулганана.

Вильфор өглөөний сэрүүн агаар амьсгалж, ухаан санаа нь сэргэжээ.

- Шүүх таслах өдөр боллоо. Өнөөдөр шударга үнэний шүүхийн илд гэмтэн буруутан бүхнийг ниргэнэ гэж хүч гарган хэлэв.

Урьд өдөр нь өвгөнийг харсан, Нуартъегийн цонхны зүг өөрийн эрхгүй харлаа. Цонхны хөшгийг нь буулгачихсан байв.

Хэдий тийм боловч, өвгөний дүр тодхон байсан учир тэрээр энэ цонх онгорхой, аймшигт өвгөн харж байгаа юм шиг харанхуй цонх руу харав.

- За, за, тайван байгаарай! Гэж Вильфцор шивгэнэв. Тэрээр толгойгоо гудайлгаж, тасалгаан дотуураа хэд хэдэн удаа явсны дараа хувцсаа тайлалгүй, унтахын тулд биш, харин бичгийн ширээний ард нойргүй хонож, ядарч, хөшсөн биеэ алжаахын тулд зөөлөн сандал дээр хэвтлээ.

Гэр доторх хүмүүс аажим аажмаар сэрлээ. Өлрийн амьдралын дуу болсон: хаалга хаах, шивэгчнээ дуудах хатагтай Вильфорын хонхны дуу, хүүхдэд байдагчлан хөгжилтэй, баяр хөөртэй сэрсэн Эдуардын дуу энэ бүхнийг Вильфор тасалгаанаасаа сонсож байв.

Вильфор ч бас хонходлоо. Шинэ хиа орж ирээд сонин өглөө.

Тэрээр сонингуудын хамт аяаг шоколад авчирч өглөө.

- Энэ юу вэ? гэж Вильфор асуухад хиа,
- Шоколад гэж хариулав.
- Би хүсээгүй юм сан. Хэн ингэж миний төлөө санаа тавиа вэ?
- Хатагтай Вильфор. Хатагтай таныг өнөөдөр яргачин Бенедеттогийн хэргийг сонсож их ярих учраас тамир тэнхээ орох хэрэгтэй гэж хэлж байна билээ.

Тэгээд хиа бусад ширээний адил бичиг цаас овоолсон зөөлөн сандлын дэргэдэх ширээн дээр алтадсан аяга тавиад гарч одлоо.

Вильфор аяга руу муухай харснаа тэр даруй огцом хөдөлгөөнөөр ухасхийн аваад нэг амьсгаагаар ууж орхилоо. Тэрээр энэ удааныг хордуулагч ундаан гэж бодод биелүүлэх нь үхэхээс хүнд байсан тэр үүргээсээ хагацахын тулд үхлийг дуудан

хүлээж байв. Дараа нь босож, тасалгаан дотуураа яваад, үзсэн хүн аймаар инээмсэглэв.

Шоколад хоргүй байжээ.

Өглөөний хоолын цаг болоход Вильфор ширээнд очиж суусангүй.

Хиа тасалгаанд дахин орж ирээд:

- Арван нэгэн цаг болж байна. хуралдаан арван хоёр цагт гэдгийг танд сануулахыг хатагтай даалгасан юм гэв.
- Тэгээд юу гээ вэ? гэж Вильфор хэллээ.
- Тэгээд хамт явах уу? гэж асууж байна?
- Хаашаа?
- Шүүхийн хуралд.
- Яах юм бэ?
- Таны гэргий энэ хуралд суух юмсан гэж их хүсэж байна гэж ярьж байна билээ.
- Аа, суух юмсан гэж хүсэж байгаа бий! Гэж Вильфор муухай дуугарч хэлэв. Тэгэхэд хиа алхам ухраад,
- Хэрэв таныг ганцаараа явах хүсэлтэй байгаа бол би тэгж хэлье л дээ гэв.

Вильфор цонхигор хацраа хумсаараа маажиж, дуугүй байлаа.

- Намайг ярих хүсэлтэй байна. Өрөөндөө хүлээж байна уу гэж хатагтай Вильфорт хэлээрэй гэж Вильфор эцэст нь хэлэв.
- Сонслоо, эрхэм минь.
- Дараа нь миний сахлыг хусахаар ирээрэй.
- Одоохон.

Хиа гарч явснаа буцаж ирээд, Вильфорын сахлыг хусаж, тас хар хувцааг өмсүүлэв.

Дараа нь,

- Хатагтай Вильфор таныг хүлээж байна гэж хэлсэн гэж айлтгав.
- Би очлоо.

Тэрээр үүдэнд нь зогсож, духныхаа хөлсийг арчаад, хаалга онгойлгов.

Хатагтай Вильфор өргөн зөөлөн сандал дээр суугаад Эдуардын эхийгээ ч уншуулалгүй хэсэг хэсэг болгоод хаячихсан сэтгүүл, товхимлуудыг тэсэж ядсан байдалтай эргүүлж байв.

Хатагтай гарахад бэлэн, бээлийгээ хийчхээд, малгай нь сандал дээр хэвтэж байв.

- Өө, та хүрээд ирэв үү? Гэж хатагтай ердийн тайван дуугаар хэлээд, - Бурхан минь, та яасан их цонхигор байх юм бэ! Та бас л бүхэл шөнийн турш ажиллаа юу? Та яагаад ирж бидэнтэй өглөөний зоог барьсангүй вэ? За яах вэ? та намайг дагуулж явах уу, аль эсвэл Эдуард бид хоёр явах уу? гэв.

Хатагтай Вильфор олон асуулт тавьсан боловч Вильфор түүний өмнө баримал хөшөө шиг хөдлөлгүй дуугүй зогсоно. Тэгээд эцэст нь хүүхэд өөд харж захирангүй дуугаар,

- Эдуард чи зочдын өрөөнд очиж тогло. Би эхтэй чинь ярих хэрэгтэй байна гэж хэлэв.

Эр нөхрийн нь биеэ барьсан хүйтэн байдал шийдмэг дуу хатагтайг айлгаж, оцчин давхийлээ.

Эдуард толгойгоо өөд өргөж эх өөдөө хараад, эх нь Вильфорын тушаалыг бататган давтаагүй учир тугалган цэрэг тоглоомынхоо толгойг зорж байв.

- Эдуард гэж Вильфор жаал хүүг давхийн бостол нь хашхираад - Чи дуулж байна уу? Яв! Гэв.

Өөртэй нь иймэрхүү харилцахад дасаагүй хүүхэд царай нь зэвхийрсэн нь чухамхүү хорссоноос буюу айснаас алин болохыг хэлэхэд хэцүү байв.

Эцэг нь түүн рүү очиж, тохойноос нь бариад духан дээр нь үнэсэв.

- Яв, хүү минь, яв! гэлээ.

Эдуард гарч одлоо.

Вильфор үүд рүү очоод түгжчихэв. Тэгэхэд хатагтай Вильфор нөхрийнхөө санаа бодлыг тааварлахыг хичээж,

- Бурхан минь, бурхан минь, юу болчхов? Гэж асуугаад уруул дээр нь инээмсэглэл гэмээр юм гарч ирснээ Вильфорын хүйтэн харц доор тэр даруй хөшиж зогслоо.

- Хатагтай та хэрэглэдэг хороо хаана хадгалдаг вэ? гэж прокурор ямар ч урьдчилсан үггүйгээр тодхон хэллээ.

Хатагтай Вильфор харцаганд хөөгдсөн болмжор шиг бүх бие нь чичрэн дагжиж байлаа.

Царай нь хөхөртлөө цонхийсон хатагтай Вильфорын цээжнээс хашхирах ч биш санаа алдах ч биш хачин сөөнгө дуу гарна.

- Би... би таны хэлж байгааг ойлгохгүй байна гэж хатагтай аяархан хэлээд босох гэсэн боловч тамир нь барагдаж, зөөлөн сандал дээрээ дахин уналаа.

- Та миний хадам де Сен-Меран бээс, хадам эх ба Барруа болон миний охин Валентинаг хорлож алсан хороо хаана нцуудаг вэ гэж би танаас асууц байна шүү гэж Вильфор тайван дуугаар үргэлжлэн ярив.

- Эрхэм та юу ярьж байна вэ? гэж хатагтай Вильфор гараа базлан дуу алдав.

- Таны хэрэг бол асуух биш, хариулах явдал шүү.

- Эр нөхөртөө юу, шүүгчид үү? Гэж хатагтай Вильфор асуулаа.

- Хатагтай минь, шүүгчид хариулаарай!

Үхтлээ цонхийж, чичрэн дагжиж, гайхаш нь тасарсан энэ хүүхнийг харахад ха-ин байлаа.

- Ай, эрхэм минь.... гэж авхай шивгэнэв. Өөр үр дуугарсангүй.

- Хатагтай т надад хариулахгүй байна аа! гэж аймшигт илрүүлэгч дуу алдаад, дараа нь хорсол заналаасаа улам ч илүү аймшигтайгаар инээмсэглэж,

- Та мэлзэхгүй юм байгаа биз дээ? гэв.

Тэгэхэд хатагтай хөдөллөө.

- Тийм ээ, тө өөрийн гэм бурууг үгүйсгэж чадахгүй гэж Вильфор түүн рүү гар сарвайж хэлээд, - Та энэ бүх гэмт хэргийг жишээлгүй хар санаагаар хийсэн шүү дээ. Тэгэхдээ та зөвхөн өөртөө талтай хүмүүсийг мэхэлж чадсан билээ. Сен-Меран бээлийхнийг үхсэнээс эхлээд гэрт маань хорлогч

байна гэж мэдсэн юм. Авринь энэ тухай надад урьдчилан сануулсан юм. Барраугийн үхсэний дараа ээ бурхан минь, миний сэжиг тэнгэрлэг охинд туссан билээ! Тодохой гэмт хэрэг хийгдээгүй байхад ч сэжиг таавар надад төрдөг юм. Харин Валентинаг үхсэний дараа надад эргэлзэх юмгүй болсон юм. Зөвхөн би ч биш, бусад хүн эргэлзэхгүй болсон доо. Хоёр хшнд тодорхой мэдэгдэж байгаа олонд сэжиг төрүүлж бөйгаа таны гэмт хэрэг илэрхий болно доо. Би танд түрүүнд хэлсэнчлэн хатагтай минь, тантай эрх нөхөр чинь биш шүүгч ярьж байна! гэв.

Хатагтай Вильфор хоёр гараараа нүүрээ дараад,

- Гадна талын шинж тэмдэгт бүүитгээч, би таныг гуйя гэж шивгэнэлээ.
- Та имй хулчгар амьтан гэж үү? Гэж Вильфор жигшин дуу алдаад – Нээрээ ч хорлогчид хулчгар амьтан байдгийг би үргэлж ажиглаж байсан юм. Танд хорлогсдон хоёр өвгөн, гэмгүй охин гурав яаж үхэж байсныг та харах зоригтой байсан биш билүү! гэв.
- Эрхэм минь!
- Та үнэхээр тийм хулчгар амьтан гэж үү? Гэж Вильфор цлам шатаж хэлээд – Та чинь дөрвөн улаагийн амь тэмцэн үхэж байсан минутыг тоолон бузар санаа бодлоо хэрэгжүүлэн биелүүлж, бузар хэргээ маш итгэлтэй, гайхам уран бэлтгэж байсан биз дээ! Та бүх зүйлийг нарийвчлан тооцоолсон боловч таны ялт хэрэг илэрвэл юу болох тухай яагаад мартчихдаг билээ? Тийм байх ёсгүй. Та зохих цээрлэлээс зайлсхийхийн тулд хамгийн амттай, хамгийн түргэн, хамгийн найда\вартай хороо хадгалсан байх ёстой. Та ингэсэн биз дээ... гэв.

Хатагтай Вильфор гараа базлаад сөхрөн уналаа.

- Би таны хэргээ хүлээж байгааг чинь харж байна. гэвч шүүгчид хэргээ хүлээх, мэлзэх аргагүй болсон хойноо хэргээ хүлээх нь цээрлэлийг ямар ч хэмжээгээр хөнгөрүүлж чаддаггүй юм гэж Вильфор хэлэхэд хатагтай Вильфор дуу алдаад,
- Цээрлэл гэнэ ээ! Энэ үгийг хоёр дахь удаагаа хэллээ гэв.
- Мэдээж хэрэг. Тө дарван удаа ялт хэрэг үйлдчихээд түүнээсээ зайлсхийнэ гэж бодож байгаа юм биш биз? Энэ цээрлэлийг шаардах хүний эхнэр учраас ял өнгөрнө гэж бодоогүй биз? Үгүй шүү, хатагтай минь! Хорлогч хүн хэнч байлаа гэсэн түүнийг цаазын индэр хүлээж байдаг юм. Хэрэв хорлогч өөртөө хэдэн дусал найдвартай хор үлдээх гэж санаа тавиагүй бол тэгэхэд хүрдэг юм.

Хатагтай Вильфор муухайгаар хашхиран бүхнийг залгигч аймшиг, түүний царайн хэлбэрийг гаж болгов.

- Бүү ай, таныг цаазын индэрт гарахыг би шаардаагүй байна. Би таныг гутамшиг болгохыг хүсэхгүй. Энэ бол миний гутамшиг боло. Тэгэхээр та цаазын индэр дээр үхэхгүй байж болох юм байна гэдгийг миний хэлсэн үгнээс ойлгох ёстой.
- Үгүй, би ойлгосонгүй.Та юу хэлэх гээд байгаа юм бэ? гэж золгүй хүүхэн дөнгөж дуулдах төдий асуув.

- Вангийн прокурорын эхнэр өөрийн булай явдлаар эр нөхөр ба хүүгийнхээ хиргүй тунгалаг нэрэнд толбо суулгаж, бузархдахыг хүсэхгүй байх гэж хэлэхийг хүсэж байна.
- Өө, үгүй, үгүй!
- Та үүгээрээ сайн үйл үйлдэж байна. Би танд талархаж байна.
- Талархах ий? юуны төлөө тэр вэ?
- Таны саяын хэлсэн үгний төлөө.
- Би юу гэж хэлчихлээ? Би мэдэхгүй байна. Санахгүй байна. Бурхам минь! гэж хэлээд хатагтай, аймаар үс нь сэгчийн, уруул дээрээ хөөс сахруулан ухасхийн босов.
- Би наашаа орж ирэхдээ танаас асуусан асуултад хариуллаа. Таны хэрэглэдэг хор чинь хаана хадгалаатай байдаг юм бэ?

Хатагтай Вильфор татваганан гараа улам чанга атгав.

Тэгээд,

- Үгүй, үгүй. Та үүнийг хүсээгүй! гэх дуу цээжнээс нь гоншигнон гарав.
- Хатагтай минь, би таныг ганцхан цаазын индэр дээр үхэхгүй байгаасай гэдэг ганцхан зүйлийг хүсэж байна гэж Вильфор харицулав.
- Өршөөж хайрлаач!
- Үнэн шударга ёсны шүүх хэрэгжин биелэхийг би хүсэж байна. Найд минь, газар дэлхий дээрх миний үүрэг бол цээрлүүлэх явдал мөн гэж нүд нь гялалзан нэмж хэлээд - Өөр бусад хүүхэн, тэр ч байтугай хатан ха нч байлаа гэсэн би түүнд алуурчныг явуулна. Харин би танд энэнрэнгүй сэтгэлтэй Үайна. Хатагтай та хамгийн эевэрлүү амтлаг, хамгийн түргэн найдвартай хэдэн дусал хор хадгалсан уу гэж би асууж байна?
- Энэрэн хайрлаж, амийг минь үлдээгээч!
- Энэ авхай тун ч сэтгэлгүй хүн байсан даа! гэж Вильфор хэлэв.
- Бодооч, санаач, би таны эхнэр чинь шүү дээ!
- Та хорлогч!
- Тэнгэрийг бодож!...
- Үгүй!
- Урьд өмнө надад дурлаж байсныгаа бодооч!
- Үгүй, үгүй.
- Хүүхдээ бодооч дээ! Хүүхдийг минь бодож амийг минь үлдээгээч.
- Үгүй, үгүй, үгүй. Хэрэв би тангы амьд үлдээвэл, та хэзээ нэгэн цагт түүнийг алж мэднэ.
- Би юу? Би өөрийнхөө хүүхдийг ална гэж үү? Гэж энэхүү тэнэг эх хашхираад, Вильфор өөд ухасхийж – Эдуардыгаа ална гэнэ ээ! Ха-ха-ха! гэж дуугарав.

Тэгээд шуламсын зэрлэг инээд, галзуурсан хүний инээд тасалгаа дүүрснээ даруй тасалдан сөөнгө гинших дуу боллоо.

Хатагтай Вильфор сөхрөн уналаа.

Вильфор түүнд ойртож очоод,

- Хатагтай минь, намайг буцаж ирэхэд үнэн шуларгын шүүх хэрэгжээгүй байвал би өөрөө таныг илчилж баривчлах болно гэдгийг санаж байгаарай гэж хэлэв.

Ниргэгдэж, устгагдсан хүүхэн амьсгаадан сонсож байгааг нь харахад энэ нүүр дээр гагцхүү нүд нь л амьд байгаа юм шиг байлаа.

- Та ойлгов уу? Би яргачинд алах ял заахыг шаардахыг тулд шүүхийн танхим руу явлаа.... Хэрэв намайг ирэхэд та амьд байвал энэ шөнийг Консьержерид өнгөрүүлэх болно гэж Вильфор хэлэхэд хат гтай Вильфор гүнээ санаа алдаад тамир нь барагдаж хивсэн дээр унав.

Тэгэхэд вангийн прокурорт өрөвдөх сэтгэл төрөв үү гэлтэй, харц нь зөөлөрч, толгойгоо бага зэрэг тонгойлгоод алгуухнаар,

- Үүрд баяртай, хатагтай минь! гэв.

Энэ үг цаазын илд шиг хатагтай Вильфорыг ниргэжээ.

Хүүхэн ухаан алдлаа.

Вангийн прокурор гарч, хаалгаа хаагаад түлхүүрийг нь хоёр эргүүлж цоожлов.

12.ЧУУЛГАН

Хуулийнханы дунд, дээдсийн хүрээлэнд Бенедеттоогийн хэрэг гэж нэрлэгдсэн энэ хэрэг асар их шуугиан дэгдээжээ. Кафе-де-Пари, Гентийн цэцэрлэг, Булоны ойгоор байнга эргэлдэгч хуурамч кавальканти Парист суусан хочр, гурван сарын дотор олон танилтай болжээ

Сонинууд түүний Парисын амьдралын тухай, ялт хөдөлмөрт байсан тухай багагүй тодорхой зүйлийг бичжээ. Энэ бүхэн нь олны сонирхол, ялангуяа ноён Андреа Кавалькантийг биечлэн таньдаг байсан хүмүүсийн сонирхлыг хөдөлгөжээ. Тэд цөм хамт ял эдэлж байсан нөхрөө алсан алуурч Бенедеттог хэрэгтний ширээнд сууж байгааг гагцхүү харахын тулд яахаас ч буцахгүйгээр байв.

Бенедетто үнэн шударгын шүүхийн олз болоогүй ч гэсэн, шүүхийн алдааны олз болж байна гэж олон хүн бодож байв. Ноён эцэг Кавалькантийг Парист мэддэг байсан учир түүнийг хүрч ирээд хүүгээ авран хамгаална гэж зарим нь итгэж байв. Монте-Кристотой уулзахдаа өмсөж ирсэн өнөө улигт мажар хувцасны тухай хэзээ ч сонсоогүй хүмүүст түүний ихэмсэг гадаад байдал, дайнч эрийн шинж, хуучин цагийн дээдсийн хүрээлэнгийн зан харилцаа багагүй сэтгэгээл төрүүлсэн юм Ямагт дуугүй ба©ж, тоо бодлогод ороогүй цагтаа үнэхээр ямбатан ихсийн дүртэй байсныг үэнэ хэрэг дээрээ хүлээх хэрэгтэй.

Хэрэгтний өөрийн нь тухай гэвэл, түүний эелдэг зөөлөн, гоо сайхан, өгөөмөр байсныг олон хүн санаж байгаа бөгөөд энэ тохиолдсон явдлыг дайсны ямар нэг хорт явуулга гэж үзэхийг урьдал болгож байв. Эд баялаг сайн, мууг бүтээх эрхийг олгож, хүмүүсийг үзэгдэж дуулдаагүйгээр хүчирхэг болгодог ертөнцөд хааяа ийм явдал тохиолддог юм.

Ийм учраас хүн бүхэн шүүхийн хуралдаанд орох сон гэж байв. Зарим нь үзэж сонирхож зугаацах, зарим нь энэ тухай хэлэлцэн ярилцахын тулд орохыг хичээж байв. Өглөөний долоон цагаас эхлээд үүдэнд нь хүмүүс бөөгнөрч, хуралдаан эхлэхээс нэг цагийн өмнө тусгалйан шилэгдсэн хүмүүс шүүхийн танхим дүүрсэн байв. Томоохон цуутай хэрэг таслах үед, шүүгч нарыг гарч ирэхээс өмнө тэр ч байтугай гарч ирсний нь дараа ч шүүхийн танхим нь танил нөхөд уулзсан зочдын тал өрөөг санагдуулах бөгөөд суудлаа алдчихаас айхгүй бол бие бие дээрээ очиж, хэрэв хэтэрхий олон хүн, өмгөөлөгч, цагдаар нар саад болоод байвал харилцан дохилцоно.

Бороо хуртай, дэндүү богинохон зуны дараа хүртээсэн хайр хишиг мэт нарын гайхамшигт сайхан өдрүүд болж байлаа. Өглөө нь нарыг халхалж байсан, хар үүл, илбэдүүлсэн мэт замхарч дулаан илч есдүгээр сарын хамгийн сүүлчийн тунгалаг сайхан өдрүүдийн нэгийг гийжүүлж байв.

Хаана ч гэсэн суудал бэлхэн байдаг хэвлэлийн хаан Бошан цугларсан олныг дурандаж суув. Тэрээр, дөнгөж сая цагдааг өмнөө халхлахын оронд ар талдаа зогсохыг итгүүлж чадсан Шато-Рено Дебрэ хоёрыг олж харав. Журам сахиулагч хүндтэй хүн, өөрийн авхаалжаар сайдын нарийн бичгийн дарга, сая хөрөнгөтөн байгааг тааварлан мэджээ. Тэрээр ямбатан хөршүүддээ анхаарал тавьж, тэр ч байтугай Бошан дээр очиж дэмий ярьж хөөрөхийг нь зөвшөөрч байрыг нь хамгаалж байхаар амлажээ.

- Та хоёр бас найзтайгаа уулзах гэж ирээ юу? гэж Бошан хэлэхэд,
- Тэгэлгүй яах вэ! Манай хонгор найз! Чөтгөр ав, итлаинь ноёд чинь ямар хачин улс вэ! гэж Дебрэ хариулав.
- Данте өөрөө гэрийн бичгийг нь эрхэлж, ураг төрөл нь “Тэнгэрдэг туулиас” гарч ирсэн хүн дээ!
- Дүүжлүүрийн язгууртнууд гэж Шато-Рено удаанаар сунжруулан хэлэв.
- Та түүнийг шийтгэгдэнэ гэж бодож байна уу? гэж Дебрэ Бошанаас асуув.
- Харин би танаас асуумаар байна. Шүүх ямаршуу зан байдалтай байгааг та л сайн мэднэ дээ. Сайд хүлээж авсан сүүлчийн уулзалт дээр та даргатай нь уулзсан уу? гэж сэтгүүлч асув.
- Уулзсан.
- Тэр танд юу гэж хэлэв?
- Та гайхах болно.
- Тэгвэл бушуухан хэлээрэй. Би гайхаж үзэлгүй удаж байна.
- Самбаа залийн гайхамшиг, хар санааны аварга гэж үзэж байсан Бенедетто бол ердөө л өчүүхэн хулгайч, ялихгүй амьтан, үхсэний дараа нь тархийг нь судлах огт хэрэгцээгүй хүн гэж надад хэлсэн шүү.
- Гэвч тэр ноёны дүр нэлээд чадмаJ тоглосон шүү дээ гэж Бошан хэлэв.
- Бошан танд л тийм харагдаж байж: Яагаад гэвэ» та өөрхий ноёдыг үзэн яддаг бөгөөд тэднийг аль нэг муу юм гаргахад дандаа баярладаг шүү дээ. Харин намайг хуурч чадахгүй. Би сүлд тэмдгийг мөрдөн эрэгч шиг ёстой язгууртныг холоос мэдэрнэ.
- Тэгвэл та түүний ноён хэргэмд хэзээ ч итгэж байгаагүй юу?
- Түүний ноён хэргэмд үү? Итгэж байсан.... Харин тайж шинж байдалд нь хэзээ ч үгүй шүү.
- Муугүй хэллээ. Гэвч танас өөр хүнд тэр яг л ноён байж чадсан.... Би сайдуудын зочдын өрөөнд дайралдаж л байсан юм.
- Танай сайд нар чинь ноёны талаар их ойлгодог байх даа! гэж Шато-Рено хэллээ.
- Товчхон, оновчтой байна гэж хэлээд Бошан инээд алдаж, - Үүнийг миний тооцоонд үлдээхийг зөвшөөрнө үү? Гэлээ.
- Эрхэм Бошан та найр тавь л даа. Би өөрийн бодлыг зорхих үнээр нь танд тавьж өгье гэж Шато-Рено хариулав.

- Би хурлын даргатай ярьсан байхад та вангийн прокурортой ярилцсан байх ёстой гэж Дебрэ Бошанд хэлэв.
- Тэгэх бололцоогүй байсан юм. Вильфор хүмүүсээс нуугаад долоо хонож байна. Охины нь үхлээр төгсгөл болсон тэр гэр бүлийн хачин үхлийн дараа тэгэх нь ч ойлгомжтой хэрэг...
- Хачин үхэл ий? Бошан та юу гэж хэлэх гээд байна?
- Та үүнийг шүүхийн язгууртнуудад хамаатай юм гэж байгаа юм байлгүй гэж Бошан өрөөсөн нүдний шилээ нүдэндээ хавчин хэвээр нь тогтоож байхыг хичээн хэлэв.
- Эрхэм минь, та ганц нүдний шил зүүх урлагаараа Дебрэгээс мөн ч хол байна гэдгийг хэлэхийг зөвшөөрнө үү. Алив, Дебрэ яаж зүүдгийг Бошанд харуулаад өгөөч гэж Шато-Рено хэлэв.
- Тиймээ, мэдээж хэрэг, би андуураагүй байна гэж Бошан хариулав.
- Аа, юу тэр вэ?
- Тэр хүүхэн мөн байна.
- Ямар хүүхэн?
- Яагаа вэ яваад өгсөн гэж яриад байсан хүүхэн.
- Мадмуазель Эжени үү? Буцаад ирсэн юм гэж үү? Гэж Шато-Рено асуув.
- Үгүй тэр биш, эх нь
- Хатагтай Данглар уу?
- Үгүй, байлгүй. Охиныгоо оргож явсны арав хоног дээр, нөхрийгөө дампуурсны гурав хоног дахь хоног дээр нь ингэж явах гэж үү! Хэмээн Шато-Рено хэлэв.
- Дебрэгийн царай бага зэрэг улайж Бошаны харж байсан зүг хараад, -За биш л байна. Тэр шигүү гивлүүртэй авгай гадаадын ихэс дээдсийн хүүхэн ч юм уу эсвэл Кавальканти ноёны ээж байлгүй. Харин Бошан та сонин юм ярих гэсэн байх аа гэж хэл.в
- Би юу?
- Тийм ээ. Валентинагийн хачин үхлийн тухай ярьсан шүү дээ.
- Өө, тийм. Харин хатагтай Вильфор яагаад харагдахгүй байна вэ?
- Хөөрхий амьтан! Эмнэлэгт эм бэлтгэж байгаа эсвэл өөртөө ч юм уу найз хүүхнүүддээ уруулын будаг хийж байгаа байх. Тэр хүүхэн энэ зугаалцалд жилд гурван мянган эки зарцуулдаг юм гэнэ билээ. Нээрэн яагаад харагдахгүй байна вэ? Би түүнийг харж дуртайяа нүд хужирлах сан. Тэр надад их аятайхан санагддаг гэж Дебрэ хэлэв.
- Өө, би бол түүнийг тэсвэрлэж чаддаггүй юм гэж Шато-Рено хэлэв.
- Яагаад тэр вэ?
- Мэдэхгүй. Бид яагаад дурлаж, яагаад үзэн яддаг юм бэ? Тэр хүн надад эвгүй хар гддаг учраас түүнд дургүй байдаг юм.
- Аль эсвэл зүгээр л зөнгөөрөө тэгдэг юм бол@в уу?
- Магадгүй.... Харин таны ярианд буцаж оръё. Бошан,
- Эрхмүүд ээ та нар Вильфор»нхон ингэж элбэг арвин үхээд байгааг бодож үзээгүй гэж үү? Гэж Бошан үргэлжлэн асуухад Шато-Рено:
- Элбэг арвин гэнэ ээ? Энэ чинь муугүй хэлсэн үг байна шүү гэв.
- Сен-Симонд ингэж хэлсэн үг байдаг юм.

- Баримт нь Вильфорт байна. Тэгэхээр Вильфорын тухай ярилцъя.
- Би энэ айлыг үнэхээр их сонирхож байна. Тэднийх одоо гурван сар гашуудал эмгэнэлээс салахгүй бөйна. Уржигдар хатагтай “өөрөө” Валентинагийн үхэлтэй холбогдуулж надтай ярьсан гэж Дебрэ хэлэхэд,
- “Өөрөө” гэж хэн бэ? гэж Шато-Рено асуув.
- Мэдээж хэрэг, сайдын эхнэр.
- Уучлаарай, би сайдынд очдоггүй. Ноёдуудыг л очиг гэж тэгдэг юм гэж Шато-Рено хэлэв.
- Та түрүүн оч үсэргэж байсан бол одоо гал цахилагаан буулгаж эхэллээ. Биднийг өрөвдөөч, тэгэхгүй бол шинэ төрсөн Тэнгэрийн ван шиг биднийг үнс болгочхож мэднэ шүү.
- Дуугүй байя. Харин та нар намайг өрөвдөж бүү тохуурхаарай гэж хүсье хэмээн Шато-Рено хэлэв.
- Бошан, өөр тийшээ займчуулж гүйцсэн юм биш үү. Тэр “өөрөө” тайлбарлаж өгөхийг надаас гуйсан юм гэж би аль түрүүн хэлсэн билээ. та энэ тухай мэдэж байгаа юмаа хэлж өгөөч, би хатагтайд дамжуулан хэлье.

Тэгэхээр эрхмүүд ээ, айлд хүн элбэг арвин үхээд байвал тэнд алуурчин байна гэсэн үг. Элбэг арвин гэж нэрлэж байгаа нь надад их л тааламжтай санагдаж байна гэж Бошан яриу.

Сонсож суугаа хүмүүсийн толгойд ийм санаа орж ирдэг байсан учир цөм цочих шиг боллоо.

- Тэгвэл тэр алуурчин нь хэн байх вэ? гэж тэд асуув.
- Бяцхан Эдуард.

Шато-Рено, Дебрэ хоёр инээд алдахад Бошан огтхон ч зовсон шинжгүйгээр цааш үргэлжлүүлэн,

- Тийм ээ эрхмүүд ээ, бяцхан Эдуард бол лут том хүүхэд, том хүнээс дооргүй лаж байна гэв.
- Энэ чинь хошигнол уу?
- Огт үгүй, би өчигдөр Вильфорныхоос явсан нэг зарцыг хөлслөн авсан юм. Та нар үүнийг анхаараарай.
- Анхаарлаа.
- Тэр тэнд байсныхаа горыг гаргах гэж хэмжээ хязгааргүй их иддэг учраас би маргааш түүнийг халж явуулна. Тэр хүүхэд нэгэн бодистой шил сав олжээ. Тэгээд л дургүйгээ хүрсэн хүнд түүнээсээ өгчихдөг байжээ. Эхлээд эмгэн өвгөн хоёр Сен-Меран дургүйгий нь хүргэсэн учир өнөөх бодисоороо гурав гурван дуслыг өгчихжээ. Гурван дусал л хангалттай гэнэ. Дараа нь хонгор жаахан, төрхгүй хүүхдийг хааяа нэг зангачихдаг байсан өвгөн Нуартъегийн зарц үнэнч сайн Барруа өртжээ. Хонгор жаахан хүүхэд түүнд өнөөхөөсөө гурван дуслыг өгчихжээ. Дараа нь загнадаггүй боловч жаал хүүхэд өөрөө атаархдаг байсан золгүй Валентинад бас тэр явдал тохиолджээ. Бас гурван дуслыг өгчихсөн чинь Валентина бусдын адил эцэс болсон байна.
- Үлгэр ярихаа боль доо гэж Шато-Рено хэлэхэд Бошан, Аймшигтай үлгэр байнаа биз гэлээ.
- Тэнэг хэрэг гэж Дебрэ хэлэхэд Бошан зөрж,

- Та нар үнэн юмыг олж харахаасаа айж байна. Тэгвэл миний зарц чухамдаа маргааш миний зарц байхаа болих гэж бөйгаа тэр хүнээс асуугаач. Энэ тухай бүх л гэрээрээ ярьса гэнэ билээ.
- Үгүй тэр чинь ямар гээч бодис вэ? 'эр нь хаана байдаг юм бэ?
- Хүүхэд тэрнийгээ нуугаад байгаа юм гэнэ.
- Хаанаас авсан юм бол?
- Тэгвэл түүний ээж нь лабораторитоо хор авч байдаг мю уу? Би яаж мэдэх вэ, Та намайг вангийн прокурор шиг байжаау байх шив. Зөвхөн надад ярьсан юмыг л давтан хэлж байна. Би дуулсан эх булгаа танд хэллээ шүү дээ. Илүү их юм хийж чадахгүй. Хөөрхий тэр зарц айгаад юу ч идэж чадахгүй байжээ.
- Энэ ч үнэмшмээргүй зүйл байна.
- Үгүй дээ найз минь энүүнд чинь үнэмшмээргүй юм юу ч алга. Өнгөрсөн жил Ришелье гудамжны нэг хүүхэд эгч ах нарыгаа унтаж байхад чихэнд нь зүү шааж зугаацаж байсныг санаж байгаа биз? Одоо цагийн хүүхэд гэдэг чинь наснаасаа илүү хөгжчихсөн байдаг болжээ.
- Та өөрөө өөрийгөө хэлж байгаа нэг ч үгэнд итгэхгүй байгаа гэж мөрийцөх үү гэж Шато-Рено хэлснээ – Монте-Кристо гүн харагдахгүй байна. Тэр энд ирээгүй юм байх даа? гэлээ.
- Тэр чинь цатгалдсан хүн. Энд үзэгдэх нь түүнд эдгүй санагдах байлгүй. Хоёр Кавальканти түүнийг дөнгөчихсөн юм чинь. Тэд түүн дээр хуурамч зээллэгийн билеттэй ирж ноён хэргэмнийхээ хүчээр зуугаад мянган франкийг нь алдуулчихсан гэж ярилцаж байна билээ.
- Ингэхэд Моррель ямар байгаа вэ? гэж Бошан Шато-Реногоос асуув.
- Би тэднийд гурван удаа орсон. Түүний тухай сураг чимээ байхгүй байсан. Гэвч дүү нь түүний төлөө сэтгэл зовохгүй байгаа бололтой, бас л гурав хоног түүнтэй уулзаагүй гэсэн ч тэрүүнд ямар ч юм тохиолдоогүй гэж итгэж байна гэж хэлж байна билээ гэж Шато-Рено хэллээ.
- Өө, тийм Монте-Кристо гүн энд ирж чадахгүй гэж Бошан хэлэв.
- Яагаад тэр вэ?
- Яагаад гэвэл тэр өөрөө энэ явдалд оролцож байгаа юм.
- Тэр бас хүн алчихсан хэрэг үү? Гэж Дебрэ асуулаа.
- Үгүй, харин түүнийг алах гэсэн байна билээ. Тэр хүндэт Кадрусс яг Монте-Кристовгийнхоос гарч яваад найз нөхөртөө алагдсан юм билээ. Тэгээд гүнгийн ргэрээс өнөөх хармаандаа зурвастай нүгэлт хантааз олдож гэрлэлтийн гэрээнд гарын үсэг зурагдаагүй өнгөрсөн шүү дээ. та нар тэр ханзтааыг харав уу? Тэр ширээн дээр нэл цус болчихсно хэвтэж байгаа. Эд мөрийн баримт.
- Харж байна, харж байна!
- Чшш, эрхмүүд ээ, эхэллээ. Байр байрандаа!

Танхим доторх хүмүүс их л чимээтэйгээр хөдөлцгөөлөө. Цагдаа хоолойгоо огцом засаж өөрийн өмгөөлөөд байгаа хүмүүсийг дуудахад, хаалгаар орж ирсэн шүүхийн түшмэл Бомаршегийн үеэс эхлэн хэрэглэх болсон хахир дуугаар “Шүүх орж ирлээ!” гэж мэдэгдэв.

13.ЯЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нам гүм байдлын дунд шүүгчид сулаа. Иргэний төлөөлөгчид байраа эзлэв. Олны анхаарал, тэр ч байтугай олны бахарлыг төрүүлсэн гэж хэлмээр Вильфор танхим өөд тайван хараад сандал дээрээ суулаа.

Эцгийн уй гашуу огтхон ч илрэн гарахгүй байгаа түүний ширүүн хайрамжгүй царайг хүмүүс гайхан харж байв. Хүний ёсны мэдрэхүй сэтгэл гэдгийг мээдэггүй энэ хүнийг харахад бараг айдас хүргэнэ.

- Хэрэгтнийг оруул гэж дарга хэлэв.

Хүмүүс энэ үгийг сонсоод Бенедеттог оруулж ирэх хаалга өөд харцгаав.

Удалгүй хаалга нээгдэж хэрэгтэн орж ирэв.

Хэрэгтэн хүн бүхэнд нэг янзын сэтгэгдэл төрүүлсэн бөгөөд хэн ч түүний царайны байдалд хууртсангүй.

Сэтгэл нь гүнээ донсолж зүрхэнд нь цус хуран царай нь зэвхийрсэн шинж тэмдэг байхгүй байв. Нэг гараа бүрх малгай дээрээ тавьж, нөгөөг нь цагаан хантаазныхаа хармаа руу шургуулж, айн чичрэхгүй явна. Нүд нь тайван, тэр ч байтугай гялалзаж байв. Дөнгөж хаалгаар орж ирмэгцээ танхим дотор сууж байгаа хүмүүс, шүүгч нар, шүүхийн дарга өөд харснаа ялангуяа вангийн прокурорыг илүү удаан харлаа.

Андреатай хамт түүний өмгөөлөгч болох \Андреа огт ач холбогдолгүй гэж үзсэн учир ийм аар саар юмаар оролдохыг хүсээгүй ажээ\ яллагдах гэж байгаа хүнээсээ зуу дахин илүү сандарч тэвдсэн нүүр нь улайсан шар царайтай залуу суув.

Шүүхийн дарга Вильфорын уран чадварлаг цөхөршгүй үзгээр бичигдсэн ялын төлөвлөгөө уншиж танилцуулахыг хүслээ.

Өөр хэнд ч гэсэн зовууртай, залхуу хүрмээр удаанаар унших үед хүмүүсийн анхаарал энэ шалгалтыг сэргэлэн цовоо өнгөрүүлж байгаа Андреа дээр татагдсан байв.

Вильфор хэзээ ч ийм товч тодохой, уран үгтэй байгаагүй байж мэдэх юм. Ялт хэргийг хамгийн хурц тод өнгөөр дүрслэн гаргажээ. Ялтны бүх өнгөрсөн явда, түүний дотоот шинж чанар а жмаар өөрчлөгдсөн, бага наснаасаа дэс дараатай хийсэн гэмт хэргүүдийг хүний амьдрал ба ухаан санааг уудлан гаргж чадах тэр их хүчээр, вангийн прокурорын дээд ухаанаар тод тодорхойгоор дүрслэн харуулжээ.

Бенедетто хуулиар шийтгэж тогтоол гаргахаас өмнө зөвхөн энэ уншсан ялын төлөвлөгөөгөөр олны нүдний өмнө эргэлт буцалтгүй устгагдах ажээ.

Дараа дараагаар тусаж байгаа аймшигт яланд Андреа өчүүхэн ч хайхарсан шинжгүй байв. Вильфор олон жил хэрэгтнүүдэд хийсэн сэтгэхүйн ажиглалтаа хийж байгаа бололтой түүн өөд байн байн харж хэчнээн ширтэвч Андреагийн зовхийг буулгаж чадсангүй.

Ялын төлөвлөгөөг уншиж төгслөө.

- Яллагдагч таны нэр овог хэн бэ? гэж хурлын дарга асуув.

Андреа босож,

- Уучлаарай эрхэм даргаа гэж тод чанга дуугаар хэлээд, - Та намайг хариулахад төвөгтэй байдлаар асуулт тавих гэж байх шиг байна. Би ердийн хэрэгтнүүдээс ангид үзэгдэх хүн болохоо удахгүй нотлон харуулах байх гэж бодож бйагаа бөгөөд ингэж нотлон харуулж ч чадна. Өөр дэс дараа барьж

хариулахыг та надад зөвшөөрнө үү? Тэгвэл би бүх асуултад хариулах болно гэв.

Дарга иргэний төлөөлөгчид өөд харахад цаадуул нь вангийн прокурор өөд харлаа.

Сонирхон цугларагсад гайхаж хоцорлоо.

- Та хэдэн настай вэ? Энэ асуултад та хариулах уу? гэж дарга асуув.
- Энүүнд ч тэр бусдад нь тэр ээлжийг нь ирэхээр хариулна.
- Та хэдэн настай вэ? гэж шүүгч давтан асуув.
- Би хорин нэгэн настай, чухамдаа гэвэл би мянган найман зуун арван долоон оны есдүгээр сарын хорин долооноос хорин найманд шилжих шөнө төрсөн учраас хэдхэн хоногийн дараа хорин нэгэн нас хүрнэ.

Ямар нэгэн юм бичиж суусан Вильфор энэ үгийг сонсоод толгойгоо өндийлгөв.

- Та хаана төрсөн бэ? гэж дарга цааш асуухад,
- Парисын ойролцоох Отейлд гэж Бенедетто хариулав.

Вильфор хоёр дахь удаагаа Бендетто өөд харж, мангасын толгой үзсэн юм шиг арай нь зэвхийллээ.

Бенедеттогийн тухайд гэвэл нарийн торгон алчуурын булангаар уруулаа хээнцэрхэн арчиж байв.

- Таны мэргэжил юу вэ? гэж дарга асуухад Андреа ажиг ч үгүй байдлаар,
- Эхлэд хуурч овлож, дараа нь хулгайлж явснаа саяхнаас хүн алсан гэж хариулав.

Дургүйцэх, гайхах чимээ танхимд сонстов. Шүүгчид гайхан бие бие өөдөө харуж, иргэний төлөөлөгчид дээдсийн хүрээлэнгийн хүнээс ийм ичгүүр сонжуургүй үг гарсанд дургүйцэж байв.

Вильфор гараараа духаа илбэв. Түүний зэвхий царай нь хүрэнтэж барайгаар ирэв. Тэгснээ гэнэт босож ийш тийшээ харав. Амьсгаа нь давхцаж байх шинжтэй.

- Эрхэм вангийн прокурор та ямар нэг юм эрээ юу? гэж Бенедетто маш эелдгээр инээмсэглэж асуув.

Вильфор түүнд юу ч хариулсангүй дахин сандал дээрээ суув. Чухамдаа сандал дээрээ уначхав.

- Яллагдагч та одоо нэрээ хэлэх юм биш биз? Та өөрийнхөө мэргэжил гэж нэрлэсэн хэргүүдээ ичгүүргүйгээр тоочин шүүхийн өмнө түүгээрээ бардамнасан явдлыг чинь шүүх зан суртахуун ба хүнийг хүндэтгэх ёсны төлөө хатуу зэмлэж байна. Та бүх алдар цолоороо нэрээ урьдчилан чимэглэх гээд тийнхүү санаатайгаар шууд мэлээгүй байсан биз гэж хурлан дарга асуув.
- Ямар гайхалтай юэ эрхэм дарга гэж Бендетто дуулгавартай бөгөөд хүндтэгэлтэйгээр хэлээд – Та миний санааг яасан мэргэн таав. Би яг л ийм зорилготойгоор асуултын дэс дарааг өөрчлөхийг хүссэн юм гэв.

Хүмүүсийн гайхах нь хэмжээнээсээ хэтэрлээ. Яллагдагчийн үгэнд бардамнан бахархах, ичгүүр сножуургүйн шинж үгүй байлаа. Энэ хар үллийн гүн дотроос аянга цахилгаан ниргэх нь гэж догдолсон хүмүүс мэдэрч байлаа.

- Тэгэхээр таны нэр хэн гэдэг вэ? гэж дарга асуув.

- Би нэрээ мэдэхгүй болохоор танд хэлж чадахгүй нь. Харин би эцгийнхээ нэрийг мэднэ. Тэгэхээр энэ нэрийг л хэлж чадна.

Вильфорын нүд бүрэлзэж, нүүр дээгүүр нь хөлс цуван гараараа бичиг цаасаа ийш тийш болгоно.

- Тэгвэл та эцгийнхээ нэрийг хэл л дээ гэж дарга хэлэв.
Том танхимд огтын чимээ аниргүй болж хүмүүс цөм амьсгаа даран чагнав.
- Миний эцэг бол вангийн прокурор гэж Андреа тайван хариуллаа.
- Вангийн прокурор гэнэ ээ! гэж дарга, Вильфорын өөрчлөгдссөн царайг ажиглалгүйгээр гайхаж асуув.
- Тимй ээ, та түүний нэрийг мэдэх гэж хүссэн болхоор би хэлж өгь. Түүнийг Вильфор гэдэг юм.

Шүүхийн х'рлыг хүндэтгэн биеэ барьж байсан хүмүүсийн дургүйцэл хүн бүрийн амнаас салхи шуурган мэт гарч ирлээ. Тэр ч байтгауй шүүгч нарч өөрсдөө дургүйцсэн хүмүүсийг намдаах гэж бодсонгүй. Ямар базаахгүйхэн улсын хашхиралдаан, хараал зүхэл, ажиггүй сууж байгаа Бенедеттог занаж чичлэх нь таван минут хэртэй үргэлжлэв.

Олны дундаас шуугиан дунд даргын дуу сонстож,

- Яллагдагч та шүүх хурлыг доромжилж байна даа. Манай завхарч задарсан үед ч гэсэн үэрэгцүүлэх юмгүй хэтэрхий эвдэрсэн зан суртахууныг та үзүүллээ! Гэв.

Зөөлөн сандалдаа шигдсэн вангийн прокурорын дэргэд арваад хүн бэгцэгнэж үнэнч шударга сэтгэл зовж байгаагаа илэрхийлэн түүнийг тайвшруулж сэргээж байв.

Танхим дотор чимээ аниргүй байдал дахин тогтож эхэлсэн боловч нэг буланд хүмүүс сандарч тэвдсэн хэвээр байв.

Нэг хүүхэн ухаан алдаж ийчжээ гэж ярьцгааж байв. Түүнд давс үнэртүүлж ухаан оруулжээ.

Андреа шуугиан үймээний дунд цугларагсад өөд эргэн харж инээмсэглэв.

Дараа нь урт сандлын царсан түшлэг дээр хээнцэр маягаар тулан зогсоод,

- Эрхмүүд ээ, би шүүх ба хүндэт хуралдааныг үймүүлэх гэж бодоогүйг минь бурхан тэнгэр хараг. Надаас хэдэн настай вэ? гэж асуулаа, би хэллээ. Намайг хаана төрсөн бэ? гэж асуухад нь би хариуллаа. Миний нэрийг асуулаа. Би тэр асуултанд нь хариулж чалахгүй нь. Яагаад гэвэл миний эцфэг эх хоёр намайг хаячихсан юм. Харин би эцгийнхээ нэрийг мэддэг юм. Миний эцгийг Вильфор гэдэг гэж давтан хэлж чадна. Бас үүнийгээ нотолж өгөхд бэлхэн байна гэв.

Яллагдагчийн дууны өнгө гойд итгэлтэй, аргагүй үнэмшмээр байсан учир олны шуугиан намдаж чимээ аниргүй болчхов. Бүх хүн вангийн прокурор өөд харлаа. Вильфор амь нь гарсан мэт дуу ч үгүй, хөлөмгүй сууна.

- Эрхмүүд ээ би өөрийн хэлсэн үгийг тайлбарлаж батлах ёстой гэж Андреа үргэлжлүүлэн хэлэв.
- Гэвч та мөрдөн байцаалтын үед өөрийгөө Бенедетто гэдэг. Корст төрсөн өнчин хүүхэд гэж хэлсэн шүү дээ гэж дарга уурлан хэлэхэд залуу хүү,
- Би мөрдөн байцаалтын үед хэрэгтэй гэж үзсэн юмаа хэлсэн. Харин би нууцаа дэлгэрэнгүй илчлэн гархаад ямар нэг юм саад болохыг хүсээгүй юм. Ийм саад зайлшгүй болох байсан юм гэв.

Тэгэхээр би давтан хэлье. Би мянган найман зуун арван долоон оны есдүгээр сарын хорин доллон хорин наймны шөнө Отейльд төрсөн. Би бол вангийн прокурор де Вильфорын хүү. Хэрэв та нар тодорхой мэдье гэж байгаа бол би бүгдийг хэлэмц.

Би Фонтен гудамжны хорин долоодугаар байшингийн хоёрдугаар давхарт улаан дотортой тасалгаанд төрсөн юм. Миний эцэг намайг гар дээрээ өргөж аваад, үхчихсэн хүүхэд байна гэж хэлээд Э.Н. гэдэг нэрийн үсэгтэй даавуунд ороож цэцэрлэгт аваачиж амьдаар минь булчихсан юм гэв.

Яллагдагчийн итгэл улам нэмэгдэхийн хамт Вильфорын сандарч тэвдэх нь улам их болж байгааг цугларсан олон харж шуугилдлаа.

- Та энэ тодорхой зүйлийг хаанаас мэдсэн юм ыбэ? Гэж дарга асуулаа.
- Эрхэм дарга минь одоохон хэлж өгье. Эцэг минь намайг булсан цэцэрлэг дотор тэр шөнө түүнийг үзэн ядаж, өшөөгөө авах гэж хэдийнээс дагаж мөшгиж явсан нэг корс хүн орсон байжээ. Тэр хүн Ёутны цаана нуугдаад миний эцэг хайрцагтай юм газар ухан булахыг хараад дотор эрдэнэс булсан бай! магадгүй гэж түүнийг нь ухаж, амайг амьд байхад минь олж авчээ. Тэгээд тэр хүн намайг Асрамжийн газар аваачиж өгөхөд тавин долоодугаар дээр бүртрэн авчээ. гурван сарын дараа түүний дүү хүүхэн намайг авах гэж Рольямаас Парист ирж миний хүү гэж хэлээд аваад явжээ. Отейльд төрөөд Корст өссөний минь учир энэ дээ.

Олон хүний догдолсон амьсгалын чимээ дуулдахгүй байсан бол танхим хоосон байна гэж хэлж болохоор чимээ аниргүй байв.

- Цааш нь гэж дарга хэлэхэд Бенедетто үргэжлүүлэн
- Би эдгээр надад хайртай сайн сэтгэлт хүмүүсийн дэргэд жаргалтай амьдарч болох байсан боловч өргөн авсан эхийнхээ хүмүүжүүлье гэх оролдлогоос төрөлхийн өөдгүй зан минь дээр нь гарч, хорон муу санаатай өсөж, сүүл сүүлдээ гэмт хэрэг хийжээ. Нэгэн удаа би, намайг бурхан тэнгэр имий хорон муу санаатай, ийм хувь заяатайгаар бүтээснийг хараан зүхэж байтал, өргөж авсан эцэг минь надад,

“Золгүй амьтан минь бурхан тэнгэрийг бүү харааж зүх! Бурхан чамайг ингэж бүтээсэн биш, харин чиний эцэг гэм буруутан нь юм. Эцэг чинь чамайг, хэрэв үхвэл тамд тарчлах, аз болж амьд гарвал өлсгөлөн гуйланчлалд учирч байхаар болгожээ” гэж хэлсэн юм.

Түүнээс хойш би бурхан тэнгэрийг харааж зүхэхээ больж эцгээ харааж зүхэх болсон юм. Тийм учраас эрхэм дарга таны уургы хүргэж, энэ хүндэт хурлынхны сэтгэлийг донсолгосон тэр зүйлийг хэлсэн билээ. Хэрэв миний энүүнийг дахиад шинэ гэмт хэрэг гэж үзвэл намайг цээрлүүлэн шийтгээрэй. Харин би төрсөн өдрөөсөө эхлэн ийм гашуун зовлонтой хувь заяатай хүн явснаа та нарт итгүүлж чадвал намайг өрөвдөж хайрлаарай! Гэв.

- Таны ээж чинь хэн бэ? гэж дарга асуув.
- Ээж минь намайг үхсэн гэж бодож байсан, тийм учраас миний өмнө ямар ч буруугүй. Би эхийнхээ нэрийг мэдэхийг хсүээгүй, тийм учраас мэдэхгүй.

Дөнгөж ухаан ороод байсан үл танигдах хүүхний сууж байсан буланд хашхирах дуу сонстож дараа нь цурхиран уйлав.

Тэр хүүхэн ухаан алдаж унасан тул түүнийг танхимаас гаргав. Бүсгүйг өргөхөд нүүрийг нь халхалсан шигүү гивлүүр унаж, дэрэгд нь байсан хүмүүс хатагтай Данглар байхыг танилаа.

Вильфор хэдий зүдэрч тарчлан, чих нь шуугин, тархин дотор нь элдвийн бодол уймран байсан боловч хатагтайг таньж бослоо.

- Нотолгоо хэрэгтэй! Гэж дарга хэлээд – Яллагдагч аа, энэ балмад дайралт чинь хамгийн гарцаагүй баримтуудаар нотлогсдон байх ёстой гэв.
- Та нотолгоо шаардаж байгаа хэрэг үү? Гэж Бенедетто тохуурхсан маягтай асуув.
- Тийм.
- Та эрхэм Вилфьор өөд хар л даа. Танд одоо өөр нотолгоо хэрэг байна уу?

Ширтэн харж байгаа олон нүдний хүнд даралтын доор гайхан гуйвалзаж байгаа вангийн прокурор өд танхимд сууж байсан бүх хүмүүс харлаа. Үс нь арзайж, нүүрээ хумсаараа урчихсан байв.

Хүмүүс дүнгэнэлдээд явчхав.

- Аав аа, надаас нотолгоо шаардаж байна. Би трэр нотолгоог нь гаргаж өгөх үү? Гэж Бенедетто хэлэхэд,
- Хэрэггүй, энэ илүү ажил гэж Вильфор сөөнгө дуугаар бувтнав.
- Юу илүү хэрэг гэж? Та юу гэх гээ вэ? гэж дарга дуу алдахад вангийн прокурор
- Намайг хавчиж байгаа үхлийн бахинаас мултрах гэж оролдоод дэмий хэрэг болно. Би цээрлүүлэгч бурхны гарт орлоо! Баримт нотолгоо хэрэггүй! Энэ хүний хэлсэн бүхэн үнэн гэж хэллээ.

Байгалийн их сүйрлийн өмнөх шиг, оройны үс өрвийм зэвүүн таг чиг байдал бүхний сэтгэлийг барайлган хүйт оргиулав.

- Яалаа гэж, эрхэм де Вильфор та хий үзэгдэлд хууртаж байна. Ухаан санаа чинь төөрөлдөв үү? Иймэрхүү аймшигт ял гэнэт тулгахад таны балмагдсан тань ойлгомжтой байна. Сэхээ орооч та! Гэж дарга дуу алдахад вангийн прокурор толгой сэгсэрч, хомхоо өвчинд автсан мэт шүд нь дагжин, царай нь хувхай цагаан боллоо.
- Эрхэм даргаа, ухаан саруул байна. Харин зөвхөн бие л зовж байна. Энэ хүний намайг буруутгаж байгаа бүхэнд би буруутайгаа хүлээж байна. Би гэртээ харьж намайг залгамжлан аван вангийн прокурорын шийдвэрийг хүлээн сууя гэсэн энэ үгийг Вильфор аяархан хэлээд гуйвсхийн_үүд чиглэж алхахад үүдний жижүүр сурсан зангаараа хаалга нээж өгөв.

Энэхүү аймшигтайгаар илчлэгдсэн болон түүнээс багагүй аймшигтайгаар хэргээ хүлээн, парисын дээдсийн хүрээлэнг хоёр долоо хоногийн турш түгшүүлсэн нууц явдал эмгэнэлтэйгээр тайлагдсанд сэтгэл нь донсолсон танхим чивчимээгүй байв.

- Амьдралд эдрээтэй будлиантай явдал үгүй гэж ярьцгаана шүү бас гэж Бошан хэлэхэд Шато-Рено,
- Тимй ээ, ер нь л би генерал Морсер шиг өөрийгөө төгсгөл болгохыг дээр гэж үзэж байна. духнадаа сум зооно гэдэг бол имй муухай балраснаас хамаагүй таатай хэрэг гэв.

- Ялгаагүй л энэ чинь алж байгаа юм гэж Бошан хэлэхэд Дебрэ,
- Би охинтой нь суух гэж бодож байсан гээч! Хөөрхий охин үхсэн нь сайн болж дээ! гэв.
- Шүүхийн хурал хаагдав. Энэ хэрэг дараагийн хуралдаан болтол хойшлогдлоо. Өөр хүн томилогдож өөр мөрдөн байцаалт явагданан гэж дарга хэллээ.

Цугларсан олны нүдэнд ихээ дээшилж эхэлсэн Андр?а өнөөх тайван байдлаара танхимаас гарч одоход харгалзаж байсан цагдаа өөрийн эрхгүй түүнд хүндэтгэлийг үзүүллээ. Дебрэ цагдаагийн гарт алтан зоос атгуулж,

- Хонгор минь та үүнийг юу гэж хэлэх вэ? гэхэд цаадах нь,
- Зөөлрүүлэх учир шалтгаан гэж үздэг юм хэмээн хариуллаа.

14.ГЭМЭЭ ЦАГААТГАСАН НЬ

Вильфорыг хаалга өөд алхахад хүмүүс зам тавьж өгч байв. Асар их уй гашуу бүхэн хүндэтгэл төрүүлдэг бөгөөд, хамгийн хатуу ширүүн үед ч гэсэн засаж залруулж болшгүй гай зовлонд тохиолдсон хүнийг эхний минутд өрөвддөггүй байсан удаа ер үгүй билээ. Уурсаж улайсан олон үзэн ядсан хүнээ алж ч мэднэ. Гэхдээ хмүүүс тэрхүү золгүй амьтныг гэмт хэрэг хийсэн байлаа ч гэсэн алах ял заагдахад нь дроомжилж байса явдал ховор юм.

Вильфор өөрөө өөртөө ял оноогоод сонирхогч олон, цагдаа, шүүхийн түшмэдүүдийн дундуур зовлон гансралдаа хамгаалагдан өнгөрч явлаа.

Хүмүүс зөвхөн сэрэхүйгээр мэдрэхээс биш овун ухаанаараа авч чадахгүй тийм эмгэнэлт явдал бас байдаг. Тэгэхэд л хамгийн тачаангуй, хамгийн үнэн голоосоо хашхирч чадсан хүн л агуу их яруу найрагч болно. Энэ хашхирах дуун нь олны дунд бүхэн бүтэн тууж болдог бөгөөд олон нь түүнд хангагдаж үнэн мөний дуу гарахад нь гүйцэд хангагдсан гэж үзэх нь зүй ёсны хэрэг юм.

Гэвч Вильфор шүүхийн хурлаас гарахдаа оюун мэдрэл нь зогсонги болж, харуулан оволзож, мэдрэхлийн судас бүр нь гүрийж зовлонт биеийн нь хэсэг бүрийг тарчилгаж байсныг гаргаж бичихэд бэрх буй заа.

Вильфор зөвхөн дадал заншлынхаа хүчээр л үүд хүрлээ. Тэр мөрнөөсөө шүүгч ямбаны хувцсыг мултлан авч хаялаа. Тэгэхдээ ёсыг бодож тэгсэнгүй, Нессагийн зовуурт хувцас шиг мөрөн дээр нь хүнд дарамт болж байсан учир авч хаяжээ.

Гуйвлан явсаар Дофины хашаа хүрч сүйх тэргээ олж, хөтчөө сэрээгээд хаалгыг нь өөрөө онгойлгоод Сент-Онорын зүг зааж орхиод сандал дээрээ уначихлаа.

Морьд хөдөллөө.

Түүний бр?аж босгосон амьдрал нь аймшигтай хүндээр сүйрэн уналаа. Энэхүү нурсан амьдралдаа дарагджээ. Үүний үр уршгийг нь урьдчилан харж, хэмжиж шзээгүй, зөвхөн мэдэрч байв. Цагаандаа гарсан алуурчин өөрийн сайн мэдэх хуулийн зүйл ангийг боддог шиг хуулийн үг үсгийг бодсонгүй.

Зөвхөн бурхан л түүнд бодогдох ажээ.

- Бурхан минь! Бурхан минь! гэж амандаа үглэнэ.

Энэ аймшигт сүйрэл нь зөвхөн бурхны гараар хийгдсэн болохыг харжээ.

Сүйх тэрэг түргэн давхина. Вильфор ар талынхаа түшлэгийг налахад ямар нэг юм уналаа. Гараараа тэмтрээд үзсэн чинь хатагтай Вильфорын мартаж орхисон дэвүүр түшлэг нуруу хоёрын нь хооронд тээглэж байжээ. Дэвүүрийг хараад нэгэн юм санагджээ.

Вильфор эхнэрийнхээ тухай бодов.

Тэгээд зүрхэнд нь халуун төмөр шаасан юм шиг гиншив.

Зөвхөн ганц өөрийнхөө л золгүй явдлын тухай бодож байтал гэнэт түүнээс нь багагүй аймшигт явдал нүдний нь өмнө босож иржээ.

Түүний эхнэр санагджээ! Тэр дөнгөж саяхан эхнэрийнхээ өмнө хэлбэршгүй шүүгч хүн зогсож байгаад үхэх ял заажээ. Вильфорын хиргүй тунгалаг сайн сайхан үйлээрээ сүрдүүлж айлгасанд ичич зовон нүглээ наманчилж байсан тэр хүүхэн хэмжээ хязгааргүй энэ эрх мэдтийн өмнө үхэх гэж бэлтгэж байсан ч байж болох юм.

Вильфор түүнийг ялласнаас хойш бүтэн цаг өнгөрчээ. Тэр хүүхэн энэ минутад өөрийн бүх гэмт хэргийг санаж, өршөөн хайрлахыг бурхнаас гуйж, захидал бичиж, өөрийн шүүгчээс амь насаа тавьж уучлахыг хүсэж байж таарна.

Вильфорын сэтгэт түгшин гялгар торгон дэр дээрээ тогтож ядан бүдэгхнээр гиншинэ.

- Хөөрхий бүсгүй гагцхүү надад л хавьтаж ойртсон учраас хэрэгтэн болж байгаа юм! Би гэдэг тэр чигээрээ гэмт хэрэг юм. Энэ маань тэдэнд хижиг, тахал шиг халдварлажээ!... Тэгэхэд Үи түүнийг цээрлүүлж байдаг!... Би түүнд нүглээ наманчилж, үх гэж зүрхлэн хэлж байдаг... Би дээ! Үгүй, үгүй тэр амьдрах ёстой.... Надтай хамт явах болно... Бид нуугдана. Бид Францыг орхин явж, дэвэн дэлхийг хэрэн тэнэнэ. Би түүнд цаазын индрийн тухай хэлсэн!... Аугаа бурхан минь! Би энэ үгийг яаж зүрхлэн хэлээ вэ! Намайг ч бас цаазын индэр хүлээж байгаа юм байна!... Бид нуугдана.... Би түүнд бүгдийг хэлж буруугаа хүлээе. Өдөр бүр би мөн л тийм хэрэгтэй гэж давтан хэл байя. Бар, могой хоёрын холбоо гээч болог! Нөхөртөө тэнцэх эхнэр юм! Тэр амьдрах ёстой, хийсэн муу хорт үйл нь минийхийн өмнө бүдгэрэх ёстой! Гэж дуу алдлаа.

Тэгээд Вильфор сүйх тэрэгнийхээ урд шилийг ухасхийн онгойлгож,

- БУшуул, бушуул! Гэж муухайгаар дуугарсанд хөтөч суудал дээрээ өндөсхийж айсан морьд гэрийн зүг салхин мэт давхилаа.
- Тэр хүүхэн амьдрах ёстой, нүглээ наманчилж, миний хөөрхий хүүг хүмүүжүүлэх ёстой. Энэ ганцаараа тэр төмөр мэт өвгөний хамт миний гэр бүлд тохиолдсон үхлийг даван туулсан юм! хатагтай хүүдээ их хайртай. Түүний төлөө гэмт хэрэг хийсэн хэрэг. Хүүхдээхайрлагч бүсгүйн зүрх сэтгэлд хэзээ ч итгэлийг алдаж болохгүй. Тэр нүглээ наманчилаг, хэн ч түүнийг ялтан хэрэгтэн гэж мэдэхгүй. Миний гэрт хийгдэж, дээдсийн хүрээлэнд шивэр авир ярилцаж байгаа хэрэг аяндаа мартагдана, хэрэв мартахыг хүсэхгүй хүн гарвал буруугий нь би өөртөө хүлээнэ. Нэг хоёр, гурваар илүү дутуу байх нь ямар хамаа байх вэ! Эхнэр маань манай бүх алт мөнгө, ялангуяа хүүгээ аваад бидний энэ уначихад бэлхэн байгаа газрын гарваас зайлан яваг. Тэр амьдраг, хүүдээ хязгааргүй хайртай болхоор аз жаргалтай байх болно.Хүүтэйгээ хамт үлдэг. Би буян хийж

байна. Энүүнээс минь болоод сэтгэл оюун минь хөнгөрлөө хэмээн Вильфор үглэн байв.

Тэгээд авнгийн прокурор чөлөөтэйгээр амьсгалав.

Вильфор гишгүүр дээрээс шат руу шууд сүрэн бууж, зарц нар нь түргэн эргээд ирсэнд гайхаж байхыг харав. Түүнээс өөр юу ч тэдний царайд харагдсангүй. Хэн нь ч түүнтэй ярьсангүй. Заншсан ёсоор түүнд зам тавьж өгөв.

Тэр Нуартъегийн тасалгааны хажуугаар өнгөрч дутуу хаалттай хаалгаар нь хоёр хүний дүрс хараад эцэг дээрээ хэн ирснийг ч анзаарсангүй. Түгшсэн стэгэл нь түүнийг тууж явлаа.

Тэгээд эхнэр ба Валентинагийн хоосон тасалгаа руу гарсан аяцхан шатаар дээш өгсөж явахдаа “Энд ч хуучнаараа байх шиг байна” гэж бодлоо.

Талбар дээрх хаалгыг хаачхаад,

- Хэн ч бүү оож ирэг. Би түүнтэй хоёулхнаа ярьж буруугаа хүлээн, бүх учрыг ярина... гэж хэллээ.

Тэгээд хаалга руу очиж болор бариулаас нь барьж татвал хаалга нээгдлээ.

- Түгжээгүй байна. Сайны ёр доо гэж бодоод үдэш болоход Эдуарды орыг засаж өгдөг бяцхан зочдын өрөөнд оров.

Жаал хүү байрлай сургуульд суралцдаг боловч орой бүр гэртээ ирдэг ажээ. Эх нь хүүгээсээ ямар ч байсан салах дургүй байжээ.

Вильфор тасалгааг эргэцүүлэн хараад,

- Хэн ч алга, лав унтлагынхаа өрөөнд байгаа байх гэж хэлээд үүд рүү ухасхийв. Гэтэл хаалга түгжээтэй байв. хамаг бие нь салганаж
- Элоиза! Гэж хашхирлаа.

Нэг хүн сандал хөдөлгөх шиг түүнд санагджээ.

- Элоиза! Гэж дахин хашхирав.
- Хэн бэ? гэж эхнэрийнх нь дуу гарав.

Энэ дуу урьдынхаасаа сулхан байх шиг түүнд санагджээ.

- Онгойлго, онгойлго, би байна гэж Вильфор хэллээ.

Вильфор хэдийгээр ингэж тушаажэ, түгшсэн дуугаар хэлсэн боловч хэн ч тайлж өгсөнгүй.

Вильфор хөлөөрөө хаалга өшиглөв.

Хатагтай Вильфор босгон дээр хачин өөрчлөгдсөн зэвхий царайтай болчхоод, хөдөлгөөнгүй, аймаар гөлөрсөн нүдээр нөхөр өөдөө харж зогслоо.

- Элоиза! Та яав? Хэлээч! Гэж асуув.

Тэгэхэд хатаай хөшиж цусгүй болсон гараа түүн өөд сунгаад,

- Эрхэм таны тушаасан бүгдийг нь биелүүлсэн гэж бүдэг дуугаар хэлээд, -
Та өөр бас яах гээ вэ? гэлэ. Ингэж хэлээд хүүхэн хадуураар цавчигдсан юм шиг хивсэн дээр уналаа.

Вильфор түүн өөд ухасхийн гараас нь барьж авав. Энэ гар алтан бөглөөтэй Жижиг болор шил атган татваганан байв.

Хатагтай Вильфор үхчихсэн байв.

Вильфор айж ухаан алдан хүүрээс нүд салгалгүй гэдрэг ухарлаа.

- Эдуард! Миний хүү хаана байна? гэж хашхираад тасалгаанаас гүйн гарч,
- Эдуард Эдуард! Гэж дуудан явлаа. Аймшигтай муухайгаар хашхирсан учир тал талаас зарц нар гүйлдэн ирэв.

- Миний хүү! Миний хүү хаана байна? Түүнийг аваад яв, бүү хараг... гэж Вильфор хэллээ.
- Эдуард агь доор алга байна билээ гэж хиа хариуллаа.
- Цэцэрлэгт байх ёстой. Хойноос нь гүйгээрэй.
- Үгүй, эзэнтэн минь. Хатагтай Вильфор хагас цагийн өмнө түүнийг дуудаж аваачсан Эдуард тийшээ ороод эргэж гарч ирээгүй.

Вильфорын духан дээр мөс шиг хүйтэн хөлс гарч, хөл нь гуйвлан толгойд нь элдвийн юм бодогдлоо.

- Түүн дээр орсон гэнэ ээ! гэж шивгэнээд, нэг гараараа духаа арчиж, нөгөө гараараа хана түшин яаран эргэж явав.

Өнөөх тасалгаанд орж золгүй хүүний биеийг дахин харах ёстой болжээ.

Тэрээр Эдуардыг дуудаж авс болсон энэ тасалгааны чимээ аниргүй байдлыг эвдэх хэрэгтэй боллоо. Энд үг дуугарна гэдэг бол булшны нам гүм байдлыг эвдэнэ гэсэн үг.

Хэл нь эргэлдэж өгөхгүй гэдгийг Вильфор мэдэрчээ.

- Эдуард! Эдуард! Гэж дуудавч ямар ч хариу дуугарсангүй.

Ээж дээрээ ороод эргэж гарч ирээгүй хүүхэд минь хаачив гэж Вильфор урагш алхлаа.

Хүүгийн нь байж болох өрөөний өмнө хатагтай Вильфорын хүүр хэвтэж байв. Энэ хүүр үүдийг нь манасан мэт ажээ. Харсаар байгаа нүд, ангайсан уруул дээр нь учиртайхан инээмсэглэл тодрон байв.

Өргөрсөн хөшигний цаад талд төгөлдөр хуур хөгжмийн хөл, хөх атласан бүтээлэгтэй зөөлөн сандлын булан харагдаж байв.

Вильфор бас хэд алхаж урт зөөлөн сандал дээр хүүгээ хэвтэж байхыг харав.

Хүүхэд унтаж байгаа боло«той.

Хөөрхий амьтанд баяр хөөр төрж, зовж зүдэрч байсан харанхуй тамд нь гэгээ гэрэл тусах шиг боллоо.

Тэрээр хүүр дээгүүр алхан орж хүүхдээ өргөн авч холын газар гүйн одох гэж боджээ.

Энэ бол соёлжсон хүний дүр үзүүлэвч ихэмсэг зантай урьдын Вильфор биш болжээ. Энэ бол үхүийн шарх олж, аймшигт амаа эцсийн удаа хамхин шүдээ хуга татаж байгаа бар болжээ.

Тэр одоо атгаг сэжгээс бус харин хий үзэгдлээс айх болжээ. Тэгээд гэдрэг ухраад гал дээгүүр харайж байгаа мэт хүүр дээгүүр харайн гарав.

Тэгээд хүүгээ өргөж цээжиндээ тэврээд сэгсрэн нэрээр нь дуудаа, уруулаараа хацар дээр нь хүргэхэд хүтээн бөгөөд үхээрийн цонхигор байв. Вильфор хүүхдийн хөшсөн биеийг дарлан үзэж, гараараа зүрхийг нь дарж үзлээ. Зүрх нь цохилохгүй байв.

Хүүхэд үхчихсэн байжээ.

Дөрөв нугалсан цаас хивсэн дээр унав.

Вильфор аянганд ниргүүлсэн мэт болж өвдөгдээрээ сөхөрч суухад амьгүй юм шиг болчихсон гараас нь хүүхэд мултран унахад эх рүүгээ бөмбөрөв.

Вильфор бичгийг газраас авч, эхнэрийнхээ гарын үсгийг таньж, шуналтайгаар уншвал,

“Би сайн ээж байсныг та мэднэ. Хүүгийнхээ төлөө явж байж ялт хэрэгтэн боллоо. Сайн ээж хүүгээсээ салдаггүй юм!” гэжээ.

Вильфор нүдэндээ ухаан санаандаа итгэсэнгүй. Тэгээд хүү өөдөө мөлхөн очиж, эм арслан үхсэн зулзагаа харж байгаа юм шиг анхааралтайгаар харлаа.

ТҮҮНИЙ ЦЭЭЖНЭЭС ЗҮРХ ШИМШРҮҮЛЭМ ХАШХИРАХ ДУУН ГАРЛАА.

- Бурхан минь! Дахиад л! гэж гиншин байв.

Хоёр үхдэл түүнийг айлгаж хоосон тасалгаанд ганцаараа арга тасран буйгаа мэдэрлээ. Саяхан болтол хүч тамиртай байдаг хүнд заяагдсан гансрал нь түүнийг түшин, цөхрөл нь түүнийг авч явсан билдээ.

Вильфорын толгой хүнд дарамтад тонгойсноо өвдөг дээрээсээ босож хөлөрч наалдсан үсээ чичирсэн гараар илбэв. Тэгээд өрөвдөн хайрлахыг огт мэддэггүй байсан өөрийн гаслан зовлонг хэн нэгэн хүнд уудлан гаргахаар хөгширсөн эцэг дээрээ очихоор салганан гарлаа.

Вильфор бидний мэдэх шатаар бууж Нуартье дээр орлоо.

Вильфорыг ороход Нуартье ихэд анхааралтай найрсгаар хэүээний тайван төвшин лам Бузони яриаг чагнаж байв.

Вильфор ламыг хараад гараараа духаа дарлаа. Өнгөрсөн нь бодогдож уур хилэнгийн давлагаан хөөсрөн цалгив.

Тэр Отейльд хоол зооглосноос хоёр хоногийн дараа ламынд очсон, мөн Валентинаг нас барсан өдөр лам тэднийд хүрч ирснийг санав.

- Эрхэм та энд байгаа юм аа! Та дандаа л үхэлтэй хамт ирэх юм гэж Вильфор хэллээ.

Бузони нуруугаа тэгшлэв. Тэгээд Вильфорын хачин өөрчлөгдсөн царайг хараад шүүхийн хурал дээр болсон явдлыг ойлгон мэдэв. Харин бусдыг нь мэдээгүй байжээ.

- Би таны охины дэргэд маань унших гэж ирсэн байсан юм гэж Бузони хариулав.

- АА өнөөдөр яах гэж ирсэн юм бэ?

- Та надад өрөө бүрэн төлсөөн гэж хэлэх гэж ирсэн юм. Бурхан бас над шиг үүгээр хангагдахыг хүсэн, одоо мөргөх болно.

- Бурхан минь энэ дуу чинь Вильфор дуу алдаж алхам ухраад,

- Энэ дуу чинь... Та лам Бузони биш Үайна гэв.

- Биш ээ гэж лам хэлээд хиймэл үсээ авч хаяхад урт хар үс зоримог царайгий нь хүрээлэн мөрөн дээр нь унжив.

- Монте-Кристо гүн! гэж Вильфор гайхан дуугарлаа.

- Тэр ч бас биш, вангийн прокурор минь, хуучин явдлуудыг дурсан санаарай.

- Энэ дуу! Би хаана сонссон юм бол?

- Та энэ дууг хорин гурван жилийн өмнө Рене де Сен-Мерантай сууж хариумаа хийж байсан өдөр Марсельд сонссон. Бичиг хэрэг бүхий хавтсаа сөхөж үзвэл олдоно оо.

- Та Бузони биш гэнэ ээ? Монте-Кристо биш гэнэ ээ? Бурхан минь, та л миний үхлийн нууц дайсан байжээ! Би танд Марсельд байхдаа ямар нэг муу юм хийжээ, чааваас минь.

- Тимй ээ, чи таачихлаа гэж хэлээд гүн хоёр гараа цээжиндээ зөрүүлж,

- Сайн бод, бод! Гэлээ.
- Үгүй би чамд ямар муу юм хийсэн юм бэ? гэж эрүүл солиотой хоёрын хооронд бослон Вильфор хэлээд – Би чамд ямар юм хийсэн юм бэ? гэж асуув.
- Чи намайг аймшигтай алгуурхан үхэлд унагаж, эцгийг минь алдаа, дурлал хайрыг минь эрх чөлөөний хамт булаан авсан шүү дээ.
- Үгүй, чи тэгээд хэн бэ? хэн бэ?
- Иф цайзад чиний оршуулчихсан хөөрхий амьтны сүнс яваа нь энэ. Энэ сүнсийг булшнаас гарган бурханд түүнд Монте-Кристо гүнгийн багийг өмсгөж, чамд танигдахааргүй үнэт эрдэнэс, алт, мөнгөөр хучжээ.
- Би чамайг танилаа. Чи бол... вангийн прокурорыг хэлэхэд,
- Би Эдмон Дантес! Гэж гүн хэллээ.
- Чи Эдмон Дантес мөн! тэгвэл явъяа! Гэж вангийн прокурор гүнгийн гараас шүүрэн авч явав. Тэгээд түүниг шат өөд аваачмв. Гайхсан Монте-Кристо хааш нь дагуулж явааг мэдэхгүй боловч бас нэгэн шинэ золгүй явдал бослыг гадарлан дага! явав.

Тэгтэл Вильфор эхнэр хүүхэд хоёрынхоо хүүрийг зааж,

- Эдмон Дантес чи хар! Сайн хар! Санаа чинь амрав уу... гэлээ.
Монте-Кристо үхсэн юм шиг зэвхий даав. Тэр өшөөгөө авахдаа хэтрүүлчихсэнээ ойлголоо. Тийм учраас одоо,
- Бурхан миний төлөө, надтай хамт... гэж хэлж зүрхлэхгүй болжэ:
Гол руу нь хүйтэн оргиод явчихсанд хүүхэд рүү ухасхийн очиж зовхийг нь татаж үзээд, судсыг нь барьж, тэврэн Валентинагийн өрөөнд ороод хаалгыг нь түжгчихлээ.
- Миний хүү! Тэр миний хүүгийн хүүрийг хулгайлаад явчихлаа! Хараал идэж үх чамайг! гэж Вильфор хашхирав.

Тэгээд Монте-Кристо гүн өөд ухасхийх гэсэн боловч хөл нь зүүдэлж байгаа юм шиг шалтай наалдчихаад, нүд нь бүлтэрчих шахаж мойнийсон хуруунууд нь хумсаараа цээж руу нь цус гартал шигдэж, чамархайны нь судас гүрийн, боргилон байгаа ухаан бодолдоо гавлын нь яс дэлбэрчих шахаж байв.

Энэ хөшсөн хөдөлгөөнгүй байдал хэдэн минут үргэлжилж, галзуурлын хар манан Вильфорыг эзэмдэн авлаа.

Тэр муухайгаар хашхиран инээгээд шатаар доошоо гүйлээ.

Арван минутын дараа Монте-Кристо гүн Валентинагийн өрөөнөөс гарч ирлээ. Царай нь зэвхийрч, хараа нь бүдгэрэн хүндээр амьсгалж байв. Үргэжл тайван байдаг царай нь зовлон зүдгүүрт автжээ.

Ямарч юмаар амьдруулж болохгүй болсон хүүхдийг гар дээрээ өргөн гарч и°ээд хүүхдийг хүндэтгэлийн ёсоор эхийн нь дэргэд толгойгий нь цээжин дээр нь дэрлүүлэн тавьж хэвтүүллээ.

Дараа нь босож өрөөнөөс гараад шатан дээр нэг зарцтай дайралдаж,

- Де Вильфор гуай хаана байна гэж асуулаа.

Зарц үг дуугаралгүй цэцэрлэг өөд заалаа.

Монте-Кристо шатаар бууж заасан зүг рүү очиж бөөгнөрсөн зарц нарын дунд Вильфор зээтүү бариад цэцэрлэг дотор ум хумгүй ухаж байгааг харлаа.

- Үгүй, энд биш, үгүй тэнд биш гэж үглээд л цааш нь ухаж байв.

Монте-Кристо түүний дэргэд очоод дөнгөж дуулдахуйц ноомой дуугаар,

- Эрхэм та хүүгээ алджээ. Гэвч танд үлдсэн... гэж хэлэхэд цаадах нь гүнгийн үгийг сонсолгүй таслан,
- Би түүнийг олноо, түүнийг энд байхгүй гэж надад битгий хэлээрэй._ Би түүнийг эрлэг номон хааны өмнө очсон байсан ч хамаагүй эрж олно гээд байлаа.

Монте-Кристовийн хөл гуйвж,

- Энэ хүн галзуурчижжээ! Гэж хэллээ.

Тэгээд энэ нүгэлт байшингийн хана дээрээс нь нурчих бий гэж айсан мэт гудамжинд гүйж гараад, зөв буруу хийсэн алин болохоо анх удаа эргэлзэн бодож зогслоо.

- Боллоо, боллоо, сүүлчийнхий нь өрөвдье гэж хэллээ.

Монте-Кристов гэртээ ирэхэд Моррель тэднийд ирсэн байв. Тэр бурхнаас тогтоосон цагаа болоход булшиндаа буцаж очих гэж байгаа хий үзэгдэл мэт үг дуу ч байхгүй тасалгаан дундуур хэсүүчлэн явж байв. Монте-Кристо инээмсэглэн,

- Максимилиан бэлтгээрэй, бид маргааш Парисыг орхин мордоно гэж хэлэхэд,
- Танд одоо энд хийх юм байхгүй юм уу? гСж Моррель асуулаа.
- Юу ч байхгүй. Дэндүү их юм хийчихсэндээ айж байна гэж Монте-Кристо хариуллаа.

15.МОРДСОН НЬ

‘үүлийн хэдэн долоо хоногт болсон явдлууд бүх Парисыг донсолголоо. Эмманюель, эхнэртэйгээ Меле гудамжин дахь зочдын бяцхан өрөөндөө сууж, гайхан ряилцаж байв. Морсер Данглар, Вильфорт гуравт тохиолдсон гэнэтийн гурван сүйрлийн хооронд ямар нэг холбоо байгааг мэдэрч тэр тухай шүүмжлэн хэлэлцэж байв.

Тэднийд ирсэн Максимилиан тэр хоёрын яриаг чагнан чухамдаа ярилцахад нь дэргэд нь байлцан, сүүлийн үед тогтсон хайнга байдлаараа сууж байв.

- Эмманюель аа, өчигдөрхөн тийм баян, тийм аз жаргалтай байсан хүмүүс эд хөрөнгө, аз жаргалаа бүтээхдээ суу санааны хувь тавилианд өргөл өгөхөө мартчихсан юм байх аа даа. Перрогийн үлгэрт гардагчлан хурим, наргиан дээрээ залаагүйн хариуд муу зүгийн шулам өшөө авахаар ирэхтэй адил юм болж байх шив дээ гэж Жюли хэллээ.
- Ямар айхтар сүйрэл вэ! хэмээн Морсер, Данглар хоёрын тухай бодон Эмманюелийн хэлэхэд, Валентинагийн тухай бодсон боловч ахыгаа байхад түүнийн хэрийг хэлж зүрхлээгүй Жюли,
- Ямар их уй гашуу вэ! гэлээ.
- Хэрэв тэднийг бурхан цээрлүүлж байгаа бол өнгөрсөн үеийнх нь явдлаас хөнгөвчлөх ямар ч шалтгаан ороогүй байх юм байх даа. Тэгэхээр эдгээр хүмүүс нүгэлт хүмүүс байж дээ гэж Эмманюель хэллээ.
- Эмманюель чи дэндүү зоригтой хэлж байна. Аав минь гартаа буу барьж байсан тэр цагт нэг хүн чам шиг “энэ хүн ингэх л үйлтэй хүн” гэж хэлбэл ташаарах байсан шүү дээ” гэж Жюли хэлэв.

- Авраам хүүгээ хохиролд учруулаагүйн адил бурхан манай аавыг үхүүлээгүй шүү ээ. Бурхан бидэнд үхлийг зам дээр нь зогсоох тэнгэрлэг хүүгээ ирүллсэн билээ.

Түүнийг дөнгөж ингэж хэлж гүйцтэл хонх дуугарлаа. Энэ бол хаалгач хүн ирснийг мэдэгдсэн дохио байв.

Бараг тэр дороо үүд нээгдэж Монте-Кристо гүн орж ирлээ.

Жюли, Эмманюель хоёр түүнийг баяртайгаар угтан авлаа. Максимилиан дөнгөж толгойгоо өндийлгөж харчхаад буцаад доошоо харчихлаа. Гүн түүний хайхрагуй байгаа байддыг мэдээгүй юм шиг дүр үзүүлж,

- Максимилиан, би таныг авахаар ирлээ шүү дээ гэж хэлэхэд,
- Намайг авахаар гэнэ ээ? гэж Моррель сэрсэн юм шиг асуув.
- Тийм ээ, чи надтай хамт явна гэж шийдсэн шүү дээ. Тэгээд таныг өнөөдөр бэлхэн байгаарай гэж хэлсэн билээ гэж Монте-Кристо хэлэхэд, Максимилиан,
- Би бэлхэн, эдэнтэй салах ёс гүйцэтгэх гэж орж ирсэн юм гэв.
- Гүн та хаашаа явах нь вэ? гэж Жюли асуув.
- Хатагтай минь эхлээд, Марсель орно.
- Марсель гэнэ ээ? гэж Жюли давтан асуув.
- Би танай ахыг хулнайлаад явлаа шүү дээ.
- Гүн та түүнийг эдгээгээд буцаагаарай гэж Жюли хэллээ.

Моррель улайсан царайгаа нуух гэж эргэн харав.

- Та түүнийг өвчтэй байна гэж бодож байна уу? гэж гүн асуув.
- Тийм ээ бидэнтэй уйтгартай байгаа байх гэж айх юм.
- Би түүнийг зугаацуулж өгөхийг л хичээе дээ гэж гүн хэллээ.
- Эрхэм минь би одоо бэлхэн байна. Хайрт та нар минь баяртай. Эмманюель минь баяртай! Гэж Максимилиан хэлэхэд, Жюли,
- Чи ингээд явчих гэж байгаа юм уу? Та хоёр одоо явчих гэж үү? Паспорт, юм чинь х ана байгаа юм бэ? гэлээ.
- Шууд салсан нь дээр байдаг юм. Мини гуйснаар Максимилиан бодвол юмаа бэлтгэчихсэн байх гэж Монте-Кристо хэлэхэд Моррель өнгөгүй тайван дуугаар,
- Паспорт бий. Юмаа бэлтгэчихсэн гэж хэллээ.
- Маш сайн. Цэргийн яг таг ёс гэдэг чинь энэ дээ гэж Монте-Кристо гүн инээмсэглэн хэлэхэд,
- Та биднийг ингээд л орхиод явах хэрэг үү? Бидэнтэй хамт ганц өдөр, ганц цаг ч болсон хамт байхгүй юм уу? гэж Жюли хэллээ.
- Хатагтай минь миний сүйх тэрэг үүдэнд хүлээж байгаа. Би тав хоногийн дараа Ромд байх ёстой.
- Максимилиан бас Ром руу явж байгаа юм уу? гэж Эмманюель асуухад, Максимилиан гунигтайгаар инээмсэглэн,
- Би гүнгийн хааш нь авч явсан ч тэр зүг рүү явна. Одоо бүтэн сар түүний мэдэлд байх болно гэж хэллээ.
- Гүн минь, яагаад үүнийг ийм гунигтайгаар хэлж байгаа юм бэ?
- Ах чинь надтай хамт явж байгаа болохоор, түүний төлөө санаа бүү зов гэж гүн зөөлнөөр хэлэхэд Максимилиан,

- Баяртай дүү минь! Баяртай Эмманюель минь! гэж дахин хэллээ.
- Түүний юм бүхэнд хайнга хайхрамжгүй болсныг харахаар зүрх минь хагарчих шахах юм. Максимилиан биднээс ямар нэг юм нуугаад л байх шиг байна! гэж Жюли хэлэхэд Монте-Кристо,
- Тэр та нар дээр баяхтай хөгжилтэй инээсээр орж ирэхийг та хоёр харна даа гэв.

Максимилиан Монте-Кристо өөд бараг уурлаж, жигшсэн байдалтай харлаа.

- За явъяа гэж гүн хэллээ.
- Гэхдээ таныг явахаас өмнө тэр удаа хэлж чадаагүй юмаа... хэлмээр бйна гэж Жюли хэлтэл гүн түүний араас барьж үгийг нь таслан,
- Хатагтай минь таны хэлэх гэж байгаа үг чинь таны зшрхнээс гарч надад харагдаж буй миний зүрх мэдрэн сонсож байгаагаас хавьгүй бага байх болно. Би роман зохиолд гардаг буян үйлдэгчдийн адил та нартай уулзахгүй явбал зохих байсан юм. гэвч би сул дорой, магтуулах дуртай хүн учраас буян үйлдэгч хүмүүсийн чинээнд хүчр чадахгүй юм. Би ойрхны хүмүүсийнхээ сэтгэл нь хөдөлсөн зөөлөн харцыг харахдаа баярладаг. Одоо би явлаа. Тэр ч байтугай би та нарт найз нөхөд минь намайг битгий мартаарай гэж хэлэх тийм биеэ тоосон хүн юм. Бид дахин хэзээ ч уулзахгүй байх даа гэлээ.
- Хэзээ чуулзахгүй байх гэнэ ээ! гэж Эмманюель дуу алдахад Жюлийн хацар дээгүүр том том нулимс бөмбөрч байв.
- Бид тантай хэзээ ч уулзахгүй хэрэг үү! Та чинь хүн биш харин сайх сайхныг бүтээх гэж газарт бууж ирсэн бурхан одоо буцаж тэнгэртээ гарах гэж байгаа хэрэг үү? Гэв.
- Тэгж бүү ярь. Найз нар минь хэзээ ч тэгж бүү яриарай. Бурхан бол ямар ч хорт үйлийг үйлдэхгүй, зогсох гэсэн газраа л зогсдог юм. Санамсаргүй явдал тэднийг захирдаггүй харин тэд санамсаргүй явдлыг захирч байдаг юм. Үгүй Эмманюель минь би бол ерийн хүн. Таны энэ шагшин гайхах чинь миний хэрээс хэтэрч байна гэж Монте-Кристо яаран хэллээ.

Тэгээд гүн аз жаргал шингэсэн тайван эхнийн энэ гэрийг орхин явахдаа харамсаж, гүйн ирж тэврүүлсэн Жюлийн гарт уруулаа наалдуулж нөгөө гараа Эмманюель өө сунгалаа. Дараа нь сонссон юм шиг гөлийн сууж байсан Максимилиан өөд толгой дохив.

- Ахыг минь буцаж баяр баясгалантай болгож өгөөрэй гэж Жюли хэлэхэд Монте-Кристо арван нэгэн жилийн өмнө хөлгийн эзэн Моррелийн тасалгаа руу ордог шатан дээр охины гарыг атгасан шигээ Жюлийн гарыг атгаж,
- Та Синдбад-Далайчинд итгэсэн хэвээрээ байна уу? гэж инээмсэглэн асуув.
- Тимй ээ.
- Тэгвэл өөр юуны ч тухай бодож гунихрах хэрэггүй. Бурхандаа итгээд л байж бай.

Бидний дээр хэлснээр, аяны тэрэг үүдэнд хүлээж байв. Дөрвөн омголон морь тогтож ядан газар цавчлан байв.

Али хол газраас гүйж ирсэн мэт хөлс нь гоожиж, амьсгаадчихсан шатны дэргэд зогсож байв.

- За яав? Чи өвгөн дээр очив уу? гэж гүн араб хэлээр асуухад Али толгой дохив.
- Чи миний хэлснээр захидлаа дэлгэж харуулсан уу? гэхэд боол толгой дхоилоо.
- Тэгээд тэр чамд юу гэж хэлэв? Чухамдаа чамд ямар дохио үзүүлэв?

Али эзэндээ сайн харагдахын тул гэрэл өөд эргэж Нуартье тийм гэж зөвшөөрсөн санагаа илчлэхдээ нүдээ аньдаг шиг өвгөнийг хичээнгүйлэн дуурайж дохилоо. Тэгэхэд нь Монте-Кристо,

- Маш сайн, тэр зөвшөөрчээ явцгаая гэж хэллээ.

Сайхь үгийг дөнгөж хэлмэгц морьд ухасхийн давхилдаж туурайнаас бөөн бөөн оч бадарна.

Максимилиан тэрэгний буланд шигдэж үг дуугүй явна.

Ингэж явсаар хагас цаг өгөртөл тэрэг гэнэт зогслоо. Гүн Алийн хуруунаас уясан торгон татуургаа тугтрахаа нуби хүн суудал дээрээсээ үсрэн бууж үүдийг нь онгойлгож өгөхөд гүн гарч ирлээ.

Одон мичид гялалзсан шөнө байлаа. Олон сая гэрэл дотор нь давалгаалан гялтганасан бараан тэнгис шиг Парис хотыг харж болох Вильжюиф хэмээх толгойн орой дээр Моние-Кристо гүн зогсжээ. Гүнгийн харж зогсон байгаа давалгаа бол үргэлжид мөргөлдөн, үргэлжид хөөсрөн, үргэлжид аюул тохиолдуулагч тайвшруулахыг үл мэдэгч их далайн давалгаанаас илүү ширүүн догшин өөрчлөгдөн хувирагч давалгаа юм.

Сүхй тэрэг гүнгийн дохиогоор хэдэн алхам урагшилж гүн ганцаар хоцров.

Монте-Кристо цээжиндээ гараа зөрүүлж, энэ оюун ухаан санаа, бодол бүхэн хайлж хатаагдаж, давтагдан цутгагдаж дэлхий дахиныг догдлуулдаг их аагийг удаан хөрж зогслоо. Дараа нь сайхь сайн санаат хүсэн мөрөөдөгчийг ч, ёжломтгой материалстуудыг ч гайхан шагшуулдаг Вавилоныг харж цадаад толгойгоо гудайлган залбирав.

- Их хот чиний газар дээр ирж гишгэснээс хойш хагас жил ч өнгөрөөгүй байна. Бурхны санаа зориг намайг нааш нь ирүүлсэн гэдэгт би итгэдэг, одоо би ялж дийлээд баяр ёслолын байдалтай чамайг орхин явж байна. Миний энд ирсний нууцыг би гагцхүү бурханд итгэн даатгасан юм. Тэр ганцаархнаа миний цээжин доторхийг уншсан. Би ямар ч өшөө хорсолгүй боловч харамссаар явж байгааг ч мэдэж байгаа. Би зөвхөн хувийн зорилгодоо надад олдсон хүч чадлыг ашигласан биш гэдгийг ганцхан тэр л мэднэ. Агуу их хот чиний дотроос би эрсэн зүйлээ оллоо. Тэвчээртэй уурхайчин шиг чиний хөрсийг ухаж дотроос нь хорон мууг оллоо. Одоо би хийх юмаа хийэ гүйцсэн. Миний гомдлын алийг ч өгч чадахгүй. Баяртай Парис, хагацъя! Гэж шивгэнэлээ.

Тэгээд шөнийн суу залийн харцаар уудам хөндийг тойруулан харлаа. Дараа нь гараараа духаа нэг илбэчихээд тэргэндээ суухад үүд нь хаагдаж тоос манаруулан дугуйгаа тачигнуулан толгойн нөгөө тал руу давхин алга боллоо.

Тэд ганц ч үг ярилцалгүй хоёр бээр газар явлаа.

Моррель бодолдоо автан суухад, Монте-Кристо түүнийг удаанаар ширтэн харж явав.

- Моррель, та надтай хамт явсандаа харамсаж байна уу? гэж гүн асуув.

- Үгүй гүн минь. харин Парисаас хагацна гэдэг чинь....
- Би таныг Парист аз жаргал хүлээж байгаа гэж бодсон бол тэндээс авч явахгүй байсан юм.
- Парист Валентина миний тайван нойрсож байгаа. Тэгэхээр Парисыг орхиж явна гэдэг бол түүнээсээ хоёр дахь удаагаа хагацна гэсэн үг.
- Максимилиан, бидний салж хагацсан нөхөд газар доор нойрсож байгаа биш харин бурхан тэнгэрийн хүслээр бидний зүрхэнд оршин байдаг юм. Бурхан тэднийг үүрд бидэнтэй хамт байлгахыг хүсэж байгаа юм. Надтай үргэлж хамт бахйдаг хоёр найз байдаг юм. Би тэр хоёрын нэгний нь ачийг амь насаараа нөгөөгий нь ачийг оюун ухаанаар хариулах ёстой. Тэдний сүнс миний зүрхэнд амьдарч явдаг юм. надад Сргэлзэх үе төрөхөд тэдэнтэйгээ зөвлөдөг бөгөөд хэрэв сайн сайхан юм бага зэрэг хийж чадсан бол гагцхүү тэдний зөвлөгөөний ачаар тэгсэн хэрэг. Моррель минь чи надтай ийм найрсаг биш байгаагийнхаа зөв бурууг зүрхнээсээ асууж түүний юу хэлэхийг сонс л доо гэж гүн хэлэхэд Максимилиан,
- Найз минь миний зүрх уй гашуугаар дүүрсэн учир надад зөвхөн зовлон зүдгүүрийг л өгч байна гэлээ.
- Зориг султай хүмүүс дандаа л гашуудлын хар хөшгийн цаанаас юмыг хардаг юм. Оюун ухаан өөрийн харах цэгийг өөрөө тогнтоодог бөгөөд таны оюун ухаан манан буданд бүрхэгдэж бүүдийсэн учир таны тэнгэрийг хар үүлээр бүрхүүлж байна.
- Таны хэлдэг үнэн ч байж магадгүй юм гэж Максимилиан хэлээд дахин бодлого болон суулаа.

Жуулчлал гүнгийн эрх мэдлийн хэрээр хурдан шалмаг гүйцэтгэгдэж байв. Тэдний замд дайралдах хотууд сүүдэр мэт хурдан жирэлзэн өнгөрнө. Намрын хонгор салхинд найган ганхсан ой модод тэднийг угтан давхих мэт жирэлзэн, эгшин зуурын дотор алга болно. маргааш өглөө нь Шалонд хүрэлцэн ирэхэд гүнгийн уурын хөлөг онгоц хүлээж байв. Жуулчид онгоцон дээрээ гарч тэргээ ачив.

Уурын онгоцыг түргэн явахад зориулан хийжээ. Онгоц энэтхэг суман завийн хэлбэртэй бөгөөд хоёр хүрд нь далавч адил, усан дээгүүр хөвөн явах нь усны шувуу мэт. Энэ хурлан хөдөлгөөн Моррелийг ч сэргээж, тархин доторх хар үүлийг нь хөөн зайлуулчих шахаж байв.

Парисаас холдох тусам гүнгийн царай тунгалаг болж байв. Эх орондоо буцжа ирж яваа цөлөгдсөн хүмүүс мэт байлаа.

Удалгүй тэдний өмнө Тир, Карфаген хоёрын дүү, Газрын дундад тэнгис дэрх тэдний үе за«гамжлагч болох дүүрэн амьдралтай, нүдэнд дулаахан Марсель хот харагдлаа. Марсель хот нас нь явах тутам улам залуужиж байв. Тэр хоёрт хоёуланд нь дурсан санах зүйл байсан бөгөөд хэн хэний нь тоглож өссөн дугариг цамхаг, гэгээн Николай цайз, чулуун хашлагатай онгоцны зогсоол, хотын захиргааны байшин харагдлаа.

Тэр хоёрын санал нийлж Каннебьер гудамж өөд гарлаа.

Нэгэн онгоц Алжир орох замаар гарч бөйгаа харагдлаа. Онгоцны тавцан дүүрэн хүмүүс, үдэн гаргаж байгаа төрөл садан, найз нөхдийн салах ёс гүйцэтгэх, дуу алдах, уйлах энэ бүхэн сэтгэлийг үргэлжид хөдөлгөх бөгөөд ийм үзэгдлийг өдөр бүр үзэж суудаг хүний ч сэтгэлийг дэнслүүлнэ. Гэвч энэ бүхэн Максимилианыг эргийн том

чулуун дээр гишгэсэн тэр минутаас эхлэн орж ирсэн бодлоос нь ангижруулж чадсангүй. Тэгээд Монте-Кристо гүнгийн гараас сугадан,

- Хараач, “Фараоныг” буудалд орж ирэхэд эцэг минь тэнд зогсож байсан сан. Үхэл гутамшгаас таны аварсан тэр үнэнчийн үнэнч хүн намайг энд тэврэн авсан сан. Хацар дээр минь нулимс нь хүрсэн газар одоо хүртэл нойтон оргих шиг санагдаж байдаг юм. Тэр ганцаараа ч уйлаагүй, олон олон хүн биднийг харж уйлу байсан сан гэв. Монте-Кристо инээмсэглэн,
- Би тэнд зогсож байсан гэж хэлээд нэгэн гудамжны булан заав. Ингэж хэлж дуусаагүй байтал заасан зүгт нт нэгэн хүн гиншин дуугарахыг сонслоо. Тэнд нэгэн эмэгтэй хөдөлж байгаа онгоцонд суусан хүн өөд гараа даллаж байв. Тэр хүүхэн гивлүүр унжуулжээ. Моррель онгоц өөд хараагүй байсан сан бол Монте-Кристовийн сэтгэл хөдөлж байхыг ажиглан харахгүй байж чадахгүй байсан юм.
- Хараач! Онгоцон дээр зогсож гараараа даллан байгаа цэрэг хувцастай хүн чинь Альбер де Морсер байна шүү дээ гэж Моррель дуу алдахад, Монте-Кристо гүн,
- Тийм байна, би ч бас танилаа гэв.
- Яалаа гэнэ ээ? Та чинь өөр тийшээ харж байсан шүү дээ.

Гүн хариулах дургүйгээ хүрэхээр инээмсэглэдэг шигээ инээмсэглэв. Тэгээд адхин нүүрээ бүтээсэн хүүхнийг харахад цаадах нь булан тойрч алга боллоо.

Тэгэхэд гүн Максимилианаас,

- Найз минь энд танд ямар нэг ажил байхгүй юу? гэж асуулаа.
- Би эцгийнхээ булшин дээр очно гэж Моррель аяархан хариулав.
- За сайн, тэгвэл яваад тэнд намайг хүлээж байгарай. Би хүрээд очно.
- Та явах нь уу?
- Тийм ээ... би нэг ариун газар очно.

Моррель гүнгийн гарыг сулхан атгаж толгойгоо дохиод хотын зүүн хэсэг өөд алхлаа.

Монте-Кристо гүн Максимилианыг далд орохыг хүлээн зогсож байгаад бид туужийнхээ эхэнд уншигчдынхаа танилцуулсан тэр нэгэн төвхөн байшин байдаг Мцльяны модот гудамж өөд явлаа.

Мареслийнхны зугаалах газар болсон модот гудамж энэхүү байшинг халхална. Байшингийн эргэн тойронд зэрлэг усан үзмийн мод ургаж, мушгиралдсан ишээрээ өмнөдийн нарны хурц илчинд шарласан чулуун хананд нь н алдана. Намрын чийг тунадас унаж хагсаа нь гарч дахин нийлэхийг тэсвэртэйгээр хүлээн жилээс жилд улам засвар гарч байгаа гурван банзаар хийсэн орох хаалга өөд харсан элэгдсэн хочр чулуун шаттай ажээ.

Байшин хэдийгээр өмхөрч муудсан ч гэсэн харахад сайхан, царай муутай ч гэсэн хөгжилтэй юм. Энэ байшин бол нэгэн үед өвгөн Дантесийн сууж байсан байшин юм. Өвгөн дэврийн хөндийн ганц өрөөг эзэлж байсан бол гүн бүх байшинг Мерседесийн мэдэлд өгчээ.

Онгоцны зогсоол дээр Монте-Кристовийн харсан өнөөх урт гивлүүртэй хүүхэн байшинд орлоо. Гүнг булан тойроод гараад ирэхэд өнөөх хүүхэн орж хаалга хааж байв. Ингэж гүн түүнийг дахин далд орчихоос нь өмнө харж амжжээ.

Гүн тэрхүү элэгдсэн гишгүүрийг сайн таних бөгөөд далбагар толгойтой хадаасаар онгойлгодог хаалганы нь түгжээг сайн мэддэг байв.

Тийм учраас хаалга цохиж ирснээ ч мэдэгдэлгүй гэрийн эзэн буюу сайн найз шиг орж очив.

Байшингийн цаад талд нарны илч туссан бяцхан цэцэрлэг байсан бөгөөд хорин дөрвөн жилийн өмнө гүнгийн булж хадгалсан мөнгийг Мерседес олж авчээ. Орох хаалганы босгон дээрээс цэцэрлэгийн захын мод харагдана.

Монте-Кристо босгыг алхаж ороод мэгшин уйлах мэт санаа алдах чимээг сонсов. Тэгээд чимээ гарсан зүг өөд харвал урт улаан цэцэгтэй, өтгөн навчит мэлрэгийн бутан дотор Мерседес суугаад уйлж байхыг харлаа.

Мерседес гивлүүрээ өргөөд нүүрээ гараараа дарж хөх цэнхэр тэнгэрийн дор орь ганцаараа гэж бодон хүүгийнхээ байхад тэсвэрлэн байсан нулимсаа дураар нь тавьж уйлан хайлж байв.

Монте-Кристо хэд алхвал хөл доор нь мөчир тасхийв.

Мерседес толгойгоо өндийлгөн айсан янзтай дуугарлаа.

- Хатагтай минь, би танд аз жаргалыг өгөх мэдэл алга, гэвч таныг тайвшруулахыг хүслээ. Та үүнийг минь танил найзаа гэж бодон хүлээн авна уу? гэж гүн хэлэхэд Мерседес,
- Тийм ээ би их золгүй хүн юм. Энэ ертөнц дээр би ганцаараа хүн... Надад ганц хүү байсан минь намайг орхид явчихлаа гэв.
- Тэр явсан нь сайн болжээ. Тэр чинь ариун сэтгэлтэй хүн. Хүн бүр эх орондоо нэг сайн юм хийх ёстой гэдгийг ойлгожээ. Зарим нь авьяас билгээ зориулдаг, зарим нь хөдөлмөрөө өгдөг. зарим нь нойр хоолгүй зүтгэж байхад зарим нь цусаа асгаруулдаг юм. Тэр тантай энд байвал ашиггүй болсон амьдралаа үрж, таны зовлон зүдгүүртэй эвлрэнэ сууж чадахгүй байсан юм. Зүгээр суувал улам доройтон ядрах болно. Харин Зовлон зүдгүүртэйгээ тулалдаж тэмцэлдэж амжилт гаргаж чадвал чадалтай хүчирхэг болно. Хатагтай минь та өөрийнхөө ба таны ирээдүйг бүтээн босгог. Аз жаргал чинь итгэлтэй гарт байгаа гэдгийг танд хэлье гэж гүн хэллээ.
- Таны тэр зөгнө хэлж, түүнд минь бэлэглэн өгөөсэй гэж бурханд миний залбирч байгаа аз жаргалыг би амсан эдэлж чадахгүй байх гэж хөөрхий авгай гунигтайгаар хэлээд – Миний дотор ба орчин тойронд бүх юм эвдэрч булшны зах дээр байгаа юм шиг ханагдаад байх болж дээ. Гүн та намайг аз жаргалтай байсан энэ газартаа хүрч ирэхэд тусалсан нь сайн хэрэг. Аз жаргалтай байсан газраа үхэх хэрэгтэй юм гэлээ.
- Таны үг чинь миний зүрхийг төөнөж, намайг шударгаар үзэн ядах бүрд чинь улам хүчтэй болж байна. Би таны бүх зовлон зүдгүүрийн буруутан. Та намайг зэмлэхийн оронд яагаад өрөвдөж хайрлаж болдоггүй юм бэ? Тэгсэн бол та намайг улам өвтгөн зовоох байсан юм... гэж Монте-Кристог хэлтэл,
- Эдмон, таныг үзэж ядаж, буруутан зэмлэх гэнэ ээ? Миний хүүгийн амийг хайрлан үлдээсэн хүнийг үзэн ядаж зэмлэх үү? Гэвч та де Морсерыг бардамнаж бахархдаг байсан хүүгээс нь хагацаах хатуу сэтгэл өвөрлөж байсан нь үнэн. Намайг хар л даа. Миний нүүр дээр өчүүхэн боловч зэмлэсэн шинж байна уу? гэж Мерседес асуув.

Гүн өөдөө харж, хоёр гараа сунган зогсож байгаа Мерседесийг харав.

- Намайг хар л даа, өвгөн эцгийнхээ өрөөний цонхон дээр хүлээн зогсож байдаг Эдмон Дантесдаа инээмсэглэн хүрч ирдэг тэр цагийн гоо үзэсгэлэн, нүдний минь гал унтарчихсан... Түүнээс хойш уйтгарт олон өдрүүд өнгөрч, тэрхүү өнгөрсөн үе бид хоёрын хооронд гүн ангал ухан гарчээ. Эдмон таныг үзэн ядаж, өөрийгөө зэмлэн буруутгаж байна! Бүхэнд би буруутан. Надад итгэл, хайр сэтгэл, бүрэн бүтэн бие цогцос гэдэг бурахн тэнгэрээс заяасан гурван чанар байсан боловч золгүй амьтан би бурханд сүсэг алдаж байсан байна.

Монте-Кристо юу ч хэлсэнгүй түүнд гараа сунгав.

- Үгүй! найз минь гэж хатагтай гараа татан анмуухан дуугаар хэлээд – Надад гараа бүү хүрэг. Та намайг өрөвдсөн. Таны цээрлүүлж өшөөгөө авсан хүмүүсийн дотроос би л ганцаараа хайр энэрэл хүлээхгүй хүн байсан юм. Ббусад хүмүүс бол үзэн ядах, хувиа хичээх үзлэс тэгсэн байхад, би бол чин сэтгэлийг эс барьснаас тэгсэн байна. Тэдэнд зорилго байсан бол, харин би зүгээр л айчихжээ. Үгүй, Эдмон минь миний гарыг бүү атга. Та надад сайн сайхан үг хэлэх гэж байх шиг байна. Хэрэггүй. Өөр тэнцэх хүндээ хэл дээ. Хар л даа. \авгай гивлүүрээ авч хаяв\ уй гашуугаас болж үс минь бууралтчихлаа. Өчнөөн их нулимс гарч зовхи минь хөхөрч дух миний үрчийлээ. А, харин Эдмон та залуу сайхан хэвээрээ байна. Энэ бол та итгэлтэй, зоригтой, бурханд итгэж байсан учир бурхан таныг дэмжсэнээс болжээ. Харин би бол өчүүхэн сэтгэл гаргасан юм. Тэгэхээр бурхан намайг орхиж, би ийм болчихжээ гэв.

Мерседес тэгшин уйлж, өнгөрснөө дурсан бодохоос зүрх нь хагарчих шахан байв.

Монте-Кристо түүний гарыг барьж хүндэтгэн үнэсэв. Гэвч гантиг баримлын гар үнэсэж байгаа юм шиг ямар ч гал дөлгүй байгааг мэдэрлээ.

- Хамгийн түрүүчийн нь алдаа бүх ирээдүйг нь эвдэж орхидог золгүй амьтан байх юм. Би таныг үхсэн гэж бодож байна, өөрөө ч бас үхэх хэрэгтэй байжээ. Зүрх сэтгэл дотроо таныг дурсан санаж уйлан хайлж явсны минь ашиг юу байна? Гучин есөн насандаа эмгэн боллоо. Энэ л байна даа. Бү бүхний дотроос ганцаараа таныг таниад хүүгээ аварсны ашиг юу байна? Ямар ч Ёх буруутай байсан нөхрөө гэж сонгож авсан хүнийхээ амийг аврах ёсгүй байсан гэж үү? Харин тэгэхэд би түүнийг үхүүлчихлээ. Түгээр зогсохгүй! Тэр ганцхан надаас л болж тангаргаа зөрчигч, урвагч болсон тухайг нь бодолгүй сэтгэлгүй зан гаргаж, жигшин үзсэнээр түүний үхлийг түргэтгэв. Би хүүгээ үхлийн орон бослон Африкт ганцааранг нь явуулах байсан бол наашаа хамт ирэх хэрэг юу байна. Би өчүүхэн сэтгэлтний амьтан байжээ! Би хайр дурлалаасаа ухран буцаж, ер нь л буцан шантрагчдын адилаар ойр орчныхондоо гай зовлон авчирч байна.
- Үгүй, Мерседес та өөрийгөө ийм хатуу ширүүн зэмлэх ёсгүй. Та бол гэгээн сайхан эмэгтэй. Өөрийнхөө уйтгах гунигаар намайг зэвсэггүй болголоо. Гэвч миний ар талд намайг ирүүлсэн үл үзэгдэгч уур хилэнт, бурхан зогсож, миний буулгасан аянгыг зогсоохыг хүзсэхгүй байв. Би танд зориулж амь насаа, түүний хамт бүх санаа бодлоо зориулан хохироход

бэлэн байсныг өдөр бүр залбирдаг бурхан гэрчлэх байх. Гэвч би бурханд хэрэгтэй байсан учир тэр надад амьдралыг минь буцааж өгсөн вч гэдгийг танд бахархан ярьж байна. Өнгөрсөн, доогоо ухааран бодож, ирээдүйгээ тааварлан мэдэхийг оролдож үзээд, намайг дээд тэнгэрийгн зэвсэг мөн үү гэдгийг хэл л дээ! Хайрлаж дурлаж байсан хүндээ мартагдан агаар, эрх чөлөө, баялаг гэдгийг мэдэхгүй хамгийн аймшигтай зовлон зүдгүүр дунд амьдралынхаа хагасыг өнгөрүүлсэн билээ. Гэтэл ийнхүү ганцаардан тарчилж байснаа гэнэт эрх чөлөө, баялгийг олж авлаа. Бурхан их үйл үйлдүүлэхээр ирүүлсэн гэж санагдах нүд гялбам асар их баялгийг эзэмшлээ. Тэр цагаас хойш би энэ их баялгийг үйл зорилгод нь зарцууллаа. Би амарч тухлахыг мэдэхээ байв. Ямар нэг хүчин намайг урагш түлхэж байв. Би бурхны хараал хүрсэн хотыг үнсэн товрог болгохын тулд тэнгэрээр хөвөн яваа галан үүл шиг байлаа. Аймшиггүй зоригт ахмадууд аймшигт аянд явахын тулд хөлөг онгоцоо бэлтгэдгийн адил би бэлтгэн, хүнсээ цуглуулж, зэв зэвсгээ базаан бие цогцсоо хүнд шалгалтад дасган, оюун ухаанаа хамгийн хүнд донсолгоонд сургаж, гараа хүн алж чадах болгож, нүдээ ямар ч зовлон зүдгүүрийг харах чадвартай болгож, ямар ч аймшигтай юм үзсэн уруулаа инээмсэглэн байж чадах болгож сурган дасгасан билээ. Би сайн санаатай итгэмтгий, хорт муу санаа гэдгийг мэдэхгүй хүн байснаа өширхөг, хорт муу санаатай, аймшиггүй хүн болж хувирсан юм. Тэгээд би бэлтгэсэн замдаа гарч, уудам зайг туулан зорьсондоо хүрэв. Миний замд дайралдсан бүрэнд зовлон тохиолдож явлаа.

- Боллоо, боллоо, Эдмон! Би ганцаараа таныг таньж чадсан болохоор бас таныг ойлгож чадсан юм. Би таны замд дайралдан шил сав шиг ниргүүлсэхсэн байлаа гэхэд би өөрийг чинь бахдан бишрэхгүй байж эс чадахсан. Бид хоёрын хооронд гав ангал байгаагийн адил бас бусад хүн таны хооронд тийм зааг байна. Таныг бусадтай зүйрлүүлэн үзэхэд сэтгэл улам их харлах юм. Энэ ертөнц дээр тантай тэнцэх, тантай адилтгах хүн алга, Эдмон, одоо надтай ʘалах ёс гүйцэтгээрэй. Бид одоо магацъя даа гэж Мерседес хэллээ.
- Хагацахын өмнө танд ямар тус хүргэж болохыг хэлж өгнө үү? Мцрседес ээ? гэж Монте-Кристо асуулаа.
- Эдмон, би ганц л юм хүсэж байна. Миний хүү л аз жаргалтай яваг.
- Хүмүүсийн амь насыг гартаа атгаж, тэднийг үхлээс холдуулжэ чаддаг бурханд л сайн мөргөж бай. Бусдын нь тухай би санаа тавъя.
- Баярлалаа. Эдмон.
- Мерседес та өөрөө?
- Надад юу ч хэрэггүй. Би хоёр булшны хооронд амьдарна. Нэг нь талийгаач болсон Эдмон Дантесын булш, би түүнд дурлаж байсан юм. Энэ нэрийг миний өнгөгүй болсон уруул дуудан нэрлэхээ больсон боловч зүрх минь юу ч мартаагүй бөгөөд, зүрхний энэ дуртгалыг ямар ч сайн сайхан зүйлээр солихгүй юм. Нөгөөх нь булшинд нь Эдмон Дантесын алсан хүн хэвтэж байна. Ингэж алсан явдлыг би зөвтгөх боловч тэрхүү алагдсан хүний төлөө залбирч маань унших ёстой.
- Таны хүү чинь аз жаргалтай явах болно гэж гүн давиан хэллээ.

- Тэгвэл би ч болохынхоо хэрээр аз жаргалтай явах болно.
- Гэсэн ч та яаж амьдрах юм бэ?

Мерседес гунигтайгаар инээмсэглэлээ.

- Би энд урьдын Мерседес шиг хөдөлмөрөөр амьдарна гэж хэлбэл та үнэмшихгүй. Би одоо зөвхөн залбирал уншихаас өөр юм чадахгүй. Тэгээд ч надад ажил хийх ч хэрэгцээ алга. Таны хадгалсан хөрөнгийг заасан газраас чинь олж авсан. Хүмүүс намайг хэн болох, юу хийж, ямар мөрөнгөөр амьдарч байгааг сонирхох байх даа. Энэ ч ямар хамаа байх вэ! Энэ бол зөвхөн бурхан та бид гуравт хамаалай юм.
- Та Морсер гүнгийн олсон хөрөнгө буюу хагас нь танд ногдох байсан тэр хөрөнгөнөөс авахгүй гэж татгалзсан чинь буруу хэрэг болсон юм гэдгийг хэлэх хэрэгтэй байна.
- Би таны юу гэх гэж байгааг тааварлан мэдэж байна. Эдмон, миний хүү түүнийг зөвшөөрөхгүй.
- Тийм учраас би Альберын зөвшөөрлийг авахгүйгээр таны төлөө юу ч хийж зүрхлэхгүй байна. Би түүний хүслийг мэдэж байгаа болохоор түүнд захирагдана. Гэхдээ миний хийх гэж байгаа юмыг тэр зөвшөөрвөл та зөрөхгүй биз дээ?
- Би ямар нэг юмыг ухааран хэлэлцэх чадваргүй болсон гэдгийг Эдмон та мэдэх ёстой. Би хэзээ ч юу ч шийдвэрлэхгүй гэдэг ганцхан юмнаас өөр зүйлийг шийдвэрлэж чадахгүй. Бурхан тэнгэр миний зоригийг мохоох шуурга илгээсэн юм. Би түүний гарт бүргэдийн саварт баригдсан болжмор шиг хүчгүй амьтан. Би амьд байгаа нь түүний л санаа зориг юм байх.
- Хатагтай минь болгоомжлоорой, бурхан тэнгэрт тэгж захирагддаггүй юм! Бурхан бол санаа бодлыг нь зөв ойлгож түүний хүчирхэг чадлыг зөв хүлээн авахыг шаарддаг юм. Ийм учраас л бурхан бидэнд чөлөөтэй эрх зоригийг өгсөн юм гэж Монте-Кристо хэлэхэд,
- Үгүй. Тэгж битгий ярь. Хэрэв бурхан надад чөлөөтэй зоригийг өгсөн бол би арга барагдсан гунихралаас аврагдах байх гэж бодох уу? гэж Мерседес дуу алдлаа.

Монте-Кристогийн царай бага зэрэг зөвхийж, энэ гашуун зовлонгийн хүчинд дарагдан толгойгоо бөхийлгөлөө.

- Та надад дараа баяртай гэж хэлэхгүй юм уу? гэж гүн түүнд гараа сарвайн хэлэхэд, Мерседес дээд тэнгэр өөд харж,
- Харин би танд дараа баяртай уулзъя гэж хэлэх гэж байна. надад бас найдлага горьдлого байгааг та харж байгаа биз гэлээ.

Тэгээд Мерседес чичирсэн гараараа гүнгийн гарыг атгаад шатаар өгсөж алга боллоо. Монте-Кристо байшингаас аажуухан гарч онгоцны зогсоолын зүг явлаа.

Мерседес өвгөн Дантесын өрөөнд зогсон харж байсан боловч түүний хаагуур далд орсныг харсангүй. Авгай, хүүг нь аваад явж байгааг хөлөг онгоцыг харж зогслоо.

Харин түүний уруул нь дөнгөж дуулдахаар,

- Эдмон, Эдмон хэмээн өөрийн эрхгүй шивгэнэж байв.

16.ӨНГӨРСӨН ҮЕ

Гүн зүрхэндээ гунигтайгаар сүүлчийн удаа ч уулзаж байж магадгүй Мерседесийг орхиж байшингаас гарч явлаа.

Бяцхан Эдуардыг үхсэнээс хойш Монте-Кристо хачин их өөрчлөгджээ. Өшөө хосрлоо авах урт удаан, мурий тахир замаар явж оройд нь гарчихаараа, гүнд гэнэт эргэлзэх сэтгэл төржээ.

Түүнээс гадна Мерседестэй ярьсан ярьа нь түүний бүтээх гэж хүсэн мөрөөдөж байсан тэр зүйлүүдийг санагдуулна.

Монте-Кристо бол удаанаар бодолд автан дүнхийж явдаг хүмүүсийн нэг биш ээ. Энэ нь жирийн нэг хшнд хэрэгтэй байдаг боловч, хүнээс онцгой сэтгэлийн тэвчээртэй хүнд муу нөлөө үзүүлнэ. Гүн мяар нэг юманд эргэлзэхэд хүрвэл, тооцоонд нь ямар нэг алдаа байжээ гэж үздэг хүн юм.

“Би өнгөрсөн үеийн явдлын тухай буруугаар шүүн бодож байж. Ийм бүдүүлгээр алдахгүй байх ёстой. Би өөртөө учир ухаангүй зорилго тавилаа гэж үү? Би бүтэн арван жил буруу замаар явлаа гэж үү? Уран барилгач хүн өөрийн итгэд найдварыг оруулж бүтээсэн зүйлээ бололцоогүй юм гэдгийг ганцхан цагийн дотор итгэн мэдэхэд өөрт нь ямар байх вэ?

Би тэгж бодох болохгүй. Ийм бодол намайг солиоруулчихна. Би өнгөрсөн үеэ дэндүү холоос харж байгаа болохоор надад хуурамч өнгөтэй харагдаж байна. Урагшаа явах тусам өнгөрсөн үе байгалийн зураглал шиг хажуугаар өнгөрөн холдож байна. Би зүүдэндээ өөрийгөө шархдуулж, цус гарч, өвдөж байгаа шиг санагдах боловч энэ шархыг яаж олсноо санахгүй байна.

Баян чинээлэг, бүхнийг харагч, бүрэн хүчирхэг сая хөрөнгөтөн чи эгшин зуурын дотор өрөвдмөөр өлсгөлөн амьдралд орж хувь заяа чинь намайг аваачиж зогсоосон тэр зам дээрээ гараад үз л дээ. Монте-Кристо гүн Дантесыг харж байгаа тэр толинд дэндүү их очир эрдэнэ, алт сувд гялалзан гялтганаж байна. Энэ очир эрдэнийг далд хийж, алт сувдын өнгийг дараад, гэрэл гэгээгийн нь арчаад үз. Баян хүн ядуу байснаа сана. Эрх чөлөөт хүн хоригдол байснаа сана. Дахин босож ирсэн хүн үхдэл байснаа сана” гэж Монте-Кристо өөрөө өөртөө хэлж байв.

Монте-Кристо ийнхүү болсоор Кессри гудамжаар явлаа. Энэ бол хорин дөрвөн жилийн өмнө түүнийг дуу шуугүй цагдаа тууж явсан гудамж билээ. Хөгжил хөдөлгөөтэй байгаа энэ байшингууд тэр шөнө харанхуй, чимээ аниргүй байж билээ.

- Энэ бол тэр л байшингууд байна. тэгэхэд шөнө байсан. Одоо бол гэгээн цаг ан өдөр байна. Наран бүхнийг гийгүүлж бүгдийг баярт царайтай болгож байна.

Тэр Сен-Лоран гудамж уруудаж, эргийн дагуу явсаар усан онгоцны буудлын захиргааны дэргэд очлоо. Тэгэхэд түүнийг эндээс завинд суулгаж байсан билээ.

Хажуугаар нь зотон сүүдрэвч бүхий завь хөвөн явахад Монте-Кристо завчинг дуудлаа. Цаадах нь муугүй гар цайлгах хүн таарсныг тааварлан дорхноо ирлээ.

Тэнгэр сайхан, зугаалахад тааламжтай байлаа. Шингэж байгаа наран тэнгэрийн хаяа руу бууж, тэнгисийн давалгааг улаан дөл мэт болгоно. Толь шиг төвшин тэнгисийн мандал жирэлзэн долгилох бөгөөд энэ нь бяцхан загас ямар нэг үл үзэгдэх дайснаас зугтан амь хоргодох газраа эрэн давхиж яваа нь ажээ. Мартиг орохоор явж байгаа цахлай шувуу шиг загасны цагаан завинууд, Корс ба Испани орох ачаа ачсан хөлөг онгоцууд алсад хөвөн яваа харагдана.

Гэвч гүн үүлгүй тэнгэр, усан дээгүүр хөвөн яваа завиуд, бүхнийг гийгүүлж байгаа алтан өнгөт гэрлийг үл анхаарна. Харин цуваараа ороож аваад өнгөрүүлсэн амьдралаа бодон явав. Каталанд гэрэлтэй байсан ганц гэрэл, түүнийг хааш нь авч яваа чигийг заагч Иф цайзны аймшигт дүр, тэнгис руу үсрэн орох гээд цагдаа нартай тулалдсан, тэгээд дийлдсэнээ мэдэрсэн чамархайд нь бууны хүйтэн ам тулгасан зэрэг санагдлаа.

Зуны халуунд хатаж шиггэсэн горхи намрын хур бороо ойртон ирэхийн зэрэгцээгээр чийг ус нь дусал дуслаар нэмэгдэн нэмэгддэгийн адил тэр нэгэн цагт Эдмон Дантесын зүрхийг дүүргэж байсан хор шар аажим аажмаар түүний цээжинд шүүрэн орж ирэхийг Монте-Кристо гүн мэдэрч байв.

Тэр минутаас хойш түүнд тунгалаг тэнгэр, хөнгөн завь, алтны туяа алга болон замхарчээ.

Тэнгэр гашуудлын үүлээр бүрхэж, Иф цайз хэмээх аварга нүдний нь өмнө босож ирэхэд, тэр үхлийн дайсныхаа хий дүрсийг харсан мэт сочиж татвасхийлээ.

Тэд зорьсон газартаа хүрлээ. Сэлүүрчин хамгийн эелдэг сайхан дуугаар бид хүрч ирлээ гэж хэлсэн боловч гүн өөрийн эрхгүй ухарч завины буланд очлоо.

Яг энэ хадархаг зөргөөр түүнийг хурц жадны үзүүрээр хатгачин явсныг Монте-“Кристо санав.

Тэр нэгэн цагт энэ зам Дантест зах хязгааргүй мэт санагдаж байжээ. Гэтэл Монте-Кристорд энэ зам маш богинохон санагдана. Сэлүүрчин сэлүүрдэж ус үсрэх бүрд сая сая санаа бодол, дурдигал төрнө.

Долдугаар сарын хувьсгалын үеэс хойш Иф цайз гяндан байхаа больж, контрабандистууд хэмээх хил зөрчин худалдаалагдчаас сэргийлэн хянах харуулын газар болжээ. Одоо үзмэрийн газар болж хувирсан энэ аюултай орны дурсгалыг үзэхээр ирэх хүмүүсийг хүлээж хаалгач харуулдан зогсоно.

Монте-Кристо гүн энэ бүгдийг мэдэж байсан боловч ийшээ орж харанхуй шатаар уруудан, газар доор оруулахад нүүр нь зэвхий цайж зүрхэнд нь хүйт оргих шиг болжээ.

Дахин сэргэлтийн үеийн хуягуудаас үлдсэн хүн бий юу? гэж гүн асуулаа. Гэвч цөм тэтгэвэрт гарсан буюу өөр ажил хийж байгаа ажээ.

Түүнийг дагуулж орсон хаалгач зөвхөн 1830 оноос эхлэн энд ажиллаж байгаа гэнэ.

Түүнийг өөрийнх нь байсан өрөөнд дагуулж орлоо.

Тэр салхивчны нүхээр орж ирж байгаа бүдэг гэрэл, ор байсан газар, мөн ширээт лам Фариагийн ухаж гаргасан нүхийг бөглөж хийсэн чулуу тодхон харагдаж байв.

Монте-Кристоргийн хөл нь нугарах шиг боллоо. Тэгээд модон сандал авч суулаа.

- Хэрэв Мирабог тооцохгүй бол энэ цайзад хоригдож байсан хоригдлуудын тухай юу гэж ярилцдаг вэ? Хүн хүнийгээ энд түгжин мартаж болно гэж бодохын аргагүй энэ харанхуй гяндангийн тухай ямар нэгэн домог яриа байдаг уу? гэж гүн асуухад
- Бий, яг энэ өрөөний тухай шоронгийн хяуг байсан Антуан надад нэг зүйл ярьж өгсөн юм гэж хаалгач хэллээ.

Тэгэхэд Монте-Кристо гүн цочих шиг болжээ. Энэ Антуан гэдэг нь түүний хуяг байсан байжээ. Гүн түүний царай зүс ба нэрийг барга мартжээ. Гэвч нэрийг нь хэлэнгүүт түүнийг амьдаараа байгаа юм шиг санагджээ. Сахалтай нүүр, бараан цамц, хэлхээтэй түлхүүрээ дуугарган алхаж явах нь түүнд харагдах шиг болжээ.

Хаалгачийн барьж байгаа бамбарын гэрэлд улам ч баргар болон харагдаж байгаа гудмын гүн дотор Антуан зогсож байх шиг санагдаад гүн эргэж харав.

- Хэрэв таныг хүсвэл би ярьж өгөх үү? Гэж хаалга хэлэхэд,
- Тэг, тэг, ярьж аль гэж Монте-Кристо хариу өгүүлэв. Тэгээд өөрийнхөө тухай туужийг сонсохоор айн бэлтгэж зүрхнийхээ цохилтыг дарж намтгахаар цээжиндээ гараа зөрүүлэн зогсоод,
- Ярь, ярь гэж давтан хэлэв.
- Олон жилийн өмнө юм байх аа, яг энэ өрөөнд маш аюултай, хамгийн гол нь ширүүн догшин хэрэгтэн хоригдож байжээ. Мөн тэр жилүүдэд энд бас нэг лам хоригдож байжээ. Харин тэр нь номхон дөлгөөн хүн байж гэнэ. Тэгээд тэр хөөрхий амьтан солиорчээ.
- Солиорсон гэнэ ээ? Юу гэдэг байсан юм бэ?
- Тэр суллан гаргасан хүнд сая сая хөрөнгө өгнө гэдэг байжээ.

Монте-Кристо тэнгэр өөд харсан боловч тэр нь харагдсангүй. Тэнгэр тэр хоёрын хооронд чулуун хана байлаа. Ширээт ламын олон саяыг өгөх гэж хэлж байсан хүмүүсийн нүд ба эрдэнэсийн сангийн хооронд багагүй халхавч саад байсныг бодов.

- Хоригдлууд хоорондоо уулзаж болдог байсан юм уу? гэж Монте-Кристо асуув.
- Үгүй эрхэм минь, үүнийг хатуу хориглосон байсан юм. гэвч тэр хоёр хориглолтоос гадуур тасалгааныхаа хоорондох ханыг цөм цохиж нүх гаргажээ.
- Тэдний хэн нь нүх гаргасан юм бол?
- Мэдээжийн хэрэг, залуу нь байхгүй яах вэ. Тэр залуу хүч чадалтай хүү байсан, харин хөөрхий ширээт лам бол өвгөрч хөгширсөн, тэгээд ухаан нь будилчихсан хүн байжээ.
- Сохор амьтад! Гэж Монте-Кристо шивгэнэв.
- Залуу нь нүх гаргасан гэж ярилцдаг юм. юугаар гаргасныг нь бүү мэд. Ямар ч л гэсэн нүх гаргасан байсан юм. Тэр хараач, одоо ч гэсэн мөр нь харагдаж байна гэж хаалгач үргэлжлүүлэн ярив.

Тэгээд бамбараа хананд ойртуулав.

- Тийм байна, харж байна гэж гүн сэтгэл нь хөдөлсөн бүдэг дуугаар хэллээ.
- Дараа нь тэр хоёр бие биедээ орж гарах болжээ. Энэ явдал хичнээн хугацаагаар үргэлжилснийг хэн ч мэдэхгүй, дараа нь өвгөн өвдөж үхжээ. Залуу нь яасан байх гэж та бодож байна?
- Ярь, ярь.
- Залуу өвгөний хүүрийг өрөөндөө оруулж орон дээрээ хана руу харуулан хэвтүүлээд, өөрөө хоосон өрөөнд орж ханаа бөглөчихөөл хүүрийн шуудайд орчихжээ. Та үүнийг юу гэж хэлэх вэ?

Монте-Кристо нүдээ аниад, ширүүн хүйтэн таар нүүр дээр нь дахин хүрэх шиг санагдлаа.

- залуу Иф цайзад үхсэн хүмүүсийг оршуулдаг, тэгэхдээ авсанд хийж илүү зардал гаргадаггүй гэж санажээ. Тэгэхээр газар доороос гараад ирчихнэ гэж боджээ. Гэтэл түүний гай болоход Иф цайзад өөр заншилтай байжээ. Үхсэн хүнийг оршуулдаггүй, зүгээр л хөлд нь ширэм зүүгээд тэнгист хаячихдаг юм аснжээ. Мань залууг ч гэсэн тэгсэн байна. Маргааш нь орон дотроос жинхэнэ үхсэн хүнийг олж бүх л зүйл илэрчээ. Түүнийг усанд хаясан манаач нар урьд хэдээгүй байсан юмаа хэлж шуудай доошоо нисэж одоход аймшигтай хашхирах дуу гарч, тэр дороо усанд замрхан алга болсон гэжээ гэж хаалгач ярилаа.

Гүн хүндээр амьсгалж зүрх нь зовуурьтай базаллаа.

- Үгүй, үгүй! Би мартаж эхэлсэн учраас эргэлзжээ. Энд миний зүрхний шарх ангайж, би дөхин өшөө авах хүслээр дүрэлзэж байна гэж эр шивгэнэлээ.
- Тэр хоригдлын тухай өөр юу ч мэдэгдээгүй юу? гэж гүн асуув.
- Юу ч мэдэгдээгүй. Тэр тавин фунтын өндрөөс унасан болохоор бяц үсэрсэн байлгүй...
- Түүний хөлд ширэм зүүж хаясан гэж та ярих шив. Тэгэхээр тэр зогсоогоороо унасан байх ёстой.
- Босоогоороо унасан ч зүүсэн ширэм түүнийг тэнгисийн ёроолд татан оруулж, хөөрхий амьтан тэндээ хоцорсон байж таарна.
- Та түүнийг өрөвдөж байна уу?
- Тэнгист гэртээ байгаа юм шиг байлаа ч гэсэн үнэндээ өрөвдөх юм.
- Яагаад тэр вэ?
- Бонапартын талын хүн гэж хэрэгт шийтгэгдэн шоронд хоригдсон залуу урьд нь далайчин байсан юм гэдэг.
- Үнээн, бурхны санаа зоригоор гал, усан дээгүүр хөвж яваа юм. Хөөрхий далайчны дурсгал амьд хэвээр, түүний гашуун хувь заяаны тухай, агаар зүсэн тэнгисийн гүнд живэн орсон тухай ярихад сонссон хүн бүр цочин дагжина гэж гүн шивгэнэлээ.
- Та түүний нэрийг мэдэх үү? Гэж гүн чанга дуугаар асуухад манаач,
- Хаанаас мэдэх вэ? Тэр зүгээр л гучин дөрөв гэсэн дугаартай байсан гэсэн.
- Вильфор, Вильфор! Миний сүнс чамайг нойргүй хонуулж байхад чи ийм л юм батлан бодож сууж дээ.
- Та цааш нь өөр юм үзэх үү? Гэж хаалгач асуухад Монте-кросто,
- Солиорсон ширээт ламынхаа өрөөг үзүүлээч гэв.
- Хорин долоог уу?
- Тийм ээ, хорин долоо гэж Монте-Кристо давтан хэллээ. Тэгээд нэрээ хэлэхийг хүсэхэд нь ханын цаанаас энэ дугаарыг хэлж чанга хашхирч байсан ширээт ламын дуу чихэнд нь сонстох шиг болжээ.
- За явъя.
- Байзаарай би энэ өрөөг сайн харъя гэж бодож байна хэмээн Монте-Кристо хэлэхэд, хаалгач,

- Энэ чинь их завшаан боллоо. Би тэр өрөөний түлхүүрийг авахаа мартчихаж гэв.
- Очоод аваад Ёр л дээ.
- Би танд бамбараа орхиё.
- Хэрэггүй, өөрөө аваад яв.
- Та харанхуйд хоцрох болно шүү дээ.
- Би харанхуйд сайн хардаг юм.
- Үгүй ер! Яг тэрүүн шиг юм аа.
- Хэн шиг гэж?
- Гучин дөрөв шиг. Тэр өрөөнийхөө хамгийн харанхуй буланд байгаа зүүг олж хардаг болж дассан юм гэж ярьцгаадаг юм.
- Ийм болоход түүнд арван жил хэрэглэгдсэн юм даа гэж гүн шивгэнэлээ.
- Хаалгач бамбараа аваад гарч явлаа.

Гүн үнэн хэлжээ. Хэдхэн хором өнгөрмөгц тасалгаан дотор байгаа юмыг өдрийн гэрэлд харж байгаа юм шиг таних боллоо. Тэгээд эргэн тойрон хару, харанхуй гяндангаа ёсоор нь үзэж таньжээ.

- Тийм ээ, миний сууж байсан чулуу энэ байна. Ханан дээр гарсан миний мөрний хэл энэ байна. Толгойгоор хана мөргөж үхэхээр завдан гоожуулсан цусны мөр одоо энд байна. Би аавыгаа амьд байх нь уу үгүй юү... Мерседес сул чөлөөтэй байх нь уу үгүй юу гэдгийг тааварлан мэдэх гэж ханан дээр зурж байсан тоонууд байна. Энэ тооцоог бодож гаргасны дараа надад горьдлого төрсөн юм. Би өлсөж үхсэний нь, урваж явсны нь ч мэдээгүй байсан юм.

Тэгээд гашуунаар инээмсэглэх дуу цээжнээс нь гарч, зүүдэлж байгаа юм шиг, эцгийг нь оршуулж, Мерседес шүтээний өмнө зогсож байгаа нь нүдэнд нь харагдах шиг болов.

Нөгөө талын нь ханан дээрх бичиг нүдэнд нь тусав. Бичиг ногоовтор ханан дээр тод харагдана.

“Бурхан минь, намайг бүү л мартагтай болгож үзээрэй” гэж бичсэн байхыг Монте-Кристо уншив.

“Тийм ээ, сүүлийн хэдэн жилд би зөвхөн үүнийг л хүсэж залбирч байсан юм. Ги эрх чөлөөний тухай мөргөж залбирахаа болиод гагцхүү л солиорхоос айж, мартагтай бүү болгоорой гэж мөргөж байсан юм. Бурхны ачаар юуг ч мартаггүй. Баярлалаа бурхан чамд! Гэж дуу алдлаа_

Энэ минутад ханан дээр бамбарын гэрэл туслаа. Энэ бол хаалгач бууж ирсэн нь ажээ. Монте-Кристо түүний өөдөөс очлоо.

- За намайг дагаад яваарай гэж цаадах нь хэлэв. Тэр хоёр газар доорхи хонгилоор явж нөгөө хаалганд очив.

Ширээт ламын өрөөнд Монте-Кристо гүнд олон зүйл дахин санагдлаа.

Юуны өмнө ханан дээр зурж, түүнийхээ тусламжтайгаар Фариа он тооллыг тэдэж байсан өргөрөг, уртраг харагдлаа. Золгүй хоригдлын амьсгаа хураасан ор байхыг ажиглав. Өөрийнхөө өрөөнд ороход аймшигтай байсан бол, харин энд ороход гүн хачин талархан баярлах сэтгэл төрж нүднээс нь нулимс гаолаа.

- Энд өнөө солиотой лам сууж байсан юм. Тэрүүгээр нөгөө өрөөнийх нь хүн орж ирдэг байжээ гээд энэ талаас нь бөглөөгүй нүх рүү заав. Чулууны

нь өнгөөр нэг эрдэмтэн тэр хоёрыг арваад жил бие биедээ орж гарч байсан байна гэж шинжилсэн юм. Хөөрхий тэр хоёр энэ арван жилийг тийм ч их хөгжилтэй, өнгөрөөгөөгүй байх аа! гэж хаалгач тайлбарлан ярив.

Дантес хармаанаасаа хэдэн алтан зоос гаргаж, өөрийг нь огт танихгүй байж хоёр ч удаа өрөвдсөн тэр хүнд өгөв.

Хаалгач мөнгийг авч бамбарынхаа гэрэд хараад хэдэн задгай мөнгө өгчихлөө хэмээн андуурч өчнөөн төчнөөн мөнгө өгчихлөө гэж бодоод,

- Эрхэм та, андуурсан багана гэж хэллээ.
- Юу тэр вэ?
- Та надад алтан зоос өгсөн байна шүү дээ.
- Тийм ээ, мэдэж байна.
- Мэдэж байна гэнэ ээ?
- Тийм.
- Та надад энэ алтан зооснуудыг өгч байгаа юм уу?
- Тийм ээ.
- Би үүнийг үнэн сэтгэлээсээ өөртөө үлдээж болох юм уу гэж манаачийн хэлэхэд гүн Гамлетын хэлдэг шиг
- Нэр төртэйгээр үлдээж болно гэж хэллээ.

Хаалгач түүн өөд гайхан харав. Тэгээд өөрийн аз завшаанд итгэхээс айсан

мэт,

- Эрхэм минь, би ийм их мөнгө авах ямар юм хийчхэв ээ? гэлээ.
- Найз минь гайхах юмгүй, би өөрөө далайчин байсан болохоор таны яри надад их сонин санагдлаа гэж гүн хэллээ.
- Та ийм өгөөмөр хүн болохоор, би танд оронд нь нэг юм өгөхийг зөвшөөрнө үү гэж хаалга асуув.
- Та надад юу өгөх вэ? Сүлжмэл сагс, танан хясаа өгөх гэж үү? Үгүй дээ хэрэггүй, баярлалаа.
- Үгүй, үгүй эрхэм минь. Энэ бол миний ярьсанд холбогдолтой юм.
- Тийм гэж үү? Тэгээд тэр чинь юу юм бэ? гэж гүн сонирхон асуув.
- Би арван таван жил хүн суусан өрөөнөөс ямар нэг юм олдоно гэж бодоод хана тоншиж эрж эхэлсэн юм гэж хаалгач ярив.

Тэгэхэд Монте-Кристо ширээт ламын юмаа нуудаг газрыг санаж,

- Тийм шүү гэв.
- Удаан эрсний эцэст орных нь толгойн тэнд хана хөндий дуугарч байхыг сонсов.
- За гэж Монте-Кристо дуугарав.
- Би чулуугий нь сугалан авч ийм юм олсон...
- Олсон шат, багаж хэрэглэл үү? Гэж гүн нуу алдахад хаалгач гайхан,
- Та хаанаас мэдээ вэ? гэж асуув.
- Би мэдээгүй л дээ, зүгээр тааж байна. Ер нь шоронгийн нууцуудад тийм л юм байдаг л даа гэж хэллээ.
- Тийм ээ, олсон шат багаж хэрэгсэл олсон.
- Тэр чинь танд бий юу?
- Байхгүй, цөмийг нь үзэхээр ирсэн хмүүүст зарчихсан. Харин нэг юм үлдсэн.

- Юу тэр вэ? гэж гүн яаран асуув.
- Хавтгай даавуун дээр бичсэн нэг ном.
- Яалаа гэнэ ээ! Тэр ном чинь чамд бий юу? гэж гүн асуув.
- Тэр ном биш ч байж мэдэх юм. Юу ч л гэсэн надад бий гэж хаалгач хэлэхэд Монте-Кристо,
- Найз минь гүйж очоод аваад ир. Хэрэв миний бодож байгаа тэр зүйл мөн бол чи харамсахгүй болно гэв.
- Гүйгээд аваад ирье эрхэм минь гэж хэлээд хаалгач гарч орлоо.

Тэгэхэд Монте-Кристо өвгөнийг үхсэнээс хойш шүтээн болж хувирсан орны өмнө сөхрөн сууж,

- Эрх чөлөө, эрдэм мэдлэг, баялаг хөрөнгөнийхөө төлөө ачийг чинь хариулах хоёрдугаар эцэг минь. Чи бол ачлал, хорлолын нууцыг эзэмшсэн дээд тэнгэрийн хүү юм. Газар дэлхий дээр амьдрагчийн дуу хоолойд хариу цуурайтах ямар нэг юм биднээс булшны гүнд үлддэг юм бол, бидний бие биеийгээ хайрлан хүндэлж байсан өөрөөр хэлбэл ихэд тарчлан зовж байсан тэр газраар мах бод хувиран өөрчлөгдсөний дараа ямар нэг амьд юм үлддэгсэн бол сайн сайхан зүрх сэтгэл, өндөр оюун ухаан, бүхнийг мэдэгч эцэг минь, намайг хайрлаж байсан эцэг ёсны хайраа санаж ганц үг, өчүүхэн төдий дохиогоор миний эргэлзлийг хийсгэн арилгаж өгөхийг чамаасаа хүсье. Хэрэв энэ зүйл итгэл найдвараар солигдохгүй бол би гэмшихэд хүрэх нь гэв.

Гүн толгой бөхийлгөн залбирав.

- Эрхэм минь энэ байна гэх дуу ард нь дуулдав.

Хаалгач түүнд ширээт лам Фариагийн бүх л эрдэм мэдлэгийнхээ арвин сангийн охь манлайг бичсэн даавуун хуудсуудыг өгөв. Энэ бол Италийн засгийн эрхийн тухай бичсэн нөр их хөдөлмөрийнх нь үр гар бичмэл байв.

Гүн түүнийг шүүрэн автал хамгийн түрүүнд нь бичсэн:

“Чи хан гардийн шүдийг сугалж, арслан барыг гишгэчин хаяна гэж бурхан хэлсэн юм” гэж иш татсан зүйл нүдэнд тусав.

- Хариулт нь энэ байна! Баярлалаа чамд, баярлалаа эцэг минь гэж гүн дуу алдлаа.

Тэгээд дотор нь нэг бүр нь арван мянган франкийн арван дэвсгэрт байгаа түрийвчээ гаргаж,

- Май үүнийг ав гэж хэллээ.
- Энүүнийг надад өгч байгаа юм уу?
- Тийм ээ, харин тэгэхдээ намайг явахаас өмнө онгойлгож болохгүй шүү.

Тэгээд энэ ертөнц дээрх ямар ч эрдэнэсээс илүү үнэтэй дэвтрээ цээжиндээ тэвэрч газар доор байшингаас гүйн гарч завиндаа үсрэн суугаад,

- Марсель өөд! гэж хэлэв.

Завь хөдлөн явахад, Монте-Кристо гунигт цайз өөд ширтэн харлаа.

- Намайг энэ харанхуй гянданд хийсэн, энд хийгээд мартчихсан хүмүүст хараал хүрэг! Гэж гүн хэллээ.

Каталаны хажуугаар өнгөрөн гарахдаа гүн буруу харж, цуваараа нүүрээ таглаад нэгэн эмэгтэй хүний нэр хэллээ.

Дүүрэн ялалт болж, гүнгийн хоёр дахь эргэлзээ арилжээ. Бараг хайрын сэтгэлээр эелдэг зөөлнөөр хэлсэн нэр бол Гайдегийн нэр байв.

Монте-Кристо эрэг дээр гараад Моррель хүлээж байсан оршуулгын газар өөд явав.

Гүн бас л рван жилийн өмнө энэ оршуулгын газар нэг булш эрсэн боловч хий дэмий эрээд ололгүй өнгөрчээ. Тэр Францад саяын хөрөнгөтэй буцаж ирээд өлсөн үхсэн эцгийнхээ булшийг олоогүй юм.

Өвгөн Моррель булшин дээрээ хэрээс тавихыг захиж хийлгэсэн боловч тэр нь ойчиж, унасан түүнийг нь оршуулгын газрын манаач аваачаад түлчихсэн байжээ. Ер нь нурж ойчих, илүү новширсон зүйлүүдийг тэгж цэвэрлэдэг юм.

Буянтай хөлгийн эзэн илүү аз жаргалтай байжээ. Тэр хүүхдүүдийнхээ гар дээр байж байгаа үхсэн бөгөөд түүнийг хоёр жилийн өмнө мөнх нойрссон эхнэрийн нь дэргэд оршуулжээ.

Тэр хоёрын нэгийг сийлсэн хоёр хавтгай гантиг чулуу төмөр хайстай дөрвөн аварга майлсын сүүдэрт зэрэгцэн байв.

Максимилиан мод налж, булшны зүг бүлтийсэн нүдээр харж зогсоно. Уйтгар гунигт автагдан ухаангүй болсон мэт байв.

- Максимилиан, ийшээ харагүй тийшээ харах хэрэгтэй гэж гүн хэлээд тэнгэр өөд заав.
- Та намайг Парисаас дагуулж гарахдаа, үхэгсэд хаана ч гэсэн бидэнтэй хамт гэж хэлсэн шүү дээ гэж Моррель хэлэв.
- Максимилиан та Парисаас гарахдаа Марсельд хэд хонох юмсан гэж байсан. Одоо ч тэр хүсэл чинь өөрчлөгдөөгүй биз? гэж гүн хэлэв.
- Гүн минь одоо надад өөр ямар ч хүсэл алга. Өөр газар хүлээснээс энд хүлээвэл надад дээр санагдаж байна.
- Тэгвэл бүр ч сайн. Яагаад гэвэл би таны тангараглаж хэлсэн үгийг чинь аваад явах учраас энэ нь илүү сайн, тийм биз?
- Гүн минь, би тэр хэлсэн үгээ мартчихаж болох юм шүү дээ гэж Моррель хэллээ.
- Үгүй, Моррель та юуны өмнө нэр төртэй хүн учраас мартаж ёсгүй. Та амлаж тангарагласан, тэгээд дахин ам гарсан учраас мартаж болохгүй.
- Гүн минь та намайг өрөвдөөч! Би тэртэй тэргүй зовсон хүн.
- Моррель, танаас илүү их зовж зүдэрсэн хүн би үзсэн юм шүү.
- Тийм юм байх ёсгүй.
- Энэ бол өөрийгөө л гэж боддог хүний өчүүхэн зан. Хүн бүр өөртэйгээ зэрэгцэн уйлж байгаа хүнийг өөрөөсөө бага зовлон зүдүүртэй гэж үздэг юм.
- Дурлаж, хайрлаж, хүсэж, мөрөөдөж байсан ганц юмнаасаа салж хагацсан хүнээс илүү золгүй хүн гэж энэ хорвоод байдаг юм уу?
- Моррель, та миний ярих зүйлийг анхааран чагнаж бай. Би таны адилаар нэг хүүхэнд дурлаж, аз жаргалаа хүсэн мөрөөдөж байсан нэг хүнийг мэднэ. Тэр залуу хүн, хайртай эцэгтэй, дурласна болзоот хүүхэнтэй байв. Хариумаа ч хийх ёстой байв. Тэгтэл хувь заяа гэнэт өөрчлөгдөж, түүний эрх чөлөө, дурласан хүүхэн, ирээдүйг нь тэр золгүй сохор амьтан зөвхөн одоо цагаа харж явжээ\ булаан авч өөрийг нь харанхуй хар гянданд хаяжээ.

- Харанхуй хар гяндангаас долоо хоног, сар, жилийн дараа гардаг шүү дээ гэж Моррель хэлэв.
 - Моррель, тэр хүн арван дөрвөн жил гянданд суужээ гэж хэлээд гүн түүний мөрөн дээр гараа тавихад Максимилиан цочлоо.
 - Арван дөрвөн жил гэнэ ээ! гэж шивнэхэд,
 - Арван дөрвөн жил гэж гүн хэлээд – Энэ хугацаад түүнд цөхрөнгөө баран бачимдах үе байжээ. Тэр, Моррель тан шиг бас л өөрийгөө хамгийн золгүй хүн хэмээн өөртөө гар хүрэхээр завдаж байсан юм гэв.
 - Тэгээд яагаа вэ? Гэж Моррель асуув.
 - Тэгтэл сүүлчийн минутад бурхан түүнд хүн дүрстэй авралыг явуулжээ. Тэр анхандаа бурхны хайр ивээлийг мэдэхгүй, ойлгодоггүй байв. \Бүрхсэн нүд дахин хараа ортол цаг хугацаа хэрэгтэй\ Гэвч тэрээр тэвчин хүлээхээр шийдсэн аж. Тэрээр баян, хүчирхэг, бараг хагас бурхан болж гарч ирэх өдөр тохиолджээ. Эхлээд эцэг рүүгээ тэмүүлсэн боловч тэр нь үхчихсэн байжээ.
 - Миний эцэг ч бас үхчихсэн шүү дээ гэж Моррель хэллээ.
 - Тийм ээ, таны эцэг бол та нарын гар дээр, та нараар хайрлуулж, хүндлүүлж, баян чинээлэг, өндөр нас насалж үхсэн. Гэтэл түүний эцэг бол ядуу зүдүү цэрхөнгөө баран бурханд эргэлзэн байж үхсэн юм. Түүнийг үхсэнээс хойш арван жилийн дараа хүү нь ирж булшийг нь эрэхэд олдохгүй болсон бөгөөд чамайг тэгж их Хайрдаж байсан зүрх энд тайван нойрсож байгаа гэж хэлэх хүнгүй байжээ.
 - Бурхан минь! гэж Моррель хэлэв.
 - Тэр хүн Моррель танаас илүү зовлон үзсэн бөгөөд тэр ч байтугай эцгийнхээ булшийг хаана байгааг нь мэдэхгүй байсан юм.
 - Үгүй түүнд дурлаж байсан хүүхэн нь үлдсэн шүү дээ гэж Моррель хэлэхэд,
 - Моррель та ташаарч байна. Тэр хүүхэн нь.... Гэхэд
 - Үхчихээ юу? гэж Максимилиан дуу алдлаа.
 - Тэрнээс ч дор юм болсон. Тэр хүүхэн түүнээс урвасан аж. Болзоот хар хүнээс нь салгасан өштөн улсын нэгэнтэй нь суусан юм. Хайр дурлалын хувьд танаас илүү зовон хүн байдгийг та харж байгаа биз дээ.
 - Тэгээд бурхан түүнд тайвширлыг явуулаа юу? гэж Моррель асуув.
 - Бурхан түүнд тайван төвшин амьдралыг илгээжээ.
 - Тэгээд тэр хүн чинь дахин аз жаргалыг үзэж чадах уу?
 - Тэр хүн тэгж найдаж байгаа шүү.
- Максимилиан Моррель чимээгүйгээр толгой бөхийлгөн,
- Би хэлсэн үгэндээ хүрнэ гэж хэлээд Монте-Кристорд гараа өгч харин битгий мартаарай... гэв.
 - Аравдугаар сарын таванд би таныг Монте-Кристо арал дээр хүлээж авна. Дөрвөнд таныг “Эвро” гэдэг хөлөг онгоц Бастийд хүлээж байх болно. Та ахмадад нь нэрээ хэлмэгц таныг над дээр хүргэж ирнэ. Максимилиан, ингэж тогтох уу?
 - Тогтлоо гүнтэн, би хэлсэн үгэндээ хүрнэ. Харин аравдугаар сарын тавныг бүү мартаарай.

- Та хүүхэд болохоороо нас бие гүйцсэн хүний амлалт гэдэг юу болохыг мэдэхгүй байна... Би тэр өдөр таныг бас л үхнэ гэж хүсээд байвал танд тусална гэж хориод удаа л лав хэлсэн байх. За баяртай.
- Та одоо намайг орхиод явах нь уу?
- Тийм ээ, надад Италид хэрэг байна. Би таныг гуниг гашуудалтай чинь хамт, бурхан сонгож авсан хүмүүсээ хөлийнхөө доор аваачиж тавь хэмээн явуулмаг энэ өргөн далавчит бүргэдтэй хамт орхиод явлаа. Ганимедын явдал бол үлгэр биш шүү, Максимилиан,
- Та хэзээ явах вэ?
- Одоо, намайг онгоц хүлээж байгаа. Нэг цагийн дараа ихээ хол явчихсан байна. Та намайг буудал хүртэл гаргаж өгөх үү?
- Би таны мэдэлд бүрэн байна.
- Тэгвэл намайг тэвэр дээ.

Моррель гүнг буудал хүртэл гаргаж өгөв. Онгоцны хар яндангаас утаа баагьж, тэнгэрт хөөрнө. Уурын хөлөг онгоц хөдлөн явж нэг цагийн даоаа Монте-Кристогийн хэлснээр харанхуй нөмрөн ирж байгаа дорно зүг рүү нь утаа нь цайран цайрсаар алга боллоо.

17. ПЕППИНО

Гүнгийн хөлөг онгоц Моржион хэмээх хошууны цаагуур далд орсон яг тэр үед флоренцоос Ром орох замаар яваа шуудангийн сүйх тэрэг Аквапенденте хэмээх бяцхан хотыг өнгөрөн гарав. Жуулчны сүйх тэрэг сэжиг төрүүлэхгүйгээр аль болох хурван явж байв.

Аяны урт хормойтой дээл чухамдаа гэвэл аян үамын уртад үнгэгдсэн дальто өмсөж хүндэт легионы шинэхэн тууз түүн дээрээ зүүжээ. Цамцандаа ч бас тийм тууз зүүжээ. Зөвхөн энэ тэмдгээр нь ч биш, хөтөчтэй ярьж байгааг нь харвал франц хүн байлаа. Хаана ч хэрэглэж болдог хэлтэй оронд төрсний нь нотолгоо нь италиар зөвхөн хөгжимд хэрэглэдэг ямар ч үгийг орлуулж болдог ганц хоёр үг мэддэг явдал болно. *Allegro!* Хэмээн өгсүүр газар бүрд хөтөчдөө хэлнэ. Уруу газар буух бүрд *moderato!* Гэж хэлнэ.

Флоренцоос Ром хүртэл Аквапендентээр дайрч явахад хэдэн өгчүүр, хэдэн уруу байдгийг бурхан л мээрэй байх!

Бас тэгээд түүний хэлдэг тэр хоёр үг сонсож байгаа хүнийхээ инээдийг мургэдгийг тамрамд хэлье.

Мөнхийн хот харагдаха р газар буюу Сторта хот хүрч ирэхэд сайхь жуулчингийн сэтгэл огтхон ч хөдөлсөнгүй. Ер нь Ром хотод ойртож очиход хамгийн түрүүнд харагдагч алдарт гэгээн Петрийн сүмийн бөмбөгөр оройг харах гэж суудал дээрээ өндийдөггүй гадаадын хүн жуулчдыг дотор байдаггүй ажээ.

Харин тэр хүн зөвхөн түрийвчээ гаргаж, түүн дотроосоо дөрөв нугалсан цаас аваад болгоомжтойгоор задалж үзээд буцаан хийснээ - Маш сайн, энд байна гэж хэллээ.

Сүйх тэрэг дель Попологийн хаалгыг өнгөрч, зүүн тийшээ эргээд "Лондон" хэмээх зочид буудлын үүдэнд очиж зогслоо.

Бидний хуучин танил эрхэм Пастрини жуулчныг үүдэн дээрээ зогсож, гартаа бүрх малгайгаа барин угтан авав.

Жуулчин сүйх тэрэгнээс гарч, сайн хоол захиад Томсон ба Френчийн банкны байшин хаана байдгийг асуув. Энэ нь Ромын хамгийн нэртэй банкуудын нэг учраас хаягийг нь тэр даруй хэлж өгөв.

Тэр нь гэгээн Петрийн сүмээс холгүй орших, Банкны гудамжинд байдаг ажээ.

Ромд мөн л бусад газрын адил шуудангийн сүйх тэрэг хүрч ирэх нь олны анхаарлыг татна. Мари болон Гракхуудын залуу удам хөл нүцгэн, тохой цоорхой авч нэг гараараа ташаагаа тулж, нөгөө гараа толгойныхоо ард хийж их л ганган байдлаар зогсож, жуулчин, сүйх тэрэг, морьдыг харна. Эдгээр мөнхий хотын залуу иргэд дээр гудамжны хийх юмаа олж ядсан, хэрэв устай цагт бол гэгээн Ангелын гүүр дээрээс Тибр глын усан дээр нулимж, тархан алга болохыг нь сонирхон байдаг гэгээн богдын үнэнч иргэд бөлох тавь гахам ажилгүй хүмүүс ирж нэмэгдэв.

Парисын гудамжны хүүхдүүийг бодвол хэл бүхнийг мэддэгээрээ азтай Ромын гудамжны жаалууд, ажилгүйчүүд, бүх хэлийг түүн дотроос цранц хэлийг сайн мэдэх учир, тэрхүү ирсэн жуулчин тасалгаа авч, хоол захиад сүүлд нь Томсон ба Френчийн банкны хаягийг асуусныг дуулцгаажээ.

Ингээд ирсэн хүнийг байнгын дагуул чичероне хэмээх хот танилцуулагчтай хамт гарч ирэхэд сонирхсон олны дундаас нэгэн хүн салан зайдуу гарч жуулчин түүнийг дагалдагч хоёрын алинд ч мэдэгдэлгүй дагаж явах нь Парисын мөр хөөгчид ч атаархмаар сэргэлэн ажээ.

Ирсэн хүн Томсон Френчийн банкинд очих гэж яарсан учир морь сольж хөллөхийг хүлээлгүй алхжээ. Сүйх тэрэг хойноос нь гүйцэж очих эс чадавч банкны үүдэн дээр хүлээх ёстой болжээ.

Сүйх тэрэг түүнийг замд нь гүйцсэнгүй.

Франц хүн банкинд орлоо. Дагаж ирсэн хүн нь үүдний өрөөнд үлдэж Ром хотод элбэг байдаг тодорхой ажилгүй, өөрөөр хэлыэл аль тохиолдсонооо хийж, банк, сүм, балгас, музей, театрын дэргэд зогсож байдаг хэсэг хүмүүстэй ярилцан байв.

Сонирхсон одны дундаас тасран явсан нөгөө хүн франц хүнтэй зэрэгцэн банкинд орлоо. Франц хүн конторын үүдэнд очиж хонх дуугаргаад эхний нэгэн тасалгаанд орлоо. Түүний араас сүүдэр нь дагаж орлоо.

- Би Томсон, Франц нартай уулзаж болохсон болов уу? гэж ирсэн хүн асуув.

Нэгдүгээр тасалгаанд байсан түшмэлийн дохиогоор үйлчлэгч хүн ирж,

- Хэн гэж айлтгах вэ? хэмээн харь орны хүнд зам зааж өгөхөөр асуухад,
- Түшээ гүн Данглар гэж жуулчин хариулав.
- Морилон орогтун.

Үүд нээгдэж үйлчлэгч, түшээ гүнтэй хамт орлоо.

Дангларын хойноос орж ирсэн хүн хүлээх сандал дээр суулаа.

Нөгөө албаны түшмэл таван минут хэртэй юм бичсээр байв. Энэ таван минутын дотор сандал дээр сууж байгаа хүн огт чимээ аниргүй, хөдлөх ч үгүй суулаа.

Тэгтэл албаны хүн үзгээ чахруулан юм бичихээ больж% толгойгоо өргөн харж хоёулхнаа байгааг мэдээд түүнд

- Аа, Пеппино чи ирсэн юм уу? гэхэд цаадах нь товчоноор,
- Тийм гэж хариуллаа.
- Энэ бүдүүн үнэд хүрэх хүн гэдгийг үнэрлэчхэв үү?
- Энэ удаа бидний гавьяа байхгүй. Бидэнд урьдчилан мэдэгдсэн юм.

- Тэгэхээр чи яах гэж ирснийг нь мэдэж байгаа юм уу?
- Мэдэхээр барах уу даа! Харин хэдийчинээ юм авахыг мэдэх үлдээд байна.
- Найз минь одоохон мэдэх болно.
- Маш сайн. Харин эртээрийнх шиг битгий худлаа хэлчихээрэй!
- Чи хэнийх нь тухай ярьж байна? Саяхан гурван мянган скцдо авсан англи хүнийг хэлж байна уу?
- Үгүй, тэрүүнд үнэхээр гурван мянган скудо байсныг бид олсон. Би нөгөө орос ноёны тухай ярьж байна.
- Тэгээд яачихаа вэ?
- Яачихаа вэ гэнэ шүү. Гучин мянга гэж чи хэлсэн, бид зөвхөн хорин хоёр мянгыг л олсон.
- Муу л нэгжсэн байж таарлаа.
- Луиджи Вампа өөрөө нэгжсэн.
- Тэгвэл өр төлсөн юм байлгүй.
- Орос уу?
- ... Эсвэл мөнгөө үрчихсэн байх.
- Магадгүй.
- Магадгүй биш, яавч тэгсэн болж таарна. За би ажиглах газар руугаа очъё. Тэгэхгүй бол франц хүн ажлаа дуусаад, би яг хэмжээгий нь мэдэж чадахгүй болчихно.

Пеппино толгой дохиод хармаанаасаа эрх гаргаж маань уншиж эхлэв. Харин албаны түшмэл үйлчлэгч түшээ гүн хоёрын орсон хаалга өөд орлоо.

Тэгээд арваад минут ч өнгөрөөгүй байтал, мишилзэн буцаж ирлээ.

- За яав? Гэж Пеппино асуухад,
- Анхааралтай! Ёстой л мөнгө байна даа гэж хариуллаа.
- Тав, зургаан сая байна уу?
- Тийм байна. Чи мэдэж байсан юм уу?
- Гэгээнтэн гүн Монте-Кристогийн гарын үсгээр өгч байгаа юм уу?
- Чи гүнг таньдаг юм уу?
- Ром, Венад зээллэгтэй байгаа биз?
- Тийм ээ, үнэн, харин чи энэ бүгдийг хаанаас мэдэв?
- Бидэнд урьдчилан мэдэгдсэн гэж чамд хэлсэн шүү дээ.
- Тэгээд чи яах гэж асуусан юм бэ?
- Тэр хүн мөн бишийг нь мэдэх гэсэн юм.
- Тэр мөн... Таван сая гэдэг чинь муугүй шүү, тийм ээ Пеппино?
- Тийм ээ.
- Чи бид хоёрт хэзээ ч ийм их мөнгө бий болохгүй дээ.
- Тэгсэн тэгээгүй бидэнд бас хувь ноогдоод л байдаг шүү дээ гэж Пеппино хэллээ.
- Чшш! Ирж явна.

Албаны түшмэл үзгээ авч, Пеппино уншлагаа уншиж, үүд нээгдэхэд нэг нь бичиж, нөгөөх нь маань уншиж байв.

Гялалзсан сайхан царайтай Данглар банкны эзэн хоёр гарч ирээд үүд хүртэл гаргаж өгөв.

Дангларын хойноос Пеппино бас шатаар буулаа.

Тохиролцсон ёсоор Томсон Френчийн банкны үүдэнд сүйх тэрэг хүлээж байв. Тйлбарлагч үлэмж самбаатай үйлчилдгээ үзүүлж сүйхний хаалга онгойлгож өглөө.

Данглар хорин настай залуу шиг сүйх тэргэнд үсрэн орж суулаа. Тйлбарлагч хаалгыг нь хаагаад хөтөчтэй хамт суув. Пеппино ар талд нь очиж суув.

- Та ариун Петрийн сүмийг үзэх сэн болов уу? гэж тайлбарлагч асуухад,
- Яах юм бэ? гэж түшнн гүн өөдөөс нь асуув.
- Зүгээр үзэхгүй юу юу?
- Би ромд юм үзэх гэж ирээгүй гэж Данглар хэлснээ өөр зуураа – Би мөнгө авах гэж ирсэн юм гэж ёжтойгоор хэлэв.

Тэгээд мөнгөө хийсэн түрийвчээ дарж үзлээ.

- Тэгэхээр та тийшээгээ явах уу?
- Зочид буудал орж явна.
- Пастринийн буудалд очно гэж тайлбарлагч хөтчид хэллээ. Хөлсний сүйх тэрэг хувийн сүйх тэрэг шиг хурдан давхин одлоо.

Арван минутын дараа Данглар өрөөндөө орж, Пеппино өнөө бидний дээр өгүүлсэн Мари ба Гракхуудын удмын нэг жаалын чихэнд юм шивгэнэж орхиод зочид буудлын үүдний сандал дээр суув. Нөгөө жаал Капитолийн замаар гүйж одов.

Данглар ядарсан учир иүрийвчтэй мөнгөө дэр доогуураа хийчхээд унтхаар хэвтэв.

Пеппинод яарах ямар ч хэрэг байсангүй. Тэрээр ачаа зөөгчидтэй тоглож гурван скудо алдаад, тайвшрахын тулд шил дарс авч уужээ.

Маргааш өглөө нь Данглар, хэдий эрт хэвтсэн боловч орой бослоо. Тэрээр зургаан шөнийн турш хэрэв унтсан байдаг байлаа гэхэд даанч муу унтжээ.

Өглөөнийхөө хоолыг цадталаа идээд Мөнхийн хотын гоо сайхныг өөрийн хэлсэнчлэн огтхон ч гайхсангүй, үд дунд шуудангийн сүйх тээг өгөхийг шаардав.

Гэвч Данглар цагдаа нарын яршигтайг, өртөөний бошгын залхуиг харгалзан үзээгүй байжээ.

Моёдыг дөнгөж хоёр цагт өгсөн бөгөөд нөгөө чичероне хэмээх тайлбарлагч хил нэвтрэх тамга дарсан үнэмлэхийг нь гурван цагт авчирч өгчээ.

Энэ бэлтгэл нь эрхэм Пастринийн үүдэнд овоо олон үгэнд дуртай хүнийг цуглуулчихлаа. Бас Мари ба Гракхуудын удам ч дутсангүй.

Түшээ гүн цайны мөнгө горьдож өөрийг нь “гэгээн эзэн” гэж хүндэтгэн өргөмжилж байгаа олны дундуур ихэмсэг байдлаар өнгөрөн гарав. Данглар үлэмж ардчилсан үзэлтэй хүн учир одоо хүртэл түшээ гүн цолдоо сэтгэл өег явсан бөгөөд хэзээ ч гэгээнтэн гэж нэрлэж байхыг дуулаагүй учир маш их хөөрч, мөнгө өгвөл “дээд эзэн” хэмээн дахин дуудахад ч бэлэн байгаа эдгээр эрээвэр хураавар хүмүүст арваад мөнгөн зоос тарааж өглөө.

- Бид ямар замаар явах вэ? гэж хөтөч итали хэлээр асуухад,
- Анконоор явна гэж түшээ гүн хариулав.

Пастрини асуулт хариултыг орчуулж өгөхөд морьд давхилдан одов.

Данглар Венец орж мөнгөнийхөө хагасыг авч, дараа нь Венецээс Вена орж үлдсэн мөнгөө авна гэж бодож байжээ.

Тэгээд хөгжил цэнгэлийн орон гэж өөрт нь бахархан магтаж ярьж байсан энэ хотод суух санаатай байжээ.

Түүнийг ромын талаар гурван бээр ч газар явж амжаагүй байтал бүрэнхий болж эхлэв. Данглар ийм орой болсон хойно грч гэж мэдээгүй бөгөөд хэрэв мэдсэн бол тэндээ үлдэх байсан ажээ. Хамгийн нааз захын хот хүртэл хэр зэрэг зайтайг асуув.

- Ойлгохгүй байна! гэж хөтөч италиао хариулав.

Данглар маш сайн гэсний тэмдэг болгож толгой дохилоо.

Сүйх тэрэг цаашлан давхина.

“Хамгийн түрүүнд дайралдсан өртөөн дээр бууна” гэж тэр бодож явлаа.

Дангларын өчигдрийн сайхан зан хэвээр байсан бөгөөд нойр нь ханаж амарсан байв. Англи хийцийн хоёр нумтай сүйх тэрэгний зөөлөн сандал дээр алхайн суув. Тэргэнд нь хоёр сайн морь хөллөжээ. Хамгийн ойрхны өртөө хүртэл долоон бээр гэдгийг тэр мэдэж байжээ. Тун саяхан үлэмж аюултай дампуурсан банкны эзний санаа бодлыг юу эзлэх ёстой вэ?

Данглар арваад минут хяраатай, Парист хоцорсон эхнэрийнхээ тухай, бас арван минут хяраатай мадмуазель Армильттай хэрэн тэнүүчилж яваа охиныхоо тухай бодов. Дараа нь өөрийнхөө мөнгийг хэрхэн яаж ашиглаж, зарцуулах тухай арваад минут бодов. Сүүлд нь өөр ямар нэг бодох юмгүй болохоороо нүдээ анин зүүрмэглэнэ.

Данглар заримдаа ширүүн донслоход сэрнэ. Сэрэх бүрдээ ромын тэгш тал газраар өнөө л хурдан давхисаар хэвээр явж байх шиг санаж байв. Энэ шөнө бороотой хүйтэн байсан учир зөвхөн “Ойлгохгүй байна” гэж хариулахаас өөр юу ч мэдэхгүй хөтчөөс удахгүй хүрэх үү гэж асуух гэж цонхоор толгойгоо цухуйлгасанд орохноо сүйх тэрэгний буланд тухтайхан үүрэглэж суувал хавьгүй дээр байв.

Тэгээд Данглар шуудангийн өртөө хүрэхээр сэрж амжих юм хойно яах вэ гэж бодоод дахин унтлаа.

Сүйх тэрэг зогсоход Данглар хүссэн газраа хүрч ирлээ гэж боджээ.

Тэгээд нүдээ нээж ямар нэг хот үгүй ядахдаа тосгод ирсэн байх гэж цонхоор харлаа. Тэгтэл түүний нүдэнд ганц муу урц, түүний дэргэдүүр гурав дөрвөн хүн сүүдэр мэт сүүдэгнэн байх харагджээ.

Энэ өртөөнд хүргэж ирсэн хөтөч зохих хөлсөө авах гэж хүрч ирнэ гэж Данглар хүлээж байв. Хөтөч солигдох завшааныг ашиглаж шинэ хүнтэй танилцъя гэж боджээ. Морьдыг сольж хөллөсөн боловч хэн ч хөлс нэхэж ирсэнгүй. Данглар гайхан үүдээ онгойлгов. Гэтэл нэг хүний хүчтэй гар үүдийг нь түлхэн хаахад сүйх тэрэг цааш давхив.

Гайхаж хоцорсон банкны эзэн бүр сэрчихлээ. Тэгээд хөтөч өөд,

- Хөөе! Хонгор минь гэж дуудлаа.

Данглар энэ үгийг охиноо Кавальканти ноёнттой хоршин дуулж байсан үеэс тогтоосон ажээ.

Гэвч хонгор найз нь юу ч дуугарсангүй.

Тэгэхээр нь Данглар цонхоо буулгаад, цухуйж

- Хөөе, найз минь! Бид хаашаа явж байна вэ? гэж асуулаа. Тэгтэл нэг чанга захирангүй дуутай хүн,

- Dentro la testa! Гэж хэллээ.

Энэ үг бол толгойгоо цааш нь хий! Гэсэн үг болохыг ойлгов. Тэр итали хэлийг ийм амжилттай сурч байгаа бололтой.

Тэр хэдийгээр үгийг нь дагасан боловч сэтгэл зовж байв. Ингэж сэтгэл зовох нь минутаас минутад нэмэгдэнэ. Анх замд гарахдаа толгойд нь юу ч орж ирэхгүй байсны улмаас унтаад өгч байсныг дурдсан билээ. Одоо бол явуулын хүнд, тэр тусмаа Данглар шиг хүнд сэтгэл зовоож, анхаарал хурцатгах элдвийн сэтгэл төрнө.

Сэтгэл ихэд догдолсон минуудад гарч ирж дараа нь улам хүч гаргасна с болж бүдгэрэн мохдог харцаар „англар орчин тойрноо харав. Хүн айхаассаа өмнө юмыг тодхон хардаг. Айхаараа нүдэнд нь юм хоёр болж харагдах ба дараа нь нүд бүрхэлздэг. Сүйх тэрэгний баруун талын үүдний дэргэд цувтай хүн давхиж явах нь Дангларт харагджээ.

“Цагдаа л байх ёстой. Францын цагдаагийн газар Богд ламын засгийн газарт миний тухай цахилгаан мэдээгээр мэдэгдчихлээ гэж үү? Гэж өөрөө зуураа бодлоо.

Тэгээд энэ учир үл мэдэгдэх байдлыг эцэс болгохоор шийдлээ.

- Та нар намайг хааш нь авч явж байгаа юм бэ? гэж асуув. Тэгэхэд мөн өнөө түрүүчийн дуу бас л,

- Толгойгоо цааш нь хий гэж заналхийлэн хэлэв.

Данглар зүүн цонх руугаа эргэж харав.

Тэгтэл бас зүүн цонхон дээр нь морьтой хүн давхиж явав.

- Би баригдчихжээ гэж Данглар бувтнаад гэдрэгээ налав.

Энэ удаа үүрэглэх гэж налсангүй харин ухаарч бодох гэж налжээ.

Төдий л удалгүй сар гарлаа.

Данглар сүйх тэрэгний гүн дотроос гадагшаа харвал өнөө түрүүчийн нь явж байсан ромын тал харагдлаа. Харин энэ нь одоо баруун талаас биш, зүүн талын цонхоор харагдаж байв.

Сүйх тэрэг буцаж Ромын зүг явж байгааг ойлголоо.

- Би өнгөрлөө! Намайг баривчилжээ! Хэмээн шивэгнэв.

Сүйх тэрэг хар эрчээрээ хурдална. Зовууртай нэг цаг өнгөрч, замд нь дайралдсан дүрс болгон түүнийг буцаан авч явааг нотлон харуулна. Гэтэл нэг аварга том юм харагдаж сүйх тэрэг тэр рүү давхиад орчихмоор санагджээ. гэвч морьд эргэж, энэ аварга харанхуй юмны хажуугаар давхилаа. Энэ бол Ромыг хүрээлсэн бэхлэлтийн хэрэм байв.

- Яаж байгаа нь энэ үэ? Бид хот руу орохгүй юм уу? намайг цагдаагийн газар барьж аваагүй юм байжээ. Өршөөлт бурхан минь! Үнэхээр намайг... гэж Данглар бувтнан байв.

Толгойтой үс нь босох шиг болов.

Тэр Ромын дээрэмчдийн тухай ярихыг сонссон бөгөөд Парист байхдаа түүнд үнэмшдэггүй байсан аж. Альбер де Морсер, хатагтай Данглар, Эжени хоёрт нэгний нь хүргэн, нөгөөгийн нь нөхөр болох гэж байхдаа ярьж зугаацуулж байсан юм санаанд нь оржээ.

- Үнэхээр дээрэмчид үү? Хэмээн бувтнав.

Гэнэт сүйх тэрэгний дугуй элсэрхэг замаас өөр хатуу замаар тачигнан явах дуулдахад Данглар зориг гарган шагайн харвал: “Альберын дүрслэн зурж ярьж байсан Аппивын зам дээр байгаагаа мэдлээ.

Зүүн талынх нь доор дугариг хонхор харагдлаа. Энэ бол Каракаллын цирк байлаа. Баруун талд давхиж яваа хүний тушаалаар сүйх тэрэг зогслоо. Тэрхэн хооронд зүүн талын хаалга нээгдэв.

- Гар! гэж нэгэн хүн италиар тушаав.

Данглар сүйх тэрэгнээс даруй гарлаа. Тэр итали хэлээр ярьж чадахгүй ч гэсэн бүгдийг ойлгох болжээ.

Үхсэн амьд нь мэдэгдэхгүй амьтан тал тал тийшээ харна.

Хөтчийг тоолохгүй бол дөрвөн хүн тойрсон байв.

- Наашаа яв гэж тэр дөрвөн хүний нэг нь италиар хэлээд Аппивын замын нөгөө талын дов дундуур уруудан явлаа.

Данглар түрүүлч яваа хүнийг үг дуугүй дагаж, эргэж ч харалгүйгээ хойноосоо гурван хүн дагаж явааг мэдэрч байв.

Тэд манааны црэгүүд шиг адил хэмжээний зайтай газруудад згосон хоцор байх шиг санагджээ.

Данглар түрүүлж яваа хүнтэй нэг ч үг дуугаралгүй арваад минут хэр ингэж явснаа өндөр өвстэй толгодын дунд орлоо. Дуугүй зогсож байгаа гурван хүн гурвалжин мэт болж төвд нь өөрөө оров.

Юм ярих гэж хүсэх боловч хэл нь эвлэж өгөхгүй байв.

- Урагшаа яв! гэж өнөөх хүн ширүүн зандрангуй дуугаар хэлэв.

Энэ удаа Данглар маш сай ойлгов. Хэлсэн үг ажил хэргээр батлагдаж хойно нь явсан хүн ар талаас нь урдаа явсан хүнийг мөргөтөл нь огцом түлхээд авав.

Зам зааж явсан хүн бол бидний танил Пеппино бөгөөд өндөр ургасан өвсөн дундуур гарсан суусар гүрвүүл ч явж чадах нарийхан муруй тахир замаар сурмаг явна.

Өтгөн бут ургасан өндөр биш хадны урд очиж Пеппино зогслоо. Тэгснээ хадны завсраар үлгэрт гардаг чөтгөр шиг л сурмаг шурган орлоо.

Ар талд нь явсан хүний дангаж дуугарснаар банкны эзэн өмнөх хүнээ дага гэснийг ойлгов. Эргэлзэх юмгүй болжээ. Парисын дампуурсан хүн ромын дээрэмчдийн гарт оржээ.

Айснаасаа болж зориг орсон Дангларт өөр арга байхгүй болохоор үгий нь дагалаа. Хадны ангалаар шургахад төдий л зохилдоогүй гүзээгээ хайхралгүй Пеппиногийн хойноос нүдээ аньж нуруугаараа гулсан орж дахин хөл дээрээ зогсов.

Газарт хөл хүрэхэд нүдээ харав.

Зам нь өргөн боловч пад харанхуй байлаа. Пеппино гэртээ ирсэн учир өөрийгөө далдлахыг больж гал гаргаж, бамбар асаав.

Дангдарын араас орсон хоёр хүн түүнийг зогсоход нь түлхэж налуу газраар явж явсаар тэгшхэн газар очив.

Авсны нүхнүүд ухаж гаргасан цагаан ханууд хохимойн толгойн нүдний аяга харлан харагдах мэт харагдана.

Тэнд зогсож байсан манаач буугаа өргөн

- Хэн бэ? гэж асуув.

- Өөрийнх, өөрийнх! Гэж Пеппино хэлээд – Атаман хаана байна гэж асуув.

Тэгэхэд харуулын хүн өргөн ангальын цаанаас гэрэл нь тусаж байгаа хаданд ухаж гаргасан тасалгаа өөд мөрөн дэгүүрээ зааж,

- Тэнд байна гэлээ.

- Атаман минь, тун аятайхан олз шүү гэж Пеппино итали хэлээр хэллээ.

Тэгээд Дангларыг заамдан толгойлогчийн суудаг өрөө бололтой тасалгаа руу оросн хаалга мэт нүх рүү аваачив.

- Өнөөх хүн чинь үү? Гэж Плутархийн бичсэн Александрын амьдралын туужийг уншиж суусан толгойлогч асуув.
- Тиймэ, тэр хүн.
- Маш сайн. Түүнийгээ надад харуулаад орхи.

Пеппино тушаалыг биелүүлж барьсан байсан бамбараа дангларын нүүрэнд тулгах шахам ойртуулахад галд хөмсгөө хуйхалчих бий гэж айсан түшээ гүн гэдрэг боллоо.

Үхээрийн муухай цагаан царай нь айсандаа жигшмээр эвгүй харагдана.

- Наадах чинь ядарсан байна. Ор дэвсгэрийг нь зааж өг.
- Энэ ор дэвсгэр гэдэг нь ханан дээр ухаж гаргасан авс л байх даа. Миний унтах гэдэг ч тэр харанхуй дотроос гялалзаж байгаа хутгануудын аль нэгэнд бүлүүлж үхэхийг л хэлж байгаа байх даа гэж Данглар дотроо шивэгнэв.

Үнэхээр ч их тасалгааны гүн дотроос, Альбер де Морсер “Цезарийн тэмдэглэлийг” уншиж байхад нь Даглар Александрын амьдралын туужийг уншиж байхад нь дайралдсан тэр хүний нөхөд хэвтэж байсан чонын арьс дэвссэн хуурай өвсөн дээрээсээ өндийж байв.

Банкны эзэн уртаар гиншсэнээ замчилж ирсэн хүнээ даган явав. Тэр хашхирч орилж, мөргөн залбирахыг оролдсонгүй. Тэрүүнд ямар ч зориг, хүсэл, чадал, мэдрэхүй байхгүй болжээ. Түүнийг яв гэсэн учраас л хөдөлж байжээ.

Данглар шатны гишгүүрт бүдэрснээ өмнө нь шат байгааг мэдрэн духаараа хаалга мөргөчихгүйн тулд тонгойж хад ухаж гаргасан жовгонд орлоо. Энэ нь хэдийгээр газар доор байгаа боловч цэвэр, бас хуурайхан байв.

Нэг буланд нь хуурай өвсөөр дэвсгэр засаж дээр нь ямааны адсага хаячихсан байв.

Данглар үүнийг хараад аврагдахын бэлэг тэмдэг гэж үзлээ.

- Бурхан минь! Үнэхээр ор дэвсгэр байна шүү гэж шивгэнэв.

Тэрээр арваад жил бурхан минь гэдэг үгийг хэлээгүй явсан бол ганцхан цагийн дотор хоёр дахь удаагаа бурхны нэрийг дуудаж байгаа нь энэ ажээ.

- За энд гэж дагуулж ирсэн хүн италиар хэлснээ, Дангларыг түлхэж оруулаад хаалгы нь хаачхав.

Хаалганы түгжээ дуугарч, Данглар бүрэн олзлогдох нь тэр.

Ер нь түгжээгүй ч гэсэн Сен-Себастианийн газар гэрийг эзэмшигч уншигч авгай нар алдарт Луижжи Вампа гэж хэдийн таньсан удирдагчаа хүрээлэн байгаа хуарангийн хажуугаар сэм зайлж гарахад өөрөө гэгээн Петр бөйх эсвэл чигaa тэнгэрээр газарчлуулсан байх хэрэгтэй ажээ.

Альбер түүний тухай Парисынханд танилцуулах гэж хичээхэд нь Данглар үнэмшихгүй байсан сайхь дээрэмчнээ одоо л таньжээ. Данглар зөвхөн түүнийг таниад зогсоогүй Альбер де Морсерын хоригдож байсан Жовгоныг таньжээ. Энэ өрөө нь гадаадын зочдод зориулагдсан бололтой.

Энэ бүхэн Дангларыг тайвшрууллаа. Дээрэмчид түүнийг алаагүй болохоор ерөөсөө алахгүй гэсэн үг.

Түүнийг дээрэмдэж тонох гэж барьж авсан, тэгэхээр биедээ хэдхэн алтан зоостой болохоор золиосны мөнгө нэхнэ гэж боджээ.

Морсерыг дөрвөн мянган экигээр үнэлснийг санаж, өөрөө Морсероос илүү сүртэй харагдах болохоор найман мянган экио шаардах байх гэж боджээ. Найман мянган экио гэдэг бол дөчин найман мянган ливр гэсэн үг.

Тэгэхэд түүнд таван сая тавин мянга шахам франк байгаа. Ийм мөнгөтэйгээр ямар ч байдлаас гарч болно.

Тэгэхээр хүний золиосонд таван сая, тавин мянган франк нэхэж байсан жишээ байгаагүй учир Данглар дэвсгэр дээрээ хэвтэж тал тал тийшээ эргэлдэн байснаа Луизи Вампын амьдралын нь туужийг судалж байгаа тэрхүү баатар шиг тайван унтлаа.

18.ЛУИЖИ ВАМПЫН ХООЛНЫ ҮНИЙН ЖАГСААЛТ

Дангларын айж унтсан тэр нойрноос өөр бусад нойрны дараа хүн аажмаар сэрдэг юм.

Данглар ч сэрдээ.

Торгон хөшиг, зөөлөн эдээр бүрхсэн хана, задгай зууханд шаржигнан шатаж байгаа түлээний давирхайн үнэр, орны атлас хөшигний анхилуун үнэрт дасаж сурсан Парисын хүн шохойдсон ханатай агуйд сэрэхэд зүүд шиг санагдах нь зүйн хэрэг.

Данглар ямааны адсаган дэвсгэртээ хүрснээ махчин лапландчуудын дунд орчихжээ хэмээн зүүдэлсэн шиг санагджээ.

Ийм үед эргэлзэж байгаа зүйлийг хамгийн үнэн зүйл болгоход ганцхан хором л хэрэгтэй болдог.

“Ингэхэд би чинь Альбер де Морсерын ярьсан дээрэмчдийн гарт байгаа шүү дээ” гэж саналаа. Тэр шархдаагүй гэдгээ мэдэхийн тулд уртаар амьсгаа авав. Данглар арай гэж уншин дуусгаж, ганц нэг юм тогтоож авсан цорын ганц ном болох “Дон-Кихотоос” үүнийг уншиж мэдсэн ажээ.

“Үгүй, тэд намайг алаагүй, тэр ч байтугай шархдуулаагүй байн.а Харин тоночихсон юм биш байгаа” гэж бодлоо.

Тэгээд бүх хармаануудаа тэмтчин үзэв. Тэгэхэд бүх юм нь бүрэн байв. Ромоос Венед орох замдаа хэрэглэх гэсэн зуун луидор өмдний нь хармаанд, таван сая тавин мянган франкийн авлагын баримт хийсэн түрийвч нь цамцны нь хармаанд байж байв.

“Хачин дээрэмчид юм даа! Миний түрийвч мөнгийг аваагүй байна шүү! Би өчигдөр унтахаар хэвтэхдээ зөв боджээ. Тэд надаас золиосны мөнгө л нэхэх байх. Цаг ч хэвээрээ байсан газратаа байж байна. хэдэн цаг болж байга юм бол харъя” гэж өөр зуураа ярив.

Брегетийн нандин бүтээлийн нэг болох Дангларын цаг, замд гарахынхаа өмнө нарийвчлан сайн түлхэж тааруулсан учир өглөөний таван цаг хагас болсныг зааж дуугарлаа. Дангларын байгаа жовгонд өдрийн гэрэл орж ирэхгүй учир өөрөөр цаг мэдэхийн аргагүй байв.

Дээрэмчдээс у-рыг нь асуух уу? Эсвэл өөрсдөө ярьж эхлэхийг нь хүлээх үү? Гэж бодсоноо сүүлчийнх нь шийдвэр илүү болгоомжтой шиг санагдаад Данглар хүлээхээр шийдээд өдөр дунд болтол хүлээлээ.

Энэ бүх хугацаанд үүдэнд манаач зогсож байв. Өглөөний найман цагт манаач нь солигдлоо. Данглар ямар хүн зогсож байгааг харах гэж хүсжээ.

Үүдний нь муу шахсан банзны нь завсраар өдрийн бус харин дэнгийн гэрэл тусаж байхыг харжээ. Данглар завсруудын нэгээр нь шагайх гэж очтол яг тэр үед нь дээрэмчин хөхүүрээс архи ууж байгаа харагдсан бөгөөд үнэр нь түүнд муухай санагджээ.

- Түй! гэж Данглар ухрав.

Өдөр дунд архинд дуртай хүний оронд өөр хүн солигдов. Данглар шинэ манаачаа сонирхон дахиад л хаалганы завсраар шагайв.

Энэ удаа түүнд том биетэй, бүлтгэр нүдтэй, зузаан уруултай, бондгор хамартай ёстой Голиаф байж байгаа харагдлаа. Бөөгнөрсөн өтгөн шар үс нь могой мэт мушгиралдан мөр рүү нь унжжээ.

“Энэ ч хүнтэй гэхээсээ махчинтай л илүү төстэй амьтан байна. Бурхны авралаар би хөгширч, мах нь хатуурсан амьтан хойно аргагүй биз дээ” гэж Данглар боджээ.

Данглар бас тоглоом хийхтэйгээ байгааг харж байгаа биз.

Яг энэ үед цаадах нь махчин биш гэдгээ мэдэгдэх гэсэн мэт хаалганы өмнө талд суугаад үүрэгнээсээ хар талх, хэдэн сонгино, бяслаг гаргаж ирээд ховдоглон идэж эхлэв.

Тэгэхэд Данглар дээрэмчний хооллохыг хараад

- Чөтгөр ав, яаж ийм заваан юм идэж болдог юм бэ гэж хэллээ.ь

Тэгээд ямааныхаа арьсан дээр суухад арьсны үнэр нь түрүүчийн манаачийн уусан архи шиг үнэртэж байв.

Данглар хэдий хичээвч байгалийн нууцын учрыг олоход даанч хэцүү байжээ. Өлсгөлөн гэдсэнд ямар ч муухай зууш үлэмж аятайхан санагдах цаг тохиолдлоо.

Данглар гэдсээ хоосон болохыг мэдлээ. Манаач түүнд тийм ч муухай маьтан биш, талх нь тийм ч хар биш, бяслаг нь тэгтлээ хатсан биш санагджээ.

Зэрлэг хүний муухай хоол болсон түүхий сонгино нь Дангларыг “Денизо, өнөөдөр надад хурцхан шиг юм бэлтгэчихээрэй” гэж хэлэхэд тогоочийнх нь маш сайхан бэлтгэдэг Роберын сүмсийг санагдуулжээ.

Тэгээд босож хаалга цохив.

Данглар дахин цохив.

- Юу вэ? гэж дээрэмчнийг италиар асуухад Данглар хуруугаараа хаалгыг нь бөмбөрдөн байж,

- Найз минь, бас миний тухай санаа тавих болсон вч биш үү? Гэв.

Аварга хүн түүний хэлснийг ойлгоогүй ч юм уу эсвэл зохих тушаал өгөөгүй алин боловч тоосонгүй дахин юмаа идэж эхлэв.

Дангларт доромжлогдсон мэт санагдаад дахин ийм бүдүүлэг амьтантай ярихаа болихоор шийдэж ямааныхаа адсаган дээр хэвтээд нэг ч үг дуугарсангүй.

Бас дөрвөн цаг өнгөрлөө. Аварга эрийн оронд өөр нэгэн дээрэмчин ирж манав. Аль хэдийн нь өлссөн Данглар сэмээрхэн босож үүдний завсраар шагайж өөрийгөө газарчилж явсан хүний ухаалаг царайг харж танив.

Энэ бол жижүүрээ тохитойхон өнгөрүүлэе гэсэн Пеппино байв. Тэр хаалганы урд суугаад, өөхөнд шарсан түрэг вандуй дүүргэсэн шавар ±ав урдаа тавив.

Вандуйныхаа хажуу талд сагсаар дүүрэн усан үзэм, нэг лонх дарс тавилаа.

Энэ амттайхан хоолыг хараад Дангларын шүлс нь гоожлоо.

“Энэ нь арай уриалгахан юм биш байгаа” гэж бодоод хаалгыг нь аяархан тогшив.

- Очлоо, очлоо гэж цаадах нь францаар хэллээ. Тэрээр Пастринийн зочид буудалд байхдаа франц хэл сурсан байжээ.

Тэгээд очиж хаалгыг нь онгойлгов. Данглар түүнийг хараад, өнөөх “Толгойгоо цааш хий!” гэж зандарч байсан хүн мөн болохыг танив. Одоо юуны нь зэмлэхтэй мантай, хамгийн найрсаг царай гарган инээмсэглэж,

- Уучлаарай эрхэм ээ? Надад хоол өгөхгүй юм болов уу? гэлээ.
- Юу гэсэн үг вэ, энэ чинь! Эрхэм ноён та ингэхэд өлсчихлөө гэж үү? Хэмээн Пеппино дуу алдлаа.
- “Ингэхэд” гэдэг чинь дэндүү байна. Юм идээгүй бүтэн хоног болж байна гэж Данглар бувтнав. Тэгснээ
- Би өлсөж байна. Тэр ч байтугай их өлсөж байна гэв.
- Эрхэм ноёнтон та юм идэх гээ юу?
- Бололцоотой бол даруйхан,
- Тэрнээс амархан юм байхгүй. Энд ямар ч хоол авч идэж болно. Харин сайн санаат христос шашинтан бүхний адилаар мөнгөөр л авч иднэ шүү дээ гэж Пеппино хэлэв.
- Мэдээж хэрэг! Хэдийгээр, шуудхан хэлэхэд та нар хүнийг барьж хорьсон болохоор үгүй ядахдаа хооллодог байх ёстой шүү дээ гэж дангларын хэлэхэд,
- Үгүй, эрхэмтэн минь. Манай энд тэгж заншаагүй юм гэж Пеппино зөрлөө.
- Энэ ч үндэсгүй нотолгоо байна даа. гэсэн ч дэмий маргаад яах вэ гэж Данглар хуягаа найрсаг дуугаар нааш татах гэж оролдон – Тэгэхээр надад өдрийн хоол өг гэж тушаагаач гэв.
- Эрхэмсэг минь одоохон. Харин та юу захих сан бол? гэж хэлснээ Пеппино хоолтой савнаас нь савсаж байгаа уур Дангларын хамрыг цоргихоор газар тавиад, - Захиарай гэв.
- Танай энд гал тогооны газар байга юм уу? гэж банкны эзэн асуув.
- Яалаа гэж? Байлгүй яах вэ. Тэгэхдээ маш сайн хоолны газар бий шүү.
- Тогооч бас бий юу?
- Дээд зэргийнх!
- Тэгвэл тахианы дэгдээхий, загас, эсвэл ямр нэг шувууны мах аль. Аль ч яахав, ганцхан идэх л юм өгч үз.
- Эрхэм таны дуртай юм бүхнийг өгнө. Тэгвэл тахианы дэгдээхий өгөх үү?
- Тэг, тэг.

Пеппино нуруугаа тэгшилж байдаг хоолойгоороо,

- Эрхэм ноёнд тахианы дэгдээхий өгөөрэй! Гэж хашхирав.

Пеппиногийн дуу цуурайтаж дуусаагүй байтал эрхтний загас зөөгч шиг нүцгэн цээжтэй, цэвэрхэн сайхан биетэй залуу гарч ирлээ. Тэр тахианы дэгдээхийтэй мөнгөн дийз толгой дээрээ тавьж гараараа түшихгүй явж байв.

- Кафе-де-Пари зоогийн газрынх шиг юмаа гэж Данглар бувтналаа.

- Ажаам уу, эрхэм ээ гэж Пеппино хэлээд залуу дээрэмчний гараас дийтэй хоол авч дөрвөлжин сандал ба яамааны адсаганы хамт энэ өрөөний бүх хэрэглэл болж байгаа хорхой идчихсэн ширээн дээр тавив.

Данглар сэрээ, хутга нэхэв.

- Болно, болно, эрхэм ээ гэж Пеппино хэлээд мухар үзүүртэй жижиг хутга, модон сэрээ өглөө.

Данглар нэг гартаа хутгаа, нөгөөдөө модон сэрээгээ барьж шувууныхаа махыг огтлох гэв.

- Эрхэм ээ, уучлаарай хэмээн Пеппино банкны эүний мөрөн дээр гараа тавьж, - Манай энд урьд нь мөнгөө төлчихдөг юм шүү. Зочин та дургүйцэхгүй сэн болов уу гэв.

“Энэ ч харин Кафе-де Парийтай адилгүй юм. Эд лав шунах гэж бодож байгаа байх. Гэсэн ч нарийлаад яах вэ. Италид амьдрал хямдхан гэж дуулсан юм. Ромд лав тахианы дэгдээхий арван хоёр су байдаг байх” гэж Данглар бодлоо.

- Май энүүнийг ав гэж хэлээд Пеппинод нэг алтан зоос чулуудчихлаа. Пеппино зоосыг авлаа. Данглар махан дээрээ хутгаа тавив.
- Эрхэм минь, жаахан хүлээгээрэй. Эрхэм ноён та надад дутуу өгөөд байна шүү шэж Пеппинл хэлэв.
- Тийм ээ эд бүр намайг лушах гэж байгаа юм гэж Данглар амандаа үглэв. Гэвч үүнээс нь зөрөхгүй гэж шийджээ.
- Би энэ тахианы туранхай маханд чинь хичнээн мөнгө төлөх ёстой юм бэ? гэж тэр асуув.
- Тахианы махны үнэд ганцхан луидор өгсөн шүү дээ.
- Тахианы махны үнэд ганцхан луидор өгсөн гэнэ ээ?
- Тийм ээ.
- За яах вэ... Тэгээд цааш нь?
- Одоо эрхэмтэн та дөнгөж мянган есөн зуун ерэн есөн луидор өгөх үлдээд байна.

Данглар энэ гайхалтай тоглоом хийхийг дуулаад нүдээ бүлтийлгэв.

- Зугаатай хэрэг байна даа. дэндүү зугаатай хэрэг байна гэж бувтналаа. Тэгээд дахин хоолоо илэх гэсэн чинь Пеппино зүүн гараараа түүнийг барьж, баруун гарынхаа алгыг тосож,
- Үнийг нь төлөөрэй гэв.
- Юу гэнэ ээ?? Та битгий тоглоом хийгээд байгаарай гэж Данглар хэлэв.
- Эрхэм ээ, бид хэзээ ч тоглоом хийдэггүй шүү гэж Пеппино ноцтой нь аргагүй хэлэв.
- Энэ тахиа зуун мянган франкийн үнэтэй юм гэж үү?
- Энэ агий дотор шувуу авч байна гэдэг я-ар хэцүү болохыг та мэдэхгүй юм даа.
- Энэ тун инээдтэй, хөгжилтэй юм болох нь. За би өлсөж байна. Хоолоо идэхэд минь битгий саад хийж үзээч. Май найз минь бас нэг луидор танд өгчихье гэж Данглар хэллээ.
- Тэгвэл одоо та дөнгөж дарван мянга есөн зуун ерэн найман луидор төлөх үлдээд байна гэж Пеппино өнөө л янзаараа хэлээд – Жаахан л тэвчиж орхивол бид тооцоогоо хийчихнэ гэв.

Ингэж зөрүүдлэн доромжлоход нь уур нь хүрсэн Данглар,

- Хэзээ ч үгүй. Чөтгөр рүүгээ тонил цаашаа. Та хэнтэй ярьж байгаагаа мэдэхгүй байна даа гэж хэлэв.

Пеппиног дохио өгөхөд залуу хүү тахианы махыг шалавхан хурааж авав. Данглар ямааны адсага дээрээ хэвтээд өглөө. Пеппино хаалгыг нь түгжчихээд дахин тостой вандуйгаа идэж эхэллээ.

Пеппино юу хийж байгааг Данглар харж чадахгүй боловч цаадах нь чанга чанга тамшаалан зажлах учир юу хийж байгааг нь мэдэж байв.

Юм идэж байгаа, гэхдээ хүмүүжилгүй хүний ёсоор чимээтэй идэж байга нь илтэд байв.

- Тэнэг амьтан! Гэж Данглар хараав.

Пеппино дуулаагүй юм шиг царай гарган суув. Тэр ч байтугай эргэж харах ч үгүй хэнэггүй, удаанаар амтлан идэж ыбайв.

Дангларт түүний гэдэс Данаидын торх мэт ёроолгүй юм шиг санагджээ. Хэзээ ч гэдэс нь дүүрнэ гэдэгт итгэмээргүй санагдана.

Гэхдээ хагас цаг хяраатай тэссэн боловч энэ хагас цаг нь жил шиг санагджээ. Эцэст нь босож дахин үүд өөд очлоо.

- Эрхэм минь намайг удаан бүү зовоогооч. Надаас су хэрэгтэй байгаагаа шууд хэлээ гэж хэллээ.

- Та биднээс юу хүсэж байна, эрхэм ээ? Тушаавал бид биелүүлнэ.

- Тэгвэл юуны өмнө хаалгаа онгойлго!

Пеппино хаалга онгойлгов.

- Чөтгөв ав, би юм идэхийг хүсэж байна! гэж данглар хэлэв.

- Та өлслөө гэж үү?

- Та өөрөө мэдэж байгаа шүү дээ.

- Эрхэм та юу идэхийг хүсэж байна?

- Энэ хараал идмэрийн газар чинь тахианы дэгдээхий тийм хэмжээгүй үнэтэй юм бол зүсэм хар талх авахаас яах вэ?

- Талх ий? Болно, болно. Хөөе талх! Гэж Пеппино хашхирав.

Залуу хүү, жижигхэн талх авчрав.

- Май, гэж Пеппино хэлэхэд Данглар,

- Үнэ нь хэд вэ? гэж асуулаа.

- Дөрвөн мянга есөн зуун ерэн найман луидор. Та урьдчилаад хоёр луидорыг төлчихсөн шүү дээ.

- Юу гэнэ ээ! Ганцхан жаахан талх зуун мянган франк байх гэж үү?

- Зуун мянган франк гэж Пеппино хариулав.

- Тахианы мах чинь зуун мянган франкийн үнэтэй шүү дээ.

- Манайд хоолны үнийн жагсаалт байдаггүй. Юм бүхэн ганцхан үнэтэй. Та их ч, бага ч иднэ үү, эсвэл арван хоол захиална уу, ганц хоол захиална уу, үнэ нь өөрчлөгдөхгүй.

- Та бас тоглоом хийж байх шив. Энэ чинь ерөөсөө тэнэг хэрэг! Та нар намайг өлсгөлөнгөөр алах гэж байгаагаа шууд хэлчихвэл дээр байна.

- Үгүй та л өөрийгөө өлсгөх гээд хүсээд байх шиг байна. Үнийг нь төлчихөөд л идэхгүй юу.

- Мал минь би юугаараа төлөх юм бэ? Чи намайг зуун мянган франк хармаалж явна гэж санаж байна цуу? Гэж Данглар байж ядан хэллээ.
- Эрхэм минь таны хармаанд таван сая тавин мянган франк бий. Энэ бол зуун мянган франкийн үнэтэй тавин тахианы дэгдээхий бас тавин мянган франкаар нь хагас дэгдээхий авч болно гэсэн үг.

Данглар цоин татвасхийв. Нүдний нь боллт унах нь тэр. Хэвийвээр энэ мэдээж тоглоом ч гэсэн Данглар одоо үүнийг ойлгожээ.

Тэр үүнийг урьдын адил шулуухан хавтгай биш гэдгийг мөн ойлгожээ гэдгийг ташрамд хэлэх хэрэгтэй юм.

- Хөөе, би тэр зуун мянган франкийг чинь өгвөл, та бид хоёр тооцоо хийсэн болж, би хоолооо тайван идэж болох уу? гэж Данглар хэлэхэд,

- Мэдээж хэрэг гэж Пеппино хариулав.

Тэгэхэд Данглар тайвшран санаа алдаж,

- Би тэр мөнгийг яаж та нарт өгөх юм бэ? гэж асуув.
- Тэрүүнээс амархан юм гэж байхгүй. Та чинь Ром хотын Банкны гудамж дахь Томсон Френчийн банкинд харилцах данстай шүү дээ. Тэгэхээд бидэнд дөрвөн мянган есөн зуун ерэн найман франкийн чек бичээд өгчих.

Манай банкны эзэн түүнийг чинь авна.

Данглар, үгүй ядахдаа сайн дураараа өгч байгаа дүр үзүүлэхийг хичээж байв.

Пеппиногийн өгсөн үзэг цаасыг авч зурвас бичээд, гарын үсэг зурчихаад,

- Май, энэ чекийг авч, зохих хүнд нь үзүүл гэв.
- Май, танд энэ тахианы дэгдээхий.

Данглар санаа алдаад махаа огтлов. Энэ нь тарган үнэтэй нь зэрэгцүүлбэл даанч туранхай мах байлаа.

Пеппиногийн тухайд гэвэл өгсөн зурвасыг нь авч анхааралтайгаар уншаад хармаандаа хийж түрэг вандуйгаа идэж гарав.

19.ӨРШӨӨЛ

Маргааш нь Данглар бас л өлслөө. Энэ агуй доторх агаар нь хоол идэх дур хүргэх ажээ. Олзны хүн энэ өдөр мөнгө үрэхгүй гэж шийджээ. Угийн нямбай учир хагас махаа хэсэг талхтай хойш нь тавьсан байжээ.

Гэтэл өлсөөс илүү ам хатах ажээ. Данглар ам цангах тухай тооцоолоогүй байжээ.

Хуурайжсан хэлээ тагнайдаа наалдах хүртэл юм уухгүй хичээгээд байв. Тэгээд тэсэхгүй болохоороо хүн дуудлаа.

Манаач хаалгыг нь онгойлгож өгөхөд, танихгүй царай харагджээ. Тэгэхээр нь Данглар хуучин танилтайгаа яривал дээр гэж бодоод Пеппиног дуудуулав.

- Эрхэм минь би энд байна гэж хэлээд дээрэмчин яаран гарч ирсэн нь Дангларт сайны ёр мэт санагджээ.
- Та юу гэсэн юм бол? гэж дээрэмчний асуухад,
- Уух юм гэж хоригдол хэлжээ.
- Ромын орчим дарс хэмжээгүй үнэтэй гэдгийг та мэдэж байгаа байх аа гэж Пеппино хэлэхэд данглар цлхилтыг нь няцаах гэж,
- Тэгвэл надад ус аль даа гэв.

- Ай, эрхэм ноён минь ус чинь дарснаас ховор зүйл шүү. Одоо тун аймшигтай ган болж байна!
 - Бас л шинээр эхлэх болж байх шив? Гэж Данглар хэллээ.
Тэгээд тоглоом хийж байгаа дүр үзүүлэх гэж оролдон инээмсэглэсэн боловч чамархайны нь хөлс гарч байв. Пеппино мөн л ажиг ч үгүй байхыг хараад Данглар
 - Найз минь ганцхан аяга дарс гуйя. Та үүнийг харамлана гэж үү гэв.
 - Эрхэм ээ бид жижиглэн худалддаггүй гэж танд хэлсэн шүү дээ гэж Пеппино ширүүхэн хэллээ.
 - Тэгвэл надад нэг лонхыг аль даа.
 - Ямраас нь авах вэ?
 - •ямдханаас нь авъя.
 - Бүх дарсны үнэ адилхан.
 - Ямар үнэтэй юм бэ?
 - Шил нь хорин таван мянган франк.
 - Та нар намайг тононо гэдэг санаг а хэлбэл дээр юм биш үү гэж Данглар зөвхөн Гарлагон л зүй ёсоор нь үнэлж чадахаар гунигтайгаар хэлээд – Энэ нь миний арьсыг хэсэг хэсгээр нь хуулахаас амар юм даа гэв.
 - Дарга маань тэгнэ гэж бодож байж болох л юм гэж Пеппино хэллээ.
 - Дарга гэнэ ээ? хэн гээч хүн бэ?
 - Уржигдар таныг түүн дээр оруулсан шүү дээ.
 - Одоо хаана байна?
 - Энд бий.
 - Би түүнтэй уулзаж болох уу?
 - Тэрүүнээс амархан юм гэж байхгүй.
- Минут ч өнгөрөөгүй байтал, Луижиг Вампа Дангларын өмнө хүрч ирлээ.
- та намайг дуудуу юу? гэж олзлогдсон хүнээс асуув:
 - Эрхэм та намайг нааш нь авчирсан энэ хүмүүсийн дарга уу?
 - Тийм ээ эрхэм минь. Тэгээд юу гээ вэ?
 - Та миний золиосонд хичнээн мөнгө нэхэх гэж байна?
 - Танд байгаа тэр таван сая цранкийг чинь л авна.
- Дангларын зүрхийг мөс шиг хүйтэн гараар базах шиг санагджээ.
- Энэ бол их хөрөнгөний минь үлдэгдэл байгаа юм. Хэрэв та үүнийг минь надаас салгаж авбал бас амийг нь аваарай.
 - Танаас цус гаргахыг бидэнд хориглосон.
 - Хэн хориглосон юм бэ?
 - Биднийг захирдаг тэр хүн.
 - Тэгвэл та өөр хүнд захирагддаг байх нь ээ?
 - Тийм ээ, даргадаа захирагддаг.
 - Би таныг л дарга нь юм байх гэж санасан гэв.
 - Би энэ хүмүүсийн дарга. Харин надад бас дарга байдаг юм.
 - Тэр дарга чинь бас өөр хүнд захирагдах уу?
 - Тийм.
 - Хэнд тэр вэ?
 - Бурханд.
- Данглар бодлогоширсноо:

- Ойлгохгүй байна гэв.
- Магадгүй ээ.
- Тэр дарга чинь та нарыг надтай ингэж харьцаарай гэж тушаасан уу?
- Тиймээ.
- Ямар зорилгоор тэр вэ?
- Эүүнийг би мэдэхгүй.
- Гэхдээ миний түрийвч нэг л өдөр хоосорно шүү дээ.
- Тэгж л таарна.
- Нэг саяыг авахгүй юу? гэж Данглар хэлэв.
- Үгүй.
- Хоёр саяыг?
- Үгүй.
- Гурван саяыг? Дөрвөн саяыг? За дөрвөн саяыг. Та нарыг суллаж тавина гэж ам өгвөл би үүнийг өгье гэв.
- Таван саяыг авах учиртай байхад та дөрвөн саяыг ав гээд байдаг чинь миний бодлоор хожих гэсэн үг биз дээ, банкны эзэн гуай?
- Бүгдийг нь ав! Бүгдийг нь ав, дуулж байна уу. Тэгээд намайг алаарай гэж Данглар хашхирав.
- Эрхэм минь, тайвшир ингэж уурлах хэрэггүй. Тэгвэл та өдөрт нэг саяыг идчихээр хоолонд тийм дуртай болчихно шүү. Чөтгөр ав, жаахан хямгатай байгаарай.
- Танд төлөх мөнгөгүй болохоор би яах вэ? гэж Данглар сандчин асуув.

Тэгвэл та өлсөх л болно доо.

- Өлсөх гэнэ ээ? гэж Данглар зэвхийрэн хэлэхэд,
- Тэгж л таарна гэж Вампа ажиггүй хариулав.
- Үгүй та чинь намайг алах дургүй байгаа гэж хэлсэн шүү дээ.
- Тийм ээ.
- Тэгээд намайг өлсгөж үхүүлэх хэрэг үү?
- Энэ бол шал өөр хэрэг л дээ.
- Тэгвэл үгүй, бузар золиг минь, би та нарын бузар тооцоон нураана даа. Би үхэх л ёстой бол түргэн үхэх нь дээр. Та нар намайг тарчилган зовоосон ч миний гарын үсгийг авч чадахгүй гэж Данглар дуу алдлаа.
- Эрхэмсэг таны дураар л болог гэж Вампа хэлээд өрөөнөөс гарлаа.

Данглар галзууран орилж ямааныхаа арьтан дээр ойчив.

Тэд ямар улс вэ?

Нүдэнд үл харагдавч дарга нь хэн бэ? Тэд ямар санаатай байгаа юм бо? Яагаад бусад хүн золиосн» мөнгө төлөөд эндээс ангижирч болж байхад би болдоггүй юм бэ?

Түргэн үхэл л үл ойлгогдом өс хонзонгоор өөрийг нь золиос болгож буй хатуу ширүүн дайснуудын нь төлөвлөгөөг эвдэн хаяж болно.

Гэвч үхэх гэдэг хэцүү!

Данглар урт удаан амьдралынхаа туршид анх удаа үхлийн тухай бодсон бөгөөд түүнийг уриалан дуудахдаа айж байжээ. Амьд амьтан бүрийн дотор нуугдан зүрхийг нь цохих бүрд “Чи үхнэ” гэж хэлж байдаг хий үзэгдлийн нүүрийг олж харах хором иржээ.

Данглар хор идээд үхэх гэж арга нь барагдан тарчилж, цөхөрсөөр байгаад аврагддаг араатантай адил байв.

Тэр оргох тухай бодлоо. Гэвч хүрээжл байгаа хана нь хаднаас зузаан, гарах ганц хаалган дээр ном уншсан хүн сууж цаад талаар нь буутай хүмүүс нааш цаашаа явж харагдана.

Данглар дөнгөж данган хоёр өдөр л шүд зууж тэвчээд дараа нь сая франкаар нь хоол авахыг гуйвал өгсөн франкийг нь авч оронд нь гомдолгүй сайхан хоол идүүлэв.

Энэ үеэс эхлэн хөөрхий олзлогдсон амьтны амьдрал ухралтын байдалд орж эхлэв. Тэр илүү зовж зүдрэх чадалгүй болтлоо тарчилсан болохоор түүнээс шаардсан бүхнийг нь гүйцэтгэж байв. Ингэж арван хоёр хоножээ. Тэгээд ахиж дэгжиж явсан үеийнхээсээ дооргүй хоол идээд, хэдэн чек өгснөө бодож үзжээ. Тэгсэн чинь түүнд дөнгөж тавьхан мянган франк үлдсэн байв.

Тэгэнгүүт аймшигтай өөрчлөлт гарч, таван саяыгаа өгсчихсэн хүн маань сүүлчийнхээ тавин мянгыг хадгалж үлдэхээр шийджээ. Тэрээр энэ мөнгөө л өгөхгүйн тулд юм бүхнээс бүрэн татгалзаж амьдрахаар шийджээ. Түүний толгойд галзуурахын даваан дээр гарсан горьдлого төрөх шиг болжээ. Аль хэдийнээс бурхан гээчийг мартчихсан тэр хүн бүхнийг чадагчийн тухай бодох болжээ. Заримдаа бурхан гайхамшигийг бүтээдэг юм гэж өөрөө өөртөө ярина. Агуй нурж мэднэ, богд ламын цэрэг энэ нүнэлт газрыг илрүүлж түүнд тусалж болох юм гэж бодно. Тэгвэл түүнд тавин мянган цранк үлдэх бөгөөд тэр нь өлсөж үхэхгүйгээр амь зогоогоод байхад хүрэх ажээ. Тэгээд л энэ тавин мянгыг нь бурхан өөрт нь үлдээж өгөхийг хүсэж, нулимс гарган мөргөнө.

Ийм аяагтай гурван хоног өнгөрүүлсэн бөгөөд энэ хугацаанд бурхны нэрийг үнэн зүрхнээсээ биш ч гэсэн аман дээрээ л лав зогсолтгүй дуудаж байв. Заримдаа хөөрхий өрөвдмөөр өвгөн үхэх гэж хэвтэж байсныг цонхоороо харсан юм шиг санагдаад явяхна. Энэ өвгөн бас өлсөж үхсэн юм.

Данглар дөрөв дэх өдөр нь амьд хүн би, амьд хүүр боллоо. Тэр урьдах хоолны үлдэгдлийг цуглуулж, чулуун шалан дээр дэвссэн сийрснийг мэргэж эхлэв.

Тэгэхэд бурхан мөргөдгийн адилаар Пеппиног идэх юм өгөөч гэж царайчлан зүсэм талхны үнэнд мянган франк өгье гэж байв.

Пеппино юм дуугарсангүй.

Тав дахь өдөр нь Данглар үүд рүү мөлхөж очоод,

- Та бол христос шашинтан биш байна. Та бірхны өмнө, өөрийн найз нөхрийг турааж алах гээ юу? гэж өвдөг сөхрөн хэлэв.

“Миний найз нөхөд хаана байна?” гэж бувтнаад газар унав.

Дараа нь өндийж:

- Даргыг, даргыг дууд! Гэж хашхирав.
- Би энд байна, Танд юу хэрэгтэй вэ? гэж Вампа тэр дороо гарч ирэн асуув.

Тэгэхэд данглар түрийвчээ гарагж,

- Миний сүүлчийн алтыг ав. Харин намайг энэ агуйдаа суухыг зөвшөөрөөч. Би одоо суллагдахыг гуйхгүй. харин зөвхөн амь насыг минь үлдээгээрэй гэв.
- Та их зовж байна уу? гэж Вампа асуув.

- Би ихэд тарчлан зовж байна.
- Гэхдээ танаас илүү их зовж зүдэрсэн хүн бий.
- Тийм байх ёсгүй!
- Үгүй тийм шүү! Өлсөж үхсэн хүн бий.

Тэгэхэд Данглар цэцэглэж явсан үедээ нэгэн муу оромжид өрөвдмөөр болсон ор дэвсгэрт хэвтэж байсан өвгөнийг санажээ.

Данглар гиншин чулуун шал руу духаа наалдуулан уналаа.

- Тийм ээ надаас илүү зовж зүдэрсэн хүмүүс байсан юм. гэвч тэд нажидаа эдлэх одонд төрсөн хүмүүс байсан юм.
- Та гэмээ наманчилж байна уу? гэж нэгэн хүн широүүн авч сүртэйгээр асуухыг дуулаад Дангларын үс өрвийх шиг болов.

Бүрэлзсэн нүдээр орчих тойрноо эргүүлэн харвал, Луизи Вампын цаад талд баганын сүүдэрт нэг цувтай хүн зогсож байв.

- Би юунд гэмээ наманчлах билээ? хэмээн Данглар дөнгөж дуулдахуйцаар хэлэхэд, нөгөө хүн,
- Хийсэн хорт муу үйлийнхээ төлөө гэж хэллээ.
- Нүглээ наманчилж байна, хүлээж байна гэж Данглар дуу тавих хэлээд, эцэнхий гараараа цээжээ нүдэв.

Тэгэхэд үл таних хүн,

- Тэгвэл би таныг уучилъя гСж хэлээд цуваа тайлж урагшаа нэг алхаж гэрэлтэй газар гарч ирлээ.
- Монте-Кристо гүн! гэж Данглар хашхирахад өлсөн зовсноос болж цонхисон царай нь улам ч зэвхийлээ.
- Та андуурч байна даа. Би Монте-Кристо гүн биш.
- Тэгээд хэн юм бэ?
- Би бол таны худалдаж, урваж, нэр төргүй боогосон тэр хүн. Би бол таны болзоот хүүхнийг нь завхруулж, баялаг хөрөнгөнд хүрэхийн тул гишгэчин хаясан тэр хүн. Би бол таны уршгаар эцэг нь өлсөж үхсэн тэр хүн. Би таныг өлсгөж үхүүлэх ёстой бйасан боловч уучлах хэрэгтэй болсон учир таныг өршөөе. Би Эдмон Дантес байна!

Данглар дуу алдан хашхираад хөлийн нь дэргэд уналаа.

- Бас! Би таны амийг хэлтрүүлж байна. Таны хамсаатнууд ийм азтай байгаагүй дээ. нэг нь галзуурч, нөгөөх нь үхсэн! Та тэр тавин мянган франкаа өөртөө үлдээ. Би танд бэлэглэж байгаа юм. Харин өнчин ядуусаас хулгайлж авсан таван сая чинв аль хэдийн очдог газартаа очсон. Одоо та ид, уу! Та өнөөдөр миний зочин. Вампа аа, энэ хүн цадахаараа сул чөлөөтэй болог гэв.

Данглар гүнг гартал хэвтсэн хэвээр байв. Тэгээд толгой өндийлгөвөл, бүртэлзэн сүүдэр гарч яваа харагдсан ба түүний өмнө дээрэмчид бөхөлзөн ёсолж байгаа харагдлаа.

Вампа гүнгийн тушаалыг биелүүлж Дангларт Италийн хамгийн сайхан жимс, хамгийн шилдэг дарс өглөө. Дараа нь шуудангийн сүйх тэргэнд суулгаж замаар явуулан нэг модны дэргэд буулгаж орхив.

Данглар тэрхүү модны доор хаана байгаагаа ч мэдэргүй өглөө болтол суув.

Үүр цайхад ойролооц горхи байхыг харжээ. Юм уумаар санагдан ус руу мөлхөн очив.

ТэгЭэя ус уух гэж бөхийхөд үс нь цайчихсан харагдлаа.

20. АРАВДУГААР САРЫН ТАВАН

Оройн зургаан цагийн орчим байв. Намрын шар нарны тунглаг туяа хөх цэнхэр тэнгисийн долгионд тусна.

Өлрийн халуун буурч, үд дундын бүгчим халуун нойрноос сэрсэн байгалийн амьсгал гэлтнэй сэвэлзсэн салхи үлээнэ. Газрын дундад тэнгисийн дасвтай усны үнэртэй хослуулан эргээм эргэд хүргэнэ.

Гибралтариас Дарданелл хүртэл Тунисаас Венец хүртэл үргэлжлэн цэлийсэн сайхь асар том нуурын мандлаар үдшийн бүрийд нэгэн цагаан хөлөг далавчаа дэлгэсэн хун шувуу хөвөн явах мэт хөвөн ятаа харагдан. Гоолиг зэгзгэрхэн энэ онгоц ардаа гэрэлтсэн усан боргио үлдээн хурдлан давхина.

Тэнгэрийн хаяанд нарны сүүлчийн туяа далдран алга боллоо. Гэвч эртний үлгэр зомгийг санагдуулам хурц туяа нь Амфитридын нууцыг илтгэн тэнгисийн долгион дээр улайран туссар байв. Галын бурхан түүний элгэн дээр нуугдаж, тэвэрсэн хайртай хөх цэнхэр цувандаа ороон нуухыг хичээх мэт ажээ.

Салхин хэлийгээр бүсгүйчүүлийн сэвлэг үсийг хийсгэхгүйгээр байсан боловч бяцхан хөлөн хурдлан давхиж байв.

Хөлөг дээр өндөр нуруутай хүрэн царайтай хүн хөдлөлгүй ураш ширтэн зогсоход долгион дундаас урган гарсан каталаны аварга том бүрх малгай шиг газар түүнд ойртсоор байв.

- Энэ чинь Монте-Кристо мөн биз! гэж бяцхан хөлгийг эзэмшиж буй боллоотой явуулын хүнийг бодлогошронгуйгаар гунигтай асуухад.
- Тийм ээ эрхэм минь_ Бид зорьсон газраа хүрч ирж байна гэж ахмад хариуллаа.
- Бид зорьсон газраа ирж байна гэнэ ээ! гэж явуулын хүн цаанаа л нэг гунигтай нь аргагүй шивгэнэлээ.

Тэгээд аяархнаар,

- Тийм ээ энд миний бууда байгаа юм даа гэв.

Тэгээд дахин бодлогошрон, зогсож, уруул дээр нь нулимснаас илүү гунигтай инээмсэглэл тодорлоо.

Хэдэн минутын дараа эрэг дээр бүдэгхэн гэрэл гарснаа тэрдороо унтарч, буун дуу дуулдав.

- Эрхэм минь эрэг дээрээс бидэнд дохио өгч байна. Та өөрөө хариу өгөх үү? Гэж ахмад хэлэв.
- Ямар дохио? Гэж цаадах нь асуув.

Ахмад арал өөд заалаа. Түүний орой дээрээс цагаан утаа гарч замхран байв.

- Харлаа, харлаа гэж нөгөө хүн нойрноосоо сэрсэн мэт хэлээд, - За сайн гэв.

Ахмад түүнд цэнэглэсэн буу өгөхөд авч аажуухан өргөөд хий буудлаа.

Арван минут ч болоогүй байтал хөлөг онгоц далбаагаа буулгаж, багахан буудлаас таван зуун алхмын зайтай газар бархгаа хаяж зогслоо. Дөрвөн сэлүүрч нэг жолоо баригчтай завийг буулгасан байв. Явуулын хүн завин дээр шилжин гараад,

өөрт нь зориулж цэнхэр хивс дэвссэн завины хошуунд очиж суухын оронд гараа зөрүүлдэн зогслоо.

Сэлүүрчид тушаал хүлээж, жигүүрээ хатаах гэж дэлгэн байгаа шувуу шиг сэлүүрээ өргөн бэлхэн болговол

- Урагшаа! Гэж аянчин хэллээ.

Дөрвөн хос сэлүүр ус үсэргэлгүй доош сэлүүрдэн орлоо. Зав сум шиг хурдлан дүүлэв.

Минутын дараа хадна нгалд гарсан далайн буланд орж завины үзүүр усны элсэн ёроолыг зүсэн зогслоо.

- Эрхэм минь, хоёр сэлүүрчин таныг эрэг дээр гарагж өгнө гэж болоо баригчийг хэлэхэд, аяны хүн яасан ч яахав гэсэн маягтай дохиод бүсэлхийгээ хүртэл усанд орлоо.
- Эрхэм та дэмий юм хийх юм. Эзэн биднийг загнана даа гэж жолоо баригч хэллээ.

Тэгэхэд аянчин хариу дуугаралгүй шууд эрэг өөд явахад, урд нь хоёр далайчин усны ёроолын аль аятайг сонгон авлаа.

Тэд гучаад алхаад хуурай газар дээр гарлаа. Аяны хүн усаа сэгсчээд бүрэнхий болчихсон байсан тул ямар газар өөд аваачих бол гэдгийг тааварлан мэдэх гэж ийш тийш харж байв.

Толгойгоо дөнгөж эргүүлтэл нэгэн хүн мөрөн дээр нь гар тавьж,

- Морилон орно уу, Максимилиан. Та яг хэлсэндээ ирж, их баярлалаа гэж дуугарахад, тэр дуунаас Моррель цочив.
- Өө гүн та юу! гэж Моррель бараг баяртайгаар дуу алдаад Монте-Кристогийн гарыг хоёр гараараа атгав.
- Би бас тан шиг цагийг яг баримталж байгаа биз. Найз минь та нэвт норчихсон байна шүү дээ. Хувцсаа солих хэрэгтэй байна. Тийшээ явъя. Таны ядарч даарсныг мартуулах байр зассан.

Монте-Кристо Максимилианы эргэж харахыг мэдээд хүлээж зогслоо.

Үнэндээ ч Моррелийг авчирч өгсөн хүмүүс түүнээс хөлс нэхэлгүй, төлөхөөс нь өмнө буцад явчихсаныг хараад гайхжээ. _ Завь хөлөг онгоц руугаа буцаж, сэлүүрчид сэлүүрдэж байх нь дуулдлаа.

- Та хүргэж ирсэн далайчдаа харж байна уу? гэж гүн асуулаа.
- Тийм ээ, тэд явчихлаа. Би мөнгийг нь төлөөгүй байсан юм сан.
- Максимилиан, энэ тухай зовох хэрэггүй. Миний арал эээр ирэх бараа ба жуулдчыг хөлсгүй авчирч өгч байх тухай далайчид, бидний хооронд гэрээтэй юм, өөрөөр хэлбэл соёлт орнуудад ярьдагчлан би урдаас суудлын захиалгаа өгчихсөн хүн л дээ гэж Монте-Кристо инээж хэллээ.

Моррель гүнг гайхан хараад,

- Та энд Парист байснаасаа шал өөр болчихож гэж хэллээ.
- Яагаад тэр вэ?
- Та энд инээж байна шүү дээ.

Монте-Кристогийн царай тэр дорхноо барайгаад явчлав.

- Максимилиан таны хэлдэг зөв. Тантай уулзсан явдал надад аз жаргалтай сайхан хэрэг боллоо. Тэгээд би аз жаргал гэдэг зурсхийн алга болдог гэдгийг мартчихаж гэж гүн хэллээ.

- Үгүй, үгүй, гүн минь, дураараа инээж жаргалтай бай. Түүгээрээ зовж байгаа хүмүүст л амьдрал хүнд бэрх байдгийг харуулж өг. Та бол энэрэнгүй сайхан санаатай хүн. Та намайг хөгжилтэй болгох гэж хөгжилтэй юм шиг байна шүү дээ гэж Моррель найзынхаа гарыг атган дуу алдлаа.
- Та ташаарч байна. Би үнэндээ аз жаргалтай сайхан байсан юм гэж Монте-Кристо хэллээ.
- Та тэгвэл миний тухай мартжээ. Тэр тумсаа сайн даа.
- Яагаад тэр вэ?
- Яагад гэвэл би циркт гладиатор их зэнэ хаанд баяр хүргэж, “Үхлийг зорин алхагч би танд баяр хүргэж байна” гэж хэлдэг шигээр л танд хандан хэлэх байна.
- Та тайвшраагүй байна гэж үү! Хэмээн Монте-Кристо учиртайхан харж, хэлэхэд Моррель гунигтайхнаар
- Та үнэхээр тэгж болно хэмээн бодлоо гэж үү?
- Хэмээн асуув.
- Максимилиан чи миний хэлэхийг ойлго. Намайг салхинд үгээ дэмий цацаж явдаг чалчаа амьтан гэж бодоогүй биз дээ? Хүний зүрх надад нууц биш байдаг учраас таныг тайвшрав уу? гэж асууха эрхтэй. таны зүрхний гүн дотор нуугдаж байгааг хоёулаа харъял даа. Зүрх чинь урьдын адил өвдөж, бие чинь шумуулд хатгуулсан арслан цоих мэт цочож байна уу? зөвхөн булш л амрааж чадах халуун хүсэл чинь таныг зовоон, хүнийг амьдралаас зөвхөн үхэл өөд түлхдэг тайтгаршгүй уй гашуу чинь хэвээр байна уу? Таны зүрх зориг чадалгүй болж, уйтгар гуниг эцсийн горьдлогыг нь унтрааж, дахин уйлан хайлах тэнхээгүй болгов уу? Хэрэв танд дахин нулимс байхгүй болж, зүрх чинь үхэж, бурхнаас өөр түших тулах юмгүй болж харц чинв зөвхөн тэнгэр өөд харах болсон бол найз минь та тайвширсан хэрэг. Өөр юунд ч дүрэлзээд байх хэрэггүй болсон.
- Гүн минь гэж Моррель номхон дөлгөөн боловч хатуугаар хэлээд – Хуруугаараа доош газар зааж байгаа боловч тэнгэр өөд харж байгаа хүний үг гэж бодож миний хэлэхийг сонсооч. Би найзынхаа дэргэд үхэх гэж тан дээр ирсэн юм. надад хайртай хүмүүс бий. Миний дүү түүний нөхөр нь байна. гэвч сүүлчийн минутад би хэн нэг хүн надад инээмсэглэж, хүчтэй тэврээсэй гэж хүссэн юм. Жюли бол уйлж унжин, ухаан алдаж ойчно. Би түүний зовж зүдэрч байгааг харах болно, гэтэл би өөрөө бишгүйдээ зовлоо. Эмманюель бол буугий минь надаас булааж аваад, байшин дүүрэн хашхирах болно. харин та бол, хэрэв үхдэггүй бол бурхан гэж бодохоор хүнээс илүү хүн учраас намайг мөнхийн хаалга өөд чимээ аниргүй, эелдэг зөөлөн үдэж гаргаж өгнө шүү дээ гэв.
- Найз минь, надад бас нэг эргэлзэх юм байна. Та зовж зүдэрснээ ид бах болгохоор хулчгар хүн биш биз гэж гүн асуув.
- Үгүй дээ, гүн минь, намайг хар л даа, би хулчгар биш шүү гэж хэлээд хоёр гараа сунгаж – Миний судас хурдан ч үгүй, удаан ч үгүй хуучнаараа л цохилж байна. Би замынхаа эцэст хүрч ирсэн хүн. Цаашаа явахгүй хүн. Та өөрийгөө ухаантай мэргэн хүн гэдэг. Та надад бодож явбал бүтнэ гэж хэлсэн шүү дээ. Энэ чинь юунд хүргэсэн гэдгийг мэдэж байна уу? Би бүтэн

сар хүлээлээ. Энэ бол бүтэн сар зовлоо гэсэн үг. Хүн гэдэг хөөрхий, золгүй амьтан. Би өөрөө юунд найдаж байгаага мэдэхгүй хүлээж байлаа. Ид шид гэхэд... ямар ид шид байв даа? Бидний оюуныг ухаангүй горьдлогоор балартуулагч бурхан л мэднэ. Би хүлээж найдаж байв. Бид хоёрын ярьсан арван таван минутад та миний зүрхийг өөрөө мэдэлгүй ихэд зовоож, хэлсэн үг бүр чинь надад цааш зорилго байхгүй гэдгийг нотолж байв. Үхэл намайг ямар эелдэг сайхнаар бүүвэйлж байна вэ? гэв.

Моррельсүүлчийнхээ үгийг тачаангуйн их хүчээр хэлсэн учир гүн цочих шиг боллоо. Моррель хариу дуугарахгүй байгааг хараад,

- Есдүгээр сарын таванд та надаас нэг сарын хугацаа сунгахыг шаардсан билээ. Би зөвшөөрсөн.... Найз минь өнөөдөр аравдугаар сарын таван гэж хэлснээ цагаа хараад, - Одоо есөн цаг болж байна. Тэгэхээр надад амьд байх гурван цаг үлчлээ гэв.

- За сайн хэрэг. Явъя гэж Монте-Кристо хариулав.

Моррель гүнгийн хойноос аяндаа дагаж, тэр ч байтугай агуйн амаар яаж орсныгоо ч мэдсэнгүй.

Хөл доор нь хивс байх шиг санагдаж, хаалга онгойлоо. Сайхан үнэртэй агаар амьсгаалагдаж, хурц гэрэл нүдийг нь гялбуулав. Моррель тээнэгэлзэн зогсов. Энэхүү зоригийг султгагч баян тансаг байдлаас айжээ.

Монте-Кристо түүнийг найрсгаар ширээ рүү түлхэв.

- Та бид хоёр үлдсэн гурван уагаа эртний ромчууд шиг өнгөрүүлж яагаад болдоггүй юм бэ? Өөрийн үе загламжлагч, эзэн Нореноос алах ял заагдаад, тэд нар цэцгийн үнэр анхилуулсан ширээний ард үхлийг хүлээн сайхан үнэр үнэртэн сууцгааж байдаг байсан юм гэв.

Моррель инээмсэглэв.

- Өөрөө л мэд, үхэл гэдэг чинь үхэл амьгүй тайван, зовлон зүдгүүргүй нойрсохыг хэлдэг юм гэж тэр хэллээ.

Түүнийг ширээний ард суухад Монте-Кристо өөдөөс нь харж суув.

Энэ бол бидний нэгэн удаа дүрслэн бичсэн тэр үлгэрийн сайхан ширээ байв. Ганшиг хөшөө, хуучин хэвээр цэцэг, жимстэй сагс толгой дээрээ барьсан байв.

Моррель орохдоо тасалгааг хайнга харсан болохоор юу ч анзаараагүй нь мэдээж.

- Би эр хүн эр хүнээсээ асуудаг ёсоор танаас нэг юм асууя гэж гүн өөд ширтэн харж хэлэв.

- Асуу, асуу.

- Гүн та хүний бүх мэдлэгийг эзэмшсэн хүн. Та манай энэ ертөнцөөс илүү дээд ертөнцөөс гарч ирсэн байх гэж надад санагддаг юм гэж Моррель үргэжлэн хэлэхэд гүн гунигтайгаар инээмсэглэж,

- Моррель таны үгэнд үнэний хувь байна. Би бол өөр нажид зовлон гэдэг Жаригаас бууж ирсэн юм гэв.

- Би таны үгэнд бүрэн итгэдэг. Тэр ч байтугайнууц утга учрыг нь мэдэх гэж ч оролддоггүй. Та намайг амьдарч бай л гэсэн. Тэгээд л би амьдарч байна. Та намайг найдаж бай гэсэн. Тэгээд би бараг л найдаж байлаа. Одоо танаас хэрэв та үхэх гэгчийг үзсэн юм бол их зовууртай байх уу гэдэг ганцхан зүйлийг асууя.

Монте-Кристо Моррелийг эцгийн энэрэнгүй харцаар харж,

- Тийм э, энэ маш зовлон шаналгаатай эд. Хэрэв та амьд баймаар санагдаад байгаа тэр үхлийн бүрхүүлийг хамаа намаагүй хэмхэчвэл ихэд тарчилна. Та хутганы нүдэнд үл үзэгдэх барсгар ирээр махаа сэглэж, хэзээ ч замаасаа гажиж болох тэнэг сумаар өчүүхэн юм хүрэхийг ч мэдэрдэг тархиа зад цохиворл зовохын муугаар зовж аминаасаа хагацах болно. Зхэхийн өмнөх зовлонт цагт амь нас чинь ийм үнээр худалдан авсан тайван нойроос чинь илүү сайхан санагдах болно.
- Ойлголоо. Үхэлд бас амьдрал шиг зовлонтой, жаргалтай хоёр тал нуугдаж байх нь. Ганцхан түүний нууцыг нь л мэдэх хэрэгтэй юм.
- Максимилиан таных туйлын зөв. Бид үхлийг найрсгаар эсвэл дайсагналтайгаар угтахын хэрээр үхэл бидэнд эелдгээр бүүвэйдэг найз нөхөр болох буюу эсвэл бидний сүнсийг биеэс минь суга татагч дайсан болно. Мянган мянган жил өнгөрч, хүн байгалийн их сүйтгэгч хүчийг эзэмшин авч түүнийг хүн төрөлхтөний сайн сайхны төлөө ашиглаж чаддаг болсон цагт таны тэр хэлснээр үхли@н нууц илрэх болно. Тэгэхэд л үмэл хайртай хүндээ тэврүүлэн байJaа юм шиг тийм амттай, сайхан зүйл болно доо.
- Гүн та хүсвэл ингэж үхэж чадах уу?
- Чадна.

Моррель гүн өөд гараа сунгаж,

- Би одоо таны энд, тэнгисийн дундах өнчин арал дээр, Фараон ч атаархмаар газар доорх энэ ордонд надтай уулзах гэсний учрыг ойлголоо. Та надад хайртай учраас л энэ, тийм биз? Та намайг саяынхаа ярьдаг үхлээр үхүүлэхээр хайртай байдаг уу? Би зовж зүдрэлгүй, Валентинагийнхаа нэрийг дуудан, таны гарыг атган байж үхэх болно гэв.
- Тийм ээ, Моррель та таачихлаа. Би үүнийг л хүссэн юм гэж гүн хэллээ.
- Маргааш зовохгүй болно гэж бодоход тарчилсан зүрхэнд минь хэчнээн сайхан байна вэ?
- Та ер нь юуны тухай ч харамсаагүй биз гэж Монте-Кристок асуухад,
- Үгүй гэж Моррель хариулав.
- Намайг ч хүртэл өрөвдөхгүй гэж үү? Хэмээн гүн сэтгэл нь ихэд хөдлөн асуув.

Моррель дуугарсангүй. Түүний хруц нүд гэнэт бүрхэж, дараа нь ерийн биш байдлаар гялалзав. Том нулимс хацар дээгүүр нь бөмбөрнө.

- Яалаа гэнэ ээ! Энэ дэлхий дээр ямар нэг хайрлаж харамсах юмтай байж үхэх гэж хүснэ гэнэ ээ? гэж гүн хэлэхэд Моррель дорой дуугаар,
- Дахиад нэг ч үг бүү хэлээч. Та намайг зовоож гүйцэлээ гэв.

Моррель суларч байна гэж гүн бодлоо.

Иф цайзад нэгэн удаа үгүй хийж чадсан тийм аймшигт эргэлзэл дахин сэргэж ирлээ.

“Би энэ хүнд аз жаргалыг нь буцааж өгөх гэсэн юм. Би энэ аз жаргалыг, хорт муу үйл хийсэн жингийн тавагны нөгөө талд тавьж цэнгэл аз жаргалын талыг дий«үүлэхийг хүсэж байна. хэрэв энэ хүн аз жаргалыг олж авахаар тийм золгүй

байдалд ороогүй байвал яана? Тэгвэл би яах вэ? Би сайн сайхныг санаж байж, хорт мууг мартсан болох нь ээ” гэж гүн дотроо бодлоо.

- Таны уй гашуу хязгааргүй их байгааг би мэдэж байна. гэвч та бурханд сүсэглэдэг мөртлөө сүнсээ сүйтгэхийг хүсэхгүй биз дээ гэв.

Моррель уйтгартайгаар инээмсэглэв.

- Гүн минь би гоё сайхан үгэнд дуртай хүн биш. гэхдээ одоо миний сүнс надад хамаарагдахаа больсон гэдгийг тангараглая гэж зөрлөө.

- Моррель та намайг энэ орчлон дээр ганцаараа гэдгийг мэднэ. Би таныг хүү шигээ бодож сурчхаж. Тэгэхээр хүүгээ аврахын тулд амь насаа, эд баялгаа бол бүр ч дуртайяа зориулахад бэлэн байна гэж Монте-Крис хэллээ.

- Та тэгээд юу гэх гээ вэ?

- Та маш баян хүн ямар их аз жаргалтай сайхан байдгийг мэдэхгүй болохоор үхэх гэж хүсээд байна гэж хэлсэн гэсэн юм. надад зуун сая орчмын хөрөнгө байна. Би үүнийгээ танд бэлэглэе. Ийм хөрөнгөтэйгээр та юу хүссэнийгээ хийж чадна. Хэрэв та нэр төртэй хүн быолохыг хүсдэг бол бүх зам нээлттэй болно. Орчлонг эргүүлж, нүүр царайг нь өөрчилж, ямар ч төрхгүй хэрэг хийж, гэмт явдал үйлдсэн ч та амьдарсаар л байх болно!

- Гүн та надад ам өгсөн шүү дээ гэж Моррель хүйтнээр хэлээд цагаа харж, - Одоо арван нэг хагас болж байна гэв.

- Моррель! Чи миний гэрт нүдэн дээр тэгэх гэж оо? Сайн бодооч!

- Тэгвэл намайг явуулчих. Би таныг тэгвэл, надад хайртай биш зөвхөн өөртөө хайртай хэн байсан юм байна гэж мэдье гэж Максимилиан царай муутай хэлээд, гарах гэж бослоо.

Тэгэхэд гүнгийн царайд гэгээ орж,

- за сайн. Та буцаж нядашгүй шийдсэн болохыг харлаа. Та үнэхээр хүнд нажид зовлонд учирсан болохоор зөвхөн гайхамшигт ид шид л таныг эдгээж чадна гэж хэлсэн шүү дээ. За, Моррель минь суугаад хүлээж бай гэв.

Моррель түүний үгэнд орж суулаа. Тэгэхэд Монте-Кристо босож биедээ алтан гинжнээс зүүн авч явдаг түлхүүрээр шүүгээгээ онгойлгож, түүн дотроос маш сайхан цоолбортой мөнгөн хайрцаг гаргаж ирэв. Дөрвөн буланд нь тэнгэрийг хүсэн мөрөөдсөн, чигаа тэнгэр лүгээ адил охидын бөхийн суусан гоолиг дүрийг цутгажээ.

Тэрээр хайрцгаа ширээн дээр тавив.

Дараа нь онгойлгож таг нь нууц пүрш дарахад онгойдог алтан хайрцаг гаргаж ирэв.

Жижиг хайрцагт зуурсна гурил шиг зунгааралдсан тослог дүүрэн байв. Хайрцгийг чимсэн алт, эрдэнэсийн чулууны туяа түүний өнгийг ялган харахад саад болж байв.

Тэр зуурмаг хөх, улаан, шар өнгөөр солонгорно.

Гүн тэр юмнаас алтан халбагаар багахныг хутгаж аваад Моррелийг тас ширтэн байж өглөө.

Ногоовтор өнгөтэй бодис болох нь одоо харагдав.

- Энэ бол таны хүсэж, миний амласан юм байгаа юм гэж гүн хэлэхэд Максимилиан Монте-Кристовийн гараас халбаыг авч,

- Би үхэхээсээ өмнө танд чин сэтгэлээсээ баярлаж байгаагаа хэлэхийг хүсэж байна гэв.

Гүн өөр нэг халбага авч мөн хутгаж авав.

- Найз минь та яах нь вэ? гэж Моррель түүний гарыг барьж хэлэв.
- Моррель минь, бурхан намайг уучлаг. Би ч бас чамаас багагүй амьдралаасаа уйдлаа. Тэгэхээр энэ сайхан завшааныг ашиглаж.... Гэж хэлтэл Максимилиан
- Та болохгүй! гэж дуу алдаад – Та бол сэтгэлтэй хүнтэй, хайрлагдах ч хүнтэй, горьдлого тасраагүй хүн. Тэгэхээр ингэж болохгүй! Энэ бол гэмт хэрэг болно! Миний сайхан санаат найз минь баяртай. Би валентинад таны миний төлөө хийсэн бүхнийг чинь ярина гэв.

Моррель алгуурхан боловч шийдэмгийгээр, зүүн гараараа гүнгийн гарыг барьж нууцлаг идээг дуртайяа залгилаа.

Тэр хоёр хоёулаа дуугүй байв. Али чимээгүй орж ирж тамхи, тамхины хэрэгсэл, кофе авчирч тавив.

Баримал хөшөөний гар дахь дэн бага багаар сүүтийж, тамхины анхилуун үнэр суларч байх шиг байв.

Монте-Кристо өмөн талд нь, сүүдэрт сууж түүнийг ажиглан харах бөгөөд Моррель гүнгийн зөвхөн гялалзсан нүдийг нь ялган харж байв.

Максимилианы бие хязгааргүй их суларч байв. Усан ганс нь гараас унаж, тэнд байсан юмс хэлбэр дүрс, өнгө зүсээ алдлаа. Түүний бүрхсэн нүдэнд өөдөөс нь харсан ханан дээр нэг хаалга онгойж хөшиг нээгдэж байх шиг санагджээ.

- Найз минь би үхэж байх шиг байна. Баярлалаа гэж тэр хэлэв.

Тэгээд гүн өөд сүүлчийн удаа гараа сарвайх гэсэн боловч гар нь сарвайж өгсөнгүй унжчихлаа.

'Эгэхэд Монте-Кристо өнөөх гайхамшигт инээмсэглэлээрээ биш, харин аав нь хүүгийнраа зүггүйтэхийг энэрэнгүй сэтгэлээр өхөөрдөн харж суугаа байраар инээмсэглэж байх шиг санагджээ.

Тэгэнгээ гүн өсөж том болчихсон юм шиг санагдана. Улаан эдээр бүрсэн ханын цаад талыд бараг аварга хүн аятай харагдаж байв. Түүний хар үс нь ар тийшээ унжиж аймшигт шүүхийн өдөр, нүгэлтнүүдийг хүлээн авч байгаа ихэмсэг дүрт эрлэгийн элч адил зогсож байв.

Моррель цохигдож сулран сандлынхаа түшлэгийг налав. Судасны нь цус юүлэгдэх шиг болж, юм бүхэн хээ угалз мэт эрээлжлэн харагдана.

Тамир тэнхээгүй болж, хагас хэвтсэн Моррельд ямар ч амьтан амьгүй болсон мэт санагдаж, ганцхан зүүд мэт юм үлджээ. Тэрээр сураггүй алга болдог үхэл гээч орон руу хар эрчээрээ хурдлан давхиж байх шиг санагджээ.

Тэр дахин гүн өөд гараа сунгах гэж оролдсон боловч тэр нь хөдөлсөн ч үгүй. Моррель сүүлчийн удаа уучлаарай гэж хэлэх гэсэн боловч хэл нь бунхны ам тагласан чулуу адил хөдөлшгүй хүндэрсэн байв.

Түүний ядарсна нүд нь өөрийн эрхгүй анив. Хэдийгээр нүдээ аньсан боловч аньсан зовхины нь цаана нэгэн тодохой биш дүрс харагдах шиг болоход түүнийг таньжээ.

Энэ бол гүн байв. Тэр нэг хаалганы дэргэд очиж онгойлголоо.

Яг тэр үед зэргэлдээ өрөө чухамдаа гэвэл үлгэрийн ордонд гэлтэй байсан хурц гэрэл Моррелийн амтат зүүд зүүдэлж байгаа өрөөг гэрэлтүүлээ.

Энэ хоёр тасалгааг зааглан байгаа хаалганы босгон дээр гайхалтай гоо сайхан хүүхэн гарч ир«ээ.

Эелдэг зөөлнөөр инээмсэглэн, өшөө хорслын чигaa тэнгэрийг хараан зүхэгч, энэрэнгүй сэтгэлийн чигaa тэнгэр мэт байлаа.

Максимилиан зовхи өргөж, “надад тэнгэр нээгдэж байна уу? Энэ тэнгэрлэг бүсгүй чинь миний алдсантай адилхан юм” гэж бодов.

Монте-Кристо бүсгүйд Моррелийн хэвтэж байгаа буйданг заав.

Бүсгүй элгэндээ гараа зөрүүлэн инээмсэглэсээр түүн рүү ойртон ирэв.

- Валентина! Гэж Моррель зүрнийхээ угаас хашхирав.

Гэвч дуугарсангүй. Тэр энэ үл дуулдах хашхираандаа хамаг хүчээ зарцуулчихсан мэт гүнээ санаа алдаад нүдээ анив.

Валентина түүн өөд ухасхийв.

Моррелийн уруул дахин хөдлөв.

- Тэр таныг дуудаж байна. Таны хувь заяагаа итгүүлж даатгасан тэр хүн, үхэл арай салгаж орхиогүй тэр хүн чинь таныг дуудаж байна. харин аз болоход би хамгаалан авч, үхлийг ялав! Тэр тантай нийлэхийн тул авсанд харайн орсон учир, одоо энэ орчлон дээжр юу ч та хоёрыг салгах ёсгүй. Хэрэв би байгаагүйсэн бол та хоёр хоёулаа үхэх байсан Би та хоёрыг бие биед чинь буцаан өгч байна. Миний аварсан энэ хоёр амийг бурхан тооцон авч үзэх биз ээ! гэж гүн хэллээ.

Валентина гүнгийн гарыг шүүрэн авч, хязгааргүй баярласны эрхээр үнэслээ.

- Тийм ээ, надад баярла! Би та нарт аз жаргалыг өгсний минь зогсолтгүй давтан хэлж бай! Ингэж итгэх явдал надад хичнээн хэрэгтэй болохыг та нар мэдэхгүй! гэж гүн хэллээ.

- Би танд чин зүрхнээсээ баярлаж байна. Хэрэв та итгэхгүй бол Гайдегаас асуугаарай. Францаас гарч явснаас хойш миний хайрт эгч Гайдегийн, таны тухай ярьсан ярьёа энэ баярт цагийн тэвчээртэйгээр хүлээхэд минь тусалсан юм гэдгийг эгч минь өөрөө хэлж өгөг.

- Та Гайдед тийм хайртай юм уу? гэж Монте-Кристо хөдөлсөн сэтгэлээ нууж ядан асуув.

- Чин сэтгэлээсээ хайртай!

- Валентина, би нэг зүйлийг танаас хүсье гэж гүн хэлэв.

- Надаас уу, бурхан мин! Би тийм азтай хүн гэж үү?

- Тийм ээ, та Гайдег эгч гэж нэрлсэн. Тэгэхээр тэр үнэхээр таны эгч болог. Та нар надад хариулах ач тусаа түүнд өгөөрэй. Моррель та хоёр түүнийг минь хайрлаж хамгаалж яваарай. Учир нь одооноос эхлэн энэ бүсгүй орчлон дээр ганцаараа болно хэмээн дуулдахтай үгүйтээ хэлэв.

- Энэ орчлон дээр ганцаараа гэнэ ээ! Яагаад тэр вэ? гэж шүнгийн араас асуух дуулдав. Гүн эргэн харлаа.

Түүний өмнө Гайде царай нь зэвхийрэн, түүн өөд үнхэлцэг нь хагарчихна уу гэлтэй бүлтэгнэн харж байв.

- Яагаад гэвэл охин минь чи маргаашнаас хлээд эрх чөлөөтэй болно... Тэгээд байх ёстой байраа эзлэх болно. Миний хувь тавилан чамайг

гутаахыг хүсэхгүй байна. Агуу их паүйн охин чамд эд хөрөнгө, эцгийн чинь нэрийг буцааж өгье.

Гайдегийн царай зэвхийрч, бурханд өөрийгөө даатган өгч байгаа тэнрэрлэг охин шиг гараа өргөж, нулимс гоожиж сөөнгөтсөн дуугаар,

- Эзэн минь, та намайг хаях нь уу? гэж асуулаа.

- Гайде минь, чи залуу үзэсгэлэнтэй сайхан байна. Миний нэрийг ч болов мартаж, аз жаргалтай яваарай.

- За сайн, эзэн таы зарлиг биелэгдэх болно. Би таы нэрийг мартаж, жаргалтай явъя гэж Гайде хэлээд үүд рүү ухрав.

Моррелийн хүндэрсэн толгойг түшин байсан Валентина,

- Бурхан минь! гэж хашхираад – Та түүний царай яаж зэвхийрч, яаж зовж шаналж байгааг ойлгохгүй байна уу? гэв.

Гайде зүрх шимшрэм дуугаар,

- Түүнд намайг ойлгох ямар хэрэг байх вэ? Тэр бол эзэн, би бол боол нь. Тэгэхээр тэр юу ч ажиглахгүй байх нь зөв гэв.

Гүн зүррний нь хамгийн эмзэг нууцыг хөндсөн энэ дууг дуулаад татвасхийв. Түүний харц Гайдегийн харцтай тулгарч охины нүдний хурц галыг тэсвэрлэсэнгүй.

- Бурхан минь! Миний тааварлаж бодож байсан үнэн болох нь гэж үү? Тэгэхээр Гайде чи надаас салмааргүй байна уу? гэж Монте-Кристо хэллээ.

- Би залуу байна. Таны тимй амттай сайхан болгож өгсөн амьдралд дуртай. Би үхэхдээ харамсаж байна гэж Гайде товчхон хариулав.

- Гайде би чамайг орхивол.... Яах вэ?

- Эзэн минь би тэгвэл үхнэ.

- Тэгвэл чи надад хайртай сайн юм уу?

- Энэ намайг өөртөө хайртай сайн уу гэж асууж байна шүү! Валентина, чи Максимилианд сайн эсэхээ энүүнд хэлж өгөөч.

Гүнгийн зүрх цээжиндээ багтахгүй болж байх шиг санагджээ. Тэгээд гараа дэлгэ урагш сунгахад Гайде гүйн ирж тэврүүлэв.

- Тийм ээ би чамд дуртай. Чамд хайртай! Эцгээ, ахаа, эр нөхрөө хайрлах сэтгэлээр хайртай сайн байдаг! Би чамайг амьдрал шигээ сайн сайхан хүн учир би чамайг бурхан шиг хайрладаг.

- Тэнгэрлэг охин минь, чиний хүсэл биелэгдэг гэж гүн хэлээд – Дайснаа дарах ялалт өгсөн бурхан, ялалтыг минь уйтгар гунигаар төгсөг гэж бодоогүй явжээ. Би өөрийгөө цээрлүүлэх гэсэн чинь бурхан намайг уучлахыг хүсэж байгаа юм байжээ. Тэгвэл Гайде минь надад хайртай сайн бай! Миний мартаж ёстой юмыг чиний дурлал мартуулж болохыг хэн мэдэх вэ?

- Эзэн минь чи юу ярьж байна вэ гэж бүсгүй асуулаа.

- Гайде чиний хэлсэн ганц үг л миний хорин жил хуримтлуулсан цэцэн мэргэн ухаанаас минь илүү их юманд сургав. Надад энэ орчлон дээр ганц чи үлдэж, намайг амьдралтай зууралдуулж, ганц чи л надад зовлон жаргалыг өгч чадна!

- Валентина чи дуулж байна уу? Түүний төлөө үхэхэд бэлхэн байгаа би үүнийг зовлонд учруулах юм гэнэ! Гэж Гайде дуу алдлаа.

Монте-Кристо гүн гүнээ бодлогоширлоо.

- Би үнэхээр үнэн юм үзэж байна гэж үү? Ай, бурхан минь, шагнал зэмлэлийн алин боловч би ногдсон хувь тавилангаа дагая. Явъя, Гайде, явъя...

Тэгээд охины уян зөөлөн нуруугаар тэвэрч Валентинатай гар бариад гарч одлоо.

Түүнээс хойш нэг цаг хяраатай өнгөрөв. Валентина Моррелийн дэргэд амьсгаа түгжин үг дуугүй гөлрөн сууж байв. Гэтэл гэнэт зүрх нь цохилж, үл мэдэг амьсгал авах мэдрэгдэн, амь орж б йгаагийн анхны шинж тэмдэг орон бүх бие нь зөөлөн чичрэхийг мэдрэв.

Эцэст нь нүдээ нээсэн боловч харц нь хараагүй бөгөөд хөдөлгөөнгүй байв. Дараа нь хурц тод харах боллоо. Хараа орохын хамт ухаан нь сэргэв. Ухаан нь сэргэмэгц гашуудал нь дахин төрлөө.

- Би амьд байна аа? Гүн намайг хуурчихжээ! Гэж цөхрөнгөө барсан янзтай хэлснээ ухасхийн ширээн дээрээс хутга шүүрэн авав.

Тэгэхэд Валентина сэтгэл татам сайхан инээмсэглэж,

- Найз минь, ухаан орж, намайг хараач гэж хэллээ.

Моррель чанга хашхираад, учир замбараагүй хэдэн үг хэлж, дээд тэнгэрийг үзсэн мэт гайхан, нүдэнд харсандаа итгэж чадалгүй сөхрөн унав.

Маргааш өглөө нь үүрээр Моррель Валентина хоёр агуйн үүд онгорхой байсныг олж гадагш агаарт гарлаа. Тэр хоёр хөтлөлцөн тэнгисийн эргээр явж, Валентина Монте-Кристо түүний өрөөнд яаж орж ирсэн, яаж түүнд бүх нууцыг нээж өгсөн, яаж гэмт явдлыг нүдээр нь харуулсан, эцэст нь үхсэн гэж тооцогдож байсан түүнийг үхлээс яаж ид шидээр аварсан зэргийг Моррельд нэгд нэггүй ярьж өгөв.

Өглөөний хөх тэнгэрт сүүлчийн одод гялалзан гялтганаж байлаа.

Гэтэл Моррель хадны сүүдэрт нэгэн хүн дуудахыг хүлээх мэт зогсож байхыг харав. Тэгээд түүнийг Валентинад зааж харуулав.

- Онгоцны ахмад Жакопо байна гэж Валентина хэлээд түүнийг нааш ир гэж дохив.
- Та бидэнд юм хэлэх гээ юу? гэж Моррель асуув.
- Би гүнгийн захидлыг дамжуулж өгөх ёстой.
- Гүнгийн захидал гэнэ Сэ? гэж тэр хоёр нэг зэрэг асуув.
- Тимй ээ, уншицгаа.

“Хүндэт Максимилиан минь! Ёрэг дээр онгоц хүлээж байгаа. Жакопо таныг эрхэт Нуартье ач охиноо хүнтэй суухаар сүмд очихын өмнө ерөөж адислахаар хүлээж байгаа Ливорнод хүргэж өгнө. Энэ агуйд байгаа бүр зүйл, Елисейн Тал дахь миний байшин, Тренпор дахь ордон энэ бүгд бол эзэн Моррелийнхоо хүүд Эдмон Дантесаас бэлэглэж байгаа хуримын бэлэг болог. Мадмуазель де Вильфор энэ хөрөнгөний хагасыг хуваалцан авч, харин галзуурсан эцэг ба хойд эхтэй чинь хамт энэ оны есдүгээр сард нас барсан дүүгийн чинь дараа ногдох хөрөнгийг Парисын ядуучуудад шилжүүлэн өгөхийг найдаж хүсье.

Моррель, таны амьдралыг хамгаалж байгаа тэнгэр бурхандаа өөрийгөө бурхантай адил болгож, номхон дөлгөөн христосын шашинтны ёсоор хүч чадал, дээд мэргэн ухаан бурхны гарт байдаг гэдгийг ойлгосон нэгэн хүний төлөө залбирч явахыг хүсээрэй. Энэ залбирал миний зүрхэндээ авч яваа гунигийн сэтгэлийг зөөлрүүлж магадгүй юм.

Би Моррель таныг ийнхүү хатуугаар туршсаны нууцыг тайлж өгөхийг хүсэж байна. Энэ хорвоо дээр аз жаргал, зовлонгийн аль аль нь байхгүй. Энэ хоёрын аль нь ч харьцуулан үзсэний хүчээр олдоно. Зөвхөн хязгааргүй их нажид зовлон эдэлж байсан хүн л жаргалын дээдийг амсан эдэлж чаддаг юм. Амьдрал хичнээн сайхан болохыг мэдэхийн тул үхлийг хүсэх хэрэгтэй.

Сайн сайхан жаргалтай амьдарцгаагаарай, миний хайрт хүүхдүүд минь. Харин бурман багш, хүний өмнө ирээдүйнх нь хаалт хөмшийг нээн онгойлгож өгөх хүртэл хүний бүх цэцэн мэргэн ухаан нь найдах хүлээх гэдэг хоёрхон үгэнд баглана гэдгийг бүү мартаарай.

Таны найз Эдмон Дантес, Монте-Кристо гүн”

Эцгээ галзуурч, зүүгээ үхсэн тухай анх мэдэгдсэн эн захидлыг уншиж дуусмагц Валентинагийн царай зэвхийрч гунигтайгаар санаа алдаад хацар дээгүүр нь халуун нулимс чимээгүй бөмбөрөв. Аз жаргал түүнд их үнээр олджээ.

Моррель санаа зовсон байртай ийш тийш харлаа.

- Гүн дэндүү өгөөмөр арвин загнажээ. Валентина миний өчүүхэн хөрөнгөөр болно. Гүн хаа байна? Найз минь намайг түүн дээр хүргэж өгөөч гэж Моррель хэлэхэд Жакопо тэнгэрийн хаяа өөд заав.
- Та юу хэлэх гэж вэ? Гүн хаана байна? Гайде ханаа байна гэж Валентина асуухад,
- Тийшээ хар л даа гэж Жакопо хэллээ.

Тэр хоёр далайчны заасан зүг өөд харвал, тэнгис, тэнгэр хоёрын завсар цахлай шувууны далавчнаас томгүй цагаан далбаа тодхон харагдав.

- Явчихжээ! Баяртай найз минь, эцэг минь! гэж Моррель дуу алдахад Валентина,
- Явчихлаа! Баяртай Гайде! Баяртай эгч минь гэж шивгэнэлээ.
- Бид дахин уулзах эсэхийг хэн мэдэх билээ гэж Моррель хэлээд нулимсаа арчихад,
- Найз минь, гүн бидэнд хүн төрөлхтөний хамаг цэцэн мэргэн ухаан нь найдах, хүлээх гэдэг хоёрхон үгэнд байдаг гэж хэлсэн биш бил үү? Гэж Валентина хариу өгүүллээ.

Эх сурвалж:

**Формат, фонт зэргийг бага зэрэг
янзалж pdf хэлбэр уруу
хөрвүүлсэн:**

www.e-pada.com

mongolnom.blogspot.com